

# Хүний эрхийн ТӨЛӨӨ!

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах  
үйл ажиллагаа, нөлөөлөл



Зохиогч: **Жанет Лорд, Катрин Гернсей, Жоел Бальф ба Валери Карр**

Орчуулсан: **А.Гэрэмаа  
Б.Оюунцэцэг  
Г.Баасанцэрэн  
Б.Батжаргал**

Хянан  
тохиолдуулсан: **С.Ганчимэг**

**“ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ” ЦУВРАЛ**

**Сэдэвчилсэн гарын авлага №6**



НЭЭЛТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

## ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨ

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа, нөлөөлөл

© Нээлттэй Нийгэм Форум

Энэхүү гарын авлагыг хувийн хэрэгцээнээс бусад зорилгоор хэсэгчлэн болон бүтнээр нь хувилж олшруулахыг хүсвэл доорхи хаягаар хандаж зохих зөвшөөрөл авна уу.

DDC

323.590 816

Λ-77

ISBN 978-99962-0-050-2

Монгол Улс

Улаанбаатар хот

2009 он

Хаяг: Жамьян гүний гудамж-1/5

Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар -48,

Утас: 976-11-313207

Факс: 976-11-324857

Вэб: <http://www.forum.mn>

И-мэйл: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)

Хэвлэлийн хуудас 49

Хэвлэсэн хувь 500

“ADMON” компанид эхийг бэлтгэж хэвлэв.

## “Хүний эрхийн боловсрол” цувралын тухай

Миннесота мужийн Их сургуулийн Хүний эрхийн мэдээллийн төв хүний эрхийн боловсролд зориулсан цуврал материал хэвлэн гаргаад байна. Ненси Флауэрсийн эмхэтгэн боловсруулсан энэхүү цуврал нь АНУ болон дэлхий даяар хүний эрхийг хүндэтгэх соёлыг хэвшүүлэхээр ажиллаж байгаа багш сургагчид, хүний эрхийн идэвхтнүүдийн өргөжин тэлж буй хамт олонд мэдээллийн чухал эх сурвалж болох юм. Энэхүү цувралд багтсан бусад гарын авлага:

### **Хүний эрх энд ба одоо:**

Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг дэмжин сайшаах нь

Эмхэтгэгч: Ненси Флауэрс

### **Эдийн засаг, нийгмийн шударга ёс:**

Хүний эрхийн хандлага

Зохиогч: Дэвид Шиман

### **Хүүхдийг үндэс угсаа, эрх, үүргээ мэддэг болгон хүмүүжүүлэх нь:**

НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцийг дэмжин сайшаах нь

Зохиогч: Лори Дюпонт, Жоан Фоли, Аннет Галиарди

### **Лесби, гомосесуал, бисексуал, трансжендер хүмүүсийн эрх:**

Хүний эрхийн хандлага

Зохиогч: Дэвид М. Донахью

**Хүний эрхийн боловсролын гарын авлага:** Сурах, эрхээ хамгаалах, өөрчлөлт хийхэд хэрэглэх үр нөлөөтэй арга туршлага

Зохиогч: Ненси Флауэрс

### **Сэтгэлийн дэм:**

Хүний эрх ба шашин шүтлэг, итгэл үнэмшилтэй байх эрх

Зохиогч: “Тандем” төсөл, Хүний эрхийн мэдээллийн төв

Хавтасны зураг Мухаммад Аль Малки

# Human Rights. YES!

**Action and Advocacy on the  
Rights of Persons with Disabilities**



**Janet E. Lord, Katherine N. Guernsey, Joelle M. Balfe & Valerie L. Karr  
Nancy Flowers, Editor**

**HUMAN RIGHT EDUCATION SERIES**

**Topic Book 6**

A Publication of the University of Minnesota Human Rights Resource Center  
Developed and Coordinated by Blue Law, LLP in partnership with  
Disabled Peoples' International  
Funded by Shafallah Center for Children with Special Needs

Copyright © 2007  
Human Rights Resource Center, University of Minnesota  
ISBN: 0-96-75334-4-5

*Human Rights. YES!* may be reproduced without permission for educational purposes only. Excerpted or adapted material from this publication must include full citation of the source. To reproduce for any other purposes, a written request must be submitted to the Human Rights Center, University of Minnesota.

Permission is granted for non-governmental organizations and non-profit groups to translate into languages other than Arabic, French, and Spanish. The only conditions for other language versions are 1) that the language of the United Nations bodies appears in its entirety, 2) that no human rights are deleted, and 3) that the Human Rights Resource Center receive a) notification of intention to translate, b) a hard copy of the translation, and c) an electronic version of the translation and permission to make it available on its website and on [www.humanrightsyes.org](http://www.humanrightsyes.org).

University of Minnesota Human Rights Center  
229 19th Avenue South  
Minneapolis, MN 55455  
1-888-HREDUC8  
[humanrts@umn.edu](mailto:humanrts@umn.edu) <http://www.hrusa.org>

### About the Human Rights Education Series

The Human Rights Education Series is published by the University of Minnesota Human Rights Resource Center. Edited by Nancy Flowers, the series provides resources for the evergrowing body of educators and activists working to build a culture of human rights in the United States and throughout the world. Other publications in the series include:

**Human Rights Here and Now:**

Celebrating the Universal Declaration of Human Rights  
edited by Nancy Flowers

**Economic and Social Justice:**

A Human Rights Perspective  
by David Shiman

**Raising Children with Roots, Rights and Responsibilities:**

Celebrating the UN Convention on the Rights of the Child  
by Lori DuPont, Joanne Foley, and Annette Gagliardi

**Lesbian, Gay, Bisexual, & Transgender Rights:**

A Human Rights Perspective  
by David M. Donahue

**The Human Rights Education Handbook:**

Effective Practices for Learning, Action, and Change  
by Nancy Flowers

**Lifting the Spirit:**

Human Rights and Freedom of Religion or Belief  
by the Tandem Project and Human Rights Resource Center

**Cover Art:** Muhammad Al Malki.

# ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨ! ГАРЫН АВЛАГЫН АГУУЛГА

<b>Монгол хэвлэлд зориулсан өмнөх үг</b>	VII
<b>ӨМНӨТГӨЛ. НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссар Лоис Арбор</b>	VIII
<b>УДИРТГАЛ</b>	XIV
<b>ХЭСЭГ 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг ойлгох нь</b>	1
<b>ХЭСЭГ 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци</b>	<b>25</b>
Бүлэг 1. Адил тэгш байдал ба үл алагчлал	26
Бүлэг 2. Хүртээмж	40
Бүлэг 3. Нийгмийн болон улс төрийн амьдралд оролцох эрх	54
Бүлэг 4. Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө	67
Бүлэг 5. Амьд явах эрх болон эрсдэлт нөхцөлд хамгаалуулах эрх	78
Бүлэг 6. Эрүү шүүлт болон бусад хэлбэрийн хэрцгийллээс ангид байх эрх чөлөө	96
Бүлэг 7. Хувийн нууц, нэгдмэл байдал, орон гэр болон гэр бүлийг хүндэтгэх нь	113
Бүлэг 8. Эрүүл байх эрх	128
Бүлэг 9. Сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээ авах эрх	150
Бүлэг 10. Хөдөлмөрлөх эрх	164
Бүлэг 11. Амьдарч буй орчиндоо бие даан, нэр төртэй амьдрах эрх	176
Бүлэг 12. Шүүх ажиллагаанд хүртээмжтэй оролцох нь	189
Бүлэг 13. Сурч боловсрох эрх	198
Бүлэг 14. Соёл, спортын арга хэмжээнд оролцох эрх	213
Бүлэг 15. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрх	231
Бүлэг 16. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн тэгш эрх, үл алагчлал	249
Бүлэг 17. Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын бусад бүлгийн хүний эрх	265
<b>ХЭСЭГ 3. Нөлөөлөл. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа</b>	<b>278</b>
<b>ХАВСРАЛТ</b>	
<b>1. Хүний эрхийн баримт бичгүүд</b>	
• Хүний эрхийн түгээмэл тунхаглал (ХЭТТ) бүрэн эх.	294
• ХЭТТ-ын хялбаршуулсан эх	299
• ХЭТТ-ын тойм эх	303
• Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци	305
• Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци	331
• Хүний эрхийн хуулиудын жагсаалт	351
<b>2. Хүний эрхийн сургалт зохион байгуулах нь</b>	<b>352</b>
<b>3. Нэмэлт эх сурвалж материалын жагсаалт</b>	<b>362</b>
<b>4. Хөгжлийн бэрхшээл ба хүний эрхийн нэр томъёоны тайлбар толь</b>	<b>364</b>
<b>5. Сэдэвчилсэн индекс</b>	<b>373</b>

## ТӨСЛИЙН ТҮНШҮҮД

**Өөрчлөлтийн төлөө хамтдаа (Advocating Change Together)** байгууллага нь сэтгэцийн болон бусад төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгуулсан хүний эрхийн төрийн бус байгууллага юм. Энэ байгууллагын эрхэм зорилго нь янз бүрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нэгтгэн, ижил зорилгын төлөө ажиллаж байгаа иргэний нийгмийн болон хүний эрхийн байгууллагуудтай холбоо тогтооход нь туслах явдал юм.

**БлүЛо ХХК (Blue Law LLC)** нь цэргийн алба хааж байхдаа хөгжлийн бэрхшээлтэй болсон ахмад дайчдын байгуулсан олон улсын эрхзүй, хөгжлийн бодлогоор хуулийн зөвлөгөө өгдөг компани юм. Вашингтон хотод байрладаг энэ байгууллагын хүний эрх, хөгжлийн бэрхшээлийн баг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг олон улсын хөгжлийн бодлогод тусгах чиглэлээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага, олон улсын хүний эрхийн болон төрийн байгууллагуудтай хамтран ажилладаг.

**Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олон улсын байгууллага (DPI)** нь янз бүрийн төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үндэсний байгууллагуудыг нэгтгэсэн дэлхийн цорын ганц сүлжээ юм. Энэ байгууллагын зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүрэн дүүрэн оролцоо, хөгжих тэгш боломж, тэдний эдийн засгийн болон нийгмийн интеграци зэргийг хангах замаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалахын зэрэгцээ тэдний төлөөллийн байгууллагуудад дэмжлэг үзүүлэхэд оршино. 1981 онд үүссэн, одоо Канадын Сент Жоунс хотод байрладаг DPI нь 140 гаруй оронд гишүүн байгууллагатай болоод байна.

**Харвардын Хөгжлийн бэрхшээлийг судлах төсөл** нь Харвардын Их сургуулийн Хуулийн сургуулийн дэргэдэх эрхзүй, бодлого судлалын төв бөгөөд НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийг сурталчлах замаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралын нөхцлийг сайжруулах зорилготой. Энэ төв нь хөгжлийн бэрхшээлийн асуудлуудаар үндэсний засгийн газар, хүний эрхийн байгууллагуудад зөвлөгөө өгөх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэднийг төлөөлдөг олон улсын болон дотоодын байгууллагуудын чадавхийг бэхжүүлж хүний эрхийн сургалт явуулах, академик судалгаа хийх зэрэг үйл ажиллагаа явуулдаг. Харвардын хөгжлийн бэрхшээлийг судлах төсөл нь Нээлттэй Нийгэм Хүрээлэнгээс санхүүгийн дэмжлэг үзүүлсэнд талархаж байна.

**Миннесота мужийн Их сургуулийн Хүний эрхийн мэдээллийн төв** нь уг их сургуулийн Хүний эрхийн төвийн салшгүй нэг хэсэг бөгөөд хүний эрхийн сургалтын материал боловсруулж, цахим болон хэвлэмэл хувилбараар тараах, оюутан, багш, иргэний нийгмийн идэвхтнүүдийг хүний эрхийн чиглэлээр сургаж бэлтгэх, хүний эрхийн боловсролыг амьдрал дээр үр өгөөжтэй хэрэгжүүлэхэд нь туслах зорилгоор нөлөөллийн сүлжээ байгуулж дэмжих зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

## ТӨСЛИЙГ САНХҮҮЖҮҮЛЭГЧ

Катарын Доха хотын **Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн Шафалла төв** нь оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, тэдний гэр бүл, олон нийтэд цогц үйлчилгээ үзүүлдэг жишиг төв юм. Гэр бүлийн асуудлаарх Дээд зөвлөлийн тэргүүн, гүнж Моза Бинт Нассер Бин Абдулла Аль-Мисснэдийн санаачилсан Шафалла төв нь гэр бүл, хүүхдийн нийгэмд гүйцэтгэх чухал үүргийг хүндэтгэдэг гүнжийн итгэл үнэмшлийн тусгал юм. Төвд ажилладаг чадварлаг мэргэжилтнүүд нь хамгийн орчин үеийн үйлчилгээ, сургалтын тоног төхөөрөмжийг ашиглан суралцагсдад сурах, хөгжих, нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцоход нь тусалдаг. Шафалла төв нь хөгжлийн бэрхшээлтэй бүх хүний эрхийг хамгаалах чин эрмэлзэлтэй ажилладаг бөгөөд “Хүний эрхийн төлөө!” энэхүү сургалтын материалыг боловсруулж гаргахад үзүүлсэн сэтгэл харамгүй дэмжлэг нь энэхүү эрхэм зорилгодоо үнэнч байгаагийн илрэл юм.

## МОНГОЛ ХЭВЛЭЛД ЗОРИУЛСАН ӨМНӨХ ҮГ

Хүний эрхийг дээдлэх нь ардчилсан нийгмийн оршин тогтнох үндэс суурь юм. Тиймээс ч ардчилсан хөгжлийн замыг 20 жилийн өмнө эргэлт буцалтгүй сонгосон Монгол Улс хүний эрхийг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэн, баталгаажуулж байх нь нэн чухал.

Хүний эрхийн нэг гол зарчим бол хүний бие болон сэтгэл, соёлын болон нийгмийн ялгаанаас үл хамааран бүх хүнд адил тэгш нөхцөл боломж бий болгоход оршино. Гэтэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тэр бүр хүний эрхээ эдэлж чадахгүй байгаа нь нийгмийн шударга бус явдал юм. НҮБ-аас 2006 онд “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци” боловсруулан баталсныг Монгол Улс 2008 онд соёрхон баталснаар дээрх нийгмийн шударга бус байдлыг арилгах хүсэл эрмэлзэлтэй байгаагаа илэрхийлсэн юм.

Хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах хандлагыг төлөвшүүлэхэд хууль тогтоомж баталж гаргахаас гадна мөн олон нийт, бодлого шийдвэр боловсруулагч болон хэрэгжүүлэгч, үйлдвэрлэл болон үйлчилгээ эрхлэгчид зохих ойлголт, мэдлэгтэй байх нь чухал. Иймээс ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тусгай хэрэгцээг бүх нийтэд ойлгуулах зорилгоор Миннесота мужийн Их сургуулийн Хүний эрхийн мэдээллийн төвөөс боловсруулсан энэхүү гарын авлагыг бид эх хэлнээ орчуулан гаргалаа. Гарын авлага нь хүний эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, хүний эрхийн багш, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүний эрхийн мэдлэгээ дээшлүүлэх, бусдад зааж сургахад нь тус дөхөм үзүүлэх практик хэрэглэгдэхүүн болно гэж найдаж байна.

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал  
П.Эрдэнэжаргал



# ХҮНИЙ ЭРХИЙН ДЭЭД КОМИССАРЫН ӨМНӨТГӨЛ ҮГ



OFFICE OF THE HIGH COMMISSIONER FOR HUMAN RIGHTS

Өнөөдөр арван хүн тутмын нэг нь хөгжлийн бэрхшээлтэй амьдарч байна. Тэдний дунд ядуу зүдүү, нийгмээс тусгаарлагдсан хүн олон байгаагийн дээр тэдний эрх нь зөрчигдөх явдал их гарч байна. Олон хүн эдлэх эрхээ мэддэггүй, тэгш бус байдалтай тэмцэх, улмаар эерэг өөрчлөлтийг авчрахад нь дэм болох боломжууд байгааг мэдэхгүй өнгөрч байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци, түүний Нэмэлт Протокол бол нийгэмд оршсоор байгаа таагүй нөхцөл, хандлагыг өөрчлөх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрхээ шаардахад туслах арга хэрэгсэл юм. Одоо энэхүү шинэ конвенцийг өөрийн оронд авчран, хүмүүст хүргэх цаг ирээд байгаа бөгөөд “Хүний эрхийн төлөө!” гарын авлага нь бидэнд энэхүү зорилтоо ажил хэрэг болгоход нэн тустай хэрэглэгдэхүүн болж чадна гэдэгт би итгэлтэй байна.

Сургалтын энэхүү хөтөлбөр нь маш энгийн, ойлгомжтой гарын авлага хэлбэрээр боловсруулагдсан ба хүний эрхийн идэвхтнүүдэд сургалт, сурталчилгааны ажилдаа ашиглаж болох чухал эх сурвалж болох юм. Агуулгыг үндсэн гурван хэсэгт хувааж танилцуулахдаа хөгжлийн бэрхшээлийг хүний эрхийн үүднээс тайлбарлах, конвенцийн эрхийг нэг бүрчлэн тайлбарлах, цаашдын нөлөөллийн болон эрхээ хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх гэсэн асуудлуудад анхаарсан бөгөөд шинээр гарсан конвенцид тухайлан төвлөрөхийн зэрэгцээ хүний эрхийн ерөнхий тогтолцоог бүрдүүлж байгаа бусад хууль, туршлагауудыг хамруулан хүний эрхийн бүхий л асуудлыг цогцоор нь тусгаж чадсан юм. Өдөр тутмын амьдрал дээр хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүндэтгэх хандлага төлөвшүүлэх зорилтыг хичээл нэг бүрт шингээж өгсөн нь онцгой чухал ач холбогдолтой юм. Материалыг бүлгээр зохион байгуулсан тул бүрэн хөтөлбөрөөр урт хугацааны сургалт хийх үү, эсвэл хүний эрхийн тодорхой асуудлаар богино сургалт хийх үү гэдгээ сургагч багш өөрөө шийдэх боломжтой.

“Хүний эрхий төлөө!” гарын авлага шиг сургалтын хөтөлбөрөөр дамжуулан олгодог хүний эрхийн боловсрол нь хувь хүн, хамт олныг бэхжүүлэх, чадавхийг нь хөгжүүлэх чухал алхам болдог. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний төлөөллийн байгууллагууд нь олж авсан мэдлэгээ ашиглан алагчлал, ялгаварлан гадуурхалтай тэнцэх, урьдчилан сэргийлэх зорилготой нөлөөллийн ажлаа эрчимжүүлж болно. Мөн мэдлэг мэдээлэлд тулгуурласан нөлөөллийн ажлаараа дамжуулан бид эрхзүйн болон бодлогын шинэчлэл хийхэд шаардлагатай төр засгийн хүсэл зоригийг дайчилж, чадавхийг бэхжүүлж чадна. Энэхүү сургалтын хөтөлбөр нь өргөн олон нийтэд хүний эрхийн тухай мэдлэг олгохын зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн амьдралд өөрийн хувь нэмрээ хэрхэн оруулж байгаа, оруулж чадах тухай ойлголт, мэдлэг өгснөөрөө шударга, хүмүүнлэг нийгэм байгуулах зорилтод хувь нэмэр болж байгаа юм.

“Хүний эрхий төлөө!” гарын авлага нь хүний эрхийн боловсролын сурвалж материалуудын дотор заавал байх ёстой нэгэн чухал хэрэгсэл болж нэмэгдэж байгаа бөгөөд түүний өмнөтгөл үгийг бичиж байгаадаа би баяртай байна. Энэхүү санаачилгыг хэрэгжүүлсэн зохиогчид, дэмжсэн ивээн тэтгэгчдэд баяр хүргээд, гарын авлагыг өргөнөөр ашиглана гэж найдаж байгаагаа илэрхийлье.

A handwritten signature in black ink, appearing to read "Lois Arbour".

Лоис Арбор

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн дээд комиссар



## ХЯНАН ТОХИОЛДУУЛАГЧ

**Ненси Флауэрс** нь зохиолч, редактор, хүний эрхийн төлөө тэмцэгч юм. Тэрээр АНУ-ын Амнести Интернешнл байгууллагын сургалтын хөтөлбөрийг боловсруулсан бөгөөд “АНУ дах хүний эрх” байгууллагыг үндэслэгчдийн нэг юм. Түүний сүүлийн үеийн бүтээлүүдэд *Компасито: Хүүхдүүдэд зориулсан хүний эрхийн боловсролын гарын авлага* (Европын зөвлөл, 2007), *Орон нутгийн түвшинд нөлөөлж глобал түвшинд өөрчлөлт хийе: Хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхийн сургалт* (Парадигм Пресс, 2007) багтана. Тэрээр төрийн ба төрийн бус байгууллага, НҮБ-ын агентлагуудад зөвлөх үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ Миннесота мужийн Хүний эрхийн мэдээллийн төвийн “Хүний эрхийн боловсрол” цувралын эмхэтгэгчээр ажиллаж байна.

## ЗОХИОГЧИД

**Жоел Бальф** нь хөгжлийн бэрхшээл, нийгмийн эрүүл мэнд, хүний эрхийн эрхзүй зэрэг олон чиглэлээр арвин практик туршлагатай бие даасан зөвлөх юм. Тэрээр төрийн бус байгууллагуудын хүний эрхийн сургалтын хөтөлбөр, материалуудыг боловсруулж, үндэсний болон олон улсын нөлөөллийн кампанит ажлуудыг удирдан хэрэгжүүлж байсан. Ж.Бальф нь НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг боловсруулах явцад төрийн болон төрийн бус байгууллагад нөлөөллийн болон мэргэжлийн дэмжлэг үзүүлж ажилласан. Тэрээр дүн шинжилгээ, харилцаа, нөлөөлөл, мэдээлэл боловсруулах чиглэлээр хувийн болон олон нийтийг төлөөлсөн хувь хүн, байгууллага, агентлагуудад зөвлөж ажилладаг.

**Катрин Гернсей** нь төрийн захиргаа, хүний эрх, хөгжлийн бэрхшээл, олон улсын хөгжлийн бодлогоор мэргэшсэн хуульч юм. Тэр Дэлхийн Банк, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олон улсын байгууллагад зөвлөгөө өгөхийн зэрэгцээ Америкийн Их сургуулийн Олон улсын харилцааны сургуульд хүний эрхийн хичээл заадаг. К. Гернсей нь НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг боловсруулах явцад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олон байгууллага, төрийн төлөөлөгчдөд хуулийн зөвлөгөө өгч байсан бөгөөд одоо Конвенцийг соёрхон батлах, хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж байна. Тэр Төв болон Өмнөд Америк, Африк, Европ, Ази, Ойрх Дорнодод хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах төсөл, хөтөлбөр санаачлан хэрэгжүүлсэн.

**Валери Карр** нь тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр олон жил ажиллаж арвин туршлага хуримтлуулсан бөгөөд ЮНЕСКО-ийн тэгш хамруулах боловсролын хөтөлбөр гэх мэт олон улсын боловсролын төсөл, хөтөлбөр гардан хэрэгжүүлсэн туршлагатай мэргэжилтэн юм. Одоогоор Колумбийн Их сургуулийн Багшийн коллежид докторын зэрэг горилох хөтөлбөрт суралцаж байгаа В.Карр нь хөтөлбөрийн тоон болон чанарын дүн шинжилгээний аргууд, үүний дотор төсөл, хөтөлбөрийн үнэлгээ, үр дүнг хэмжих стратеги, шалгуур үзүүлэлт боловсруулах асуудлыг сонирхон судалж байна.

**Жанет Лорд** нь олон улсын эрхзүй, хөгжлийн асуудлаар ажилладаг БлүЛо компанийн эздийн нэг, Марилендийн Их сургуулийн Хуулийн сургуулийн профессор юм. Хүний эрхийн боловсролоор 10 гаруй жил ажилласан Ж.Лорд дэлхийн олон улсад хүний эрхийн сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлсэн бөгөөд хамгийн сүүлд Йемен, Египет, Либерид ажиллаад ирсэн. Тэрээр НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг бэлтгэх бүх хэлэлцээрт оролцож, гэрээний эхийг найруулах, эрхзүйн ба техникийн эдрээтэй асуудлаар иргэний нийгэм, төрийн төлөөлөгчдөд зөвлөгөө өгч ажилласан. Хүний эрхийн олон улсын эрхзүй, хөгжлийн бэрхшээлийн асуудлаар мэргэшсэн ахлах зөвлөх Лорд нь НҮБ-ын Хүний эрхийн Дээд комиссарын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, АНУ-ын Хөгжлийн бэрхшээлийн асуудлаарх үндэсний зөвлөл, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олон улсын байгууллага, IFES зэрэг байгууллагад хүний эрхийн төсөл, хөтөлбөр боловсруулахад тусалж байсан туршлагатай.



## ТАЛАРХАЛ

“Хүний эрхийн төлөө!” гарын авлагыг боловсруулах болсон сэдэл, зорилго нь НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг бичиж, батлахад хүргэсэн зорилго, эрмэлзэлтэй агаар нэг юм. 1999 онд НҮБ-ын ивээл доор Хонг Конгод зохион байгуулсан бага хурлаар конвенцийг боловсруулах, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг тусгайлан авч үзсэн хүний эрхийн сургалтын материал гаргах санаа төрсөн. Энэ санаачилгын хүрээнд хүний эрхийн олон сургалт зохиогдсоны хажуугаар анх Хонг Конгод гарсан санааны дагуу Конвенцийн бүтэц, найруулгад тулгуурлан сургалтын материал ч боловсруулагдсан юм.

Бидний үзэл санааг бодит ажил болгоход Катар улсын Доха хотод байрладаг “Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн Шафалла төв” сэтгэл харамгүй дэмжин тусалсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн асуудлаар боловсрол олгох зорилгыг чин сэтгэлээсээ дэмжсэн Шафалла төвийн захирал Хассан Али Бин Алигийн чадварлаг манлайллын дор манай төсөл хэрэгжин, энэ гарын авлага дөрвөн хэл дээр ном, CD болон цахим хэлбэрээр гарч өргөн олон нийтийн хүртээл болоод байна. Уг төслийн албан ёсны нээлтийг 2007 онд Катарын Доха хотод болсон Шафаллагийн Хоёрдугаар Бага хурлын үеэр хийсэн билээ. Мөн төслийн үйл ажиллагааны зохицуулалтыг хийж, шаардлагатай бүхий л дэмжлэгийг үзүүлж байсан Том Койн, Доминик Койн нарт талархал илэрхийлье. Хавтасны чимэглэлд ашигласан зургийг Катарын 14 настай зураач хүү Мухаммад Аль Малки хандивласан юм.

Төслийн олон түнш, дэмжигчийн тусламжтайгаар л энэ ажил бодитой үр дүнд хүрснийг тэмдэглээд гарын авлагын зохиогч, эмхэтгэгч бид дараах байгууллага, хувь хүмүүст талархал илэрхийлж байна:

- **Өөрчлөлтийн төлөө хамтдаа (Advocating Change Together)** байгууллага нь өөрсдийн боловсруулсан хүний эрхийн сургалтын материалаас хуваалцаж, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн хялбаршуулсан эхийг боловсруулахад тусалсан. Мери Кей Кеннеди, Брет Несла нарыг онцгойлон дурьдаж, талархал илэрхийлье.
- **Блү Ло (Blue Law)** компанийн Жефф Волкер нь бидэнд байнга урам өгч, дэмжин туслахад хэзээд бэлэн байсан бөгөөд энэ байгууллагын хамт олон, ялангуяа Трейси Энтон, Жастин Баксли, Волт Бёрнс, Сет Ковелл, Ховарт Фентон, Судхир Махара, Жоу Мей, Дейв Прончин нарын дэмжлэгийг дурьдах ёстой.
- **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олон улсын байгууллага (Disabled Peoples' International буюу DPI)** нь НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн конвенцийг боловсруулах үеэр бидэнд байнга тусалж байв. ХБХОУБ-ын Удирдах зөвлөлийн дарга асан Венус Илаган нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах нөлөөллийн ажлыг хүний эрхийн сургалттай холбох саналыг бүр 1999 оны Хонг Конгийн уулзалтын үеэр гаргасан анхдагчдын нэг, гарын авлагын анхны туршилтуудад идэвхтэй оролцсон хүн юм. Өөрийн төрөлх Филлиппин болон дэлхий даяар хийж ирсэн түүний ажил нь хүний эрхийг хамгаалах нөлөөлөл, сургалтын үйл ажиллагааны шилдэг жишээ, туршлага болдог. ХБХОУБ-ын Гүйцэтгэх захирал Мери Эннис нь гарын авлага боловсруулах ажлын явцыг урам зориг, хичээл зүтгэлтэйгээр удирдан чиглүүлж, сургалтын материалыг хэсэг бүлгүүдийг Нью Йорк дах НҮБ-ын ажлын алба дээр, мөн Перугийн Лима хотод болсон бүсийн уулзалт, 2007 оны 9 дүгээр сард Өмнөд Солонгосын Сөүл хотод болсон ХБХОУБ-ын Дэлхийн ассамблейн үеэр турших боломжийг олгосон юм. Эдгээр уулзалт, хэлэлцүүлэгт оролцож үнэтэй зөвлөмж, бүтээлч санаагаа нэмэрлэсэн хүн бүрт бид тусгайлан талархал илэрхийлж байна. ХБХОУБ-ын хүний эрхийн мэргэжилтэн Стив Эслей, манай төслийг анхнаас нь дэмжиж ирснийг мөн тэмдэглэх хэрэгтэй. ХБХОУБ-ын Удирдах зөвлөлийн шинэ даргаар томилогдож буй Вильфредо Гусманы бидэнд үзүүлсэн дэмжлэг, мөн Латин Америк, Карибын тэнгисийн бүс нутагт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах олон ажил санаачлан

хэрэгжүүлсэнд нь бид талархалтай байдгаа илэрхийлээд, ХБХОУБ-ын Удирдах зөвлөлийн гишүүний албыг хашиж байсан болон одоо хашиж байгаа бүх хүнд талархал илэрхийлье. Гарын авлагын төслийг Сөүл хотод хуралдсан ХБХОУБ-ын Дэлхийн ассамблейн үеэр турших ажилд тусалсан доктор Кристан Парк, доктор Ик-ли, Жозеф Жүүн болон үнэтэй санал нэмэрлэсэн ассамблейн бүх оролцогчид талархал илэрхийлье.

- **Харвардын Хөгжлийн бэрхшээлийг судлах төсөл** нь төслийн түнш, хамтран ажиллагч байж, гар бичмэлд санал өгөх, туршилтын ажлын аргагүй, хэрэглэгдэхүүнүүдийг боловсруулах, туршилтыг зохион байгуулж хэрэгжүүлэх зэрэгт мэргэжлийн тусалцаа үзүүлээд зогсохгүй бүхэлдээ маш хариуцлагатай хандан бидэнд заавар, зөвлөгөө өгч байсанд талархаж байна. Ялангуяа төслийн Гүйцэтгэх захирал Майкл Стайн, Харвардын Хуулийн сургуулийн орлогч захирал Вилльям Альфорд, Харвардын Хуулийн сургуулийн Зүүн Азийн эрхзүйн судалгааны төвийн Пенелопа Стайн нарт чин сэтгэлээсээ гүнээ талархаж байна.
- **Миннесота мужийн Их сургуулийн Хүний эрхийн төв** нь энэ төслийн онцгой нэгэн түнш байв. Төслийг эхлүүлэх хэд хэдэн удаагийн амжилтгүй оролдлого, дараа нь конвенцийн нөхцлийг хэлэлцэх үеэр үүссэн зогсонги байдал зэргээс болж гарын авлагыг боловсруулах цаг хугацаа богиноссоор байхад ч Кристи Рудилиус-Палмер нь бидний ажлын амжилтад эргэлзэж байгаагүй юм. Уулзаж ярилцах, дэмжлэг үзүүлэхэд хэзээд бэлэн байсан тэрбээр энэ төсөлд өөрийн цаг, хүний эрхийн тухай мэдлэг туршлагаа харамгүй хандивласан. Рима Реда нь хэвлэлийн дизайн, зураг чимэглэлийн нарийн түвэгтэй олон асуудлаар манай төслийн багтай уйгагүй ажиллаж, гарын авлагын дизайныг гойд сайхан болгож өгсөн хүн юм. Патрик Финнеган, Жон Коломбо нар нь хэвлэлтийн өмнө эх бичвэрийг шүүн, ишлэлүүдийг нягтлах ажлыг нягт нямбай гүйцэтгэсэн.

НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газрын Саймон Волкер оновчтой шүүмж, мэргэн санаа нэмэрлэж байсанд гүнээ талархаж байна. Мөн төсөлд дэмжлэг үзүүлж байсан НҮБ-ын Эдийн засаг, соёлын хэлтсийн ажилтан Акико Ито, Томас Шиндлмайер нарт талархал илэрхийлье.

Америкийн Их сургуулийн Жули Мертус, түүний бичсэн “*Орон нутгийн түвшинд нөлөөлж глобал түвшинд өөрчлөлт хийе: Хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхийн сургалт*” ном нь манай төслийн ажлыг чиглүүлэн залсан чухал хэрэглэгдэхүүн болсныг дурьдаад талархал илэрхийлье. Түүний идэвх зүтгэл, мэдлэг туршлагын ачаар энэ ном бодит ажил болж чадсан юм. Мөн 2007 онд Балтимор хотод зохион байгуулсан найруулан бичих семинарын үеэр маш сайн эх бичиж бидний ажлыг хурдацтай урагшлуулж өгөхийн хажуугаар судалгааны туслахын үүргийг гүйцэтгэсэнд талархаж байна.

Хүний эрхийн боловсролын чиглэлээр хуримтлуулсан мэдлэг, туршлага, боловсруулсан сургалтын материалаа бидэнтэй хуваалцахын зэрэгцээ сэтгэл санааны дэмжлэг үзүүлсэн олон найз, түнш, хамтрагч нартаа талархаж байна. “Аксесс Ливинг” байгууллагын (Access Living) Теодор Андерсон, Марко Бристо нар; Нью Йоркийн Браун Ллойд Жеймсийн баг; Австралийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс” байгууллагын Филип Френч; Хөгжлийн бэрхшээлийн асуудлаарх үндэсний зөвлөлийн Жоан Дюрочер; Эквадор улсаас АНУ-д суугаа элчин сайд Луис Галлегос; Йелийн Их сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн Нора Гроус; Марилендийн Их сургуулийн Хуулийн сургуулийн Дайан Хоффман; Вашингтон мужийн Их сургуулийн Хуулийн сургуулийн Пол Стефен Миллер; Америкийн Их сургуулийн Даян дэлхийн энх тайвны төвийн Кэрол О’Лиери, Бетти Ситка нар; Галбей Их сургуулийн эрхзүйн тэнхмийн Жерар Квин; Нью Йорк хотын Винстон фон Лихтенштейн; Вашингтон хотын Жон Вест болон бидний эцэг эх Брюс ба Донна Бальф, Тим ба Пэт Гернсей, Вилли ба Кетти Карр, Пегги Лорд нарт талархал илэрхийлье.

“Хүний эрхийн төлөө!” гарын авлагын редакцийн багт гүн талархал илэрхийлье. Маш их ажлынхаа хажуугаар тэд гарын авлагын хэсэг бүлэг бүрийг уншиж хянах цаг гаргаж, хөгжлийн бэрхшээл болон хүний эрхийн асуудлуудаар хуримтлуулсан арвин туршлага, баялаг мэдлэгтээ тулгуурлан



оновчтой шүүмж өгч байсан юм. Энэ багийн ахлагчаар Харвардын Хөгжлийн бэрхшээлийг судлах төслийн Майкл Стайн ажиллаж, гар бичмэлд бүхэлд нь болон зохиогч бүрийн хариуцсан хэсгүүдийн найруулгыг хянасан юм. Гарын авлагын эцсийн найруулга болон гарсан байж мэдэх алдаануудыг зохиогч бид бүрэн хариуцна.

## **“Хүний эрхийн төлөө” гарын авлагын редакцийн баг**

**Майкл Стайн**, багийн ахлагч, Харвардын Хөгжлийн бэрхшээлийг судлах төсөл

**Анн Хайес**, USAID-ийн IWID хөтөлбөрийн судлаач

**Тересия Деженер**, Бочум Их сургууль

**Жоан Дюрочер**, АНУ-ын Хөгжлийн бэрхшээлийн асуудлаарх Үндэсний зөвлөл

**Алисон Хиллман**, Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах олон улсын байгууллага

**Робин Хант**, Шинэ Зеландын Хүний эрхийн комисс

**Роузмари Кайес**, Нью Саут Вейлсийн Их сургууль

**Шарлотт Макклейн-Нхлапо**, Дэлхийн Банкны групп

**Жери Миндес**, Америкийн судалгааны хүрээлэн

**Пат Мориссей**, Танин мэдэхүйн хөгжлийн бэрхшээлийн асуудлаарх агентлаг, АНУ-ын Эрүүл мэнд, төрийн үйлчилгээний департамент

**Стефани Ортолева**, Ардчилал, хүний эрх, хөдөлмөрийн хэлтэс, АНУ-ын Төрийн департамент

**Эрик Розенталь**, Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах олон улсын байгууллага

**Элис Рой**, хүний эрхийн өмгөөлөгч

**Марша Сакстон**, Хөгжлийн бэрхшээлийн дэлхийн институт

**Эли Вольф**, Спорт болон нийгэм судлалын төв, Зүүнхойд бүсийн Их сургууль

Энд дурьдагдсан бүх хүн, байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах чиглэлээр олон улсын хэмжээнд хийж байгаа нөлөөлөл, сургалт боловсролын ажлын тань төлөө гүн талархал илэрхийлье.

*Жанет Лорд, Катрин Гернсей, Жоел Бальф, Валери Карр, Ненси Флауэрс нар  
Мариленд мужийн Балтимор хот,  
2007 он*



## УДИРТГАЛ

### **“Хүний эрхийн төлөө!” гарын авлагын зорилго**

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2006 онд баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци (ХБХЭК) нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалагч бүх хүнд нэг талаас таатай боломж нээж өгсөн ч, нөгөөтэйгүүр тодорхой сорилыг бас авчирсан билээ. Энэхүү конвенци нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг заавал дагаж мөрдөх олон улсын гэрээ болгож баталгаажуулахын зэрэгцээ шийдвэрлэвэл зохих олон чухал асуудлаар байр сууриа нэгтгэн нөлөөллийн ажил явуулах боломж нээж өгсөн. Харин дэлхий даяар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгэмдээ хүндтэй байр суурь эзэлж, биеэ даан амьдрах боломжоо баталгаажуулахын тулд тэд өөрсдөө эрхээ мэддэг, хэрэгжүүлэхийг шаарддаг болох ёстой тул ХБХЭК-иор өргөн хүрээтэй сургалт, сурталчилгааны ажил явуулах шаардлага гарч ирсэн нь гол сорил юм.

### **“Хүний эрхийн төлөө!” гарын авлагыг ашиглах нь**

Энэхүү гарын авлага нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудалд санаа тавьдаг хэн бүхэнд хүсэл зориг, мэдлэг чадвараа бусадтай хуваалцах чадавхитай хүний эрхийн сургагч, нөлөөллийн ажилтан болоход нь туслах зорилготой юм. Гарын авлагыг боловсруулахдаа олон байгууллага, сургагч багшийн туршлагаас санаа авч, тэдний хэрэглэсэн үр дүнтэй нөлөөллийн ажлын жишээ, оролцоонд суурилсан дасгал ажлуудаас шигшин орууллаа.

Хүний эрхийн сургалтын бусад материалын нэгэн адил энэхүү “Хүний эрхийн төлөө!” гарын авлага нь уншихад хялбар, хэрэглэхэд төвөггүй, хувилж олшруулахад амар, бодит амьдралд тусган ойлгоход дөхөмтэй учир нэг талаас унших материал, нөгөө талаас мөн сурах бичиг болж чадах юм. Энэ гарын авлагын бүлэг, хэсэг бүр нь бие даасан шинжтэй тул уншигч өөрийн хэрэгцээгээр хэсэгчлэн ашиглах боломжтой. Нэр томъёонуудыг тод үсгээр онцолж, гарын авлагын эцэст тодорхойлолтыг нь хавсаргав.

“Хүний эрхийн төлөө!” гарын авлагын хэл найруулга, дизайныг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ашиглахад хялбар байх талаас нь бодолцож хийсэн онцлогтой. Гэхдээ тусгай хэрэгцээт уншигчдад тохируулан өөрчлөх шаардлага гарна гэдгийг бид мөн удаа дараа сануулсан байгаа. Гарын авлагыг ашиглахдаа зорилтот бүлэг, оролцогчдын хэрэгцээнд мэдрэмжтэй хандаж, хүн нэг бүрийн бүрэн дүүрэн оролцоог хангахуйц байдлаар анги танхимын орчин, сургалтын үйл ажиллагаа болон харилцааны арга хэрэгслүүдээ зохицуулан өөрчилж байхыг сургагч багшид зөвлөж байна. Уг гарын авлагын “Хүний эрхийн сургалт зохион байгуулах нь” нэртэй Хавсралт 2-оос (хуудас 352) сургагч багшид зориулсан дэлгэрэнгүй мэдээллийг үзнэ үү.

**Хэсэг 1** буюу “Хөгжлийн бэрхшээлийг хүний эрхийн үүднээс харж ойлгох нь” хэсэгт хүний эрх болон хөгжлийн бэрхшээлийг холбон ойлгоход туслах үндсэн зарчмуудыг тодорхойллоо. Энэ хэсэгт хүний эрхийг хангаж хэрэгжүүлэх үүргийг хэн хүлээдэг тухай товч өгүүлээд, НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг

танилцуулав. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлийн талаарх бидний зарим хандлага, ойлголт нь хүний эрхийн хэрэгжилтэд саад тотгор үүсгэж мэдэх тухай дурьдаад, хөгжлийн бэрхшээлийг хэрхэн тодорхойлж, судалж ирснийг шинжилж үзсэн байгаа. Эцэст нь, хөгжлийн бэрхшээлд хүний эрхийн байр сууринаас хандах хандлагыг танилцуулаад, хөгжлийн бэрхшээл, хүний эрх, үр дүнтэй нөлөөллийн үйл ажиллагаа зэргийг уялдаа холбоотой тайлбарлав.

**Хэсэг 2** буюу “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци” хэсэгт уг конвенцийн арван долоон бүлэгт багтсан эрхийг цогцоор нь шинжилж тайлбарлалаа. Энэ хэсгийн бүлэг тус бүрт ХБХЭК-д заасан тодорхой нэг багц эрхийг сонгон авч, дотор нь багтсан эрхийг энгийн хялбар байдлаар тайлбарласны дараа суралцагчдад сурсан зүйлээ бататган тодорхой нөхцөлд тохируулан өөрийн үгээр илэрхийлэх, нөлөөллийн ажлаа үр дүнтэй хэрэгжүүлэх талаар бүтээлчээр сэтгэхэд нь туслах дасгалуудыг багтаав. Түүнчлэн нөлөөллийн стратегийн зарим жишээ, ашиглаж болох тоо, баримт, сэдэвчилсэн нэмэлт мэдээллийг бүлэг тус бүрт орууллаа. Бүлгийн эцэст тухайн сэдэвтэй холбоотой нэмэлт эх сурвалжийг жагсаалаа.

Бүлэг 1.	Адил тэгш байдал ба үл алагчлал .....	26
Бүлэг 2.	Хүртээмж.....	40
Бүлэг 3.	Нийгмийн болон улс төрийн амьдралд оролцох эрх.....	54
Бүлэг 4.	Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө .....	67
Бүлэг 5.	Амьд явах эрх болон эрсдэлт нөхцөлд хамгаалуулах эрх .....	78
Бүлэг 6.	Эрүү шүүлт болон бусад хэлбэрийн хэрцгийллээс ангид байх эрх чөлөө .....	96
Бүлэг 7.	Хувийн нууц, нэгдмэл байдал, орон гэр болон гэр бүлийг хүндэтгэх нь .....	113
Бүлэг 8.	Эрүүл байх эрх .....	128
Бүлэг 9.	Сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээ авах эрх .....	150
Бүлэг 10.	Хөдөлмөрлөх эрх.....	164
Бүлэг 11.	Амьдарч буй орчиндоо бие даан, нэр төртэй амьдрах эрх.....	176
Бүлэг 12.	Шүүх ажиллагаанд хүртээмжтэй оролцох нь.....	189
Бүлэг 13.	Сурч боловсрох эрх .....	198
Бүлэг 14.	Соёл, спортын арга хэмжээнд оролцох эрх .....	213
Бүлэг 15.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрх .....	231
Бүлэг 16.	Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн тэгш эрх, үл алагчлал.....	249
Бүлэг 17.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын бусад бүлгийн хүний эрх.....	265

**Хэсэг 3** буюу “Нөлөөлөл! Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа” хэсэгт хүний эрхийг хамгаалах нөлөөллийн ажилд дэм болох эрхээ мэддэг байх, өөрийгөө мэддэг байх, үйлдэл хийх гэсэн зарчмуудыг тайлбарлав. Энэ хэсэгт мөн нөлөөллийн үйл ажиллагааны зарим жишээ, загварын зэрэгцээ нөлөөллийн ажлыг төлөвлөх дасгал ажлуудыг оруулж өглөө. Нөлөөллийн ажлыг үндсэн зургаан алхмаар гүйцэтгэж болохыг энэ бүлэгт тайлбарласан бөгөөд үүнд:

Алхам 1: Хийхийг хүсэж буй өөрчлөлтөө тодорхойлох

Алхам 2: Хийхийг хүсэж буй өөрчлөлтөө томъёолох





Алхам 3: Үйлдэл хийхэд бэлдэх

Алхам 4: Үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах

Алхам 5: Үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх

Алхам 6: Үнэлгээ дүгнэлт, дараагийн алхам зэрэг юм.

**Хавсралт** хэсэгт нэмэлт эх сурвалжуудыг оруулсан ба үүнд:

- **Хавсралт 1. Хүний эрхийн баримт бичгүүд:** Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн бүрэн эх ба *тэдгээрийн хялбаршуулсан болон тойм эх*, хүний эрхийн гол баримт бичгүүд, **тэдгээрийн веб хаяг**
- **Хавсралт 2. Хүний эрхийн сургалт зохион байгуулах нь:** Сургалтын идэвхтэй аргуудыг ашиглан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээнд нийцсэн сургалт зохион байгуулах тухай заавар зөвлөгөө, мөн сургалт семинарын үлгэрчилсэн загвар
- **Хавсралт 3. Нэмэлт эх сурвалж:** Хэвлэмэл, цахим болон бусад хэлбэрээр олдох боломжтой чухал эх сурвалжууд
- **Хавсралт 4. Нэр томъёоны тайлбар толь:** гарын авлагад дурьдагдсан нэр томъёонуудын тодорхойлолт, тайлбар
- **Хавсралт 5. Сэдэвчилсэн индекс:** гарын авлагын үндсэн ухагдахуунуудын жагсаалт



# ХЭСЭГ 1.

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ОЙЛГОХ НЬ



### НЭГДҮГЭЭР ХЭСГИЙН АГУУЛГА

Эхлэл: хүний эрхийн тухай эргэцүүлэх нь . . . . .	4
Хүний эрхийн эрхзүйн хүрээ . . . . .	9
Хүний эрхийн хэрэгжилтийг хэн хариуцах ёстой вэ? . . . . .	10
НҮБ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци . . . . .	12
Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай бүс нутгийн конвенциуд . . . . .	15
Хөгжлийн бэрхшээлийн талаарх заавал дагаж мөрдөх албагүй чухал баримт бичгүүд . . . . .	15
Хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох, судлах нь . . . . .	17
Хөгжлийн бэрхшээлийн талаарх нийтлэг хандлага, түгээмэл ойлголт . . . . .	20
Хөгжлийн бэрхшээлийн асуудалд хүний эрхийн байр сууринаас хандах нь . . . . .	21
Хүний эрхийг хамгаалах нөлөөллийн үйл ажиллагаа . . . . .	24



# ХЭСЭГ 1.

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ОЙЛГОХ НЬ

### ЗОРИЛТУУД

Энэ бүлэг нь оролцогчдод дараах сэдвээр мэдлэг, ойлголтыг өгч, улмаар уг гарын авлагыг илүү үр өгөөжтэй ашиглахад нь оролцогчдод туслах зорилготой:

- Хүний эрхийн үндсэн зарчмууд
- Хүний эрхийн олон улсын эрхзүйн хүрээ, түүний дотор ХБХЭК болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тухай эрхзүйн бусад баримт бичгүүд
- Эрхээ эдлэхэд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгардаг нийтлэг саад, бэрхшээл
- Асуудал, нөлөөллийн стратегийг хүний эрхийн байр сууринаас хэрхэн тодорхойлох, илэрхийлэх.

### ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ТУХАЙ УДИРТГАЛ

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх нь бусад хүмүүсийнхээс огт ялгаагүй. Гэвч эдгээр эрхээ бусадтай адил тэгш эдлэхэд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нийгэм ба эрхзүйн хүрээний, эсвэл практик түвшний олон саад тулгардаг. Эдгээр нь ихэвчлэн хөгжлийн бэрхшээлийн талаар нийгэмд тогтсон буруу ойлголт, сөрөг хандлагаас улбаатай байдаг.

### ДАСГАЛ 1: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар нийгэмд тогтсон буруу ойлголт, хэвшмэл үзлийн уршиг

<b>Зорилт:</b>	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар нийгэмд тогтсон буруу ойлголт, хэвшмэл үзлээс үүдсэн ялгаварлан гадуурхлын бодит жишээнүүдийг гаргаад, эдгээр нь хүний эрхээ эдлэхэд хэрхэн нөлөөлж байгааг хэлэлцэх
<b>Хугацаа:</b>	45 минут
<b>Хэрэглэгдэхүүн:</b>	“Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар нийгэмд тогтсон буруу ойлголт, хэвшмэл үзэл” материалыг ашиглаж болно

#### 1. Танилцуулах

Ялгаварлан гадуурхал нь ихэнхдээ нэг бүлэг хүн нөгөөгийнхөө талаар буруу ойлголт, хэвшмэл үзэлтэй болсноос үүсдэг тухай тайлбарла. Эдгээр буруу ойлголт, хэвшмэл үзэл нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өдөр тутмын амьдралд хэрхэн нөлөөлдгийг энэ дасгалаар авч үзэх болно.

## 2. Санал солилцох/шинжлэх

Оролцогчдыг жижиг багуудад хуваагаад, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар нийгэмд тогтсон буруу ойлголт, хэвшмэл үзлүүдийг жагсааж бичих даалгавар өг. Багаараа дараах асуултуудыг хэлэлц:

- Эдгээр үзэл бодол нь юунаас үүдэлтэй байж болох вэ (айдас, соёлын юмуу шашны үзэл баримтлал, үнэн бодит мэдээлэл дутсанаас гэх мэт)?
- Дээрх хэвшмэл үзэл, ойлголтууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нийгмийн болон тэдний гэр бүлийнхэн хэрхэн хандаж байгаа, хэрхэн харьцаж байгаа, эсвэл хууль, бодлогуудад хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудлыг хэрхэн тусгаж байгаад ямар нөлөө үзүүлж байна вэ?

## 3. Илтгэх/хэлэлцэх

Баг болгоноос томилогдсон илтгэгч нь багийнхаа хэлэлцүүлэг, дүгнэлтийг дараах асуултуудын дагуу тоймлон танилцуулна.

- Эдгээр буруу ойлголт, хэвшмэл хандлагын цаана ямар шалтгаан оршиж байна вэ?
- Эдгээр буруу ойлголт, хэвшмэл хандлага нь хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдралд ноцтой ямар үр дагавруудыг дагуулж байна вэ? Цаашлаад нийгэмд ямар нөлөөтэй байж болох вэ?

### **Дараах асуултуудыг ашиглан, эсвэл төстэй асуултууд зохиож хэлэлцүүлэг хий:**

- Таны амьдарч буй орчин, нийгэмд дээрх үзэл, хандлагын аль нь хамгийн нийтлэг тааралддаг вэ?
- Эдгээр үзэл нь ямар байдлаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг алагчлагдахад хүргэж, эрхээ эдлэхэд нь саад болж байна вэ?
- Эдгээр үзэл, хандлагыг хэрхэн няцаан сөрж болох вэ?
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх эдгээр буруу ойлголтыг өөрчлөх, залруулах нь яагаад чухал вэ?

**Нөөц хувилбар:** Дээрх дасгалын төгсгөлд “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар нийгэмд тогтсон буруу ойлголт, хэвшмэл үзэл” материалыг тараагаад, оролцогчдын өөрсдийнх нь боловсруулсан жагсаалттай харьцуулж судлах цаг гаргаж өгөөд, эцэст нь дараах асуултуудыг асуу:

- Танай багийн гаргасан жагсаалт үүнтэй төстэй байна уу?
- Энд таны санаанд ороогүй зүйлс байна уу? Энд багтаагүй ч таны жагсаалтад орсон зүйлс байна уу?
- Энэ хоёр жагсаалтын хоорондын ялгаа, зөрүүг та хэрхэн тайлбарлах вэ?
- Та хувьдаа санал нийлэхгүй/дэмжихгүй зүйлс энэ жагсаалтад байна уу?
- Энэ жагсаалт танд шинэ бодол, санаа өгч чадав уу?



## Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар нийгэмд тогтсон буруу ойлголт, хэвшмэл үзэл

### Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бол:

- бие дааж амьдарч чадахгүй/бусдаас бүрэн хамааралтай
- өрөвдмөөр
- хөндлөнгийн тусламжид найдахаас өөр аргагүй
- хөгжлийн бэрхшээл бол үйлийн үр/буруу зүйл хийснийхээ төлөө эдэлж байгаа гэсгээлт
- хувь заяандаа гутарч явдаг
- эрүүл хүмүүст дургүй
- амьдрал нь утга учиргүй
- гэртээ байж байсан нь дээр
- ажил хийх чадваргүй
- гэр бүл болох хэрэггүй, сайн эцэг эх болж чадахгүй
- бэлгийн амьдралд оролцох чадваргүй
- эмч, мэргэжилтнүүдийн тусламжтайгаар эмчилж, эдгээх шаардлагатай хүмүүс
- тусгай хөтөлбөрөөр тусад нь боловсрол эзэмшүүлэх хэрэгтэй
- соёл, амралтын арга хэмжээнд оролцож чадахгүй
- сурах чадавхгүй
- (Сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүс) хүүхэд шиг гэнэн, бие даан шийдвэр гаргаж чадахгүй
- (Сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүс) аюултай (бусдыг эрсдэлд оруулна) хүчирхийлэл үйлдэж мэднэ
- тэнэг учир тэдэнтэй харилцахдаа өөр, нийтлэг бус аргуудыг ашиглах хэрэгтэй.

### ЭХЛЭЛ: ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЭХ НЬ

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг судлахад туслах суурь болгож энэ бүлэгт эхлээд хүний эрхийн тулгуур зарчмууд болон эрхзүйн ерөнхий хүрээг танилцуулаад, дараа нь хүний эрхийг хөгжлийн бэрхшээлтэй холбон тайлбарлав.

### Хүний эрх гэж юу вэ?

Хүний эрх нь хүний хэрэгцээнээс үүдэлтэй. Хүний эрхийн үүднээс харвал хүн бүр амьд явах төдийгүй нэр төртэй амьдрах адил тэгш эрхтэй бөгөөд нэр төртэй амьдруулахын тулд хүн бүрт тодорхой суурь нөхцөл, боломжуудыг хангаж өгсөн байх шаардлагатай.

## **Хүний эрх нь бусад үзэл баримтлал, зарчмуудаас ялгагдах онцгой шинж чанартай. Хүний эрх бол:**

**түгээмэл:** буюу хүний эрх нь гарал үүсэл, арьсны өнгө, хүйс, яс үндэс, шашин, шүтлэг, хэл, иргэний харьяалал, нас, бэлгийн чиг баримжаа, биеийн хөгжил болон бусад нөхцлөөс үл хамааран дэлхийн бүх хүнд ямар ч ялгаварлалгүйгээр үйлчилнэ. Хүний эрхийг эдлэхийн цорын ганц нөхцөл нь хүн байх л явдал юм.

**төрөлхийн:** хүний эрх бол хүн байхын салшгүй нэг хэсэг билээ. **Хүний эрхийн түгээмэл тунхаглалын (ХЭТТ) 1** дүгээр зүйл нь “Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байдаг” гэж эхэлдэг.

**салшгүй:** хүний эрх нь хүн бүрт автоматаар олгогддог. Хүний эрхийг аль нэгэн эрх мэдэлтэн, засгийн газар олгохгүй, түдгэлзүүлэхгүй. Танд энэ эрх хамаарахгүй гэж хэн ч хэлэх учиргүй. Хэн нэгэн таны эрхийг зөрчиж, эсвэл эрхээ эдлэхэд тань саад болж байхад ч та эрхээ шаардах эрхтэй.

## **Хүний эрх хоорондоо чухал холбоо хамааралтай байдаг. Тэдгээр нь:**

**нэгдмэл:** хүний эрхийг нэг нэгнээс нь салгаж болохгүй

**харилцан хамааралтай:** эдлэх ёстой эрхийн нэгийг ч орхигдуулахгүй байж чадсанаар л хүний эрх бүрэн хангагдана.

**хоорондоо уялдаатай:** хүний нэг эрх нь нөгөөдөө нөлөөлдөг.

Энгийнээр хэлбэл, хүний эрх бүгд нийлж цогцоор үйлчилдэг бөгөөд бидэнд хүний бүх эрх хэрэгтэй. Жишээлбэл, хүний сурч боловсрох эрх, өөрийн үзэл бодолтой байх эрх, мэдээлэл авах эрх чөлөө, тэр ч бүү хэл хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрх зэрэг хангагдсан эсэхээс түүний сонгох, сонгогдох эрхээ эдлэх боломж хамаарч болно. Төр иргэдийнхээ аль нэг эрхийг нь хамгаалж, нөгөө эрхийг нь үл тоомсорлож болохгүй. Эрх бүр зайлшгүй шинжтэйн дээр бусад эрхтэйгээ холбоотой байдаг.

## **Хүний эрхийн баримт бичгүүд**

Хүний эрхийг хүний эрхийн олон улсын баримт бичгүүдэд тодорхойлсон байдаг. Эдгээрийн зарим нь заавал дагаж мөрдөх ёстой хууль байдаг бол зарим нь **олон улсын хууль** биш ч чухал ач холбогдолтой зөвлөмж юм. Гарын авлагын энэ хэсэгт хүний эрхийн эрхзүйн орчинг бүхэлд нь авч үзнэ.

### **1. Хүний эрхийн түгээмэл тунхаглал (ХЭТТ)**

Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг НҮБ-аас 1948 онд баталсан бөгөөд үүнээс хойш хүний эрхийн асуудлыг улам нарийвчилсан олон баримт бичиг гарсан нь бүгд л ХЭТТ-ын хүний эрхийн суурь зарчмуудад тулгуурлажээ. Дор ХЭТТ-ыг **зүйл** бүрийн гол үзэл баримтлалыг тоймлосон ХЭТТ-ын хураангуй эхийг толилуулж байгаа бөгөөд бүрэн эхийг нь Хавсралт 1 (хуудас 294)-ээс үзнэ үү.



## Хүний эрхийн түгээмэл тунхаглал (ХЭТТ) (албан ёсны хураангуй<sup>1</sup>)

- 1 дүгээр зүйл Адил тэгш байх эрх
- 2 дугаар зүйл Ялгаварлан гадуурхлаас ангид байх эрх
- 3 дугаар зүйл Амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрх
- 4 дүгээр зүйл Боолчлолоос ангид байх эрх
- 5 дугаар зүйл Эрүү шүүлт, нэр төрийг доромжилсон харьцаанаас ангид байх эрх
- 6 дугаар зүйл Эрхзүйн чадвартай байх эрхээ хүлээн зөвшөөрүүлэх эрх
- 7 дугаар зүйл Хуулийн өмнө адил тэгш байх эрх
- 8 дугаар зүйл Эрх мэдэл бүхий шүүхээр эрхээ сэргээлгэх эрх
- 9 дүгээр зүйл Дур мэдэн баривчлагдах, хөөн зайлуулагдахаас ангид байх эрх
- 10 дугаар зүйл Хараат бус шүүхээр нээлттэй шударгаар шүүлгэх эрх
- 11 дүгээр зүйл Гэм буруутайг нь батлах хүртэл гэм буруугүйд тооцогдох эрх
- 12 дугаар зүйл Хувь хүн, гэр бүл, орон байр, захидал харилцааны халдашгүй дархан байдлыг зөрчихөөс хамгаалагдах эрх
- 13 дугаар зүйл Улсынхаа дотор чөлөөтэй зорчих, гадаад оронд зорчих, эх орондоо буцаж орох эрх
- 14 дүгээр зүйл Мөрдөлт мөшгөлтөөс зугтаж, өөр улсад орогнох эрх
- 15 дугаар зүйл Иргэний харьяалалтай байх, түүнийгээ чөлөөтэй солих эрх
- 16 дугаар зүйл Сайн дурын үндсэн дээр гэрлэх, гэр бүл болох эрх
- 17 дугаар зүйл Хувийн өмчтэй байх эрх
- 18 дугаар зүйл Шашин шүтлэг, итгэл үнэмшилтэй байх эрх
- 19 дүгээр зүйл Өөрийн үзэл бодолтой байх, мэдээлэл авах эрх
- 20 дугаар зүйл Тайван замаар хуран цугларах, эвлэлдэн нэгдэх эрх
- 21 дүгээр зүйл Улсаа удирдахад болон чөлөөт сонгуульд оролцох эрх
- 22 дугаар зүйл Нийгмийн хангамж эдлэх эрх
- 23 дугаар зүйл Ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох, үйлдвэрчний эвлэлд нэгдэх эрх
- 24 дүгээр зүйл Амрах, зав чөлөөтэй байх эрх
- 25 дугаар зүйл Хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрх
- 26 дугаар зүйл Сурч боловсрох эрх
- 27 дугаар зүйл Нийгмийнхээ соёлын амьдралд оролцох эрх
- 28 дугаар зүйл Энэхүү Тунхаглалд заасан эрх, эрх чөлөөг эдэлж болохуйц нийгмийн дэг журамд аж төрөх эрх
- 29 дүгээр зүйл Чөлөөтэй, өв тэгш хөгжлийг хангахад нийгмийн өмнө хүлээх үүрэг
- 30 дугаар зүйл Дээрх эрхээ эдлэхэд төр, бие хүний хөндлөнгийн нөлөөнөөс ангид байх эрх чөлөө

1 Англи хэл дээрх албан ёсны хураангуй эхийн албан бус орчуулга

## ДАСГАЛ 2: Эрхийн харилцан хамаарал

<b>Зорилт:</b>	ХЭТТ-д заагдсан хүний суурь эрхийг хэлэлцэж, эдгээр нь хоорондоо хэрхэн уялдаж байгааг ойлгох
<b>Хугацаа:</b>	45 минут
<b>Хэрэглэгдэхүүн:</b>	Самбар, шохой эсвэл том самбар, фломастер, багийн ажилд зориулсан “Үр дагаврын каскад” материалын хуулбар, ХЭТТ-ын хялбаршуулсан эх

### 1. Танилцуулах

Хүний эрх нь хүний хэрэгцээнээс үүдэлтэй бөгөөд хүн болгонд эдгээр эрх нь хэрэгтэй, шаардлагатай гэдгийг тайлбарлаж дасгалаа эхлүүлнэ. Хүний эрх нэгдмэл, хоорондоо уялдаа холбоотой, харилцан хамааралтай, нэгийг нь зөрчвөл ноцтой үр дагавар гарч болохыг харуулах зорилгоор энэ дасгалыг хийж байгааг тайлбарла.

“Үр дагаврын каскад”-ыг хэрхэн ашиглах талаар дараах тайлбарыг өг:

- i. Схемийн эхний, хамгийн том тойрогт нь ХЭТТ-ын аль нэг эрхийг сонгон авч бичнэ (жишээлбэл, сурч боловсрох эрх)
- ii. “Энэ эрх зөрчигдвөл ямар үр дагавар гарах вэ?” гэж асууна. Гарсан хариултуудаас 3-ыг сонгоод, схемийн хоёрдах түвшний тойрог дотор нэг нэгээр нь бич.
- iii. Хоёрдах түвшний тойрогт бичсэн үр дагавруудыг нэг нэгээр нь авч үзээд (жишээлбэл, сайн ажилтай болж чадахгүй), “Энэ үр дагаврын нөлөөгөөр ямар эрх зөрчигдөх вэ” гэж асуун (жишээлбэл, хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрх), гарсан хариултыг гурав дах түвшний тойрог дотор бич.

**Нөөц хувилбар:** Тойрог дотор хүний эрхийг шууд бичихийн оронд ХЭТТ-ын зүйл заалтыг дугаарыг бичиж болно (жишээлбэл, “сайн ажил олж чадахгүй” нь 25 дугаар зүйл: хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрх; 23 дугаар зүйл: хүссэн ажлаа эрхлэх эрх зэрэгтэй холбоотой).

### 2. Гүйцэтгэх/Биелүүлэх

Оролцогчдыг 2-4 хүнтэй жижиг багуудад хуваагаад, “Үр дагаврын каскад”-ын хуулбарласан хувиудыг тарааж өг. Баг болгон нэг эрхийг сонгож хуудасны голд бичнэ. Энэ эрх зөрчигдвөл хөгжлийн бэрхшээлтэй/бэрхшээлгүй хүмүүст ямар үр дагавар учрахыг хэлэлцэх даалгаврыг багуудад өг.

**Сургагч багшид:** Оролцогчид гурваас илүү үр дагавар нэрлэж болох ч хамгийн ноцтой гурван үр дагаврыг сонгож төвлөрөхийг зөвлө.

### 3. Хэлэлцэх


Баг бүрээс томилогдсон илтгэгч нь багийнхаа бүдүүвч зургийг тайлбарлана. Дараах асуултуудын дагуу хэлэлцүүлэг хий:

- Аль нэг эрх зөрчигдсөнөөс үүсэх эдгээр үр дагаврын дотор таны санаанд ороогүй шинэ зүйл нэрлэгдсэн үү?
- Нэгээс олон эрх зөрчигдвөл юу болох вэ?



- Ямар үр дагавар нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хамгийн ноцтой сөрөг нөлөө үзүүлэх вэ?
- Энэ дасгалаас эрхийн харилцан хамаарлын талаар та юу ойлгосон бэ? (жишээлбэл, хүний бүх эрхийг эдлэхийн ач холбогдлын тухай).

### Үр дагаврын каскад Жишээ



## 2. Олон улсын хүний эрхийн конвенциуд

**Конвенци** (мөн **гэрээ** гэж нэрлэдэг) гэдэг нь хэд хэдэн улсын хооронд бичгээр байгуулсан гэрээ юм. Конвенцийн эхийг ихэнхдээ НҮБ-ын Ерөнхий ассамблейгаас томилсон ажлын хэсэг боловсруулдаг. Бэлэн болсон гэрээний эхийг НҮБ-ын Ерөнхий ассамблейд өргөн барьж батлуулна. Дараагийн алхам бол улс орнууд гэрээнд гарын **үсэг зурах, соёрхон батлах** ажил юм. Конвенцид гарын үсэг зурснаар тухайн улс уул гэрээний зарчмуудыг дагаж мөрдөх амлалт авч, дотооддоо гэрээг соёрхон батлах үйл явцыг эхлүүлж байгаа хэрэг бөгөөд соёрхон батлагдах хүртлээ конвенци нь заавал дагаж мөрдөгдөх албагүй баримт хэвээр байна. Гэрээг соёрхон батлах үйл явцыг улс орон бүр дотооддоо өөрөө зохион байгуулдаг ба энэ гэрээг үзэглэсэн орны хууль тогтоох байгууллага нь конвенцийг өөрийн үндэсний эрхзүйд албан ёсоор суулгах бүхий л арга хэмжээг авна. Конвенцид гарын үсэг зурж, соёрхон баталсны дараа улс орон нь уг **конвенцид нэгдсэн Оролцогч улс** болж, конвенцид заагдсан эрхийг хэрэгжүүлэх албан ёсны үүрэг хүлээнэ. Тодорхой тооны улс соёрхон баталсан тохиолдолд конвенци **хүчин төгөлдөр** болж олон улсын хууль болдог.



Сүүлийн 60 жилийн дотор ХЭТТ-д заагдсан хүний эрхийг улам нарийвчлан үзсэн хэд хэдэн конвенци гарсан. Эдгээрээс ес нь хүний эрхийн зангилаа асуудлуудыг хөндсөн тул хүний эрхийн “суурь” баримт бичигт тооцогдох болж, эдгээрийн дагуу хүлээсэн үүргээ Оролцогч улсууд хэрхэн биелүүлж байгааг хянах, шаардлага тавих үүрэгтэй тусгай байгууллагууд бий болжээ.

Эдгээрээс хоёр нь хүний эрхийн асуудлуудыг өргөн хүрээнд авч үзсэн **олон улсын пакт** юм. Үүнд:

- 1966 онд батлагдаж, 1976 онд хүчин төгөлдөр болсон **Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИУТЭОУП)**<sup>2</sup>
- 1966 онд батлагдаж, 1976 онд хүчин төгөлдөр болсон **Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (ЭЗНСЭОУП)**<sup>3</sup>

Дээрх хоёр Пактыг ХЭТТ-тай нийлүүлээд **хүний эрхийн олон улсын хууль** гэж нэрлэдэг. Бусад долоон конвенци нь хүний эрхийн тодорхой асуудал юмуу хүн амын тодорхой бүлэгт хамаардаг.<sup>4</sup>

<b>ХҮНИЙ ЭРХИЙН ЭРХЗҮЙН ХҮРЭЭ</b>	<b>Хүчин төгөлдөр болсон</b>
<b>Эрхзүйн баримт бичиг</b>	
Хүний эрхийн түгээмэл тунхаглал (ХЭТТ)	Хамаарахгүй
Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИУТЭОУП)	1976
Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (ЭЗНСЭОУП)	1976
Арьсны өнгөөр алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенци (АӨАБХУК)	1965
Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенци (ЭАБХУК)	1979
Эрүү шүүлт болон бусад хэлбэрийн хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжилсон харьцаа, шийтгэлийн эсрэг конвенци (буюу Эрүүдэн шүүхийн эсрэг конвенци (ЭШЭК)	1984
Хүүхдийн эрхийн конвенци (ХЭК)	1989
Цагаач ажилчид болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай конвенци	1990
Хүчээр сураггүй алга болохоос хамгаалах олон улсын конвенци	*
Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци	*

\* 2007 оны 9 дүгээр сарын байдлаар хүчин төгөлдөр болоогүй байв.

Хүний эрхийн энэ есөн суурь конвенци нь биеэ даасан **хүний эрхийн эрхзүйн тогтолцоог** бүрдүүлнэ. Эдгээрээс танай улс алинд нь нэгдэн орж, улмаар биелүүлэх, хангах үүрэг хүлээсэн болохыг та олж мэдээрэй.

2 [www.ohchr.org/english/law/ccpr.htm](http://www.ohchr.org/english/law/ccpr.htm) сайтыг үз.

3 [www.Unhchr.ch/html/menu3/b/a\\_ceschr.htm](http://www.Unhchr.ch/html/menu3/b/a_ceschr.htm) сайтыг үз.

4 Хавсралт 1 (351-р хуудас)-ээс эдгээр баримт бичгийн интернет хаягийг үзнэ үү



### 3. Хүний эрхийн тухай бүс нутгийн конвенциуд

Дэлхий даяар нийтлэг үйлчлэх НҮБ-ын хүний эрхийн хуулиудын зэрэгцээ зарим бүс нутгийн олон улсын байгууллагууд өөрийн онцлогт тохирсон хүний эрхийн баримт бичиг гаргасан байдаг. Үүнд:

- Африкийн Эв Нэгдлийн Байгууллагаас 1986 онд боловсруулсан **Хүний ба улс түмний эрхийн Африкийн дүрэм**<sup>5</sup>
- 1953 онд Европын Зөвлөлөөс гаргасан **Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах Европын конвенци**<sup>6</sup>,
- 1973 онд Америк тивийн хүний эрхийн хорооноос боловсруулсан **Америк тивийн хүний эрхийн конвенци**<sup>7</sup> зэрэг болно.

#### ХҮНИЙ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХЭН ХАРИУЦАХ ЁСТОЙ ВЭ?

##### Төр:

Хүний эрхийг хангах үндсэн хариуцлагыг төр хүлээнэ. Төр нь хууль, бодлого, хөтөлбөрөөрөө хүний эрхийг ханган хэрэгжүүлж чадахуйц улс төрийн болон эрхзүйн тогтолцоог бүрдүүлж, үр дүнтэй ажиллуулах үүрэгтэй. Зарим улс хүний эрхийг сахин хамгаалахтай холбоотой төр, засгийн газрынхаа үүрэг хариуцлагыг олон улсын гэрээгээр зохицуулдаг. Харин ихэнх улс орон өөрийн Үндсэн хууль, үндэсний хүний эрхийн хууль болон бусад хуульдаа ХЭТТ-ын зарчим, хэм хэмжээнд нийцүүлсэн өөрчлөлт, нэмэлтүүдийг оруулдаг нь хүний эрхийг хамгаалах давхар баталгаа, дээрх зарчмуудыг үндэсний түвшинд хэрэгжүүлэх нэмэлт нөхцөл болдог.

Төр нь хүний эрхийг **хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх** үүргийг хуулиар хүлээдэг.

#### Хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх нь

**Хүндэтгэх** гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүн эрхээ эдлэхэд нь төрийн зүгээс саад болохгүй байх зарчим юм. Төр нь хүний эрхийг зөрчих аливаа үйлдэл хийхээс түдгэлзэх ёстой. Мөн түүнчлэн төр нь хүний эрхэд нийцээгүй аливаа хууль, бодлого, арга хэмжээнүүдээ хүчингүй болгох ёстой.

**Хамгаалах** нь төр хүн болгон, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг аливаа төрийн бус этгээдийн (бие хүн, аж ахуйн нэгж, бусад хувийн байгууллага) халдлагаас хамгаалах үүрэгтэй гэсэн утгатай.

**Хэрэгжүүлэх** нь төр хүн болгон, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрхийг нь эдлүүлэхийн төлөө шаардлагатай бүхий л арга хэмжээг авах ёстой гэсэн утгатай. Өөрөөр хэлбэл, төр хүний эрхийг дэмжсэн хууль, бодлого боловсруулах ёстой. Төр мөн эдгээр эрхийг хэрэгжүүлэх хөтөлбөр, бусад арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлэх ёстой. Эдгээр хууль, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг төр хангаж өгөх ёстой.

5 [www1.umn.edu/humanrts/instree/z1afchar.htm](http://www1.umn.edu/humanrts/instree/z1afchar.htm) сайтыг үз.

6 [www.conventions.coe.int/treaty/en/treaties/html/005.htm](http://www.conventions.coe.int/treaty/en/treaties/html/005.htm) сайтыг үз.

7 [www.umn.edu/humanrts/oasinstr/zoas3con.htm](http://www.umn.edu/humanrts/oasinstr/zoas3con.htm) сайтыг үз.

Хэдийгээр олон улсын хүний эрхийн эрхзүйд хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх үүргийг төрд оноосон байдаг ч энэ нь дан ганц төрийн үүрэг биш юм. Хүний эрх нь хуулиар тавигдах шаардлага төдийхнөөр хязгаарлагдахгүй. Хүний эрх нь ойлголцол, тэгш байдал, хүлээцтэй хандлага, шударга ёс зэрэг шударга, хүмүүнлэг нийгмийн салшгүй хэсэг болсон бусад олон шинжийг бэхжүүлэх ёс зүйн хэм хэмжээ болж өгдөг. Хуулиар ямар зан үйлийг зохицуулж болох, болохгүйгээс үл хамааран нийгмийн янз бүрийн бүлэг, хувь хүн, байгууллагууд хүний эрхийг хамгаалах, хэрэгжүүлэхэд мөн чухал үүрэг гүйцэтгэнэ.

### **Хувь хүн:**

Хүн болгон өөрийнхөө эрхийг мэддэг, ойлгодог болсноор эдгээр эрхээ эдэлж, хамгаалдаг болохын зэрэгцээ эрхэд нь нөлөөлж буй аливаа үйлдлийн төлөө хариуцлага тооцох шаардлагыг өөртөө болон бусад хүн, засгийн газар, нийгэмд тавьж чаддаг болно. Хүний бүх эрх хүн бүрт хамаатай учир эрхээ хамгаалуулахын төлөө тэмцэж буй ганц хүний үйлдэл ч бусад хүний төлөө, тэдний нэрийн өмнөөс хийж буй чухал алхам юм. Үүнтэй адилаар, өөр хүний эрхэд халдсан нэг хүний үйлдлийг нийт хүмүүсийн эрхийг зөрчсөн томоохон халдлага гэж үзнэ.

### **Бүлэг хүн:**

Нийгмийн болон соёлын хэм хэмжээнүүд нь хүний эрхээ эдлэх боломжид хүчтэй нөлөөлдөг. Гэр бүлээс авахуулаад нийгмийг бүхэлд нь багтааж болох бүлэг хүмүүсийн хамтын үйлдэл нь хүний эрхэд нөлөөлж байдаг. Тухайлбал, хэрэв эцэг эх нь зөвхөн хөвгүүдээ сургуульд сургахаар шийдвэл энэ нь охин хүүхдийнхээ сурч боловсрох эрхийг зөрчиж байгаа хэрэг юм. Хэрэв нийгэмд ноёрхож байгаа соёлын хэм хэмжээний улмаас үндэстний цөөнхийн нэгэн гишүүн нь орон байр хайх, нийгмийн үйлчилгээ авахдаа алагчлалд өртвөл хүний хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхийг зөрчихөд нийгэм нь өөрөө оролцож буй хэрэг юм. Эерэг жишээ дурьдахад, хүний эрхийн тодорхой зөрчлийг ил гарган тавьж, сөрөг нөлөөтэй хандлага, хууль, бодлогыг өөрчлөхийн төлөө ажиллаж байгаа нийгмийн бүлгүүд нь хүний эрхийг бүхэлд нь хамгаалах, сурталчлах хүч болж чадна.

### **Хувийн хэвшил:**

Аливаа нийгэмд, ялангуяа чөлөөт зах зээлийн эдийн засагтай нийгэмд хүн бүр л хувийн хэвшилтэй өдөр тутам харьцдаг. Хувийн хэвшилд, жишээлбэл, ажил олгогч, бараа үйлдвэрлэгч, үйлчилгээ үзүүлэгч, барилга байшин, үүний дотор төрийн байгууллагуудын барилга байшинг барьж байгаа барилгачид гээд янз бүрийн хүмүүсийг хамааруулж болно. Хүмүүс хувийн хэвшлийнхнээс олон зүйл дээр хамааралтай байдаг. Хэдийгээр төр нь хүний эрхийг сахин хамгаалсан тодорхой хууль, хэм хэмжээг мөрдөж ажиллах шаардлагыг хувийн хэвшилд тавьдаг ч хувийн салбарын үйл ажиллагааны бүх тал дээр төр хяналт тавьж чадахгүй. Тийм учир хувийн хэвшил нь хүний эрхийг зөрчихгүй байх, улмаар хүний эрхийг сахин хамгаалж, дэмжсэн хэм хэмжээг өөрийн санаачилгаар баримталж ажиллахыг өөртөө үүрэг болгох ёстой.



Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь эдлэх ёстой эрхээ олон улсын хуулиар албан ёсоор баталгаажуулахын төлөө олон жил тэмцсэн. 2006 онд НҮБ-ын Ерөнхий ассамблейгаас баталсан **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци (ХБХЭК)** нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг тунхагласан анхны конвенци юм. Ер нь ХБХЭК бол хөгжлийн бэрхшээлийг тусгайлан авч үзсэн дэлхийн анхны гэрээ юм.

ХБХЭК-ийг боловсруулах хамгийн эхний уулзалтаас л энэхүү конвенцид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өөрсдийнх нь үг, үзэл бодлыг тусгах ёстой гэсэн байр суурийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд илэрхийлж ирсэн. Улмаар НҮБ-ын бусад гэрээ, конвенцитай харьцуулахад энэ конвенцийн боловсруулалтад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хамгийн ихээр оролцож чадсан билээ. Энэ бүхний үр дүнд ХБХЭК нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхтэй холбоотой бүхий л асуудлыг тусгахын зэрэгцээ маш хатуу баримтлалтай эрхзүйн баримт бичиг болж чадсан юм. Хэрвээ улс орнуудын төр, засгийн газар үүнийг дангаараа хийсэн бол ийм хүчтэй байр суурь гарахгүй ч байсан байж мэднэ. Үүний хажуугаар, конвенцийг боловсруулах явцад НҮБ, төрийн байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдгээрийн эрхийг хамгаалах байгууллагуудын хооронд маш чухал холбоо харилцаа тогтсон юм.

Ингээд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг ХБХЭК-иар баталгаажуулан олон улсын эрхзүйн нэгэн хэсэг болгож чадсан учраас одоо дараагийн алхам бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс уг конвенцийг соёрхон батлуулах нөлөөллийн ажлыг явуулж, төр засагтаа шахалт үзүүлэх явдал юм. ХБХЭК-иар эрхээ баталгаажуулахаар тэмцэж буй хүн болгон нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах даян дэлхийн хөдөлгөөний нэг гишүүн юм.

### **ХБХЭК-ийн нийтлэг зарчмууд**

ХБХЭК-д нийтлэг зарчмуудыг тусгай зүйл болгож оруулсан нь уг баримт бичгийн нэг онцлог юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралд амин чухал нөлөөтэй суурь зарчмуудыг тэдний эрхийн үндэс болгож конвенцид тусгахыг боловсруулагчид нь хүссэн ажээ. Зарчмын суурь ойлголтуудыг конвенцийн эхэнд байрлуулснаар энэ конвенцид багтсан бүх эрхийг тэдгээр зарчмын үүднээс тайлбарлаж, ойлгох нөхцөл болж чадна гэж тэд үзсэн юм.

## ХБХЭК-ийн 3 дугаар зүйл: Нийтлэг зарчмууд

### Энэ конвенцийн зарчмууд нь:

- а) Сонголт хийх эрх чөлөө болон хүний бие даасан байдлыг оролцуулан хүний нэр төр, нандин чанар, хувийн хараат бус байдлыг хүндэтгэх
- б) Ялгаварлан гадуурхагдахгүй байх
- в) Нийгэмд бүрэн дүүрэн, үр бүтээлтэй оролцох болон хамрагдах,
- г) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлог байдлыг хүндэтгэх, тэднийг хүний ялгаатай байдал, хүн төрөлхтний нэг хэсэг гэж үзэн хүлээн авах,
- д) Тэгш боломж олгох
- е) Хүртээмжтэй байх
- ж) Эрэгтэй, эмэгтэйчүүд тэгш эрхтэй байх
- з) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьсаж өөрчлөгдөх чадамжийг хүндэтгэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өөрийн онцлог байдлаа хадгалах эрхийг хүндэтгэн хандах

Хүний эрхийн конвенциуд бараг бүгдээрээ хүний эрх, суурь эрх чөлөөний үндэс болсон хүний нэр төр, бүх хүний төрөлхийн адил тэгш байдлыг хүлээн зөвшөөрснөөр эхэлдэг. ХБХЭК-ийн үндсэн зарчмуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд онцгой ач холбогдолтой өөр хэд хэдэн баримтлалыг нэмж багтаасан бөгөөд эдгээр нь, тухайлбал, тэгш боломжоор хангагдах, алагчлагдахгүй байх, ялгаатай байдлаа хүндэтгүүлэх зэрэг юм. Мөн хараат бус байх, халдашгүй дархан байдлаа хадгалах, нийгмийн амьдралд оролцох ба хамрагдах эрх зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангахад маш чухал үүрэгтэй бусад үзэл баримтлалыг ХБХЭК-ийн суурь зарчим болгон тунхаглажээ. Эдгээр зарчим нь бусад конвенциудад зөвхөн шууд бус утгаар туссан байдаг (жишээлбэл, эрх чөлөөтэй, бусдаас хараат бус байх, алагчлагдахгүй байх зэрэг сэдвийн хүрээнд) бөгөөд бусад аль ч конвенцид халдашгүй дархан байдал, хараат бус байдал, оролцоо зэрэг асуудлыг шууд хөндөөгүйгээр үл барам нэр томъёо болгож ашиглаагүй байна. Эдгээрийг нэр томъёо болгож хэрэглэхийн зэрэгцээ үндсэн зарчим гэж тодорхойлсноороо хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эдгээр эрх хичнээн чухал болохыг ХБХЭК маш тодорхой харуулж чадсан юм.

### ХБХЭК-д заагдсан нийтлэг үүргүүд

“Нийтлэг зарчмууд”-ыг тодорхойлсон 3 дугаар зүйлийн араас “Нийтлэг үүргүүд” нэртэй 4 дүгээр зүйл орсон бөгөөд үүнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх баталгааг хангахын тулд төрөөс авч хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээнүүдийг нарийвчлан зааж өгчээ. ХБХЭК-д заасан үндсэн үүргүүдийн ихэнх нь хүний эрхийн бусад конвенцид туссан үндсэн үүргүүдтэй адил боловч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хүндэтгэх талаар хүний эрхийн бусад гэрээнд тусаагүй зарим нэг онцгой шаардлага мөн багтжээ. Тухайлбал, бараа, үйлчилгээний **нийтлэг дизайныг** хэвшүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэхэд туслах технологиудыг хөгжүүлэх чиглэлийн судалгааг эрчимжүүлэх зэрэг арга хэмжээг дурьджээ. Эдгээр зарчим нь ХБХЭК-ийн бүх зүйл, заалтад хамаарах суурь шинжтэй нийтлэг үүрэг гэдгийг ойлгох нь юу юунаас илүү чухал юм.



Үндсэн үүргүүдийг ХБХЭК-ийн 4 дүгээр зүйл болгон ийнхүү онцолсон нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өмнө төрийн хүлээсэн үүргийг улс орнууд хүний эрхийг хангах үндсэн үүргийнхээ нэгэн хэсэг гэж харалгүй явж ирсэн түүхэн алдааг залруулах зорилготой ажээ. Улс орнууд эдгээр үүргээ хүний эрхийн эрхзүйн шаардлагын дагуу заавал биелүүлэх үүрэг гэж харахаасаа илүүтэй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тусгайлан харж үзсэн алхам юмуу нийгмийн онцлог арга хэмжээ гэж хандаж ирсэн. Эдгээр зарчмыг конвенцийн хүрээнд үндсэн үүрэг болгон тодорхойлсноор энэхүү уршигт хандлагыг залруулах чухал алхам хийгдэж байгаа билээ.

## **ХБХЭК-д багтсан бусад нийтлэг заалтууд**

Хүний эрхүүд нэгдмэл, харилцан хамааралтай, уялдаа холбоотойн адил ХБХЭК-ийн бүх зүйл, заалтууд ижил ач холбогдолтой, хоорондоо нягт холбоотой юм. Гэхдээ зарим заалт нь мөн чанарын хувьд нийтлэг шинжтэй тул бусад заалтдаа илүү нөлөөтэй учраас тэдгээрийн ач холбогдлыг чухалчлан конвенцийн эхэнд оруулж өгсөн байна. Энэ ангилалд дээр дурьдсан 3, 4 дүгээр зүйлээс гадна дараах зарчмууд багтана:

**5 дугаар зүйл:** Адил тэгш байдал болон үл алагчлал

**6 дугаар зүйл:** Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд

**7 дугаар зүйл:** Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд

**8 дугаар зүйл:** Мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх

**9 дүгээр зүйл:** Хүртээмж

ХБХЭК-д тусгагдсан эрхийн талаар та бүхэн илүү гүнзгий ойлголттой болохын хэрээр 3-9 дүгээр зүйл нь конвенцийн бусад зарчим, үүргүүдтэй нийтлэг байдлаар байнга холбогдож байгааг илүү тодорхой олж харах болно.

## **ХБХЭК-д заагдсан тусгайлсан эрх**

10-аас 30 дугаар зүйлд хөдөлмөрлөх эрх, улс төрийн амьдралд оролцох эрх гэх мэт тусгайлсан эрхийг зааж өгчээ. ХБХЭК-ийг бүрдүүлж байгаа бүх зүйл, заалтын бүрэн жагсаалтыг энэ бүлгийн эцэст оруулав. Сэдэвчилсэн эдгээр зүйл, заалтын ихэнх нь хүний эрхийн бусад конвенцийн харгалзах зүйл, заалтыг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хамааруулан тайлбарлажээ. Харин доор жагсаасан цөөн хэдэн зүйл нь ХБХЭК-ийн онцлог болж байгаа юм:

**19 дүгээр зүйл:** Бие даан амьдрах, тухайн оршин суугаа орчиндоо байх эрх

**20 дугаар зүйл:** Хувийн хөдөлгөөн

**26 дугаар зүйл:** Сэргээлт, нөхөн сэргээлт

Эдгээр нь зөвхөн хөгжлийн бэрхшээлээс үүдэлтэй онцлог хэрэгцээ, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өвөрмөц байдлаар ялгаварлан гадуурхаж, эрхийг нь зөрчих нөхцөл болж ирсэн чиглэл юм. Эдгээр зүйл, заалт нь ямар нэг шинэ эрх гаргаж ирээгүй ч төрийн хүлээх үүргийг хөдөлбөргүй ойлгуулах зорилгоор оруулж ирсэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн нарийвчилсан тодорхойлолт, зарим тохиолдолд урьд өмнө нь олон улсын эрхзүүд тусаагүй шинэ үүрэг, арга хэмжээ юм.



## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ БҮС НУТГИЙН КОНВЕНЦИУД

2007 оны байдлаар, Америк тивийн хүний эрхийн хороо нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг тусгайлан авч үзсэн конвенци гаргасан бүс нутгийн цорын ганц байгууллага байв. Энэ байгууллага нь **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Америк тивийн конвенцийг** 1999 онд боловсруулсан юм. Бүс нутгийн бусад байгууллагууд нь заавал дагаж мөрдөх албагүй гэрээ, гэрээний нэмэлт өөрчлөлтийг батлах, зөвлөмж, төлөвлөгөө боловсруулах замаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалдаг. Мөн бүс нутгийн хүрээнд үйлчлэх хүний эрхийн нийтлэг баримт бичигт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг тусгайлан дурьдсан тохиолдлууд бий.

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТАЛААРХ ЗААВАЛ ДАГАЖ МӨРДӨХ АЛБАГҮЙ ЧУХАЛ БАРИМТ БИЧГҮҮД

### **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх даян дэлхийн үйл ажиллагааны хөтөлбөр:**

НҮБ, 1981 оныг “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олон улсын жил” (ХБХОУЖ) болгон зарлаж хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн адил тэгш, бүрэн дүүрэн оролцоог дэмжих сэдвийн дор үндэсний, бүс нутгийн, олон улсын түвшинд авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэхийг уриалжээ. ХБХОУЖ-ийн нэгэн чухал үр дүн нь НҮБ-аас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны даян дэлхийн хөтөлбөр боловсруулж гаргасан явдал юм. Энэ хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн амьдрал болон хөгжилд бүрэн дүүрэн бөгөөд адил тэгш оролцуулах зорилтыг хэрэгжүүлэхэд дэм болох үр өгөөжтэй арга хэмжээг хөхиүлэн дэмжих зорилготой юм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хангалттай цаг хугацааг улс орнуудын засгийн газарт гаргаж өгөх үүднээс НҮБ-аас 1983-1992 оныг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн арван жил болгон зарлажээ.

### **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боломжийг тэгшитгэх тухай НҮБ-ын Стандарт дүрэм:**

Даян дэлхийн Хөтөлбөр нь хэрэгтэй ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах зорилгодоо хүрч чадахгүй гэж олон хүн үзэж байв. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн төслийг боловсруулах асуудлаар НҮБ 1984 онд хуралдсан боловч дэмжлэг дутагдсанаас бодит ажил болгож чадаагүй билээ. Гэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хамааралтай олон улсын хууль биш харин тэдэнд тэгш боломж олгох улс төрийн болон ёс зүйн хүсэл эрмэлзлийг тунхагласан баримт бичиг боловсруулах шийдвэрийг НҮБ 1990 онд гаргажээ. Үүний үр дүнд **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боломжийг тэгшитгэх тухай Стандарт дүрмүүд (стандарт дүрэм)**-ийг 1993 онд баталсан бөгөөд энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хэрэгжилтэд эрхзүй, нийгэм, улс төр, дэд бүтцийн орчин маш хүчтэй нөлөөлж байгааг хүлээн зөвшөөрсөн олон улсын анхны баримт бичиг болсон юм. Хэдийгээр ач холбогдлоороо ХБХЭК-ийг гүйцэхгүй ч Стандарт дүрмүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах нөлөөллийн ажилд өнөөдөр ч өргөн хэрэглэгддэг бөгөөд түүний олон зарчмууд нь энэ конвенцийн суурь болсон юм.



## **Сэтгэцийн өвчтэй хүмүүсийг хамгаалах, сэтгэцийн эрүүл мэндийн хамгааллыг сайжруулах НҮБ-ын зарчмууд (СӨ Зарчмууд):**

Эдгээр зарчмыг сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах ажилд баримтлах хамгийн наад захын буюу минимум стандарт болгон 1991 онд баталжээ. **СӨ зарчмуудад** тулгуурлан дэлхийн олон улс орон сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль, тогтоомж боловсруулсан. СӨ зарчмуудын дотор нийгмийн дунд амьдрах эрх гэх мэт чухал үзэл баримтлалууд багтдаг.

Энэхүү баримт бичиг нь хүний эрхийн бусад хууль, бодлоготой харьцуулахад зарим асуудлаар арай сул стандарт тавьж байна гэж сэтгэц-нийгмийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалагч олон хүн үздэг. Ялангуяа, сэтгэц-нийгмийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эмчилгээнд хамруулахдаа “үнэн зөв, бүрэн дүүрэн мэдээлэлд тулгуурласан зөвшөөрөл”-ийг авч байхтай холбоотой шаардлагуудын талаар болгоомжлол их байдаг. Иймд энэ баримт бичгийн шаардлагуудыг сайтар судалсны үндсэн дээр сэтгэц-нийгмийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн төлөөх нөлөөллийн ажилдаа ашиглах эсэхээ хүний эрхийг хамгаалагчид өөрсдөө шийдэх ёстой.

### **ДАСГАЛ 3: Эрхийн тогтолцооны мод**

<b>Зорилт:</b>	Хүний эрх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хэрхэн хамаарч байгааг тодорхойлох
<b>Хугацаа:</b>	45 минут
<b>Материал:</b>	том цаасан дээр зурсан модны эх бие хайчилсан жимс, навч, мөчир тус бүр 10 ширхэг (дээр нь бичиж болох хэмжээтэй) Самбар, шохой/бал
<b>Тараах материал:</b>	ХЭТТ (хураангуй эх) ХБХЭК-ийн 3 дугаар зүйл: Үндсэн зарчмууд, 4 дүгээр зүйл: Үндсэн үүргүүд

#### **1. Танилцуулах**

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусад хүнтэй адил тэгш эрхтэй болохыг онцол. Эрхээ шаардахын тулд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдөө эрхээ мэдэж ойлгохын зэрэгцээ тэдгээрийг эдэлж, хамгаалж, хангуулахын тулд юу хийхээ сайн мэддэг байх ёстой гэсэн санааг тайлбарла.

#### **2. Санал солилцох/бүтээх**

Оролцогчдыг жижиг багуудад хуваана. Баг болгонд том үзүүлэнгийн цаасны хэмжээтэй модны их биеийн зураг, мөн навч (10), мөчир (10), жимсний (10) хайчилбаруудыг тараан өгөөд дараах даалгаврыг өг:

- Оролцогчид ХЭТТ-аас 10 зарчмыг сонгож аваад, мөчир болгон дээр нэг зарчим бичээд, мөчрөө модны их бие дээр нааж салаалсан мод бүтээнэ.
- Дараа нь мөчир болгон дээр дараах зүйлсийг нэмж наана:
  - нэг навч - навчин дээрээ тухайн эрх нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ямар хамааралтай болохыг тайлбарлан бичнэ (ХБХЭК-ийн 3, 4 дүгээр зүйл нь хүний бүх эрхийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хамааруулан тайлбарласан суурь зарчмууд тул энэ даалгаварт оролцогчид дээрх хоёр Зүйлийг ашиглаж болно)



- нэг жимс- жимсэн дээрээ тухайн эрхийг хангахын тулд төрөөс ямар арга хэмжээ авч болохыг бичнэ.

**Жишээ:** Мөчир – Хуулийн өмнө адил тэгш байх эрх (ХЭТТ-ын 7 дугаар зүйл)

Навч – Оршин суух газраа чөлөөтэй сонгох эрх

Жимс – Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг автоматаар “эрхзүйн чадамжгүй” гэж үзэхээс сэргийлж, улмаар амьдралд нь нөлөөлөх эрхзүйн шийдвэр гаргахад өөрсдийг нь оролцуулж байх тухай хууль батлах

### 3. Илтгэх/шинжлэх

Моднуудыг ханан дээр өлгө. Баг болгон өөрийн хийсэн модны зарим мөчир, навч, жимсийг уншиж тайлбарлана.

- ХЭТТ-ын аль зарчмыг нэгээс олон тооны баг сонгосон байна вэ?
- ХЭТТ-ын адил зарчмыг сонгосон багуудын навч, жимснүүд нь хоорондоо юугаараа ялгаатай байна вэ?
- Сонгон судлахад арай илүү бэрхшээлтэй, хэцүү нь ямар эрх байсан бэ? Навчин дээр юу бичихээ шийдэхэд хэцүү байсан уу? Яагаад?

1-2 жишээг сонгож аваад, тэдгээрт холбогдох заалтыг ХБХЭК-ийн бүрэн эхээс (305 дугаар хуудас дах Хавсралт) олж уншаад, уг зарчим нь тухайн эрхийн хүрээнд ямар боломж олгож байгааг шинжлэн хэлэлц.

### 4. Хэлэлцэх

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх нь бусад хүний эдлэх ёстой эрхээс огт ялгаагүй ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд эдгээр нь өөрөөр илрэх тохиолдол олонтаа гардаг.

- ХБХЭК нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг тодорхойлох тал дээр ХЭТТ-аас хэрхэн, юугаараа илүү оновчтой байна вэ?
- ХБХЭК нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хүндэтгэн хангах үүргээ хэрэгжүүлэхэд нь засгийн газруудад хэрхэн чиглэл өгч тус болж чадах вэ?

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙГ ТОДОРХОЙЛОХ, СУДЛАХ НЬ

Хөгжлийн бэрхшээл бол олон талтай нарийн асуудал боловч хөгжлийн бэрхшээлийн хүлээн зөвшөөрөгдсөн нэгдсэн тодорхойлолт одоо болтол гараагүй л байна. Гэсэн ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн төлөө тэмцэгч хүн болгон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэж ярихдаа нийгмийн ямар бүлгийг хэлж байгаагаа бусдад тайлбарлаж чаддаг байх ёстой. Хөгжлийн бэрхшээл хэмээх зарчмын ойлголтыг та өөрөө хэрхэн тодорхойлж, илэрхийлж байгаа тань тэдний эрхийн тухай асуудлыг бусад хүмүүс хэрхэн ойлгож, хүлээн авч, хандахад ихээхэн нөлөөлнө.



## ДАСГАЛ 4: Өөрийн оронд зориулсан хүн амын тооллогын асуулга боловсруулах

<b>Зорилт:</b>	Хөгжлийн бэрхшээлийн тодорхойлолтууд нь нөлөөллийн болон бусад үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгааг судлах
<b>Хугацаа:</b>	45 минут
<b>Материал:</b>	цаас, үзэг/харандаа, жишээ тодорхойлолтуудын жагсаалт

### 1. Танилцуулах

Хүн амын тооллогын зорилго бол тухайн улсад хэдэн хүн амьдарч байгаа, тэдгээр нь хүн амзүйн ямар бүлгүүдэд хэрхэн хуваагдаж байгааг тодорхойлох явдал гэдгийг тайлбарла. Жишээлбэл, сургуулийн насны хүүхэд хэд байгааг мэдэж байж л засгийн газар тэдний боловсролд хэдий хэмжээний зардал хуваарилах шаардлагатай байгааг мэдэж авдаг.

### 2. Хэлэлцэх

Дараах асуудлуудыг жижиг багаар, эсвэл нийтээрээ хэлэлц:

- Хөгжлийн бэрхшээлтэй хэдэн хүн, хаана амьдарч байгааг мэдэх нь ямар ач холбогдолтой вэ? Энэ нь хүний эрхтэй хэрхэн холбогдох вэ?
- Хүмүүс ямар хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй байгааг тодорхойлж авах нь чухал уу (тухайлбал, хөдөлгөөний, мэдрэхүйн, сэтгэц-нийгмийн бэрхшээл гэх мэт)?

### 3. Шинжлэх

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг зөв, бүрэн тоолохын тулд хөгжлийн бэрхшээлийн ямар тодорхойлолтыг ашиглах нь зүйтэй вэ? Доор бид олон улсын болон үндэсний хэмжээнд ашиглагддаг хөгжлийн бэрхшээлийн зарим тодорхойлолт, тайлбарыг жагсаалаа.

- Эдгээр тодорхойлолтын хооронд ямар ямар гол ялгаа байна вэ?
- Аль нь хэрэглэхэд илүү дөхөм, өргөн хамралттай, оновчтой байна вэ?
- Аль нь хамгийн хязгаарлагдмал байна вэ? Юуг орхигдуулсан байна вэ?

#### **НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци (ХБХЭК):**

хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогтой бөгөөд уг согог нь бусад төрлийн бэрхшээлтэй хавсран бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон этгээдийг хэлнэ.

#### **Хөгжлийн бэрхшээлтэй америкчуудын тухай хууль (ХБАХ):**

хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж (1) өдөр тутмын амьдралын үйл ажиллагааг нь ноцтой хязгаарласан бие махбодын болон сэтгэцийн согогтой, эсвэл (2) урьд өмнө нь ийм согогтой байсан, эсвэл (3) ийм согогтой гэж тооцогдож байгаа хүнийг хэлнэ.

#### **Угандын Засгийн газраас явуулсан 2002 оны хүн ам, орон сууцын тооллогод ашигласан тодорхойлолт:**

хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж 6 сар буюу түүнээс дээш хугацаагаар үргэлжилсэн бие махбодын болон эрүүл мэндийн доройтлоос үүдэн одоо ч арилаагүй хүндрэл бэрхшээлийн улмаас хийж гүйцэтгэх ажлын төрөл, эсвэл хэмжээ нь хязгаарлагдсан хүнийг хэлнэ. Эдгээр хүндрэлд 6 буюу түүнээс олон сараар үргэлжлэх магадлалтай бүх бэрхшээлийг багтаана.

#### 4. Тодорхойлох/танилцуулах/хэлэлцэх

Амьдралын нөхцөл байдал янз бүр байдаг тул хөгжлийн бэрхшээлийг нарийвчлан тодорхойлох шаардлага чухал болох явдал олонтаа гардаг. Хүний эрхийн төлөө тэмцэгчийн хувьд та харилцан адилгүй нөхцөлд хөгжлийн бэрхшээл хэмээх ойлголтын талаар өөрийн байр суурь, бодлыг илэрхийлэх бэлтгэлтэй байх хэрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай бусад хүмүүстэй ярьж байхдаа ашиглах тодорхойлолтыг та хажуудаа сууж байгаа хүнтэйгээ хамтран боловсруулна уу. Өөрийн гаргасан тодорхойлолтыг нийтэд танилцуул.

Оролцогчдын гаргасан тодорхойлолт болгоны давуу болон сул талыг хэлэлцэн дүгнэ. Боломж байвал тодорхойлолтыг засаж сайжруулах цаг өг.

#### 5. Судлах

- Танай улсын хүн амын тооллогод хөгжлийн бэрхшээлийн асуудал багтдаг уу?
- Хэрэв тийм бол танай үндэсний хүн амын тооллогод хөгжлийн бэрхшээлийн ямар тодорхойлолтыг ашигладаг вэ?
- Энэ тодорхойлолт нь танай улсын хууль тогтоомжид ашигладаг тэр л тодорхойлолт мөн үү?
- Та үүнийг хэрхэн олж мэдэж болох вэ?
- Үндэсний хууль тогтоомжид ямар тодорхойлолтыг ашиглахыг та зөвлөх вэ? Үндэсний хүн амын тооллогод ямар тодорхойлолт зохимжтой вэ?

#### **Хүн амын тооллогын асуулгад багтсан хөгжлийн бэрхшээлийн холбогдолтой асуултууд**

Хөгжлийн бэрхшээлийн асуудлаарх Вашингтоны бүлгийн боловсруулсан дараах зургаан асуултыг үндэсний хүн амын тооллогын асуулгад оруулж, улсынхаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийг тогтооход ашиглахыг Дэлхийн Банк зөвлөжээ.

Бие махбодын, сэтгэцийн, сэтгэл санааны байдлаасаа болоод та:

1. Нүдний шил зүүсэн ч муу хардаг уу?
2. Сонсголын аппараттай байхдаа ч муу сонсдог, эсвэл дүлий юу?
3. Алхах, шатаар явахад танд хүндрэлтэй байдаг уу?
4. Юм санах, анхаарлаа төвлөрүүлэхэд танд хүндрэлтэй байдаг уу?
5. Биеэ арчлахад (усанд орох, хувцаслах зэрэг) танд хүндрэлтэй байдаг уу?
6. Бусадтай харилцах, бусдыг ойлгох, өөрийгөө ойлгуулахад танд хүндрэлтэй байдаг уу?

Боломжит хариултууд: үгүй, заримдаа, байнга, хариулж чадахгүй.<sup>8</sup>

8 Өвчлөлийн хяналтын төв, Эрүүл мэндийн статистикийн үндэсний төв, Хөгжлийн бэрхшээлийн асуудлаарх Вашингтоны бүлгийн гаргасан статистик, 2007. [www.cdc.gov/nchs/citygroup.htm](http://www.cdc.gov/nchs/citygroup.htm)



Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдын адил эрхтэй ч хүмүүсийн үзэл бодол, хандлага, буруу ойлголт, мэдлэг дутсанаас ноцтой ялгаварлан гадуурхалд байнга өртдөг. Жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс үр бүтээлтэй ажиллах хүчин болж чадахгүй гэсэн үзлээс болоод мэдлэг, чадвараараа бүрэн тэнцэх ажилд тэднийг авахгүй байх зэргээр ажил олгогч ялгаварлан гадуурхал гаргаж мэднэ. Эсвэл ажлын байрны барилга, дэд бүтэц нь хөдөлгөөний хязгаарлалттай хөгжлийн бэрхшээлтэй хүний нэвтрэх боломжийг харгалзалгүй хийгдсэн байвал мөн л ялгаварлал болно.

Иймэрхүү хязгаарлалт нь хүн амын бусад бүлгүүдэд ч нөлөө үзүүлж мэднэ. Жишээлбэл, эмэгтэйчүүдийн талаар зарим нийгэмд хэвшсэн үзэл, хандлагаас болж тэдний хөрөнгө өмчлөх, нийгмийн амьдралд оролцох боломж хязгаарлагддаг. Арьсны өнгө, үндэс угсаагаараа үндэстний цөөнх болж байгаа зарим бүлэгт төрөлх хэлээрээ ярих, уламжлалт шашны зан үйлээ дагаж мөрдөхөд хориг саад учрах нь элбэг байдаг. Ялгаварлан гадуурхалд өртдөг нийгмийн аль нэг бүлгийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс (жишээлбэл, үндэсний цөөнхийн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүн) хүний эрхийн давхар зөрчил, давхар алагчлалд өртөж ч болзошгүй.

Хөндлөнгийн эх сурвалжаас үүдэлтэй буюу бусад хүний зүгээс илрэх хандлага, ойлголтын зэрэгцээ хүн бүрийн өөрийнх нь хандлага хүний эрхээ хэрхэн эдэлж байгаад нь нөлөөлдөг. Хөгжлийн бэрхшээл нь түүнийг хүний эрхээ эдлэх тал дээр бусдаас өөр, ялгаатай болгодог гэж үздэг хүн эрхээ шаардахдаа (эсвэл эс шаардахдаа) мөн л өөр хандлага гаргадаг байна.

## **Сөрөг үр дагавартай хандлага, үзэл баримтлал**

### **Хөгжлийн бэрхшээлд хандах эмнэлзүйн загвар**

Хөгжлийн бэрхшээл бол шийдвэрлэх шаардлагатай анагаах ухааны асуудал, эсвэл “эмчлэх” шаардлагатай өвчин гэж үзэх хандлага нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхэд нөлөөлдөг хамгийн түгээмэл бөгөөд хамгийн их уршигтай төөрөгдөл юм. Энэ хандлага нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бол ямар нэг хэмжээнд “өвчтэй”, “эмгэгтэй”, тиймээс тэднийг “анагаах”, “эмчлэх” хэрэгтэй гэсэн утга санааг агуулдаг. Хөгжлийн бэрхшээлийг хүндрэлтэй асуудал мэт харж, түүнийг шийдэх арга замыг эмнэлзүйн үйл ажиллагаа гэж тодорхойлсноор хувь хүн, нийгэм, төр засаг нь нийгэм, хувь хүмүүсийн хандлагаас үүдэлтэй хүний эрхийн саад тотгорыг арилгах талаар хүлээх үүрэг хариуцлагыг өөрсдөөсөө холдуулж байгаа хэрэг юм. Улмаар тэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “асуудлыг” эмнэлэг, эмч нарт тохоон үлдээдэг.

### **Хөгжлийн бэрхшээлд хандах өглөг хандивын загвар**

Өөр нэг ноцтой төөрөгдөл бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрийгөө аваад явах чадваргүй тул тэднийг халамжлах хэрэгтэй гэсэн үзэл юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй харьцахдаа өөрт төрөх эвгүйцэл, айдсыг өрөвдөл, өглөгөөр солих нь хүмүүст хавьгүй хялбар байдаг шүү дээ. Мөн хэн нэгний төлөө ямар нэг зүйлийг шууд хийх нь хүн өөрийнхөө төлөө бүхнийг өөрөө хийх боломж, нөхцлөөр хангахаас хамаагүй амар байдаг.

Эмнэлзүй болон хандивын эдгээр хоёр загвар нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өөрийнхөө амьдралд эзэн байх, бусадтай адил тэгшээр эрхээ эдлэх боломжийг нь булааж авах үр дагаварт хүргэдэг.

## Эерэг хандлага, үзэл баримтлал

### Хөгжлийн бэрхшээл бол хүний олон талт байдлын нэг хэсэг мөн

Арьсны өнгө, хүйс, яс үндэс, гарал үүсэл, хэлбэр галбир, жин хэмжээ болон өөр олон талаараа хүмүүс ялгаатай байдаг. Хөгжлийн бэрхшээл үүнтэй л адил. Хөгжлийн бэрхшээлээсээ болоод хүний хөдөлгөөн, эсвэл сонсох, үнэрлэх, амтлах чадвар хязгаарлагдсан байж болно. Нийгэм-сэтгэцийн буюу **оюуны хөгжлийн бэрхшээл** нь зарим хүний сэтгэх, мэдрэх, мэдээлэл боловсруулах чадварт нөлөөлж болно. Мөн чанар нь ямар байхаас үл хамааран хөгжлийн бэрхшээл нь ямар ч хүний эрх, үнэлэмж, хүмүүнлэг чанарыг нэмэгдүүлэх, багасгах нөлөө үзүүлэхгүй. Хөгжлийн бэрхшээл бол тэр хүний л нэг хэсэг юм.

### Боломжит тохируулга

Хөгжлийн бэрхшээлээс болоод хүмүүст тэргэнцэр зэрэг дэмжих хэрэгсэл, эсвэл даалгаврыг гүйцэтгэхэд илүү хугацаа гэх мэт нэмэлт нөхцөл шаардагдаж болно. Боломжит тохируулга бол хөгжлийн бэрхшээлтэй хүний бүрэн дүүрэн оролцоо, хүртээмжийг дэмжих, өөрөө аливаа зүйлийг хийж гүйцэтгэхэд нь дэм болох зориулалттай нөөц, эсвэл арга хэмжээ төдий л юм. Энэ бол хөгжлийн бэрхшээлийг нь юмуу ийм бэрхшээлтэй хүнийг хэвийн байдалд оруулахыг оролдох (Эмнэлзүйн загвар), эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өөрсдийгөө аваад явах чадваргүй гэж үзэх (Хандив өглөгийн загвар) хандлагаас ялгаатай юм.

### Хөгжлийн бэрхшээлийн талаарх Нийгмийн загварууд

Энэ загвар нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхээ эдлэх чадавхийг нь хязгаарлаж байгаа нийгмийн болон дэд бүтцийн саад тотгорыг арилгахад төвлөрдөг. Үүнд, жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх эерэг хандлага, үзэл бодлыг сурталчлан төлөвшүүлэх, барилга байгууламжийг өөрчлөн нийцүүлэх, **ойлгомжтой хэлбэрээр** мэдээллийг хүргэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй тохиромжтой арга хэлбэрээр харилцах, хууль тогтоомж бодлогоороо хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүрэн оролцоог хангах, ялгаварлан гадуурхахгүй байх зэрэг багтана.

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН АСУУДАЛД ХҮНИЙ ЭРХИЙН БАЙР СУУРИНААС ХАНДАХ НЬ

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоо, хүртээмж, хамрагдалтыг хангахад төр засаг, нийгмийн хүлээх үүрэг хариуцлагыг чухалчилдаг. Хөгжлийн бэрхшээлийн талаарх нийгмийн загвар нь хөгжлийн бэрхшээлд хүний эрхийн байр сууринаас хандах хандлагын суурь болдог. Энэхүү хандлага нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төрөлхийн хүний эрхэд тулгуурладаг бөгөөд энэ нь:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрх эзэмшигч хэмээн **тодорхойлж**, бусад хүмүүстэй адил тэгш эрхтэй олон улсын хүний эрхийн хуулийн этгээд гэж үздэг
- Хүнд илэрч болох хөгжлийн бэрхшээлийг хүмүүний бие биенээсээ ялгагдах шинжүүдийн нэгэн хэлбэр (арьсны өнгө, хүйсийн адил) хэмээн **хүлээн зөвшөөрч** хүндлэн, хөгжлийн бэрхшээлтэй холбоотой сүжиг, хандлага, эрхээ эдлэхэд нөлөөлж буй бусад саад тотгорыг арилгах асуудлыг чухалчилдаг



- Тухайн улсын улстөр, эрхзүй, нийгэм болон дэд бүтцийн орчин нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хэрэгжилт, тэдний хамрагдалт, оролцоог дэмжсэн байх нөхцлийг хангах хариуцлагыг засгийн газар, нийгэмд **оногдуулдаг**.

НҮБ-ын **Хүний эрхийн дээд комиссарын газар** (ХЭДКГ) эрхэд тулгуурласан хандлагыг дараах байдлаар тоймлон тодорхойлжээ:

“Хүний эрхэд тулгуурласан хандлага нь нийгмийн нэг хэсэг нь эмзэг, шоовдорлогдсон, ялгаварлан гадуурхагдсан байдалтай байгаагийн урт хугацааны, эсвэл суурь шалтгаан юунд оршиж байна вэ гэж асуудаг.

Дараа нь олон улсын хүний эрхийн эрхзүй, хэм хэмжээг ашиглан энэ ялгаварлан гадуурхлын үндэс суурь болж буй шалтгааныг арилгахад чиглэсэн стратегийг энэ хандлага гаргаж өгдөг.”

ХЭДКГ нь дараах санааг онцгойлон чухалчилжээ:

**Чадавхижуулах:** Хүний эрхэд тулгуурласан хандлага нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдийнхөө хүсэл зорилгод нийцсэн сонголт хийх, өөрсдийгөө өмгөөлөн хамгаалах, амьдралдаа эзэн болох чадварыг нь бэхжүүлэхийг зорьдог.

**Хэрэгжүүлэхэд анхаарах, зөрчил гарвал арилгах арга хэмжээ авч байх:** Хүний эрхэд тулгуурласан хандлага нь хөгжлийн бэрхшээлтэй хүн эрхээ үндэсний болон олон улсын түвшинд хэрэгжүүлж, эдлэх боломжтой байх ёстой гэсэн утгатай.

**Нэгдмэл байдал:** Хүний эрхэд тулгуурласан хандлага нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн иргэний болон улс төрийн эрх, мөн тэдний эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн аль алиныг нь хамгаалах ёстой гэж үздэг.

**Оролцоо:** Хүний эрхэд тулгуурласан хандлага нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралд нөлөөлөх асуудлаар шийдвэр гаргахдаа тэдний саналыг авах, тэднийг оролцуулахыг шаарддаг<sup>9</sup>.

Хүний эрхээ эдлэхэд учирдаг саад тотгорууд нь хандлага, сүжиг, бодит амьдрал дээрх нөхцөл байдал, эрхзүйн хязгаарлалт, эсвэл эдгээрийн нийлбэрээс үүдэлтэй байж болно. Харин хүний хөгжлийн бэрхшээл нь өөрөө эрхээ эдлэх боломжийг нь хязгаарлах юмуу өөр ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг юуны өмнө бусадтай адил тэгш эрх эзэмшигч, хүний эрхийн хуулийн этгээд гэж тодорхойлох нь бусад хүмүүсийн ойлголт, хандлагыг өөрчлөх, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах тогтолцоог төлөвшүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулах хүчтэй хандлага юм.

9 “Удирдамжийн төсөл: Ядуурлыг бууруулах стратеги дахь хүний эрхийн хандлага”, 2002 оны 9 сарын 10. НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газрын веб хуудас: [www.unhcr.ch/development/povertyfinal.html](http://www.unhcr.ch/development/povertyfinal.html)



## ДАСГАЛ 5: Бидний ашигладаг үг хэллэг ба хүний эрх

- Зорилт:** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгэмд гүйцэтгэх үүрэг ролийн талаарх эерэг ба сөрөг хандлагыг бэхжүүлэхэд бидний ашиглаж байгаа үг, хэллэг хэрхэн нөлөөлж байгааг ойлгох
- Хугацаа:** 45 минут
- Материал:** Том цаас, фломастер, эсвэл самбар, шохой

### 1. Танилцуулах

Бидний ашигладаг үг, хэллэг нь хөгжлийн бэрхшээлийн талаарх эерэг, сөрөг хандлагуудыг бэхжүүлэх нөлөөтэй байж болохыг тайлбарла. Үүнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хэрхэн нэрлэж, хөгжлийн бэрхшээлийг ямар үг, найруулгаар дүрсэлж, эсвэл тэдний гэр бүл, нийгэмдээ гүйцэтгэх үүргийг ямар үг, хэллэгээр илэрхийлж байгаа зэрэг багтана. Хүмүүсийн хэрэглэхээс зайлсхийж буй үг, хэллэгэд хүртэл тэдний хандлага туссан байдаг.

### 2. Санал солилцох

Дасгалыг гүйцэтгэхийн тулд оролцогчдыг жижиг багуудад хуваа. Багаараа хөгжлийн бэрхшээл, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний нийгэм, гэр бүлдээ гүйцэтгэх үүрэг ролийг дүрслэхдээ бидний ашигладаг үг, хэллэгийн жишээнүүдийг гаргаж ирэх даалгавар өг.

### 3. Илтгэх/шинжлэх

Багууд хийсэн ажлаа ээлжлэн танилцуулна. Доорх хүснэгтийг самбар дээр зураад, багуудын нэрлэх үг, хэллэгүүдээр бөглөнө. Дараа нь доорх асуултуудын дагуу хэлэлцүүлэг хий:

- Төрөлх хэлний тань эдгээр үг, хэллэг нь хөгжлийн бэрхшээл болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бусад хүмүүс хэрхэн хандаж байгааг харуулсан ямар хандлагуудыг тусгасан байна вэ?
- Эдгээр үг, хэллэг нь хөгжлийн бэрхшээлийн талаарх сөрөг хандлагыг (эмнэлзүйн загвар, өглөг хандивын загвар зэрэг) хэрхэн тусгаж байна вэ? Мөн эдгээр сөрөг хандлагыг хэрхэн улам тодруулж, бэхжүүлж байна вэ?
- Энэ үг, хэллэг нь эерэг үзэл хандлагыг хэрхэн тусгаж байна вэ? Эерэг хандлагыг хэрхэн тодруулж, дэмжиж байна вэ?
- Энэ үг, хэллэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хэрхэн нөлөөлдөг вэ?
- Сөрөг агуулга бүхий үг, хэллэгийг өөрчлөхийн тулд юу хийж болох вэ?
- Хөгжлийн бэрхшээлд хүний эрхийн үүднээс хандах хандлага нь ямар ямар давуу талтай байна вэ? Түүнийг хэрхэн хөхиүлэн дэлгэрүүлэх вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй холбоотой үг, хэллэг		
Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс	Хөгжлийн бэрхшээл	Хөгжлийн бэрхшээлтэй хүний гүйцэтгэдэг үүрэг



Хүн болгон хүний эрхээ хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэхийг шаардах эрхтэй. Хэрэв та хүний эрхийн нөлөөллийн үйл ажиллагаа явуулахдаа хүний эрхийн эрхзүйн хүрээг ашиглавал таныг онцгой эрх дарх, онцгой харьцаа, хандлагыг шаардаж байна гэж хэн ч буруушааж чадахгүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцийг бүрэн хэрэгжүүлэхэд холбогдох бүх талууд өөр өөрийн үүрэгтэй.

“Хүний эрхийн төлөө!” хэмээх энэ гарын авлага нь хүний эрхийг хамгаалах нөлөөллийн ажилд тань дэмжлэг болох зорилготой. Эхний энэ бүлэгт хөгжлийн бэрхшээлтэй холбоотой хүний эрхийн зарчим, эрхзүйн баримт бичиг, нийгмийн хандлага зэргийг дэлгэрэнгүй танилцууллаа. 2 дугаар бүлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхтэй холбоотой тодорхой сэдвүүдээр нарийвчилсан мэдээлэл өгч, үндэсний бодлого, хууль, мөн нийгмийн болон соёлын орчинд өөрчлөлт хийхэд шаардлагатай мэдлэгийг хүний эрхийн идэвхтнүүдэд өгөх болно. 3 дугаар бүлэг нь нөлөөллийн стратеги, арга техникийг эзэмшүүлэх сургалтын хэсэг бөгөөд нөлөөллийн үйл ажиллагааны зорилгоо тодорхойлох, төлөвлөгөө боловсруулах, түүнийхээ үр дүнг хэмжих зэрэг сэдвийг хамарна.

Хүний эрхийн хууль батлаад л хүний эрхийг хэрэгжүүлээ гэж үзэж болохгүй. Мөн сайн санаа, эерэг хандлага нь дангаараа хангалтгүй юм.

**Хувь хүний хүчин чармайлтгүйгээр, нийгэм соёлын бүлгүүдийн чин эрмэлзэлгүйгээр, засгийн газрын хатуу хяналт, хэрэгжилтгүйгээр хүний эрх баталгаажихгүй!**



## ХЭСЭГ 2. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦИ



### ХОЁРДУГААР ХЭСГИЙН АГУУЛГА

Бүлэг	1. Адил тэгш байдал ба үл алагчлал . . . . .	26
Бүлэг	2. Хүртээмж. . . . .	40
Бүлэг	3. Нийгмийн болон улс төрийн амьдралд оролцох эрх . . . . .	54
Бүлэг	4. Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө . . . . .	67
Бүлэг	5. Амьд явах эрх болон эрсдэлт нөхцөлд хамгаалуулах эрх . .	78
Бүлэг	6. Эрүү шүүлт болон бусад хэлбэрийн хэрцгийллээс ангид байх эрх чөлөө . . . . .	96
Бүлэг	7. Хувийн нууц, нэгдмэл байдал, орон гэр болон гэр бүлийг хүндэтгэх нь . . . . .	113
Бүлэг	8. Эрүүл байх эрх . . . . .	128
Бүлэг	9. Сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээ авах эрх . . . . .	150
Бүлэг	10. Хөдөлмөрлөх эрх . . . . .	164
Бүлэг	11. Амьдарч буй орчиндоо бие даан, нэр төртэй амьдрах эрх. . . . .	176
Бүлэг	12. Шүүх ажиллагаанд хүртээмжтэй оролцох нь . . . . .	189
Бүлэг	13. Сурч боловсрох эрх . . . . .	198
Бүлэг	14. Соёл, спортын арга хэмжээнд оролцох эрх . . . . .	213
Бүлэг	15. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрх . . . . .	231
Бүлэг	16. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн тэгш эрх, үл алагчлал . . . . .	249
Бүлэг	17. Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын бусад бүлгийн хүний эрх . . . . .	265

## БҮЛЭГ 1. АДИЛ ТЭГШ БАЙДАЛ БА ҮЛ АЛАГЧЛАЛ

### НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци

#### 5 дугаар зүйл. Адил тэгш байдал, үл алагчлал

1. Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд хуулиар ямарваа нэгэн алагчлалгүйгээр тэгш хамгаалуулж, адил ашиг хүртэх эрхтэй болохыг оролцогч улсууд хүлээн зөвшөөрнө.
2. Оролцогч улсууд нь хүнийг хөгжлийн бэрхшээлийн улмаас бүх хэлбэрээр алагчлах явдлыг хориглох бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг аливаа хэлбэрийн алагчлалд өртөхөөс хамгаалах адил тэгш, үр дүнтэй хууль зүйн хамгаалалтыг бий болгоно.
3. Тэгш байдлыг хөхиүлэн дэмжих, алагчлалыг устгах үүднээс оролцогч улсууд нь боломжит тохируулгыг хангах бүхий л алхмыг хийнэ.
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш байдлыг *de facto* хангах, ийм байдлыг бий болгоход чиглэсэн зайлшгүй шаардлагатай тусгай арга хэмжээнүүдийг энэхүү конвенцийн агуулгад алагчлал гэж үзэхгүй.

#### 2 дугаар зүйл. Тодорхойлолт (хэсэгчилсэн ишлэл)

*“Хөгжлийн бэрхшээлийн улмаас алагчлах” гэж улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, иргэний болон бусад салбарт хүний эрх, үндсэн эрх чөлөөг бусадтай адил тэгш байх үндсэн дээр эдлэх явдлыг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан сулруулах буюу ийм эрхийг хүлээн зөвшөөрөхийг үгүйсгэх зорилго агуулсан, эсхүл тийм үр дүнд хүргэсэн бүх төрлийн алагчлал, гадуурхал, хязгаарлалтыг хэлнэ. Энэ нь алагчлалын бүх хэлбэр, түүний дотор боломжит тохируулга хангаж өгөхөөс татгалзах явдал мөн хамаарна.*

#### 3 дугаар зүйл. Нийтлэг зарчмууд

Энэхүү конвенцийн зарчмууд нь:

- a) сонголт хийх эрх чөлөө болон хүний бие даасан байдлыг оролцуулан хүний нэр төр, нандин чанар, хувийн хараат бус байдлыг хүндэтгэх;
- b) алагчлахгүй байх;
- c) нийгэмд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох болон хамрагдах;
- d) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлог байдлыг хүндэтгэх, тэднийг хүний ялгаатай байдал, хүн төрөлхтний нэг хэсэг гэж хүлээн авах;
- e) тэгш боломж олгох;
- f) хүртээмжтэй байх;
- g) эрэгтэй, эмэгтэйчүүд тэгш эрхтэй байх;
- h) хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьсаж өөрчлөгдөх чадамжийг хүндэтгэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өөрийн онцлог байдлаа хадгалах эрхийг хүндэтгэн хандах.

## ЗОРИЛТУУД

Энэ бүлгийн үндсэн мэдээлэл, дасгалууд нь оролцогчдод дараах зорилтыг хангахад туслах зорилготой:

- Адил тэгш байх, үл алагчлагдах эрхийг тодорхойлох
- Адил тэгш байх ба үл алагчлагдах эрх нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд ямар ач холбогдолтой болохыг тайлбарлах
- Тэгш байдал, үл алагчлал болон хүний бусад эрхийн хоорондын уялдааг ойлгох
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш байдал, үл алагчлагдах эрх хэрхэн хангагдаж эсвэл зөрчигдөж байгааг мэддэг болох
- НҮБ-ын **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн** (ХБХЭК) тэгш байдал ба үл алагчлалтай холбоотой заалтуудыг ойлгох.

## ЭХЛЭЛ: ТЭГШ БАЙДАЛ БА АЛАГЧЛАГДАХГҮЙ БАЙХ ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЭХ НЬ

“Тэгш байдал”, “үл алагчлал” зэрэг ухагдахуун нь хүний эрхийн хамгийн суурь үзэл баримтлал боловч эдгээрийн цаад утгыг сайтар ойлгохгүйгээр хэрэглэх явдал элбэг гардаг. Тэгш байх, үл алагчлагдах зарчмуудыг ойлгох нь хүний эрхийн нөлөөллийн үйл ажиллагааг амжилтад хүргэхэд чухал нөлөөтэй.

### Тэгш байдал

Тэгш байдал гэдэг нь хамгийн энгийнээр тайлбарлавал “адил байх”, “тэнцүү байх”, “таарч нийцэх”, “ижил байх” гэсэн үг юм. Адил тэгш байна гэдэг нь хүмүүс бие биетэйгээ яг адилхан, нэг нэгнийхээ хуулбар гэсэн үг огт биш. Хүмүүс хоорондоо яг ижилхэн байна гэж огт үгүй! Хүний эрхийн хүрээнд тэгш байдал гэдгийг хэрэглэхдээ хүмүүс хоорондоо ялгаатай ч бид бүгд хүн гэдгээрээ нийтлэг шинжтэй, үүгээрээ ч үнэ цэнэтэй бөгөөд ижил юм гэсэн утгатай. Бид хүн л учир хүний эрх эдэлдэг бөгөөд бусдаас ялгаж байгаа шинж чанарууд нь хүнийг хэн нэгнээс илүү, эсвэл дорой болгодоггүй. Практик дээр энэ зарчим нь хүн бүр, нийгэм бүхлээрээ хүмүүний ялгаатай байдал, тэр дундаа хөгжлийн бэрхшээлээс үүдэлтэй ялгааг ойлгож, хүндэтгэж хандахыг шаардана.

Тэгш байдлын зарчмыг ойлгож, хэрэглэх талаар хэд хэдэн хандлага байдаг. Эхнийх нь “**эрхзүйн тэгш байдал**” юм. Энэ нь, тухайлбал, нийгмийн аль ч бүлгийг ялгаварлан гадуурхаж болохгүй гэсэн заалтыг хууль болон бодлогын баримт бичгүүдэд оруулах замаар янз бүрийн бүлэгт адил хандах эрхзүйн шаардлага тавихыг хэлж байгаа юм. Хэдийгээр энэ нь илт ойлгомжтой, чухал ач холбогдолтой зарчим боловч амьдрал дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон нийгмийн бусад бүлгүүд тэгш эрхтэй болохыг тунхагласнаар асуудал бүрэн шийдэгддэггүй. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгардаг өөр өөр нөхцөл байдлыг тооцон үзэж, тэдний бүрэн дүүрэн оролцоог хязгаарладаг нийгмийн бүтээсэн хиймэл саад тотгорыг арилгахад чиглэсэн арга хэмжээ авах шаардлагатай. Жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бусдын адилаар хандаж харьцахыг зөвхөн уриалах нь үр дүнд



хүргэхгүй. Ийм уриалгаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст учирдаг дэд бүтцийн, мэдээллийн, харилцааны, хандлагын саад тотгорыг арилгаж чадахгүй, мөн хөгжлийн бэрхшээлийн улмаас тусгай арга хандлага шаардлагатай хүмүүсийн хэрэгцээг ч хангаж чадахгүй.

Тэгш байдлын талаарх өөр нэг хандлага бол **тэгш боломж** юм. Хүнээс өөрөөс нь огт хамаарахгүй хүчин зүйлсээс, жишээлбэл, хүйс, арьсны өнгө, хөгжлийн бэрхшээл, нийгмийн гарал үүсэл зэргээс үүдэлтэй саад тотгор учирч болохыг энэ хандлага сануулдаг. Эдгээр хүчин зүйл дангаараа болон нийгэмд тогтсон үзэл, бусад саад тотгортой хавсраад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүссэнээрээ амьдарч, нийгэмдээ хүссэнээрээ нэмэр хандив болох боломжийг хумьж болох юм. Ийм учраас боломжийг тэгш байлгах үүднээс эрхзүйн тэгш байдлаас нэг алхам ахиж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бусадтай адил тэгш байх боломжийг хангаж өгөхөд чиглэсэн тусгай арга хэмжээ авах шаардлага гарна. Эдгээр арга хэмжээнд нийтийн тээврийн хүртээмжийг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхахад хүргэдэг хэвшмэл үзэл, буруу хандлагатай тэмцэх, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, бусад салбарт боломжит тохируулга хийх зэргийг багтааж болно.

Гуравдах хандлага нь **“жинхэнэ тэгш байдал”** буюу **“де факто тэгш байдал”** юм. Энэ нь зөвхөн боломжийг тэгшитгэхээр хязгаарлахгүй, мөн үр дүнг тэгш байлгахад чиглэсэн хандлага юм. Өөрөөр хэлбэл, **“де факто тэгш байдал”**-ын зарчмаар бол ямар ч хүн ур чадвар, гавьяанаасаа үл хамааран хүний эрхээ бүрэн эдлэх эрхтэй.

Хэдийгээр тэгш боломжийн зарчмыг бодитойгоор хэрэгжүүлж чадвал хөгжлийн бэрхшээлтэй ихэнх хүн эрхээ хүссэнээрээ бүрэн эдлэх боломжтой болж болох ч төрөөс **“де факто тэгш байдлыг”** бий болгоход чиглэсэн нэмэлт хүчин чармайлт гаргавал хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх илүү бүрэн дүүрэн хангагдах юм. Жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхахгүй байх шаардлагыг ажил олгогчдод тавьсан ч гэсэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ямар нэг байдлаар тухайн ажилд тэнцэхгүй байх юм бол тэдний хөдөлмөрлөх эрх бүрэн хангагдахгүй. Иймд хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд **де факто тэгш байдлыг** бий болгохын тулд хөдөлмөрийн зах зээл дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бусадтай эн тэгш өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд төр, засаг тэднийг сурган дадлагажуулахад анхаарах хэрэгтэй болно.

## Үл алагчлал

“Үл алагчлал” буюу үл ялгаварлал гэсэн зарчмыг авч үзэхийн өмнө эхлээд “ялгаварлал” (англиар *discrimination*) гэсэн үгийн утгыг тайлбарлах хэрэгтэй. Энэ үг нь аливаа зүйлийг ялгах, онцгойлох, мөн “өөрөөр хандах” гэсэн утгатай бөгөөд эерэг, сөрөг аливаа утга агуулдаггүй. Гэхдээ хүмүүсийн хоорондын харилцаанд бол энэ үг сөрөг утгатай, хэн нэгнийг “ялгаварласан” бол тэр хүнд өөрөөр хандаад зогсохгүй бас шударга бус хандсан гэсэн утгатай болдог. Ийм шударга бус хандлага ил тод хэлбэртэй (жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хуулиар ялгаварлах), эсвэл далд хэлбэртэй байж болно (жишээлбэл, дүрэм журамдаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг илт алагчлаагүй ч хэрэгжүүлэх үйл явцад сөрөг хандлага гаргах). Далд хэлбэрийн ялгаварлан гадуурхал нь хүний нүдэнд тусдаггүй, хууль журам нь шударга үйлчилж байгаа мэт сэтгэгдлийг хүмүүст төрүүлдэг учраас илүү их хор уршигтай юм.

Энэ хоёр хэлбэрийн ялгаварлан гадуурхлыг заримдаа “шууд” ба “шууд бус” гэж нэрлэдэг ч хэрхэн нэрлэхээс илүүтэйгээр үүнээс үүсэх хор уршгийг ойлгох, түүнтэй тэмцэх арга хэлбэрийг мэдэх нь илүү чухал юм. Олон улсын хүний эрхийн эрхзүйд тодорхой үндэслэлээр, жишээлбэл, хөгжлийн бэрхшээл, арьсны өнгө, хүйс, яс үндэс болон бусад шинжээр алагчлах бүх хэлбэрийг хориглосон байдаг. Улмаар үл алагчлалын зарчим нь гадуурхал, алагчлалын эдгээр хэлбэрийг гаргуулахгүй байх, далд буюу шууд бус гадуурхалтай тэмцэх арга хэмжээ авахыг шаарддаг. Ялгаварлал нь хувь хүмүүсийн хооронд, эсвэл хууль тогтоомж, бодлого, дүрэм журмаар тогтмол, системтэй гарч байна уу гэдгээс үл хамааран улс орнууд түүнтэй тэмцэх ёстой.

Алагчлалтай холбоотой хамгийн адармаатай зүйл бол төрөөс хүмүүст ялгавартай хандахыг дандаа хориглоод байдаггүй, тэр ч бүү хэл заримдаа чингэх зайлшгүй шаардлагатай гэж үздэг явдал билээ. Энэ нь үл ялгаварлал, тэгш эрх гэсэн хоёр зарчмын харилцан үйлчлэлээс үүдэлтэй нөхцөл юм. Жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн бүлгийнх нь хувьд ялгаварлан гадуурхсаар ирсэн урт хугацааны түүхэн нөхцлийн улмаас тэд бусад хүмүүстэй адил тэгшээр эрхээ эдэлж чадахгүй явсаар ирсэн. Эл байдлыг өөрчлөхийн тулд “тусгай арга хэмжээ”, “илт дэмжсэн арга хэмжээ”, “шударга ялгаварлал”, “ээрэг ялгаварлал” гэж нэрлэж болох арга хэмжээг авах хэрэгцээ гарч иржээ. Энэ хандлагыг хэрхэн нэрлэхээс үл хамааран цаад зорилго нь тэгш байдалд хүрэх явдал бөгөөд түүнд хүрэхийн тулд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зарим харьцангуй давуу талыг олгох явдал юм. Жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажил олгогчид нь үнэлдэг, илүү олон ийм хүнийг ажилд авдаг болгох үүднээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бусад хүмүүсээс давуу боломж олгох зарчим баримталж болох юм. Эдгээр арга хэмжээ нь хүмүүст ялгавартай хандах нөхцлийг үүсгэж байгаа ч эдгээр нь хязгаарлалтыг даван туулж, тэгш байдалд хүрэх, хүний эрхийг зөрчих бус харин ч хөхиүлэн дэмжих зорилготой учраас “алагчлал, гадуурхал” гэж тооцогдохгүй. Тэр ч бүү хэл, ХБХЭК-ийн 2 дугаар зүйлээр, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст боломжит тохируулгыг хангаж өгөхгүй байх нь конвенцийг зөрчсөн, хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхсан хэрэг гэж тооцогдоно.

Тэгш байдал, үл алагчлалын зарчмууд харилцан бие биедээ үйлчлээд зогсохгүй хүний бусад эрхтэй **нэгдмэл, уялдаа холбоотой, харилцан хамааралтай** юм. Жишээлбэл, төрөөс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ажил эрхлэлтийг хязгаарласан хууль гаргавал энэ нь тэдний хөдөлмөрлөх эрхийг зөрчсөн хэрэг болоод зогсохгүй ялгаварлан гадуурхлын илт хэлбэр, адил тэгш байх эрхийн зөрчил юм. Тэгш байдал, үл алагчлалыг хангаагүй тохиолдолд хүний эрх бодитойгоор хангагдсан гэж үзэх үндэслэлгүй. Тийм ч учраас хүний тодорхой эрхийг хангаж өгөх нь хангалгүй бөгөөд эдгээрийг дагаад үл алагчлал, тэгш байдлыг хангасан нөхцөлд л хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрхээ бүрэн эдлэх боломжтой болно гэж зарим хүн үздэг. Жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст боловсролын үйлчилгээнд хамрагдах боломжийг хангаж өгөөгүй хэрнээ боловсрол эзэмших эрхээ эдлэхэд нь ялгаварлан гадуурхахгүй байх шаардлага тавих нь хангалтгүй юм. Үүнтэй адилаар, төрөөс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст боловсролын үйлчилгээ хүртэх боломжуудыг хангаж өгсөн хэрнээ энэ үйлчилгээг ашиглахад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхах явдал гарч байгаа бол энэ эрх бүрэн хэрэгжихгүй. Иймээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нэр төр, нандин чанараа хүндэтгүүлсэн байдлаар хүний эрхээ жинхэнэ утгаар нь эдлэх боломжийг хангаж өгөхийн тулд төр засаг нь тэгш байдал, үл алагчлалын зарчмыг хэрэгжүүлэх, мөн хүний эрхийг хангах гэсэн хоёр асуудалд нэгэн зэрэг анхаарах шаардлагатай.



## Тэгш байдал, үл алагчлал ба хөгжлийн бэрхшээлийн талаарх үндэсний хууль тогтоомжуудад туссан хандлагууд

Эдгээр суурь зарчмуудын ач холбогдлыг хүлээн зөвшөөрч хүндэтгэсний үндсэн дээр олон орон Үндсэн хуульдаа тэгш байдал, үл алагчлах зарчмыг тусгай зүйл, заалт болгож оруулсан байдаг. Мөн хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхахыг хориглосон заалтуудыг Үндсэн хуульдаа оруулах явдал нэмэгдэж байна. Ийм заалтуудыг янз бүрийн орны хуульд хэрхэн тусгасныг харуулах зарим жишээг энд өгөв (“хөгжлийн бэрхшээл”-ийг илт дурьдсан хэсгүүдийг тод хараар онцоллоо):

### Канадын Хүний эрх, эрх чөлөөний тухай хууль Адил тэгш байх эрх

- (1) Хүн болгон гарал үүсэл, арьсны өнгө, шашин шүтлэг, хүйс, нас, биеийн болон сэтгэцийн **хөгжлийн бэрхшээлээс** үл хамааран хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчлалгүйгээр хуулиар адил тэгш хамгаалуулж, үр шимийг нь хүртэх эрхтэй.
- (2) Дэд хэсэг 1 нь гарал үүсэл, арьсны өнгө, шашин шүтлэг, хүйс, нас, биеийн болон сэтгэцийн **хөгжлийн бэрхшээл** болон бусад шалтгаанаар эмзэг болсон хүмүүс, бүлэг хүний нөхцөл байдлыг сайжруулахад чиглэсэн хууль, хөтөлбөр, арга хэмжээг хориглосон заалт болохгүй.

### Фижигийн Үндсэн хууль 38 дугаар хэсэг. Тэгш байдал

- (1) Хүн бүр хуулийн өмнө адил тэгш байх эрхтэй.
- (2) Доорх үндэслэлээр хүнийг илт болон далдуур шударга бусаар ялгаварлан гадуурхаж үл болно:
  - (а) Гарал үүсэл, яс үндэс, арьсны өнгө, төрсөн нутаг, шашин шүтлэг, хүйс, бэлгийн чиг хандлага, өмч хөрөнгө, нас, хөгжлийн бэрхшээл зэрэг тухайн хүний бодит болон төсөөлөгдсөн шинж чанар
  - (б) Бусад хүнд хохирол учруулах, бусад хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах үр нөлөөтэй, эсвэл Үндсэн хуулиар хориглосон бусад үндэслэлээр биш л бол хүний үзэл бодол, итгэл үнэмшил

### Өмнөд Африкийн Үндсэн хууль 2 дугаар бүлэг: Хүний эрхийн тухай хууль 9. Тэгш байдал

1. Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд хуулиар адил тэгш хамгаалуулж, үр шимийг нь хүртэх эрхтэй.
2. Тэгш байдал нь эрх, эрх чөлөөг бүрэн дүүрэн, адил тэгш эдлэх ойлголтыг багтаана. Тэгш байдлыг хангах зорилгоор шударга бус ялгаварлан гадуурхлын улмаас эмзэг байдалд орсон хувь хүн, бүлэг хүмүүсийг хамгаалсан хууль эрхзүйн болон бусад арга хэмжээг авч болно.
3. Төр нь хүний үндэс угсаа, хүйс, жендер, бие давхар байдал, гэр бүлийн байдал, яс үндэс, нийгмийн гарал, шашин шүтлэг, арьсны өнгө, бэлгийн чиг хандлага, нас, **хөгжлийн бэрхшээл**, ухамсар, итгэл үнэмшил, соёл, хэл, төрсөн байдал зэрэг шинжийн аль нэг юмуу хэд хэдийг нь үндэслэн илт болон далдуур шударга бусаар алагчилж үл болно.



4. 3 дугаар зүйлд заасан шинжүүдийн аль нэг юмуу хэд хэдийг нь үндэслэн хэн ч хэнийг ч алагчилж үл болно. Шударга бус ялгаварлалыг хориглох, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор үндэсний хууль батлан хэрэгжүүлнэ.
5. Ялгаварлал нь шударга болох нь тогтоогдоогүй л бол 3 дугаар зүйлд заасан шалтгаануудын аль нэг буюу хэд хэдийг нь үндэслэн ялгаварлахыг шударга бус гэж үзнэ.

### **Угандагийн Үндсэн хууль**

#### **Тэгш байдал ба алагчлалаас ангид байх эрх чөлөө**

21. (1) Хүн бүр улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын амьдралын бүхий л хүрээнд ямар ч нөхцөлд хуулийн өмнө адил тэгш байж, хуулиар адил тэгш хамгаалуулна.
- (2) Энэ зүйлийн 1-д заасанчлан хэнийг ч хүйс, яс үндэс, арьсны өнгө, гарал үүсэл, язгуур угсаа, итгэл үнэмшил ба шашин шүтлэг, нийгмийн болон эдийн засгийн байдал, улс төрийн болон бусад үзэл бодол, хөгжлийн бэрхшээл зэрэгт үндэслэн алагчлахыг хориглоно.
- (3) Энэхүү зүйлийн хүрээнд “алагчлах” гэдэг нь хүйс, арьсны өнгө, гарал үүсэл, язгуур угсаа, итгэл үнэмшил ба шашин шүтлэг, нийгмийн болон эдийн засгийн байдал, улс төрийн үзэл бодол, хөгжлийн бэрхшээлээр нь онцолж бусдаас өөрөөр хандах, харьцахыг хэлнэ.
- (4) Энэхүү зүйлийн ямар ч заалт нь парламентаас доорх зорилгыг хангахад чиглэсэн хууль гаргахад хориг болохгүй:
- (а) нийгэмд оршиж байгаа нийгэм, эдийн засаг, боловсролын болон бусад тэнцвэртэй бус байдлыг өөрчлөхөд чиглэсэн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх
  - (б) Үндсэн хуулиар зөвшөөрсөн юмуу шаардсан зүйлсийг баталгаажуулах
  - (в) чөлөөт ардчилсан нийгэмд хүлээн зөвшөөрөгдөхүйц бөгөөд нийцтэй болох нь тогтоогдсон бусад арга хэмжээ авах
- (5) Энэхүү Үндсэн хуулийн аливаа заалтаар зөвшөөрсөн зүйл бүрийг энэхүү заалтад нийцээгүй гэж үзэхгүй.

## **ДАСГАЛ 1.1: Тэгш байх, алагчлагдахгүй байх гэж юуг хэлэх вэ?**

**Зорилт:** Тэгш байдал, үл алагчлал гэж юуг хэлж байгааг ойлгох

**Хугацаа:** 30 минут

**Хэрэглэгдэхүүн:** Том цаас, фломастер, эсвэл самбар, шохой

### **1. Санал солилцох/Хэлэлцэх**

Дараах асуудлуудыг хэлэлцэж, гарсан хариултуудыг жагсаан бич:

1. “Тэгш байдал” гэдэг нь таны хувьд ямар утгатай вэ?
2. “Тэгш байх, алагчлагдахгүй байх эрхээ бүрэн дүүрэн эдэлнэ” гэдэг нь дараах нөхцөлд ямар утга агуулгатай гэж та бодож байна вэ?
  - Та өөрийн амьдралыг хэрхэн зохион байгуулж байгаа тухайд
  - Бусад хүмүүст та хэрхэн хандаж байгаа тухайд
  - Бусад хүмүүс танд хэрхэн хандаж байгаа тухайд
  - Танд нээлттэй байгаа боломжуудын хувьд





- Таны хүртэж болох амьдралын практикт туршлагын хувьд
- Бусад хүмүүс амьдрал, туршлагаа хэрхэн зохион байгуулж, олж авч байгаа тухайд

Эрхзүйн тэгш байдал , тэгш боломж, *де факто* тэгш байдал гэсэн гурван ойлголтын тодорхойлолтыг дахин нэг сануул. Өөрсдөдөө тохиолдсон юмуу хөндлөнгөөс ажигласан тохиолдлуудыг ашиглан эдгээрийн талаар нэг, нэг жишээ гаргахыг оролцогчдоос хүс.

## 2. Төсөөлөх

Оролцогчдыг жижиг багуудад хуваагаад дараах даалгаврыг өг:

Сургууль, ажлын байр, нийгмийн амьдрал зэрэг хүрээнд эрхзүйн тэгш боломжийг эдлэх эрхтэй ч *де факто* тэгш боломжийг бүрэн эдэлж чадахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүн байна гэж төсөөлье. Энэ хүнд нэр, нас, хөгжлийн бэрхшээлийн төрөл, амьдралын нөхцөл зэрэг шинжийг зохиож оноо. Ингээд энэ хүний хувьд дараах зүйлсийг тунгаан бод:

- Энэ хүнд эрхзүйн тэгш боломжийг хангаж өгөхийн тулд ямар саад тотгорыг арилгаж, ямар арга хэмжээ авсан бэ?
- Ямар саад бэрхшээлийг *арилгаагүй* вэ?
- *Де факто* тэгш боломж байсан бол энэ хүний амьдрал хэрхэн өөр байх байсан вэ?

## 3. Танилцуулах/хэлэлцэх

Баг болгоноос зохиомол дүрээ танилцуулахыг хүс. Танилцуулга бүрийн дараа дараах асуултуудын дагуу хэлэлцүүлэг хий:

- Энэ хүнд *де факто* тэгш боломжийг хангаж өгөхийн тулд өөр ямар нэмэлт арга хэмжээ авах хэрэгтэй вэ?
- Тэдгээр арга хэмжээг хэн хариуцах вэ? Хэрхэн хэрэгжүүлэх вэ?

## **Өмнөд Африкийн Тэгш байдлын шүүх, Хүний эрхийн комисс нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хөхиүлэн дэмжиж байна**

2000 онд батлагдсан “Тэгш байдлыг дэмжиж, шударга бус ялгаварлалыг урьдчилан сэргийлэх хууль”-ийг хэрэгжүүлэх хүрээнд Өмнөд Африк улс нь 60 орчим Тэгш байдлын шүүх байгуулжээ. Эдгээр шүүх нь “системийн шинжтэй алагчлал, тэгш бус байдлыг арилгах” зорилготойгоор үзэн ядалтыг турхирсан үг яриа, арьсны өнгөөр ялгаварлан доромжлох, арьсны өнгө, хүйс, хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхах асуудлаар дагнан ажилладаг. Шүүхүүд нь ялгаварлан гадуурхалд хүргэсэн нөхцөл байдлыг арилгах зорилгоор гомдол гаргагчийг дэмжсэн шийдвэр гаргах, тусгай арга хэмжээ авахыг хариуцагчдаас шаардах бүрэн эрхтэй ажээ.

Өмнөд Африкийн Хүний эрхийн комиссын (ӨАХЭК) Тэгш байдлыг дэмжих хэлтэс Өмнөд Африкт “жинхэнэ тэгш байдлыг бий болгох” эрхэм зорилгынхоо хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг зөрчсөн хэд хэдэн хэргийг эдгээр шүүхээр шийдвэрлүүлэхэд идэвхтэй оролцжээ. Тэгш байдлын шүүхээр шийдвэрлэсэн анхны хэргүүдийн нэг нь Өмнөд Африкийн шүүхийн танхимууд тэргэнцэртэй хүмүүст хүртээмжгүй байгаа тухай хөгжлийн бэрхшээлтэй өмгөөлөгчийн үүсгэсэн хэрэг байсан бөгөөд түүнийг ӨАХЭК дэмжин оролцсон юм (энэ хэргийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 189 дүгээр хуудасны “Шударга шүүхийн хүртээмж” нэртэй 12 дугаар бүлгээс үзнэ үү). Шүүхээс үндэсний хэмжээнд шүүхийн танхимуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгох шийдвэр гаргасан бөгөөд энэ шийдвэрийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавих үүргийг засгийн газар хүлээх ёстой гэж үзжээ. 2006 онд дараагийн алхам хийгдэж, Кабега Паркийн цагдаагийн газрын байрыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгох шийдвэр гарчээ. Цагдаагийн газрын барилга байшинг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгохын тулд томоохон засвар хийхийг шаардаад зогссонгүй, засвар дуустал түр зуурын зохицуулалтын арга хэмжээ авахыг (тухайлбал, түрдэг тэргээр дээд давхруудад хүрэх боломжтой болтол дээд давхарт байдаг зарим албыг нэгдүгээр давхарт нүүлгэн байрлуулах г.м.) шүүх шаарджээ. Цаашлаад, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зохимжгүй хандсанаа хүлээн зөвшөөрч, гомдол гаргагчаас бичгээр уучлал гуйхыг улсын болон орон нутгийн цагдаагийн комиссаруудад үүрэг болгосон байна<sup>1</sup>.

### **ДАСГАЛ 1.2: Тэгш байх, үл алагчлагдах зарчмыг хэрэгжүүлэхэд учирдаг саад бэрхшээлүүдийг ойлгох нь**

<b>Зорилт:</b>	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш байх, үл алагчлагдах эрхээ эдлэхэд учирдаг саад бэрхшээлийг таньж мэдэх
<b>Хугацаа:</b>	45 минут
<b>Хэрэглэгдэхүүн:</b>	Том цаас, фломастер эсвэл самбар, шохой

1 “Тэгш байдлын тухай шинэ мэдээ”. 2006 оны 11-12 сар. Өмнөд Африкийн Хүний эрхийн комисс. [http://www.sahrc.org.za/sahrc\\_cms/downloads/equality\\_update\\_dec.pdf](http://www.sahrc.org.za/sahrc_cms/downloads/equality_update_dec.pdf);



## 1. Санал солилцох/Хэлэлцэх

- Янз бүрийн төрөл, хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өдөр тутмын амьдралд нийтлэг тохиолддог алагчлал, тэгш бус байдлын жишээ гаргаад, бүгдийг нь жагсааж бич.
- Алагчлал, тэгш бус байдлын эдгээр жишээнд алагчлал нь зөвхөн хөгжлийн бэрхшээлээс үүдэлтэй юу? Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөр ямар төрөл, хэлбэрийн алагчлалд өртдөг вэ?
- Алагчлал нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгардаг зүйл мөн үү? Тэдний найз нөхөд, гэр бүлийнхэнд мөн тохиолддог уу?

## 2. Шинжлэх

Өмнөх алхмаар гаргасан жагсаалтаас нэг жишээ сонгоод, хосоороо юмуу жижиг багаар дараах асуултуудын дагуу хэлэлцүүлэг хийх даалгавар өг:

- Тэгш бус байдал, алагчлал гарсаар байгаагийн хариуцлагыг хэн хүлээх ёстой вэ?
- Тэгш байх, алагчлахгүй байх зарчмуудыг зөрчих явдал яагаад гардаг вэ? Ялгаварлан гадуурхал гаргаж байгаагаа тэд өөрсдөө мэддэг үү?
- Тэгш бус байдал, алагчлалын үндсэн шалтгаанууд юу вэ?

## 3. Дүрд тоглох

Багаараа хэлэлцсэн зүйлсээ танилцуулаад, хөгжлийн бэрхшээлтэй хүнд учирч болзошгүй ялгаварлан гадуурхал, тэгш бус байдлын наад зах нь нэг үндсэн шалтгаан, саадыг харуулсан дүрийн тоглолт бэлдэж үзүүлэх даалгавар өг.

## 4. Хэлэлцэх

- Тэгш бус байдал, алагчлалын үндсэн шалтгааныг арилгаагүйн улмаас ямар үр дагавар гарах вэ? Хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд? Нийгэмд бүхэлд нь?
- Ямар саад/үндсэн шалтгаан нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хамгийн ноцтой үр дагавар дагуулах вэ? Нийгэмд бүхэлд нь?
- Эдгээр ноцтой үр дагаварт хүргэдэг саад/үндсэн шалтгааныг арилгахын тулд юу хийх хэрэгтэй вэ?
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхсан зан үйл гаргаж байгаагаа хүмүүс мэдэрдэг болохын тулд юу хийх хэрэгтэй вэ?

ТЭГШ БАЙДАЛ, ҮЛ АЛАГЧЛАЛЫН ТАЛААР ХҮНИЙ ЭРХИЙН ЭРХЗҮЙД  
ЮУ ГЭЖ ЗААСАН БАЙДАГ ВЭ?

Хүний эрхийг хэрэгжүүлэхэд тэгш байдал, үл алагчлалын зарчмууд маш чухал нөлөөтэй болохыг хүний эрхийн олон улсын эрхзүйн баримт бичгүүдэд онцолсон байдаг. Жишээлбэл, **Хүний эрхийн түгээмэл тунхаглал**<sup>2</sup> (ХЭТТ) эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эрхтэй болохыг онцлоод, 1 дүгээр зүйлийн эхэнд “Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна” гэж тэмдэглэжээ. ХЭТТ-ын 2 дугаар зүйлд “арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон

2 <http://www.unhchr.ch/udhr> сайтыг үз.

бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад ялгаа” нь ялгаварлан гадуурхах үндэс болохгүй гэжээ. 7 дугаар зүйлд бүх хүн хуулиар тэгш хамгаалуулах, үр шимийг нь адил тэгш хүртэх эрхтэй гэж заасан нь ямар ч хүнийг хуулиар гадуурхах ёсгүй гэсэн санаа юм. ХЭТТ нь гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эрхтэй зэргээр тухайлсан эрхийн хүрээнд тэгш байдлын зарчмыг буулган хэрэглэжээ.

ХЭТТ-ын суурь зарчмууд нь **Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт** (ЭЗНСЭОУП)<sup>3</sup> болон **Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт** (ИУТЭОУП)<sup>4</sup> зэрэгт туссан байдаг. Энэ хоёр пактад эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эрхтэй болохыг (тус бүрийн 3 дугаар зүйл), мөн ХЭТТ-д дурьдсан үндэслэлээр хүмүүсийг гадуурхаж үл болохыг (тус бүрийн 2 дугаар зүйл) онцолжээ. ИУТЭОУП-ийн 26 дугаар зүйлд хуулийн өмнө адил тэгш байх, үр шимийг адил тэгш хүртэх эрхийг тунхагласан байдаг.

Олон улсын бусад гэрээнд ч дээрхтэй төстэй заалтууд оржээ. Тухайлбал, Хүүхдийн эрхийн конвенцийн (ХЭК) 2 дугаар зүйлд янз бүрийн үндэслэлээр, жишээлбэл, хүүхдийн, эсвэл эцэг эхийнх нь хөгжлийн бэрхшээлээс болж алагчлахыг шууд хориглосон байдаг<sup>5</sup>. Заримдаа олон улсын хууль, гэрээ нь бүхэлдээ тодорхой нэг хэлбэрийн алагчлалтай тэмцэх зорилготой байдаг. Жишээлбэл, **Арьсны өнгөөр алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенци** (АӨАБХУК)<sup>6</sup> болон **Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенци** (ЭАБХУК)<sup>7</sup> нь ийм гэрээний жишээ юм.

НҮБ-аас баталсан заавал дагаж мөрдөх албагүй **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боломжийг тэгшитгэх тухай Стандарт дүрмүүд** (Стандарт дүрмүүд)<sup>8</sup> нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох зорилготой бөгөөд нэрэндээ хүртэл тэгш боломжийн зарчмыг шингээжээ. Стандарт дүрмүүдэд орсон бүх дүрэм нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүрэн оролцоог хангах, тэдэнд тэгш боломж олгох зорилготой.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн (ХБХЭК) 2, 3, 5 дугаар зүйлүүд нь тэгш байдал, үл алагчлалтай холбоотой заалтууд юм. 3 дугаар зүйлд (“Нийтлэг зарчмууд”) тэгш байдал ба үл алагчлалын зарчмуудыг дэлгэрэнгүй тайлбарлаагүй ч эдгээр нь конвенцийн хамгийн чухал хоёр зарчим болохыг онцолжээ. Эдгээр зарчим нь бие даасан байдлыг дэмжих, ялгаатай байдлыг хүндэтгэх зэрэг бусад зарчимтай нийлээд конвенцийн бүх заалтыг тайлбарлах, хэрэгжүүлэхэд баримтлах суурь зарчмууд болох ёстой.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хуулийн өмнө тэгш байх, хуулийн хамгаалал болон түүний үр шимийг тэгш хүртэх эрхийг хүлээн зөвшөөрөхийг Оролцогч улсуудаас шаардсан 5 дугаар зүйл нь тэгш байдал, үл алагчлалын асуудлыг илүү нарийвчлан авч үзсэн заалт юм. 5 дугаар зүйл нь мөн хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхахыг шууд хориглоод, “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг аливаа хэлбэрийн алагчлал”-

3 [http://www.unhchr.ch/html/menu3/b/a\\_ccpr.htm](http://www.unhchr.ch/html/menu3/b/a_ccpr.htm) сайтыг үз.

4 [http://www.unhchr.ch/html/menu3/b/a\\_ceschr.htm](http://www.unhchr.ch/html/menu3/b/a_ceschr.htm) сайтыг үз.

5 <http://www.unhchr.ch/html/menu3/b/k2csrc.htm> сайтыг үз.

6 <http://www.unhchr.ch/html/menu3/b/9.htm> сайтыг үз.

7 <http://www.unhchr.ch/html/menu3/b/e1cedaw.htm> сайтыг үз.

8 <http://www.ochcr.org/english/law/opportunities.htm> сайтыг үз.

аас хамгаалсан тэгш бөгөөд үр дүнтэй эрхзүйн хамгаалалт бий болгохыг Оролцогч улсуудаас шаарджээ. Хэдийгээр конвенцийн энэ Зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг алагчлахад хүргэдэг бусад үндэслэлийг шууд жагсаан хориглоогүй ч эдгээрийг конвенцийн Удиртгалын (р) хэсэгт:

*... арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэс угсаа, гарал үүсэл, нийгмийн гарал, өмч хөрөнгө, төрсөн байдал, нас болон бусад шинж зэргээр дурьдсан байгаа.*

Хориглосон үндэслэлүүдийн энэ жагсаалт нь ИУТЭОУП, ЭЗНСОУП, олон улсын хүний эрхийн бусад баримт бичигт дурьдсан үндэслэлүүдтэй төстэй ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг “үндэс угсаа”, “гарал үүсэл”, “нас”-аар ялгаварлан гадуурхаж болохгүй гэж зааснаараа арай өргөн хүрээтэй болж чадсан юм.

5 дугаар зүйлд хүмүүсийг хөгжлийн бэрхшээлээр алагчлахыг шууд хориглосон нь хүний эрхийн олон улсын конвенциуд дотроос анхны тохиолдол юм. Өмнөх үеийн олон улсын конвенциудын алагчилж үл болох үндэслэлийн жагсаалт дотор “хөгжлийн бэрхшээл” гэдэг үгийг дурьдаагдаагүй нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг алагчилж болох нөхцөл болсон гэж хэлж болохгүй нь мэдээж. ИУТЭОУП, ЭЗНСОУП болон олон улсын бусад гэрээнд “бусад байдал”-аар ялгаварлан гадуурхахыг хориглоно гэж заасны дотор хөгжлийн бэрхшээлээр ялгаварлахыг багтаан ойлгох хэрэгтэй. 5 дугаар зүйлд энэ нэр томъёоны тодорхойлолтыг өгөөгүй ч хөгжлийн бэрхшээлээр алагчлахыг ямар нэг эргэлзээ, маргаангүйгээр шууд хоригложээ.

Харин хөгжлийн бэрхшээл болон бусад нэр томъёоны (үүний дотор **боломжит тохируулга** багтана) тодорхойлолтыг конвенцийн 2 дугаар зүйлд өгсөн байна. Хөгжлийн бэрхшээлийн улмаас алагчлах” гэж “хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалсан “алагчлал, гадуурхал, хязгаарлалт”-ыг хэлж байгааг тодорхой заажээ. Мөн боломжит тохируулгыг хангаж өгөөгүй явдал нь өөрөө ялгаварлан гадуурхлын нэг хэлбэр болохыг тайлбарлажээ.

Хөгжлийн бэрхшээл болон бусад үндэслэлээр хүмүүсийг ялгаварлан гадуурхахыг хориглохын зэрэгцээ 5 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш байдлыг хангах, тэднийг ялгаварлан гадуурхах явдлыг арилгах зорилгоор боломжит тохируулгаар хангаж өгөхийг төр, засгийн газруудаас шаарджээ. Мөн энэ зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн *де факто* тэгш байдлыг хангах, эрчимжүүлэх зорилгоор авч байгаа бүх арга хэмжээг конвенцийн хүрээнд ялгаварлан гадуурхал гэж тооцохгүй гэжээ. Олон улсын бусад гэрээ, конвенцийн төсөөтэй заалтуудтай харьцуулахад (жишээлбэл, ЭАБХУК-ийн 4 дүгээр зүйл) конвенцийн 5 дугаар зүйлд эдгээр арга хэмжээг хэрэглэх цаг хугацааг хязгаарлаагүй, тэдгээрийг “түр” гэж дурьдаагүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй олон хүн *де факто* тэгш байдлаа эдлэх боломжтой болтол эдгээр арга хэмжээг тодорхойгүй урт хугацаагаар хэрэгжүүлэх шаардлагатай байгаа нь амьдралын бодит үнэн юм.

Бүхэлд нь аваад үзвэл тэгш байдал, үл алагчлалыг хангах хүрээнд төр, засаг дараах үүрэг хүлээнэ:

- **Хүндэтгэх үүрэг:** Тэгш байдал, үл алагчлалын зарчимд харшилсан аливаа үйл ажиллагаа явуулахаас татгалзах (жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхсан заалт бүхий хууль батлахгүй байх, байгаа заалтуудыг хүчингүй болгох)

- **Хамгаалах үүрэг:** Хувь хүн, байгууллага, хувийн хэвшил зэрэг төрийн бус этгээдийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш байдал, үл алагчлагдах эрхийг зөрчсөн үйлдэл гаргуулахгүй байхад анхаарах, зөрчил гарвал арилгах зохистой бүхий л арга хэмжээг авах (жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд авах, ажил олгогчид ялгаварлан гадуурхал гаргахгүй байхад засгийн газрууд хяналт тавих)
- **Хэрэгжүүлэх үүрэг:** Тэгш байдал, үл алагчлалын зарчмыг хэрэгжүүлэхэд чиглэсэн бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх (жишээлбэл, “шударга ялгаварлал”, эсвэл “илт дэмжсэн арга хэмжээ” авах зэргээр).

### ДАСГАЛ 1.3: Тэгш байдал, үл алагчлалыг ойлгох нь

<b>Зорилт:</b>	ХБХЭК-ийн тэгш байдал, үл алагчлалын тухай заалтуудыг давтах, ойлгох
<b>Хугацаа:</b>	45 минут
<b>Хэрэглэгдэхүүн:</b>	Том цаас, фломастер эсвэл самбар шохой

#### 1. Бататгах

Оролцогчдыг жижиг багуудад хуваагаад, ХБХЭК-ийн 5 болон 2 дугаар зүйлийг энгийн үг хэллэгээр найруулах даалгавар өгнө. Эдгээр эрхээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хэрхэн эдэлж болох, ингэснээр тэдний амьдрал хэрхэн өөрчлөгдөхийг харуулсан тодорхой жишээг оролцогчдоор гаргуул. Эсвэл зарим баг нь 5 дугаар зүйл, зарим нь 2 дугаар зүйл дээр төвлөрөн ажиллахаар хуваарилан өгч болно.

#### 2. Энгийн үг хэллэгээр өөрчлөн найруулах

5 болон 2 дугаар зүйлийг чангаар уншиж, таслал, утгат хэсэг бүрийн дараа зогсож, тухайн хэсгийг багууд энгийн үг хэллэгээр хэрхэн өөрчлөн найруулсныг сонсоно. Бүгд санал нэгтэй хүлээн зөвшөөрсөн нэг найруулга гарч иртэл хэлэлцүүлгээ үргэлжлүүлээд, эцсийн найруулгаа том цаасан дээр бич.

#### 3. Жишээ гаргах

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тэгш байх, үл алагчлагдах эрхээ хэрхэн эдэлж, ингэснээр тэдний амьдрал хэрхэн өөрчлөгдөхийг харуулсан жишээ гаргуул.

#### 4. Хэлэлцэх

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах асуудлыг үндэсний хэмжээний бодлогын асуудал болгож тавих, мөн улс төрийн нам, шийдвэр гаргагчдад өргөн барих үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулахад ХБХЭК-ийн 5 болон 2 дугаар зүйлийг хэрхэн ашиглаж болох вэ?



## Тэгш байдал ба үл алагчлалын талаар мартаж болохгүй зүйлс

Хүний эрхийн эдгээр чухал зарчимтай холбоотой дараах зүйлсийг мартаж болохгүй:

- Тэгш байдал ба үл алагчлал нь хүний бусад эрхийн цөм, суурь нь юм
- Хүн эрхээ эдлэх боломжтой байх нь тэгш байх, үл алагчлагдах эрхээ эдлэхэд хамгийн ихээр нөлөөлдөг нөхцөл мөн.
- Тэгш байдал гэдэг нь бид хоорондоо хичнээн ялгаатай ч бидний төрөлхийн үнэ цэнэ адил гэсэн үг юм. Тэгш байдлын тухайд ялгаатай хэд хэдэн хандлага байдаг:
  - эрхзүйн тэгш байдал
  - тэгш боломж
  - жинхэнэ буюу *де факто* тэгш байдал
- Үл алагчлах зарчим нь хөгжлийн бэрхшээлээр ялгаварласан шударга бус ил, далд аливаа үйлдэл гарахаас сэргийлэх, гарсан үед нь засч залруулах зорилго агуулдаг.
- ХБХЭК-ийн хүрээнд:
  - Тэгш байдал, үл алагчлал бол хамгийн чухал хоёр зарчим юм.
  - Оролцогч улсууд өөрсдөө хөгжлийн бэрхшээлээр ялгаварласан хандлага гаргаж болохгүй, ийм хандлагыг төрийн бус этгээдүүд гаргах юм бол таслан зогсоох тодорхой арга хэмжээ авах ёстой.
  - Боломжит тохируулгыг хангаж өгөхгүй байх нь хөгжлийн бэрхшээлээр ялгаварлаж байгаагийн нэг хэлбэр гэж үзнэ.
  - Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст *де факто* тэгш байдлыг хангаж өгөхөд чиглэсэн нааштай алхмуудыг авч хэрэгжүүлэх ёстой.

### ДАСГАЛ 1.4: Тэгш байдал, үл алагчлалыг дэмжих амлалт авах нь

Хүний эрх бол эдлэх эрх, хүлээх үүргийн нэгдэл гэдгийг онцлон тайлбарла.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн адил тэгш байх, үл алагчлагдах эрхийн талаар мэдлэг, ойлголттой болсны эцэст оролцогчид энэ чиглэлээр тодорхой зүйл хийхэд бэлэн байгаа эсэхийг асуу.
- Мэдээлэл цуглуулах, ажлаа төлөвлөх чиглэлээр хийх зүйл их байгаа ч өөрчлөлт хийх сэдэл, тэмүүлэл маш чухал гэдгийг тэмдэглэн хэл.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрхээ бүрэн эдлэхэд нь нэмэр болох жижиг ч хамаагүй ямар ажлыг ирэх сард хийхийг хүсэж байгаа, хийх боломжтой байгааг оролцогч бүрээр хэлүүл.
- Хэрэв цаг хангалттай байгаа бол тэгш байдал, үл алагчлалыг дэмжсэн үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл боловсруул. Төсөлдөө тэгш байдал, үл алагчлалыг хөхиүлэн дэмжих үүрэг хариуцлагыг хүлээж байгаа талуудыг тодорхойлоод, эдгээр нь энэхүү үүргээ биелүүлдэг байхын тулд хэн юу хийж болохыг тодорхойл.



Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах нөлөөллийн ажил хэрхэн төлөвлөх талаар “Хэсэг 3. Нөлөөлөл! Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа” (хуудас 278) хэсгээс уншина уу.

ТЭГШ БАЙДАЛ, ҮЛ АЛАГЧЛАЛЫН ТАЛААРХ НЭМЭЛТ МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

- Хүний эрхийн хорооны Ерөнхий зөвлөмж №18:  
[http://www.unhchr.ch/tbs/doc.nsf/\(Symbol\)/3888b0541f8501c9c12563ed004b8d0e?Opendocument](http://www.unhchr.ch/tbs/doc.nsf/(Symbol)/3888b0541f8501c9c12563ed004b8d0e?Opendocument)
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны Ерөнхий зөвлөмж №15:  
[http://www.unhchr.ch/tbs/doc.nsf/\(Symbol\)4b0c449a9ab4ff72c12563ed0054f17d?Opendocument](http://www.unhchr.ch/tbs/doc.nsf/(Symbol)4b0c449a9ab4ff72c12563ed0054f17d?Opendocument)
- Жерар Квинн, Тересия Деженер. *Хүний эрхийг хүн бүрт: НҮБ-ын хүний эрхийн эрхзүйн баримт бичгүүдийг хөгжлийн бэрхшээлтэй холбон ашиглаж байгаа өнөөгийн байдал, цаашдын төлөвийн судалгаа* (Хүний эрхийн дээд комиссарын газар, 2002 оны 2 дугаар сар):  
<http://www.ohchr.org/english/issues/disability/study.htm>
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийг хэрэгжүүлсэн байдлын талаарх НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газрын илтгэл:  
<http://www.ohchr.org/pacific/docs/R>

## БҮЛЭГ 2. ХҮРТЭЭМЖ

### НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци

#### 9 дүгээр зүйл. Хүртээмж

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бие даан амьдрах, амьдралын бүхий л хүрээнд бүрэн дүүрэн оролцох боломжийг бий болгох зорилгоор оролцогч улсууд нь хөдөө орон нутаг, хот суурин газрын хаана ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусдын нэгэн адил өөрийг нь хүрээлэн буй орчин, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо тухайлбал, мэдээлэл харилцаа холбооны технологи, систем болон нийтэд нээлттэй үйлчлэх буюу зориулагдсан бусад төрлийн объект, үйлчилгээг хүртэх явдлыг хангахад чиглэсэн зохих арга хэмжээ авна. Хүртээмжтэй байх явдалд учруулж буй саад, тотгорыг илрүүлэх, устгахад чиглэсэн эдгээр арга хэмжээг *inter alia* дараах газарт авна:
  - a) барилга байшин, зам, тээвэр болон сургууль, орон сууцны байр, эмнэлгийн газар, ажлын байр зэрэг бүх төрлийн доторх болон гаднах байгууламж;
  - b) мэдээлэл, харилцаа холбооны болон бусад төрлийн үйлчилгээ тухайлбал, түргэн тусламжийн болон цахим үйлчилгээ
2. Түүнчлэн оролцогч улсууд нь дараах шаардлагатай арга хэмжээг авна:
  - a) нийтэд нээлттэй үйлчлэх буюу зориулагдсан объект, үйлчилгээг хүртээмжтэй байлгахад чиглэсэн наад захын стандарт, гарын авлагыг боловсруулж мөрдүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих;
  - b) нийтэд нээлттэй үйлчлэх буюу зориулагдсан объект, үйлчилгээг эрхэлдэг хувийн хэвшлийн байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байдлыг бий болгох бүхий л хүчин зүйлийг харгалзан үзэх явдлыг хангах;
  - c) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өмнө тулгарч буй хүртээмжийн асуудлаар холбогдох талуудад зориулсан сургалт зохион байгуулах;
  - d) нийтэд нээлттэй үйлчлэх байшин барилга, бусад байгууламжид брайль үсгээр буюу хялбар уншигдах, ойлгогдохуйц байдлаар тэмдэг, тэмдэглэгээ хийх;
  - e) нийтэд нээлттэй үйлчлэх байшин барилга, бусад байгууламжийн хүртээмжтэй байдлыг дээшлүүлэх үүднээс хүний туслалцаа, зуучлалын хэлбэрүүд, тухайлбал, хөтөч, уншигч, дохионы хэлний мэргэжлийн орчуулагчийг бий болгох;
  - f) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэдээлэл хүлээн авах хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн дэмжлэг, туслалцаа үзүүлэх зохих хэлбэрийг хөхиүлэн дэмжих;
  - g) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс мэдээлэл, харилцаа холбооны шинэ технологи, систем, үүний дотор интернетийг хэрэглэх боломжийг нэмэгдүүлэх;
  - h) хүртээмжтэй мэдээлэл, харилцаа холбооны технологи, системийн загварыг зохиох, сайжруулах, үйлдвэрлэх, түгээн борлуулахдаа эхний ээлжинд эдгээр технологи, системийг байж болох хамгийн хямд өртөгтэй байх явдлыг хангах.



## 2 дугаар зүйл. Тодорхойлолт (хэсэгчлэн авав)

“Боломжит тохируулга” гэж тодорхой тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын нэгэн адил хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг эдлэх явдлыг хангах үүднээс зохицоогүй, эсхүл үндэслэлгүй саад тотгорыг арилгах, багасгахад чиглэгдсэн нэн хэрэгцээтэй бөгөөд шаардлагатай тохируулга хийх болон өөрчилж засварлахыг хэлнэ;

“Нийтлэг дизайн” гэж ямарваа нэгэн нэмэлт тохиргоо, тусгай загвар шаардагдахгүйгээр бүх хүн ашиглахад хамгийн дээд зэргээр тохиромжтой байж болох бүтээгдэхүүн, байрлал, програм болон үйлчилгээний хэв маягийг хэлнэ. Нийтлэг дизайнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс шаардлагатай тохиолдолд хэрэглэх туслах хэрэгслүүдийг орхигдуулахгүй.

### ЗОРИЛТУУД

Энэ бүлгийн мэдээлэл, дасгалууд нь оролцогчдод дараах зорилтод хүрэхэд тусална:

- Хүртээмж, боломжит тохируулга болон нийтлэг дизайн гэж юу болохыг тодорхойлох
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмж ямар ач холбогдолтой болохыг тайлбарлах
- Хүртээмж болон хүний бусад эрхийн хоорондын уялдаа холбоог ойлгох
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүртээмжтэй холбоотой эрх хэрхэн хангагдаж эсвэл зөрчигдөж байгааг мэддэг болох
- НҮБ-ын ХБХЭК-ийн хүртээмжийн тухай заалтуудыг ойлгох

### ЭХЛЭЛ: ХҮРТЭЭМЖИЙН ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЭХ НЬ

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаар ярихад хүртээмжийн асуудал заавал хөндөгддөг. Өөрт нь хүртээмжгүй эрхийг ямар ч хүн эдэлж чадахгүй бөгөөд өнөөдөр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрхээ бүрэн дүүрэн эдлэхэд нь олон саад тотгор учирч байна. Эдгээр саад, тотгор нь “хөгжлийн бэрхшээл”-ийг хэрхэн тодорхойлж, ойлгож байгаатай шууд холбоотойгоор барахгүй энэхүү ойлголтын нэгэн хэсэг юм. ХБХЭК-ийн оршилд:

(е) хөгжлийн бэрхшээл гэдэг нь өөрчлөгдөн хувьсаж байдаг ойлголт бөгөөд нийгмийн амьдралд бусдын нэгэн адил бүрэн дүүрэн чөлөөтэй оролцоход саад тотгор учруулахуйц бие эрхтний согог, нийгмийн хандлагын болон орчны хязгаарлалтаас үүдэн бий болж байгаа гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой тухай сануулжээ.

Хүртээмжийг хязгаарладаг олон саад тотгор байдаг. Үүнд:

- **Биет саад:** Энд орчны аливаа саад, түүний дотор барилга, байгууламж, дэд бүтцийн (өөрөөр хэлбэл, хүний гараар бүтсэн) саадууд орно. Эдгээр нь нүдэнд ил байдаг тул хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүртээмжтэй холбоотой ямар ч асуудлыг хөндөхөд хамгийн түрүүнд хэн хүний санаанд ордог зүйлс юм. Жишээлбэл, байшин руу ордог



тэргэнцэрийн зам хийх, гудамжны нэвтрүүлэх чадварыг сайжруулахын тулд явган хүний замын төгсгөлийг налуу болгохын ач холбогдлыг хүн болгон одоо ойлгодог болжээ. Гэвч нүдэнд шууд тусахгүй биет саадунд бас байдаг. Тухайлбал, “дундаж өндөр”-тэй хүмүүст зориулж барьсан орчинд одой хүмүүс ямар олон саад туулах болдогийг бусад хүн тэр бүр анзаардаггүй. Түүнчлэн харааны бэрхшээлтэй хүмүүст гудамж, барилга байгууламж дотор зорчих, нэвтрэхэд нь тэмтэрч мэдрэгддэг юмуу хурц өнгөөр ялгасан тэмдэглэгээ шаардлагатай байдаг.

- **Мэдээллийн саад:** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэдээллийн хэлбэр, агуулга аль аль нь төвөг, бэрхшээл үүсгэж магад. Тухайлбал, жижиг үсэгтэй, эсвэл ялгарал муутай бүдэг өнгөтэй веб хуудас, хэвлэмэл материалыг хараа муутай хүн ашиглаж чадахгүй. Урсдаг болон бусад төрлийн текстэн тайлбар, дохионы орчуулга ашигладаггүй телевизийн нэвтрүүлэг сонсголын бэрхшээлтэй хүмүүст хүрэхгүй. Түүнчлэн телевизийн мэдээ нь аудио тайлбаргүй бол хараагүй хүмүүст хүртээмжгүй болдог. Хурц ялгаралтай юмуу Брайль үсгээр хийгээгүй хэвлэмэл мэдээллийг харааны бэрхшээлтэй хүмүүс ашиглаж чадахгүй. Хэлбэрээс гадна мэдээллийн агуулга нь асар чухал үүрэгтэй бөгөөд тухайлбал, хялбар, энгийн хэл найруулгад оруулаагүй мэдээлэл нь сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүрэхгүй байж мэднэ.
- **Институцийн бэрхшээл:** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоо, хүртээмжийг шууд хязгаарласан юмуу хангаж өгөөгүй хууль, процедур, тогтсон практик зэргийг үүнд багтаана. Тухайлбал, зарим оронд сэтгэц-нийгмийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сонгуульд санал өгөхийг хуулиар хориглосон байдаг бол өөр газарт бусад төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг санал өгөх байранд нэвтрүүлэх, нэвтрэн орсон хойно нь саналаа хэрхэн өгөх тухай зэрэг сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр хангахыг шаардсан хууль байхгүй, практик хэвшээгүйгээс болж тэд саналаа өгч чаддаггүй.
- **Хандлагаас үүдэлтэй бэрхшээл:** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тохиолддог хамгийн түгээмэл саад бол бусад хүмүүсийн хандлага юм. Заримдаа хөгжлийн бэрхшээлийн талаар нийгэмд тархсан хэвшмэл үзэл, ташаа ойлголтын нөлөөгөөр хүмүүс өөрсдөө ч мэдэлгүй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүртээмжийг хязгаарлах зүйл хийдэг. Заримдаа хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдралыг ноцтой хүндрүүлэх саад, тотгорыг хүмүүс зүгээр л анзаарахгүй, мэдрэхгүй байгаа нь ийм саад үүсэх, арилахгүй байхын шалтгаан болдог. Жишээлбэл, гадаа байгаа “цөөн хэдхэн шат” нь тэргэнцэртэй хүнд төдийлөн саад болохгүй гэдэгт итгэлтэй байгаа зоогийн газрын эзэн нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бусдын туслалцаагүй бие даан орж гарах хэрэгцээ байдгийг ойлгоогүй л байна. Ийм хайхрамжгүй хандлага технологийн салбарт бүр их уршигтай. Уг нь технологи бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст төрөл бүрийн боломж нээж өгөх чадалтай ч хүртээмжтэй байлгах талаас нь анхаараагүй технологийн дэвшил нь эсрэгээр шинэ саад үүсгэдэг. Тухайлбал, гар утас, интернетийг мэдээллийн эх үүсвэр, харилцаа холбооны хэрэгсэл болгон өргөн ашиглах болсон өнөө үед тоног төхөөрөмж, програм хангамжийн ихэнх нь дүлий, хараагүй болон хараа, сонсголын хавсарсан бэрхшээлтэй (хараагүй-дүлий) хүмүүст хүртээмжгүй байгаа нь тэднийг улам бүр ялгаварлагдах, тусгаарлагдахад хүргэж байна.

Хүртээмж бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрхээ цогцоор нь, бүрэн дүүрэн эдлэхэд шууд нөлөөлдөг учир маш чухал зарчим юм. Өөрөөр хэлбэл, хүртээмж муугаас болж хөгжлийн бэрхшээлтэй хүн аль нэг эрхээ эдэлж чадахгүйд хүрч болзошгүй. Зарим саад тотгороос болж хөгжлийн бэрхшээлтэй хүн хэд хэдэн эрхээ эдэлж чадахгүйд хүрч мэднэ. Тухайлбал, нийтийн

тээвэр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжгүй байгаа өнөөгийн нөхцөлд тэд чөлөөтэй зорчих эрхээ эдэлж чадахгүйн дээр боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, нөхөн сэргээлт, соёл, спортын арга хэмжээнд оролцох зэрэг эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйлчилгээ үзүүлдэг газарт хүрч чадахгүй. Улс төрийн амьдралтай холбоотой мэдээлэл хүртээмжгүй байвал хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн болон нийгмийн амьдралд оролцох эрх хязгаарлагдахаас гадна бусад эрхтэй холбоотой олон асуудлаар шийдвэр гаргалтад оролцох, сонголтоо хийх тал дээр хүндрэл гарч мэднэ. Жишээлбэл, орон нутгийн засаг захиргаанаас иргэдэд үзүүлэх яаралтай тусламжийн үйлчилгээг (цагдаа, гал түймэртэй тэмцэх, эмнэлгийн түргэн тусламж, аврах алба) хэрхэн зохион байгуулах талаар бүх нийтийн санал асуулгад оролцож байгаа хөгжлийн бэрхшээлтэй сонгогч нь шаардлагатай бүх мэдээллийг авсны үндсэн дээр сонголтоо хийх боломжоор хангагдах ёстой. Хүний эрх нь нэгдмэл, хоорондоо уялдаатай, харилцан хамааралтай болохыг эдгээр жишээ харуулж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн тэгш бөгөөд бүрэн эрхтэй гишүүний нь хувьд нийгмийн амьдралд бүрэн оролцуулахын тулд юуны өмнө хүртээмжийг сайжруулах хэрэгтэй. Хүний ямар эрхийн тухай ярьж байгаагаас үл хамааран хүртээмжийн асуудлыг заавал багтааж харах ёстой бөгөөд ингэхдээ зарим нэг хүнд бус харин бүхий л төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байх талаас нь харах ёстой.

## **ДАСГАЛ 2.1: Хүртээмжийн тухай эргэцүүлж эхлэх нь**

**Зорилт:** Мэдээллийн хүртээмжийг хязгаарлаж байгаа саад тотгорыг ойлгох  
**Хугацаа:** 20 минут  
**Материал:** Цаас, үзэг

### **1. Санал солилцох**

Өдөр тутам дэлгүүрээс худалдаж авдаг өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүнүүдийн жагсаалтыг бүгдээрээ нийлж гаргана. Эдгээр бүтээгдэхүүнээ нэг нэгээр нь жижиг цаасан дээр зурах, эсвэл нэрийг нь бичнэ.

### **2. Дүрд тоглох**

Оролцогчдыг хосоор нь баг болгоно. Багийн нэг гишүүн хүнсний нэг бүтээгдэхүүнийг сонгоод, нөгөөдөө үг хэлэхгүйгээр дохиж ойлгуулна.

Нөөц хувилбар: Дүрд тоглогчийн үзүүлснийг хоёр баг уралдаж таана.

### **3. Хэлэлцэх**

- Цаасан дээрх зүйлийг үг хэлэхгүйгээр тайлбарлах хэр амархан байсан бэ?
- Тайлбарласан, таасан аль аль талд дасгалын явцад тэсвэр алдах, шантарч гонсойх явдал тохиолдсон уу?
- Хэрэв тийм бол шалтгаан нь юу байсан бэ?
- Хөгжлийн бэрхшээлтэй хүн өдөр тутмын амьдралдаа туулдаг саад тотгорын талаар энэ дасгалаас та юу ойлгосон бэ?



## Хүртээмжийг нэмэгдүүлэх арга зам

### Нийтлэг дизайн гэж юу вэ?

ХБХЭК-ийн 2 дугаар зүйлд тайлбарласнаас үзэхэд, нийтлэг дизайныг “ямарваа нэгэн нэмэлт тохиргоо, тусгай загвар шаардагдахгүйгээр бүх хүн ашиглахад хамгийн дээд зэргээр тохиромжтой” буюу хүртээмжтэй байх зорилгоор ашигладаг ажээ. Хэрэглэгч нэг бүрийн хүртээмжийн хэрэгцээг урьдчилан тодорхойлох боломжгүй нөхцөлд нийтлэг дизайн онцгой ач холбогдолтой. Шинээр бүтээгдэхүүн, хөтөлбөр, үйлчилгээ бий болгох, эсвэл байшин барилга, спортын байгууламж, цэцэрлэгт хүрээлэн барьж байгуулахдаа аль болох олон хүнд хүртээмжтэй байх үүднээс нийтлэг дизайны дараах зарчмуудыг баримталж болно:

- **Тэнцүү ашиглах боломж:** янз бүрийн чадавхитай хүмүүст хэрэгтэй, худалдан авах сонирхлыг нь төрүүлэх загвар дизайнтай байх
- **Хэрэглээний уян хатан чанар:** загвар нь өргөн хүрээний хүмүүсийн хэрэгцээ сонирхол, чадавхид нийцсэн байх
- **Энгийн бөгөөд ойлгомжтой:** загварын зориулалт, ажиллагааг ойлгоход амар, хэрэглэгчийн мэдлэг, туршлага, хэлний чадвар, төвлөрөх чадвар, боломж зэргээс хамааралгүй байх
- **Мэдээллийг хүлээж авахад хялбар байдлаар хүргэх:** загвар нь шаардлагатай мэдээллийг оновчтой хүргэж чаддаг байх, хэрэглэгчийн тухайн үеийн нөхцөл байдал, мэдрэх чадвараас хамааралгүй байх
- **Алдааг тэсвэрлэх чадвар:** болгоомжгүй, эсвэл санаандгүй үйлдлээс гарах аюулт болон сөрөг үр дагавар хамгийн бага байх
- **Биеийн хүч бага шаардах:** биеийн хүч аль болох шаардахгүйгээр үр ашигтай, биед тавтай хэрэглэж болохуйц байх
- **Ашиглах, хүрч очиход тохиромжтой хэмжээ, орон зайтай байх:** хэрэглэгчийн биеийн хэмжээ, төрх, хөдөлгөөний чадавхиас үл хамааран хүрч очих, авах, өөрчлөх, ашиглах боломжтой хэмжээ, орон зайтай байх.<sup>1</sup>

## ДАСГАЛ 2.2 Хүртээмжтэй байдлыг ашиглах гэж юу гэсэн үг вэ?

- Зорилт:** Хүртээмжтэй байдлыг ашиглах гэж юу болохыг ойлгох  
**Хугацаа:** 30 минут  
**Хэрэглэгдэхүүн:** Том цаас, фломастер, самбар, шохой, бичгийн цаас, үзэг

### 1. Санал солилцох/төсөөлөх

Хүмүүсийн байнга хийдэг өдөр тутмын үйлдлүүдийг (дэлгүүр, ажил, сургуульдаа явах, нийтийн тээврээр зорчих, зоогийн газарт хооллох, найзуудтайгаа ярилцах, шашны үйл хэрэгт оролцох, спорт болон соёлын арга хэмжээнд оролцох г.м) оролцогчдоор нэрлүүлээд, цаасан дээр жагсааж бич.

<sup>1</sup> “Нийтлэг дизайны зарчмууд”. 2007. Нийтлэг дизайны төв.  
[http://www.design.ncsu.edu/cud/about\\_ud/udprinciples](http://www.design.ncsu.edu/cud/about_ud/udprinciples)

Дараа нь хөгжлийн бэрхшээлийн янз бүрийн төрөл буюу бие махбод, мэдрэхүй, оюун ухаан, сэтгэц-нийгмийн болон хавсарсан бэрхшээлүүдийг оролцогчдоор нэрлүүлээд, жишээ болгоныг тусдаа цаасан дээр бичнэ. Ингэхдээ “Та ...” гээд тэр хүндээ нас, хүйс зэрэг нэмэлт шинжүүдийг оноох маягаар дүрслэн бичнэ (жишээлбэл, “Та дундаж насны, тэргэнцэртэй эрэгтэй хүн”; “Та хорин настай, сэтгэл хөдлөлийн туйлшралын эмгэгтэй эмэгтэй”; “Та өсвөр насны, Дауны синдромтой охин”; “Та далан настай, дүлий, ярианы согогтой хүн”, г.м). Хүн бүр дор хаяж нэг жишээ гаргана.

Жишээ бүхий цааснуудаа цуглуулж, нугалаад хайрцагт хийнэ.

## 2. Шинжлэх

Оролцогчид хосоороо баг болоод, дээрх жагсаалтаас хоёр үйл ажиллагааг сонгож авна (нэг жишээн дээр хэд хэдэн баг ажиллаж болно). Дараа нь багууд хайрцагт хийсэн дүрийн тайлбартай цааснаас нэгийг сугалж авна.

Дараах зааврыг өгч багийн ажлыг зохион байгуулна:

- а) Таны сугалсан тайлбар бол энэ дасгалын туршид таны тоглох дүр юм.
- б) Энэ дүрд тоглож байгаа “Та” тухайн сонгосон үйл ажиллагаанд оролцоход ямар байхыг төсөөл.
- в) Тухайн үйл ажиллагааны хүртээмжийг хязгаарласан ямар саад тотгор тулгарч болох вэ? Үүнд:
  - Биет саад
  - Мэдээллийн хүртээмжийн саад
  - Институцийн саад
  - Хандлагаас үүдэлтэй саад
- г) Тухайн үйл ажиллагаанд оролцоход танд юу шаардагдах вэ? Хүртээмжтэй холбоотой ямар нөхцлүүд бүрдсэн байх хэрэгцээтэй вэ?

Сургагч багшид: Янз бүрийн саад тотгорын ялгааг оролцогчдод тайлбарлаж, жишээгээр тодруулж өгөх шаардлага гарч болзошгүй.

## 3. Илтгэх

Баг бүрээс “хэн”-ий дүрээр ямар үйл ажиллагаанд оролцож байгааг асуу. Эдгээр үйл ажиллагаанд оролцохын тулд хүртээмжтэй холбоотой ямар ямар нөхцлийг тэдэнд бүрдүүлж өгөх шаардлагатайг асуу. Эдгээр нөхцөл буюу хэрэгцээг дараах хүснэгтэд жагсаан бич (үүнийгээ дараагийн дасгалд ашиглахаар хадгална). Мэдээлэл, хандлага, институцийн болон биет саадыг бүгдийг багтааж асуу.

Саад	Хүртээмжийг сайжруулахын тулд ямар нөхцлүүдийг хангах хэрэгтэй вэ?





#### 4. Хэлэлцэх

- Багуудын боловсруулсан хүртээмжийн тодорхойлолт нь ямар дүрд тоглож байгаагаас хамааран ялгаатай байна уу, эсвэл бүх хүний хувьд ижил байна уу?
- “Хүртээмж” гэдэг ойлголтыг та бүхний ажилласан бүх кейс, жишээнд нийтлэгээр хамаатуулахын тулд ямар тодорхойлолт өгч болох вэ?
- Хүртээмж нь хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдралыг хэрхэн өөрчилж чадах вэ? Нийгмийн амьдралыг хэрхэн өөрчлөх вэ?
- Хүртээмж хангалтгүй байх нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралд ямар нөлөө үзүүлэх вэ? Нийгмийн амьдралд?

### Хүртээмжийг нэмэгдүүлэх арга зам

#### Боломжит тохируулга гэж юу вэ?

Хүртээмжийг нэмэгдүүлэхтэй холбоотой нэг хандлага бол **нийтлэг дизайныг** ашиглах хандлага бөгөөд энэ нь бүхий л төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, орчин нөхцлийг бүх хүн хэрэглэж болохуйц байхад анхаарна гэсэн үг юм. Гэвч нийтлэг дизайн нь хаа сайгүй нийтлэг хэрэглээ болж чадаагүйн дээр хувь хүн болгоны хэрэгцээг бүрэн хангаж хүртээмжийг нь нэмэгдүүлэх арга зам болж чадаагүй байна. Ийм нөхцөлд хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой өөр нэг хандлага болох боломжит тохируулгыг ашиглах хэрэгтэй. ХБХЭК-д өгсөн тодорхойлолтоор, мөн дэлхийн олон оронд хэрэглэж заншсанаар **боломжит тохируулга** гэж хүртээмжтэй холбоотой тодорхой хүмүүсийн тодорхой хэрэгцээг хангах зорилгоор тусгай зохицуулалт, тохируулга, нийцүүлэг, өөрчлөлт хийхийг хэлдэг байна. Өөрөөр хэлбэл, энэ нь хүртээмжийг хувь хүний хэрэгцээнд нийцүүлэх зорилготой хариу арга хэмжээ юм.

Боломжит тохируулгыг хийхийн тулд хэрэглэгчийн хэрэгцээг илрүүлэх, нөгөө талаасаа нийлүүлэгчийн хэрэгжүүлж чадах зүйл мөн гэдгийг баталгаажуулах үүднээс нийлүүлэгч, үйлчлүүлэгч хоёр хоорондоо ярилцах шаардлага гарч ирнэ. Хэрэв энэхүү тохируулга нь нийлүүлэгчдэд “хэт их юмуу өвөрмөц хүндрэл” учруулахаар бол түүнийг заавал хийх шаардлагагүй гэж үздэг. Боломжит тохируулгын хэмжээ, цар хүрээ нь тухайн хувь хүн, байгууллагын боломж, нөөц бололцооноос хамаардаг. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр хүртээмжийг нэмэгдүүлсэн шинэ шинэ шийдэл гарч ирдэг тул тохируулгын боломжит түвшний талаарх бидний ойлголт мөн хувьсан өөрчлөгдөж байдаг. Гэхдээ, ерөнхийдөө нийлүүлэгчийн “боломжит” гэж үзсэн хэмжээ нь боломжтой хэмжээнээс доогуур байх нь элбэг.

Тохируулга нь голдуу тодорхой хүний өвөрмөц хэрэгцээнээс үүдэлтэй ойлголт учраас тул боловсрол, ажил эрхлэлтийн орчинд өргөнөөр ашиглагддаг үйл явц юм. Учир нь эдгээр орчинд хүний сурч боловсрох, хөдөлмөрлөх эрхийг хангахын тулд хүртээмжийг нэмэгдүүлэх урт хугацааны шийдлүүд шаардлагатай байдаг. Жишээлбэл, сургалтын орчинг сурах бэрхшээлтэй хүнд тохируулахын тулд түүнд тусгай бэлтгэлтэй тэмдэглэл хөтлөгч гаргаж өгөх, эсвэл шалгалтын үеэр нэмэлт цаг өгөх зэрэг арга хэмжээ авч болно. Ажлын байрны орчинд бол өрөө, тасалгааг тэргэнцэртэй хүнд саад

учруулахааргүй байдлаар зохион байгуулах, эсвэл харааны бэрхшээлтэй ажилтны компьютерийн хэрэглээг нэмэгдүүлэхийн тулд тусгай програм хангамж, бусад технологи суурилуулж өгөх зэрэг арга хэмжээ орж болно.

Боломжит тохируулгын хандлага нь нийтлэг дизайны хандлагаас ялгаатай. Нийтлэг дизайн нь бүх хэрэглэгчид ижилхэн ханддаг бол боломжит тохируулга нь тодорхой хэрэглэгчид тусгайлан зориулагдсан арга хэмжээ юм. Харин энэ хоёр хандлага нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүртээмжийн хэрэгцээг бүрэн хэмжээнд хангаж, тэднийг нийгмийн амьдралд бусадтай адил тэгш бүрэн хамруулах ижил зорилготой юм.

### ДАСГАЛ 2.3: Хүртээмжийг хязгаарладаг саад тотгорууд

- Зорилт:** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүртээмжийг хязгаарладаг саад тотгоруудыг таньж тодорхойлох
- Хугацаа:** 30 минут
- Хэрэглэгдэхүүн:** Өмнөх 2.2 дасгалаар хийсэн өдөр тутмын амьдралын үйлдлүүдийн жагсаалт

#### 1. Хэлэлцэх

Өмнөх 2.2 дасгалаар багуудын гаргасан хүртээмжийг нэмэгдүүлэхэд тус болох нөхцлүүдийн жагсаалтыг ашиглан, оролцогчдын амьдардаг орчинд хүртээмжийг нэмэгдүүлэх эдгээр тохируулга нь хэр хангагдсан байгааг үнэлэх даалгавар өгнө. Хариултыг дараах хүснэгтэд тэмдэглэ.

Сургагч багшид: Хэрэв оролцогчид хариултыг мэдэхгүй байвал асуултын тэмдэг тавиад, хаанаас энэ мэдээллийг олж болох талаар ярилц.

Хүртээмжийг нэмэгдүүлэх нөхцөл	Огт байхгүй	Тодорхой хэмжээнд бий	Ерөнхийдөө бий	Ихэнх газар бий	Дандаа байдаг

#### 2. Хэлэлцэх

- Хүртээмжийг сайжруулах ямар нөхцлүүд танай орон нутагт хамгийн их хангагдсан байна вэ? Яагаад?
- Хүртээмжийг сайжруулах ямар нөхцлүүд хамгийн сул байна вэ? Яагаад?
- Зарим төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь бусад төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээс хүртээмжийн арай таатай нөхцлүүдээр хангагдсан байна уу? Ямар нөхцлүүд байгааг нэрлэнэ үү? Яагаад?



- Зарим төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь бусад төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй харьцуулахад хүртээмжийг нэмэгдүүлэх нөхцөл, боломжуудаар арай дутуу хангагдсан байдал илэрч байна уу? Ямар нөхцөл, боломжууд болохыг нэрлэнэ үү? Яагаад?

**Сургагч багшид:** Хүртээмжийг сайжруулах зарим нөхцөл нь бусад нөхцлүүдээсээ ерөнхийдөө илүү түгээмэл байгааг асуухдаа энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн явуулсан нөлөөллийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон давуу байдал мөн эсэхийг заавал тодруулаарай.

### 3. Үнэлэх

- Таны амьдарч байгаа орчинд хүртээмжийг сайжруулах ямар нөхцлүүд хамгийн их шаардлагатай вэ? Ингэхдээ асуудлыг өргөн хүрээнд авч үзэн, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн аль нэг бүлгийг орхигдуулахгүй бүхий л төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг багтааж хэлэлцээрэй.
- Эдгээр хэрэгцээг хангахын тулд юу хийвэл зохих вэ?

ХҮРТЭЭМЖИЙН ТАЛААР ХҮНИЙ ЭРХИЙН ХУУЛЬ ЭРХЗҮЙД ЮУ ГЭЖ ЗААСАН БАЙДАГ ВЭ?

1993 онд НҮБ-аас “**Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боломжийг тэгшитгэх тухай Стандарт дүрмүүд**”-ийг батлах хүртэл хүртээмжийн асуудлыг олон улсын эрхзүйн баримт бичгүүдэд дээрх шиг нарийвчлан тусгаж байсангүй. Өмнөх үеийн зарим баримт бичигт “хүртээмж” болон түүнтэй холбоотой зарим ойлголтыг дурьдсан байдаг. Тухайлбал, **Хүний эрхийн түгээмэл тунхаглал** (ХЭТТ)-ын 21 дүгээр зүйлд төрийн алба нь тухайн орны хүн бүрт тэгш эрхийн үндсэн дээр хүртээмжтэй байх тухай заажээ. Мөн ХЭТТ-ын 26 дугаар зүйлд дээд, мэргэжлийн болон тусгай боловсрол нь зөвхөн хүний авьяас чадварын үндсэн дээр бүх нийтэд хүртээмжтэй байх ёстой тухай заажээ.

**Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын (ИУТЭОУП)**<sup>2</sup> 25 дугаар зүйлд хүртээмжийн асуудлыг хөндөхдөө “хүмүүс өөрийн орондоо тэгш эрхийн нийтлэг нөхцөлтэйгээр төрийн алба хаах эрхтэй” гэжээ. Үүнтэй адилаар, **Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт** (ЭЗНСЭОУП)<sup>3</sup> нь хүртээмжийн асуудлыг 13 дугаар зүйлдээ боловсрол эзэмших тэгш эрхийн хүрээнд л дурьджээ. Харин ЭЗНСЭОУП-ын хэрэгжилтийг хянах үүрэгтэй **Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос** гаргасан **Ерөнхий зөвлөмж №5**-д тээвэр, эрүүл мэндийн үйлчилгээ, ажлын байр, орон гэр, эрүүл мэнд, боловсрол, соёл амралтын газрууд, мөн эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг эдлүүлэхэд чиглэсэн хөтөлбөр, үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгоход оролцогч улсууд анхаарах ёстой гэжээ.

**Хүүхдийн эрхийн конвенцид** (ХЭК) хүртээмжийн тухай үзэл баримтлалыг илүү олон удаа дурьдсан бөгөөд тухайлбал, 17 дугаар зүйл (Мэдээллийн хүртээмж), 24 дүгээр зүйл (Эрүүл мэнд, хоол тэжээлийн талаар мэдээлэл, боловсролын хүртээмж), 28 дугаар зүйл (Боловсролын хүртээмж), 37 дугаар зүйл (Эрх чөлөөгөө хасуулсан хүүхдүүдийн эрхзүйн

2 [http://www.unhchr.ch/html/menu3/b/a\\_ccpr.htm](http://www.unhchr.ch/html/menu3/b/a_ccpr.htm) сайтыг үз.

3 [http://www.unhchr.ch/html/menu3/b/a\\_ceschr.htm](http://www.unhchr.ch/html/menu3/b/a_ceschr.htm) сайтыг үз.

туслалцаа хүртэх боломж)<sup>4</sup> зэрэг заалтыг нэрлэж болно. Түүнчлэн 23 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг тусгайлан авч үзсэн ба Оролцогч улсууд нь

*... хүүхдийн хөгжил, түүний дотор хүүхдийн соёлын болон оюун ухааны хөгжлийг хангах, нийгмийн амьдралд оролцох бололцоог боломжийн дээд зэргээр бүрдүүлсэн арга хэлбэрээр боловсрол, эрүүл мэндийн болон нөхөн сэргээх үйлчилгээ, хөдөлмөр эрхлэхэд бэлтгэх, амралт, чөлөөт цагийн үйлчилгээнд хүртээмжтэй хамруулна* гэсэн байна.

**“Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боломжийг тэгшитгэх тухай НҮБ-ын Стандарт дүрмүүд”** (Стандарт дүрмүүд)–ийн 5 дугаарт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүртээмжийн асуудлыг биет орчны, мэдээллийн болон харилцаа холбооны хүртээмж хэмээн илүү нарийвчлан авч үзсэн байдаг. Үүнд Оролцогч улсуудыг тодорхой стандарт, удирдамж боловсруулах, архитекторч зэрэг барилгын мэргэжлийн хүмүүсийг сургах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудтай зөвшилцөх зэргээр биет орчны аливаа саад тотгорыг арилган хүртээмжийг сайжруулахыг уриалсан байдаг. Түүнчлэн уг Дүрэмд мэдээллийг төрөл бүрийн хүртээмжтэй хэлбэрээр хүргэх, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд (жишээлбэл, телевиз, радио, сонин) үйлчилгээгээ хүртээмжтэй болгоход анхаарах, шинэ технологи, компьютерийг анхнаас нь хүртээмжтэй байхаар төлөвлөх, эсвэл үйлдвэрлэсний дараа хөгжлийн бэрхшээлтэй хүний тусгай хэрэгцээнд тохируулан өөрчлөх боломжтойгоор хийх, мөн хэрэгцээ гарвал үйлчлэхэд бэлэн дохионы болон бусад орчуулагчдыг бэлэн байлгахыг уриалжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци (ХБХЭК) нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст “бие даан амьдрах, амьдралын бүхий л хүрээнд бүрэн дүүрэн оролцох” боломжийг хангахын тулд Оролцогч улсууд нь хүртээмжийн холбогдолтой ямар үүрэг, хариуцлага хүлээж байгааг нарийвчлан тодорхойлсон анхны заавал мөрдөх олон улсын эрхзүйн баримт бичиг юм. Тухайлбал, 9 дүгээр зүйлд төрөл бүрийн байгууламж, үйлчилгээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бусдын адил хэмжээнд хүртээмжтэй байхад Оролцогч улсууд хяналт тавих ёстой гэжээ. Ийм газруудын жишээ болгож 9 дүгээр зүйлд хүний олон эрх, эрх чөлөөнд нөлөөлж болох “байшин, сургууль, орон байр, эмнэлэг, ажлын байр гэх мэт барилга доторх болон гандах бүтэц, зам, тээврийн хэрэгсэл”, мөн “мэдээлэл, харилцаа холбооны” болон түргэн тусламжийн үйлчилгээ зэргийг нэрлэжээ. 9 дүгээр зүйлд мөн “хөдөө орон нутаг, хот суурин газарт хаана ч нийтэд үйлчилдэг болон нийтэд нээлттэй объект, үйлчилгээ” гэж дурьдсанаараа хүртээмжийн асуудлыг зөвхөн хот суурин газраар хязгаарлаагүй мөн хөдөө орон нутагт амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хамааруулан авч үзэх ёстойг онцолж байгаа хэрэг юм.

9 дүгээр зүйлээр бол хүртээмжтэй байдлыг хангахын тулд Оролцогч улсууд нь хүртээмжийг хязгаарлаж байгаа саад бэрхшээлийг илрүүлэх, улмаар арилгахад чиглэсэн арга хэмжээ авах ёстой. Эдгээр арга хэмжээг нэлээд нарийвчлан зааж өгсөн бөгөөд ялгаатай орчин нөхцөлд амьдарч буй янз бүрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүртээмжийн хэрэгцээг өргөн хүрээнд тусгахыг оролджээ. Үүнд:

- хүртээмжтэй байхад чиглэсэн наад захын стандарт, заавар боловсруулж мөрдүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих

4 <http://www.unhchr.ch/html/menu3/b/k2crc.htm> сайтыг үз.

- холбогдох талуудад хүртээмжийн асуудлаар сургалт явуулах
- мэдээлэл, харилцаа холбооны технологи, системийн загварыг зохиох, сайжруулах, үйлдвэрлэх, түгээн борлуулахдаа аль болох эрт үеэс хүртээмжийн асуудалд анхаарч, хамгийн хямд өртөгтэй байлгахыг хичээх
- мэдээлэл, харилцаа холбооны шинэ технологи, систем, түүний дотор интернет ашиглах боломжийг нэмэгдүүлэх
- нийтэд нээлттэй үйлчлэх байшин барилга, бусад байгууламжид Брайль үсгээр, эсвэл тод харагдах, хялбаршуулсан тэмдэг, тэмдэглэгээ хийх
- туслах ажилтан бэлтгэх (хөтөч, уншигч, дохионы хэлний мэргэжлийн орчуулагч зэрэг)
- мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн “бусад төрөл, хэлбэрийн туслалцаа, дэмжлэгүүдийг” хангаж өгөхийг хөхиүлэн дэмжих зэргийг багтаасан байна.

ХБХЭК-ийн бусад зүйл, заалтуудын адилаар 9 дүгээр зүйлийн хамрах хүрээ нь зөвхөн төв болон орон нутгийн засаг захиргаа, засгийн газрын агентлаг, төрийн өмчит компани зэрэг Оролцогч улсуудын төрийн байгууллагаар хязгаарлалгүй, хувийн хэвшлийг ч хамруулсан онцлогтой. Тухайлбал, Оролцогч улсууд нь “нийтэд нээлттэй үйлчлэх буюу зориулагдсан объект, үйлчилгээг эрхэлдэг хувийн хэвшлийн байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байдлыг бий болгох бүхий л хүчин зүйлийг харгалзан үзэх явдлыг хангах” ёстой ажээ. Өөрөөр хэлбэл, хэдийгээр энэ конвенци нь хувийн салбарт заавал мөрдөх ёстой эрхзүй баримт биш ч гэсэн (олон улсын гэрээгээр зөвхөн Оролцогч улсуудын төр, засгийн газрууд үүрэг хүлээнэ) 9 дүгээр зүйлийн зорилго, үүргийг хувийн хэвшлийнхэнд хүргэх, мөрдүүлэх үүргийг төр, засгийн газрууд хүлээдэг. Эдгээр хувийн хэвшлийн тоонд зоогийн газар, такси компани, супермаркет болон нийтэд зориулсан бусад байгууламж, үйлчилгээ эрхэлж буй бизнесүүд багтана.

9 дүгээр зүйл нь ХБХЭК-ийн эхний хэдэн заалтын нэг нь юм. ХБХЭК-ийн 1-8 дугаар зүйлийн нэгэн адил 9 дүгээр зүйл нь ХБХЭК-д багтсан бүх эрхийг тайлбарлаж, хэрэгжүүлэхэд суурь болох учиртай. Тухайлбал, 13 дугаар зүйлийг (Шүүх ажиллагаанд хүртээмжтэй оролцох) хэрэгжүүлэхийг зорьсон хэн ч гэсэн шүүхийн байр, эрүүгийн шүүхийн тогтолцооны хүртээмжийг хэрхэн сайжруулах асуудлаар эн түрүүнд 9 дүгээр зүйлийг нарийвчлан харах хэрэгтэй. Хүртээмжтэй байдлын үзэл баримтлалыг **ХБХЭК-ийн** тусгай заалтуудад нарийвчлан тайлбарлаагүй, зарим үед огт дурьдаагүй байгаагийн шалтгаан үүгээр тайлбарлагдах ба өөрөөр хэлбэл, 9 дүгээр зүйл нь хүртээмжтэй байх зарчимтай холбоотой бүх асуудлыг нийтлэгээр зохицуулах үндэс болох ёстой гэж **ХБХЭК-ийг** зохиогчид үзжээ.

Хүртээмжтэй байдлыг хангахад Оролцогч улсууд дараах ерөнхий үүргийг хүлээнэ:

1. **Хүндэтгэх үүрэг:** хүртээмжийг хязгаарлах, саад тотгор учруулах аливаа үйлдэл, зан заншил, практик ажиллагаанаас татгалзах;
2. **Хамгаалах үүрэг:** төрийн бус буюу хувийн хэвшлийнхэн (нийтэд зориулсан байгууламж, үйлчилгээ эрхэлдэг бизнесийн байгууллага зэрэг) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүртээмжийг хязгаарласан саад тотгорыг бий болгохгүй байх, байгааг нь арилгаж байхад анхаарах;
3. **Биелүүлэх үүрэг:** Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүртээмжийг хангахад чиглэсэн бүх арга хэмжээг (9 дүгээр зүйл; заасан үйл ажиллагаанууд) идэвхтэй авах ёстой.

Товчоор хэлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бие даан амьдарч, амьдралын бүхий л хүрээнд бүрэн дүүрэн оролцдог байхын тулд хүртээмжтэй байдлыг хангаж өгөхийг олон улсын хүний эрхийн хуулиуд шаарддаг байна.

## ДАСГАЛ 2.4: Хүртээмжтэй байх үзэл баримтлалыг ойлгох нь

**Зорилт:** Хүртээмжтэй байдлын талаарх ХБХЭК-ийн заалтуудыг давтах, ойлгох  
**Хугацаа:** 45 минут  
**Хэрэглэгдэхүүн:** Том цаас, фломастер, эсвэл самбар, шохой

### 1. Бататгах

Оролцогчдыг жижиг багуудад хуваа. Багууд 9 дүгээр зүйлийг энгийн үг хэллэгээр өөрчлөн найруулж, энэ заалтыг бодит амьдралд хэрхэн хэрэгжүүлж болох, ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн амьдрал хэрхэн өөрчлөгдөхийг харуулсан жишээ гаргана. 9 дүгээр зүйл урт учир өмнөх дасгалуудын явцад 9 дүгээр зүйлийн хэсгүүдийг хангалттай хэлэлцсэн гэж үзэж байгаа бол давтахаас зайлсхийж багууд энэ заалтын тодорхой хэсгийг давхардуулалгүй сонгон авч ажиллаж болно.

### 2. Энгийн үг хэллэгээр өөрчлөн найруулах

9 дүгээр зүйлийг чангаар уншиж өг. Ингэхдээ таслал, утгат хэсэг бүрийн дараа зогсож, тухайн хэсгийг энгийн үг хэллэгээр хэрхэн найруулж болохыг асуу. Найруулгыг бүх оролцогчид санал нэгтэй зөвшөөрөх хүртэл үргэлжлүүлэн хэлэлц. Бүгд санал нэгтэй зөвшөөрсөн найруулгыг самбар дээр бич.

### 3. Жишээ гаргах

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүртээмжийг хэрхэн нэмэгдүүлэх, энэ нь тэдний амьдралд ямар өөрчлөлт авчрахыг харуулсан жишээг багуудаар гаргуул.

### 4. Хэлэлцэх

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах асуудлыг үндэсний хэмжээний бодлогын асуудал болгож тавих, мөн улс төрийн нам, шийдвэр гаргагчдад өргөн барих үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулахад 9 дүгээр зүйлийг хэрхэн ашиглаж болох вэ?

## ДАСГАЛ 2.5: Хүртээмжийг сайжруулах амлалт авах нь

Хүний эрх нь эдлэх эрх, хүлээх үүргийн нэгдэл болохыг онцлон тэмдэглэ.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүртээмжийн талаар судалж мэдсэний эцэст оролцогчид нь энэ талаар тодорхой алхам хийхэд бэлэн болсон эсэхийг асуу.
- Мэдээлэл цуглуулах, ажлаа төлөвлөх чиглэлээр хийх зүйл их байгаа ч өөрчлөлт хийх сэдэл, тэмүүлэл маш чухал гэдгийг тэмдэглэн хэл.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрхээ бүрэн эдлэхэд нь нэмэр болох жижиг ч хамаагүй ямар ажлыг ирэх сард хийхийг хүсэж байгаа, хийх боломжтой байгааг оролцогч бүрээр хэлүүл. (Ийм тодорхой ажлын нэг жишээ: барилга байгууламж,





эсвэл засгийн газрын веб хуудасны хүртээмжтэй байдалтай холбоотой үндэсний стандарт байдаг эсэхийг судлах, байдаг бол хэрэгжилтийг нь судлах, байдаггүй бол ийм стандарт боловсруулж батлуулахад чиглэсэн нөлөөллийн ажил хийх г.м.)

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах нөлөөллийн ажил хэрхэн төлөвлөх талаар “Хэсэг 3. Нөлөөлөл! Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа” (хуудас 278) хэсгээс уншина уу.

### **Хүртээмжийн асуудалд цогц байдлаар хандах нь: БиБиСи телевизийн туршлага**

БиБиСи нь телевиз, радиогийн мэдээ, шоу, цэнгээнт нэвтрүүлгээрээ олон улсад сайтар танигдсан байгууллага билээ. Харин хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хэр хүртээмжтэй ажиллаж байгаагаа судалж үзэхдээ БиБиСи нь нэвтрүүлгүүдээ субтитр, аудио тайлбартай эсэхийг шалгах төдийхнөөр хязгаарласангүй. Үйлчилгээнийхээ олон нэр төрлийн зэрэгцээ ажил олгогчийн хувьд өөрийн бүх үйл ажиллагаагаа хянан үзэхдээ:

- Телевизийн лиценз олголт
- Мэдээ, мэдээлэл, боловсролын болон шоу, цэнгээнт нэвтрүүлгийг бүтээх, бэлтгэх, нэвтрүүлэх ажил
- Веб хуудсаар дамжуулан мэдээлэл хүргэгч
- Өргөн нэвтрүүлгийн цацалтаа аналогоос дижитал хэлбэрт шилжүүлэх хөдөлгөөний оролцогч
- Хэрэглэгчид зориулсан үйлчилгээ үзүүлэгч
- Британи улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхлаас хамгаалах хуулийг мөрдөх үүрэгтэй олон нийтийн байгууллага

болох чиг үүргүүдээ хамруулсан цогц үнэлгээ хийжээ.

Хөгжлийн бэрхшээл, арьсны өнгө, үндэс угсаа болон жендерээр ялгаварлахгүй тэгш хандах зорилтынхоо хүрээнд БиБиСи нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд болон хөгжлийн бэрхшээлтэй ажиллагсадтайгаа зөвшилцөн “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж бүрдүүлэх төлөвлөгөө” боловсруулжээ. Ингэхдээ анкетын асуулга, зорилтот бүлгийн ярилцлагын аргаар БиБиСи нь одоогийн үйл ажиллагааныхаа хүртээмжтэй байдал, хаана нь хүмүүст бэрхшээл тулгарсан, цаашид ажиллагаагаа хэрхэн сайжруулах талаар мэдээлэл авчээ. Анкетын судалгаанд хамрагдсан ихэнх хүмүүс телевизийн лиценз авахдаа саад тотгортой таараагүй ч хэрэглэгчдэд үйлчлэх хэлтэстэй харьцахад хэцүү байсан, мөн БиБиСи нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгардаг асуудлуудыг тэр бүр ойлгодоггүй гэж бодож байгаагаа хэлжээ.





БиБиСи-ийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж бүрдүүлэх төлөвлөгөө”-нд (2006 оны 12 сараас 2009 оны 12 сар хүртэлх хугацааг хамарсан) үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнд үнэлгээ хийх нарийвчилсан хуваарь, журмыг тусгаж өгчээ. Энэхүү төлөвлөгөөг БиБиСи-ийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж бүрдүүлэх ерөнхий хандлага” баримт бичигтэй уялдаатай хэрэгжүүлэх бөгөөд эдгээр нь хамтдаа хөгжлийн бэрхшээлтэй үзэгч, хэрэглэгчдэд хүрэх хүртээмжийг сайжруулах бодлого, арга хэмжээний суурь болох юм. Мөн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй ажилчид, зохиогч, продюсер, жүжигчин, нэвтрүүлэгчдийг ажиллуулах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй дижитал, интернетийн болон бусад технологийг ашиглах, ажилчдын дунд хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх сургалт явуулах, боловсролын материал тараах зэрэг ажил хэрэгжүүлж байна.<sup>5</sup>

## ХҮРТЭЭМЖИЙН АСУУДЛААРХ НЭМЭЛТ МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

- Хүртээмжийн асуудлаар олон улсын туршлага солилцох байгууллага. Дэлхийн тээврийн үйлчилгээний хүртээмж:  
<http://www.globalride-sf.org/index.html>
- Америкийн хараагүй хүмүүсийн зөвлөл. Хараагүй болон харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан мэдээлэл:  
<http://www.acb.org/resources/index.html>
- Нийтлэг загварын төв: Бүх хүнд хүртээмжтэй орчин, бүтээгдэхүүнүүд:  
[http://www.design.ncsu.edu/cud/about\\_ud/udprinciples.htm](http://www.design.ncsu.edu/cud/about_ud/udprinciples.htm)
- Хүртээмжийг дэмжсэн дизайн: Соёлын байгууллагын зохион байгуулагчийн гарын авлага. Төрийн өмчийн соёлын байгууллагуудын үндэсний холбоо: <http://www.nea.gov/resources/Accessibility/pubs/DesignAccessibility.html>
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны ерөнхий тайлбар №5:  
[http://www.unhchr.ch/tbs/doc.nsf/\(Symbol\)/4b0c449a9ab4ff72c12563ed0054f17d?OpenDocument](http://www.unhchr.ch/tbs/doc.nsf/(Symbol)/4b0c449a9ab4ff72c12563ed0054f17d?OpenDocument)
- Нийтлэг загвар боловсруулах олон улсын шилдэг туршлага: глобаль тойм. Канадын Хүний эрхийн комисс:  
[http://www.chrc-ccdp.ca/whats\\_new/default-en.asp?id=376](http://www.chrc-ccdp.ca/whats_new/default-en.asp?id=376)
- Хүртээмжтэй мэдээлэл болон харилцаа холбооны технологийн тухай Манилын тунхаглал:  
<http://www.un.org/esa/socdev/enable/maniladecl.htm>
- НҮБ-ын хэрэгжүүлсэн интернетийн глобаль аудит:  
<http://www.un.org/esa/socdev/enable/gawanomensa.htm>
- W3C байгууллагын интернетийн хүртээмжийг нэмэгдүүлэх санаачилга. Интернетийн хүртээмжтэй холбоотой бодлогын баримт бичгүүд:  
<http://www.w3.org/WAI/Policy/>

5 “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж бүрдүүлэх Би Би Си-ийн төлөвлөгөө” ( “The BBC Disability Equality Scheme”). 2007 оны 4 сарын 30. BBC. <http://www.bbc.co.uk/info/policies/diversity.shtml#DES1>



## БҮЛЭГ 3. НИЙГМИЙН БОЛОН УЛС ТӨРИЙН АМЬДРАЛД ОРОЛЦОХ ЭРХ

### НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци

#### 29 дүгээр зүйл. Нийгмийн болон улс төрийн амьдралд оролцох эрх:

Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн эрхийг баталгаажуулж, эдгээр эрхээ бусдын нэгэн адил эдлэх боломжийг бий болгох үүднээс дараах арга хэмжээг авна:

- a) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс улс төрийн болон нийгмийн амьдралд бусадтай адил тэгш, шууд эсхүл сонгосон төлөөлөгчдөөрөө дамжуулан бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох нөхцлийг хангах ба тэдний сонгох, сонгогдох эрхээ эдлэх боломжийг дараах замаар бүрдүүлнэ:
  - i) Санал өгөх процедурууд, байр ба тоноглол, материалыг зохистой, хүртээмжтэй, хэрэглэхэд хялбар, ойлгомжтой байлгах
  - ii) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сонгууль, ард нийтийн санал асуулгад аливаа сүрдүүлэг, хавчлагагүйгээр саналаа нууцаар өгөх, сонгуульд нэрээ дэвшүүлэх, сонгогдсон албаа хаших, төр, засгийн газрын аливаа түвшинд үр дүнтэй ажиллах эрхийг хангах, шаардлагатай тохиолдолд туслах болон шинэ технологийг хэрэглэх нөхцлийг бүрдүүлэх
  - iii) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сонгогчийн хувьд санал, бодлоо чөлөөтэй илэрхийлэх, саналаа өгөхөд нь тэдний гаргасан хүсэлтийн дагуу, өөрсдийнх нь сонгосон хүнээр шаардлагатай тохиолдолд туслуулах нөхцлийг баталгаажуулах
- b) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусадтай адил тэгш үндсэн дээр, аливаа ялгаварлан гадуурхалгүйгээр нийтийн үйл хэрэгт бүрэн дүүрэн, үр нөлөөтэй оролцох орчин нөхцлийг бүрдүүлэх явдлыг хөхиүлэн дэмжиж, тэдний нийтийн үйл хэрэгт оролцох оролцоог урамшуулах, тухайлбал,
  - i) Өөрийн орны олон нийтийн болон улс төрийн асуудлаар ажилладаг төрийн бус байгууллага, холбоо, мөн улс төрийн намын удирдах байгууллагын үйл ажиллагаанд оролцох
  - ii) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг олон улсын, үндэсний, бүсийн болон орон нутгийн түвшинд төлөөлөх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага байгуулах, тийм байгууллагад элсэх

### ЗОРИЛТУУД

Энэ бүлгийн мэдээлэл, дасгалууд нь оролцогчдод дараах зорилтыг хангахад тусална:

- Улс төрийн болон нийгмийн амьдралд оролцох эрхийг тодорхойлох
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангахад оролцоо ямар ач холбогдолтой болохыг тайлбарлах

- Оролцох эрх болон хүний бусад эрхийн хоорондын холбоог ойлгох
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн шийдвэр гаргалтад оролцох эрх, үүний дотор улс төр, нийгмийн амьдралд оролцох эрх хэрхэн хангагдаж, эсвэл зөрчигдөж байгааг мэддэг болох
- **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн (ХБХЭК)** оролцооны эрхтэй холбоотой заалтуудыг тайлбарлах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн шийдвэр гаргалтад оролцох эрх, үүний дотор улс төр, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангахад чиглэсэн нөлөөллийн ажилд ашиглах стратегиудыг тодорхойлох.

## ЭХЛЭЛ: НИЙГМИЙН БОЛОН УЛС ТӨРИЙН АМЬДРАЛД ОРОЛЦОХ ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЭХ НЬ

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралд нөлөөлдөг олон асуудлаар шийдвэр гаргахдаа тэднийг оролцуулахгүй байх тохиолдол маш их гардаг. Шийдвэр гаргах үед тэд өөрсдөө байдаггүй тул тэдний нийгмийн оролцоог хязгаарладаг саад, тотгорууд арилдаггүй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн шийдвэр гаргалтад оролцох, түүний дотор улс төр, нийгмийн амьдралд оролцох эрхийн хэрэгжилт нь тэдний бусад эрхээ эдлэхэд шууд нөлөөлдөг. Жишээлбэл, боловсролоор дамжуулан хүмүүс идэвхтэй иргэний чадваруудыг эзэмшдэг тул сурч боловсрох эрх нь зөрчигдсөн хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн үйл явцад оролцох эрх мөн хэрэгжиж чадахгүй болж мэднэ. Сонгуульд саналаа өгөх, шийдвэр гаргалтад оролцох эрхийг хэрэгжүүлэхэд мэдээллийг хүртээмж маш чухал нөлөөтэй. Үүнтэй нэгэн адилаар, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгуулийн хороондоо бүртгүүлэх, саналаа өгөх, амьдралд нь нөлөөлөх чухал хурал, цуглаанд оролцох зэрэг нь нийтийн тээврийн хүртээмжээс хамаарна. Ялгаварлан гадуурхсан утга агуулгатай хуулийн заалт нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хууль ёсны эрхийг бүрмөсөн хязгаарлаж, улмаар тэднийг эрхзүйн чадамжгүй болгож мэднэ. Үүний нэг жишээ нь шүүхийн шийдвэрээр сэтгэцийн өвчтэй хүмүүсийн эмчилгээгээ сонгох эрхийг хаадаг явдал юм. Эдгээр жишээ нь хүний эрх **нэгдмэл, уялдаа холбоотой, харилцан хамааралтай** байдгийг харуулж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн амьдралд оролцох эрхийг янз бүрийн шалтгаан хязгаарлаж мэднэ. Ялгаварлан гадуурхсан утга агуулгатай хуулиар хөгжлийн бэрхшээлтэй хүн, ялангуяа сэтгэц-нийгмийн болон окуны хөгжлийн бэрхшээлтэй хүний сонгуульд саналаа өгөх эрхийг хязгаарлах, тэр ч бүү хэл бүрмөсөн үгүйсгэх явдал гарч болзошгүй. Мөн хэвшмэл үзлийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс улстөрийн намуудын ухуулга сурталчилгааны ажилд хамрагдаж чадахгүй, эсвэл төрийн албанд орох боломжгүй болох нь ч бий. Нийтийн хурал цуглаан хийхдээ, эсвэл санал өгөх үйл явцыг журамлахдаа мэдээллийн хүртээмжийг анхаараагүй нь оролцоог хязгаарласан саад, тотгор болж ч магад. Харилцааны саад, тотгорын улмаас сонсгол муутай юмуу дүлий хүмүүс шийдвэр гаргалт, тухайлбал, эмчилгээтэй холбоотой шийдвэр гаргалтад оролцож чадахгүй байх явдал нэлээд гардаг. Олон улсын хөгжлийн чиглэлээр ажилладаг хандивлагч, үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тэдний төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжүүлэлтэд оролцох чадваргүй, хүсэлгүй байна гэсэн буруу дүгнэлтэд хүрч мэднэ. Эдгээр болон бусад олон саад тотгор нь хөгжлийн

бэрхшээлтэй хүмүүсийг улс төр, нийгмийн амьдралаас улам бүр тусгаарлан, улмаар тэдний ашиг сонирхлыг хөндсөн нийгмийн болон хувийн амьдралтай холбоотой бүхий л асуудлаар шийдвэр гаргалтад оролцох боломжийг нь хязгаарлаж байна.

### Шийдвэр гаргалтад оролцоход тулгардаг саад, бэрхшээл (жишээ)

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг шийдвэр гаргахад оролцуулснаар гарах ач холбогдлын талаарх элдэв хандлага;
- Нийтийн хурал, зөвлөгөөн, улс төрийн нам, сонгууль, бүртгэл зэрэг үйл ажиллагааны талаарх мэдээллийн хүртээмж муу;
- Нийтийн хурал, сонгуулийн байр, бүртгэлийн ажиллагаа явагдаж байгаа газарт хүргэх тээврийн хэрэгсэл олдоц муутай;
- Нийтийн зориулалттай барилга байгууламж, жишээлбэл, шүүх танхим, сонгуулийн хороо, хэсгийн байранд орж гарахад биет саад учирдаг;
- Санал өгөх байрны хаалга нь тэргэнцэр багтахааргүй жижиг, саналын хайрцгийг өндөр ширээн дээр байрлуулсан байдаг;
- Мэдрэхүйн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст санал хураах явцыг тайлбарласан мэдээлэл хомс;
- Сонгуульд дайчлагдсан ажилтнуудын бэлтгэл, сургалт хангалтгүй;
- Сэтгэцийн болон оюуны бэрхшээлтэй хүмүүсийг шийдвэр гаргахад оролцуулах шаардлагагүй гэсэн үзэл;
- Мэдрэхүйн бэрхшээлтэй хүмүүсийн саналыг хураах хувилбарт механизм, арга хэлбэр дутмаг;
- Эмнэлэгт болон гэртээ байдаг хүмүүсийн саналыг хураах явуулын механизмууд дутмаг.

### ДАСГАЛ 3.1: ХБХЭК-д шийдвэр гаргалтад оролцохтой холбоотой ямар эрх баталгаажсан бэ?

**Зорилт:** Шийдвэр гаргалт, нийгмийн амьдралд оролцохтой холбоотой ямар эрхийг ХБХЭК-д багтаасныг судлах, ойлгох

**Хугацаа:** 30 минут

**Хэрэглэгдэхүүн:** Том цаас, фломастер эсвэл самбар, шохой

#### 1. Бататгах

Оролцогчдыг жижиг багуудад хуваагаад, баг болгонд 29 дүгээр зүйлийн тодорхой нэг хэсгийг (жишээлбэл, 29 /a//i/; 29/b/ г.м.) оноож өгөөд, дараах даалгаврыг тайлбарла:

- Баг болгон өөрт оногдсон хэсгийг энгийн үг хэллэгээр өөрчлөн найруул
- Тухайн эрхийг хэрхэн эдлэхийг харуулсан жишээ гаргаад, энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдралд ямар өөрчлөлт авчрахыг тайлбарла.

## 2. Энгийн үг хэллэгээр өөрчлөн найруулах/жишээ гаргах

29 дүгээр зүйлийг чангаар уншаад, тодорхой хэсгүүдийг багууд энгийн үг, хэллэгээр хэрхэн өөрчлөн найруулсныг асуу. Бүх хүн санал нэгтэй зөвшөөрсөн найруулга гарч иртэл хэлэлцүүлгээ үргэлжлүүл. Эцсийн найруулгыг том цаасан дээр бич.

Хэсэг болгоны дараа тухайн эрхийг хэрхэн эдлэх тухай жишээнүүд, энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралд хэрхэн нэмэр болох тухай тайлбарыг сонс.

## 3. Хэлэлцэх

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах асуудлыг үндэсний хэмжээний бодлогын асуудал болгож тавих, мөн улс төрийн нам, шийдвэр гаргагчдад өргөн барих үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулахад ХБХЭК-ийн 29 дүгээр зүйлийг хэрхэн ашиглаж болох вэ?

УЛС ТӨР, НИЙГМИЙН АМЬДРАЛД ОРОЛЦОХ ТАЛААР ХҮНИЙ ЭРХИЙН ХУУЛЬ ЭРХЗҮЙД  
ЮУ ГЭЖ ЗААСАН БАЙДАГ ВЭ?

Улс төрийн амьдралд оролцох эрх бол хүний эрхийн хуулиудад маш тууштай дэмждэг эрх бөгөөд **Хүний эрхийн түгээмэл тунхаглалын (ХЭТТ) 21** дүгээр зүйлд энэ эрхийг тодорхой дурьдсан байдаг.<sup>1</sup> **Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын (ИУТЭОУП) 25** дугаар зүйлд заасан ёсоор:

*иргэн бүр аливаа ... үндэслэлгүй хязгаарлалтгүйгээр... бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр санал[аа] нууцаар хураа[лгах], сонгогч[дын] жинхэнэ хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг баталгаажуулсан, жинхэнэ ёсоор тогтмол явагддаг сонгуульд сонгох буюу сонгогдох ... эрхтэй<sup>2</sup> ажээ.*

ХБХЭК нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмийнхээ улс төрийн амьдралд бүрэн оролцох эрхтэй болохыг дэлгэрүүлэн тайлбарлаад, энэ эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой зөвлөмжийг Оролцогч улсуудад өгчээ. ХБХЭК нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог зөвхөн сонгуульд санал өгөхөөр хязгаарлалгүй, өөрсдийнх нь ашиг сонирхлыг хөндсөн аливаа асуудлаар шийдвэр гаргахад бусад хүмүүсийн адилаар оролцох бүрэн эрх гэдэг утгаар тайлбарлажээ. 29 дүгээр зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дараах эрхийг онцлон заажээ:

- Ялгаварлан гадуурхагдалгүй сонгуульд саналаа өгөх
- Алагчлагдахгүйгээр сонгогчдын бүртгэлд бүрэн хамрагдах
- Санал өгөх эрхээ хэрэгжүүлэхийн тулд санал өгөх үйл явц болон санал хураах байрыг тэгш, үр дүнтэй ашиглах боломжоор хангагдсан байх
- Саналаа нууцаар өгөх
- Санал өгөх, төрийн албан тушаалд нэрээ дэвшүүлэхдээ шаардлагатай тусламж авах
- Төрийн захиргааны үйл хэрэг, үүний дотор улс төрийн нам, иргэний нийгмийн удирдах ажилд оролцох

1 <http://www.unhchr.ch/udhr> сайтыг үз.

2 [http://www.unhchr.ch/html/menu3/b/a\\_ccpr.htm](http://www.unhchr.ch/html/menu3/b/a_ccpr.htm) сайтыг үз.



- Олон улсын байгууллагын үйл ажиллагаанд оролцох, түүний дотор засгийн газрын төлөөлөгчийн үүргээр оролцох
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүх шатны байгууллага байгуулах, гишүүнээр элсэх

ХБХЭК-ийн Оролцогч улсуудын төр, засгийн газар нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгуульд саналаа өгөх зэрэг улс төрийн эрхийг баталгаажуулах, тэдэнд улс төрийн амьдралд оролцох бодит боломжийг бүрдүүлэх чиглэлээр *бүхий л нааштай арга хэмжээг авч хэрэгжүүлэх* үүрэг хүлээдэг. ХБХЭК-ийн 3 дугаар зүйл (Нийтлэг зарчмууд)-д оролцоо бол хүний эрхийн суурь зарчим мөн гэж заагаад “нийгэмд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох, хамрагдах” боломж бүрдүүлэхийг уриалжээ. ХБХЭК-ийн 4 дүгээр зүйлд “хууль тогтоомж, бодлого хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх”-дээ “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй зөвлөлдөх бөгөөд тэднийг төлөөлөх байгууллагаар нь дамжуулан тэднийг идэвхтэй оролцуулах” нийтлэг үүргийг Оролцогч улсууд хүлээж байгааг онцолжээ. 29 дүгээр зүйл нь 3 дугаар зүйлд заасан Нийтлэг зарчмууд, 4 дүгээр зүйлд заасан Нийтлэг үүргүүдтэй нийлээд ашиг сонирхлыг нь хөндсөн аливаа асуудлаар шийдвэр гаргахад хүмүүс оролцох эрхтэй болохыг хамгийн тодорхой, ойлгомжтой байдлаар зааж өгсөн олон улсын хүний эрхийн хуулийн заалтууд юм.

Дүгнэж хэлэхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төр, нийгмийн амьдралд оролцох эрх, мөн ашиг сонирхлыг нь хөндсөн асуудлаар шийдвэр гаргахад оролцох эрхийг нь *хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх* үүргийг төр хүлээнэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төр, нийгмийн амьдралд оролцох эрхийг *хүндэтгэх* үүргийнхээ хүрээнд төр нь тэдний аливаа оролцоог хязгаарлахгүй, хөндлөнгөөс оролцохгүй байх ёстой. Оролцогч улсууд нь мөн ялгаварлан гадуурхсан зүйл, заалтыг хууль, төрийн бодлогод оруулахгүй байх, оролцооны асуудлаар ялгаварлан гадуурхсан хэм хэмжээг тогтоохоос зайлсхийх үүрэгтэй. *Хамгаалах* үүргийнхээ хүрээнд Оролцогч улсууд нь бүрэн дүүрэн оролцоог дэмжсэн эрхзүйн, захиргааны болон бусад арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд, жишээлбэл, сонгуулийн хялбар бөгөөд хүртээмжтэй дүрэм журам, дэд бүтцийг бий болгох, улс төрийн эрхээ эдлэх тэгш боломжийг хангаж өгөхөд чиглэсэн үйл ажиллагаа зэрэг багтана. Эцэст нь, оролцох эрхийг *хэрэгжүүлэх* үүргийнхээ хүрээнд Оролцогч улсууд эдгээр эрхийг бодитойгоор хэрэгжүүлэхэд чиглэсэн нарийвчилсан төлөвлөгөө гаргаж батлах үүрэгтэй. ХБХЭК-ийн Оролцогч улсууд нь сонгуулийн ажилтнуудыг зохих түвшинд сургаж бэлтгэх, сонгуулийн кампанит ажлын мэдээлэл сурталчилгааг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй арга хэлбэрээр хийхийг дэмжих ёстой. Хэрэгжүүлэх үүрэгт, цаашилбал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст улс төрийн оролцооны эрхээ эдлэх боломжийг бүрдүүлж, туслалцаа үзүүлэхэд чиглэсэн эерэг арга хэмжээ багтдаг.



## **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн амьдралд болон шийдвэр гаргах үйл явцад оролцох боломжийг нэмэгдүүлэх арга хэмжээ**

- Сонгогдсон төлөөлөгчдийг (парламентын гишүүд, орон нутгийн хурлын төлөөлөгчид) хөгжлийн бэрхшээлийн асуудлуудаар сургах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөө ажилладаг байгууллагуудын бүхий л төрлийн шийдвэр гаргалтад нөлөөлөх чадавхийг бэхжүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлийн асуудлаар олон нийтийн сургалт, сурталчилгаа явуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгох, сонгогдох эрхийг сурталчлан таниулсан компани ажил өрнүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлийн талаар нэгдмэл байр суурьтай болох үүднээс улс төрийн намуудтай хамтарсан олон нийтийн форум зохион байгуулах;
- Сонгуулийн хорооны гишүүд, ажилтнуудыг оролцуулсан сонгуулийн үйл ажиллагааны хүртээмжийг сайжруулах хамтарсан ажлын хэсэг байгуулах
- Иргэний болон сонгогчдын боловсролыг дээшлүүлэх сургалт, мэдээллийн материалд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дуу хоолойг тусгах, зураг чимэглэлдээ дүр төрхийг нь оруулах;
- Харааны бэрхшээлтэй хүмүүст хараат бус байдлаар нууцаар саналаа өгөх боломжийг хангаж өгөх үүднээс санал хэрхэн өгөх тухай зааврыг тэмтэрч уншдаг хэлбэрээр боловсруулж ашиглах;
- Сонгуулийн ажилд дайчлагдсан ажилтнуудад хүртээмжтэй байдлын талаар сургалт явуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сонгуулийн ажиглагчаар оролцуулах, сонгуулийн ажиглагчийн хяналтын хуудсанд хүртээмжтэй байдлын талаар асуулга, асуулт оруулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөгжлийн төсөл, хөтөлбөрийн төлөвлөлтөд оролцуулах, ийнхүү оролцуулах чиглэлээр хөгжлийн агентлаг, байгууллагуудыг лоббидох;
- НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг соёрхон батлахыг төрд уриалах, нөлөөлөх.<sup>3</sup>

### **САНАЛ ӨГӨХ БОЛОН СОНГУУЛИЙН БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ НЬ**

ХБХЭК-д хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сонгуульд оролцох эрхтэй гэж заасан бөгөөд энэ нь сонгогчоор бүртгүүлэх, сонгуулийн талаар мэдээлэл хүлээж авах, сонгуулийн өдөр саналаа хураалгах эрхтэй гэсэн үг юм. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сонгогчийн нэрийн жагсаалтад бүртгэх процедур, хэрэгслүүдийг хангаж өгөхийн зэрэгцээ санал өгөх байруудыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгож засах үүрэгтэй.

3 “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгуульд оролцох эрхийг хангах дэлхийн санаачлага (Global Initiative to Enfranchise People with Disabilities).” Сонгуулийн тогтолцооны олон улсын сан (*International Foundation for election systems IFES*). <http://www.electionaccess.org>





Оролцогч улсууд нь мөн иргэн бүр саналаа нууцаар өгөх боломж, нөхцлийг хангаж өгөх ёстой. Сонгогчоор бүртгүүлэх, саналаа өгөх эрх нь хэдийгээр бүх хүнд хамаатай эрх боловч энд нас, иргэний харьяалалтай холбоотой нийтлэг хязгаарлалтууд үйлчилнэ. Мөн сонгууль өгөх эрхээ хасуулсан хүмүүс байдаг бөгөөд түүний дотор эрх бүхий шүүхээр эрүүгийн шүүн таслах үйл явцын үр дүнд ял эдэлж байгаа хүмүүс багтдаг. Үүнээс гадна шүүхээр эрхзүйн чадамжгүй нь тогтоогдсон хүмүүсийн хувьд ийм хязгаарлалт мөн үйлчилдэг бөгөөд энэ нь ихэнхдээ оюуны болон сэтгэц-нийгмийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тохиолддог. Ийнхүү санал өгөх эрхийг хязгаарласан шийдвэр гараагүй л бол сонгогчид тавигдах бусад шалгуурт нийцсэн бүх хүн сонгуульд оролцох эрхтэй бөгөөд энэ эрхээ эдлэхэд нь хэн ч саад болох ёсгүй. Харин бодит амьдрал дээр оюуны болон сэтгэцийн чадавхид үндэслэсэн хязгаарлалтыг дур мэдэн, шүүхийн шийдвэргүй хэрэглэж буруугаар ашиглах явдал олонтаа тохиолддог. Ийм л учраас сонгогчид, сонгуулийн бүртгэл болон санал хураах үйл ажиллагааг зохион байгуулж байгаа хүмүүс, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өөрсдийнх нь боловсролыг дээшлүүлэх асуудал онцгой чухал юм.

Сонгуулийн процедур болон санал хураахтай холбоотой дэд бүтэц нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байх ёстой. Санал хураах байр нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүртгүүлэх, саналаа өгөхөд тотгор болох биет саадгүй байвал зохино. Жишээлбэл, шат бол тэргэнцэртэй болон хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүст саад, тотгор болохоос гадна харааны бэрхшээлтэй, хараагүй хүмүүст аюул учруулж мэднэ. Мэдээлэл, харилцааны саад тотгороос болж сонсголын бэрхшээлтэй хүмүүс сонгогчоор бүртгүүлэх, сонгуулийн өдөр саналаа хураалгах эрхээ эдэлж чадахгүйд хүрч магадгүй. Ийм сонгогчдод дохионы хэлний орчуулагч, мөн тод томруун зурган илэрхийлэл бүхий хэвлэмэл материал тус болдог. Энгийн хялбар найруулга, тайлбартай материал нь оюуны бэрхшээлтэй хүмүүст дэм болох талтай. Хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдыг хэрэгцээнд нь нийцсэн орчин нөхцлөөр хангаж, ялгаварлан гадуурхал гаргалгүй сонгуульд оролцуулж байхын тулд сонгуулийн ажилтнуудыг сайтар сургаж бэлтгэх хэрэгтэй.

Хүн бүр саналаа нууцаар өгөх эрхтэй бөгөөд энэ эрхийг ямар ч нөхцөлд хязгаарлаж болохгүй. Гэтэл олон оронд сонгогчийг бүртгэх, санал хураах үйл явц нь хөгжлийн бэрхшээлтэй, ялангуяа харааны бэрхшээлтэй хүний саналаа нууцаар хураалгах эрхийг хамгаалж чадахуйц хүртээмжтэй болж чадаагүй байна. Харааны бэрхшээлтэй хүмүүсийн нууцаар санал өгөх эрхийг хангахын тулд тэмтэрч уншдаг заавар болон саналын хуудас, эсвэл дуут заавар бүхий санал хураах автомат төхөөрөмж ашигладаг. Олон оронд мөн сонгуулийн процедурыг илүү хүртээмжтэй болгон журамладаг (Доорх мэдээллийг үз).

### Хараагүй хүмүүст зориулсан сонгуулийн хуудас

Либерийн 2005 оны сонгуулиар Либерийн Үндэсний сонгуулийн хороо, Олон улсын сонгуулийн тогтолцооны сан (ОУСТС)-тай хамтран харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан тэмтэрч уншдаг саналын хуудас ашиглах тухай заавар боловсруулж хэрэглэсэн нь хараагүй иргэдэд саналаа нууцаар өгөх эрхээ хэрэгжүүлэх боломж олгожээ. Энэ хуудсыг хэрхэн ашиглах талаар сонгуулийн ажилтнуудад сургалт явуулсан тул тэд харааны бэрхшээлтэй хүмүүст заавар, зөвлөгөө өгч байжээ. Мөн, Либери даяар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн байгууллага, эвслүүд нь энэ саналын хуудсыг хэрхэн ашиглах талаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст сургалт явуулжээ. Энэ хуудсыг Армени, Гана, Йемен зэрэг улсад нэвтрүүлэх ажилд ОУСТС дэмжлэг үзүүлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь сонгогчийн нэрийн жагсаалтад бүртгүүлэх, санал өгөхдөө туслалцаа авах эрхтэй. Жишээлбэл, санал өгөх байранд хамаатан, эсвэл найзаа дагуулан ирж болно. Сонгогчийг бүртгэх, санал хураах байраа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бүрэн хүртээмжтэй болгож чадаагүй газруудад дэмжлэг туслалцаа авах энэ эрх маш чухал ач холбогдолтой. Мөн хөтөч буюу туслах амьтад ч хүний улс төрийн амьдралд оролцох эрхийг хэрэгжүүлэхэд тус болдог.

Дэлхийн олон оронд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд нь сонгуулийн үйл явцыг бүх хүнд хүртээмжтэй болгохын зэрэгцээ хөгжлийн бэрхшээлийн талаарх хүмүүсийн ерөнхий мэдлэг, мэдээллийг сайжруулах боловсрол, сурталчилгаа, нөлөөллийн ажлуудыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг роль гүйцэтгэж ирсэн. Сонгууль бол хөгжлийн бэрхшээлийн асуудалд бүх нийтийн анхаарлыг татах, улс төрийн намуудтай ажиллах, сонгуулийн үйл явцыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгох, тэдний сонгуульд оролцох эрхийг хангахын тулд сонгуулийн байгууллагууд юу хийж байгааг үнэлэх боломж олгодог үйл явц юм. Мөн сонгуулийн үеэр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага нь сонгогчдын боловсролыг дээшлүүлэх, сонгуулийн үйл явцад ажиглалт, мониторинг хийх асуудлаар олон нийтийн бусад байгууллагатай хамтран ажиллах өргөн боломж гарч ирдэг. Ингэснээр эдгээр байгууллага өөр хоорондоо мэдээлэл солилцож, нөлөөллийн нэгдсэн зорилго чиглэлтэй ажиллан, бие биенээсээ нөлөөллийн ажлыг арга техник суралцах боломж бүрддэг.

### ДАСГАЛ 3.2: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ба сонгуулийн санал хураалгах үйл явцын хүртээмж

<b>Зорилт:</b>	Санал хураах үйл явц нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хэр сайн хангаж байгаад шинжилгээ хийх
<b>Хугацаа:</b>	45 минут
<b>Хэрэглэгдэхүүн:</b>	Самбар, шохой эсвэл том цаас, фломастер



## 1. Хэлэлцэх

Оролцогчдыг жижиг багуудад хуваагаад, дараах асуудлуудыг хэлэлцэх даалгавар өгнө. Асуултуудад хариулахдаа янз бүрийн төрлийн хөгжлийн бэрхшээлийг хамруулах (жишээлбэл, сонсголын, биеийн, сэтгэц-нийгмийн) хэрэгтэй гэдгийг сануул:

- Танай орон нутагт улс төрийн оролцоог бүрэн дүүрэн хангахад ямар саад бэрхшээл тулгарч болох вэ (жишээлбэл, санал өгөх, төрийн албанд орох, мэдээлэл хүртэх зэрэгтэй холбоотойгоор)?
- Сонгуульд саналаа өгөхтэй холбоотой саад, тотгор байгаа эсэхийг мэдэхгүй байгаа бол хаанаас, хэрхэн олж мэдэж болох вэ?
- Сонгуульд саналаа өгөхтэй холбоотойгоор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ямар саад тотгор тулгардгийг Та өөрийн биеэр мэдэрсэн, эсвэл хөндлөнгөөс ажиглаж байсан уу?

## 2. Илтгэх

Багуудад хэлэлцүүлгээ тоймлон танилцуулаад, тухайн тохиолдлыг дүрийн тоглолтоор үзүүлэх даалгавар өг. Оролцогчдын нэрлэсэн саад, тотгоруудыг бичиж ав.

## 3. Хэлэлцэх

Ялгаварлан гадуурхал гэдэг нь нэг бүлэг хүн өөр нэг нийгмийн бүлгийн талаар буруу ойлголттой, эсвэл сөрөг хэвшмэл үзэлтэй байдгаас үүсдэг гэдгийг тайлбарлаад дараах асуудлуудыг хэлэлц:

- Сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн санал өгөх чадавхитай холбоотой буруу ойлголтыг та хэрхэн няцаах вэ?
- Сонгуулийн үйл явцад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тавих анхаарлыг хэрхэн сайжруулах вэ?
- Сонгуулийн ажиглагчид хяналт тавих үүргийнхээ хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүртээмжийн асуудалд анхаардаг болохын тулд яах ёстой вэ?
- Сонгуультай холбоотой мэдлэг, боловсролыг дээшлүүлэх арга хэмжээндээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулахын тулд ямар алхмууд хийх шаардлагатай вэ?

**Нөөц хувилбар:** Сонгуулийн үйл явцын хүртээмжийг сайжруулах тухай баримт бичигт тусгах саналаа хамтран боловсруул. Үүнд сонгогчдын боловсрол, сонгогчдыг бүртгэх болон санал өгөх байр, саналын хуудасны тооллого, сонгуулийн ажиглалт зэрэг асуудлыг бүгдийг нь, эсвэл заримыг нь хамруул. Боловсруулсан саналаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах нөлөөллийн ажилдаа ашиглан үндэсний сонгуулийн хороод, сонгуулийн ажиглалт болон мониторинг хийдэг ТББ, ардчилал болон засаглал сайжруулах чиглэлээр ажилладаг олон улсын байгууллагуудад тараа.

### ДАСГАЛ 3.3: Сонгуулийн ажиглалт ба мониторинг

<b>Зорилт:</b>	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэднийг дэмжигчид сонгуулийн явцад мониторинг хийх, үнэлгээ өгөх ажилд хэрхэн оролцож болохыг хэлэлцэх
<b>Хугацаа:</b>	45 минут
<b>Хэрэглэгдэхүүн:</b>	Самбар, шохой эсвэл том цаас, фломастер

## 1. Танилцуулах

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь сонгуулийн үйл явцад ажиглалт хийх замаар сонгуулийн ил тод байдлыг сайжруулах, санал өгөхөд үүсч буй саад бэрхшээлийг илрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг онцлон тайлбарла. Сонгуулийн ажиглагчид нь санал хураах, саналын хуудас тоолох зэрэг үйл ажиллагаанд хяналт тавьдаг. Ажиглалт нь олон асуудлыг хамардаг бөгөөд үүнд тухайлбал:

- санал өгөх байрны байршил, түүний хүртээмжтэй байдлын талаар:
  - а. цагтаа нээж, хааж байх
  - б. санал хураах кабины байрлал
  - в. сонгогчдын эмх цэгцтэй хөдөлгөөн
- процедуруудын талаар мэдлэгтэй, тусламж хүссэн үед хариу өгөх чадвартай, сайтар бэлтгэгдсэн, чадавхитай сонгуулийн ажилтнуудтай байх
- сонгогчийн нэрийг жагсаалтаас хайж олох, шалгах тогтсон процедуртай байх
- санал хураалт нууц байх, үүнд:
  - а. саналын хуудсыг сонгуулийн ажилтнууд, ажиглагчдын нүднээс далд бөглөх боломж
  - б. хараагүй сонгогчид саналаа нууцаар өгөх боломж
- саналын хайрцгийн бүрэн бүтэн байдал, саналын хуудас тоолох, дүнг гаргах явцын баталгаатай байдал. Үүнд:
  - а. санал хураах хайрцаг нь санал хураалт эхлэхээс өмнө хоосон байсан эсэх, санал хураах байрыг хааснаас хойш болон саналын хуудсыг тээвэрлэх үед лац тэмдэг нь гэмтээгүй байх
  - б. санал тоолох үйл явц эргэлзээгүй, итгэл төрүүлэхүйц байх

## 2. Хэлэлцэх/боловсруулах

Оролцогчдыг жижиг багуудад хуваагаад дараах асуудлуудыг хэлэлц:

- Сонгуулийн ажиглалтад хөгжлийн бэрхшээлийн асуудлыг хэрхэн багтаах вэ?
- Сонгуулийн ажилтнуудыг хэрхэн сонгуулийн хүртээмжтэй байдалд мэдрэмжтэй, зохистой ханддаг болгох вэ?
- Дараагийн сонгуулийг улам хүртээмжтэй болгохын тулд сонгуулийн ажиглалтын үр дүнг хэрхэн ашиглаж болох вэ?

Сонгуулийн үйл явцыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгохтой холбоотой асуудлуудыг багтаасан сонгуулийн ажиглагчийн хуудас ба/эсвэл процедур боловсруулах даалгаврыг багуудад өг.

## 3. Илтгэх/хэлэлцэх

Багаас томилогдсон илтгэгчээс багийн хэлэлцүүлэг, сонгуулийн ажиглалтын хуудсыг танилцуулахыг хүс. Багуудын гаргасан санаануудыг самбар дээр бич.

## 4. Арга хэмжээ авах

Боловсруулсан хэрэглэгдэхүүнээ ажилдаа ашигла! Сонгуулийн ажиглалтад оролц! Ажиглагч бэлтгэх сургалтад туслалцаа дэмжлэг үзүүл! Гүйцэтгэсэн сонгуулийн ажиглалтаа тайлан болгож бичээд, хэвлүүл!



## СОНГУУЛЬД НЭР ДЭВШИХ БОЛОН ТӨРИЙН АЛБАНД АЖИЛЛАХ ТЭГШ БОЛОМЖ

Хөгжлийн бэрхшээлтэй хүн сонгуульт албан тушаалд нэр дэвших эрхтэй. Насны доод хязгаарыг хангасан иргэдийн сонгогдох эрхийг төрөөс хязгаарлах тохиолдол байдаг ч үндэслэлтэй, зохистой шалтгаанаар л ийм арга хэмжээ авч болно. Харин хөгжлийн бэрхшээл нь ийм хязгаарлалтын үндэс болох учиргүй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс аль ч түвшний төрийн болон захиргааны албанд орж ажиллах, түүний дотор орон нутгийн засаг захиргаанд алба хаших, НҮБ зэрэг олон улсын байгууллагад улсаа төлөөлж ажиллах зэрэг эрхийг бусадтай адил тэгшээр эдэлнэ. ХБХЭК-ийг батлахаас өмнө НҮБ-ын хэлэлцээрүүдэд хөгжлийн бэрхшээлтэй олон төрийн албан хаагч, сонгуульт төлөөлөгчид оролцсон юм. Энэ оролцоо нь төр, засгийн бүх түвшинд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг анхаарч хэвшихэд туслах алхам болсон.

Зарим улсад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд нь улсынхаа хууль тогтоох байгууллагад өөрсдийнхөө төлөөллийг баталгаатай оруулахад чиглэсэн нааштай шийдвэрүүдийг гаргуулж чаджээ. Жишээлбэл, Уганда улсын Үндсэн хуульд парламентын суудлын тодорхой хувийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эзэлж байхаар заажээ. Зарим улсад гүйцэтгэх засаглал нь парламентын гишүүдийн тодорхой хэсгийг томилдог бөгөөд тухайлбал Намибид энэ бодлогын үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй хэд хэдэн иргэнийг Ерөнхийлөгчийн зарлигаар хууль тогтоох байгууллагад суулгаж байна. Бусад улсад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, ашгийг төлөөлөх албан тушаалтан/ бүтэц бий болоод байна. Жишээлбэл, Шведэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах омбудсман, Намибид Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах зөвлөх байдаг бол АНУ-д Хөгжлийн бэрхшээлийн асуудал хариуцсан зөвлөл ажилладаг.

## ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ

ХБХЭК-д заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс аль ч түвшинд өөрсдийгөө төлөөлөх зорилгоор байгууллага байгуулж, эвлэлдэн нэгдэх эрхтэй. Энэ эрх нь аливаа асуудлаар бусад хүмүүстэй нийлж эвсэл байгуулах, байгуулагдчихсан эвсэл, холбоонд гишүүнээр элсэх боломжийг бүх хүнд олгодог. Эвсэл байгуулах, гишүүнээр элсэх нь зөвхөн сайн дурын асуудал бөгөөд ямар ч хүнийг аль нэг холбоо, эвсэлд элсэхийг шаардан, шахалт үзүүлж болохгүй. Оролцогч улсууд нь ийнхүү сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаажуулсан эрхзүйн орчныг бий болгож, энэ эрхийг хөндлөнгийн нөлөөллөөс хамгаалах үүрэгтэй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өөрсдийнх нь байгуулсан, эсвэл тэдний төлөө ажилладаг учраас эдгээрийг ХБХЭК-д олон удаа онцгойлон дурьдсан байдаг. Хөгжлийн бэрхшээлийг өөрийн биеэр амсаж буй хүмүүсийн үүсгэн, ажиллуулж байгаа эвслүүд нь тэднийг хамгийн сайн төлөөлж, дуу хоолойг нь шийдвэр гаргах түвшинд хүргэж чадна. ХБХЭК-ийг боловсруулахад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд идэвхтэй оролцсон бөгөөд цаашид ч хэрэгжүүлэх явцад тэдний оролцоо маш чухал байх юм.

## Парламентын оролцоо ба хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс

**Канад:** Парламентын доод танхимд хөгжлийн бэрхшээлтэй нэг гишүүн сонгогдсоны дараа “танхимын ажилд бүрэн оролцох боломжийг хөгжлийн бэрхшээлтэй гишүүнд хангаж өгөх үүднээс” Доод танхимын хурлын дэгт өөрчлөлт оруулжээ. Энэ дэгийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй гишүүн үг хэлэх, санал хураалгахдаа заавал босох албагүй болжээ. Мөн, хөгжлийн бэрхшээлтэй гишүүн хуралдаанд туслахаа дагуулан орж болно гэж заасан байна.

**Уганда:** 1995 онд батлагдсан шинэ Үндсэн хуулийн дагуу хууль тогтоох байгууллагын 5 гишүүн нь хөгжлийн бэрхшээлийг биеэр туулсан хүн байх ёстой ажээ. 1997 оны Орон нутгийн засаг захиргааны тухай хуульд бүх тосгон, омог, дүүрэг, тойргийн зөвлөлд хөгжлийн бэрхшээлтэй нэг эмэгтэй, нэг эрэгтэй төлөөлөгчийг сонгох ёстой гэж заажээ. Ийнхүү шууд сонгогдсон байгууллагад ажиллаж буй 47000 гишүүн нь дэлхийн хамгийн том хөгжлийн бэрхшээлтэй улс төрчдийн бүлэг юм. Хөгжлийн бэрхшээлтэй гишүүд парламентын Байнгын хороодод орж ажиллаж байгаагийн дотор Ерөнхийлөгчийн томилгоо, Дүрмийн болон Парламентын дархан эрх, Хууль зүйн болон Парламентын харилцаа, Комисс, Тусгай хороодын болон төрийн өмчийн аж ахуйн нэгжийн, Нийгмийн үйлчилгээний, Төрийн захиргаа, жендер, нутгийн удирдлагын зэрэг олон хороог нэрлэж болно. Хөтөч нохой, дохионы хэлний орчуулагчийн үйлчилгээг хууль тогтоох байгууллагын ажилд ашиглахыг зөвшөөрснөөс хойш парламентад ажиллах нь илүү амар болжээ.

**Шри Ланка:** Шри Ланкийн Үндсэн хуулийн 23 (2) дугаар зүйл буюу “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тусгай оролцооны талаар” хэсэгт “хөгжлийн бэрхшээлтэй хэн боловч бусад хүмүүсийн хэрэглэж, орж болдог байшин, барилгад хөгжлийн бэрхшээлээсээ болоод орж чадахгүй байх, ашиглах боломжгүй байдалд орж эрх нь хязгаарлагдах ёсгүй” гэж заажээ.

Шри Ланкийн Үндсэн хуулийн 89 дүгээр зүйл буюу “Сэтгэцийн бэрхшээлээс үүдэлтэй хязгаарлалт” хэсэгт

*“Дараах нөхцлийг хангасан хэн боловч ерөнхийлөгчийн, парламентын сонгууль, бүх нийтийн санал асуулгад оролцох эрхгүй болно. Үүнд ... (в) Шри Ланкад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн дагуу сэтгэцийн эмгэгтэй гэдэг нь тогтоогдсон буюу зарлагдсан тохиолдолд...” 91.1-д 89 дүгээр зүйлд дурьдсан нөхцлийг хангасан “хэн боловч парламентын гишүүнээр сонгогдохгүй, парламентын үүрэгт ажил гүйцэтгэхгүй, санал өгөхгүй” ... гэж заажээ*

**Танзани:** Маргарет Агнес Мканга бол Танзаний хууль тогтоох байгууллагад эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг төлөөлдөг гишүүн юм. Түүний гол үүрэг нь засгийн газрын бодлогыг боловсронгуй болгох замаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн хамгааллыг сайжруулахад зуучлах, хэлэлцэх, зөвлөх явдал юм. Парламентад ганцаараа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг төлөөлж суудаг учир тэрээр орон даяар хөдөө хотгүй явж хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөө ажилладаг байгууллага, хүмүүстэй уулзаж зөвлөлддөг байна.





**Өмнөд Африк:** Өмнөд Африкийн парламент хөгжлийн бэрхшээлтэй 11 гишүүнтэй. 1994 оны сонгуулиас өмнө хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс улс төрийн аргаар асуудлаа шийдвэрлүүлэх арга замыг судалж үзжээ. Тэд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Дүрэм гэдэг баримт бичиг боловсруулж ашиглаж, тухайн үед эрх барьж байсан Африкийн Үндэсний Конгрессийн намд (АҮКН) шахалт үзүүлэн, хөгжлийн бэрхшээлийн асуудал хариуцсан нэгж байгуулж чаджээ. Гурван жилийн дотор хөгжлийн бэрхшээлийн талаарх үндэсний хөтөлбөр батлагдаж, уг нэгжийг дэд ерөнхийлөгчийн албанд нэгтгэсэн байна.

### ДАСГАЛ 3.4: Оролцох эрхийг хөхиүлэн дэмжих амлалт авах нь

Хүний эрх гэдэг нь эдлэх эрх, мөн хүлээх үүрэг хоёрын нэгдэл гэдгийг тайлбарла.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төр, нийгмийн үйл хэрэг, шийдвэр гаргах явцад оролцох эрхийг судалж ойлгосны эцэст өөрсдөө үйл ажиллагаа явуулах, тодорхой арга хэмжээ авахад бэлэн байгаа эсэхийг оролцогчдоос асуу.
- Мэдээлэл цуглуулах, ажлаа төлөвлөх гээд хийх зүйл их байгаа ч өөрчлөлт хийх чин эрмэлзэл маш чухал гэдгийг тэмдэглэн хэл.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст улс төр, нийгмийн амьдрал, шийдвэр гаргалтад оролцох эрхээ бүрэн эдлэхэд нь нэмэр болох жижиг ч хамаагүй ямар ажлыг ирэх сард хийхийг хүсэж байгаа, хийх боломжтой байгааг оролцогч бүрээр хэлүүл.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах нөлөөллийн ажил хэрхэн төлөвлөх талаар “Хэсэг 3. Нөлөөлөл! Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа” (хуудас 278) хэсгээс уншина уу.

#### УЛС ТӨР, НИЙГМИЙН АМЬДРАЛД ОРОЛЦОХ ТАЛААР НЭМЭЛТ МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

- Хөгжлийн бэрхшээлтэй америкчуудын тухай хуулиар баталсан Сонгуулийн санал өгөх байранд хэрэглэх хяналтын хуудас. АНУ-ын Хууль зүйн департаментын Иргэний эрхийн хэлтсийн Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн нэгж, 2004 оны 2 дугаар сар:  
[www.ada.gov/votingck.htm](http://www.ada.gov/votingck.htm)
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгуулийн санал өгөх эрхийн талаарх дэлхийн санаачилга, Олон улсын сонгуулийн тогтолцооны сан (IFES):  
[www.electionaccess.org](http://www.electionaccess.org)
- Гудвил Гилл, Гай С. Чөлөөт, шударга сонгууль. Парламент хамтын ажиллагааны холбоо, 2006.



## БҮЛЭГ 4. ҮГ ХЭЛЭХ, ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

### НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци

#### 21 дүгээр зүйл. Үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэх, мэдээлэл хүртэх эрх чөлөө

Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусадтай адил тэгш байх үндсэн дээр энэхүү конвенцийн 2 дугаар зүйлд заасан өөрсдийн сонгосон харилцааны бүх төрлийн хэрэглэгдэхүүнээр дамжуулан үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл хүртэх, тухайлбал, төрөл бүрийн мэдээлэл, үзэл бодлыг хайх, олж авах, түгээх эрхээ эдлэх нөхцөл байдлыг бий болгох үүднээс зохих бүхий л арга хэмжээ авах бөгөөд ялангуяа:

- a) нийгмийн бүх гишүүнд зориулсан мэдээллийг түгээхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүн ашиглахад хүртээлтэй байхад зориулж хөгжлийн бэрхшээлийн янз бүрийн хэлбэрт нийцсэн арга замаар, тухайн цаг хугацаанд нь, ямар нэг нэмэлт өртөг зардалгүйгээр түгээх;
- b) албан харилцаанд дохионы хэл, брайль үсэг, харилцааны нэмэлт болон сонголтот хэлбэр болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгосон мэдээлэл хүртэх харилцааны бусад арга зам, хэлбэр, хэв маягийг ашиглах явдлыг хүлээн авч дэмжлэг үзүүлэх;
- c) интернетийг оролцуулан нийгмийн бүх гишүүнд зориулсан үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг мэдээлэл түгээх, үйлчилгээ үзүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ашиглаж болохуйц хэлбэрээр түгээх нөхцөл бололцоо бий болгохыг уриалах;
- d) интернетээр мэдээлэл түгээдэг байгууллагуудыг оролцуулан олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийн үзүүлдэг үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байлгахад дэмжлэг үзүүлэх;
- e) дохионы хэлнүүдийг хэрэглэх явдлыг хүлээн зөвшөөрч, хөхиүлэн дэмжих.

#### 2 дугаар зүйл. Тодорхойлолт (хэсэгчилсэн ишлэл):

“Харилцаа” гэж хэл яриа, эх бичвэрийн үзүүлэн, Брайль болон тактил хэл, том үсгээр хэвлэгдсэн ойлгоход хялбар мультимедиа хэлбэртэй тоног төхөөрөмж, тухайлбал хэвлэмэл төхөөрөмж, аудио тоног төхөөрөмж, ердийн хэл яриа, ярьдаг ном, түүнчлэн эдгээрийг томруулсан болон орлуулсан аргачлал, харилцаа, түүний дотор мэдээлэл харилцааны технологид нэвтрэх бусад хэрэгслийг хэлнэ;

“Хэл яриа” гэдэгт ярианы болон бичгийн хэл, түүнчлэн ярианы бус бусад төрлийн хэлийг хэлнэ.

## ЗОРИЛТУУД

Энэ бүлэгт багтсан мэдээлэл, дасгалууд нь оролцогчдод дараах зорилтыг хангахад туслах зорилготой:

- Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг тодорхойлох
- Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд ямар ач холбогдолтой болохыг тайлбарлах
- Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон хүний бусад эрхийн хоорондын уялдааг ойлгох
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх хэрхэн хангагдаж эсвэл зөрчигдөж байгааг мэддэг болох
- **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн (ХБХЭК)** үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний талаарх заалтуудыг ойлгох.

## ЭХЛЭЛ: ҮГ ХЭЛЭХ, ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЭХ НЬ

Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь хэд хэдэн салангид боловч хоорондоо харилцан холбоотой зарчимд суурилдаг бөгөөд эдгээр нь тус бүрдээ ямар нэг хэмжээнд төрийн хязгаарлалтад өртөж болзошгүй.

### 1. Өөрийн үзэл, бодолтой байх эрх чөлөө

Хүн бүр өөрийн үзэл, бодолтой байх эрхтэй ба энэ нь хэр түгээмэл, таагүй, эсвэл эргэлзээтэй байхаас огт хамаарахгүй. Төрөөс хүний энэ эрхийг хязгаарлавал төр хүний бодол санаанд хөндлөнгөөс оролцож байгаа хэрэг болох тул энэ эрхийг төр үг дуугүй хамгаалж, ямар ч хэлбэрээр хязгаарлах учиргүй. Үндсэндээ бид юу дуртайгаа бодож, юуг, яаж бодохоо хэнээр ч заалгахгүй байх эрхтэй.

### 2. Үг хэлэх эрх чөлөө

Үг хэлэх эрх чөлөө нь хоёр хэсгээс бүрдэнэ:

- а) Бүх төрлийн мэдээлэл, үзлийг чөлөөтэй илэрхийлэх, түгээх эрх
- б) Мэдээллийг эрж сурвалжлах, олж ашиглах эрх.

Үүнээс харахад үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь мэдээлэл солилцох, санал бодлоо илэрхийлэх, мөн итгэл үнэмшлээ боловсруулахад шаардлагатай мэдээллийг олж авах эрхийг багтааж байгаа нь тодорхой.

Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь үзэл бодолтой байх эрхээс хариуцлага дагуулдгаараа, мөн төрийн хязгаарлалтад өртдөгөөрөө ялгаатай. Учир нь мэдээлэл солилцох, үзэл бодлоо илэрхийлэх нь зарим тохиолдолд, жишээлбэл, үзэн ядалтыг дэвэргэх, бусдын нэр хүндэд халдсан худал мэдээлэл тараах зэрэг тохиолдолд бусдад гэм хохирол учруулж мэднэ. Иймээс нийгмийн аюулгүй байдал, дэг журам, эрүүл мэнд, ёс суртахуун, мөн бусдын суурь эрх, эрх чөлөөг хамгаалах үүднээс эдгээр эрхэд төрөөс хязгаарлалт тавихыг зөвшөөрдөг.

Гэхдээ энэхүү хязгаарлалтыг төр хуулиар тавьдаг бөгөөд дээр дурьдсан ашиг сонирхлыг хамгаалах зорилготой байх ёстой. Мөн аливаа хязгаарлалт нь тэр эрхийг бүрэн үгүйсгэх хэмжээтэй өргөн байж болохгүй.

Үг хэлэх, үзэл, бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бусад эрхээ эдлэхэд чухал ач холбогдолтой. Жишээлбэл, мэдээлэл, үзэл, бодлоо чөлөөтэй солилцоход оролцох боломжгүй бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хэрхэн эвсэл холбоо байгуулж, үйлдвэрчний эвлэлд нэгдэж, үр ашигтай ажиллах билээ. Үүний нэгэн адилаар, хэрэв нэр дэвшигчид өөрсдийн үзэл бодлоо илэрхийлж болдоггүй, эсвэл сонгогчид өөрсдийн сонирхсон асуудлаар мэдээлэл авч чаддаггүй байх юм бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн болон нийгмийн амьдралд оролцох (жишээлбэл, сонгуульд саналаа өгөх, төрийн алба хаших зэрэг) боломж нь хязгаарлагдана. Судалгаа хийх, хэлэлцүүлэг явуулах нь сургалтын орчны амин чухал бүрдэл хэсэг болдог учраас үзэл, бодлоо тодорхойлох, солилцох нь сурч боловсрох эрхтэй нягт холбоотой. Үүнтэй нэгэн адилаар үзэл, бодол бүрдэх, солилцох нь соёл урлагийн хөгжилд чухал үүрэгтэй бөгөөд хүмүүст өөрийгөө илэрхийлэх чухал арга хэрэгсэл болж өгдөг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс үг хэлэх, үзэл бодолтой байх эрх чөлөөгөө эдлэхгүй бол Оролцогч улсуудын засгийн газар нь ХБХЭК-ийн 3 дугаар зүйлд заасан ёсоор ХБХЭК-ийн хэрэгжүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй зөвлөлдөх, тэднийг идэвхтэй оролцуулах шаардлагыг биелүүлж чадахгүйд хүрч, улмаар ХБХЭК-ийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бусад эрх нь зөрчигдвөл тэдний үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө эдлэх боломж хязгаарлагдаж болох юм. Жишээлбэл, боловсрол хүртээмжгүй бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үзэл бодлоо уралдуулах, бусадтай санал бодлоо солилцоход нэмэр болдог мэдлэг, чадвар эзэмших боломж хумигдана. Хэрэв хүний хувийн нууцыг хамгаалахгүй бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс үзэл, бодлоо цаасан дээр буулгахаас зайлсхийдэг болно. Ялангуяа бие дааж, эсвэл олон нийтийн дунд амьдрах эрхээ эдэлж чадахгүй асрамжийн газар зэрэг байгууллагад (ажилтнууд нь хүний хувийн нууцыг хангалттай дээдэлдэггүй бол) амьдардаг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст энэ нь онцгой чухал асуудал юм.

Үг хэлэх, үзэл, бодлоо илэрхийлэх эрх чөлөөний ач холбогдол нь тодорхой атал энэ эрхээ бүрэн эдлэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст олон саад тотгор учирдаг. Жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй олон хүн хүртээмжтэй хэлбэрээр мэдээлэл авч чаддаггүй. Технологийн олон шийдэл, арга хэлбэр байдаг ч ялангуяа хөгжиж буй орнуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй, бөгөөд боломжийн өртөгтэй хэрэгсэл тэр болгон байдаггүй. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд энэ асуудалд онцгой анхаарах шаардлагатай. Телевизүүд урсдаг текст, дүлий үзэгчдэд зориулсан дохионы хэлмэрч, хараагүй болон сул хараатай үзэгчдэд зориулсан аудио текст зэргийг бага хэрэглэдэг. Хараагүй хүмүүст зориулсан Брайль үсгээр бичсэн, эсвэл оюуны бэрхшээлтэй хүмүүст зориулсан энгийн хэллэгтэй сонин мөн ховор. Интернетийг мэдээллийн эх үүсвэр, судалгааны хэрэгсэл болгон ашиглах явдал нэмэгдэж байгаа ч ихэнх вебсайт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжгүй хэвээр байна. Телевиз, радио, интернетийн дижитал технологиуд зэрэг шинээр нэвтэрч буй шийдлүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүрэх хүртээмжийг өргөжүүлэх ихээхэн боломжийг агуулж байгаа. Гэхдээ энэ боломжийг амьдрал дээр хэрэгжүүлэх эсэх нь шийдвэр

гаргагчид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг хэр ойлгож байгаа, тэдний дуу хоолойг хэр зэрэг сонсож байгаагаас хамаарах юм.

Хүний эрхийн хэрэгжилтэд ноцтой саад болдог зүйл бол бусад хүмүүсийн хандлага, үзэл бодол юм. Нийгэмд тогтсон хэвшмэл үзэл, хандлага нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үзэл бодлыг таагүй хүлээж авах уур амьсгалыг үүсгэдэг. Тэд үзэл бодлоо илэрхийллээ ч гэсэн түүнийг нь бусдынхтай адил хэмжээнд ойшоох шаардлагагүй гэж үзэх хандлага байдаг. Оюуны бэрхшээлтэй болон сэтгэц-нийгмийн бэрхшээлтэй хүмүүс сэтгэж бодох, тэр ч бүү хэл өөрсдийгөө илэрхийлэх арга хэлбэрээ “нийтийн жишигт” нийцүүлэх шахалтад өртөх нь элбэг. Сэтгэцэд нөлөөлөх эм албадан уулгаснаас сэтгэн бодох процесст өөрчлөлт орж, тод сэтгэх, үзэл бодлоо тодорхойлоход хэцүү болдог гэж сэтгэц-нийгмийн бэрхшээлтэй хүмүүсийн зарим нь ярьж байна. Заримдаа сэтгэц-нийгмийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хийж, ярьж байгаа зүйлс бусад хүмүүст эвгүйцэл, эмзэглэл төрүүлэхээс сэргийлэхийн тул тэдний сэтгэн бодох, өөрийгөө илэрхийлэх арга хэлбэрийг өөрчлөх зорилгоор ийм эмийг хэрэглэдэг бөгөөд “логикгүй” бодол, санаа, бодлоос нь ангижруулах учраас ийм эмчилгээ тэдэнд хэрэгтэй гэсэн тайлбараар үүнийгээ зөвтгөдөг.

Дүгнэж хэлэхэд, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бие хүн болж төлөвших, нийгмийн амьдралд бусадтай адил тэгш оролцох боломжийг хангахад маш чухал үүрэгтэй. Харамсалтай нь хүртээмж, хандлагаас улбаатай саад, бусад олон тотгорыг арилгахгүй бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс энэ эрхээ бүрэн эдэлж чадахгүй хэвээр байх юм.

### **Мэдээллийг энгийн хэллэгээр илэрхийлэх**

Техник мэргэжлийн болон сэргээн засварлах судалгааны төвийн Жан Росс, Жанет Прингл нар 2002 онд Энгийн хэлний олон улсын нийгэмлэгийн (PLAIN) хурал дээр “Би үүнийг уншиж чадаж байна! Энгийн хэлний асуудлууд ба оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс” гарчигтай илтгэл тавьжээ. Өөрийгөө хөгжлийн хоцрогдолтой гэж тодорхойлдог Жан Росс мэдээллийг энгийн хэлээр илэрхийлэх нь ямар ач холбогдолтой болохыг тайлбарлан дараах шалтгаануудыг нэрлэж байна:

*Бидний мэдэх ёстой зүйлийг бидний уншиж чадахгүй хэлбэрээр бичих нь шударга бус юм. Тийм зүйлийг унших гэж бид туслах ажилтан, эсвэл гэр бүлийн хүмүүсээс тусалцаа хүлээх хэрэгтэй болдог. Гэвч тэд заримдаа завгүй байдаг, заримдаа мартдаг. Иймээс бид өөрсдөө уншиж чаддаг байх ёстой.*

Жан шиг хөгжлийн хоцрогдолтой хүмүүс оюуны хөгжлийн бэрхшээлтэй Жанет шиг хүмүүст мэдээллийг энгийн хэллэгээр “орчуулж” тусалдаг. Энэ нь мэдээллийн агуулгыг аль болохоор олон хүнд хүртээмжтэй болгоход тусалдаг ажээ (Мэдээллийг бусад төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгохын тулд Брайль үсэг зэрэг альтернатив хэлбэрт оруулах шаардлага ч гардаг).

Мэдээллийг орчуулсны дараа тэд багаараа ажиллаж, чухам ямар агуулгыг хүргэхээр зорьж, энэ агуулгаа хүн бүрт ойлгомжтойгоор илэрхийлж чадсан эсэхээ шалгадаг байна. Энэ процессыг Жан тайлбарлахдаа:

*Жанет бидний хоёр, гурван хүнийг хамтран ажиллахыг хүсээд, тэдэнд текстийг багахан хэсгээр чанга уншиж өгдөг. Огт уншиж чадахгүй зарим нь сонсоно. Над шиг сайн уншдаг хүмүүс ч бий. Хэсэг бүр ямар утгатай тухай бид ярилцдаг ба ойлгоогүй бол бид түүнийгээ хэлдэг. Заримдаа илүү ойлгомжтой үг олоход Жанет бидэнд тусалдаг бол заримдаа бид өөрсдөө тэр үгийг олдог. Бид бүгдээрээ оролцдог. Хэнийг ч орхидоггүй. Бие биедээ итгэдэг, найддаг учраас ойлгоогүй үедээ бид түүнийгээ хэлж чаддаг. Ойлгосонгүй гэж хэлэх болгондоо бид ойлгоогүй өөр хүмүүст тусалж байгаагаа мэддэг<sup>1</sup> хэмээн ярьж байна.*

## ДАСГАЛ 4.1: Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг эдлэх нь

- Зорилт:** Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг эдлэх гэж юуг хэлж байгааг ойлгох
- Хугацаа:** 30 минут
- Хэрэглэгдэхүүн:** Том цаас, фломастер эсвэл самбар, шохой

### 1. Санал солилцох/Хэлэлцэх

Таны амьдарч буй орчинд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өдөр тутам хийдэг ердийн гурван үйлдлийг жагсаан бич (Энэ жагсаалтаа дараагийн 4.2, 4.3 дасгал хийхэд мөн хэрэглэнэ).

### 2. Шинжлэх

- Жагсаан бичсэн өдөр тутмын үйл ажиллагаануудыг судлан дүн шинжилгээ хийж, оролцогчдын хариултуудыг мөн жагсаан бич:
  - Эдгээр ажлын алинд нь бүрэн оролцохын тулд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэдээлэл шаардлагатай вэ?
  - Ямар төрлийн мэдээлэл тэдэнд хэрэгтэй вэ?
  - Тэр мэдээллийг хүргэх үүргийг хэнд хүлээх ёстой вэ?
- Жагсаан бичсэн өдөр тутмын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж оролцогчдын хариултуудыг мөн жагсаан бич:
  - Эдгээр ажлын алинд нь бүрэн оролцохын тулд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс үзэл бодлоо тодорхойлж, илэрхийлэх шаардлагатай болох вэ?
  - Харилцааны өөр ямар арга хэрэгслийг тэд хэрэглэх боломжтой вэ?

1 Жин Росс, Жанет Прингл нар. “Би үүнийг уншиж чадна! Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ярианы хэлийн хэтийн төлөв.” 2002 оны 9 сарын 27. Ярианы хэлний олон улсын ассоциаци (PLAIN). Хоёр жил тутмын Дөрөвдүгээр бага хурлын эмхтгэл. <http://www.plainlanguagenetwork.org/conferences/2002/perspect/perspect.pdf> Мөн Техник мэргэжлийн болон сэргээн засах судалгааны институтын (VRRRI) веб сайтыг үзнэ үү: <http://www.vrri.org>



### 3. Ач холбогдлоор нь эрэмбэлэх

1. Оролцогчдыг жижиг багуудад хуваа. Хоёрдугаар алхамд тэдний тодорхойлсон хэрэгцээний жагсаалтаас, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ бүрэн эдлэхэд нь хамгийн хэрэгтэй таван хэрэгцээг нэрлүүл.
2. Багуудаа буцааж нэгтгээд, эрэмбэлсэн жагсаалтуудыг харьцуулах даалгавар өг. Хүн бүр зөвшөөрсөн нэг жагсаалт гарга.
3. Энэ бол үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний талаарх нөлөөллийн ажлыг төлөвлөх анхны алхам байсныг тайлбарла. Энэ жагсаалтаа дараа дахин хэрэглэхээр хадгалахыг сануул.

#### НҮБ-аас хэрэгжүүлсэн интернетийн глобаль аудит

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өдөр тутмын хэрэглээнд дэлхийн вебсайтууд хэр зэрэг хүртээмжтэй байгааг тандан судлах судалгааг НҮБ-ын захиалгаар технологийн хүртээмжийн чиглэлээр дагнан ажилладаг Номенза компани хийжээ. Судалгаанд 20 орны жуулчлал, санхүү, хэвлэл мэдээлэл, улс төр, жижиглэн худалдааны салбарын 100 вебсайтыг хамруулжээ. Судалгаагаар эдгээр вебсайт одоогоор хүртээмжтэй байдлын талаарх олон улсын стандартад нийцэхгүй байгааг, мөн сайжруулахын тулд нэлээд хэмжээний ажил хийх шаардлагатай байгаа нь харагджээ. Дэлхийн вебсайтуудын 3 нь л хүртээмжтэй байдлын шалгуурт нийцсэн байна. Вебсайт ашиглахад янз бүрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгардаг саад бэрхшээлийг харуулсан зарим дүгнэлтийг доор сийрүүлэв:

- 93% нь график мэдээлэлдээ хангалттай текстэн тайлбар өгөөгүй ба энэ нь харааны бэрхшээлтэй хүмүүст түвэгтэй байдаг.
- 78% нь өнгөний ялгаралд анхаараагүйгээс өнгө ялгах зэрэг харааны ялимгүй бэрхшээлтэй хүмүүс уншихад түвэгтэй байдаг.
- 97 % нь линк хийж өгөхдөө хаягны өнгөний ялгарлыг анхаараагүйгээс сурах бэрхшээлтэй хүмүүст түвэгтэй байдаг.
- 92% нь хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээнд нийцсэн товчлуурууд байдаггүй тул ашиглахад бэрхшээлтэй байдаг байна.<sup>2</sup>

2 “НҮБ-ын “Вебийн хүртээмжийн талаарх глобаль аудит. Тайлангийн хураангуй.” 2006 оны 11 сар. НҮБ-ын Нийгэм, Эдийн засгийн хэлтэс: Нийгмийн бодлого ба Хөгжил <http://www.un.org/esa/socdev/enable/documents/execsumnomensa.doc>.

Мөн НҮБ-ын Нийгэм, Эдийн засгийн хэлтэс (DESA)-ийн Глобаль аудитын вебсайт: <http://www.un.org/esa/socdev/enable/gawanomensa.htm>

Мөн Nomensa: <http://www.nomensa.com/about.html> зэрэг сайтыг үз.



## ДАСГАЛ 4.2: Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө эдлэхэд учирдаг саад тотгор

<b>Зорилт:</b>	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө эдлэхэд учирдаг саад бэрхшээлийг таньж мэдэх
<b>Хугацаа:</b>	40 минут
<b>Хэрэглэгдэхүүн:</b>	4.1 дасгалаар гаргасан жагсаалт

### 1. Шинжлэх

Оролцогчдыг хосоор нь баг болгоод 4.1 дасгалаар гаргасан жагсаалтаас нэг үйл ажиллагааг сонгон, түүнтэй холбоотойгоор мэдээлэл авах, үзэл бодлоо илэрхийлэхэд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тохиолддог саад бэрхшээлийг олох, мөн ямар байвал тэдэнд илүү тохиромжтой байхыг тодорхойлуул.

### 2. Дүрд тоглох

Оролцогчдоос дүн шинжилгээгээ танилцуулахыг хүсээд, дээрх үйл ажиллагаанд оролцоход нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэдээллийг ойлгох, үзэл бодлоо илэрхийлэхтэй холбоотой учирдаг бэрхшээлийн дор хаяад нэг зохиомол боловч нийтлэг жишээг дүрийн тоглолтоор үзүүлэхийг хүс.

### 3. Хэлэлцэх

- Шинжилж үзсэн тохиолдол бүрт мэдээлэл авах болон түгээхэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулаагүйгээс ямар үр дагавар үүсэх вэ?
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнд өөрт нь ямар үр дагавар гарах вэ?
- Нийгэмд бүхэлд нь ямар үр дагавар гарах вэ?
- Аль саад, тотгор нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хамгийн ноцтой нөлөө үзүүлэх вэ?
- Мэдээлэл авах, дамжуулахтай холбоотой үүсэх хамгийн ноцтой саад бэрхшээлүүдийг арилгахын тулд юу хийж болох вэ?

ҮГ ХЭЛЭХ, ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТАЛААР  
ХҮНИЙ ЭРХИЙН ХУУЛЬ ЭРХЗҮЙД ЮУ ГЭЖ ЗААСАН БАЙДАГ ВЭ?

**Хүний эрхийн түгээмэл тунхаглалын (ХЭТТ)** 19 дүгээр зүйлд үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний суурь зарчмуудыг бүгдийг нь багтаасан цогц тайлбарыг өгсний дотор хөндлөнгийн нөлөөллөөс ангид байдлаар өөрийн үзэл бодолтой байх эрх, мөн “улс орны хилээр үл хязгаарлан аливаа арга замаар”<sup>3</sup> мэдээлэл, үзэл санааг олж авах, түгээн дэлгэрүүлэх эрх зэргийг дурьджээ. Иймд, энэ эрхэд газар зүйн хязгаарлалт байхгүй бөгөөд энэ эрхээ эдлэхдээ янз бүрийн арга, хэрэгсэл, сувгийг ашиглаж болох ажээ.

**Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИУТЭОУП)**<sup>4</sup> энэ эрхийг дэлгэрүүлэн тайлбарлаж, энэ эрхийг эдлэхэд Оролцогч улсууд хэзээ, хэрхэн хязгаарлалт

3 <http://www.unhchr.ch/udhr> сайтаас үз.

4 <http://www.ohchr.org/english/law/ccpr.htm> сайтаас үз.





тавьж болохыг нарийвчлан тайлбарлажээ. ИУТЭОУП-ын 19 дүгээр зүйлд өөрийн үзэл бодолтой байх хүний эрх чөлөөг хязгаарлахыг зөвшөөрөөгүй ч, Ерөнхий зөвлөмжид “бусдын эрх, эрх чөлөө, нэр төр”, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, эрүүл мэнд, ёс суртахууныг хүндэтгэх үүднээс үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, эрх чөлөөнд хязгаарлалт тавихыг зөвшөөрсөн бөгөөд Хүний эрхийн хороо энэ хязгаарлалтыг хуулиар зохицуулсан байх ёстойг тэмдэглэжээ. Хязгаарлалтууд нь “энэхүү эрхэд өөрт нь аюул занал учруулж болохгүй” бөгөөд хэн нэгний үзэмжээр хэрэглэгддэг байж болохгүй.

Хүний эрхийн бусад конвенцид үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн талаар ИУТЭОУП шиг нарийвчилсан заалтууд ороогүй байна. Жишээлбэл, **Арьсны өнгөөр алагчлах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенцийн** (АӨАБХУК) 5 дугаар зүйлд Улс орнууд арьсны өнгөөр ялгаварлан гадуурхахыг хориглох, устгах, “үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг” эдлэх тэгш боломжийг хангах ёстой гэдгийг л дурьдсан байдаг.<sup>5</sup> **Хүүхдийн эрхийн конвенцийн**<sup>6</sup> (ХЭК) 13 дугаар зүйл үндсэндээ ИУТЭОУП-ын санааг давтсан ч 12 дугаар зүйлд хүүхдүүд өөрсдөд нь холбоотой бүх асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжтой байж, хүүхэд өсөж хөгжин, чадвар туршлага нь нэмэгдэхийн хэрээр үзэл бодлыг нь илүүтэй харгалзах тухай заажээ.

Заавал мөрдөх албагүй **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боломжийг тэгшитгэх НҮБ-ын стандарт дүрмүүдэд** (Стандарт дүрмүүд)<sup>7</sup> үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн талаар тусгай заалт ороогүй байна. Гэхдээ уг Дүрмийн хэд хэдэн заалтад энэ эрхийг эдлэхийн тулд оролцооны тэгш байдлыг хангасан байх ёстой тухай заажээ. Үүнд:

- Дүрэм №1-д үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст саад болдог бусдын хандлагаас үүдэлтэй бэрхшээл, тотгорыг арилгахад эерэг нөлөө үзүүлэх мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх
- Дүрэм №4-д үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тустай байж болох туслах тоноглол, үйлчилгээг хангаж өгөх
- Дүрэм №5-д мэдээлэл, харилцаа холбооны хүртээмжтэй байдал зэрэг хүртээмжтэй холбогдолтой асуудлуудыг багтаасан
- Дүрэм №10-д уран зохиол, кино болон театрын үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст соёл урлагийн үр шимийг хүртээмжтэй хүртэхэд чиглүүлэх тухай онцлон тэмдэглэсэн байдаг.

**Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн** (ХБХЭК) 21 дүгээр зүйлд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг ИУТЭОУП шиг нарийвчилж тусгаагүй ч энэхүү эрхээ бусадтай ижил тэгш эдлэх боломжид нөлөөлж болох асуудлуудыг нарийвчлан авч үзжээ. Энэ зүйлд мэдээллийн хэрэгцээнд ихээхэн ач холбогдол өгч, тэр дундаа олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж буй мэдээлэл, улсын болон хувийн мэдээллийн хэрэгслээр нийтэд зориулан түгээж буй мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй технологи, хэлбэрээр хүргэх ёстойг онцлон тэмдэглэсэн байдаг. Энэ зүйл мөн Улс орнуудыг дохионы хэл, Брайль, болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “албан ёсны харилцаанд” орохдоо хэрэглэдэг бусад хэрэгсэл, форматыг нэвтрүүлэхийг уриалжээ. 21 дүгээр зүйлд дохионы хэлийг хүлээн зөвшөөрч, хэрэглээг нь өргөтгөхийг Улс орнуудад уриалжээ. “Хэл”, “харилцаа холбоо” гэсэн нэр томъёоны тодорхойлолтыг 2 дугаар зүйлд өгсөн байна.

5 <http://www.ohchr.org/english/law/cerd.htm> сайтаас үз.

6 <http://www.unhcr.ch/html/menu3/b/k2crc.htm> сайтаас үз.

7 <http://www.un.org/ecosocdev/geninfo/dpi1647e.htm> сайтаас үз.

Дүгнэж хэлэхэд, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний талаар Улс орнууд дараах үүрэг хариуцлагыг хүлээнэ:

1. **Хүндэтгэх үүрэг** - энэ эрхээ хэрэгжүүлэхэд нь хүмүүст саад тотгор үүсгэх аливаа үйлдэл, зан заншил, практик дадал зэргээс татгалзах (жишээ нь, дүлий хүмүүст дохионы хэл ашиглахыг хориглохгүй байх)
2. **Хамгаалах үүрэг** –олон нийтэд мэдээлэл түгээх бизнес эрхэлдэг хувийн хэвшлийнхэн, мөн төрийн бус этгээд энэхүү эрхийг эдлэхэд саад тотгор үүсгэхгүй байх, байгаа саад тотгорыг арилгах (жишээ нь, хүртээмж муутай веб хуудсаа засварлах) байх нөхцлийг бүрдүүлэх
3. **Хэрэгжүүлэх үүрэг** - хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст энэ эрхээ эдлэх боломжийг хангаж өгөхөд чиглэсэн идэвхтэй арга хэмжээг Улс орнууд авч хэрэгжүүлэх зэрэг болно.

Товчоор хэлэхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн амьдралын бүхий л хүрээнд бусадтай адил тэгш оролцох боломжоор хангах үүднээс үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг олон улсын хүний эрхийн эрхзүйд тууштай дэмждэг юм.

### ДАСГАЛ 4.3: Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний талаар

<b>Зорилт:</b>	Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай ХБХЭК-ийн заалтыг сануулах, ойлгох
<b>Хугацаа:</b>	45 минут
<b>Хэрэглэгдэхүүн:</b>	Том цаас, фломастер эсвэл самбар, шохой

#### 1. Бататгах

Оролцогчдыг жижиг багуудад хуваагаад, багаараа 21 дүгээр зүйлийн аль нэг хэсгийг хэлэлцэх даалгавар өг.

- Хэсэг тус бүрт ямар нөхцлийг хангасан байхыг шаардсан байна вэ?
- Тэрхүү шаардлагыг хангах нь хэний үүрэг вэ?
- Хэрэгжүүлэхэд нь ямар бэрхшээл тохиолдож болох вэ?
- Тэдгээр бэрхшээлийг хэрхэн даван туулах вэ?

#### 2. Хэлэлцэх

Баг болгон хэлэлцүүлгийнхээ дүнг танилцуулна.

#### 3. Жишээ гаргах

21 дүгээр зүйлийн заалт бүрийг 4.1, 4.2 дасгалаар хэлэлцсэн бодит амьдралын жишээн дээр хэрхэн хэрэглэж болохыг харуулсан жишээ гаргаж ирэхийг хүс.

#### 4. Хэлэлцэх

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах асуудлыг үндэсний хэмжээний бодлогын асуудал болгож тавих, мөн улс төрийн нам, шийдвэр гаргагчдад өргөн барих үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулахад ХБХЭК- 21 дүгээр зүйлийг хэрхэн ашиглаж болох вэ?



- ХБХЭК-ийг танай оронд хэрэгжүүлэх нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ямар ач холбогдолтой байх вэ?

**Сонсголгүй хүмүүсийн үндэсний нийгэмлэг: Үзэл, бодолтой байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах нь**

Сонсголгүй хүмүүсийн үндэсний нийгэмлэг (СХҮН) бол АНУ-ын сонсголгүй, сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг байгууллагуудын нэг юм. Нийгэмлэгээс ердийн хэвлэл мэдээллийг сонсголгүй хүмүүст хүртээмжтэй болгох, харилцаа холбоог сонсголгүй болон сонсголын бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгож хялбаршуулах зэрэг зорилготой кампанит ажлууд, мөн тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Текстэн тайлбартай телевизийн нэвтрүүлгийн тоог нэмэгдүүлэх, телевизийн нэвтрүүлэгт зураг, дүрсэн тайлбар ашиглах талаар шинэ дүрэм бий болгох чиглэлээр конгресс болон үндэсний харилцаа холбооны газартай хамтран ажиллах;
- Кинотеатрт гарч буй бүх киног анхны өдрөөс нь субтитртэй болгохын төлөө ажилладаг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нэгдсэн байгууллага болох Киноны текстэн тайлбарын эвсэлтэй хамтран ажиллах;
- Сонсголтой болон сонсголгүй хүмүүсийн хоорондын харилцааг дэмжих зорилгоор утасны товчлуураар шивж харилцах телефон релейн системийг ашиглахыг эсэргүүцсэн компаниудын эсрэг шүүхэд гомдол гаргах;
- Өргөн нэвтрүүлгийн болон шуурхай мэдээ түгээдэг байгууллагууд мэдээллээ сонсголгүй болон сонсголын бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгох нөлөөллийн үйл ажиллагаа явуулах;
- Сонсголгүй хүүхдүүдэд дохионы хэл сурах боломж олгох, тэдний эцэг эхчүүдэд хандсан хүүхдэдээ дэмжлэг үзүүлэх талаар (эх эцэг нь сонсголтой бол тэднийг дохионы хэлний курст хамруулах) нөлөөллийн кампанит ажил явуулах<sup>8</sup>

**ДАСГАЛ 4.4: Үзэл бодолтой байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжих амлалт авах нь**

Хүний эрх гэдэг нь эдлэх эрх болон үүргийн нэгдэл гэдгийг тайлбарла.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний талаарх мэдлэгээ нэмэгдүүлсний дараа оролцогчид тодорхой үйл ажиллагаа хийхэд хэр бэлэн болсныг асуу
- Мэдээлэл цуглуулах, ажлаа төлөвлөх гээд хийх зүйл их байгаа ч өөрчлөлт хийх чин эрмэлзэл маш чухал гэдгийг тэмдэглэн хэл.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрхээ бүрэн эдлэхэд нь нэмэр болох жижиг ч хамаагүй ямар ажлыг ирэх сард хийхийг хүсэж байгаа, хийх боломжтой байгааг оролцогч бүрээр хэлүүл.

8 Сонсголгүй хүмүүсийн үндэсний нийгэмлэг: <http://www.nad.org>

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах нөлөөллийн ажил хэрхэн төлөвлөх талаар “Хэсэг 3. Нөлөөлөл! Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа” (хуудас 278) хэсгээс уншина уу.

ҮЗЭЛ БОДОЛТОЙ БАЙХ, ҮГ ХЭЛЭХ, ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ  
НЭМЭЛТ МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

- Америкийн хараагүйчүүдийн зөвлөл, хараагүй болон харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан мэдээлэл:  
<http://www.acb.org/resources/index.html>
- Хүний эрхийн хорооны Ерөнхий зөвлөмж, Дугаар 10:  
<http://www1.umn.edu/humanrts/gencomm/hrcom10.htm>
- Inclusion Daily Express сонин:  
[www.inclusiondaily.com/archives/04/09/15/091504sacourtaccess.htm](http://www.inclusiondaily.com/archives/04/09/15/091504sacourtaccess.htm)
- Хүртээмжтэй мэдээлэл, харилцаа холбооны технологийн талаарх Манилын Тунхаглал:  
<http://www.un.org/esa/socdev/enable/maniladecl.htm>
- Сонсголгүй хүмүүсийн үндэсний нийгэмлэг:  
<http://www.nad.org>
- Энгийн хэлний олон улсын нийгэмлэг (PLAIN):  
<http://www.plainlanguagenetwork.org>
- НҮБ-ын Нийгэм, эдийн засгийн хэлтэс (DESA)-ийн глобаль аудитын вебсайт:  
<http://www.un.org/esa/socdev/enable/gawanomensa.htm>
- НҮБ-ын “Вебийн хүртээмжийн талаарх глобаль аудит. Тайлангийн хураангуй” (2006):  
<http://www.un.org/esa/socdev/enable/documents/execsumnomensa.doc>
- Мэргэжлийн болон нөхөн сэргээлтийн судалгааны хүрээлэн (VRRRI):  
<http://www.vrrri.or>
- W3C Вебийг хүртээмжийн нэмэгдүүлэх санаачилга – вебийг хүртээмжтэй болгоход чиглэсэн бодлогууд  
<http://www.w3.org/WAI/Policy>

## БҮЛЭГ 5. АМЬД ЯВАХ ЭРХ БОЛОН ЭРСДЭЛТ НӨХЦӨЛД ХАМГААЛУУЛАХ ЭРХ

### НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци

#### 10 дугаар зүйл. Амьд явах эрх:

Оролцогч улсууд нь хүн бүр амьд явах салшгүй эрхтэй гэдгийг дахин нотолж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдын нэгэн адил энэ эрхээ бүрэн дүүрэн эдлэх явдлыг хангах талаар шаардлагатай бүх арга хэмжээ авна.

#### 11 дүгээр зүйл. Хүмүүнлэгийн гамшиг болон эрсдэл бүхий нөхцөл байдал

Оролцогч улсууд олон улсын хүмүүнлэгийн эрхзүй, олон улсын хүний эрхийн хэм хэмжээг оролцуулан олон улсын эрхзүйгээр хүлээлгэсэн үүрэгтэй нийцүүлэн эрсдэл бүхий байдал, тухайлбал зэвсэгт мөргөлдөөн, хүмүүнлэгийн гамшиг, байгалийн аюул гамшиг тохиолдсон үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалах, аюулгүй байдлыг нь хангахад чиглэсэн шаардлагатай бүхий л арга хэмжээг авна.

### ЗОРИЛТУУД

Энэ бүлгийн мэдээлэл, дасгалууд нь оролцогчдыг дараах зорилтуудад хүрэхэд тусална:

- Амьд явах эрхийг тодорхойлох
- Хүмүүнлэгийн яаралтай тусламж шаардсан болон эрсдэлт нөхцөл байдалд хамгаалуулах эрхийг тодорхойлох
- Амьд явах эрх, хүмүүнлэгийн яаралтай тусламж шаардсан болон эрсдэлт нөхцөлд хамгаалуулах эрх нь хүний бусад эрхтэй холбоотойг ойлгох
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьд явах эрх, хүмүүнлэгийн яаралтай тусламж шаардсан болон эрсдэлт нөхцөл байдалд хамгаалуулах эрхийг хангаж чадсан, эсвэл зөрчиж байгааг ялган тодорхойлох
- Амьд явах эрх, хүмүүнлэгийн яаралтай тусламж шаардсан болон эрсдэлт нөхцөл байдалд хамгаалуулах эрхийн талаарх НҮБ-ын **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн** (ХБХЭК) заалтыг тайлбарлах.

**Бидний амьдрал бусдынхаас доогуур үнэ цэнэтэй гэж үздэг нийгмийн үзэлтэй байнга тулгарч байдаг над шиг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьд явах эрхийн тухай хуулийн заалт нь бидний үхэх, сэхэхийг тодорхойлдог. Тийм ч учраас энэ заалтыг боловсруулахад оролцох нь амин чухал ач холбогдолтой байлаа.**

— Их Британий хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалагч Жейн Кампбеллийн Их Британий Хүний эрхийн хуулинд амьд явах эрхийн тухай заалтыг оруулах хэлэлцүүлэг дээр тавьсан илтгэлээс

## ЭХЛЭЛ: АМЬД ЯВАХ БОЛОН ЭРСДЭЛТ НӨХЦӨЛД ХАМГААЛУУЛАХ ЭРХИЙН ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЭХ НЬ

Хөгжлийн бэрхшээл болон амьд явах эрх нь хоорондоо салшгүй холбоотой. Байгалийн гамшиг, зэвсэгт мөргөлдөөн, хүмүүнлэгийн хямрал зэрэг олон нөхцөлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьд явах эрх, хамгаалуулах эрх зөрчигдөх явдал их гардаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьд явах эрхэд шууд заналхийлж мэдэх соёлын зан үйлүүд ч байдаг. Эрэгтэй хүүхдийг илүүд үздэг ядуу буурай оронд хөгжлийн бэрхшээлтэй охидод хоол тэжээл, эмнэлгийн тусламж хүрэхгүй байх явдал гардаг. Зарим газарт хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидыг бэлэвсэрснээс болж бусад эмэгтэйчүүдийн нэгэн адил шатаах, инжний аллагын золиос болгодог соёлын зан үйл арилаагүй л байна. Эмэгтэйчүүд, охидын бэлэг эрхтнийг эрэмдэглэх заншлаас болж эмэгтэйчүүд цус алдан нас барах, хожим хүүхэд төрүүлэхдээ амь эрсдэх явдал гардаг.

Өөр бусад зан үйл ч мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьд явах эрхийг зөрчдөг. Жишээлбэл, олон оронд энэрлийн аллага (эвтаназия) нь хөгжлийн бэрхшээлтэй нярайн амийг аврах эмчилгээ хийхгүй байлгасаар эндүүлэх хэлбэрээр илэрч байна. “Ийм амьдралаар амьдрах хэрэггүй” гэж дур мэдэн тодорхойлсон эмнэлгийн ажилтнуудын гар дээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрэгчид амьсгал хураасан тохиолдлуудыг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд илрүүлсээр байна. Эдгээр тохиолдлын дотор “сэхээх эмчилгээ хийлгэхгүй” гэсэн зааврыг албан шахалтаар гаргуулан авч, өвчний түүхэнд нь бичсэн хэд хэдэн явдал багтдаг (дараах өгүүллэгийг унш). “Сэхээх эмчилгээ хийлгэхгүй” гэсэн заавар нь өвчтөний уушиг, зүрх зогсох тохиолдолд эмнэлгийн аппарат, хиймэл амьсгалаар зүрх, уушигны үйл ажиллагааг сэргээх арга хэмжээ авахыг өвчтөн өөрөө хүсэхгүй байгааг илэрхийлсэн гэрээслэл юм.

## Амьд явах эрхээ эдлэхэд учрах саад, бэрхшээл

- Хөгжлийн бэрхшээлтэй л бол “амьдрах хэрэггүй” гэсэн үзэл
- Асрамжийн газруудад гардаг аминд аюултай нөхцлүүд
- Бэлэвсэрсэн эмэгтэйг шатаах, инжний золиос болгож амь насыг нь бүрэлгэх, эмэгтэйчүүдийн бэлэг эрхтнийг эрэмдэглэх зэрэг аюулт зан уламжлал
- Хөгжлийн бэрхшээлтэй гэсэн үндэслэлээр жирэмслэлтийг таслах
- Хөгжлийн бэрхшээлтэй нярайг үл асрамжлах, үхүүлэх
- “Сэхээх эмчилгээ хийлгэхгүй” гэсэн зааварчилгаа хүчээр тулгах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст сэхээн амьдруулах эмчилгээ хийхгүй байх
- Гэр бүлийн хүчирхийлэл, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийлэл
- Байгалийн гамшиг, онцгой байдалд, мөн дүрвэгсэд болон дотоодын шилжин суурьшигчдад зориулсан хөтөлбөр болон бусад хүмүүнлэгийн хөтөлбөрүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг орхигдуулах
- Хоол, хүнс, ундны цэвэр ус, орогнох байр зэрэг наад захын хэрэглээ хүрэлцээгүй байх

Эмчийн тусламжтайгаар амиа егүүтгэх явдал нь хүний амьд явах эрхийг зөрчиж байна гэж хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалагчид үзэн, эсэргүүцлээ илэрхийлж байжээ. Тэдний санааг зовоодог бусад тохиолдлуудын дотор хөгжлийн бэрхшээлтэй гэсэн үндэслэлээр жирэмслэлтийг таслах явдал багтдаг. Хөгжиж буй улс орнуудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эндэгдэл хамаагүй өндөр үзүүлэлттэй байдаг нь эдгээр хүүхдүүд зохих эмнэлгийн тусламж, түүний дотор бага насны хүүхдэд тусдаг халдварт өвчнөөс хамгаалах дархаажуулалтын үйлчилгээ авч чаддаггүйтэй холбоотой. Эмнэлгийн ажилтнууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралын чанарыг доогуур үнэлж ханддагийн улмаас өөр өвчтөнд хийдэг амь аврах, амьдрал залгуулах эмчилгээг хийхгүй байх явдал цөөнгүй тохиолддог.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьд явах эрх нь тэдний бусад эрхтэй нягт холбоотой. Жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэндийн үйлчилгээ, сэхээн амьдруулах эмчилгээ хүртээмжгүй бол түүний амьд явах эрх мөн зөрчигдөнө. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг аюултай нөхцөлд ажиллуулах, албадан хөдөлмөр эрхлүүлэх нь тэдний амь насанд аюул занал учруулж мэднэ.

Мэдээлэл хүртэх эрх нь хүний эрхээ эдлэхийн өөр нэгэн угтвар нөхцөл, зарим тохиолдолд амьд явах эрхээ эдлэхтэй шууд холбоотой нөхцөл болдог. Жишээлбэл, албан тушаалтнууд чухал мэдээллийг (ХДХВ/ДОХ-оос сэргийлэх хөтөлбөр, байгалийн гамшгийн үед яаралтай нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний заавар, журам) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй хэлбэрээр хүргээгүйн улмаас тэдний амьд явах эрх ноцтой зөрчигдөх нөхцөл үүсэж болох юм. Хүний эрхүүд **нэгдмэл, уялдаа холбоотой, харилцан хамааралтай** болохыг эдгээр жишээ харуулж байна. Амьд явах эрхийг хүндлээгүй нөхцөлд бусад бүх эрхийн утга учир алдагдах нь тодорхой.



## “Сэхээх эмчилгээ хийлгэхгүй” зааварчилгааг хэрэглэх дүрэм

“Сэхээх эмчилгээ хийлгэхгүй” гэсэн зааварчилгааг ашиглахдаа хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх зөрчигдөхөөс сэргийлж Бритиш Колумбиа мужийн “Хамтын амьдралын нийгэмлэг”-ээс дараах зааврыг боловсруулан гаргажээ.

- Хөгжлийн бэрхшээл бол эмчилгээгүй өвчин биш.
- Аливаа хүн амьдралынхаа эцсийн шатанд орсон эсэхээ хөгжлийн бэрхшээлээс үл хамааруулан өөрөө гаргах ёстой.
- Амьдралынхаа эцсийн шатанд орсон аливаа хүн асрамж, арчилгаа хүртэх эрхтэй ба үүнд юуны өмнө өвчин намдаах эмчилгээ багтана.
- “Сэхээх эмчилгээ хийлгэхгүй” гэсэн зааварчилгааг зөвхөн өвчний эцсийн шатанд эргэлтгүй орсон, эсвэл сэхээх эмчилгээ нь уг хүнд ноцтой гэм болохуйц үед л гаргах ёстой.
- Эмч нар “сэхээх эмчилгээ хийлгэхгүй” гэсэн зааврыг өвчний түүхэнд бичихийн өмнө өвчтөнөөс өөрөөс нь, эсвэл түүний өмнөөс шийдвэр гаргах эрх бүхий хүнээс зөвшөөрөл авах ёстой.
- Эмчилж болох өвчиндөө эмчилгээ хийлгэж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүн сэхээх эмчилгээ хийлгэх эрхтэй бөгөөд хийхгүй байх ганцхан нөхцөл бол ийм эмчилгээ нь өвчтөнд ноцтой гэм учруулах тохиолдол болно<sup>1</sup>.

### ДАСГАЛ 5.1: Амь насанд заналхийлсэн аюул

<b>Зорилт:</b>	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьд явах эрхэд заналхийлдэг аюулуудыг ойлгох
<b>Хугацаа:</b>	30 минут
<b>Хэрэглэгдэхүүн:</b>	Том цаас, фломастер эсвэл самбар, шохой.

#### 1. Танилцуулах

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хөгжлийн бэрхшээлээс нь биш харин хөгжлийн бэрхшээлтэй байдлаас нь улбаалсан олон аюул занал учирдаг. Эдгээрийн дотор асрамжийн газарт амьдрах, эмнэлгийн мэргэжилтнүүдийн гаргах шийдвэр, нийгмийн үзэл хандлага, энэрэнгүйн үзлийн улмаас үхүүлэх бодлого зэрэг багтдаг. Ядуурлын зэрэгцээ байгалийн гамшиг, зэвсэгт мөргөлдөөн зэрэг нөхцөл нь тэдний амьдралын чанар, эрүүл мэндэд аюул учруулж мэдэхийг оролцогчдод тайлбарла.

#### 2. Хэлэлцэх

Оролцогчдыг хосоор нь баг болгоод дараах даалгаврыг өг:

- Амьдрал аюултай нөхцөл тэдэнд өөрсдөд нь юмуу орчин тойронд нь амьдарч байгаа өөр хүмүүст тохиолдож байсан тухай жишээ гаргаж, хэлэлцэх

1 “Сэхээх эмчилгээ хийлгэхгүй” зааварчилгааны талаарх бодлого.Хамтын амьдралын төлөөх Бритиш Колумбийн холбоо [www.bcaccl.org/index.cfm?act=main?call=788F8794](http://www.bcaccl.org/index.cfm?act=main?call=788F8794)



- Хөгжлийн бэрхшээлтэй хүний амь нас эрсдэх аюулын учир шалтгааныг тайлбарлахыг оролд
- “Амьд явах эрхээ эдлэхэд учрах саад, бэрхшээл” гарчигтай мэдээлэл (дээр бичсэний үз), эсвэл оролцогчдын гаргаж ирсэн жагсаалтыг ашигла.

### 3. Илтгэх/Шинжлэх

Баг болгон тодорхойлон гаргасан шалтгаануудаа нийтэд мэдээлэх даалгавар өг.

Шалтгааныг нэрлэх явцад самбар/цаасан дээр жагсаалт болгож бич.

- Багуудын нэрлэсэн шалтгаануудыг бүлэглэх боломжтой эсэхийг оролцогчдоос асуу (жишээлбэл, ядуурал болон нийгэм соёлын хандлагаас үүдэлтэй, эмчийн шийдвэр юмуу төрийн бодлоготой холбоотой гэх мэтээр).
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалж эдгээр шалтгаан үүсэхээс сэргийлэхийн тулд ямар арга хэмжээ авч болох вэ? Амь насанд заналхийлсэн нөхцөл үүсэхээс сэргийлэхийн тулд юу хийж болох вэ? Үүнд тус болох нөлөөллийн ямар стратегиуд байж болох вэ?

АМЬД ЯВАХ ЭРХ БОЛОН ЭРСДЭЛТ НӨХЦӨЛД ХАМГААЛУУЛАХ ЭРХИЙН ТАЛААР ХҮНИЙ ЭРХИЙН ЭРХЗҮЙД ЮУ ГЭЖ ЗААСАН БАЙДАГ ВЭ?

Амьд явах эрх бол хүний бүх эрхийн дотроос хамгийн чухал суурь эрх юм. “Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй”<sup>2</sup> гэж **Хүний эрхийн түгээмэл тунхаглалын (ХЭТТ)** 3 дугаар зүйлд заасан байдаг. **Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИУТЭОУП)**-ын 6(1) дугаар зүйлд:

*Амьд явах эрх бол хүн бүрийн салшгүй эрх мөн. Энэ эрхийг хуулиар хамгаална. Хэний ч амийг дур мэдэн бүрэлгэж болохгүй<sup>3</sup> гэжээ.*

Гэвч амьд явах эрх нь туйлын ойлголт биш юм. Олон улсын хүмүүнлэгийн эрхзүйн хүрээнд болж буй зөвшөөрөгдсөн байлдааны ажиллагааны үед байлдагч амь эрсэдсэн тохиолдол нь амьд явах эрхийн зөрчил болохгүй. Зайлшгүй хамгаалалт хэрэглэсэн зэрэг зарим хязгаарлагдмал нөхцөлд хууль сахиулагч этгээд хүний аминд хүрч болно. Зарим улсын эрхзүйд онц ноцтой гэмт хэрэгт ялын дээд хэмжээ оноодог ба үүнийг хэдийгээр ИУТЭОУП хүлээн зөвшөөрдөг ч зөвхөн ийм арга хэмжээг хуульчилсан орнуудад хэрэглэхээр хязгаарлажээ.

Олон улсын эрхзүйгээр баталгаажсан хүний амьд явах эрхийг хүлээн зөвшөөрсөн улс орнууд олон үүрэг хүлээдэг. НҮБ-ын тунхаг бичгийн дагуу өөрийгөө хамгаалахаас бусад тохиолдолд нэг улс нөгөөгийнхөө эсрэг хүч хэрэглэх, хэрэглэхээр заналхийлэхийг хориглоно гэсэн байдаг.<sup>4</sup> ИУТЭОУП-ийн биелэлтийг хянадаг **Хүний эрхийн хорооноос** гаргасан Ерөнхий зөвлөмж №6-д “Хүний амь алдахад хүргэх дайн, геноцид, үйл олноор

2 <http://www.unhchr.ch/udhr/lang/eng.htm> сайтаас үз.

3 <http://www.ochcr.org/english/law/ccpr-one.htm> сайтаас үз.

4 <http://www.un.org.aboututn/charter> сайтаас үз.

хүний амь бүрэлгэх бусад үйлдлээс сэргийлэх нь Улс орнуудын дээд үүрэг болно”<sup>5</sup> гэсэн байдаг. Улс орнуудын хүлээсэн үүргийн дотор дайнаас сэргийлэх, олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хамгаалахад чиглэсэн бүхий л арга хэмжээ багтана. Энэ бол хүний амьд явах эрхийг хамгаалах хамгийн чухал баталгаа юм. **Оон улсын хүмүүнлэгийн эрхзүйгээр** дайн, онц байдлын үеэр улс орнууд хүний амьд явах эрхийг хязгаарлах эрхгүй бөгөөд ийм нөхцөл үүссэн тохиолдолд Оролцогч улсууд энгийн иргэдийг хамгаалах, аюулгүй байдлыг нь хангах үүрэгтэй.

Улс орнууд мөн хүний амийг санаатайгаар хөнөөх үйлдлээс түдгэлзэх үүрэгтэй. **Хүний эрхийн хороо** хөгжлийн бэрхшээлтэй нярай хүүхдийг эмч нар албаар эндүүлж байгаа явдлыг буруушаагаад “эмнэлгийн мэргэжилтнүүд хөгжлийн бэрхшээлтэй нярайн амийг тасалж байгаа тухай тайлан, мэдээллийг хүлээж аваад ихэд эмзэглэж”<sup>6</sup> буйгаа илэрхийлсэн байна. **Хүүхдийн эрхийн хороо** Улс орнуудыг “...хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сөргөөр нөлөөлж буй конвенцид үл нийцэх хуулиудаа эргэн харж, өөрчлөхийг”<sup>7</sup> уриалаад, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бусдын адил амьд явах, амиа авруулах, хөгжих эрхийг түдгэлзүүлсэн хуулиуд, ялангуяа үр хөндөлтийг хуулиар зөвшөөрсөн улс орнуудын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхэд нөлөөлөх ялгавартай үр хөндөлтийн тухай болон эрүүл мэндийн үйлчилгээг ялгавартай хүртээх тухай зэрэг заалтуудыг эн тэргүүнд өөрчлөхийг уриалжээ.

Хүний эрхийн хорооны үзэж байгаагаар хүний амьд явах эрхийг хамгаална гэдэг нь хүний амийг хамгаалахад чиглэсэн идэвхтэй арга хэмжээ авахыг хэлж байгаа ажээ. Эдгээр арга хэмжээнд хүний наслалтыг нэмэгдүүлэх, хүүхэд, нярайн эндэгдлийг бууруулах, өвчинтэй тэмцэх, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, хоол хүнс, ундны ус, орон байрны хүртээмжийг хангалттай хэмжээнд хүргэх зэрэг арга хэмжээ орно. **НҮБ-ын Стандарт дүрмүүдийн 2.3-т** заасны дагуу “Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй нярай болон хүүхдүүд нийгмийн бусад гишүүдтэй ижил хэмжээнд эрүүл мэндийн үйлчилгээ хүртэж байхад анхаарах ёстой”<sup>8</sup> гэжээ.

ХБХЭК нь ч мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгардаг дээрх асуудлуудыг тусгажээ. Тухайлбал, 10 дугаар зүйлд амьд явах эрх нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн салшгүй эрх мөн болохыг дурьдаад, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэрхүү эрхээ бусад хүмүүсийн адил тэгш эдлэх боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн “бүх арга хэмжээг” Улс орнууд авах ёстой гэж нэмж заажээ. ХБХЭК-ийн 11 дүгээр зүйлд Оролцогч улсууд “зэвсэгт мөргөлдөөн, хүмүүнлэгийн гамшиг, байгалийн гамшиг тохиолдсон үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалах, аюулгүй байдлыг нь хангахад чиглэсэн шаардлагатай бүхий л арга хэмжээг авна” гэжээ. Дайн, үй олныг хамарсан хүчирхийлэлд жил бүр олон мянган гэмгүй хүн амиа алдсаар байгаа өнөө үед 10, 11 дүгээр зүйл нь хоорондоо нягт уялдаатай заалтууд юм.

Дүгнэж хэлэхэд, Улс орнууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьд явах эрх, эрсдэлтэй нөхцөлд хамгаалуулах эрхийг **хүндэтгэх, хамгаалах, хангах** үүрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьд явах, хамгаалуулах эрхийг **хүндэтгэнэ** гэдэг нь тэдний амьд явах эрхийг төрөөс шууд буюу шууд бусаар хязгаарлахгүй, хохироохгүй байна гэсэн үг юм.

5 <http://www.umn.edi/humanrts/gencomm/hrcom6.htm> сайтаас үз.

6 Нидерландын Хүний эрхийн хорооны ажиглалтын дүгнэлт. НҮБ-ын баримт бичиг. CCPR/CO/72

7 <http://www.unhchr.ch/html/menu2/6/crc/doc/days/disabled/pdf> сайтаас үз..

8 <http://www.ochcr.org/english.law/opportunities.htm> сайтаас үз.

Улс орнууд хүмүүнлэгийн хямралын үед ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн энэ эрхийг хязгаарлах алагчласан бодлого, үйл ажиллагаа явуулахаас татгалзах ёстой.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьд явах, хамгаалуулах эрхийг *хамгаална* гэдэг нь төрийн албан хаагч болон гуравдагч этгээдийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амь насанд аюул учруулахаас сэргийлсэн хууль, захиргааны болон бусад арга хэмжээ авахыг хэлнэ. Үүнд, жишээлбэл, төрийн болон хувийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүргэж байгаа орчин, нөхцөлд тогтмол хяналт тавих ажлууд багтана. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг асрамжийн газраас гаргаж, нийгэм дунд амьдрахад нь шаардлагатай дэмжлэг туслалцаа хангаж өгөх нь тэдний эрхийг хамгаалж буй тодорхой ажил юм. Гамшиг, хямралд бэлэн байх төлөвлөгөөг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцуулан боловсруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй бөгөөд тохиромжтой арга хэлбэрийн үйлчилгээ, аврах болон дүрвэгсдэд туслах арга хэмжээ мөн багтана.

*Хэрэгжүүлэх* үүрэг гэдэг нь Оролцогч улсууд амьд явах эрх, хүмүүнлэгийн хямралын үед хамгаалуулах эрхийг тэгш эдлэх боломжийг хангахад чиглэсэн нааштай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг хэлнэ. Үүнд, жишээлбэл, хөгжлийн бэрхшээл эдлэн амьдрах хэрэггүй гэсэн нийгэмд тогтсон буруу үзэл бодлыг няцаах мэдээллийн кампанит ажил хэрэгжүүлэх, гамшгийн үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст туслах тусгай аврагчдыг сурган бэлтгэх зэрэг орно.

## **ДАСГАЛ 5.2: Амьд явах, эрсдэлт нөхцөлд хамгаалуулах эрхийн талаар ХБХЭК-д юу гэж заасан бэ?**

**Зорилт:** 10, 11 дүгээр зүйлийг судалж ойлгох  
**Хугацаа:** 30 минут  
**Хэрэглэгдэхүүн:** Том цаас, фломастер эсвэл самбар, шохой

### **1. Бататгах**

Оролцогчдыг жижиг багуудад хуваагаад 10 эсвэл 11 дүгээр зүйлийг уншиж танилцаад, утгыг энгийн, ойлгомжтой үг хэллэгээр найруулан тайлбарлаж, тэрхүү эрхийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хэрхэн эдлэх, энэ нь тэдний амьдралыг хэрхэн өөрчилж болохыг харуулсан жишээ гаргах даалгавар өг.

### **2. Энгийн үг хэлээгээр өөрчлөн найруулах/Жишээ гаргах**

10, эсвэл 11 дүгээр зүйлийг чанга уншаад энгийн үг хэллэгээр өөрчлөн найруулснаа танилцуул. Бүгд санал нэгтэй зөвшөөрсөн найруулга гарч иртэл хэлэлцүүлгээ үргэлжүүл. Ялангуяа дараах зүйлсэд анхаарах хэрэгтэй:

- “төрөлхийн” буюу “салшгүй” гэдэг нь юу гэсэн үг вэ?
- “шаардлагатай арга хэмжээ” гэж юуг хэлж байна вэ?
- Хэлэлцүүлэгтээ бодит амьдрал дээр тохиолдсон зэвсэгт мөргөлдөөн, хүмүүнлэгийн хямрал, онц байдал, байгалийн гамшгийн жишээг ашигла.

Эцсийн найруулгыг том цаасан дээр бичээд бүгдэд харагдахуйц газар хад.

Хэлэлцсэн хэсэг болгоны дараа тухайн эрхийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хэрхэн эдлэх, энэ нь тэдний амьдралд ямар өөрчлөлт авчрах талаар ярилц. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьд явах эрх, эрсдэлт нөхцөлд хамгаалуулах эрхийг хэрэгжүүлэхийн тулд төрөөс ямар “шаардлагатай арга хэмжээ” авч болох вэ? Оролцогчдод аль болох дэлгэрэнгүй тодорхой ярихыг зөвлө.

### 3. Хэлэлцэх

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах асуудлыг үндэсний хэмжээний бодлогын асуудал болгож тавих, мөн улс төрийн нам, шийдвэр гаргагчдад өргөн барих үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулахад ХБХЭК-ийн 10, 11 дүгээр зүйлийг хөгжлийн бэрхшээлийн талаар үндэсний бодлого, улс төрийн намууд болон шийдвэр гаргагчдад өргөн барих зөвлөмжинд хэрхэн ашиглаж болох вэ? Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд нь амьд явах, хамгаалуулах эрхийг хамгаалах зорилготой нөлөөллийн үйл ажиллагаагаа ямар албан тушаалтан, байгууллагуудад (Эрүүл мэндийн яам, онцгой байдлын комисс, хүмүүнлэгийн байгууллагууд, НҮБ-ын Дүрвэгсдийн ерөнхий хороо зэрэг) чиглүүлэх вэ?

#### АСРАМЖИЙН ГАЗАРТ БАЙГАА ХҮМҮҮСИЙН АМЬ НАСАНД НҮҮРЛЭХ АЮУЛ

Асрамжийн газар амьдардаг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьд явах болон бусад эрх зөрчигдөх магадлал өндөр байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэмд бусад хүмүүсийн дунд амьдруулахын оронд нүсэр асрамжийн газарт байлгаж байгаа нь нийгмээс тусгаарлаж, эрүүл мэндийн байдлыг нь тогтмол хянах боломжоос холдуулсан хэрэг юм. Сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах олон улсын байгууллага (СБХЭХОУБ)-ын судалгаагаар шаардлага хангахгүй, аюултай нөхцөлтэй асрамжийн газар амьдардаг сэтгэц-нийгмийн бэрхшээлтэй насанд хүрсэн хүмүүс, хүүхдүүдийн эрх бүдүүлгээр зөрчигдөж байгаа тохиолдуудыг баримтжуулжээ. Асрамжийн газруудад эрүүл ахуйн шаардлага хангаагүй орчинд амьдруулах, хүний биеийн хөдөлгөөнийг шаардлагагүйгээр хэтрүүлэн хорих, хоол, унд, хувцас, эмнэлгийн үйлчилгээ дутаах явдал, тэр ч бүү хэл хүн осгож үхсэн тохиолдол гарч байсныг СБХЭХОУБ-ын тайланд дурьджээ. Асрамжийн газарт амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст өөр аюул ч нүүрэлдэг. Гамшиг, ослын үед асрамжийн газрын захиргаа дутуу, буруу ажилласнаас олон хүний амь эрсэддэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг зүгээр л орхиод явах нь элбэг байдгийг ОХУ-д гарсан саяхны тохиолдлууд, АНУ-д болсон Катрина, Рита хар шуурганы үеэр болсон үйл явдлууд гэрчилж байна (өгүүллэгийг унш). СБХЭХОУБ, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бусад байгууллага ийм асрамжийн газруудыг хааж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бие даалган, зохих дэмжлэгтэйгээр нийгэм дунд амьдруулах чиглэлээр нөлөөллийн ажил хэрэгжүүлж байна. (Мөн “Бүлэг 6. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрийн хүчирхийллээс ангид байх эрх, эрх чөлөө” бүлгийг хуудас 96-гаас уншина уу).

## Минесота мужийн асрамжийн газар амь үрэгдсэн хүмүүсийн дурсгалд

### “Нэр төртэйгөөр эргэн дурсахуй” кампанит ажил

**Нэр төртэйгөөр эргэн дурсахуй** байгууллага нь Минесота мужийн асрамжийн газарт амьдарч байгаад нас барсан хүмүүсийн дурсгалыг мөнхжүүлэх зорилгоор 1994 онд байгуулагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах болон нөлөөлөл үзүүлэх байгууллагуудын эвсэл юм. Энэхүү кампанит ажлын гол зорилго нь:

- Асрамжийн газрын оршуулгын газарт нэргүй оршуулагдсан 12500 хүний нэрийг сэргээх. Ямар ч тэмдэггүй, эсвэл зөвхөн цементэн дээр дугаарлаад орхисон булшнууд дээр нэр, төрсөн болон нас барсан өдрийг тэмдэглэх
- Хөгжлийн бэрхшээлтэй, ялангуяа уг асрамжийн газар амьдарч байсан хүмүүсийн аман дурсамжийг тэмдэглэж авч, цуглуулах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй хамтран ажиллаж нийгэмд нь буцааж оруулах, дахин асрамжийн газарт амьдруулахгүй байх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх
- Минесота мужийн захиргаанаас эдгээр хүнээс уучлал гуйхыг шаардах

### Кампанит ажлын үр дүн

- Буяны газар, ерөнхий прокурорын газар, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хуулийн товчоо, Фарибо дах мужийн бүсийн төвтэй хамтран Фарибо оршуулгын газар оршуулагдсан хүмүүсийн нэрсийн жагсаалтыг гаргуулсан.
- Одоо хаагдсан Фарибо эмнэлгийн дэргэдэх оршуулгын газарт нэргүй оршуулсан хүмүүсийн нэрийн жагсаалтыг бүрдүүлсэн.
- 1997-2005 онд мужийн хууль тогтоох байгууллага 12500 нэргүй булшийн нэрийг сэргээх ажилд 725000 ам. доллар зарцуулахаар төсөвлөсөн
- Мужийн хуучин эмнэлгүүдийн дэргэдэх оршуулгын газарт байсан 2500 булш дээр нэр бүхий чулуу босгосон.
- Кембридж дах оршуулгын газрыг “Эргэн дурсах цэцэрлэг” нэртэй болгосон.
- Асрамжийн газруудад амьдарч байсан Минесота мужийн иргэдээс мужийн хууль тогтоох байгууллага албан ёсоор уучлал гуйх, асрамжийн газар амьдруулж байсан нь тэдний амьдралын чанарыг доройтуулсан хэрэг болсныг хүлээн зөвшөөрч уучлал гуйхыг мужийн захирагчид даалгасан захирамж гаргуулсан.<sup>9</sup>

9 “Нэр төртэйгөөр эргэн дурсаж, уучлал хүссэн шийдвэрийг унш”, 2005. “Өөрчлөлтийн төлөө хамтдаа” байгууллага [http://www.selfadvocacy.com/programs\\_rwd\\_apology.htm](http://www.selfadvocacy.com/programs_rwd_apology.htm)



## **ДАСГАЛ 5.3: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тусгаарлахгүй байх талаар нөлөөллийн үйл ажиллагаа хийх нь**

- Зорилт:** Асрамжийн газар амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьд явах эрхэд заналхийлэх аюулыг бууруулах стратегийн төлөвлөгөө боловсруулж, хүмүүсийг тусгаарлалгүй нийгэмд нь амьдруулахын төлөө нөлөөлөл явуулах
- Хугацаа:** 30 минут
- Хэрэглэгдэхүүн:** Том цаас, фломастер эсвэл самбар, шохой

### **1. Танилцуулах**

Олон оронд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс одоо ч төвлөрсөн асрамжийн газар амьдарч байгаа бөгөөд бусад хүмүүсээс тусгаарлахгүй нийгэмд амьдруулах зарчим ихэнх газар цоо шинэ ойлголт хэвээр байгааг тайлбарла. Америкийн СБХЭХОУБ болон Унгарын Сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах нөлөөллийн төв зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд асрамжийн газруудад гардаг зөрчлүүдийг ил гаргаж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмээс тусгаарлахгүй байхыг сурталчлан нөлөөлөл явуулж байна.

### **2. Хэлэлцэх**

Оролцогчдыг хос хосоор нь баг болгоод дараах даалгаварыг өг:

- Оролцогчдын амьдарч буй орон нутаг/улс/бүс нутагт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нийгэмдээ тусгаарлагдахгүй амьдрах боломжийг хангаж өгөхгүй байгааг харуулсан жишээ гаргах;
- Асрамжийн газар амьдардаг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд тулгарах аюулыг нэрлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмээс тусгаарлалгүй бусад хүмүүсийн дунд амьдруулахад ямар саад тулгарч байгааг нэрлэх.

### **3. Илтгэх/Шинжлэх**

Багууд, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмээс тусгаарлаж байгааг харуулсан жишээ, тэдний амьд явах эрхэд нөлөөлөх аюул, тусгаарлагдахгүй амьдрахад учирч байгаа саад зэргийг хэрхэн тодорхойлсноо уншиж өгөөд, самбар дээр жагсааж бичнэ.

- Эдгээр асуудлыг шийдэж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьд явах эрхийг хамгаалахын тулд ямар арга хэмжээ авах ёстой талаар ярилц.
- Ямар төрлийн нөлөөлөл илүү үр дүнтэй байх вэ (жишээлбэл, иргэний боловсрол, олон нийтийн хэлэлцүүлэг, зөрчлийг баримтжуулсан тайлан, мэдээллийн хэрэгслээр кампанит ажил хийх, шүүхэд хандах гэх мэт)?
- Арга хэмжээ авахын тулд мэдээллийг хэнд хүргэх хэрэгтэй вэ?



## ОХУ-д гарсан галын аюулаас хүмүүсийг хамгаалж чадаагүй тохиолдол

Орост жил бүр 18000 хүн галд амь насаа алддаг. Бусад улстай харьцуулахад энэ нь хэд дахин өндөр тоо юм. Осолд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хамгийн ихээр өртдөг. Жишээлбэл, ОХУ-д 12 дугаар сарын гуравхан өдрийн дотор гарсан явдлуудыг тоочвол:

- 12 сарын 9-нд Москвагийн өмнөд хэсэгт орших наркологийн нөхөн сэргээх асрамжийн газарт гарсан гал түймрийн үеэр 46 эмэгтэй амь үрэгджээ. Бүх хаалга нь цоожтой, цонхнуудаа торлосон тул хүмүүс галаас зугтаж чадаагүй тухай гэрчүүд ярьж байна.
- 12 сарын 11-нд Сибирийн Тайга хотын сэтгэл мэдрэлийн эмнэлэгт гарсан гал түймэрт 8 хүн амиа алдсан.
- 12 сарын 11-нд сэтгэцийн бэрхшээлтэй хүүхдүүдийн асрамжийн газарт түймэр гарсан бөгөөд азаар нэг ч хүүхэд ноцтой гэмтэл аваагүй байна.<sup>10</sup>

## АРИУН ҮР УДМЫН ҮЗЭЛ БОЛОН НАЦИСТУУДЫН ХҮЙС ТЭМТРЭЛ

Дэлхийн ихэнх улс оронд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдаас ялгаатайгаасаа болоод алагчлагдан, гадуурхагдаж байсан түүх байдаг ч 19 дүгээр зууны эцсээр Америк, Европт газар авсан **ариун үр удмын үзэл буюу эвгеникийн** үзлийн нөлөөгөөр тэднийг хүчирхийллийн бай болгох, эцэстээ нацист Германд үй олноор нь хүйс тэмтрэх явдалд хүргэж байлаа. Евгеник үзлийг баримтладаг хүмүүс нийгмийн “эрүүл”, “авъяаслаг” гишүүдийн төрөлт ноцтой хэмжээнд хүртлээ огцом буурч, харин “хүсээгүй” хүмүүс өсч үржсээр байгаа талаар “сэрэмжлүүлжээ”. Нийгмийн энэхүү бусармаг явдлын хамгийн бузар жишээ нь нацистуудын явуулсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг устгах бодлого байсан бөгөөд асрамжийн газар амьдардаг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг алж устгах хөтөлбөр хүртэл хэрэгжүүлж байжээ (Энэ талаар дараах өгүүллэгээс унш). Энэ хөтөлбөрөөр эхлээд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг, дараа нь насанд хүрсэн хүмүүсийг зохион байгуулалттайгаар устгаж байжээ. Тушаалын дагуу гурваас доош настай хөгжлийн бэрхшээлтэй бүх хүүхдийг бүртгэдэг болж Дауны синдромтой, сонсголгүй, хараагүй, саажилттай, төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг бүртгэн авчээ. Зүрхэнд нь өндөр тунгаар хор тарих, удаан хугацааны туршид хордуулах, цианит болон байлдааны химийн бодисоор утах, өлбөрүүлэх, хөлдөөх зэрэг сэрдхийлгэм хэрцгий олон аргыг ашигласан байна. Сүүлийн хоёр аргыг хэрэглэсэн тохиолдолд эмч нар үхлийн шалтгааныг “хөндлөнгийн нөлөөгүй” хатгаа гэх мэт өвчнөөр нас барсан гэсэн онош хэрэглэж байжээ. Дэлхийн хоёрдугаар дайны үеэр 5000 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ийм аргаар хөнөөсөн гэсэн мэдээ бий.

10 “ОХУ: Эмнэлэгт гарсан хэд хэдэн түймрийн мөрөөр хараат бус шалгалт хийх хэрэгтэй” 2006 оны 12 дугаар сарын 12. Хөгжлийн бэрхшээлийн ертөнц. [http://www.disabilityworld.org/01\\_07/russiafires.shtml](http://www.disabilityworld.org/01_07/russiafires.shtml)

#### Т-4 ажиллагаа

1933 онд Германы Хууль зүйн яам нэгэн хуулийн төсөл өргөн барьжээ. Энэ төсөлд “жинхэнэ хүмүүнлэг ёсны үүднээс эмчлэгдэхгүй өвчтэй хүмүүсийн өөрсдийн хүсэлтээр зовлон, шаналалыг нь зогсоох” үүднээс “хүмүүнлэгээр үхүүлэх” эрхийг эмч нарт олгох тухай өгүүлжээ Хэдийгээр энэ хууль батлагдаагүй ч гол санаа нь хожим Т-4 ажиллагаа болж хэрэгжихдээ эвтаназия биш харин хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүйс тэмтрэх хэлбэрээр биелжээ.

Маш нууц энэ ажиллагаа нь улсын болон сүмийн мэдлийн сувилал, асрамжийн газарт эмчлүүлж байсан удмын шинжтэй бие махбодын, мэдэрхүйн, сэтгэцийн бэрхшээлтэй бүх хүнийг “онилжээ”. Үүнд хараагүй, сонсголгүй, саажилттай, оюуны хомсдолтой, депресстэй, хөдөлгөөний бэрхшээлтэй, төрөлхийн гажигтай хүмүүсийг багтаасан байна. Хожим энэ ажиллагаа хүрээгээ тэлж, өндөр настан болон ядуучуудад зориулсан асрамжийн газарт амьдардаг өвчтэй хүмүүс өртжээ.

Т-4 ажиллагаа нь нацистуудын алан хядах механизмын туршилт болсон юм. Эхлээд тэд золиосны хүмүүсээ тариагаар алж байсан бол удалгүй Бранденбергийн шоронд анх удаа хорт хийгээр утах өрөөг туршжээ. 1940 оны 1 дүгээр сард сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийг хорт хийгээр утаж бүрэлгэх туршилтыг хийхдээ хорт хий нь аллагын бусад аргаас давуу болохыг харуулах зорилго тавьж байжээ. Т-4 ажиллагааны хүрээнд нацистууд хийгээр хордуулах өрөөнүүдэд хуурамч шүршүүрийн толгой суулгах, усанд орох өрөө шиг засаж тусгай хавтангаар доторлох зэрэг аргыг хожим Аушвиц, Биркенау зэрэг аллага хядлагаараа “алдаршсан” аймшигт газруудад хэрэглэж байжээ.<sup>11</sup>

Сүүлийн үед евгеникийн үзэлд суурилсан бодлогыг Хойд Солонгост хэрэгжүүлж байгаа талаар хүний эрхийн байгууллагууд мэдээлж байгаа бөгөөд тэнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүнд хэцүү нөхцөлтэй хорих газруудад авчирч, эмгэгээр нь ангилж тусгаарладаг байна. Жишээлбэл, давжаа хүмүүсийг тусгай хорих газарт төвлөрүүлээд, дараа нь нутаг заан амьдруулж, гэрлэх, хүүхэд төрүүлэхийг хориглодог ажээ. Сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийг “49 дүгээр тасаг” гэгдэх тусгай хорих газруудад маш хүнд, амь насанд нь аюултай нөхцөлд хорьж байна.<sup>12</sup>

11 Лорд, Жанет Е. “Хоморголон хүйс тэмтрэх болон хүн төрөлхтөний эсрэг гэмт хэргийн эсрэг хуулийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зохицуулан хэрэглэх нь” Хоморголон хүйс тэмтрэх болон хүн төрөлхтөний эсрэг гэмт хэргийн энциклопеди (редактор Дина Л. Шелтон, АНУ-ын Макмилланы лавлагаа материалын сан, 2004).

12 “Хойд Солонгосын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хорих лагерьт амьдарч байна.” 2006 оны 11 дүгээр сарын 10. Олон улсын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага.  
<http://v1.dpi.org/lang-en/resources/details?page=753>

Сүүлийн үед тохиолдсон Азийн цунами зэрэг байгалийн гамшиг, Косово, Либери, Иракийн зэвсэгт мөргөлдөөн зэргээс үүдэлтэй хүмүүнлэгийн хямралын олон тохиолдолд олон улсын тусламжийн байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалах өргөн хүрээтэй үйл ажиллагааг хангалттай хэмжээнд хийж чадахгүй байгаа нь илэрсэн. Тусламжийн хөтөлбөрүүдийн үр дүнг үнэлэн дүгнэх НҮБ-ын судалгаа, цунамитай холбоотой арга хэмжээнд үнэлгээ өгсөн эвслийн тайланд<sup>13</sup> аврах ажиллагааны үеэр нэрвэгдсэн хүмүүст хүрэх мэдээлэл, тайлагналт болон үйл ажиллагааны ил тод байдал маш хангалтгүй байгааг дурьджээ. Хүмүүнлэгийн байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажиллах, тэдний наад захын хоол, ус, орон байр, эмнэлгийн тусламжийн хэрэгцээг хангах бэлтгэлгүй, техник төхөөрөмжгүй байгааг тайлангууд харуулжээ.

Үүнтэй адилаар, Катрина, Рита хар салхи нь АНУ-ын холбооны түвшний гамшгийн албад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг хангасан хамгаалалт, үйлчилгээ үзүүлэхэд бэлэн биш байгааг харуулсан. Катрина хар салхины үеэр болон түүний дараа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэрээсээ гарч чадалгүй олон хонож, аврах оромжинд очсон хойноо ч гэсэн шаардлагатай эмнэлгийн тусламж авч чадаагүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй олон хүн үүний улмаас нас баржээ. Хожим тэд тусламжийн хөтөлбөрүүдэд хамрагдаж чадаагүй бөгөөд жишээлбэл, аврах оромж руу түрдэг тэрэгтэй орох боломжгүй байжээ.<sup>14</sup> Хүний амь нас, аюулгүй байдалд хамгийн ноцтой аюул занал дагуулдаг үзэгдэл бол олон улсын юмуу үндэсний хэмжээний, эсвэл зэвсэгт босогчид болон бүлэглэл хоорондын орон нутгийн шинжтэй зэвсэгт мөргөлдөөн юм. Мөргөлдөөн нь төрөл бүрийн хөгжлийн бэрхшээл үүсэх шалтгаан болохын зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрүүл мэндийн доройтол, шинээр хоёрдогч хүндрэл гарах нөхцөл болдог. Мөргөлдөөний улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дэмждэг нийгмийн болон гэр бүлийн холбоо сүлжээ нь тасрах, дүрвэж зугтах, халамж хяналтгүй хаягдах, эрүүл мэндийн, тээврийн, нөхөн сэргээлтийн дэд бүтэц устах зэрэг ноцтой сөрөг үр дагаврууд үүсдэг. Зэвсэгт мөргөлдөөнд өртсөн хүмүүсийн сэтгэцийн болон сэтгэл-нийгмийн эрүүл мэнд хямардаг нь бас нэгэн эрсдлийн хүчин зүйл юм.

Хүмүүнлэгийн хямралын үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хамгийн эмзэг байдалд ордогийг олон улсын баримт бичгүүдэд хүлээн зөвшөөрсөн байдаг ч хүмүүнлэгийн тодорхой хөтөлбөр, бодлого, аргазүй болгож хэрэгжүүлсэн зүйл цөөн байна. Гэтэл НҮБ-ын тусгай агентлагууд, хувийн сайн дурын томоохон байгууллагууд бүгд өөрсдийнхөө ажлыг “эрхэд тулгуурласан”, хамгаалахад чиглэгдсэн гэж тодорхойлдог. Эдгээрээс цөөн хэдэн байгууллага л хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандсан тусгай бодлоготой байдаг бол ихэнх ажилтан нь хөтөлбөр, төслийнхөө хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажиллах бэлтгэл муутай байдаг ажээ. Тэгэхлээр хүмүүнлэгийн хямралын үеэр хэрэгжүүлэх тусламжийн хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өвөрмөц хэрэгцээг анхаарах шаардлагыг хангахад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудаас явуулах нөлөөллийн ажил нь маш чухал үүрэгтэй болж ирж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний төлөөллийн байгууллагууд эрсдэлт нөхцөлд орсон хүмүүст тусламж үзүүлэх зорилготой бүх төсөл, хөтөлбөрт оролцох шаардлагатай.

13 Косгрейв, Жон. “Цунамигийн хяналт үнэлгээний эвсэл: Урьдчилсан дүгнэлт.” 2005 оны 12 сар. <http://www.tsunami-evaluation.org/NR/rdonlyres/576D8E84-27DB-44DC-866383AB9D5BF614/0/lowresA520060221.pdf>

14 [www.nobodyleftbehind.org](http://www.nobodyleftbehind.org) сайтаас үз.

## ДАСГАЛ 5.4: Эрсдэлт нөхцөлд орсон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс

- Зорилт:** Байгалийн гамшигт нэрвэгдсэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг тодорхойлох, онцгой байдалд бэлэн байх бодлогод хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалах стратегийг оруулах
- Хугацаа:** 45 минут
- Хэрэглэгдэхүүн:** Том цаас, фломастер эсвэл самбар, шохой

### 1. Санал солилцох

Бидний амьдарч буй орчинд байгалийн ямар гамшиг (цасан шуурга, хар шуурга, хуй салхи, газар хөдлөлт) нүүрлэж болохыг тодорхойлон жагсаан бичих даалгаврыг оролцогчдод өг. Дараа нь оролцогчдын эргэн тойронд амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй гурван хүний жишээ гаргуул. Ингэхдээ аль болох олон төрлийн хэв шинжийг гаргуулахыг хичээх хэрэгтэй ба үүнд янз бүрийн насны бүлэг, хөгжлийн бэрхшээлийн төрөл (сэтгэц-нийгмийн эмгэгийг багтаах), үндэсний цөөнх, амьдралын хэв маяг (ганцаараа, асрамжийн газар, гэр бүлтэйгээ) зэргийг багтаа. Оролцогчдын гаргасан тодорхойлолтуудыг бичүүлэн цуглуулж аваад, эдгээрээс аль болох олон төрлийг сонгон дүрийн тоглолтод бэлд.

### 2. Төсөөлөх

Оролцогчдыг жижиг багуудад хуваагаад, баг болгонд нэг хэв шинжийн тодорхойлолт, дараах зааврыг өг:

Байгалийн гамшиг тохиолдвол юу болж болохыг дүрийн тоглолтоор үзүүл. Үүнд:

- Энэ дасгалын эхний хэсэгт жагсааж бичсэн байгалийн гамшигаас нэгийг нь сонгоод даалгавраар хүлээж авсан хөгжлийн бэрхшээлтэй хүний хэв шинжийн жишээг ашиглан дүрийн тоглолт бэлд. Энэ үед таны орчин тойронд юу болох вэ (цахилгаан, ус тасрах, харилцаа холбооны ихэнх суваг тасрах, протез, сонсголын аппарат, шил, хөдөлгөөний аппарат гэх мэт туслах төхөөрөмжүүд гээгдэх, хоол, унд, оромж байр, ариун цэвэр, эрүүл мэндийн энгийн хэрэгцээг хангах боломжгүй болох гэх мэт)?
- Багийн нэг гишүүн хөгжлийн бэрхшээлтэй хүний дүрд тоглож, бусад нь тусламж үзүүлэх, эсвэл үл туслах хүмүүсийн (хамаатан, хөрш, цагдаа, аврагч, эмч гэх мэт) дүрд тоглоно.
- Тоглогчид нэг бол дээд зэргээр эерэг нөхцөл, эсвэл хамгийн сөрөг нөхцөл, эсвэл аль алийг нь харуулан тоглож болно.

### 3. Танилцуулах

Багуудын дүрийн тоглолтыг үзсэний дараа хөгжлийн бэрхшээлтэй хүний дүрд тоглосон оролцогчдыг нийлүүлээд, сая туулж өнгөрүүлсэн туршлагынх нь талаар “ярилцлага” ав.

- Саяын нөхцөлд танд хамгийн их хэрэг болох ямар арга хэмжээ авагдсан, мөн авагдаж болох байсан бэ?
- Танд тус болж чадахгүй ямар арга хэмжээ авагдсан, мөн авагдаж болох байсан бэ?

### 4. Хэлэлцэх

Хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс амьд явах эрхтэй, тэр эрхийг нь хамгаалахын тулд Оролцогч улсууд нь тодорхой арга хэмжээ авах ёстой ч, бодит амьдрал дээр байгалийн



гамшиг, зэвсэгт мөргөлдөөн гарсан үед тэдний хэрэгцээг ихэнх тохиолдолд умартдаг тухай тайлбарлаж өг.

- Энэ эрхийг хэрэгжүүлэхийн тулд юу хийж болох вэ?
- Тэрхүү эрхийг хамгаалах үүрэг хариуцлагыг хэн хүлээх вэ?
- Танай орон нутагт гамшигт бэлэн байх үйл ажилагааны төлөвлөгөө байгаа юу?
- Тэр төлөвлөгөөнд дээрх хамгааллын арга хэмжээнүүд багтсан уу? Анхны хариу арга хэмжээг хэрэгжүүлэх хүмүүс, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх үүрэгтэй хүмүүсийн ажилд хөгжлийн бэрхшээлийн асуудлыг илүү сайн тусгахын тулд та өөрөө юу хийж чадах вэ?

Нэмэлт дасгал: багуудаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг тооцсон гамшгийн үеэр ажиллах төлөвлөгөө гаргуулах, эсвэл хүмүүнлэгийн тусламжаа үзүүлэх ажилтнуудад зориулсан зайлшгүй авах арга хэмжээний жагсаалтыг боловсруулах даалгаврыг гүйцэтгүүлнэ (Ийм жагсаалтын жишээг дараах өгүүллэгээс, эсвэл [www.nobodyleftbehind.org](http://www.nobodyleftbehind.org) веб хуудаснаас унш).

### **Хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүсийг аврах ажиллагаанд анхаарах зайлшгүй авах арга хэмжээний жагсаалт**

- Гамшгийн үед танай орон нутаг хэрхэн ажиллах төлөвлөгөө боловсруулах явцад оролц.
- Гамшиг болж хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хаягдаж үлдтэл хүлээх хэрэггүй.
- Эхлээд гэр орондоо бэлтгэлээ базаагаад дараа нь орчин тойрондоо түгээ.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг аврах, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө боловсруулагдчихсан байгаа гэж битгий бод.
- Ажил дээрээ болон нийтийн үйлчилгээ, төрийн үйлчилгээний бусад газарт “Хүртээмжийн асуудал хариуцсан хороо” байгуул.
- Бусадтай хамт таныг ч бас аварна гэж найдаж үлдээх хэрэггүй.
- Онцгой байдлын мэргэжилтэн, бусад холбогдох хүмүүстэй хамтарч аврах боломжуудыг судла.
- Аврах зорилготой хувилбарт аргуудыг харгалз. Жишээлбэл, тусгай сандал.
- Гаргасан төлөвлөгөөгөө нэг байшинд байгаа/ эргэн тойронд чинь байгаа бүх хүнд танилцуулаад, дасгал сургуулилт хий.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудалд иргэдийн анхаарлыг хандуулахын тулд гамшиг тохиохыг бүү хүлээ.
- Гамшгийн талаарх өөрийн мэдлэгээ дээшлүүлээд сурч мэдсэн бүхнээ бусадтай хуваалц.
- Орогнох байрын хүртээмж, тэнд туслах амьтан (хөтөч нохой гэх мэт) байгаа эсэхийг шалга.
- Гамшгийн асуудал хариуцсан орон нутгийн менежер, ажилтнуудтай хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаар ярилц.

- Гамшгийн үеэр ажиллах төлөвлөгөөгөө бусдад эртнээс танилцуулж, бэлтгэлийг нь хангуул.
- Гамшгийн асуудал хариуцсан менежер, аврагчид, улаан загалмайн хүмүүстэй санаачилга гаргаж ярилц.
- Та нарт туслах, дэмжлэг үзүүлэх хүмүүсийн сүлжээг үүсгэж, бэлтгэхээ бүү март.
- “Хэнийг ч орхихгүй” байхын тулд өөрөө бүх ажилд идэвхтэй оролц.<sup>15</sup>

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН АМЬД ЯВАХ ЭРХИЙГ ХАНГАХ НӨЛӨӨЛЛИЙН АЖИЛ

Сүүлийн үед хүчээ авч байгаа “үхэх эрх” буюу “хөндлөнгийн туслалцаатайгаар амиа хорлох”-ыг дэмжсэн хөдөлгөөн нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьд явах эрхэд хэрхэн нөлөөлж болох талаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд санал бодлоо илэрхийлэх нь нэмэгдэж байна. Ноцтой буюу эцсийн шатандаа орсон өвчин, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс үхэх цаг, газраа өөрийн хүсэлтээр сонгох боломжийг олгож байна гэж энэ хөдөлгөөнийхөн ярьдаг. Харин энэхүү сонголт нь жинхэнэ сайн дурын үндсэн дээр мэдээлэл, мэдлэгтэйгээр хийж буй сонголт уу, эсвэл хөндлөнгийн дарамт шахалт, хөгжлийн бэрхшээлээс үүдэлтэй “ачаа”, амьдралын чанарын талаарх сөрөг хандлага, буруу ойлголтод үзүүлж буй хариу үйлдэл төдий юү гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалагчдын хамгийн их санаа зовоож буй асуулт юм. Америкийн “Арай л үхээгүй байна”<sup>16</sup> хэмээх хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага энэхүү “үхэх эрхийг” дэмжигчдийг сөрөн зогсож, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралыг илтэд үнэгүйдүүлж байна гэж тэднийг буруушааж байгаа билээ. Үүнтэй ижил бусад байгууллагууд эмчийн туслалцаатайгаар амиа хорлох явдлыг хуульчлах оролдлого болон бусад эмнэлзүй, био-этикийн олон асуудлаар ажилладаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьд явах эрх зөрчигдөх магадлалтай бусад нөхцөлд үйл ажиллагаагаа чиглүүлсэн өөр байгууллагууд ч мөн байдаг бөгөөд тэд, жишээлбэл, эрүүл мэндийн чанартай үйлчилгээ, дархлаажуулалт, эрүүл мэндийн боловсролыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгохын төлөө ажилладаг. Гамшгийн үед үүсэх янз бүрийн эрсдэлт нөхцөлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст туслах бэлтгэлийн хангуулахад анхаарч ажилладаг байгууллагууд ч мөн бий. Эдгээр болон бусад олон нөхцөлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьд явах эрхийг хамгаалах нөлөөллийн ажилдаа хүний эрхийн идэвхтнүүд нь холбогдох бусад талуудыг татан оролцуулж, хамтран ажиллах хэрэгтэй.

15 “Гамшигт бэлэн байх нь: Гамшгийн үед хийх, хийхгүй байх зүйлсийн жагсаалт.” Хэнийг ч орхихгүй: Гамшгийн үед хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүсийн аюулгүй байдлыг хангах бэлтгэл [www.nobodyleftbehind2.org](http://www.nobodyleftbehind2.org)

16 Арай л үхээгүй байна. notyetdead, 2005. [www.notdeadyet.org/ocs/about.html](http://www.notdeadyet.org/ocs/about.html)





## ДАСГАЛ 5.5: Амьд явах эрх, эрсдэлт нөхцөлд хамгаалуулах эрхийг дэмжих амлалт авах нь

Хүний эрх бол эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагын нэгдэл гэдгийг тайлбарла.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьд явах эрх, эрсдэлт нөхцөлд хамгаалуулах эрхийн талаар судалж мэдсэний эцэст үйл ажиллагаа, үйлдэл хийхэд хэр бэлэн болоод байгааг оролцогч нэг бүрээс асуу.
- Мэдээлэл цуглуулах, ажлаа төлөвлөх гээд хийх зүйл их байгаа ч өөрчлөлт хийх чин эрмэлзэл маш чухал гэдгийг тэмдэглэн хэл.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст амьд явах эрх, эрсдэлт нөхцөлд хамгаалуулах эрхээ бүрэн эдлэхэд нь нэмэр болох жижиг ч хамаагүй ямар ажлыг ирэх сард хийхийг хүсэж байгаа, хийх боломжтой байгааг оролцогч бүрээр хэлүүл.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах нөлөөллийн ажил хэрхэн төлөвлөх талаар “Хэсэг 3. Нөлөөлөл! Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа” (хуудас 278) хэсгээс уншина уу.

### АМЬД ЯВАХ БОЛОН АЮУЛЫН НӨХЦӨЛД ХАМГААЛУУЛАХ ЭРХИЙН ТУХАЙ НЭМЭЛТ МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

- Орон нутгийн засаг захиргаанд зориулсан ADA-ийн удирдамж: гамшигт бэлэн байх, хариу үйл ажиллагааны хэрэгжүүлэх орон нутгийн төлөвлөгөөг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгох. АНУ-ын Хууль зүйн департамент:  
<http://www.ada.gov/publicat.htm#Anchor-Emergency>.
- Бритиш Колумбия мужийн Хамтын амьдралын нийгэмлэг:  
<http://www.bcacl.org/index.cfm?act=main&call=788F8794>
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн олон улсын ажиглагч. *Энэтхэг, Индонези, Тайландад цунамигийн уршгийг арилгах үйл ажиллагаа ба хөгжлийн бэрхшээл* (Нөхөн сэргээлтийн олон улсын төв, 2005 оны 9 сар): <http://www.disability.ws/idrm>
- Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах олон улсын байгууллага:  
<http://www.mdri.org>
- Хөгжлийн бэрхшээлийн асуудлаарх Үндэсний хороо. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан гамшгийн бэлэн байдлын зөвлөмж:  
<http://www.nod.org>
- “Хэнийг ч орхихгүй” судалгааны төсөл. Канзас мужийн Лоренс хотын Бие даан амьдрах асуудлаарх сургалт, судалгааны төв. “Хэнийг ч орхихгүй” төслийн эцсийн тайлан: Хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүсийн бэлэн байдлыг судлах төсөл” (М.Х. Фокс нар, 2007 он):  
<http://www.nobodyleftbehind.org>
- Арай л үхээгүй байна: <http://www.notdeadyet.org>



- НҮБ-ын Хүний эрхийн хорооны Ерөнхий зөвлөмж №6. Амьдрах эрх (6 дугаар зүйл), 16 дугаар хуралдаан, 1982:

<http://www.unhchr.ch/tbs/doc.nsf/>

084ab9690ccd81fc7c12563ed0046fae3?Opendocument



## **БҮЛЭГ 6. ЭРҮҮ ШҮҮЛТ БОЛОН БУСАД ХЭЛБЭРИЙН ХЭРЦГИЙЛЛЭЭС АНГИД БАЙХ ЭРХ ЧӨЛӨӨ**

### **НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци**

#### **15 дугаар зүйл. Эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрх**

1. Хэнд ч эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхийг хориглоно. Ялангуяа, өөрийнх нь чөлөөтэй өгсөн зөвшөөрөлгүйгээр хэнийг ч эмнэлгийн буюу шинжлэх ухааны туршилтад оруулж болохгүй.
2. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусадтай адил тэгш байх эрхийн үндсэн дээр эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхээс урьдчилан сэргийлэх бүхий л үр дүнтэй хууль тогтоох, захиргааны, шүүхийн буюу бусад арга хэмжээг авна.

#### **16 дугаар зүйл. Аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос ангид байх эрх**

1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь орон гэрийнхээ дотор, гадна хаана ч жендерт үндэслэсэн байдлыг оролцуулан аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос ангид байх явдлыг хангах үүднээс бүхий л зохистой хууль тогтоох, захиргааны, боловсролын болон бусад арга хэмжээг авна.
2. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нас, хүйсийн онцлогт тохирсон тусламж, туслалцаа үзүүлэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гэр бүл, асран халамжлагчдад нь аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолтой холбоотой бодит явдлын талаар мэдээлэх, таниулах болон эдгээрээс хэрхэн сэргийлэх талаар мэдээлэл түгээх боловсрол олгох зэргээр дэмжлэг үзүүлэх явдлыг хангах замаар аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос урьдчилан сэргийлэх зохистой бүхий л арга хэмжээ авна. Оролцогч улсууд ийнхүү үзүүлж буй хамгаалалтын арга хэмжээ нь нас, хүйсийн онцлог болон хөгжлийн бэрхшээлийг харгалзан үзсэн байх явдлыг хангана.
3. Аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлол гарахаас урьдчилан сэргийлэхийн тулд оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулагдсан байгууллага, хөтөлбөрийг хараат бус эрх бүхий байгууллагаар үр нөлөөтэй хянуулах явдлыг хангана.
4. Оролцогч улсууд аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолын хохирогч болсон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бие махбод, танин мэдэхүй, сэтгэлзүйн хувьд сэргээх, нөхөн сэргээх, нийгмийн амьдралд дахин оролцуулах, ялангуяа хамгаалах үйлчилгээ үзүүлэх зэрэг зохистой бүхий л арга хэмжээг авна. Тийнхүү сэргээх, нийгэмд оролцуулах арга хэмжээг тухайн хүний эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, өөрийгөө хүндэтгэх байдал, нандин чанар, хувь хүний хараат бус байдлыг хангасан орчин нөхцөлд л авахын зэрэгцээ тухайн хүний нас, хүйсийн онцлогийг харгалзан үзсэний үндсэн дээр хэрэгжүүлнэ.

5. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг мөлжсөн, хүчирхийлсэн, доромжилсон тохиолдол гарсан бол түүнийг илрүүлэх, мөрдөн шалгах болон мөрдөн байцаах хууль тогтоох болон бусад үр дүнтэй арга хэмжээ, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдэд чиглэсэн хууль тогтоох болон бусад арга хэмжээг оролцогч улсууд авна.

## ЗОРИЛТУУД

Энэ бүлгийн сэдэв, үндсэн мэдээлэл, дасгалууд нь оролцогчдод дараах зорилтыг хангахад туслах зорилготой:

- Эрүү шүүлт болон бусад хэлбэрийн хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь гутаасан харьцаа, шийтгэлээс ангид байх эрхийг тодорхойлох
- Мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос ангид байх эрхийг тодорхойлох
- Эрүү шүүлт болон бусад хэлбэрийн хэрцгийллээс ангид байх эрх нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд ямар ач холбогдолтой болохыг тайлбарлах
- Эрүү шүүлт болон бусад хэлбэрийн хэрцгийллээс ангид байх эрх болон хүний бусад эрхийн хоорондын уялдааг ойлгох
- Эрүү шүүлт, хүчирхийллийн бусад хэлбэрээс ангид байх эрх хэрхэн хангагдаж эсвэл зөрчигдөж байгааг мэддэг болох
- Эрүү шүүлт болон бусад хэлбэрийн хэрцгийлэл, хүнлэг бус, гутаасан харьцаа, шийтгэлээс ангид байх эрх ба мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос ангид байх эрхийн заалтуудыг тайлбарлаж чаддаг болох.

## ЭХЛЭЛ: ЭРҮҮ ШҮҮЛТ, БУСАД ХЭЛБЭРИЙН ХЭРЦГИЙЛЛЭЭС АНГИД БАЙХ ЭРХИЙН ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЭХ НЬ

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь эрүү шүүлт болон бусад хэлбэрийн хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь гутаасан харьцаа, шийтгэлд өртөх маш өндөр магадлалтай. Мөн тэд мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолд өртөмхий байдаг. Ийм үйлдэл нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тусгаарлан амьдруулдаг асрамжийн газар, эсвэл гэр бүл, бүлгээр амьдардаг орчин, саатуулах газар, шорон зэрэг бусдын нүднээс далд газруудад тохиолдох нь их байдаг тул тэр бүр нийгмийн анхааралд өртөөд байдаггүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүчирхийлэл, доромжлолоос ангид байх эрх нь бусад хүний нэгэн адилаар хүний эрхийн эрхзүйгээр хамгаалагдсан байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүү шүүлт болон бусад төрлийн хэрцгийллээс ангид байх эрх чөлөө нь тэдний бусад эрхтэй салшгүй холбоотой. Жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүн эрүү шүүлтэд өртөх юм бол түүний амьд явах, сэтгэл санааны болон бие махбодын хувьд эрүүл байх зэрэг эрх зөрчигдөнө. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн орчинд хүчирхийлж, доромжлох явдал гарвал түүний эрүүл байх болон сурч боловсрох эрх нь зөрчигдөнө (Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн талаар 15 дугаар бүлгээс (хуудас 231) дэлгэрүүлж уншаарай). Асрамжийн газарт хөгжлийн бэрхшээлтэй



хүмүүсийг хүнлэг бус нөхцөлд амьдруулан, анхаарал халамжаар дутаах, анхаарал огт тавихгүй байх, хувийн эрүүл ахуйн наад захын хэрэгцээг хангах нөхцлийг бүрдүүлж өгөхгүй байх, сонирхолдоо нийцсэн чөлөөт цагийн үйл ажиллагаанд хамруулахгүй байх зэрэг нь тэдний хүнлэг бус, гутаасан харьцаанаас ангид байх эрх чөлөөг зөрчөөд зогсохгүй бас зохистой нөхцөлд амьдрах, чөлөөт цагаа чанартай өнгөрүүлэх, эрүүл байх зэрэг эрх зөрчигдөж байгаа юм. Эдгээр жишээ нь хүний эрхүүд **нэгдмэл, уялдаа холбоотой, харилцан хамааралтай** болохыг харуулж байна.

### **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хамгийн ихээр өртдөг хүчирхийллийн төрөл**

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдаас гурав дахин илүүтэйгээр хүчирхийлэлд өртдөг тухай Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага тайландаа дурьджээ.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй зүй бусаар харьцах явдал бусад хүүхдээс 1.7 дахин их гардаг байна.
- АНУ-д хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй оюутнууд ийм бэрхшээлгүй эмэгтэй оюутнуудаас хавьгүй илүүтэйгээр бэлгийн дарамтанд ордог тухай Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн судалгааны төв мэдээлжээ. Мөн, хөгжлийн бэрхшээлтэй охид хөгжлийн бэрхшээлтэй хөвгүүдээс илүүтэйгээр бэлгийн дарамтад өртдөг.
- Эмнэлгийн байгууллагад сэтгэцийн эмчилгээ хийлгэж байгаа эмэгтэйчүүдийн 60-80 хувь нь хүчирхийлэлд өртөж байжээ.
- Хөгжлийн хоцрогдолтой хүмүүсийн 90 хувь нь бэлгийн хүчирхийлэлд өртдөг.
- Хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэйчүүдийн 12 хувь нь анхаарал халамж дутмаг нөхцөлд амьдарч үзсэн бол 9 хувь нь асран халамжлагчаасаа бие махбодын хүчирхийлэл амсаж үзжээ.
- Өндөр настнуудын хувьд жил бүр 25 хүний нэг нь хүчирхийлэлд өртдөг байна.

Хүний эрхийн хуулиуд нь нэг талаас эрүү шүүлт, нөгөө талаас хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг гутаасан харьцаа, шийтгэлийг ялгаж үздэг. Ямар нэг үйлдэл нь “эрүү шүүлт”-ийн тодорхойлолтод бүрэн дүүрэн нийцээгүй бол энэ үйдлийг шалтгаан, ноцтой байдал, зорилгоос хамааран хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг гутаасан харьцаа юмуу шийтгэл гэж тодорхойлж болох ажээ. Нөлөөллийн үйл ажиллагаа явуулж байгаа хэн бүхэн гомдол гаргах, мэдээлэл өгөхдөө энэхүү эрхзүйн ялгааг сайтар ойлгож мэдсэн байх шаардлагатай. Гэхдээ бодит амьдрал дээр эрүү шүүлт ба хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг гутаасан харьцаа болон шийтгэлийг ялган салгаж, хязгаарлах нь амаргүй болохыг ойлгох хэрэгтэй. Тохиолдол бүрт хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хэр удаан хугацааны туршид хэр хүчтэй шаналалд оруулсан, мөн тухайн тохиолдлын илэрсэн нөхцөл байдалд үнэлгээ өгч шүүн тунгаах хэрэгцээ үүсдэг нь асуудлыг улам ээдрээтэй болгодог. Тодорхой нэг тохиолдлыг нэг шүүхээс эрүү шүүлтийн хэмжээнд хүрсэн гэж үзсэн байхад яг үүнтэй ижил хэргийг өөр нэг шүүхэд эрүү шүүлт биш гэж үзэх ч тохиолдол гарна.

Эрүү шүүлт бол хүний эрхийн зөрчлийн хамгийн ноцтой хэлбэрийн нэг юм. Эрүү шүүлт болон бие махбод, сэтгэл санааны, бусад хэлбэрийн хүчирхийллээс ангид байх эрх нь туйлын бөгөөд ямар ч нөхцөлд хязгаарлагдахгүй, цуцлагдахгүй эрх юм. Цагдаагийн байгууллагад саатуулагдан шалгагдаж байх үед эрүү шүүлт, ёс бус харьцаанд өртөх эрсдэл учирдаг тул эрүү шүүлт гарах эрдслийг бууруулах зорилгоор олон улсын хүний эрхийн хуулиудад дагаж мөрдөх хамгааллын хэд хэдэн процедурыг суулгаж өгсөн байдаг.

Эрүү шүүлт өөрөө хөгжлийн бэрхшээлийн шалтгаан болох нь элбэг байдаг бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүү шүүлт тулгасны улмаас хоёрдогч хөгжлийн бэрхшээл юмуу хүнд өвчин үүсэж мэднэ. Эрүү шүүлт гэж үзэж болох байцаалтын зарим арга техник нь хэн бүхэнд хор хохирол учруулах ч зарим төрлийн хөгжлийн бэрхшээл, эсвэл өвчтэй хүний хувьд маш хүнд тусаж мэднэ. Үүнээс гадна, байцаалт өгч байгаа хүн нь хөгжлийн бэрхшээлийн улмаас асуултыг сонсохгүй, асуусан зүйлийг ойлгохгүй юмуу хариултаа илэрхийлж чадахгүй байгаа байдлыг байцаагч нь эсэргүүцэл үзүүлж байна хэмээн буруугаар тайлж ойлгож мэднэ.

### **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эсрэг хүчирхийлэл гарахад нөлөөлдөг хүчин зүйлс**

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сул дорой, өөрийгөө хамгаалах чадваргүй, хүчирхийллийн хялбар бай гэж үзэх хэвшмэл, буруу ойлголт;
- хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүний асрагч хоёрын хүч тэнцвэргүй байдал;
- бусдын нүднээс далд гэртээ юмуу асрамжийн газар тусгаарлагдан амьдардаг;
- хүчирхийллийг таньж, түүний эсрэг тэмцэх чадвар, мэдлэг олгох сургалт хийгддэггүй (энэ нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидод онцгой хамаатай);
- хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг асрах тал дээр тэдний гэр бүлийн гишүүд, асран хамгаалагч, эмнэлгийн ажилтнуудад явуулдаг сургалт, дадлага хангалтгүй;
- зэвсэгт мөргөлдөөн болон газарт булсан тэсрэх бөмбөг гэх мэт орчны аюул;
- ядуурал;
- эмэгтэй хүний бэлэг эрхтнийг эрэмдэглэх зэрэг зарим заншил.

Хөгжлийн бэрхшээлийг “эмчлэх”, “засах” нэрийдлээр эмчилгээний хор хөнөөлт аргуудыг хэрэглэх явдал маш олон жилийн урт түүхтэй. Эртний хүмүүс хөгжлийн бэрхшээлийг ад чөтгөрийн хорлол гэж үздэг байсан тул бөө, удган нар янз бүрийн аюултай бөгөөд хор хохирол учруулж мэдэх аргаар хүнийг эзэмдсэн муу сүнсийг хөөх оролдлого хийдэг байжээ. Нүдэнд харагдахуйц хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг анагаах ухааны үзүүлэн болгох, насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг албадан циркийн үзмэр болгон үзүүлэх нь хүний нэр төрийг гутаахын зэрэгцээ сэтгэл санаанд нь хөнөөлтэй үр дагавар авчирдаг. Иймэрхүү явдлын ихэнх нь эмнэлэг, асаргаа үзүүлэх ёстой газруудад гардаг бөгөөд хамгийн эмзэг хүмүүс болох нийгэм-сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүс үүнд өртөх нь элбэг байдаг. Эрүүл мэндийн тогтолцоо нь сайн хөгжөөгүй улс орнуудад ийм практик илэрдэг билээ.

Ялангуяа нийгэм-сэтгэцийн хөгжлийн бэрхшээлийн талаарх хандлагуудад эрүү шүүлт болон хэрцгий, хүнлэг бус, гутаасан харьцаа, шийтгэл болж хувирах магадлалтай хүчирхийллийн шинж илүүтэй илэрдэг. Дэлхийн олон соёлд сэтгэц-нийгмийн хөгжлийн бэрхшээлийг чөтгөрийн хорлол гэж үзэн, түүнийг хөөхийн тулд бие махбодын хэрцгийлэл үйлдэхээс буцдаггүй бөгөөд гавлын ясыг нь өрөмдөж “чөтгөрийг гаргах”-даа тулж байлаа. Дундад зууны Европт “галзуурлыг” харанхуй өрөөнд цоожлох, олон нийтийн өмнө ташуурдах зэрэг аргаар “эмчлэх” практик хэвшсэн байв. “Сэргэн мандалтын” 18 дугаар зуунд нийгэм-сэтгэцийн өвчтэй хүмүүсийг муу нэртэй Лондоны Бедламын эмнэлэг шиг улсын галзуугийн эмнэлэгт хорьж, иргэд нь галзуу хүмүүсийг үзэж зугаацахын тулд тасалбар худалдан авдаг байжээ.<sup>1</sup>

Сэтгэц-нийгмийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ингэж хандах нь түүх болж үлдсэнгүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрүүдэн шүүх, эсвэл тэдэнтэй хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь гутааж харьцсан орчин цагийг жишээг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд баримтжуулсан байдаг. Тухайлбал, удаан хугацаагаар хөдөлгөөнийг нь хязгаарлан өвдөлт мэдрүүлж хүлэх, мэдээ алдуулалгүйгээр цахилгаанд цохиулж цочроох эмчилгээг албадан хийх, хүчирхийллээс хамгаалагдаагүй аюултай орчинд хорих, хүчирхийлэлд өртсөн нэгэнд нь эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхгүй байх явдлууд гарсаар байна. Өөрсдийнх нь зөвшөөрөлгүйгээр тархины үйл ажиллагаанд нөлөөлөх лоботоми (сэтгэлийн хөдөлгөөнийг дарах зорилготой тархины мэс засал) хийх явдал одоо ч гарсаар байгаа ба ялангуяа “сэтгэлийн хөөрөлтэй” эмэгтэйчүүд үүнд өртдөг байна. Хүний эрхийг нь зөрчин хор хөнөөлт үр дагавар бүхий эмчилгээнд хамруулж байгаагийн өөр нэг жишээ бол нийгэм-сэтгэцийн өвчтэй хүмүүсийн “сэтгэлийн хөөрлийг дарах” зорилгоор сэтгэцийг гэмтээх эм уулгах явдал юм. Сэтгэл мэдрэлийн тодорхой “эмчилгээний” аргыг шийтгэл болгон ашиглаж байсан тохиолдлуудыг Сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах олон улсын байгууллага (СБХЭХОУБ) илрүүлж, мэдээ алдуулалгүйгээр өндөр хүчдэлийн цахилгаанаар цохиулах зэрэг нь эрүүдэн шүүхийг хориглосон хуулийн заалтыг зөрчсөн хэрэг мөн болохыг нотолж чаджээ.<sup>2</sup>

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бие махбодын болон сэтгэл зүйн хүчирхийлэл, амь насанд нь аюул учруулах хэмжээний үл хайхралтад өртөх нь маш элбэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрүүл ахуйн шаардлага хангаагүй нөхцөлд хорьж, шаардлагагүйгээр хүлж баглан, хоол, унд, хувцас, эрүүл мэндийн үйлчилгээгээр хангахгүй, амь насанд нь заналхийлсэн аюултай, аймшигтай нөхцөлтэй асрамжийн болон эмнэлгийн газруудад амьдруулж байгаа жишээнүүдийг СБХЭХОУБ-ын тайланд дурьджээ. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг мэдрэхүйн ямар нэг сэрэл өгөхөөргүй харанхуй, хоосон камерт удаан хугацаагаар байлгаж байсныг СБХЭХОУБ баримтжуулжээ.<sup>3</sup> Эдгээр зөрчлийг илэрсэн тодорхой нөхцлөөс нь хамааруулан эрүү шүүлт, эсвэл хэрцгий, хүнлэг бус, доромжилсон харьцаа, шийтгэлийн жишээ гэж үзэх үндэслэлтэй.

- 1 Харрис, С. Жэймс. Сэтгэцийн хөгжлийн бэрхшээл: шалтгаан, ангилал, үнэлгээ болон эмчилгээний тухай (Оксфорд: 2005), хуудас 14-16 ; Альбрехт, Л. Гари нар, Хөгжлийн бэрхшээл судлалын гарын авлага (Sage Publications: 2001), хуудас 15-18.
- 2 “Хаалттай хаалганы цаана: Туркийн сэтгэцийн байгууллагууд, өнчин хүүхдийн асрамжийн газар болон сэргээн засах төвүүдэд гарсан хүний эрхийн зөрчлүүд.” Олон улсын сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах байгууллага (MDRI). 2005. [www.mdri.org/projects/turkey](http://www.mdri.org/projects/turkey)
- 3 “Сүйрсэн амьдрал: Аргентины сэтгэцийн эмнэлэгт ялгарлан гадуурхагдагсад” 2007. Олон улсын сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах байгууллага (MDRI) болон Нийгэм, эрх зүй судлалын төв [www.mdri.org/projects/americas/argentina/mdri.arg.eng.new.pdf](http://www.mdri.org/projects/americas/argentina/mdri.arg.eng.new.pdf)



## Асрамжийн газарт гардаг хүний эрхийн зөрчилтэй тэмцэх нь

- 2007 онд өөрийнх нь хүслийг үл харгалзан сэтгэл мэдрэлийн эмнэлэгт хүчээр хорьж, өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр сэтгэл мэдрэлийн эмчилгээнд хамруулсан нэгэн эмэгтэйн эрхийг хамгаалсан шийдвэрийг Чехийн бүсийн шүүхээс гаргажээ. Түүний түрээслэн амьдарч байсан байрыг хууль бусаар чөлөөлүүлж авах гэсэн байрны эзний явуулгаар эмэгтэйг сэтгэцийн эмнэлэгт хорьжээ. Эмнэлэгт хүчээр аваачиж хорьсон нь хүний эрхийг зөрчсөн явдал мөн гэж шүүх үзсэн байна.
- 2006 онд Америк тивийн Хүний эрхийн шүүхээс сэтгэц-нийгмийн хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудлаар анхны шийдвэрээ гаргахдаа Бразиль улс Америк тивийн хүний эрхийн конвенцийг зөрчсөн хэмээн шийджээ. Энэ нь хувийн сэтгэл мэдрэлийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байхдаа эмнэлгийн ажилтнуудад зодуулан, ирж хэвтсэнээсээ хойш гурав хоногийн дараа нас барсан эрэгтэй өвчтөний үхэлтэй холбоотой хэрэг байв. Бразиль улс нь энэ хүний амьд явах эрх, хэрцгий, хүнлэг бус, гутаасан харьцаанаас ангид байх эрхийг зөрчсөн гэж Америк тивийн Хүний эрхийн шүүх үзжээ.
- 2001 онд Европын Хүний эрхийн шүүхээс нийгэм-сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг шоронгийн сэтгэл мэдрэлийн тасгийн маш давчуу, халуун, агааржуулалт муутай камерт өөр нэг хүний хамтаар хорьсон явдал нь Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах Европын конвенцийн 3 дугаар зүйлд заасан нэр төрийг нь гутааж харьцахыг хориглосон заалтыг зөрчсөн гэж үзжээ.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг үйлчилгээнд хамруулах үүднээс асрамжийн газар амьдруулах нь Хөгжлийн бэрхшээлтэй америкчуудын тухай хуулиар хориглосон ялгаварлан гадуурхал мөн гэж АНУ-ын дээд шүүх 1999 онд үзжээ. *Ольмстедын* хэрэг гэж нэрлэгдэх болсон энэхүү шүүхийн шийдвэрийн дагуу төрийн үйлчилгээний байгууллагууд аливаа үйлчилгээ, үйл ажиллагаагаа түүнд хамрагдах эрхтэй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээнд нийцүүлэн зохион байгуулж, тэдний оршин сууж байгаа орчинд нь аль болох ойр хэрэгжүүлж байх шаардлага тавигджээ.

Оролцогчоос **бүрэн мэдээлэлд үндэслэсэн** сайн дурын зөвшөөрөл аваалгүйгээр хийгдсэн эмнэлгийн болон шинжлэх ухааны туршилтыг хүний эрхийн зөрчил гэж үзнэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ийм туршилтад өртсөөр байна. Ийм хүчирхийллийн хамгийн жигшим жишээ нь дэлхийн хоёрдугаар дайны үед нацист эмч нарын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс дээр хийж байсан аймшигт туршилтууд юм. Дайны дараагаар Нюрембергийн шүүх эдгээр эмчийг цэргийн гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн зүйл ангиар шүүж, шийтгэл оноосон билээ. Бүрэн мэдээлэлд тулгуурласан сайн дурын зөвшөөрөлгүйгээр хүнийг эмнэлгийн болон шинжлэх ухааны туршилтад хамруулахыг хориглосон заалт нь хүнийг хөгжлийн бэрхшээлтэй болгодог, одоогоор эмчилгээгүй боловч анагаах ухааны судалгаа, туршилтын сэдэв болж байгаа өвчнүүдийн хувьд хурцаар тавигддаг асуудал юм. Сэтгэц-нийгмийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эцэслэн туршигдаагүй горимоор янз бүрийн эм уулгах, эсвэл үр дүн нь тодорхой харагдаагүй байгаа хосолсон эмчилгээнүүдэд хамруулах явдал олонтаа гардаг бөгөөд энэ арга туршлага нь “эмчилгээ” гэхээсээ илүү “туршилт” болж байгаа тул мэдээлэлд үндэслэн чөлөөт зөвшөөрөл аваагүй л бол хүний эрхийг зөрчил мөн.





Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хүчирхийлэл, доромжлол, мөлжлөгийн бусад хэлбэрүүдэд мөн өртөмхий байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, ялангуяа томоохон асрамжийн газруудад амьдарч байгаа хүүхдүүд бие махбодын болон сэтгэл санааны ноцтой хохирол дагуулж мэдэх хүчирхийллийн олон төрөл, хэлбэрт өртөх магадлалтай. Бэлгийн хүчирхийлэл бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөгшин залуу, эрэгтэй эмэгтэй гэж ялгалгүйгээр тохиолддог аюул юм. Ийм төрлийн хүчирхийлэлд асрамжийн газар амьдардаг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өртөх маш өндөр магадлалтай бөгөөд ийм тохиолдлуудыг Сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах олон улсын байгууллага (СБХЭХОУБ) баримтжуулжээ.<sup>4</sup> Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон насанд хүрэгчдийг цалингүй юмуу маш бага цалинтайгаар аюултай орчинд албадан хөдөлмөрлүүлэх нь тэдний эрүүл мэнд, бие махбодыг доройтуулахын зэрэгцээ нийгмийн хөгжилд нь ноцтой хохирол учруулдаг. Эрт гэрлэлт, эм бэлэг эрхтний зэрэмдэглэл зэрэг соёлын зан үйлүүд ч мөн хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийн эрхэд халдсан хэрэг болохын зэрэгцээ бие махбод, сэтгэцийн согог үүсгэх шалтгаан болох аюултай.

## **ДАСГАЛ 6.1: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүчирхийлэл хэрхэн нөлөөлдөг талаар**

- Зорилт:** Янз бүрийн төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүчирхийлэл хэрхэн нөлөөлж болох талаар ойлгох
- Хугацаа:** 30 минут
- Хэрэглэгдэхүүн:** Том цаас, фломастер эсвэл самбар, шохой.

### **1. Танилцуулах**

Хөгжлийн бэрхшээл нь хүчирхийллийн шалтгаан болж байгаа бус харин хүчирхийлэгч, дарамтлагч этгээдүүдийн үйлдлээс болж хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хүчирхийлэлд өртөж байгааг тайлбарла. Хүчирхийлэл нь янз бүрийн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст өөр өөрөөр тусдаг болохыг мөн тайлбарла. Хүчирхийлэл, хэрцгийллээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулахдаа тэдгээр ялгааг тооцох хэрэгтэй.

### **2. Багаар хэлэлцүүлэх**

Оролцогчдыг жижиг багуудад хуваагаад дараах даалгаврыг өг:

- Янз бүрийн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй (харааны, хөдөлгөөний, сонсголын, сэтгэц-нийгмийн гэх мэт) өөр өөр бүлэг хүмүүсийн (эмэгтэй, хүүхэд, эрэгтэй хүн, настан, дүрвэгч гэх мэт) жишээг жагсааж бичих.
- Янз бүрийн бүлгүүдэд хүчирхийлэл хэрхэн нөлөөлж болохыг харуулсан жишээнүүд гаргах.

Сургагч багшид: Энэ жагсаалтыг 6.3 дасгалд дахин хэрэглэхээр хадгал.

4 “Хөтөлбөрт байхгүй: Косово дахь Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх.” 2002. Олон улсын сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн төлөө байгууллага (MDRI). <http://www.mdri.org/pdf/KosovoReport.pdf>

### 3. Илтгэх

Баг болгоноос томилогдсон илтгэгч нар багийнхаа ажлын тоймыг танилцуулах ба дараах загвар хүснэгтэд хариултуудыг тэмдэглэ. Эхний хоёр баганыг бөглөж дууссаны дараа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүлэг болгоны эсрэг үйлдэгдэж мэдэх хүчирхийлэлтэй тэмцэхэд ямар бэрхшээл тохиолдож болохыг нийтээрээ хэлэлц. Хариултуудыг гуравдах баганад бичнэ.

### 3. Шинжлэх

Өмнөх хэлэлцүүлэгт үндэслэн дараах асуултуудаар хэлэлцүүлэг явуул:

- Хүчирхийлээс урьдчилан сэргийлэхийн тулд ямар арга хэмжээ авах ёстой вэ?
- Эдгээр арга хэмжээг үр дүнтэй болгохын тулд хэний оролцоо зайлшгүй шаардлагатай вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүлэг	Хүчирхийллийн төрлүүд	Энэхүү хүчирхийлэлтэй тэмцэхэд учрах саад тотгор

Эх сурвалж: Марша Сакстон, *Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст учирч буй хүчирхийллийн нөлөө*. Хөгжлийн бэрхшээлийн дэлхийн институт: [www.wid.org](http://www.wid.org)-оос материалаас өөрчлөн ашиглав.

## ЭРҮҮ ШҮҮЛТ БОЛОН БУСАД ХЭЛБЭРИЙН ХЭРЦГИЙЛЛЭЭС АНГИД БАЙХ ЭРХИЙН ТАЛААР ХҮНИЙ ЭРХИЙН ЭРХЗҮЙД ЮУ ГЭЖ ЗААСАН БАЙДАГ ВЭ?

Эрүү шүүлт бол хүний эрхийн зөрчлийн хамгийн ноцтой хэлбэрүүдийн нэг юм. Эрүү шүүлт болон бусад хэлбэрийн бие махбодын болон сэтгэл санааны хүчирхийллээс ангид байх эрх нь туйлын бөгөөд ямар ч нөхцөлд хязгаарлагдахгүй, цуцлагдахгүй эрх юм. Эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг гутааж харьцах, шийтгэхээс ангид байх эрхийг **Хүний эрхийн түгээмэл тунхаглал (ХЭТТ)**<sup>5</sup>, **Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИУТЭОУП)**<sup>6</sup>, олон улсын хүний эрхийн бусад баримт бичиг, тэр дундаа уг сэдвийг тусгайлан хөндсөн **Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид (ЭШЭК)**<sup>7</sup> авч үзжээ. Эрүү шүүлт, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжилсон харьцаа, шийтгэл зэргээс цаашиг бусад хэлбэрийн хүчирхийллийн асуудлыг олон улсын тусгай конвенцид мөн тусгахыг хичээсэн байна. Тухайлбал, **Хүүхдийн эрхийн конвенцид (ХЭК)**<sup>8</sup> хүүхэд эрүү шүүлтээс ангид байх эрхтэй гэж заагаад улмаар “бүх төрлийн бие махбодын болон сэтгэл санааны хүчирхийлэл, гэмтэл, доромжлол, хайр халамж дутаах,

5 <http://www.unhchr.ch/udhr/lang/eng.htm> сайтаас үз.

6 <http://www.ohchr.org/english/law/ccpr/htm> сайтаас үз.

7 [http://www.unhchr.ch/html/menu3/b/h\\_cat39.htm](http://www.unhchr.ch/html/menu3/b/h_cat39.htm) сайтаас үз.

8 <http://www.ohchr.org/english/law/crc.htm> сайтаас үз.



буруу хандах, мөлжлөг, бэлгийн хүчирхийлэл зэрэгт өртөхгүй байх эрхтэй” гэж заагаад бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл, эдийн засгийн мөлжлөг зэргээс болж хохирсон хүүхдийг нөхөн сэргээх хариуцлагыг Оролцогч улсууд хүлээхээр заажээ.

Хүчирхийлэл, доромжлолын олон төрөл хэлбэрийг тодорхойлоход хэцүү, тэдгээрийг хооронд нь ялган зааглах амаргүй. ЭШЭК-д эрүү шүүлт болон бусад төрөл, хэлбэрийн ёс бус харьцааг хориглохтой холбоотой нарийвчилсан стандартуудыг гаргаж өгсөн байдаг бөгөөд үүний дотор эрүү шүүлт болон хориглогдсон бусад төрлийн хүчирхийлэл, доромжлол амссан хүмүүсийн шүүхэд гомдол гаргах процедур, өртөгсдөд үзүүлэх тусламж дэмжлэгийн баталгаа зэргийг тодорхойлсон байдаг. ЭШЭК-ийн 1 дүгээр зүйлд эрүү шүүлт бол “албан тушаалтан эсвэл албан үүрэг гүйцэтгэж буй хүний, эсвэл тийм хүний өдөөн хатгаснаар юмуу зөвшөөрөснөөр аливаа хүнийг ямар нэг зорилгод хүрэх үүднээс, тухайлбал, мэдээлэл авах, мэдүүлэг өгүүлэх, шийтгэх, дарамтлах, ялгаварлан гадуурхах зэрэг зорилгоор зориудаар бие махбодын болон сэтгэл санааны зовлон, өвдөлтөд оруулах үйлдлийг хэлнэ” гэж тодорхойлжээ. Эдгээр шалгуурыг бүгдийг хангаагүй үйлдлийг тухайн нөхцлөөс хамааруулан хэрцгий, хүнлэг бус, доромжилсон харьцаа, шийтгэл гэж үзнэ. Ямар үйлдлийг эрүү шүүлт гэж үзэх, алийг нь хориглосон бусад төрлийн зөрчил гэж үзэх вэ гэдэг дээр хүний эрхийн шүүхүүд нарийвчилсан стандарт гаргаж ирээгүй л байна.

**Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн (ХБХЭК)** хоёр зүйл ангид хүчирхийлэл, доромжлолын асуудлыг хөнджээ. 15 дугаар зүйл (Эрүү шүүлт, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг гутаасан харьцаа, шийтгэлээс ангид байх эрх) болон 16 дугаар зүйлд (Мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос ангид байх эрх) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхтэй холбоотой дараах асуудлуудыг хөнджээ:

- эрүү шүүлт болон хэрцгий, хүнлэг бус, доромжилсон харьцаа, шийтгэлээс ангид байх эрх;
- бүрэн мэдээлэлтэйгээр сайн дурын үндсэн дээр өгсөн зөвшөөрөөгүйгээр эмнэлгийн болон шинжлэх ухааны туршилтаас ангид байх эрх;
- бүх төрлийн мөлжлөг, хүчирхийллээс ангид байх эрх;
- эрүү шүүлт, бусад хүчирхийлэлд өртөхөөс сэргийлэх чиглэлээр арга хэмжээ авах төрийн үүрэг;
- гэр дотроо болон гадуур орчинд бүх төрлийн мөлжлөг, хүчирхийлэл, хэрцгийлэл, үүний дотор жендерт суурилсан бүх төрлийн хүчирхийлэлд өртөхөөс сэргийлэх арга хэмжээ авах төрийн үүрэг;
- бүх төрлийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах төрийн үүрэг. Урьдчилан сэргийлэх эдгээр арга хэмжээний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүл, асрагчдад зориулсан нас, жендерийн мэдрэмжтэй туслалцаа, дэмжлэгийг зохистой арга хэлбэрээр хүртээмжтэй хүргэх асуудал мөн багтсан байх ёстой. Зарим жишээг дурьдвал: мөлжлөг, хүчирхийлэл, хэрцгийллээс зайлсхийх, гарсан тохиолдолд таньж мэдэх, мэдээлэхэд чиглэсэн сургалт, мэдээлэл зэрэг болно;
- үзүүлж буй хамгаалалтын үйлчилгээ нь нас, хүйс, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрт зохицсон байхад анхаарах төрийн үүрэг
- хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үйлчилгээ үзүүлдэг газрууд, тэдэнд хандсан хөтөлбөрийн үйл ажиллагаанд үр дүнтэй хяналт тавих төрийн үүрэг;

- аливаа төрлийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолын хохирогч болсон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бие махбод, танин мэдэхүй, сэтгэл зүйн засал, нөхөн сэргээлт, нийгэмшүүлэх арга хэмжээг хохирогсдын эрх, нэр төр, нас, хүйсийн онцлогийг хүндэтгэсэн орчинд хэрэгжүүлэх төрийн үүрэг;
- хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдэгдсэн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолын тохиолдол бүрийг бүртгэх, шалган мөрдөх, шаардлагатай бол шийтгэж байх хууль тогтоомж, бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх төрийн үүрэг.

Дүгнэж хэлэхэд, эрүү шүүлт, бусад төрлийн хэрцгийллээс ангид байх эрхийн хүрээнд Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эдгээр эрхийг хүндэтгэж, хамгаалах, хэрэгжүүлэх үүрэгтэй. Хүндэтгэх үүрэг гэдэгт хөгжлийн бэрхшээлтэй хоригдлуудыг эрүүдэн шүүхийг хориглох, мөн шорон, саатуулах газар, асрамжийн газар зэрэгт байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй хүнлэг бус харьцахаас сэргийлэх төрийн үүрэг багтана. Оролцогч улсууд нь мөн бүрэн дүүрэн мэдээллийн үндсэн дээр гадны шахалтгүйгээр өгсөн сайн дурын зөвшөөрөл өгсөнөөс бусад тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эмнэлгийн болон шинжлэх ухааны туршилтад хамруулахыг хориглох ёстой. Хамгаалах үүрэг гэдэг нь Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг төрийн өөрийнх нь болон төрийн бус аливаа этгээдийн дарангуйлал, тэр дундаа төрийн болон хувийн асрамжийн газарт хүнлэг бус, нэр төрийг нь доромжилсон нөхцөлд байлгахаас хамгаалах үүрэгтэй гэсэн үг болно. Хэрэгжүүлэх үүрэг гэдэг нь Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалахад чиглэсэн идэвхтэй арга хэмжээ авах ёстой гэсэн үг бөгөөд үүнд, жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээс мэдээлэл, мэдүүлэг авах зохистой арга хэлбэр эзэмшүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хоригдлуудтай хэрхэн харьцах талаар цагдаа нарт сургалт явуулах, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үйлчилдэг газруудын үйл ажиллагаанд хяналт мониторинг хийх зэрэг асуудал багтана. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хүчирхийллийн шинжтэй шийтгэл оногдуулахгүй байх, үе тэнгийнхнийх нь дарамт, хүчирхийллээс хамгаалахад чиглэсэн сургалтад багш нарыг хамруулах шаардлагатай.

## **ДАСГАЛ 6.2: Эрүү шүүлт, бусад хэлбэрийн хэрцгийллээс ангид байх эрхийн талаар ХБХЭК ямар баталгаа гаргасан бэ?**

**Зорилт:** ХБХЭК-ийн 15, 16 дугаар зүйлээс ойлгосноо бататгах

**Хугацаа:** 30 минут

**Хэрэглэгдэхүүн:** Том цаас, фломастер эсвэл самбар, шохой.

### **1. Бататгах**

Оролцогчдыг жижиг багуудад хуваагаад, баг болгонд ХБХЭК-ийн 15, 16 дугаар зүйлийн аль нэг хэсгийг онооно (16 дугаар зүйлийг дөрвөн хэсэгт хувааж болно). Багууд оногдсон хэсгээ энгийн үг хэллэгээр өөрчлөн найруулаад, уг эрхийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хэрхэн эдлэх, энэ нь тэдний амьдралд ямар нэмэр болохыг харуулсан жишээ боловсруулах даалгавар авна.

### **2. Энгийн үг хэллэгээр өөрчлөн найруулах/Жишээ гаргах**

15, 16 дугаар зүйлийн тодорхой хэсэг бүрийг чангаар уншиж өгөөд, тухайн хэсгийг багууд энгийн үг хэллэгээр хэрхэн өөрчлөн найруулсныг сонсоно. Хүн бүр санал нэгтэй



зөвшөөрсөн найруулга гартал хэлэлцүүлгээ үргэлжүүл. Дараа нь 15, 16 дугаар зүйлийн хялбаршуулсан найруулгын эцсийн хувилбарыг самбар дээр бич. Хэсэг болгоны энгийн найруулгыг бичсэний дараа тэрхүү эрхийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хэрхэн эдэлж болох, энэ нь тэдний амьдралд ямар нэмэр болохыг харуулсан жишээнүүдийг хэлүүл.

### 3. Хэлэлцэх

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах асуудлыг үндэсний хэмжээний бодлогын асуудал болгож тавих, мөн улс төрийн нам, шийдвэр гаргагчдад өргөн барих үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулахад ХБХЭК-ийн 15, 16 дугаар зүйлийг хэрхэн ашиглаж болох вэ?
- Шорон, асрамжийн газар болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хүчирхийлэл, дарангуйлалд өртөх магадлал ихтэй бусад орчинд нөхцөл байдал ямар байгаад хяналт мониторинг хийхэд 15, 16 дугаар заалтыг хэрхэн ашиглаж болох вэ?
- Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаарх нөлөөллийн үйл ажиллагаанд дээрх заалтыг хэрхэн ашиглаж болох вэ?

#### ШОРОНГИЙН НӨХЦӨЛ ДЭХ БИЕ МАХБОДЫН БОЛОН СЭТГЭЛ САНААНЫ НЭГДМЭЛ БАЙДАЛ

Төрөлх нэр төрийг нь хүндэтгэн хүнлэг харьцах нь эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүмүүсийн нэг эрх мөн болохыг олон улсын хүний эрхийн эрхзүйд заасан байдаг. **Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт** (ИУТЭОУП)-ын 10 дугаар зүйлд “эрх чөлөөгөө хязгаарлуулсан бүх хүнд хүмүүнлэг хандаж, хувь хүний төрөлх нэр төрийг нь хүндэтгэхтүн”<sup>9</sup> гэж уриалжээ. ИУТЭОУП-ын биелэлтийг хянадаг **НҮБ-ын Хүний эрхийн хорооны** Ерөнхий зөвлөмжийн **21-д** хоригдлууд “эрх чөлөөг нь хязгаарласнаас бусад зовлон, хязгаарлалтад өртөх ёсгүй”<sup>10</sup> гэжээ. Харин хөгжлийн бэрхшээлтэй хоригдлуудын эрхийн асуудлыг хүний эрхийг хамгаалагчид тусгайлан анхаарч байсангүй. Хөгжлийн бэрхшээлтэй хоригдлууд шоронд байх үедээ хүний эрх, нэр төрийг нь хүндэлсэн байр, орчин нөхцлөөр хангагдсан байх ёстой.

Эрүү шүүлт тулгах, хүчирхийлж харьцахыг хориглосон заалт нь шоронгийн удирдлагад ч мөн хамаарах бөгөөд бусад хоригдлуудын зүгээс гарч мэдэх хүчирхийллээс хөгжлийн бэрхшээлтэй хоригдлыг хамгаалах шаардлага тавигдана. Мөн энэ нь шорон дотор хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжилсон харьцаа, шийтгэл гэж тооцох орчин бий болохоос сэргийлэхийг шаардсан хэрэг юм. Төр, засгийн газрууд хоригдлуудын эрхийг хангахтай холбоотой олон улсын эрхзүйгээр хүлээсэн үүргээ хэрхэн хангах тухай тодорхой удирдамжийг НҮБ-ын системийн байгууллагуудын боловсруулсан олон улсын хүний эрхий баримт бичгүүдээс үзэж болно. Зарим тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хоригдол, саатуулагдсан хүний эрхийн талаар тодорхой удирдамж ч багтсан байдаг. Эдгээр баримт бичгийн тоонд Эдийн Засаг, Нийгмийн Зөвлөлөөс 1957 онд баталсан **Хоригдлуудтай харьцах НҮБ-ын минимум жишиг дүрэм**<sup>11</sup>, Ерөнхий Чуулганаас 1988

9 <http://www.ohchr.org/english/law/ccpr.htm> сайтаас үз.

10 <http://www1.umn.edu/humanrts/gencomm/hrcomm21.htm> сайтаас үз.

11 [http://www.unhchr.ch/html/menu3/b/h\\_comp34.htm](http://www.unhchr.ch/html/menu3/b/h_comp34.htm) сайтаас үз.

онд баталсан **Аливаа хэлбэрээр саатуулагдсан бүх хүмүүсийг хамгаалах зарчим**<sup>12</sup>, Ерөнхий Чуулганаас 1990 онд баталсан **Хоригдлуудтай харьцах ерөнхий зарчим**<sup>13</sup> зэрэг багтана. Хэдийгээр эдгээр баримт бичиг нь олон улсын гэрээ биш боловч хүний эрхийн заавал дагаж мөрдөх хуулиудыг тодорхой тайлбарласан нэр хүндтэй эх сурвалжууд юм.

Зэвсэгт мөргөлдөөний үед өөр нэг бие даасан боловч дээрхтэй уялдаа холбоотой эрхзүйн багц баримтыг ашигладаг бөгөөд эдгээр нь энгийн иргэдийг хамгаалах зорилготой. **Олон улсын хүмүүнлэгийн хууль** гэж нэрлэгддэг эдгээр хууль нь энгийн номхон иргэд болон байлдагч бус хүмүүсийн эрхийг хамгаалахад чиглэдэг. Эдгээр хуулийг **Дайны үед энгийн иргэдийг хамгаалах тухай Женевийн 4 дүгээр конвенцид** тусгасан байна<sup>14</sup>.

Хүний эрхийн идэвхтнүүд шоронд хүний эрх зөрчигдөж байгааг илрүүлж, олон тохиолдолд засаж залруулж чадсан байна. Жишээлбэл, “Хүний эрхийн ажиглагч” олон улсын байгууллага АНУ-ын шоронгуудад нийгэм-сэтгэцийн бэрхшээлтэй хоригдлуудын эрхийг ноцтой зөрчиж байгааг баримтжуулсан байна.<sup>15</sup> Саяхнаас хүний эрхийг хамгаалагчид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тусгай хэрэгцээг харгалзан үзэх асуудлыг тусгайлан анхаарч эхэлсэн бөгөөд зарим шоронгийн удирдлагууд нааштай хариу арга хэмжээ авч эхлээд байна. Жишээлбэл, Умард Ирландын Шоронгуудын алба хүний эрхийн зөвлөх авч ажиллуулахын зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст туслах хөтөлбөр боловсруулж, хорих камеруудад нэвтрэх боломжийг сайжруулах, оюуны болон сурах бэрхшээлтэй хоригдлуудад зориулан сургалтын хөтөлбөрүүдээ шинэчлэх, сонсголын бэрхшээлтэй болон дүлий хоригдлуудын харилцааны хэрэгцээг хангах чиглэлээр тодорхой арга хэмжээ авсан байна.<sup>16</sup>

### **ДАСГАЛ 6.3: Хөгжлийн бэрхшээлтэй хоригдол, саатуулагдсан хүмүүсийн эрхийг ойлгох нь**

<b>Зорилт:</b>	Шоронд хоригдсон, саатуулагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээний талаар ойлголттой болох
<b>Хугацаа:</b>	30 минут
<b>Хэрэглэгдэхүүн:</b>	Том цаас, фломастер эсвэл самбар, шохой.
<b>Нэмэлт хэрэглэгдэхүүн:</b>	6.1 дасгалаар боловсруулсан жагсаалт

12 [http://www.unhchr.ch/html/menu3/b/h\\_comp36.htm](http://www.unhchr.ch/html/menu3/b/h_comp36.htm) сайтаас үз.

13 [http://www.unhchr.ch/html/menu3/b/h\\_comp35.htm](http://www.unhchr.ch/html/menu3/b/h_comp35.htm) сайтаас үз.

14 <http://www.unhchr.ch/html/menu3/b/92.htm> сайтаас үз.

15 “Чадавхи муутай: Америкийн сэтгэцийн өвчтэй хоригдлууд болон хэрэгтнүүд” 2003. Хүний Эрхийн Байгууллага. <http://www.hrw.org/reports/2003/usa1003>

16 “Умард Ирландын Хөгжлийн Бэрхшээлтэй Хоригдлуудад зориулсан Үйлчилгээний төлөвлөгөө: 2007 оны 7 сараас 2010 оны 3 сар хүртэл.” Умард Ирландын Алба. [http://www.nio.gov.uk/nio\\_disability\\_action\\_plan\\_july\\_2007\\_march\\_2010.pdf](http://www.nio.gov.uk/nio_disability_action_plan_july_2007_march_2010.pdf)



## 1. Танилцуулах

Хөгжлийн бэрхшээлтэй хоригдлуудад хөгжлийн бэрхшээлтэй бусад бүх хүний нэгэн адилаар хөгжлийн бэрхшээлд нь нийцсэн тусгай нөхцөл бүрдүүлж өгөх шаардлагатай болохыг тайлбарла. Энэ асуудлыг ойлгохын тулд Европын хүний эрхийн шүүхээр шийдвэрлэсэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой хэргүүдийн тоймтой танилцахыг даалга (доорх хайрцагт өгсөн жишээ). 6.1 дасгалаар гаргасан жагсаалтаа ашиглан, эсвэл шинээр жагсаалт гаргаж хөгжлийн бэрхшээлийн янз бүрийн төрөл (жишээлбэл, харааны, хөдөлгөөний, сонсголын, нийгэм-сэтгэцийн зэрэг) мөн нийгмийн янз бүрийн бүлгүүд (жишээлбэл, эмэгтэйчүүд, хүүхэд, өсвөр насныхан, эрэгтэйчүүд, өндөр настнууд, дүрвэгсэд гэх мэт) байгааг дахин нэг сануул.

## 2. Хэлэлцэх

- Оролцогчдыг жижиг багуудад хуваагаад, жагсаалтаа ашиглан дараах даалгаврыг гүйцэтгүүл:
  - Шийтгэж болон саатуулан хорьж байгаа нөхцөл, хандлага нь хөгжлийн бэрхшээлтэй хүний байдалд хэрхэн нөлөөлж, түүнийг хүчирхийлэлд өртөх эрсдэлд учруулах нөхцөл болж болохыг харуулсан жишээ гарга
  - Шоронд хоригдож байгаа болон саатуулагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхэд заналхийлж болох аюулуудыг нэрлэ.

## 3. Шинжлэх

Дараах асуудлаар нэмэлт хэлэлцүүлэг хий:

- Шорон, саатуулах байранд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангахад чиглэсэн ямар арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж болох вэ?
- Урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй болгохын тулд хэн, хэнийг татан оролцуулах хэрэгтэй вэ?
- Энэ чиглэлээр бодитой өөрчлөлт гаргахад нөлөөллийн ямар арга хэмжээ тус болох магадлалтай вэ?



## **Их Британи улс хөгжлийн бэрхшээлтэй хоригдлуудын эрхийг зөрчиж байгааг Европын Хүний Эрхийн шүүх тогтоолоо**

2001 онд “Их Британи Улс иргэн Кийнаны эсрэг” хэргийг Европын хүний эрхийн шүүх хянаж үзээд, сэтгэц-нийгмийн хөгжлийн бэрхшээлтэй хоригдолтой хүнлэг бус, доромжилж харьцах, шийтгэхийг хориглосон 3 дугаар зүйл зөрчигдсэн болохыг тогтоожээ. Гянданд хоригдож байсан залуу камертаа боомилж амиа хорлосон байдалтай олджээ. Түүнд үзүүлсэн эмнэлгийн тусламж, түүний эрүүл мэндийн байдалд тавих хяналт сул байсныг шүүх тогтоожээ. Түүнийг тусгаарласан, мөн суллагдахаас нь есхөн хоногийн өмнө хорих хугацааг 28 хоногоор сунгасан зэрэг нь хоригдлын сэтгэл санааны болон бие махбодын тэсвэрлэх чадварт сөргөөр нөлөөлсөн байх магадлалтай тул энэ нь “шоронгийн нөхцөлд сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй харьцах стандартад нийцээгүй үйлдэл болсон” гэж шүүхээс дүгнэжээ.

“Их Британи улс иргэн Прайсын эсрэг” хэргийг 2001 онд Европын хүний эрхийн шүүх хянаж үзээд, саатуулагдаад байсан хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйн эрх зөрчигдсэн болохыг тогтоожээ. Гомдол гаргагч хөл гарын ажиллагаагүй, тэргэнцэртэй эмэгтэй байжээ. Тэрбээр нэг долоо хоног шоронд хоригдохдоо тэргэнцэр дээрээ унтаж байсан ба яаралтай эмнэлийн тусламж дуудах болон гэрэл асаах товчлуурт хүрэхгүй, жорлонд орж чадахгүй байсан гэж мэдүүлжээ. Эмэгтэй хуяг түүнийг өргөн жорлонгийн суултуур дээр суулгасан боловч гурван цаг гаруй тэнд нь орхисны эцэст тэрбээр эрэгтэй асрагчаас тусламж хүсэхэд хүрчээ. Эдгээр тохиолдол нь 3 дугаар зүйлээр доромжилсон харьцаа мөн гэж шүүх үзжээ.<sup>17</sup>

## **Хоригдож байгаа болон саатуулагдсан хүмүүсийн холбогдолтой олон улсын стандарт**

### **Хоригдлуудтай харьцах суурь зарчмууд**

- Хоригдлууд нь шоронгийн орчноос гадуурх эрүүл мэндийн үйлчилгээтэй дүйцэхүйц чанартай эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхтэй болохыг тунхагласан.

### **Аливаа хэлбэрийн хорих болон саатуулагдах арга хэмжээнд өртсөн бүх хүнийг хамгаалах зарчмууд**

- Шоронгийн удирдлага нь шинэ хоригдлуудыг эрүүл мэндийн үзлэгт оруулах, шаардлагатай бүх эмнэлгийн үйлчилгээ, эмчилгээг зохимжтой хэлбэрээр үнэ төлбөргүй хүргэх үүрэгтэй болохыг тунхагласан

17 “Европын Хүний Эрхийн шүүх – сэтгэцийн хөгжлийн бэрхшээлийн кейсүүд.” Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлийн асуудлаар зөвлөгөө өгөх төв. [www.mdac.info/resources/echr\\_cases.htm](http://www.mdac.info/resources/echr_cases.htm)

### **Минимум Стандарт дүрэм**

- Эмнэлгийн болон сэтгэцийн эрүүл мэндийн зохистой үйлчилгээ нь шоронгийн өдөр тутмын үйл ажиллагааны салшгүй хэсэг, засан хүмүүжүүлэх ажлын нэгэн зорилго мөн болохыг тунхаглажээ. “Эрүүл мэндийн үйлчилгээ нь .. хоригдлуудын засрал хүмүүжилд саад болж болох сэтгэцийн өөрчлөлт, согогыг... илрүүлэх, эмчлэхэд...чиглэнэ. Үүнд шаардлагатай сэтгэл мэдрэлийн бүхий л үйлчилгээг хангаж өгнө”.
- Сэтгэцийн өвчтэй хоригдлын хөгжлийн бэрхшээлийн төрөл, түвшинд нийцүүлэн орон байр, хяналтын арга хэлбэр, эрүүл мэндийн үйлчилгээнд өөрчлөлт хийхэд бэлэн байхыг уриалжээ. Шоронгийн сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээний ажилтнууд нь шаардлагатай үед хоригдолд сэтгэл мэдрэлийн эмчилгээ хийх үүрэгтэй.
- Хүний эрхийг хангах үүргээ биелүүлэхийн тулд шоронгууд нь зохих түвшинд бэлтгэгдсэн хангалттай тооны эрүүл мэндийн мэргэжилтэн авч ажиллуулах ёстой гэжээ. Сэтгэл мэдрэлийн эмчээс гадна шоронгууд мөн сэтгэл зүйч, нийгмийн ажилтан зэрэг мэргэжилтэнг боломжийнхоо хэрээр ажиллуулна. Хоригдлуудад зориулсан гэдэг шалтгаанаар эрүүл мэндийн үйлчилгээний стандартыг бууруулж болохгүй. “Хоригсон болон саатуулагдсан хүмүүсийн бие, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, эмчлэх үүрэг хүлээсэн эрүүл мэндийн ажилтнууд, ялангуяа дотрын эмч нар нь бусад хүмүүсийн хүртэж байгаагаас дутуугүй чанартай үйлчилгээ үзүүлэх ёстой.”
- Эмчилгээтэй холбоотой аливаа шийдвэр нь анагаах ухааны шалгуурт нийцсэн байх шаардлагатай болохыг заажээ. Олон улсын эмчийн ёс зүйд эмнэлгийн ажилтан нь “хоригдож байгаа хүмүүст боломжийн хамгийн сайн үйлчилгээ” үзүүлэх, асаргаа, эмчилгээний талаар ямар нэг шийдвэрийг зөвхөн хоригдлын эрүүл мэндийн хэрэгцээнд үндэслэн гаргах ба энэ хэрэгцээ нь эмнэлзүйн бус шинжтэй бусад асуудлаас дээгүүр тавигдах ёстой.
- Шоронд үзүүлэх сэтгэл мэдрэлийн зохистой эмчилгээ нь шоронгийн бус нөхцөлтэй адилаар хоригдол бүрт зориулсан эмчилгээний төлөвлөгөөнд суурилсан байхыг зөвлөжээ. Ийм эмчилгээ нь дуу, хөгжим, театр, биеийн тамир, ганцаарчилсан сэтгэлзүйн эмчилгээ, бүлгийн эмчилгээ зэрэг эмийн бус эмчилгээ, сэргээн засварлах үйл ажиллагааны хэлбэрүүдийг багтаана.
- Эмчлүүлэгсэд нь зохих хэмжээнд тоноглогдсон амралт чөлөөт цагийн өрөөг ашиглах, өдөр тутам гадаа салхинд гарах боломжтойн дээр суралцах, тохиромжтой ажил хийх боломжтой байх ёстойг хүлээн зөвшөөрсөн байна.<sup>18</sup>

18 “Чадавхи муутай: Америкийн сэтгэцийн өвчтэй хоригдлууд болон хэрэгтнүүд.” 2003. Хүний Эрхийн Байгууллага. [www.hrw.org/reports/2003/usa1003](http://www.hrw.org/reports/2003/usa1003)

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бэлгийн хүчирхийлэлд өртөх явдал маш их гарч байгааг удаа дараагийн судалгаа харуулсаар байна. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охид үүнд илүү өртдөг ч эрэгтэйчүүд, хөвгүүд ч мөн хүчирхийлэл, мөлжлөг, доромжлолд өртдөг ажээ. Судалгаанаас харахад хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн 50 орчим хувь нь хүүхэд насандаа, 30 орчим хувь нь насанд хүрсэн хойноо бэлгийн хүчирхийлэлд өртөж байжээ. Эдгээрийн ихэнхийг мэдээлдэггүй учир шийдэгдэхгүй өнгөрдөг. Хүчирхийлэл ихэнхдээ тэдний гэр орон, асрамжийн газар зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүнд аюулгүй гэж бидний төсөөлдөг газруудад гардаг ажээ.

Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг, доромжлол нь хөгжлийн бэрхшээлтэй хохирогчдод удаан хугацааны ноцтой сөрөг нөлөө учруулдаг. Ийм явдал тусгаарлагдсан орчинд гарвал хохирогчдод нөхөн сэргээх тусламж үзүүлэх магадлал тун бага. Түүгээр зогсохгүй ийм хямралт явдал нь хөгжлийн бэрхшээлээс үүдэлтэй хязгаарлалтыг нь улам даамжруулж, хоёрдогч хөгжлийн бэрхшээл үүсэх шалтгаан болж мэднэ. Бэлгийн хүчирхийллийн эсрэг хөтөлбөр, үйлчилгээ, ялангуяа охид, эмэгтэйчүүдэд зориулсан үйлчилгээ нь ихэнхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүрдэггүй тул хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалагчид эдгээр үйлчилгээ, хөтөлбөрийг бүгдэд хүртээмжтэй болгохын төлөө ажиллаж байна. Хүчирхийлэл гарахаас сэргийлэх нөлөөллийн үйл ажиллагаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүчирхийллээс ангид байх эрхийг хамгаалах, биеэ даан өөрийн хүсэл зоригоор амьдрах эрхийг хангахад чухал үүрэгтэй.

#### **ДАСГАЛ 6.4. Эрүү шүүлт болон бусад хэлбэрийн хэрцгийллээс ангид байх эрхийг дэмжих амлалт авах нь**

Хүний эрх гэдэг нь эдлэх эрх болон хүлээх үүргийн нэгдэл гэдгийг тайлбарла.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүү шүүлт болон бусад хэлбэрийн хэрцгийллээс ангид байх эрхийг судалж мэдсэний эцэст оролцогчид өөрсдөө тодорхой ажил хийх талаар юу бодож байгааг асуу.
- Мэдээлэл цуглуулах, ажлаа төлөвлөх гээд хийх зүйл их байгаа ч өөрчлөлт хийх чин эрмэлзэл маш чухал гэдгийг тэмдэглэн хэл.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрүү шүүлт болон бусад хэлбэрийн хэрцгийллээс ангид байх эрхээ бүрэн эдлэхэд нь нэмэр болох жижиг ч хамаагүй ямар ажлыг ирэх сард хийхийг хүсэж байгаа, хийх боломжтой байгааг оролцогч бүрээр хэлүүл.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах нөлөөллийн ажил хэрхэн төлөвлөх талаар “Хэсэг 3. Нөлөөлөл! Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа” (хуудас 278) хэсгээс уншина уу.

ЭРҮҮ ШҮҮЛТ БОЛОН БУСАД ХЭЛБЭРИЙН ХЭРЦГИЙЛЛЭЭС АНГИД БАЙХ ЭРХИЙН ТУХАЙ  
НЭМЭЛТ МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

- Хүний эрхийн байгууллага, “Чадавхи дутагдаж байна: Америкийн сэтгэцийн өвчтэй хоригдлууд болон хэрэгтнүүд” (2003):  
<http://www.hrw.org/reports/2003/usa1003>
- Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлийн талаар зөвлөгөө өгөх төв:  
<http://www.mdac.info/index.html>
- Олон улсын сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх:  
<http://www.mdri.org>
- Хөгжлийн бэрхшээлийг судлах дэлхийн институт. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүчирхийллийн үзүүлэх нөлөө (Марша Сакстон, 2006):  
<http://www.wid.org>

## **БҮЛЭГ 7: ХУВИЙН НУУЦ, НЭГДМЭЛ БАЙДАЛ, ОРОН БАЙР БОЛОН ГЭР БҮЛИЙГ ХҮНДЭТГЭХ НЬ**

### **НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци**

#### **17 дугаар зүйл. Хувийн нэгдмэл байдлыг хамгаалах**

Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүр бусдын нэгэн адил өөрийнхөө бие махбод болон сэтгэхүйн нэгдмэл байдлаа хүндэтгүүлэх эрхтэй.

#### **22 дугаар зүйл. Хувийн нууцыг хүндэтгэх**

1. Амьдран буй газар, орон байрны нөхцөл байдлаас нь үл шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байр буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд уг халдлага буюу өртөлтөөс хуулийн дагуу хамгаалагдана.
2. Оролцогч улсууд нь бусадтай адил тэгш байх эрхийн үндсэн дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн, эрүүл мэндийн болон нөхөн сэргээлтийн талаарх мэдээллийн нууцлалыг хамгаална.

#### **23 дугаар зүйл. Орон байр болон гэр бүлийг хүндэтгэх**

1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг гэрлэлт, гэр бүл, эцэг эх, төрөл садангийн харьцаанд бусадтай адил тэгш эрхийн үндсэн дээр алагчлах явдлыг устгах үр дүнтэй, шаардлагатай дараах арга хэмжээг авна:
  - а) гэрлэх насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй хүний гэр бүл болох эрхийг гэрлэх хүнийх нь бүрэн, чөлөөтэй өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр хүлээн зөвшөөрөх;
  - б) хөгжлийн бэрхшээлтэй хүн нь хүүхдийн тоо, хүүхэд төрүүлэх хоорондын зайг чөлөөтэй шийдвэрлэх, хариуцах эрхтэй бөгөөд насныхаа онцлогт тохирсон мэдээлэл, нөхөн үржихүй, гэр бүл төлөвлөлтийн боловсрол эзэмшиж, эдгээр эрхээ эдлэхэд нь шаардлагатай нөхцөл бололцоо болон үр удмаа үлдээх тэгш боломжоор хангагдах;
  - в) хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оролцуулан хөгжлийн бэрхшээлтэй бүх хүнийг бусадтай адил тэгш эрхийн үндсэн дээр үр удмаа үлдээх эрхээр хангах.
2. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асран хамгаалах, харгалзан дэмжих, итгэмжлэх, хүүхэд үрчлэх, эсхүл эдгээртэй ижил төрлийн арга хэмжээ хэрэв үндэсний хууль тогтоомжид тусгагдсан бол эдгээр арга хэмжээний хувьд эрх, үүргээр хангах бөгөөд ямар ч тохиолдолд хүүхдийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавина. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүүхэд өсгөхтэй холбогдсон үүргээ биелүүлэхэд нь зохих тусламжийг үзүүлнэ.

3. Оролцогч улсууд нь гэр бүлийн харилцаанд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тэгш эрхийг хангана. Энэхүү эрхийг хэрэгжүүлэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нууцлах, орхих, үл тоомсорлох, хөндийрүүлэхээс урьдчилан сэргийлэхийн тулд оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон тэдний гэр бүлийн гишүүдийг эхнээсээ л бүх талын мэдээллээр хангаж, үйлчилгээ болон туслалцаа үзүүлнэ.
4. Оролцогч улсууд нь холбогдох хууль тогтоомж, журмын дагуу тийнхүү хөндийрүүлэх нь хүүхдийн эрх ашигт хамгийн ихээр нийцэх тухай шүүхээр шийдвэрлэсний дагуу эрх бүхий зохих байгууллагаас тодорхойлохоос бусад тохиолдолд хүүхдийг өөрийнхөө хүсэл зоригоос гадуур эцэг эхээсээ тусгаарлагдахгүй байх эрхээр хангана. Ямар ч тохиолдолд эцэг эхийн аль нэг нь, эсхүл хоёулаа, эсхүл хүүхэд нь хөгжлийн бэрхшээлтэй гэх шалтгаанаар хүүхдийг эцэг эхээс нь тусгаарлаж болохгүй.
5. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үндсэн гэр бүл нь асран халамжлах боломжгүй тохиолдолд төрөл садангийн гэр бүлийн хүрээнд асран хамгаалуулах бүх төрлийн арга хэмжээг авах бөгөөд ийм арга хэмжээ үр дүнгүй болсон тохиолдолд тухайн оршин суугаа орчинд нь гэр бүлийн нөхцлийг бий болгож асран хамгаална.

## ЗОРИЛТУУД

Энэ бүлгийн сэдэв, үндсэн мэдээлэл, дасгалууд нь оролцогчдод дараах зорилтыг хангахад туслах зорилготой:

- Хувийн нууц, нэгдмэл байдал, орон байр, гэр бүлээ хүндлүүлэх эрхийг тодорхойлох;
- Эдгээр эрх нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд ямар ач холбогдолтой болохыг тайлбарлах;
- Эдгээр болон хүний бусад эрхийн хоорондын уялдааг ойлгох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эдгээр эрх хэрхэн хангагдаж, эсвэл зөрчигдөж байгааг мэддэг болох;
- Хувийн нууц, нэгдмэл байдал, орон байр, гэр бүлээ хүндлүүлэх эрхийн талаарх НҮБ-ын **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн** (ХБХЭК) холбогдох заалтуудыг ойлгох.

**ЭХЛЭЛ: ХУВИЙН НУУЦ, НЭГДМЭЛ БАЙДАЛ, ОРОН БАЙР, ГЭР БҮЛЭЭ ХҮНДЛҮҮЛЭХ ЭРХИЙН ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЭХ НЬ**

Нэг талаас улс төр, олон нийтийн үйл ажиллагааг багтаадаг нийгмийн амьдралын хүрээ, нөгөө талаас хувь хүний бие махбод, орон гэр, гэр бүлийн асуудлыг багтаадаг хувийн амьдралын хүрээ хоёрын хил хязгаарыг хаагуур татах талаар олон хүн удаан хугацааны туршид хэлэлцсээр, нэгдсэн шийдэлд хүрч чадахгүй маргасаар л байгаа билээ. Мөн дээрх

хүрээнүүдэд төр, хувь хүн хоёр хэдий хэмжээний эрх мэдэлтэй байх талаар ч маргасаар л байна. Энэ бүлэгт бид хувийн амьдралын хүрээг авч үзэн, хувийн нууц, хувь хүний нэгдмэл байдал, орон байр, гэр бүлээ хүндлүүлэх эрхийн тухай ярих болно.

## **Хувийн нууц ба хувь хүний нэгдмэл байдлыг хүндэтгэх нь**

Өнөө үед хувийн нууцыг хүндэтгэх эрх нь олон асуудлыг хамрах болсны дотор дараах зүйлс багтана:

- **Мэдээллийг нууцлах** эрх гэдэг нь хэн нэгэн хүн өөртэй нь холбоотой ямар мэдээллийг бусдад дамжуулах, тэрхүү “бусад” нь хэн байх вэ гэдгээ өөрөө шийдэх эрх юм. Үүнд тухайн хүний үзэл, бодол, хувийнх нь орчин гэж үндэслэлтэйгээр тооцогдох орчин нөхцөлд түүний хийдэг үйлдэл, мөн хувь хүний санхүүгийн болон эрүүл мэндийн байдалтай нь холбоотой мэдээллүүд орно.
- Мэдээллийг нууцлах эрхтэй холбоотой өөр нэг эрх бол **хувийн харилцаа холбооны халдашгүй байдал** юм. Энэ нь захидал, телефон утас, хувийн нүүр тулсан яриа, эсвэл электрон шуудан болон харилцааны бусад хэлбэрийг ашиглан хүмүүс хувийн харилцаанд орж байгаа тохиолдолд нууцыг хамгаалах асуудал юм. Өөрөөр хэлбэл, төр ч бай, хувь хүн ч бай таны хувийн яриаг чагнах, захидал харилцааг унших эрхгүй. Гэхдээ, жишээлбэл, хэн нэгнийг гэмт хэрэгт сэжиглэж байгаа тохиолдол зэрэг онцгой зарим нөхцөлд энэ эрхийг түдгэлзүүлэх явдал гарах нь мэдээж боловч ийм онцгой тохиолдолд ч гэсэн хөндлөнгийн аливаа оролцоо нь зайлшгүй шаардлагатай байх ёстойн дээр зохимжтой арга замаар хэрэгжиж байхад анхаарсан тусгай хууль, журмуудаар зохицуулагдсан байх ёстой.
- Хувийн нууцаа хамгаалуулах эрх нь хүний **хувийн орчин** буюу хүний орон байр, гэр бүл, түүнтэй хамт амьдардаг хүмүүс гэх мэт түүний амьдарч буй орчинтой юуны өмнө холбоотой ойлголт юм. Мөн энэхүү ойлголт нь хүний хувийн орчин гэж тооцогдох машин унаа, хувийн өмч зэрэгт хамаарна.
- Хувийн нууцаа хамгаалуулах эрхийн нэгэн хэсэг нь мөн **хүний нэр төр, алдар хүндэд халдахаас хамгаалуулах** эрх юм. Жишээлбэл, үнэн л биш бол таныг нийгэмд хүлээн зөвшөөрөгдөөгүй зан үйл болон нэр төрд тань халтай байж болох өөр бусад зүйлийг үйлдсэн хэмээн бусдад мэдэгдэх эрх хэнд ч байхгүй.

Хувийн нууц, хувийн нэгдмэл байдлаа хүндэтгүүлэх эрх нь хоёр тусдаа боловч хоорондоо уялдаатай зарчмууд юм. Учир нь хувийн нэгдмэл байдлыг зөрчихөд хүргэдэг үйлдэл, нөхцлүүд нь хувийн нууцаа хүндэтгүүлэх эрх зөрчигдсөнөөс үүдэлтэй юмуу түүнтэй зэрэгцэн илэрдэг. Нэгдмэл байдлаа хамгаалуулах эрхийн мөн чанар нь хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй хүний ёсоор харьцаж, бие махбод, сэтгэхүйн “бүрэн бүтэн” байдалд нь халдахгүй, хүндэтгэж харьцахад оршиж байгаа юм. Өөрөөр хэлбэл, бидний бие махбод болон сэтгэхүйд төрийн болон хувийн этгээдийн зүгээс ямар нэг хор хохирол учруулахаас бид бүгд хамгаалагдсан гэсэн үг юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдын адил хувийн нууц, нэгдмэл байдлаа хүндлүүлэх эрхтэй ч тэдний эдгээр эрх зөрчигдөх явдал их гардаг. Жишээлбэл, хувийн хэрэгцээгээ хангах, тодорхой ажил гүйцэтгэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүнд хувийн туслах юмуу асран хамгаалагчийн туслалцаа хэрэгтэй болдог. Улмаар эдгээр туслагч, асрагч нь хөгжлийн бэрхшээлтэй хүний бичиг баримтын дугаар, мөнгө санхүүгийн мэдээлэл зэрэг хувийн





олон төрлийн мэдээллийг олж мэдэх боломжтой байдаг. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг усанд ороход нь туслах зэргээр асрагч нар түүний биед хүрэх шаардлага гардаг. Асрагчид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нэгдмэл байдал, хувийн нууцыг нь хүндэтгэж харьцах ёстой бөгөөд мэргэжлийн асрагчид дийлэнхдээ мэргэжлийн ёс зүйг сахиж мөрддөг ч зөрчил буурахгүй л байна. Эдгээрийн дотор хөгжлийн бэрхшээлтэй хүний хувийн мэдээллийг буруу мэдээлэх, буруугаар ашиглах, санхүүгийн мэдээллийг нь ашиглан мөнгийг нь хулгайлах, эсвэл хэл амаар доромжлох, хүч хэрэглэх, сэтгэл санааны дарамтанд оруулах зэрэг явдлууд гарсаар байгаа юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хувийн халдашгүй байдал, хувийн нэгдмэл байдлаа хамгаалуулах эрхийг зөрчсөн эдгээр үйлдэл нь мөн түүний төрөлхийн нэр хүндийг гутаасан хэрэг мөн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хувийн халдашгүй байдал, нэгдмэл байдлаа хүндлүүлэх эрх зөрчигдөхөд хүргэдэг олон шалтгаан байдаг ч давамгайл нөлөөтэй нэг нь бусад хүмүүсийн хандлага, итгэл үнэмшил бөгөөд ялангуяа сэтгэцийн, сурах, эсвэл сэтгэц-нийгмийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх хандлагыг онцгойлох хэрэгтэй. Ийм төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хувийн мэдээлэлдээ эзэн болж “чадахгүй” гэж үздэгээс зарим нэг хүн үүнийг нь зохих газарт өгөхгүй, эсвэл өөрийнх нь хүсээгүй хүмүүст мэдээллийг тараах үйлдэл гаргадаг. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүнд өөрт нь мэдэгдэхгүй л бол тэдний хувийн нууц, бие махбод болон сэтгэхүйн нэгдмэл байдлаа хүндлүүлэх эрхийг зөрчиж болно гэж үзэх хүн ч таардаг. Түүгээр ч зогсохгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бодол, үзэл, зан үйлийг бусдын “хэвийн” гэж үздэг зүйлстэй нийцүүлэх хэрэгтэй гэсэн итгэл үнэмшлээр зарим хүн тэднийг хүчээр болон дарамт шахалтаар “эмчилгээнд” оруулах, эм уулгах зэргээр бие сэтгэхүйд нь урт богино хугацааны хор хохирол учруулж мэдэх үйлдэл хийдэг.

Зөрчлүүдийг илрүүлж арга хэмжээ авч байх нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн нууц, нэгдэл байдлаа хүндэтгүүлэх эрхийн баталгаа болохоос гадна эдгээр эрх нь бусад эрхээ эдлэхэд нөлөөлдөг тул чухал юм. Жишээлбэл, хүний нэгдмэл байдлаа хүндэтгүүлэх эрх зөрчигдсөн тохиолдлыг шалгаж арга хэмжээ авалгүй орхих юм бол энэ нь яваандаа эрүү шүүлт, хүчирхийлэл, доромжлолоос ангид байх эрхийн зөрчилд хүргэж ч болзошгүй. Нэгдмэл байдлаа хүндлүүлэх эрх нь зөрчигдсөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс үзэл, бодлоо илэрхийлэх эрх чөлөө, улс төр, нийгмийн амьдралд оролцох эрхээ эдлэх сэдэл, сонирхолгүй болж мэднэ. Мөн өөр бусад эрхийн зөрчлүүдээс үүдэн хувийн нууц, нэгдмэл байдлаа хүндэтгүүлэх эрх зөрчигдөж болно. Жишээлбэл, эрүүл мэндийн чанартай сайн үйлчилгээг хүртээмжтэй хүргэж чадахгүй бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь хувийн нууцыг чандлах баталгаа хангагдаагүй, мэдээллийн хяналт сул орчинд үйлчлүүлэх, эсвэл хүний нэгдмэл байдалд хүндэтгэлгүй ханддаг эмнэлгийн мэргэжилтнээр үйлчлүүлэхэд ч хүрч мэднэ. Шударга шүүхийн хүртээмж муу байвал хувийн нууц, нэгдмэл байдлаа хүндлүүлэх эрх нь зөрчигдсөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс шүүхээр асуудлаа шийдүүлэлгүй өнгөрч, ийм зөрчлүүд цаашид ч үргэлжлэх нөхцөл болдог байна.

## **Орон байр болон гэр бүлийг хүндлэх нь**

Хүний хувийн амьдралын хүрээний нэг хэсэг бол хүний гэр бүл, орон байр, тэдгээртэй холбоотой харилцаа билээ. Хэдийгээр “гэр бүл” гэдэг ойлголтын олон улсын нэгдсэн нэг тодорхойлолт байхгүй ч “нийгмийн жам ёсны бөгөөд суурь нэгж” гэж тооцож, ойлгож ирсэн.

Энэ утгаараа ч хэд хэдэн эрхээр хамгаалдсан байдаг бөгөөд эдгээр нь:

- “насанд хүрсэн” хосууд сайн дураараа харилцан бүрэн зөвшөөрсний үндсэн дээр гэрлэх эрх
- гэрлээд хамт амьдрах, гэрлэлтээ хууль ёсоор цуцлуулах явцад болон гэрлэлтээ цуцлуулсны дараа талууд адил тэгш эрх эдлэх
- “гэр бүл үүсгэх” эрхтэй, өөрөөр хэлбэл хамт амьдарч, хүүхэд төрүүлж өсгөх, улсын гэр бүл төлөвлөлтийн бодлогоос улбаалсан ялгаварлан гадуурхал, албадлагад өртөхгүй байх эрх
- улс төр, эдийн засаг болон бусад шалтгаанаар гэр бүлээсээ тусгаарлагдсан бол буцаж нэгдэх эрх
- гэр бүлээ нийгэм, төрөөр хамгаалуулах эрх зэрэг болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн халдашгүй дархан байх эрхийг зөрчсөн явдал их гардагийн нэгэн адилаар гэр бүл, орон байраа хүндлүүлэх эрхийн зөрчил ч их гардаг. Жишээлбэл, насанд хүрсэн хүн болгон гэрлэх эрхтэй ч хөгжлийн бэрхшээлтэй, ялангуяа сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүсийн гэр бүл болох эрхийг нь төрийн хууль, бодлого, практик дээр хязгаарлах явдал гардаг. Гэрлэхийг хүсэхгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бэлгийн амьдралаа өөрийн хүссэнээр зохиох, бэлгийн болон бусад төрлийн хувийн харьцаатай байх боломж олгохоос татгалзах явдал гардаг. Улсын албан ёсны бодлого тийм харилцааг хязгаарлаагүй байхад хүртэл хувийн дотны харилцааны талаарх шийдвэрээ гаргах, түүнийгээ хэрэгжүүлэхэд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст гэр бүлийнхэн, эрүүл мэндийн болон асрамжийн газрын ажилтнууд саад, хориг учруулахуйц зан үйл гаргадаг.

Эдгээр саад, хориг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэр бүлийн харилцаа, хариуцлагыг “зохицуулах чадваргүй”, үүнээсээ болоод өөртөө “хор хохирол учруулна” гэсэн бусдын хэвшмэл үзлээс үүдэлтэй. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь хөгжлийн бэрхшээлээ үр удамдаа дамжуулж болзошгүй, эсвэл хүүхдээ асарч өсгөж чадахгүй гэсэн үзэл бодлоос үүдэлтэй. Ийм хандлага, үзэл бодлууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрэгсдийг хүчээр үргүй болгох, хүүхэд гаргахгүй байхыг зөвлөн ухуулах, хөгжлийн бэрхшээлтэй жирэмсэн эмэгтэйчүүдэд төрөхийн өмнөх болон дараах зохистой үйлчилгээ үзүүлэхгүй байх зэрэг үйлдлийг төрөөс сайшаах, санхүүжүүлэхэд хүргэдэг.

Үүнээс гадна, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хүүхэд үрчилж авах, хууль ёсны халамжлагч, итгэмжлэгч болоход хөгжлийн бэрхшээлтэй гэсэн үндэслэлээр хязгаарлалт тавих явдал бас гардаг. Хэрэв хүүхэдтэй болсон бол төр, эсвэл хамаатан саднууд нь “хүүхдийнх нь сайн сайхны төлөө” эцэг эхээс нь салгах гэж шахалт үзүүлэх нь ч бий. Хүүхдийг хүчээр салгахгүй ч гэсэн хөгжлийн бэрхшээлтэй эх, эцгүүд хүүхдээ өсгөж бойжуулахад шаардлагатай бүх дэмжлэг, туслалцааг авч чаддаггүй. Үүнтэй нэгэн адилаар, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх ийм зөрчилтэй байнга тулгарч, гэр бүл болон хамтдаа байх өөрсдийнхөө болон хүүхдийнхээ эрхийн төлөө байнга тэмцэхэд хүрдэг. Тэднийг шаардлагатай туслалцаа, дэмжлэгээр дутаах, эсвэл хүүхдээ асрамжийн газар өг гэж шаардах явдал албан тушаалтнуудын зүгээс байнга гардаг байна.

Орон байр, гэр бүлээ хүндлүүлэх эрхийн эдгээр болон бусад зөрчлүүд нь хүний бусад эрхийн зөрчилд хүргэдэг. Жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг гэр бүлтэй нь амьдруулахгүй байх нь тэдний бие даан амьдрах, нийгмийнхээ дунд амьдрах эрхийг



зөрчиж буй хэрэг болно. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ч бусдын адил хэнтэй, хаана амьдрахаа өөрсдөө бие даан шийдэх эрхтэй. Үүнтэй адил, хүчээр үргүй болгох нь хөгжлийн бэрхшээлтэй хүний хүүхэдтэй байх эрхийг нь зөрчөөд зогсохгүй, мөн хүний нэр төрөө хүндлүүлэх эрхийг зөрчсөн хүчирхийлэл, доромжлолын нэг хэлбэр юм.

Хүний бусад эрхийн зөрчлүүд нь гэр бүл, орон байраа хүндлүүлэх эрхийн зөрчилд хүргэж болно. Жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүрэлцэхүйц амьжиргаатай байх, чанартай эрүүл мэндийн болон нөхөн сэргээх үйлчилгээ авах эрхийн зөрчил нь хоол тэжээлийн дутагдал, эрүүл мэндийн доройтол, үргүйдэл зэрэгт хүргэж болзошгүй. Хуулийн өмнө тэгш байх, мөн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдэлж чадахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хувийн амьдралынхаа хүрээнд ч шийдвэр гаргаж, түүнийгээ бусдад мэдэгдэн, шийдсэнээрээ амьдралаа зохион байгуулах боломжгүй болж ч мэднэ. Үүнтэй адил, мэдээлэл хүртээмжгүй нөхцөлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бэлгийн хөгжил, харилцаа, гэр бүл төлөвлөлт, халамжийн үйлчилгээ болон бусад олон асуудлаар мэдээлэл авах, судалж суралцах боломжоо хязгаарлуулна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн халдашгүй дархан байх, бүрэн бүтэн байдлаа болон гэр бүл, орон байраа хүндлүүлэх эрх нийлээд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст маш чухал ач холбогдолтой адил тэгш байх, төрөлхийн нэр төртэй амьдрах эрхийн үндэс суурь болдог. Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг боловсруулалцсан Элеанор Рузвельтийн хэлснээр хүний эрх нь “гэрт ойрхон жижиг газар”-аас эхэлж, “тэндээ л утга төгөлдөр байж, үйлчлэхгүй бол өөр хаана ч үйлчлэхгүй, утгагүй болно”.

### **ДАСГАЛ 7.1: Хувийн халдашгүй байдал, бүрэн бүтэн байдал болон орон байр, гэр бүлээ хүндлүүлэх эрхээ эдэлнэ гэж юуг хэлэх вэ?**

- Зорилт:** Хувийн халдашгүй байх эрх болон бүрэн бүтэн байдал, орон байр, гэр бүлээ хүндлүүлэх эрхээ эдлэхийн утга, учрыг ойлгох
- Хугацаа:** 40 минут
- Хэрэглэгдэхүүн:** Том цаас, фломастер эсвэл самбар, шохой.

#### **1. Санал солилцох/Хэлэлцэх**

Оролцогчдыг жижиг багуудад хуваагаад баг болгонд дараах жишээний нэгийг хуваарилж өг:

- Эмчид үзүүлэх
- Найздаа захиа бичих, утсаар ярих, электрон шуудангаар харьцах
- Банкаар үйлчлүүлэх
- Хүүхдийнхээ багштай уулзаж, сургалтын талаар ярих

Эдгээр жишээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст юу тохиолдож болох талаар хэлэлцэхийг баг болгонд даалга:

- Аль тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бүрэн дүүрэн оролцохын тулд хувийн халдашгүй байдал, бүрэн бүтэн байдал, гэр бүл, орон гэрээ хүндлүүлэх эрхээ эдлэх шаардлагатай вэ? Амьдралд тохиолддог жишээнүүдийг жагсаан бич.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ямар мэдээллээ нууцлахыг хүсэх вэ?

- Хүний бүрэн бүтэн байдал нь биеийн, эсвэл сэтгэл санааны, эсвэл бие, сэтгэл санааны хоёулангийн бүрэн бүтэн байдлыг хамрах уу?
- Жишээ бүрд хүний эрхийг хамгаалах үүргийг хэн хүлээх вэ?

## 2. Илтгэх

Баг болгоноос илтгэгч томилж, багаар хэлэлцсэн зүйлийг товч яриул.

- Өөр хоорондоо ялгаатай эдгээр тохиолдолын ижил төстэй тал нь юу вэ?
- Хүний өдөр тутмын амьдралын өөр ямар нөхцөл, тохиолдолд эдгээр асуудал хөндөгдөх вэ?
- Тийм нөхцөл байдалд хувийн халдашгүй байдал, бүрэн бүтэн байдлыг хамгаалах талаар хөгжлийн бэрхшээлтэй хүн юу хийх хэрэгтэй вэ?

## 3. Хэлэлцэх

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний хувийн халдашгүй, бүрэн бүтэн байдлыг хамгаалахын тулд ямар өөрчлөлт хийх хэрэгтэй вэ?

### Хувийн асрагчийн ёс зүй

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асардаг хүмүүс асруулагчийнхаа эрхийг хүндэтгэх зарчмыг баримтлах үүрэгтэй. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн асрагчийн ёс зүйн дүрэм байхгүй ч, Миссури мужийн Их сургууль, Колумбын Их сургуулийн Эрүүл мэндийн сургуулиас хамтран боловсруулсан дараах дүрэм үйлчлүүлэгчийн эрхийг эрхэмлэх зарчимд үндэслэжээ:

- Ажил олгогч/үйлчлүүлэгчийн арьсны өнгө, шашин шүтлэг, бэлгийн хандлага, бусад итгэл үнэмшлийг үл харгалзан түүний эрхийг хүндэтгэх;
- Ажил олгогч/үйлчлүүлэгч нь энэхүү хөдөлмөрийн харилцааны эзэн нь бөгөөд өөртөө хэрэгтэй туслалцаа дэмжлэгийн талаарх эцсийн шийдвэрийг гаргах эрхтэйг хүлээн зөвшөөрөх;
- Доромжлох, үл хайхрах, мөлжих аливаа үйлдлээс зайлсхийх;
- Өөрийн хүсэл сонирхлыг ажил олгогчийн/үйлчлүүлэгчийн хүсэл сонирхлоос дээгүүр тавихгүй байх;
- Ажил олгогчийн/үйлчлүүлэгчийн хувийн халдашгүй дархан байх эрхийг хамгаалах;
- Хэн нэгний чадваргүй, ёс зүйгүй, хууль бус үйлдэл нь ахуйн болон эрүүл мэндийн үйлчилгээ, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхүйц нөхцөл үүсвэл үйлчлүүлэгч болон олон нийтийг хамгаалах арга хэмжээ авах;
- Өөрийн үйлдэл, шийдвэрийн төлөөх хариуцлагыг бүрэн хүлээх;
- Гэрээр үйлчилгээ үзүүлдэг бол мэргэжлийн өндөр түвшинд үйлчлэх;
- Бусдаас зөвлөгөө авах, хариуцлага хүлээхээр зөвшөөрөх, бусдад үүрэг хариуцлагаа шилжүүлэх нөхцөлд үнэн зөв мэдээлэлд үндэслэн үнэлгээ дүгнэлт өгөх, хувь хүний болон мэргэжлийн мэдлэг чадвараа дайчлах зэрэг шалгуурыг баримтлах;



- Өндөр чанартай үйлчилгээ үзүүлэх боломжийг дэмжсэн хөдөлмөрийн орчин нөхцөл бий болгох, хадгалахыг хичээх;
- Олон нийтийг буруу мэдээлэл, буруу ойлголтоос хамгаалахад хүчин чармайлт гаргаж, гэрийн үйлчилгээнд нэр төр, шударга ёс, үнэнч байдлын зарчмуудыг баримтлах.<sup>1</sup>

## **ДАСГАЛ 7.2: Хувийн халдашгүй дархан байдал, бүрэн бүтэн байдал, орон байр, гэр бүлээ хүндлүүлэх эрхээ хүндэтгүүлэхэд учирдаг саад бэрхшээлийг мэдэх, ойлгох**

- Зорилт:** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн халдашгүй дархан байдал, бүрэн бүтэн байдал, орон байр, гэр бүлээ хүндлүүлэх эрхийн хэрэгжилтэд учирдаг саад бэрхшээлийн талаар мэдлэг, ойлголттой болох
- Хугацаа:** 40 минут
- Хэрэглэгдэхүүн:** Дасгал 1-д боловсруулсан жагсаалт

### **1. Шинжлэх**

Оролцогчдыг ганцаараа юмуу хосоор нь ажиллуулж, эхний дасгалаар гаргасан жагсаалт, мөн дээрх хэлэлцүүлгээр гаргасан санаануудаас нэг жишээ сонгон авч, хөгжлийн бэрхшээлтэй хүнд хувийн халдашгүй дархан байдал, бүрэн бүтэн байдал, орон байр, гэр бүлээ хүндлүүлэх эрхээ эдлэхэд учирч болох саад бэрхшээлийг үнэлэх дасгал хийлгэнэ.

### **2. Дүрд тоглох**

Оролцогчид дүн шинжилгээнийхээ үр дүнг танилцуулаад дор хаяж нэг жишээг дүрийн тоглолтоор үзүүлнэ.

**Нөөц хувилбар:** Эдгээр саад бэрхшээлийн хамгийн хүнд хэцүү болон хамгийн энгийн жишээг дүрийн тоглолтоор харуулаад, тухайн саад тотгорыг даван туулах/ арилгах арга замыг олох даалгавар өгнө.

### **3. Хэлэлцэх**

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хувийн халдашгүй дархан байдал, бүрэн бүтэн байдал, орон байр, гэр бүлээ хүндлүүлэх эрхээ эдэлж чадахгүй бол ямар хор уршиг гарах вэ? Тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүнд? Нийгэмд нийтэд нь?
- Аль саад бэрхшээл нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хамгийн ноцтой уршиг дагуулах вэ?
- Эдгээр хүнд хэцүү саад тотгорыг арилгахын тулд ямар арга хэмжээ авах ёстой вэ?

<sup>1</sup> “Бие даасан байдлыг бэхжүүлэх нь: Хувийн туслалцаа үзүүлэх ажилтанд зориулсан гарын авлага”, 1995. Нуруу нугасны гэмтлийг загварчлах систем (*Missouri Model Spinal Cord Injury System*), Миссури мужийн Их сургууль, Колумбын Их сургуулийн Эрүүл мэндийн сургууль . <http://www.umshp.org/hp/resources/sci/atmanual/atman2.shtml>

## **Хөгжлийн бэрхшээлтэй зорчигчдын хувийн халдашгүй байдал, бүрэн бүтэн байдлыг хангах нь**

Терроризмаас сэргийлэх, аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоор агаараар зорчиход тавих хязгаарлалт, хяналт сүүлийн жилүүдэд улам нарийн болж, онгоцны буудал дахь аюулгүй байдлын шалгалт илүү чангаран зорчигчдын зарим хувцсыг нь тайлуулж, ачааг нь онгойлгож үздэг болсон. Ийм нэгжлэгийн үйл явц, тэдгээрийг гүйцэтгэдэг хил, гаалийн ажилчид хөгжлийн бэрхшээлтэй хүний тусгай хэрэгцээг үл хайхарсан байдгаас болж хөгжлийн бэрхшээлтэй зорчигчдын эрх зөрчигдөж магадгүй гэж АНУ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд үзэж байна.

Эдгээр асуудлыг шийдэхийн тулд Хөгжлийн бэрхшээлийн асуудлаарх Үндэсний Хороо, Холбооны нислэгийн удирдлага, Тээвэр хамгааллын алба (ТХА), хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгэмлэгүүд хамтран хөгжлийн бэрхшээлтэй зорчигчдын эрх, аюулгүй байдлын талаар удирдамж гарган, сургалт явуулжээ. Сургалтын зорилго нь аюулгүйн албаныханд хөгжлийн бэрхшээлтэй зорчигчдын эрх, хэрэгцээний талаар мэдээлэл, мэдлэг олгож, удирдамжийг ойлгож, хэрэгжүүлэхэд дэмждэг үзүүлэх явдал байв. Хөгжлийн бэрхшээлтэй зорчигчдыг эрхээ мэддэг болоход нь туслахын тулд ТХА веб хуудсандаа тэдэнд зориулан аюулгүй байдалтай холбоотой мэдээлэл тавьжээ. Эрхээ зөрчигдсөн гэж үзсэн зорчигчид ТХА-ны Иргэний эрхийн албанд хандах боломжтой болжээ. Удирдамжид багтсан зарим эрх, үүргийг доор дурьдав:

- Биед нэгжлэг хийх шаардлага гарсан тохиолдолд зорчигч өөрөө нийтэд ил газар байх, эсвэл тусгай өрөөнд орохоо сонгож болно. Энэ хоёр боломжийг хоёуланг эсэргүүцвэл таныг онгоцонд оруулахгүй.
- Таны биед нэгжлэг хийх явцад хувцсаар далдалсан эрүүл мэндийн аппаратыг ил гаргахуйцаар хувцсыг чинь сөхөх шаардлагатай бол нэгжлэг эхлэхээс өмнө танд тусгай өрөөнд орж болох тухай сануулах ёстой.
- Биед нэгжлэг хийж байх явцын ямар ч үед та тусгай өрөөнд орох хүсэлт тавьж болно.
- Та хэрэгтэй гэж үзвэл хамт яваа хүн, туслагч, гэр бүлийн хүнээр нэгжлэгийн явцад туслуулж болно. Энэ тохиолдолд танд тусалсан хүнийг дахин шалгах болно.
- Төмөр илрүүлэх хаалга дундуур гарах, эсвэл гар төмөр илрүүлэгчээр шалгуулахын оронд та биедээ тэмтрэх үзлэг хийлгэхээр сонгож болно. Үүнийхээ шалтгааныг та тайлбарлах албагүй.
- Хэрэв танд бусдаас далдлахыг хүсэж байгаа хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн өөрчлөлт, протез байгаа бол түүнийгээ аюулгүйн албаны ажилтанд мэдэгдэж нэгжлэг хийх явцдаа ил гаргахгүй байхыг хүсэж болно.<sup>2</sup>

2 “Шалгах явцад анхаарах зүйлс: хөгжлийн бэрхшээлтэй, эрүүл мэндийн онцгой нөхцөлтэй зорчигчид.” Тээврийн аюулгүй байдлын алба.  
[http://www.tsa.gov/travelers/airtravel/specialneeds/editorial\\_1567.shtm](http://www.tsa.gov/travelers/airtravel/specialneeds/editorial_1567.shtm)



ХУВИЙН ХАЛДАШГҮЙ БАЙДАЛ, БҮРЭН БҮТЭН БАЙДАЛ, ОРОН БАЙР, ГЭР БҮЛЭЭ ХҮНДЛҮҮЛЭХ ЭРХИЙН ТАЛААР ХҮНИЙ ЭРХИЙН ЭРХЗҮЙД ЮУ ГЭЖ ЗААСАН БАЙДАГ ВЭ?

**Хүний эрхийн түгээмэл тунхаглалын (ХЭТТ)** 12 дугаар зүйлд хувийн халдашгүй байдлаа хадгалах эрхийн асуудлыг авч үзэн, нэр төр, алдар хүндэд дураар халдах, хөндлөнгөөс оролцохоос сэргийлсэн хамгаалалтыг оруулж өгсөн байна. Тунхаглалын 16 дугаар зүйлд гэр бүл болох, гэр бүл үүсгэх эрх, нийгэм, төрөөс гэр бүлийг хамгаалах тухай заажээ. Үүнтэй ижил утгатай заалт **Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын (ИУТЭОУП)**<sup>3</sup> 17, 23 дугаар зүйлд, мөн **Цагаач ажилчид болон тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай конвенцийн (ЦАГБГХОУК)**<sup>4</sup> 14, 44 дүгээр зүйлд мөн байдаг. **Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад (ЭЗНСЭОУП)**<sup>5</sup> хувийн халдашгүй байдал, бүрэн бүтэн байдлын талаар тодорхой заагаагүй боловч (эдгээр нь иргэний болон улс төрийн эрх учир) 10 дугаар зүйлд “гэр бүл нь нийгмийн жам ёсны суурь нэгж” болох утгаар нь төрөөс хамгаалж дэмжих ёстой гэж дурьдсан байдаг. Үүнтэй адилаар, **Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенци (ЭАБХУК)**<sup>6</sup> -д хувийн халдашгүй байдалтай холбоотой тодорхой заалт ороогүй ч 16 дугаар зүйлд гэрлэлт, мөн хэдэн хүүхэд хэдэн жилийн зайтай төрүүлэхээ шийдэх зэрэгт эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эрхтэй байна гэж заасан байдаг.

**Хүүхдийн эрхийн конвенцийн (ХЭК)**<sup>7</sup> 16 дугаар зүйлд хүүхдийн “хувийн болон гэр бүлийн амьдрал, орон гэр болон захидал харилцааг хөндлөнгийн оролцооноос ангид байлгах”, “нэр төр, алдар хүндийг хууль бус халдлагаас хамгаалах” тухай заалтууд оржээ. ХЭК-д гэр бүлийн холбогдолтой олон заалт байдаг ч хүүхдийн эрх ашгийг хамгаалахын тулд өөр арга зам байхгүй нөхцлөөс өөр тохиолдолд хүүхдийг эцэг эхээс нь тусгаарлахгүй байх тухай өгүүлсэн 9 дүгээр зүйл хамгийн чухал нь юм. Мөн 23 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг онцгойлон тусгахдаа тэднийг өсгөж байгаа гэр бүл, асран халамжлагчдад шаардлагатай бүхий л туслалцаа, дэмжлэг үзүүлэх талаар жич заасан байдаг.

Хүний эрхийн эдгээр баримт бичигт “хүний бүрэн бүтэн байдал” гэж шууд нэрлээгүй ч “хувь хүний халдашгүй байдал”, “хувь хүний аюулгүй байдал” зэрэг ойролцоо зарчмуудыг эрх чөлөөг хязгаарлахгүй байх, хүний “төрөлхийн нэр хүнд”-ийг хамгаалах зэрэг ойлголттой холбож тайлбарласан байдаг. Харин, заавал дагаж мөрдөх албагүй **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боломжийг тэгшитгэх тухай НҮБ-ын стандарт дүрмүүд (Стандарт дүрмүүд)**<sup>8</sup>-д хүний нэр төрийн талаар, тэр дундаа гэр бүлийн амьдралын хүрээнд энэ асуудлыг хамруулан онцолжээ. 9 дүгээр дүрмийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гэр бүлийнхээ амьдралд бүрэн оролцох эрх, хувийн бүрэн бүтэн байдлаа хадгалах эрхийг хөхиүлэн дэмжих шаардлагатайг заагаад, “бэлгийн харилцаа, гэрлэлт, эцэг эх болох зэрэг асуудлаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хуулиар ялгаварлан гадуурхахгүй байхыг” онцолсон байдаг. Энэ Зүйлд мөн

3 [www.unhchr.ch/html/menu3/b/a\\_ccpr.htm](http://www.unhchr.ch/html/menu3/b/a_ccpr.htm) сайтыг үз.

4 [www.ohchr.org/english/la](http://www.ohchr.org/english/la) сайтыг үз.

5 [www.unhchr.ch/html/menu3/b/a\\_cescr.htmw/cmw.htm](http://www.unhchr.ch/html/menu3/b/a_cescr.htmw/cmw.htm) сайтыг үз.

6 [www.un.org/womenwatch/daw/cedaw/](http://www.un.org/womenwatch/daw/cedaw/) сайтыг үз.

7 [www.unicef.org/crc/](http://www.unicef.org/crc/) сайтыг үз.

8 [www.un.org/esa/socdev/enable/dissre00.htm](http://www.un.org/esa/socdev/enable/dissre00.htm) сайтыг үз.



хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бэлгийн болон бусад төрлийн хүчирхийлэл, халдлагыг таньж ялгадаг, сэргийлдэг, арга хэмжээ авч чаддаг болгоход чиглэсэн мэдээлэл өгөх, сургалт хийх шаардлагатайг дурьджээ. Үүнээс гадна, 13 дугаар дүрэмд “мэдээлэл, судалгаа хийх, тэдгээрийг түгээх явцад хувь хүний халдашгүй байдал, бүрэн бүтэн байдлыг хамгаалах” хэрэгцээг тодотгон заасан байдаг.

Эдгээр баримт бичигт тусгагдсан бүх зарчим, хандлагууд **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци** (ХБХЭК)-ийн үндэс болдог. 17 дугаар зүйлд (Хүний бүрэн бүтэн байдлыг хамгаалах) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бие, сэтгэлийн бүрэн бүтэн байдлаа бусад хүмүүсийн адил хамгаалуулах эрхтэйг тодорхой заасан байдаг. **Америк тивийн Хүний эрхийн конвенцийн**<sup>9</sup> 5(1) дүгээр зүйлийн “хүнлэг харьцах эрх” зэрэг бүс нутгийн хүний эрхийн зарим хуулийн хэллэг, нэр томъёог энэ конвенцид ашигласан юм.

Хувийн халдашгүй байдлаа хүндлүүлэх эрхийн асуудалд ХБХЭК-ийн 22 дугаар зүйлийг (Хувийн халдашгүй байдлыг хүндэтгэх) бүхэлд нь зориулсан бөгөөд энэ Зүйл нь “хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох”, мөн “хүний нэр төр, алдар хүндэд” хууль бусаар халдахаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалж байхаар заажээ. Энэ Зүйлд, жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эд зүйлсэд цагдаа хууль ёсны нэгжлэг хийхийг хориглоогүй ч дур зоргоор, хууль бус нэгжлэг хийх, мөрдөлт явуулахыг хориглосон байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн халдашгүй байдлаа хадгалах эрх нь онцгой чухал эрх болохыг 22 дугаар зүйл онцлоод, энэ эрхийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “амьдардаг байр, амьдралын хэв шинж”-ээс үл хамааран хамгаална гэж үйлчлэх хүрээг нь өргөтгөхийн зэрэгцээ халдашгүй байдлын зөрчил олон гардгаараа түүхэнд цуутай асрамжийн газруудыг ч мөн хамруулахаар заажээ.

“Харилцааны бусад хэлбэр”-ийг тайлбарлахдаа дээрх заалт “захидал харилцаа” гэдэг нэр томъёоны уламжлалт утгыг өргөжүүлэн өөрчлөхийг зорьсныг дурьдах хэрэгтэй. Хуулийн төсөл боловсруулсан зарим хүмүүс “захидал харилцаа” гэдгийг “захиа” гэсэн явцуу утгаар нь ойлгодог тул конвенцийн хүрээнд энэ нэр томъёонд мөн цахим шуудан, гар утасны мессэж зэрэг харилцаа холбооны орчин үеийн болон ирээдүйн хэлбэрүүдийг багтаах хэрэгтэй гэж үзэж байв. Эцэст нь, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдийн хувийн, эрүүл мэндийн байдал болон нөхөн сэргээлттэй холбоотой мэдээллийг бусадтай адил тэгш хамгаалуулах эрхтэй гэдгийг 22 дугаар зүйл цохон тэмдэглэжээ. Энэ санааг 31(1) дүгээр зүйлийн (а) (Статистикийн болон бусад мэдээлэл цуглуулах) хэсэгт дахин онцолж, статистик болон бусад судалгааны мэдээ цуглуулах явцдаа “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн халдашгүй байдлыг хүндэтгэх, хамгаалах” үүргийг төр хүлээнэ гэж заажээ.

Гэр бүл, орон байраа хүндлүүлэх эрхийг ХБХЭК-ийн 23 дугаар зүйл дэлгэрүүлэн авч үзжээ. Гэрлэлт, гэр бүл, эх эцэг болох зэрэг асуудлаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг түүхэнд байнга ялгаварлан гадуурхаж ирсэн учир эдгээр тохиолдлыг 23 дугаар зүйлд нэг бүрчлэн тусгасан байдаг. Тухайлбал:

- **23(1)(а) зүйлээр** хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн чөлөөтэй бөгөөд өөрөө бүрэн зөвшөөрсний үндсэн дээр гэрлэх, гэр бүл болох эрхийг хамгаалдаг.

9 [www1.umn.edu/humanrts/oasinstr/zoas3con.htm](http://www1.umn.edu/humanrts/oasinstr/zoas3con.htm) сайтыг үз.

- **23(1)(б) зүйлээр** хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэзээ, хэдэн жилийн зайтай, хэдэн хүүхэдтэй болох шийдвэр гаргах эрхийг хамгаална. Мөн, эдгээр асуудлаар бүрэн дүүрэн мэдээлэлд үндэслэн шийдвэр гаргах боломж олгох үүднээс “насныхаа онцлогт тохирсон мэдээлэл, нөхөн үржихүй, гэр бүл төлөвлөлтийн боловсрол” эзэмших эрхийг хангаж өгчээ.
- **23(1)(в) зүйлээр** хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хүмүүсийн “бусадтай адил үр удмаа үлдээх тэгш эрх”-ийг хамгаалж өгчээ. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хүмүүсийг хүчээр үргүй болгохыг хориглоод зогсохгүй нөхөн үржихүйн чадавхиа хадгалан, хамгаалахад шаардлагатай эрүүл мэндийн үйлчилгээ, хоол тэжээл, бусад боломжоор хангагдсан байх ёстой гэсэн утга агуулгатай заалт юм.
- **23(2) зүйл** нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусад хүмүүсийн нэгэн адил хүүхэд үрчилж авах, хүүхдийн асран хамгаалагч, харгалзан дэмжигч, итгэмжлэгч нь байх эрхийг баталгаажуулж өгчээ. Өөрөөр хэлбэл, зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй гэсэн үндэслэлээр хүүхэд үрчилж авах, хүүхдийн халамжлагч, итгэмжлэгч, асрамжлагч, хариуцагч байх эрхийг хязгаарлаж болохгүй ажээ. Цаашилбал, хөгжлийн бэрхшээлтэй эцэг эхчүүдэд хүүхдээ хүмүүжүүлж, өсгөхөд шаардлагатай юмуу хүссэн тусламжаа шаардлагатай хэмжээгээр үзүүлж байх үүргийг төрд хүлээлгэжээ.
- **23(3) зүйл** нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн зарим эрх, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нууцлах, орхих, үл тоомсорлох, нийгмээс тусгаарлахгүй байх, хамгаалагдах эрхийг заажээ. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэднийг өсгөж байгаа гэр бүлд нь мэдээлэл, үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх үүргийг төр хариуцна гэж заасан байдаг.
- **23(4) зүйл нь** хүүхдийн эрх ашигт хамгийн ихээр нийцэх тухай шүүхээр шийдвэрлэсний дагуу эрх бүхий зохих байгууллагаас тодорхойлохоос бусад тохиолдолд хүүхдийг өөрийнх нь хүсэл зоригоос гадуур эцэг эхээс нь тусгаарлахгүй байх тухай заажээ. Мөн цаашлаад, хүүхдийн эх, эцгийн аль нэг нь юмуу хоёулаа, эсвэл хүүхэд өөрөө хөгжлийн бэрхшээлтэй гэдэг үндэслэлээр хүүхдийг эцэг эхээс нь салгаж болохгүй гэж заасан байна.
- **23(5) зүйл** нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үндсэн гэр бүл нь асран халамжлах боломжгүй тохиолдолд хэрхэх талаар заажээ. Ийм тохиолдолд хүүхдийн асаргаа, хүмүүжлийг “төрөл садангийн гэр бүлийн хүрээнд”, хэрэв энэ боломжгүй бол “тухайн оршин суугаа орчинд нь гэр бүлийн орчныг бий болгох” замаар хамгаалуулах бүх төрлийн арга хэмжээ авах үүргийг төрд оноожээ. Энэ заалт нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асрамжийн газарт үг дуугүй хүлээлгэж өгдөг олон оронд хэрэглэгддэг практикаас сэргийлэхийг зорьжээ.

Ерөнхийдөө, хувийн халдашгүй байдал, бүрэн бүтэн байдал, орон байр, гэр бүлээ хүндлүүлэх эрхтэй холбоотойгоор төр дараах үүрэг хүлээнэ:

1. **Хүндэтгэх үүргийн** хүрээнд дээрх эрхийг эдлэхэд саад учруулах аливаа үйлдэл, зан заншил, практик ажиллагааг хэрэглэхээс татгалзах (жишээ нь, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гэр бүл болох, эх, эцэг болох эрхийг хязгаарлахаас татгалзах)
2. **Хамгаалах үүргийн** хүрээнд энэ эрхийг төрийн, эсвэл хувийн хэвшлийн этгээд зөрчихгүй байх баталгааг хангах (жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрүүл мэндийн болон нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэгчдийг хянах, зохицуулалт хийх замаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн мэдээллийн нууцыг хамгаалах)

3. **Хэрэгжүүлэх үүргийн** хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст энэ эрхээ эдлэх боломжийг хангахад чиглэсэн бүхий л нааштай арга хэмжээг авах (үүнд, хөгжлийн бэрхшээлтэй эх, эцэг, хүүхэд гэр бүлдээ байх боломж нөхцлийг хангахад чиглэсэн дэмжлэг, туслалцаа мөн багтана).

Товчоор хэлэхэд, олон улсын хүний эрхийн эрхзүй нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хувийн халдашгүй байдал, бүрэн бүтэн байдал, гэр бүл, орон байраа бусадтай адил хэмжээнд хүндлүүлэх эрхийг хамгаалж, энэ эрхээ бүрэн дүүрэн эдлэхэд нь туслах чиглэл баримталж байгаа юм.

### **ДАСГАЛ 7.3: Хувийн халдашгүй байдал, бүрэн бүтэн байдал, орон байр, гэр бүлээ хүндлүүлэх эрхийг ойлгох нь**

- Зорилт:** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн нууц, бүрэн бүтэн байдал, нэр төр, орон байр, гэр бүлээ хүндлүүлэх эрхийн талаарх ХБХЭК-ийн заалтуудыг судалж, ойлгох
- Хугацаа:** 45 минут
- Хэрэглэгдэхүүн:** Том цаас, фломастер эсвэл самбар, шохой.

#### **1. Бататгах**

Оролцогчдыг жижиг багуудад хуваагаад 17, 22, 23 дугаар зүйлүүдийн аль нэг хэсгийг хэлэлцэх даалгавар өг. Тухайлбал, уг хэсэгт ямар нөхцөл байдлыг хангасан байхыг шаардсан байна вэ? Үүнийг хэн хариуцах вэ? Хэрэгжүүлэхэд ямар саад бэрхшээл гарч болох, тэдгээрийг хэрхэн даван туулах вэ?

#### **2. Хэлэлцэх**

Багууд хэлэлцүүлгийнхээ дүнг танилцуулна.

#### **3. Жишээ гаргах**

17, 22, 23 дугаар зүйлийн заалт тус бүрийг 7.1, 7.2 дугаар дасгалуудад ярилцсан бодит амьдралын жишээн дээр хэрхэн хэрэглэж болох талаар асуу.

#### **4. Хэлэлцэх**

ХБХЭК-ийн 17, 22, 23 дугаар зүйлүүдийг хөгжлийн бэрхшээлийн талаар үндэсний бодлого, улс төрийн намууд болон шийдвэр гаргагчдад өргөн барих зөвлөмжид хэрхэн ашиглаж болох вэ? Танай улсад энэ нь ямар утга холбогдолтой байх вэ?



## Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувийн халдашгүй байдал

НҮБ-ын Хүүхдийн Сангийн веб хуудсанд тавигдсан дараах тоон мэдээллээс харахад бие махбодын болон сэтгэл санааны бүрэн бүтэн байдлаа хүндлүүлэх эрх, бусад эрхээ эдлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд гэр бүл дотроо болон гадуур орчинд олон ноцтой саад тотгортой тулгарсаар байна:

- Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд хүчирхийлэлд онцгой өртөмтгий байдаг. Энэтхэгийн Ориссад хийсэн нэгэн жижиг судалгаанд хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд бараг бүрдээрээ гэртээ зодуулдаг, оюуны бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн 25 хувь нь бэлгийн хүчирхийлэлд өртсөн, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн 6 хувийг хүчээр үргүй болгосон зэрэг баримт дурьдагджээ.
- Орон гэргүй тэнэмэл залуучуудын 30 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй байна.
- Их Британий Олон улсын хөгжлийн агентлагийн мэдээлснээр, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 20 хувиас бага болж буурсан хөгжиж буй орнуудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эндэгдэл 80 орчим хувьтай байх магадлалтай ажээ. Хүүхдийг хогийн ургамал адил устгаж байгаа мэт сэтгэгдэл төрснөө тус яам нэмж хэлжээ.
- Англид 2004 онд хийсэн судалгаанаас харахад хүчирхийлэлд өртөх магадлал хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд илүү өндөр бөгөөд ийм тохиолдолд цагдаагийн оролцоо, хуулийн хамгаалалт, сэргийлэх туслалцаа авах найдвар хамаагүй бага байдаг байна.
- Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бусад хүүхдээс дунджаар 1,7 дахин илүү өртөж байгааг судалгаа харуулж байна.<sup>10</sup>

### ДАСГАЛ 7.4: Хувийн халдашгүй байдал, бүрэн бүтэн байдал, орон байр, гэр бүлээ хүндлүүлэх эрхийг дэмжих амлалт авах нь

Хүний эрх нь эдлэх эрх, хүлээх үүргийн нэгдэл гэдгийг тайлбарла.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн халдашгүй байдал, бүрэн бүтэн байдал, орон байр, гэр бүлээ хүндлүүлэх эрхийн талаар судалж мэдсэний эцэст оролцогчид өөрсдөө тодорхой үйл ажиллагаа, үйлдэл хийхэд бэлэн болсон эсэхийг асуу.
- Мэдээлэл цуглуулах, ажлаа төлөвлөх гээд хийх зүйл их байгаа ч өөрчлөлт хийх чин эрмэлзэл маш чухал гэдгийг тэмдэглэн хэл
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хувийн халдашгүй байдал, бүрэн бүтэн байдал, орон байр, гэр бүлээ хүндлүүлэх эрхээ бүрэн эдлэхэд нь нэмэр болох жижиг ч хамаагүй ямар ажлыг ирэх сард хийхийг хүсэж байгаа, хийх боломжтой байгааг оролцогч бүрээр хэлүүл.

10 “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаарх “Бид мэднэ” мэдээллийн товчоон.” НҮБ-ын Хүүхдийн Сан: Залуусын дуу хоолой. [http://www.unicef.org/explore\\_3893.html](http://www.unicef.org/explore_3893.html) сайтыг үз. загварчлах систем (*Missouri Model Spinal Cord Injury System*), Миссури мужийн Их сургууль, Колумбын Их сургуулийн Эрүүл мэндийн сургууль . <http://www.umshp.org/hp/resources/sci/at-manual/atman2.shtml>

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах нөлөөллийн ажил хэрхэн төлөвлөх талаар “Хэсэг 3. Нөлөөлөл! Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа” (хуудас 278) хэсгээс уншина уу.

ХУВИЙН ХАЛДАШГҮЙ БАЙДАЛ, БҮРЭН БҮТЭН БАЙДАЛ, ОРОН ГЭР, ГЭР БҮЛЭЭ  
ХҮНДЛҮҮЛЭХ ЭРХИЙН ТУХАЙ НЭМЭЛТ МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

- Эдийн засаг, нийгэм, соёлын хороны Ерөнхий зөвлөмж №5  
[http://www.unhchr.ch/tbs/doc.nsf/\(Symbol\)/4b0c449a9ab4ff72c12563ed0054f17d?OpenDocument](http://www.unhchr.ch/tbs/doc.nsf/(Symbol)/4b0c449a9ab4ff72c12563ed0054f17d?OpenDocument)
- Хүний эрхийн комиссын Ерөнхий зөвлөмж №16:  
[http://www.unhchr.ch/tbs/doc.nsf/\(Symbol\)/23378a8724595410c12563ed004aeeed?OpenDocument](http://www.unhchr.ch/tbs/doc.nsf/(Symbol)/23378a8724595410c12563ed004aeeed?OpenDocument)
- Хүний эрхийн комиссын Ерөнхий зөвлөмж №19:  
[http://www.unhchr.ch/tbs/doc.nsf/\(Symbol\)/6f97648603f69bcdc12563ed004c3881?OpenDocument](http://www.unhchr.ch/tbs/doc.nsf/(Symbol)/6f97648603f69bcdc12563ed004c3881?OpenDocument)



## БҮЛЭГ 8: ЭРҮҮЛ БАЙХ ЭРХ

### НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци

#### 25 дугаар зүйл. Эрүүл мэнд:

Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөгжлийн бэрхшээлийн улмаас алагчлалгүйгээр, эрүүл мэндийн хувьд боломжийн хамгийн дээд түвшний стандартад хүрэх эрхийг хүлээн зөвшөөрнө. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэндтэй холбоотой нөхөн сэргээх эмчилгээг оролцуулан жендерийн мэдрэмжтэй эрүүл мэндийн үйлчилгээгээр хангагдах боломжийг баталгаажуулах бүхий л зохистой арга хэмжээг авна. Тухайлбал, Оролцогч улсууд нь:

- a) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүн амд суурилсан нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөр, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн салбарыг оролцуулан бусад хүмүүст хүрдэгтэй ижил түвшин, чанар, стандарт бүхий үнэ төлбөргүй буюу худалдан авах чадварт нь нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, хөтөлбөрүүдээр хангах
- b) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрүүл мэнд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй нь холбоотойгоор шаардлагатай үйлчилгээнд хамруулах, эрт оношлох, зохих үед таслан зогсоох буюу багасгахад чиглэгдсэн болон хүүхдүүд, ахмадуудыг цаашид хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх үйлчилгээнд хамруулах;
- c) хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан эмнэлгийн үйлчилгээг бүх газарт тухайлбал, хөдөө орон нутагт ч аль болох гэрт нь ойр газар үзүүлэх;
- d) эмч, эмнэлгийн ажилтнуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бусдад үзүүлдэгийн нэгэн адил чанартай үйлчилгээ, тухайлбал, хүний эрх, нандин чанар, хараат бус байдал болон хөгжлийн бэрхшээлтэй хүнд боловсрол олгох тусгай хэрэгцээ, мөн төрийн болон хувийн эмнэлгийн байгууллагуудын ажилтнуудын баримтлах ёс зүйн хэм хэмжээний талаарх ойлголтыг нэмэгдүүлэх замаар *inter alia* бүрэн дүүрэн мэдээлэлд үндэслэсэн чөлөөт зөвшөөрлийн үндсэн дээр үзүүлэх;
- e) эрүүл мэндийн даатгал, хэрэв дотоодын хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бол амь насны даатгалын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг алагчлахыг хориглох бөгөөд эдгээрт шударга, боломжит үндэслэлээр даатгуулна;
- f) хөгжлийн бэрхшээлийн улмаас эмнэлгийн тусламж, эрүүл мэндийн үйлчилгээ, эсхүл хоол хүнс, ундны асуудалд алагчилж, үгүйсгэхээс урьдчилан сэргийлэх.

## ЗОРИЛТУУД

Энэ бүлгийн сэдэв, үндсэн мэдээлэл, дасгал нь дараах зорилтыг биелүүлэхэд оролцогчдод тусална:

- “Боломжийн хамгийн дээд түвшинд эрүүл байх эрх” гэж юуг хэлж байгааг ойлгох;
- Хөгжлийн бэрхшээл болон эрүүл мэнд хоёрын холбоог тодорхойлох
- Эрүүл мэндийн үйлчилгээ болон сэргээх/нөхөн сэргээх үйлчилгээний хоорондын зааг ялгааг тодорхойлох;
- Эрүүл мэндийн үйлчилгээ, бусад нөөц боломжийг тэгш хүртээмжтэй байлгах нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ямар ач холбогдолтой болохыг өөрөө ойлгох, бусдад тайлбарлаж чаддаг болох;
- Эрүүл байх эрх болон бусад эрхийн хоорондын холбоог ойлгох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боломжийн хамгийн дээд түвшинд эрүүл байх эрх хэрхэн хангагдаж, эсвэл зөрчигдөж, буруу ойлгогдож ирсэн талаар мэддэг болох;
- НҮБ-ын **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн** (ХБХЭК) эрүүл мэндтэй холбоотой заалтуудыг ойлгох.

## ЭХЛЭЛ: ЭРҮҮЛ БАЙХ АСУУДЛЫГ ХҮНИЙ ЭРХИЙН ТАЛААС ХАРЖ ЭРГЭЦҮҮЛЭХ НЬ

Эрүүл байх эрх гэдэгт юу багтах вэ? Өвчин эмгэггүй эрүүл саруул байх эрхийг хэлэх үү? Эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхийг хэлэх үү? Эсвэл өөр юм байна уу? Хүний эрх болгон нь уг эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангахад чиглэсэн төрийн болон нийгмийн хүлээх тодорхой үүргийг багтаасан ойлголт болохыг бид мэднэ. Гэтэл бүх өвчнөөс ангид байх эрхийг хангах боломжгүй. Хүний өөрийн сонголт болох эрүүл бус зан үйл, эсвэл тодорхой нэг өвчин тусах магадлалыг нэмэгдүүлэх удамшлын нөлөө зэрэг төр, засгийн хянаж чадахгүй олон хүчин зүйл хүний эрүүл мэндэд нөлөөлдөг.

Гэхдээ л төр, нийгмийн аль аль нь хүний эрүүл мэндэд шууд нөлөөтэй нийтийн эрүүл ахуй, цэвэр усны хангамж, орчны бохирдлын түвшин зэрэг эрүүл мэндийн олон суурь хүчин зүйлийг хянах, зохицуулах бүрэн боломжтой. Мөн аль ч нийгэм төрийн хууль, бодлого, хөтөлбөрүүдээрээ дамжуулан хүний эрүүл мэндийг хамгаалах, дэмжих зорилт тавьж ажилладаг. Улс орон бүр эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх тогтолцоотой, мөн хүний эрүүл мэндэд учрах эрсдэл, өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, эрүүл амьдралын хэвшлийн тухай мэдээлэл өгөх зорилготой нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүдтэй байдаг. Үндэсний эрүүл мэндийн тогтолцоог тэгш хүртээмжтэй бөгөөд чанартай үйлчилгээ үзүүлдэг байлгах нь төрийн хариуцах асуудал юм. Цаашилбал, хүмүүсийн эрүүл мэндийн байдал нь сурч боловсрох, ажил эрхлэх, хүрэлцэхүйц амьжиргаатай байх зэрэг бусад эрхээ хэр эдэлж чадаж байгаатай нь шууд холбоотой байдаг. Эдийн засгийн хувьд тогтвортой, амьжиргааны түвшин сайтай хүмүүстэй харьцуулахад ядуу, эсвэл боловсролгүй хүмүүсийн эрүүл мэндийн байдал муу байх магадлал хамаагүй илүү юм. Эдгээр жишээ нь хүний эрүүл байх эрх нь бусад эрхүүдтэй **нэгдмэл, уялдаа холбоотой, харилцан хамааралтай** болохыг тодорхой харуулж байна.





Ядуурал, боловсролын хоцрогдол, хүнд хэцүү амьдралын нөхцөл, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг хүний эрхийн бусад зөрчлүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдаас илүүтэйгээр нэрвэгддэг. Жишээлбэл, олон оронд ундны усны эх үүсвэрийг олон нийтийн газар суурилуулсан байдаг ч цоргыг хөгжлийн бэрхшээлтэй хүн хүрэхээргүй газарт байрлуулсан байдаг. Эмнэлгийн байшин барилгыг барихдаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нэвтрэх боломж олгох талаас нь харж тооцоолоогүй, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхдээ харилцаа холбооны олон сувгийг ашигладаггүй, эсвэл бүр хөгжлийн бэрхшээлээс нь болж үйлчилгээ үзүүлэхээс татгалздаг зэрэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст саад болж, бусадтай адил тэгш хэмжээнд эрүүл мэндийн үйлчилгээ хүртэж чадахгүйд хүргэж байна.

Хүмүүсийг огт өвчин тусгахгүй, өвчлүүлэхгүй байхыг төр, нийгэм бүрэн хариуцаж чадахгүй ч хүний эрүүл мэндэд нөлөөлөх нийгэм, эдийн засаг, хууль эрхзүй болон орчны хүчин зүйлсийг анхааралдаа авах үүрэгтэй. Ийм ч учраас эрүүл мэндийн асуудлыг хүний эрхийн үүднээс “боломжийн хамгийн дээд түвшинд эрүүл байх эрх” хэмээн тодорхойлж байна. Өөрөөр хэлбэл, эрүүл амьдралыг хөхиүлэн дэмжсэн, эрүүл амьдрах боломж олгосон орчин, нөөцөөр хангагдан нь хүний эрх юм.

## ЭРҮҮЛ МЭНДИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Эрүүл байх эрх гэж юуг хэлж байгааг мэдэхийн зэрэгцээ бид “эрүүл мэнд” гэж юуг хэлж байгааг ойлгож авах ёстой. **Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын (ДЭМБ) үүнийг дараах байдлаар тодорхойлжээ:**

*Эрүүл мэнд гэж зөвхөн ямар нэг өвчин, өвчлөлтгүй байхыг хэлээд зогсохгүй мөн бие, сэтгэл, нийгмийн амьдралын бүрэн дүүрэн сайн сайхан байдлыг<sup>1</sup> хэлэх ажээ.*

ДЭМБ дээрх тодорхойлолтоо улам лавшруулан эрүүл байх эрх хичнээн ач холбогдолтой болохыг дараах мэдэгдэлдээ тэмдэглэсэн байна:

*Боломжийн хамгийн дээд түвшинд эрүүл байх эрх нь арьсны өнгө, улс төрийн итгэл үнэмшил, эдийн засгийн болон нийгмийн хүчин зүйлсээс үл хамааран хүн бүрийн хамгийн чухал суурь эрхийн нэг юм.*

*Төр засаг нь хүн амынхаа эрүү мэндийг хариуцах үүрэгтэй бөгөөд энэ хариуцлагыг зохимжит эрүүл мэндийн болон нийгмийн арга хэмжээнүүдийг хангаж өгөх замаар хэрэгжүүлж болно<sup>2</sup>.*

“Хүний эрхийн төлөө!” гарын авлагад “эрүүл байх эрх” гэсэн нэр томъёог “боломжийн хамгийн дээд түвшинд эрүүл байх эрх” гэдэг утгаар нь хэрэглэлээ.

1 Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын Үндсэн Хуулийн Удиртгал хэсэг <http://www.who.int/governance/eb/constitution/en/index.html>

2 Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын Үндсэн Хуулийн Удиртгал хэсэг <http://www.who.int/governance/eb/constitution/en/index.html>

## ДАСГАЛ 8.1: Эрүүл байх эрхийн талаар

**Зорилт:** “Боломжийн хамгийн дээд түвшинд эрүүл байх эрх”-тэй холбоотой эрх, үүргүүдийг ойлгож авах

**Хугацаа:** 30 минут

**Хэрэглэгдэхүүн:** Цаас, үзэг/бал эсвэл самбар, шохой.

### 1. Танилцах/ Санал солилцох

Хүнийг эрүүл байлгана гэдэгт эдлэх эрх, хүлээх үүрэг багтдаг болохыг онцол.

Оролцогчдыг жижиг багуудад хуваагаад, эрүүл мэндтэй холбоотой дараах сэдвүүдээс нэгийг сонгоод, дараах асуултуудын дагуу ярилцахыг даалга:

- А. Хүний ямар ямар эрх эрүүл мэндийн энэ асуудалтай холбоотой байгааг жагсааж бич.
- Б. Эрүүл мэндийн энэ асуудалтай холбоотой төр, засаг ямар ямар үүрэг хариуцлагыг хүлээх тухай ярилцаж шийд
- В. Хувь хүмүүс өөрсдийнхөө төлөө юу хийх ёстой талаар ярилц.

Багууд хэлэлцүүлгээ хэрхэн чиглүүлж, хариултуудаа яаж тэмдэглэхийг доорх хүснэгтийг ашиглан тайлбарла.

### 2. Илтгэх

Баг болгоноос нэг хүн томилж багийн ажлаа танилцуулахыг хүс.

### 3. Хэлэлцэх

- Хүний энэ эрхийг хэрэгжүүлэх үүргээ биелүүлэхийн тулд засгийн газар ямар арга хэмжээ авах ёстой вэ? Танай засгийн газар энэ үүргээ биелүүлж байна уу?
- Хувь хүмүүс энэхүү эрхийг хэрэгжүүлэх үүргээ биелүүлэхийн тулд ямар арга хэмжээ авах ёстой вэ? Таны бодлоор хүмүүсийн ихэнх нь энэ хариуцлагаа ойлгодог уу?
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст энэ эрхээ эдлэх баталгааг хангаж өгөхийн тулд засгийн газар ямар тусгай арга хэмжээнүүдийг авах ёстой вэ?

### Хэлэлцэх сэдэв

- Таргалалт
- Амьсгалын замын өвчин
- ХДХВ/ДОХ
- Ариун цэвэр эрүүл ахуй нөхцөл
- Дархлаажуулалт
- Таны орон нутагт байгаа бусад асуудлууд

### Жишээлбэл: ундны цэвэр ус

**Эрхийн тухай тайлбар:** Өвчин үүсгэгч химийн бодис болон бохирдол агуулаагүй цэвэр ус хэрэглэх эрх хүн бүрт бий. Ундны цэвэр ус хүн бүрт тэгш хүртээмжтэй байх ёстой.



<b>Эрүүл мэндийн асуудал: Ундны цэвэр ус</b>	
<b>Хүний эрх:</b> Өвчин үүсгэгч химийн бодис болон бохирдол агуулаагүй цэвэр ус хэрэглэх эрх хүн бүрт бий. Ундны цэвэр ус хүн бүрт тэгш хүртээмжтэй байх ёстой.	
<b>Засгийн газрын үүрэг</b>	<b>Хувь хүний үүрэг</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Нийтийн ундны усны эх үүсвэрийн аюулгүй байдлыг хангах</li> <li>• Цэвэр усыг хүн бүрт тэгш хүртээмжтэй байлгах</li> <li>• Аюулгүйн баталгаагүй ус хэрэглэхгүй байх, сөрөг нөлөөг нь багасгах тухай мэдээлэл өгөх</li> <li>• Онц байдлын үеэр цэвэр усаар хангах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Ундны цэвэр усыг бохирдуулж мэдэх үйлдлээс зайлсхийх</li> <li>• Ус бохирдсон байж мэдэх нөхцөлд холбогдох зөвлөмжийг хэрэгжүүлэх (жишээлбэл, усыг буцалгах, эсвэл өөр аюулгүй эх үүсвэрээс ус авах)</li> <li>• Нийтийн ундны усны эх үүсвэрээс авсан аюулгүйн баталгаагүй уснаас үүссэн гэж үзэж байгаа өвчний тухай мэдээлэл</li> <li>• Усыг бохирдуулж байгаа эх үүсвэрүүдийн талаар мэдээлж байх</li> </ul>

## Хөгжлийн бэрхшээл ба эрүүл мэнд

Хүний эрүүл мэндэд ядуурал, бичиг үсэг тайлагдалтын түвшин зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байдгийг нийтээр хүлээн зөвшөөрдөг хэрнээ олон хүн хөгжлийн бэрхшээлийг мөн чанартаа зөвхөн эрүүл мэндийн асуудал гэж харсаар ирсэн. Гэтэл бодит амьдрал дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ч гэсэн бусдын адил өвчин, өвчлөлд өртөж байдаг шүү дээ. Ямар ч хүний нэгэн адил тэдний эрүүл мэнд нь сайн, муу янз бүр байж болно. Хөгжлийн бэрхшээлтэй зарим хүн ханиад томуу зэрэг халдварт өвчинд илүү өртөмтгий байж болохоос гадна зарим төрлийн хөгжлийн бэрхшээл нь өөрөө “хоёрдогч өвчлөлт” гэж нэрлэгддэг эрүүл мэндийн доройтолд хүргэх шалтгаан болдог. Хоёрдогч өвчлөлтийн түгээмэл жишээнүүдийн дотор хөдөлгөөний бэрхшээлтэй зарим хүнд тохиолддог даралтаас үүдэлтэй арьсны цооролт, амьсгалын тогтолцооны хямрал зэргийг нэрлэж болно. Эрүүл мэндийн зарим хүндрэл нь байнгын хөгжлийн бэрхшээл, эсвэл түр зуурын чадвар алдалт үүсэх шалтгаан болдог нь ч мөн үнэн. Өөрөөр хэлбэл, хөгжлийн бэрхшээл нь эрүүл мэндийн доройтлын үр дагавар юмуу шалтгаан аль аль нь болж болохоос гадна цоо эрүүл хүн ч хөгжлийн бэрхшээлтэй байж болно.<sup>4</sup>

Харин, харамсалтай нь, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндийн ерөнхий байдал нь нийт хүн амын байдлаас арай муу байдаг бөгөөд үүнээс болж хөгжлийн бэрхшээл бол өөрөө эрүүл мэндийн доройтол гэж үзэх буруу ойлголт төлөвшдөг. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндийг доройтуулдаг олон хүчин зүйл байдаг ба эдгээрийн ихэнх нь ямар

4 “Эрүүл байх эрх: хөгжлийн бэрхшээлийн талаарх үзэл баримтлал ба Америкийн туршлага”, 2005. Хөгжлийн бэрхшээлийн асуудлаарх Үндэсний зөвлөл <http://www.ncd.gov/newsroom/publications/2005/righttohealth.htm>

ч хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх нөхцөл юмуу нөөцийн хүртээмжгүй байдалтай холбоотой байдаг. Жишээлбэл, хөдөлмөр эрхлэлт, боловсролын салбар дахь ялгаварлан гадуурхлын улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ядуурал улам гүнзгийрдэг. Эрүүл мэндийн үйлчилгээ, эрүүл мэндтэй холбоотой зарим чухал мэдээлэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүрэхгүй байх нь элбэг. Эдгээр хүчин зүйл нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндэд хөгжлийн бэрхшээлээс нь хавьгүй ноцтой нөлөө үзүүлдэг.

Хөгжлийн бэрхшээлийг эрүүл мэндийн хүндрэл гэж тодорхойлж байгаа нөхцөлд хүмүүс хөгжлийн бэрхшээл бол өвчин юмуу өвчлөлттэй ижил зүйл гэж ойлгож ханддаг. Улмаар төр, нийгэм нь хөгжлийн бэрхшээлийг нийгмийн бодлого, хүний эрхийн хүрээний асуудал гэж хандахын оронд анагаах ухааны мэргэжлийн хүмүүсийн “эмчлэх”, “эдгээх” ёстой өвчлөл гэсэн хандлага хэвшдэг. “Хөгжлийн бэрхшээлд хандах эмнэлзүйн загвар” гэж нэрлэж болох энэхүү үзэл нь хөгжлийн бэрхшээлийг урьдчилан сэргийлэх, эмчлэх, шинж тэмдгүүдийг анзаарч хариу арга хэмжээ авах эмнэлгийн мэргэжилтнүүдийн хариуцлага гэж үзэхэд хүргэдэг. Харамсалтай нь, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэндийн доройтлын үндсэн шалгаан болдог ялгаварлан гадуурхал, хүртээмжгүй байдал, бусад нийгэм, улс төрийн асуудлыг засаж залруулахад энэ хандлага ямар нэг хувь нэмэр оруулж чадахгүй юм.

## Эрүүл мэнд ба сэргээлт/нөхөн сэргээлт

Хөгжлийн бэрхшээлийг эрүүл мэндийн асуудал гэж үзэх буруу ойлголтыг үүсгэдэг хөгжлийн бэрхшээлд хандах эмнэлзүйн хандлагаас болж **сэргээлт/ нөхөн сэргээлтийг** мөн л эрүүл мэндийн салбарын асуудал, улмаар эрүүл мэндийн байдалтай холбоотой гэсэн ташаа ойлголт улам бэхждэг. Гэтэл НҮБ-ын **Стандарт дүрмүүдэд** сэргээлт/ нөхөн сэргээлтийг “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бие махбод, мэдрэхүй болон/ эсвэл нийгмийн амьдралын чадавхиа зохистой түвшинд хүргэж, хадгалах боломжийг олгосон, улмаар амьдралаа илүү бие даасан байдал руу залж өөрчлөхөд туслах арга хэрэгслээр хангаж өгөх үйл явц” гэж тодорхойлсон байдаг.<sup>5</sup> Тиймээс ч сэргээлт, нөхөн сэргээлт нь хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн болон сэтгэхүйн эрүүл мэндийг хамгаалах төдийхнөөр хязгаарлагдахгүй хөгжлийн бэрхшээлтэй хүний хараат бус байдлыг дээд зэрэгт хүргэн нэмэгдүүлэх, нийгмийн амьдралд бүрэн оролцуулахад чиглэсэн бие махбод, техник мэргэжил, боловсрол, сургалт, бусад олон асуудлыг багтаасан өргөн хүрээтэй ойлголт юм. Энэ л шалтгаанаар Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци, “Хүний эрхийн төлөө!” гарын авлага хоёр нь эрүүл байх эрхийг сэргээлт, нөхөн сэргээлтийн эрхээс тусад нь авч үзэж байгаа юм. Харин энд нэг онцлох асуудал байгаа нь эрүүл мэндтэй холбоотой нөхөн сэргээлтийг эрүүл байх эрхийн зүй ёсны нэг бүрэлдэхүүн хэсэг гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа явдал юм. Үүнд, жишээлбэл, гэмтэл, өвчлөлт, хөгжлийн бэрхшээлийн улмаас үүссэн булчингийн сулралыг физик эмчилгээгээр анагаах зэрэг арга хэмжээ багтана.

5 <http://www.ohchr.org/english/law/opportunities.htm> сайтыг үз.

## **ДАСГАЛ 8.2: Эрүүл байх эрхээ эдлэхэд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгардаг саад бэрхшээлийг таних, тодорхойлох**

- Зорилт:** Эрүүл байх эрхээ эдлэхэд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгардаг нийгэм, эрхзүйн болон практик саад бэрхшээлүүдийг таньж мэдэх
- Хугацаа:** 45 минут
- Хэрэглэгдэхүүн:** ХБХЭК-ийн 25 дугаар зүйл

### **1. Санал солилцох**

Эрүүл байх эрхээ эдлэхэд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгардаг саад, тотгорыг жишээг оролцогчдоор нэрлүүл. Жишээнүүдийг жагсааж бич.

#### **Эмнэлзүйн загварыг Нийгмийн болон Хүний эрхийн загвартай харьцуулах нь**

Хөгжлийн бэрхшээл бол өвчин, өвчлөлт, эсвэл эрүүл мэндийн хүндрэл БиШ харин хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгарч байгаа дэд бүтэц, нийгмийн орчин нөхцлөөс үүдэлтэй хязгаарлалт гэдгийг хүлээн зөвшөөрсөн нийгмийн загвар болон хүний эрхийн загварыг төлөвшүүлэх замаар хөгжлийн бэрхшээлд хандах хандлагыг өөрчлөх чиглэлээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд олон ажил хийжээ.

#### **Хөгжлийн бэрхшээлд хандах эмнэлзүйн загвар**

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхэд хамгийн хүчтэй нөлөөлдөг хамгийн түгээмэл хэвшмэл ойлголт бол хөгжлийн бэрхшээлийг эрүүл мэндийн асуудал, эдгээх ёстой “өвчин” гэсэн үзэл юм. Энэ үзэл нь хөгжлийн бэрхшээлтэй хүн “эмгэгтэй” учир “засах”, эсвэл “өвчтэй” учир “эмчлэх” шаардлагатай гэж харахад хүргэдэг. Ийнхүү хөгжлийн бэрхшээлийг шийдвэрлэх ёстой асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам нь эмчилгээ гэж тодорхойлсноор төр, нийгэм, хувь хүмүүс хүний эрхийг хэрэгжүүлэхэд саад болдог нийгмийн болон дэд бүтцийн тотгорыг арилгах үүрэг хариуцлагыг өөрсдөөсөө зайлуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүний “асуудлыг” шийдэх хариуцлагыг эмнэлгийн мэргэжилтнүүдэд үүрүүлэн үлдээдэг

#### **Хөгжлийн бэрхшээлд хандах нийгмийн загвар**

Энэ хандлага нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүний эрхээ эдлэхэд нь саад болж байгаа нийгмийн болон дэд бүтцийн тотгоруудыг арилгахад чиглэдэг. Үүнд, жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар зөв, эерэг хандлага, төсөөллийг төлөвшүүлэх, байшин барилгыг өөрчлөх, мэдээллийг хүртээмжтэй арга хэлбэрээр түгээх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй зохистой хэлбэрээр харьцах, мөн бодлого, хууль тогтоомжоороо тэдний бүрэн оролцоо, үл алагчлалыг дэмжихэд анхаарах зэрэг арга хэмжээ багтана.

#### **Хөгжлийн бэрхшээлд хандах хүний эрхийн загвар**

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрх эзэмшигч бөгөөд бусдын адил хүний эрхийн субъект мөн гэж **тодорхойлдог**. Хөгжлийн бэрхшээл бол арьсны өнгө, ▶

хүйсийн ялгааны нэгэн адил хүний олон талт байдлын ердийн нэгэн хэлбэр хэмээн **хүлээн зөвшөөрч** хүндэлсний үндсэн дээр хүний эрхээ эдлэхэд нь саад болж буй сүжиг, сөрөг хандлага, бусад тотгорыг арилгахад чиглэсэн арга хэмжээ авахад анхаардаг. Улс төр, хууль эрхзүй, нийгмийн болон дэд бүтцийн орчин нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүний эрхийг дэмжсэн байх, тэдний бүрэн дүүрэн оролцоо, хамрагдалтыг хангаж өгсөн байхад анхаарч хяналт тавих хариуцлагыг нийгэм, засгийн газарт **хүлээлгэдэг**.

*Энэ сэдвийн тухай дэлгэрүүлж уншихыг хүсвэл “Хэсэг 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүний эрхийг ойлгох нь” хэсгийн “Хөгжлийн бэрхшээлийн талаарх нийтлэг хандлага, түргээмэл ойлголт” бүлгийг үзнэ үү (хуудас 20).*

## **2. Хэлэлцэх**

Оролцогчдыг гурван жижиг багт хувааж, баг болгонд хөгжлийн бэрхшээлийн дараах ерөнхий төрлүүдээс нэгийг хуваарилж өг:

- А. Бие махбодын бэрхшээл (мэдэрхүйн бэрхшээлийг оруулан)
- Б. Оюуны бэрхшээл (танин мэдэхүйн бэрхшээл)
- В. Сэтгэц-нийгмийн бэрхшээл

Багууд тухайн төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгардаг саад тотгорыг жагсаан бичээд, эдгээр саад тотгор нь яагаад арилахгүй оршсоор байгааг тайлбарлах оролдлого хийнэ. Зарим төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдаасаа илүү ялгаварлан гадуурхал амсаж байгаа эсэх, тийм бол яагаад гэдгийг асуу.

## **3. Илтгэх/Хэлэлцэх**

Багууд гаргаж ирсэн саад тотгоруудын жагсаалтаа уншиж танилцуулаад дараах асуултуудын дагуу хэлэлцүүлэг хийнэ:

- Зарим төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ялгаварлан гадуурхалд бусдаасаа илүү өртдөг үү? Яагаад?
- Танай багийн тодорхойлж бичсэн саад тотгоруудын талаар 25 дугаар зүйлд юу гэж дурьдсан байна вэ?
- ХБХЭК-д эдгээр саадыг арилгахын тулд төр, засаг юу хийх ёстой гэж шаардсан байна вэ?
- Эдгээр өөрчлөлтийг хийхэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс төр, засагтаа хэрхэн тусалж чадах вэ?
- Эдгээр өөрчлөлт нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэндийг сайжруулахад ямар хувь нэмэр оруулж чадах вэ?

**ЭРҮҮЛ БАЙХ ЭРХИЙН ТАЛААР ХҮНИЙ ЭРХИЙН ЭРХЗҮЙД ЮУ ГЭЖ ЗААСАН БАЙДАГ ВЭ?**

Хүний эрүүл байх эрхийг анх **Хүний эрхийн түгээмэл тунхаглалын (ХЭТТ) 25.1** дүгээр зүйлд шууд бусаар хүлээн зөвшөөрсөн:





*Хүн бүр хоол хүнс, хувцас хунар, орон байр, эмчилгээ сувилгаа, нийгэм ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг оролцуулаад өөрийн болон гэр бүлийнхээ эрүүл мэнд, сайн сайхан байдлыг хангахад хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй. Ажилгүйдэх, өвчлөх, тахир дутуу болох, бэлэвсрэх, өтлөх, эсвэл өөрөөс үл хамаарах бусад шалтгаанаар амь зуулгагүй болох нөхцөлд тэтгэмж авах эрхтэй.*<sup>6</sup>

ХЭТТ нь хүрэлцэхүйц амьжиргаатай байх хүний эрхийн асуудал нь хүний “эрүүл мэнд, сайн сайхан” байдлыг хангах туйлын зорилготой болохыг онцолжээ. Улмаар, эрүүл байх эрх нь хүний орон байртай байх, нийгмийн халамж, эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхтэй **нэгдмэл, уялдаа холбоотой, харилцан хамааралтай** ажээ.

Эрүүл байх эрхийг 1966 онд **Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын** (ЭЗНСЭОУП) 12 дугаар зүйлд илүү нарийвчлан, шууд зааж өгсөн байна:

*Энэхүү Пактад Оролцогч улсууд нь биеийн болон оюуны боломжийн хамгийн дээд түвшинд эрүүл байх хүн бүрийн эрхийг хүлээн зөвшөөрнө.*<sup>7</sup>

Энэ өгүүлбэр нь хүний эрүүл байх эрхийг хүний эрхийн байр сууринаас тодорхойлсон үндсэн тодорхойлолт юм. Гэхдээ энэ асуудлын мөн чанар нэн нарийн, олон талтай учраас ЭЗНСЭОУП-ын хэрэгжилтийг хянадаг **Эдийн Засаг, Нийгэм, Соёлын Эрхийн Хорооноос** ЭЗНСЭОУП-аар баталгаажсан боломжийн хамгийн дээд түвшинд эрүүл байх эрхийн хүрээнд багтах эрх чөлөө, эрх, үндсэн үүргүүдийг илүү бүрэн дүүрэн томъёолох үүднээс **Ерөнхий зөвлөмж №14-ийг** боловсруулан гаргажээ:

*Эрүүл байх эрх бол эрүүл саруул байх эрх биш. Эрүүл байх эрхийн хүрээнд эрх чөлөө, хүртэх эрх хоёул багтана. Эрх чөлөөнд нь өөрийнхөө эрүүл мэнд, бие махбодыг захирах эрх, түүний дотор бэлгийн болон нөхөн үржихүйн эрх чөлөө, мөн эрүү шүүлт болон зөвшөөрөлгүй эмчилгээ, туршилтаас ангид байх эрх зэрэг хөндлөнгийн оролцооноос ангид байх эрх багтана. Үүнээс ялгаатайгаар, хүртэх эрхэд хүрч болох дээд түвшинд эрүүл байх тэгш боломжийг хангадаг эрүүл мэндийн хамгааллын тогтолцоог ашиглах эрх багтана.*<sup>8</sup>

Ерөнхий зөвлөмж 14-д эрүүл байх эрхийг хангахад чухал нөлөөтэй “хоорондоо уялдаа холбоотой элементүүдийг” мөн тодорхойлжээ:

- **Хүрэлцэхүйц байх**
- **Хүртээмжтэй байх:** Энэ нь үл алагчлал, дэд бүтцийн хүртээмж, эдийн засгийн хүртээмжтэй байдал (үнийн хувьд боломжтой байх), мэдээллийн хүртээмж зэрэг хоорондоо холбоотой дөрвөн хэмжүүртэй.
- **Хүлээн зөвшөөрөгдөх түвшинд байх**
- **Чанартай байх**

Пактын хүрээнд хөгжлийн бэрхшээл, түүний дотор эрүүл мэндийн асуудлыг хэрхэн үзэж байгааг илэрхийлэх зорилгоор **Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос**

6 <http://www.un.org/Overview/rights.html> сайтыг үз.

7 [http://www.unhchr.ch/html/menu3/b/a\\_cescr.htm](http://www.unhchr.ch/html/menu3/b/a_cescr.htm) сайтыг үз.

8 <http://www.umn.edu/humanrts/gencomm/escgencomm14.htm> сайтыг үз.



ЭЗНСЭОУП-ын **Ерөнхий зөвлөмж №5-ыг** боловсруулан гаргажээ.<sup>9</sup> ЭЗНСЭОУП-ын 5 дугаар зүйл, Ерөнхий зөвлөмж №14 нь нийлээд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрүүл мэндийн үйлчилгээг хүртэх тэгш эрхтэйгээр зогсохгүй, мөн эрүүл мэндийн эрхийн холбогдолтой бүхий л асуудлаар адил тэгш байх, алагчлалаас ангид байх эрхтэй болохыг тунхаглажээ. Үүнд эрүүл мэндийн үйлчилгээг тэгш хүртээд зогсохгүй, мөн боломжийн хамгийн дээд түвшинд эрүүл байхад шаардлагатай нөөц, бусад нөхцөл, хүчин зүйлсийг ч мөн тэгш хүртэх зарчим багтаж байна.

1993 онд баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боломжийг тэгшитгэх тухай НҮБ-ын стандарт дүрмүүдийн (Стандарт дүрмүүд) “Эрүүл мэндийн үйлчилгээ” хэмээх 2 дугаар дүрэмд хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрт үеэс арга хэмжээ авах асуудлыг авч үзжээ. Энэ дүрэмд эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, үйлчилгээний хүргэлтэд хамааралтай маш чухал хэд хэдэн зарчмыг тодорхойлж өгсөн ба эдгээрт:

- бусад хүмүүсийн хүртэж байгаатай ижил түвшний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэг л тогтолцоогоор дамжуулан хүргэж байх
- эмнэлгийн ажилтнуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусламж, үйлчилгээ үзүүлэхэд сургах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах
- чадавхийн түвшнийг хэвээр хадгалах, сайжруулахад шаардлагатай эмчилгээний арга хэлбэр, техник технологи, эмийг хүртээмжтэй байлгах<sup>10</sup>

зэргийг онцолжээ.

ХБХЭК-ийн 25 дугаар зүйл нь өмнөх үеийн эрхзүйн баримтуудад тунхаглагдсан тэгш байдал, үл алагчлал, хүртээмжийн зарчмуудыг баталгаажуулаад, тодорхой чиглэлээр төр засгийн хүлээх үүргийг улам өргөжүүлж өгсөн байна. Тухайлбал:

- бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ хүртэх эрх
- хүн амд суурилсан нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрт хамрагдах эрх
- үйлчилгээг хүмүүсийн амьдардаг газарт аль болох ойр байлгах
- хөгжлийн бэрхшээлтэй холбоотой эрүүл мэндийн тусгай үйлчилгээ үзүүлэх, тэр дундаа хөгжлийн бэрхшээл даамжирхаас сэргийлэх
- эрүүл мэндтэй холбоотой шийдвэрүүд нь бие даасан, хөндлөнгийн нөлөөлөлгүй, бүрэн дүүрэн мэдээллийн үндсэн дээр өгсөн чөлөөт зөвшөөрөлд үндэслэсэн байх
- эрүүл мэндийн болон амь насны даатгалын үйлчилгээг үл ялгаварлах зарчмаар тэгш хүртээмжтэй байлгах
- хөгжлийн бэрхшээлийн улмаас үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, үүний дотор хоол, унд хязгаарлахыг хориглох тухай заажээ.

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

ХБХЭК-ийн “Хүртээмж” гэсэн 9 дүгээр зүйлд эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжтэй байдлын талаар маш тодорхой заалтууд орсон учраас 25 дугаар зүйлд энэ асуудлыг тусгайлан дурьдаагүй байна (Хүртээмжийн асуудлыг Бүлэг 2. Хүртээмж” хэсгээс дэлгэрүүлж

9 <http://www.umn.edu/humanrts/gencomm/escgencomm5.htm> сайтыг үз.

10 <http://www.ohchr.org/english/law/opportunities.htm> сайтыг үз.



үзнэ үү). ХБХЭК-ийн 9 дүгээр зүйл бол *нийтлэг үйлчлэх хэсэг* тул энэ бүлгийн агуулга нь конвенцийн агуулгад бүхэлд нь хамааралтай. 9 дүгээр зүйлд хүртээмжийн асуудлыг ерөнхийд нь авч үзээд, Оролцогч улсуудаас:

*хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусдын нэгэн адил өөрийг нь хүрээлэн буй орчин, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо тухайлбал, мэдээлэл харилцаа холбооны технологи, систем болон нийтэд нээлттэй үйлчлэх буюу зориулагдсан бусад төрлийн объект, үйлчилгээг хүртэх явдлыг хангахад чиглэсэн зохих арга хэмжээ авах-ыг шаарджээ.*

Энэ зүйлд эрүүл мэндийн үйлчилгээг багтаахын зэрэгцээ “эрүүл мэндийн байгууллага” гэж тусгайлан нэр заасан байдаг.

Дээр дурьдсанчлан, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос боловсруулсан Ерөнхий зөвлөмж №14-т эрүүл байх эрхийг хангахад амин чухал үүрэгтэй “хоорондоо уялдаа хамааралтай” 4 элементийг тодорхойлсноос хоёр нь дэд бүтэц болон мэдээллийн хүртээмжтэй холбоотой заалтууд байна. Эдгээр нь:

**Дэд бүтцийн хүртээмж:** эрүүл мэндийн байгууллага, бараа, үйлчилгээ нь хүн амын бүх бүлэг, ялангуяа үндэстний цөөнх, уугуул иргэд, хүүхэд эмэгтэйчүүд, өсвөр насныхан, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ХДХВ/ДОХ-той хүмүүс зэрэг нийгмийн эмзэг бүлгүүдэд ойр, хүрч очиход аюулгүй зайд байх ёстой. Хүртээмжтэй байна гэдэг нь мөн эрүүл мэндийн үйлчилгээ болон эрүүл мэндэд нөлөөтэй суурь нөхцлүүдэд багтах ундны цэвэр ус, ариун цэврийн зохимжтой байгууламж зэрэг нь бүх газарт, тэр тусмаа хөдөө орон нутагт хүмүүстээ ойр, аюулгүй хүрч болох зайд байрлах шаардлагыг багтаана. Цаашилбал, хүртээмжтэй байх зарчимд мөн барилга байгууламжуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нэвтрэх боломжтой байлгах шаардлага багтана.

**Мэдээллийн хүртээмж:** хүртээмжтэй байх зарчимд эрүүл мэндтэй холбоотой мэдээлэл, үзэл бодлыг хайж олох, хүлээж авч, түгээх эрх багтана. Харин мэдээллийн хүртээмж нь хүний эрүүл мэндтэй холбоотой хувийн мэдээллийг нууцлах эрхэд халдах ёсгүй.

### **ДАСГАЛ 8.3: Эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэйгээр зохион байгуулах нь**

- Зорилт:** Эрүүл мэндийн үйлчилгээг хүртэхэд саад болдог практик тотгоруудыг арилгахад туслах нөөц боломж, шийдлүүдийг олж тодорхойлох
- Хугацаа:** 45 минут
- Хэрэглэгдэхүүн:** Боломжит нөхцлүүдийг (сценари) дүрсэлсэн тараах материал

#### **1. Танилцуулах**

Эрүүл мэндийн үйлчилгээ нийт хүн амд хүртээмжтэй байгаа газарт ч гэсэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст олон саад тотгор учирдаг тухай онцлон дурьд. Оролцогчдыг жижиг багуудад хуваагаад, баг бүрт эрүүл мэндийн үйлчилгээ авах гэсэн хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай нэг сценари өгөөд дараах зааврыг өг.

А. Сценарийг уншаад дараах асуултуудын дагуу хэлэлцүүлэг хий:

- Эрүүл мэндийн байгууллагад хандсан өвчтөнд ямар ямар саад бэрхшээлүүд тулгарч болох вэ? Сценарид дүрслэгдсэн дүр болгон нь эрүүл мэндийн үйлчилгээ (хүлээн авах, эмчийн өрөө, үзлэгийн өрөө гэх мэт) авахаар ирэхэд түүнд юу тохиолдож болох вэ?
- Тухайн нөхцөлд байж болох хамгийн чанартай сайн эрүүл мэндийн үйлчилгээ авахад өвчтөнд ямар бэрхшээл тохиолдож болох вэ?
- Хөгжлийн бэрхшээлийг харгалзсан ямар шийдлүүд шаардлагатай болох вэ? Эдгээр шийдлийг хэрэгжүүлэхэд ямар ямар нөөцийг дайчлах шаардлагатай вэ?
- Тухайн нөхцөлд байж болох хамгийн чанартай сайн үйлчилгээ үзүүлэхийн тулд эрүүл мэндийн ажилтнуудад ямар төрлийн сургалт (жишээлбэл, хүртээмжийн талаарх сургалт, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаар сургалт гэх мэт) шаардлагатай вэ?

Б. Багийн ажилд тулгуурлан хамгийн сайн болон хамгийн муу үр дагавар дагуулах хоёр тохиолдлыг дүрийн тоглолтоор үзүүл.

### Хүртээмж бол нийтлэг бэрхшээл

Дэд бүтцийн бэрхшээлээс гадна мөн хүртээмжтэй харилцаа, хөгжлийн бэрхшээлийн асуудлаар мэргэшсэн эрүүл мэндийн ажилтнууд дутагдалтай байх гэх мэт практик бэрхшээлээс үүдэлтэй үйлчилгээний хүртэмжгүй байдал нь хөгжингүй болон хөгжиж буй орнуудын аль алинд нь тохиолддог бэрхшээл юм. Эрүүл мэндийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байлгахад хуульчилсан улс орнуудад хүртэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс энэ эрхийнхээ төлөө тэмцэх шаардлага тулгарсаар байна. “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалагчид” нэртэй АНУ-ын нөлөөллийн байгууллага “Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж” төслийнхөө хүрээнд Калифорни мужийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дунд судалгаа хийжээ. Судалгааны зарим үр дүнг дурьдвал:

- Хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүсийн **17%** хувь нь эмнэлгийн гол хаалгаар ороход хүндрэлтэй тулгардаг тухайгаа мэдээлжээ.
- Хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүсийн **33%** хувьд нь үзлэгийн өрөөнд ороход хүндрэл тулгарсан байна.
- Тэргэнцэртэй хүмүүсийн **69%** хувьд нь үзлэгийн ширээг ашиглахад бэрхшээл тулгарчээ.
- Тэргэнцэртэй хүмүүсийн **45%** хувьд нь хэт авианы оношлогооны тоног төхөөрөмж (тухайлбал, маммографи) ашиглахад хэцүү байжээ.
- Сонсголгүй хүмүүсийн **26%** хувь нь үзлэгийн дугаар бичүүлэхдээ тайлбарлагчийн туслалцаа авахад хэцүү байсан гэж мэдээлжээ.
- Хараагүй болон харааны бэрхшээлтэй хүмүүсийн **95%** хувьд нь өвчтөний түүхийг хүртээмжтэй хэлбэрээр гаргаж өгөөгүй байна.



- Сурах бэрхшээлтэй хүмүүсийн **59%** хувь, танин мэдэхүйн бэрхшээлтэй хүмүүсийн **64%** хувь нь эмч нар тэдэнтэй шууд харьцалгүй өрөөнд байгаа өөр хэн нэгэн хүнтэй харьцаж байсан тухай мэдээлжээ.
- Танин мэдэхүйн бэрхшээлтэй хүмүүсийн **79%** хувь нь эмч, өвчтөний хоорондын харилцааг үр дүнтэй болгоход хамгийн их нөлөөлдөг үйл ажиллагаа болох шинж тэмдгээ эмчид тайлбарлах, асуулт асуухад эмч хэтэрхий бага цаг зарцуулсан тухай мэдээлжээ.<sup>11</sup>

### 1. Хэлэлцэх/Төлөвлөх

Оролцогчдод дүрийн тоглолтдоо бэлтгэх хангалттай хугацаа өг.

### 2. Дүрд тоглох

Багууд ээлжлэн дүрийн тоглолтоо үзүүлнэ. Тоглолт бүрийн дараа дараах асуултуудын дагуу тайлбар ав:

- “Хамгийн муу” үр дагавартай өөр тохиолдол байж болох уу?
- “Хамгийн сайн” үр дагавартай тохиолдлын талаар нэмэх зүйл байна уу?

### 3. Хэлэлцэх

- Дүрийн тоглолтууд үнэмшилтэй байж чадсан уу?
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тухай нөхцөлд байж болох эрүүл мэндийн хамгийн сайн үйлчилгээг хүргэхийн тулд юу хийх хэрэгтэй вэ?
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст боломжийн хамгийн сайн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхийн тулд эмч, эрүүл мэндийн ажилтнуудад ямар төрлийн сургалтууд хэрэгтэй вэ?

Сургагч багшид: Эдгээр сценарийг оролцогчдынхоо хэрэгцээ, нөхцөл байдалд тохируулан өөрчилж болно (жишээлбэл, өөр орчин, хөгжлийн бэрхшээлийн өөр төрөл, өвчин эмгэгийн өөр хэлбэр, үүний дотор бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндтэй холбоотой асуудал, эсвэл өөр төрлийн саад тотгор зэргийг ашиглаж болно).

#### Сценари 1:

Хосе бүсэлхийнээс доош мэдээгүй учир тэргэнцэр хэрэглэдэг суугаа хүн. Овон товон ихтэй гадаргуутай явган хүний замаар явж байтал тэргэнцэр нь онхолдож хөлөө хугалж, духаа шалбалжээ.

#### Сценари 2:

Алика сонсголгүй бөгөөд гэдэс нь өвдөж халуураад эмч дээр ганцаараа иржээ. Тэрээр бичиг үсэг тайлагдсан учир эмчтэйгээ бичгээр харьцах чадвартай.

#### Сценари 3:

Карен оюуны хомсдолтой, 28 настай, гэр бүлтэйгээ хамт амьдардаг.

Тэрээр бие даасан нийгмийн амьдралтай, найз залуутай, хүнсний нэгэн дэлгүүрт ажилладаг. Ээж нь түүнтэй хамт эмч дээр иржээ. Тамхи татаж эхэлснээсээ хойш өнгөрсөн нэг жилийн дотор хэд хэдэн удаа амьсгалын замын ноцтой халдвар авч байсан.

11 “Эрүүл мэндийн хүртээмж” төсөл. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалагчид.  
[http://www.dralegal.org/projects/health\\_access/index.php](http://www.dralegal.org/projects/health_access/index.php)

Нөөц хувилбар: Хүртээмжтэй үзлэгийн өрөөний загвар зохио. Янз бүрийн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээнд нийцүүлэхийн тулд тэр өрөө ямар байх ёстойг зурах, эсвэл түүний шинж тэмдгүүдийг тоочиж бичих даалгавар өгнө.

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭН ДЭХ ТЭГШ БАЙДАЛ, ҮЛ АЛАГЧЛАЛ

ХБХЭК-ийн 25 дугаар зүйлд “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөгжлийн бэрхшээлийн улмаас алагчлалгүйгээр эрүүл мэндийн дээд түвшний стандартад хүрэх эрхийг хүлээн зөвшөөрнө” гэсэн бөгөөд Оролцогч улсууд нь:

*... хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүн амд суурилсан нийтийн эрүүл мэндийн хөтөлбөр, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн салбарыг оролцуулан бусад хүнд хүргэдэгтэй ижил түвшин, чанар, стандарт бүхий үнэ төлбөргүй буюу худалдан авах чадавхид нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хөтөлбөрүүдээр хангах үүрэгтэй ажээ.*

Уг шаардлага нь дээр дурьдсан эрүүл байх эрхийн суурь дөрвөн зарчмын нэг болох “үл алагчлах” зарчмыг баталгаажуулж байгаа ба энэ зарчмыг Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос гаргасан Ерөнхий зөвлөмж №14-т дараах байдлаар тодорхойлжээ:

*Үл алагчлал: эрүүл мэндийн байгууллага, эрүүл мэндийн бараа, үйлчилгээ нь хориглосон аливаа үндэслэлээр хуулиар болон бодит амьдрал дээр ялгаварлан гадуурхалгүйгээр хүн болгонд, ялангуяа хүн амын хамгийн эмзэг, орхигдсон хэсэгт хүртээмжтэй байх ёстой.*

Гэтэл эрүүл мэндийн тогтолцооны зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг алагчлах явдал арилахгүй байгаа юм.

### **Хөгжлийн бэрхшээлээс болж эрүүл мэндийн үйлчилгээг хязгаарлаж байгаа тухай жишээ**

ХБХЭК-д “хөгжлийн бэрхшээлийн улмаас эмнэлгийн тусламж, эрүүл мэндийн үйлчилгээ, эсвэл хоол хүнс, ундны асуудалд алагчилж, үгүйсгэх”-ийг хориглосон байдаг. Гэтэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээс айж эмээх, тэдний амьдралын үнэ цэнийг дутуу үнэлэх зэрэг хандлага, мөн урт хугацааны асаргаа сувилгаанд шаардлагатай хөрөнгө мөнгөний хэрэгцээ зэрэг эмнэлгийн бус олон хүчин зүйлийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхах, тэр ч бүү хэл эрүүл мэнд, цаашлаад амь насанд нь халтай шийдвэр гаргах зэрэг явдал гарч болзошгүй.

Гэхдээ эрүүл мэндийн тусламж үйлчилгээ бол хязгаартай, ховор нөөц мөн. Бараг бүх улсад эм, эмнэлгийн ор, эмч, эрүүл мэндийн бусад үйлчилгээний хэрэгцээ нь эдгээр үйлчилгээг хүргэхэд зарцуулах боломжтой нөөц хөрөнгөнөөс хамаагүй давсан байдаг. Хүмүүс хүссэн, бүр шаардлагатай эмчилгээ, шинжилгээ, үйлчилгээгээ тэр бүр авч чаддаггүй. Эрүүл мэндийн энэ хязгаарлагдмал нөөцийг нийгмийн бүх гишүүнд



шударгаар хүргэж хуваарилах ярвигтай асуудлаар шийдвэр гаргах хариуцлагыг засгийн газар, нийгэм хүлээнэ. Үүнд бэлэн хариулт байхгүй ч хүний эрхийн байр сууринаас харах юм бол эрүүл мэндийн үйлчилгээг хүргэхдээ хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхах нь хүний эрхийн зөрчил болно.

## ДАСГАЛ 8.4: Эмнэлгийн үйлчилгээний талаарх шийдвэр гаргах тухай кейс

### 1. Хэлэлцэх

Энэ дасгалаар эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой шийдвэр гаргахад хөгжлийн бэрхшээл хэрхэн нөлөөлж болох тухай асуудлыг судлах гэж байгааг тайлбарлана. Оролцогчдыг гурван багт хуваагаад, баг бүрт нэг кейс өгөөд, тухайн тохиолдолд ямар арга хэмжээ авах тухай шийдвэр гаргах даалгавар өг.

**Кейс 1:** Насаар чацуу хоёр хүүхдэд зүрх шилжүүлэн суулгах хэрэгтэй болжээ. Тэдний нэг нь Дауны хам шинжтэй, нөгөө нь хөгжлийн бэрхшээлгүй хүүхэд. Хоёуланд нь зүрхний гажигаас өөр өвчин байхгүй. Зүрх шилжүүлэн суулгах хагалгаа амжилттай болох магадлал хоёр хүүхдийн хувьд адил. Хэрэв ядуурал, асаргаа дутагдах зэрэг хүний насыг богиносгодог бусад хүчин зүйл хоёр хүүхдэд тохиолдохгүй бол Дауны хам шинжтэй хүн ийм төрлийн хөгжлийн бэрхшээлгүй хүнээс дунджаар 20 насаар богино наслах тооцоо байдаг.

Энэ нөхцөлд хоёр хүүхдийн алинд нь зүрх шилжүүлэн суулгах вэ?

**Кейс 2:** ХДХВ-ийн халдвартай хоёр эмэгтэй өртөг өндөртэй вирусын эсрэг эм авахаар хязгаарлагдмал хөрөнгө нөөцтэй улсын нэгэн эмнэлэгт ханджээ. Нэг нь сэтгэц-нийгмийн архаг өвчтэй, нөгөө нь хөгжлийн бэрхшээлгүй ажээ. Уг эмнэлэг нэг л шинэ өвчтөн авах боломжтой.

Энэ нөхцөлд хоёр эмэгтэйн алинд нь эмийг өгөх вэ?

**Кейс 3:** Нэгэн тосгоны хоёр хүн газарт булсан тэсрэх бөмбөг дээр гишгэж хоёулаа өвдөгнөөс доош хөлгүй болжээ. Нэг нь долоон настай сурагч, нөгөө нь 40 настай тариачин. Хоёулаа хиймэл хөлтэй болохыг хүсэж байгаа боловч зөвхөн нэгэнд нь л хиймэл хөл өгөх нөөц хөрөнгө байна. Насанд хүрсэн хүн энэ хиймэл хөлөө олон жил хэрэглэх бол хүү өсөж том болохын хэрээр хэд хэдэн удаа хиймэл хөлөө солих хэрэгтэй болно. Тиймээс хүүгийн нөхөн сэргээлт насанд хүрсэн тариачныхаас хамаагүй илүү үнэтэй болно.

Энэ нөхцөлд хиймэл хөлийг хэнд нь өгөх вэ?

### 2. Илтгэх/Хэлэлцүүлэх

Баг бүрээс томилогдсон илтгэгч эхлээд кейсээ тайлбарлаад, дараа нь гаргасан шийдвэрээ танилцуулна. Багийн ажлыг танилцуулсны дараа бусад багууд доорхтой ижил төрлийн асуулт, бусад нэмэлт тайлбар өгнө:

- Танай баг шийдвэрээ хэрхэн гаргасан бэ? Танай шийдвэрт ямар хүчин зүйлс нөлөөлсөн бэ?



- Хөгжлийн бэрхшээлээс үүдэлтэй ялгаварлан гадуурхал гарав уу?
- Иймэрхүү шийдвэрийг бодит амьдрал дээр хэрхэн гаргах ёстой вэ?

### 3. Хэлэлцэх

- Эдгээр тохиолдолд хүний эрхийн ямар зарчмууд хөндөгдөж байна вэ?
- Ийм төрлийн шийдвэр гаргах үүрэг хариуцлагыг хэн хүлээх ёстой вэ? Эмч үү? Засгийн газар уу? Ёс зүйн хороо юу?
- Иймэрхүү шийдвэрийг бодит амьдрал дээр хэрхэн гаргадаг вэ?
- Хөгжлийн бэрхшээлээс үүдэлтэй ялгаварлан гадуурхлаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хэрхэн хамгаалах вэ?

### Эрүүл мэндийн сурталчилгаа ба өвчнөөс урьдчилан сэргийлэх ажил

Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн дийлэнх нь эрүүл аж төрөх ёсыг сурталчлах, урьдчилан сэргийлж болох өвчнөөс өөрийгөө хэрхэн хамгаалах тухай мэдээлэл, боловсрол олгох зорилготой арга хэмжээнүүд байдаг. Эдгээр хөтөлбөрт багтдаг мэдээллийн зарим жишээг дурьдвал:

- Шим тэжээлтэй хоол идэх, биеийн тамир хийх, жингээ хянахын ашиг тусыг ухуулан таниулах;
- Ус, хөрсний бохирдол, ажлын байран дахь аюул зэрэг байгалийн болон хүнээс шалтгаалсан орчны аюулыг таниулах;
- Тамхи, хар тамхи хэрэглэх, хамгаалалтгүй бэлгийн харьцаанд орох зэрэг зан үйлтэй холбоотой эрүүл мэндийн эрсдэлүүдийг ойлгуулах;
- Дархлаажуулалт, гэр бүл төлөвлөлт, ХДХВ/ДОХ болон бусад БЗДХ-аас урьдчилан сэргийлэх, гараа угаах, ханиад томуутай хүнээс хол байх, хумхаа өвчнөөс сэргийлэхийн тулд шумуулын тор хэрэглэх зэргээр халдварт өвчнөөс сэргийлэх арга замуудыг таниулах зэрэг болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ч бусад хүний адил эрүүл сонголтын ашиг шимийг хүртэхийн зэрэгцээ өвчин, осолд өртөж хохирдог. Гэхдээ нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүд нь хүртээмжтэй арга хэлбэрээр мэдээлэл хүргэж чаддаггүй, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүрч ажиллах хүчин чармайлт гаргадаггүй зэргээс болж халдварт өвчин, урьдчилан сэргийлж болох бусад өвчлөлүүд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дунд хүн амын бусад бүлгийнхээс илүү тохиолддог. Нийгмийн эрүүл мэндийн төсөл, хөтөлбөрийн үр өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд төлөвлөлт, хэрэгжүүлэлтэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний төлөөллийн байгууллагуудыг оролцуулах хэрэгтэй.

ХБХЭК-д жендерийн мэдрэмжтэй эрүүл мэндийн үйлчилгээг онцлоод, бэлгийн болон нөхөн үржихүйн, мөн хүн амд суурилсан эрүүл мэндийн хөтөлбөрүүдэд тэгш хамруулах зарчмыг суулгаж өгөх хэрэгцээг дурьдсан байдаг. ХБХЭК нь нийгмийн эрүүл мэндийн бүх хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусадтай адил тэгш оролцуулахыг шаардсан байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бэлгийн амьдралгүй гэж үзэх, эсвэл тэднийг мартан орхигдуулах, тэдний хэрэгцээнд ач холбогдол өгөхгүй байх, үндэсний эрүүл мэндийн тогтолцоо, улсын болон олон улсын эрүүл мэндийн бодлогод тэднийг ялгаварлан гадуурхсан хандлага гардаг энэ л учир шалтгааны улмаас уг асуудлыг конвенцид тусгайлан авч үзсэн юм.



## Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ба ХДХВ/ДОХ-оос сэргийлэх арга хэмжээ

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ХДХВ/ДОХ-ын халдварт өртөх эрсдэл өндөртэй бүлэгт багтаахгүй байх нь элбэг. Дэлхийн Банк, Йелийн Их сургуулийн хамтарсан нэгэн судалгаа дараах дүгнэлтүүдэд хүрчээ:

*Бие махбодын, мэдэрхүйн (сонсгол, хараа), оюуны бэрхшээлтэй хүмүүсийг ХДХВ-ын халдварт өртөх эрсдэл багатай бүлэг гэж үзэх нийтлэг хандлага байдаг. Тэднийг бусад хүмүүстэй харьцуулахад бэлгийн идэвхгүй, архи, хар тамхи хэрэглэх магадлал багатай, хүчирхийлэлд өртөх, хүчингийн гэмт хэргийн хохирогч болох эрсдэл багатай гэсэн ташаа ойлголт түгээмэл байдаг.<sup>12</sup>*

Гэтэл олон тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс харин ч бусдаас илүү эрсдэлд өртдөг болохыг харуулсан нотолгоо хангалттай байгаа бөгөөд ХДХВ/ДОХ-оос хамгаалах нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүрдэггүйгээс энэ эрсдэл улам лавширдаг ажээ.

*Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг алагчлах явдал нь олон хэлбэрээр илэрдэг. ХДХВ-ээс сэргийлэх сургалтыг тэргэнцэртэй хүн орж чадахааргүй байранд зохион явуулах нь элбэг. ДОХ-ын шинжилгээний төвийн ажилтнууд англи, суахили хэлээр уншиж, бичиж чадахгүй сонсголын бэрхшээлтэй хүмүүстэй хэрхэн харьцахаа мэддэггүй тул олон хүн үйлчилгээ авч чадалгүй буцдаг. Голдуу радио, телевизээр цацагддаг олон нийтийн боловсролын кампанит ажлууд хараагүй, сонсголгүй хүмүүст мэдээлэл хүргэх асуудалд огт анхаардаггүй байна.<sup>13</sup>*

## Олон нийтийн оролцоонд түшиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээ

ХБХЭК нь хөгжлийн бэрхшээлийн улмаас шаардлагатай болсон эрүүл мэндийн тусгай тусламж, үйлчилгээг Оролцогч талууд хангаж өгөх ёстой болохыг сануулаад, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг “бүх газарт, тухайлбал, хөдөө орон нутагт ч аль болох гэрт нь ойр газар үзүүлэх”-ийг шаарджээ. (Амьдарч буй орчиндоо байх эрхийн талаар уг гарын авлагын Хэсэг 2-ын “Бүлэг 11. Амьдарч буй орчиндоо нэр төртэйгөөр, бие даан амьдрах” хэсгээс (хуудас 176) уншина уу). Эрхзүйн болон нийгмийн алагчлалыг арилган хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эмнэлэг, асрамжийн газарт тусгаарлан амьдруулахаас татгалзсан улс орнуудад хүртэл сэтгэц-нийгмийн бэрхшээлтэй хүмүүс сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээг зөвхөн сэтгэл мэдрэлийн эмнэлгээс авах боломжтой байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс “бусад хүмүүстэй ижил чанартай эрүүл мэндийн үйлчилгээг бусад хүмүүст үйлчилдэг нэг л тогтолцоогоор дамжуулан хүртэх эрхтэй” болохыг Стандарт дүрмүүдэд баталгаажуулсан байдаг. Тиймээс эрүүл мэндийн үйлчилгээ авахаар хүн болгон

12 Нора Гроус. “Эрсдэлд өртсөн хүн ам: ДОХ/ХДХВ ба хөгжлийн бэрхшээл: Нуугдмал дуу хоолойг сонсоё” Йелийн Их сургууль, Дэлхийн Банкны судалгаа. Вашингтон: Дэлхийн Банк, 2004. <http://sitesources.worldbank.org/disability/resources/health-and-wellness/HIVAIDS.pdf>

13 “Африкийн дүлий, сохор хүмүүст ДОХ-оос сэргийлэх сурталчилгаа хүрэхгүй байна” Нью Йорк Таймс, 2004 оны 3 дугаар сарын 28.

хол зам туулдаг газарт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бусдын л адил хүндрэл, бэрхшээл тулгардаг гэж та бодож болох юм. Гэтэл, жишээлбэл, нийтийн тээвэр хүртээмжгүй газарт хөгжлийн бэрхшээл нь энэ замыг туулж үйлчилгээнд хүрэхэд саад болж байгаа бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдаас илүү таагүй нөхцөлд орж, энэ нь түүний эрүүл мэндийн үйлчилгээг тэгш хүртэх эрхийг зөрчиж байгаа явдал болно. Ийм нөхцөлд хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэндийн үйлчилгээг гэрт нь, эсвэл түүний хүрч чадах орон нутгийнх нь орчинд үзүүлэх, эсвэл нийтийн тээврийг хүртээмжтэй болгох тусгай арга хэмжээ авах хэрэгтэй.

## БИЕ ДААСАН БАЙДАЛ БА ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ШИЙДВЭР ГАРГАЛТАД ОРОЛЦОХ НЬ

### Мэдээлэлд үндэслэсэн зөвшөөрөл ба эрхзүйн чадамж

ХБХЭК-ийн “Хуулийн өмнө тэгш байх эрх” гэсэн 12 дугаар зүйлд авч үзсэн эрхзүйн чадамж, шийдвэр гаргалтанд оролцох эрх нь шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх өргөн хүрээт ойлголтын үргэлжлэл юм. 12 дугаар зүйлд тунхагласан эрүүл мэндтэйгээ холбогдолтой шийдвэрийг хүн өөрөө гаргах эрх чөлөөтэй холбоотой зарчмуудыг конвенцийн 25 дугаар зүйлд давтаад, Оролцогч талууд эрүүл мэндийн мэргэжилтнүүдийнхээ:

*... хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бусдад үзүүлдэгийн нэгэн адил чанартай үйлчилгээ, тухайлбал хүний эрх, нандин чанар, хараат бус байдал болон хөгжлийн бэрхшээлтэй хүнд боловсрол олгох тусгай хэрэгцээ, төрийн эзэмшлийн болон хувийн эмнэлгийн байгууллагуудын ажилтнуудын баримтлах ёс зүйн хэм хэмжээний талаарх ойлголтыг нэмэгдүүлэх шаардлагатай гэжээ.*

Эрүүл мэндтэйгээ холбоотой асуудлаар шийдвэр гаргахдаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн биеэ даан хараат бусаар шийдвэр гаргах эрхийг хүндлээгүйн улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүчээр үргүй болгох, сэтгэц-нийгмийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гаргадаг зарим зан үйлийг “эмчлэх”, хүнлэг бус арга хэрэглэх, тархины лоботомид хагалгаа хийх, эмийн болон эмийн бус био-анагаахын судалгаа, туршилтад оруулах зэрэг жигшим явдлууд гарч байжээ. Эрүү шүүлт, бусад төрлийн хэрцгийллээс ангид байх эрхийн тухай энэ гарын авлагын Хэсэг 2-ийн “Бүлэн 6. Эрүү шүүлт болон бусад хэлбэрийн хэрцгийллээс ангид байх эрх” хэсгээс дэлгэрүүлж уншина уу.

Эмчилгээ нь эрүү шүүлт, хүнлэг бус харьцаа гэж тооцож болох хэмжээнд хүрээгүй ч гэсэн хөгжлийн бэрхшээлтэй өвчтөнөөс үнэн зөв мэдээлэлд үндэслэсэн зөвшөөрөл авалгүй, өөрийг нь идэвхтэй оролцуулалгүй гаргасан эмчийн шийдвэр нь хүний эрхийн болон эмчийн ёс зүйн зөрчил болно. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдийн эрүүл мэндтэй холбоотой шийдвэрийг бусдын адил өөрсдөө гаргах эрхтэй бөгөөд үйлчлүүлэгчийн хүслийг хүндэтгэх нь эмчийн мэргэжлийн хариуцлагын нэгэн чухал зарчим мөн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусад хүмүүсийн адил бүх эмчилгээ, амь залгуулах арга хэмжээ хүртэхийн зэрэгцээ энэ төрлийн эмчилгээнээс өөрийн хүсэлтээр татгалзах эрхтэй. Энэ бол амьд явах эрх, хувийн нэгдмэл байдлаа хадгалах эрх болон ямар эмчилгээ хийлгэх тухай



шийдвэр гаргах эрхийн хүрээнд адил тэгш байх асуудал юм. Эдгээр зарчим нь хүний эрхийн ч, аль МЭӨ IV зуунд Гиппократын үндэслэж, түүнээс хойш анагаах ухааны салбарт тасралтгүй баримталж ирсэн эмчийн ёс зүйн тулгын чулуу билээ.

Хүн ухаан алдах, эсвэл өвчнөөсөө болж өөрийн хүслээ илэрхийлэх чадваргүй болсон үед түүнд ямар эмчилгээ хийх шийдвэрийг эмч, гэр бүлийнхэн нь гаргадаг. Харин өвчтөн өмнө нь амь залгуулах эмчилгээ авах, эсвэл энэ төрлийн эмчилгээнээс татгалзах хүслээ илэрхийлж байсан бол тэр хүслийг хүний эрх, эмчийн ёс зүй, мөн үндэсний болон олон улсын хууль тогтоомжийн дагуу хүндэтгэж биелүүлэх ёстой. Өөрийнхөө амьдралд тэвчишгүй нөхцөл, тэсвэрлэшгүй шаналгаа гэж юу болохыг хүн болгон өөрөө тодорхойлох эрхтэй. Амьдралаа уртасгахын оронд үхэх сонголт хийх хэрэгцээ хэзээ нэгэн цагт гарна гэж бодож төсөөлөхөд эвгүй ч гэлээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өмнөөс өөр хүн шийдвэр гаргах олон тохиолдол гарах магадлалтай. Энэ үед тэр хүн амьдралын чанар, амьд явахын утга учрын тухай өөрийнхөө ойлголтод үндэслэн шийдвэр гаргадаг. Та өөрөө эмчлүүлэхийг хүсэж байлаа ч үнэн сэтгэлээсээ таныг хайрладаг гэр бүлийн гишүүн, сайн санаа өвөрлөсөн эмч хүн тухайн нөхцлийг та өөрөө найдваргүй, тэсвэрлэшгүй гэж ч үзэж байгаа байх гэж бодоод таны өмнөөс шийдвэр гаргаж мэднэ.

Онцгой чухал эмнэлгийн шийдвэр гаргах тэр л үед та өөрийгөө илэрхийлэх боломжгүй болсон байвал таны хүсэл зоригийг бусдад мэдүүлж, хүндэтгүүлэх хамгийн сайн арга зам бол таны өмнөөс хүслийг чинь илэрхийлж “ярих” “Урьдчилсан зааварчилгаа” үлдээх явдал юм.

## ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ Үхэх, сэхэхийг шийдэх бодлого

2004 онд Их Британийн Дээд шүүх бага тархины атаксия өвчтэй 43 настай Оливер Лесли Буркегийн гаргасан нэхэмжлэлийн дагуу шийдвэр гаргажээ. Тэрээр Их Британий эмнэлгийн үйлчилгээнд хяналт тавьдаг Эмч нарын ерөнхий зөвлөлөөс (ЭЕЗ) 2002 онд гаргасан “Амь залгуулах эмчилгээг түдгэлзүүлэх, зогсоох: жишээ болохуйц сайн туршага, шийдвэр гаргалт” нэртэй удирдамжийн заалтуудыг шүүмжлэн шүүхэд хандсан байна. Энэ удирдамжийн дагуу Буркег тэжээл, шингэнээр хангаж байсан системийг таслах шийдвэрийг эмнэлэг гаргаад байтал Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн комисс Буркегийн нэрийн өмнөөс энэ хэрэгт оролцжээ. “Хатан хаан, Эмч нарын ерөнхий зөвлөлийн эсрэг” нэртэй энэ хэрэгт Бурке амь залгуулах эмчилгээ авах ёстой гэсэн шийдвэрийг шүүх гаргажээ.

Дээрх шүүх хуралд гэрчээр оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалагч Жейн Кампелл энэ хэргийн тухай Хатан хааны нэрэмжит Анагаахын нийгэмлэгийн “Эмчилгээг түдгэлзүүлэх” симпозиум дээр ярихдаа:

*Шүүхийн шийдвэрийг сонсоод миний сэтгэл хоёр шалтгаанаар асар их хөдөлсөн. Нэгд, миний өөрийн ирээдүйн аюулгүй байдлын үүднээс, хоёрдугаарт, хөгжлийн бэрхшээлтэй болон хүнд өвчтэй хүмүүсийн өмнөөс “өөрийнх нь сайн сайхны төлөө” шийдвэрийг дан ганц эмч нар гаргахыг шаардах эрхгүй бөгөөд ийм хүлээлт байж болохгүй гэдгийг манай шүүх, магадгүй анх удаагаа, ойлгосон учраас би ингэж их баярласан юм Намайг төрөхөд эмч нар намайг нэг жил ч амьдрахгүй гэсэн шиг хүүхдээ аваад харь, хамт байх хугацаагаа аль болох бүрэн дүүрэн*

эдлэхийг хичээ гэж ээжид минь хэлж байсан. Хүнд хэлбэрийн хөгжлийн аргагүй байсан байх л даа.. Уушигны олон халдвар, амь насанд минь аюултай бусад олон өвчинтэй тулгарсан хүүхэд насыг туулахад надад тусалсан эмнэлгийн ажилтнуудад би талархаж явдаг.

Гэтэл 40 жилийн дараа минийхтэй ижил өвчтэй (нурууны булчингийн хатингиршил) 18 сартай хүүхэд уушигны халдвар авахад эмч нар түүнд хиймэл амьсгалын аппарат залгахгүй байхаар шийдсэн. Эцэг эх нь энэ шийдвэрийг эсэргүүцэн шүүхэд хандсан юм. Шүүхэд “С нэртэй хүүхэд” гэдэг нэрээр түүний хэргийг авч хэлэлцсэн юм. Эмч нар хүүхдийн хөгжлийн бэрхшээл үнэхээр аюултай учир тэрээр чанартай амьдралаар амьдарч чадахгүй гэж байлаа. Дээрээс нь хүүхдэд ” насан туршид нь бүрэн асаргаа шаардлагатай” учир төсвийн хөрөнгө, гэр бүлдээ ч хүнд дарамт болно гэж тэд хэлж байлаа. Өөр эмч нараас санал авах нь зүйтэй гэж шүүх шийдсэн ч эмч нар бүгд л ийм өвчтэй хүүхэд хоёр жилийн ч насгүй, амьд үлдсэн ч амьдрал нь амьдын там болно гэж эргэлзээгүй хэлж байсан юм.

Ийм өвчтэй насанд хүрэгчид бид эмч нарынхаас маш өөр зүйл өгүүлж чадах байсан ч энэ тухай бид хүүхдийг нас барсны дараа л мэдсэн юм.<sup>14</sup>

Урьдчилсан зааварчилгааг эрхзүйн хүчинтэй баримт бичиг мөн эсэх талаар улс орнууд өөр өөр бодлоготой байж болох бөгөөд тухайлбал, үүнийг бичигч нь тухайн баримт бичгийг үйлдэх үедээ сэтгэцийн хувьд чадамжтай, саруул ухаантай байсныг нотлох гэрч байхыг шаардаж мэднэ. Мөн Урьдчилсан зааварчилгааны олон янзын хэлбэр, загвар байдаг. Танай улсад ямар шаардлага тавьдагийг та олж мэдэх хэрэгтэй. Гэхдээ та ямар хэлбэр загвар, шаардлага тавьж байгааг мэдэхгүй байлаа ч гэсэн хүслээ илэрхийлж, таны хувьд “хүлээн зөвшөөрөхүйц амьдралын чанар” гэж юу болохыг өөрөө тодорхойлж үлдээх нь маш хүчтэй хэрэгсэл юм. Та энэ баримт бичгийнхээ тухай гэр бүл, эмч, засаг захиргааны ажилтан, мөн таны эмчилгээний тухай шийдвэр гаргахад чухал үүрэгтэй оролцох бусад хүмүүст мэдэгдсэн бол тэд таны шийдвэрийг хүндэтгэх ёстой. Доор бид Урьдчилсан зааварчилгааны маш энгийн нэг загварыг толилуулав. Таных илүү нарийвчлалтай, тодорхой байж болно.

## ДАСГАЛ 8.5: Эрүүл байх эрхээ дэмжих амлалт авах нь

Хүний эрх бол эдлэх эрх, хүлээх үүргийн нэгдэл гэдгийг тайлбарла.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл байх эрхийн талаар судалж мэдсэний эцэст оролцогчид өөрсдөө тодорхой үйл ажиллагаа явуулахад бэлэн болсон эсэхийг асуу.
- Мэдээлэл цуглуулах, ажлаа төлөвлөх гээд хийх зүйл их байгаа ч өөрчлөлт хийх чин эрмэлзэл маш чухал гэдгийг тэмдэглэн хэл.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст боломжийн хамгийн сайн эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхээ бүрэн эдлэхэд нь нэмэр болох жижиг ч хамаагүй ямар ажлыг ирэх сард хийхийг хүсэж байгаа, хийх боломжтой байгааг оролцогч бүрээр хэлүүл.

14 Жейн Кампелл. Эзэн хааны анагаах ухааны нийгэмлэгээс зохион байгуулсан “Эмчилгээг түдгэлзүүлэх” симпозиумд хэлсэн үг. 2004 оны 11 дүгээр сар.  
<http://www.leeds.ac.uk/disability-studies/archiveuk/Campbell/Withholding%20Treatment1%20%20Jane's%20final%20draft%208.11.04.pdf>

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах нөлөөллийн ажил хэрхэн төлөвлөх талаар “Хэсэг 3. Нөлөөлөл! Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа” (хуудас 278) хэсгээс уншина уу.

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ АВАХТАЙ ХОЛБООТОЙ УРЬДЧИЛСАН ЗААВАРЧИЛГААНЫ ЗАГВАР

### (ГЭРЭЭСЛЭЛ)

\_\_\_\_\_ миний бие хүсэл зоригоо бусдад илэрхийлж чадахгүй болсон үед надад эрүүл мэндийн ямар тусламж үзүүлээсэй хэмээн хүсэж байгаагаа миний төлөө санаа тавьдаг бүх хүнд энэ баримтаар мэдэгдэхийг хүсэж байна.

#### ХЭСЭГ 1.

Намайг боломжийн чанартай амьдралд эргүүлэн оруулах эмчилгээг эмчлэгч эмч надад хийж үзээсэй гэж хүсэж байна. Гэвч, хэрэв амьдралын минь чанар миний хүлээн зөвшөөрөхөөргүй хэмжээнд хүрч, миний биеийн байдал сайжрахаргүй (засал авахааргүй) болох юм бол миний амьдрах хоног хугацааг уртасгах эмчилгээг зогсоохыг хүсэж байна.

Миний хувьд хүлээн зөвшөөрч чадахгүй амьдралын чанар гэж дараах байдлыг ойлгож байна (тохирохыг нь тэмдэглэ):

- Ухаан орохгүй байх (архаг кома, эсвэл байнгын вегетатив байдал)
- Хэрэгцээгээ илэрхийлж чадахгүй болох
- Гэр бүл, найз нөхдөө танихгүй болох
- Бүрэн эсвэл бараг бүрэн асаргаанд орох
- Бусад:

Зөвхөн нэгийг тэмдэглэ:

- Дээр дурьдсан байдалд орсон ч надад тэжээл, шингэнийг судсаар, эсвэл гуурсаар хийж байхыг хүсэж байна
- Дээр дурьдсан байдалд орвол надад тэжээл, шингэнийг судсаар, эсвэл гуурсаар хийж байхыг ХҮСЭХГҮЙ байна

#### ХЭСЭГ 2 (Заавал бөглөх шаардлагагүй).

Зарим хүн эдгэх найдвар байлаа ч зарим төрлийн эмчилгээнээс ямар ч тохиолдолд татгалздаг.

Ямар ч тохиолдолд авахыг хүсэхгүй байгаа эмчилгээг тэмдэглэнэ үү:

- Зүрхний массаж
- Хиймэл амьсгал (амьсгалын аппаратаар)
  - Хоолны гуурс
  - Диализ (хиймэл бөөр)
- Бусад:

#### ХЭСЭГ 3

Нас нөгчих дөхсөн үед надад дараах зүйлс чухал байх болно:

- Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын Үндсэн Хууль:  
[http://www.who.int/governance/eb/who\\_constitution\\_en.pdf](http://www.who.int/governance/eb/who_constitution_en.pdf)
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн өмгөөлөгчид:  
[http://www.dralegal.org/projects/health\\_access/index.php](http://www.dralegal.org/projects/health_access/index.php)
- Франсуа Хавьер Баньогийн нэрэмжит Эрүүл мэнд, хүний эрхийн төв:  
<http://www.hsph.harvard.edu/fxbcenter>
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны Ерөнхий зөвлөмж №15:  
<http://www.umn.edu/humanrts/gencomm/escgencomm5.htm>
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны Ерөнхий зөвлөмж №14:  
<http://www.umn.edu/humanrts/gencomm/escgencomm14.htm>
- Гроус, Нора. Эрсдэлд өртсөн хүн ам: ДОХ/ХДХВ ба хөгжлийн бэрхшээл: Нуугдмал дуу хоолойг сонсоё”. Йелийн Их сургууль, Дэлхийн Банкнаас хийсэн ДОХ/ХДХВ ба хөгжлийн бэрхшээлийн талаарх дэлхийн тандалтын судалгааны дүн. Вашингтон хот, Колумбийн Тойрог: Дэлхийн Банк, 2004  
<http://sitesources.worldbank.org/disability/resources/health-and-wellness/HIVAIDS.pdf>
- *Эрүүл мэндийн үйлчилгээг хүртэхэд тулгардаг саад тотгорыг арилгах нь: Эрүүл мэндийн мэргэжлийн ажилтнуудад зориулсан удирдамж.* Нийтлэг дизайны төв ба “Хөгжлийн бэрхшээл ба Эрүүл мэнд” байгууллагын Умард Каролина дахь салбар:  
<http://www.fpg.unc.edu/~ncodh/rbar>
- Эрүүл байх эрх: хөгжлийн бэрхшээлийн талаарх үзэл баримтлал ба Америкийн туршлага”. Хөгжлийн бэрхшээлийн асуудлаарх Үндэсний зөвлөл, 2005:  
<http://www.ncd.gov/newsroom/publications/2005/righttohealth.htm>
- Бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэндийн боломжийн хамгийн дээд стандарт бүхий үйлчилгээ авах хүн бүрийн эрхийн талаар хүний эрхийн комиссын тусгай илтгэгчийн мэдүүлэг:  
<http://www.ohchr.org/english/issues/health/right>
- Дэлхийн анагаах ухааны холбооноос гаргасан Өвчтөний эрхийн тухай Лиссабоны тунхаглал:  
<http://www.wma.net/e/policy/l4.htm>



## БҮЛЭГ 9. СЭРГЭЭХ, НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ЭРХ

### НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци

#### 26 дугаар зүйл: Сэргээлт, нөхөн сэргээлт

1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хараат бус байдлыг дээд зэргээр хангах, тэднийг бие махбод, оюун санаа, нийгмийн болон мэргэжлийн бүрэн чадавхитай болгох, нийгмийн бүхий л хүрээнд бүрэн хамрагдах, оролцох боломжийг олгох, эзэмшүүлэх үүднээс бүхий л үр дүнтэй, зохистой арга хэмжээ авна. Эл зорилгоор оролцогч улсууд, ялангуяа эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, боловсрол, нийгмийн үйлчилгээний салбарт өргөн хүрээтэй сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээ, хөтөлбөрүүдийг дараах арга замаар зохион байгуулан бэхжүүлж, өргөжүүлнэ:
  - a) тухайн хувь хүний зүгээс нэн түрүүн шаардлагатай байгаа хэрэгцээг олон талаас нь үнэлж, дүгнэсний үндсэн дээр аль болох эрт үед хэрэгжүүлж эхлэх;
  - b) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тухайн оршин суугаа орчинд нь болон нийгмийн амьдралын бүхий л салбарт сайн дурын үндсэн дээр оролцуулах болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тэдний амьдарч буй, ялангуяа хөдөө, орон нутаг дахь орчинтой нь аль болох ойртуулахад дэмжлэг үзүүлэх.
2. Оролцогч улсууд нь сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх салбарт ажилладаг мэргэжилтнүүд, ажилтнуудад зориулсан анхан болон үргэлжилсэн шатны сургалт зохион байгуулах ажлыг хөхиүлэн дэмжинэ.
3. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулагдсан сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээнд хэрэглэх туслах тоног төхөөрөмж, технологиудыг хүртээлтэй байлгах, тэдгээрийг хэрэглэх зааварчилгаа, мэдлэг олгох явдлыг хөхиүлэн дэмжинэ.

#### ЗОРИЛТУУД

Энэ бүлгийн мэдээлэл, дасгалууд нь оролцогчдод дараах зорилтыг хангахад туслах болно:

- Сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээ авах эрхийг тодорхойлох;
- Сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээ авах эрх нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд нь ямар ач холбогдолтой болохыг тайлбарлах;
- Сэргээх ба нөхөн сэргээх үйлчилгээ авах эрх, хүний бусад эрхийн хоорондын уялдааг ойлгох;
- Сэргээх ба нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн төлөвлөгөө боловсруулах үйл явцыг ойлгож авах;



- Сэргээх ба нөхөн сэргээх үйлчилгээ авах эрхийг хангах, эсвэл энэ эрхийг зөрчдөг арга хэлбэрүүдийг таньж мэдэх;
- **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенци (ХБХЭК)**-ийн сэргээх ба нөхөн сэргээх үйлчилгээ авах эрхтэй холбоотой заалтуудыг ойлгох.

ЭХЛЭЛ: СЭРГЭЭХ БА НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ  
ЭРГЭЦҮҮЛЭХ НЬ

**“Сэргээх үйлчилгээ”** гэж тодорхой ур чадвар, чадавхи, мэдлэгийг шинээр эзэмшихэд нь хүмүүст туслах зорилготой үйл явцыг хэлнэ. **“Нөхөн сэргээх үйлчилгээ”** гэж хөгжлийн бэрхшээлтэй болсон, эсвэл хөгжлийн бэрхшээлийн мөн чанар юмуу нөхцөл байдал нь өөрчлөгдсөний улмаас алдагдсан юмуу муудсан байж болох ур чадвар, чадавхи, мэдлэгийг дахин олж авахыг хэлнэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци (ХБХЭК)-д сэргээх ба нөхөн сэргээх үйлчилгээний зорилгыг “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хараат бус байдлыг дээд зэргээр хангах, тэднийг бие махбод, оюун санаа, нийгмийн болон мэргэжлийн бүрэн чадавхитай болгох, нийгмийн бүхий л хүрээнд бүрэн хамрагдах, оролцох боломж болон ур чадварыг эзэмшүүлэх үүднээс бүхий л үр дүнтэй, зохистой арга хэмжээ авах” гэж тодорхойлжээ. Бусад бүхий л төрлийн үйлчилгээ, эмчилгээний адилаар сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээнд хүний эрхийн зарчмуудыг баримтлан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүрэн оролцоог хангаж, зөвшөөрлийг авсан байх шаардлагатай.

Сэргээх болон нөхөн сэргээх үйлчилгээ нь ихэнхдээ хүний эрүүл мэндийн байдалтай уялдаатай учраас эрүүл байх эрхтэй холбоотой бодлогуудаар дамжин хэрэгждэг. Үнэн хэрэгтээ нөхөн сэргээлт нь илүү нарийн төвөгтэй, хамаагүй алсын зорилготой асуудал юм. Нөхөн сэргээлтийн эрүүл мэндтэй холбоотой зорилгууд нь чухал ач холбогдолтой ч ажил эрхлэлт, боловсрол, эсвэл зүгээр л амьдрах ухаантай холбоотой бусад хэсгүүд нь мөн ижил ач холбогдолтой. Сэргээх болон нөхөн сэргээх үйлчилгээ нь дээрх олон зорилтыг хангахад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст шаардлагатай бүхий л төрлийн цогц арга хэмжээг багтааж байгааг ойлгуулахын тулд ХБХЭК-д сэргээлт, нөхөн сэргээлтийн асуудлыг тусгай зүйл болгон оруулжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрхээ эдлэхэд нь тулгардаг саад тотгоруудыг арилгахын тулд олон янзын стратеги, механизм шаардлагатай болдог. Олон хүчин зүйлийн хавсарсан нөлөөллийн үр дүнд л нийгэм энгийн иргэдэд нээлттэй байдаг шигээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нээлттэй байх нөхцөл бүрддэг (тухайлбал, хүртээмжтэй орчин, тусгай хөтөлбөр болон технологиуд, нийгэм соёлын хандлагын өөрчлөлт, ялгаварлан гадуурхлын эсрэг хуулийн хэрэгжилт, хүний эрхийн зарчмуудын талаарх мэдлэг гэх мэт). Гэхдээ нийгмийн, хууль эрхзүйн, улс төрийн болон дэд бүтцийн орчныг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд нийцүүлэх оролдлогууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүн бүрт тэгш боломж бүрдүүлэхэд хангалттай арга хэмжээ болж чаддаггүй. Хувь хүний өвөрмөц нөхцөл, хөгжлийн бэрхшээлийн онцлогоос хамааран хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст туслах техник технологи, тусгай сургалт, боловсрол, эсвэл ур чадварын хөгжил гэх мэт нэмэлт дэмжлэг шаардагдаж болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бусадтай адил тэгш амжилтад хүрэхэд шаардлагатай нөхцлөөр хангасан ерөнхий орчин, хөтөлбөр, тогтсон арга дадлага, ажлын байрыг бүрдүүлж өгөхөд чиглэсэн **“Боломжит тохируулгын”** зарчмаас ялгаатай нь сэргээлт ба нөхөн сэргээлт нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд шаардлагатай өвөрмөц, тусгай мэдлэг, арга хэрэгсэл, эх үүсвэрийн хангаж өгөхөд чиглэдэг. Жишээлбэл, тэргэнцэртэй хүнд орж гарах боломжтой ажлын орчныг бүрдүүлэх шаардлага ажил олгогчид тавигдаж болох ч ажил олгогч ажилтныг тэргэнцрээр хангах албагүй. Банк үйлчилгээнийхээ тухай мэдээллийг Брайль үсэг зэргийг ашиглан хүртээмжтэй арга замаар өгөх үүрэгтэй ч харааны согогтой хүнд Брайль цагаан толгой заах үүрэг хүлээхгүй. Харин үүрэг хариуцлага ихэнхдээ тодорхойгүй байдаг нь үнэн. Тухайлбал, уламжлалт компьютерийн гарыг ашиглаж чадахгүй хүнд зориулж нэгэн албан газар хүний яриаг таньдаг программ хангамж худалдан авсан байлаа гэхэд боломжит тохируулгын зарчмаар ажил олгогч нь ажилтандаа шинэ программ хангамжийг хэрхэн ашиглахыг зааж сургасан байх логик хүлээлт үүснэ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнд бүхий л эрхээ эдлэх боломжийг хангаж өгөхөд сэргээлт болон нөхөн сэргээлт маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Шаардлагатай сэргээлт, нөхөн сэргээлтийн үйлчилгээг авч чадахгүй бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хөдөлмөр эрхлэх, сургуульд сурах, соёл, урлаг, спорт болон бусад арга хэмжээнд оролцох боломжгүй болж ч мэднэ. Үүний зэрэгцээ, бусад эрхээ эдлэхэд саад болдог тотгоруудын улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сэргээлт, нөхөн сэргээлт авах эрхээ эдэлж чадахгүйд хүрч ч мэднэ. Жишээлбэл, үйлчилгээ авах боломж байгаа ч тээврийн үйлчилгээ хүртээмжгүй бол хөгжлийн бэрхшээлтэй олон хүн эдгээр үйлчилгээний үр шимийг хүртэж чадахгүй үлдэнэ. Хэрэв сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээний тухай мэдээллийг хүртээмжтэй хэлбэрээр тараахгүй бол зарим төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ийм үйлчилгээ байдаг тухай мэдэхгүй хоцорно. Эдгээр жишээ нь сэргээх болон нөхөн сэргээх үйлчилгээ авах эрх болон хүний бусад эрх **нэгдмэл, уялдаа холбоотой, харилцан хамааралтай** болохыг харуулж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусад хүнтэй адил эрх эдлэх ёстой ч тэдний амьдралын зорилгодоо хүрэх арга зам буюу жишээлбэл, мэдлэг хэрхэн олж авах, бусадтай хэрхэн харилцах, хүрээлэн буй материаллаг орчинтойгоо хэрхэн харьцах, нийгмийн харилцаанд хэрхэн оролцох болон бусад нөхцлүүд нь янз бүрийн шалтгаанаар ялгаатай байдаг. Сэргээх болон нөхөн сэргээх үйлчилгээ бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст өмнөө тавьсан зорилгодоо хүрэхэд нь туслах хувь хүний онцлогт тааруулсан стратеги, арга, эх үүсвэрийг хангаж өгөхөд чиглэсэн үйл явц юм. Зорилт нь автобусанд суугаад хотын нөгөө захад хүрэх гэх мэт маш энгийнээс авахуулаад дэлхийд алдар нэрээ цуурайтуулсан сансрын технологийн инженер болох хүртэл хэцүү зүйл ч байж болно! Харин мартаж болохгүй нэг зүйл бол сэргээх болон нөхөн сэргээх үйлчилгээ хүртэх боломжийг хүний эрхийн хуулиудад төрийн үүрэг гэж тодорхойлж өгснөөр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрхээ хангуулах шаардлага тавих эрхтэй болж байгаа явдал билээ.

## Нөхөн сэргээх үйлчилгээний ашиг шимийг хэн хүртэх вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь нөхөн сэргээх хөтөлбөрт хамрагдах, үйлчилгээ авах эрхтэй нэг л бүлэг хүмүүс юм. Нийгмийн идэвхтэй гишүүн байх, эсвэл нийгмийн амьдралд эргэн орж, үр бүтээлтэй, аз жаргалтай, бие даасан амьдралаар амьдрахын тулд сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээ авах эрхтэй хүн амын хэд хэдэн бүлгийг олон улсын эрхзүйд хүлээн зөвшөөрсөөр иржээ.

### Цэрэг хүүхдүүд, дайнд нэрвэгдсэн хүүхдүүд

Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг Хүүхдийн эрхийн конвенцийн нэмэлт протоколд “зэвсэгт мөргөлдөөний хохирогч болсон хүүхдүүдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд нөхөн сэргээх, нийгмийн амьдралд эргэж ороход туслах шаардлагатай бүх арга хэмжээг авах” хэрэгтэй гэжээ.<sup>1</sup>

### Дүрвэгсэд

**Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн (ЭШЭК) 14 дүгээр зүйлд** “Оролцогч улсууд нь эрүү шүүлтийн хохирогч болсон хүмүүст шүүхэд гомдол мэдүүлэх боломж, шударга бөгөөд тохирсон нөхөн төлбөр авах эрхийг хууль эрхзүйн тогтолцоогоороо хангаж өгсөн байх үүрэгтэй бөгөөд үүний дотор аль болох бүрэн дүүрэн нөхөн сэргээх үйлчилгээний арга хэрэгслүүдээр хангах ёстой”<sup>2</sup> гэжээ. ЭШЭК-ийг хэрэгжүүлж буй улс орнуудын заавал дагаж мөрдөх ёстой удирдамжийн дагуу улс орнууд хохирогчдод нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, нийгмийн амьдралд эргэн ороход нь туслах зорилгоор авч хэрэгжүүлсэн бүх арга хэмжээгээ тайлагнаж байх ёстой байна.

### Газарт булдаг тэсрэх бөмбөгөнд өртөгсөд

Газарт булдаг тэсрэх бөмбөгийг (мина) хориглох тухай олон улсын гэрээний 6.3 дугаар зүйлд Оролцогч улсууд “бөмбөгөд өртөгсдийг асрах, нөхөн сэргээх, нийгмийн болон эдийн засгийн амьдралд эргэн оруулах арга хэмжээ, мөн газарт булдаг тэсрэх бөмбөгийн тухай мэдлэг, мэдээллийг түгээх зорилготой хөтөлбөрүүдэд дэмжлэг үзүүлэх” тухай уриалга орсон байдаг.<sup>3</sup>

### Эрүү шүүлтийн хохирогчид

Эрүү шүүлт, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь гутаасан харьцаа, шийтгэлийн асуудлаарх **тусгай илтгэгчийн** тавьсан тайлангийн хариуд НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2007 онд нэгэн тогтоолдоо улс орнуудад хандан эрүү шүүлтийн хохирогчдод “зохих нийгмийн болон эрүүл мэндийн нөхөн сэргээлт авах” боломжийг хангаж өгөхийг уриалжээ.<sup>4</sup>

Заримдаа нөхөн сэргээлтийн асуудлыг байгалийн гамшиг, зэвсэгт мөргөлдөөн болсны дараа бүхэл бүтэн улс оронд хамааруулан, эсвэл дэлхий нийтийн байгаль орчинтой холбон ярьдаг. Нөхөн сэргээлт нь туслалцаа дэмжлэгийн үр шимээр үйл ажиллагааны чадамжтай болж, нөөц чадавхиа бүрэн ашиглах боломжид хүрч чадах хүн, нөхцөл, зүйлийн аль алинд нь хамаатай ойлголт мөн!

1 <http://www.unhcr.ch/html/menu2/6/protocolchild.htm> сайтаас үз.

2 [http://www.unhcr.ch/html/menu3/b/h\\_cat39.htm](http://www.unhcr.ch/html/menu3/b/h_cat39.htm) сайтаас үз.

3 <http://www.icbl.org/treaty/text> сайтаас үз.

4 НҮБ-ын Ерөнхий Ассамблейн шийдвэр №61/153, <http://daccessdds.un.org/doc/UNDOC/GEN/N06/503/61/PDF/N0650361.pdf?OpenElement> сайтаас үз.

## ДАСГАЛ 9.1. Сэргээлт үү, нөхөн сэргээлт үү

**Зорилт:** Сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээ авах эрхээ эдлэх гэж юуг хэлж байгааг ойлгох

**Хугацаа:** 45 минут

**Хэрэглэгдэхүүн:** Том цаас, фломастер, эсвэл самбар, шохой

### 1. Танилцуулах

Сэргээлт ба нөхөн сэргээлтийн хоорондын ялгааг оролцогчдод сануулж тайлбарла.

### 2. Жишээ гаргах

Оролцогчдыг жижиг багуудад хувааж, баг тус бүрт 10 хуудас цаас, үзэг тарааж өгөөд дараах даалгаврыг өг:

- Багаараа ажиллан, *сэргээлт, нөхөн сэргээлт, боломжит тохируулга* зэрэг нэр томъёог тайлбарласан хоёр, хоёр жишээ гарга.
- Жишээ бүрийг тусдаа цаасан дээр бичээд, энэ жишээ нь аль нэр томъёонд хамаарч байгааг харуулсан тэмдэглэгээ хий.
- Жишээ гаргахдаа янз бүрийн хөгжлийн бэрхшээл (нийгэм-сэтгэцийн, бие махбодын гэх мэт), мөн янз бүрийн зорилтыг (жишээлбэл, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, боловсрол, нийгмийн үйлчилгээ) ашиглахыг хичээ.

### Жишээ:

Харвалтын дараа та бичих чадвараа алджээ. Одоо та шинээр бичиж сурч байна.

#### Нөхөн сэргээлт

### 3. Мэдлэгээ шалгах

Цааснуудыг хураан авч, дундуур нь нугалаад битүү саванд хий. Оролцогчдыг хоёр баг болгоод, тэмцээнийг тайлбарла:

- А багийн оролцогч савнаас нэг хуудас авч чангаар уншина.
- Б багийн эхний оролцогч энэ жишээ *сэргээлт, нөхөн сэргээлт, боломжит тохируулгын* аль нь болохыг хэлнэ. Зөв хариулт өгсөн бол Б баг оноо авна.

Энэ маягаар багууд ээлжилж хариулан цаасыг дуустал тоглоно. Оноонуудаа нэгтгээд ялагчийг тодруулан зарла.

### 4. Тодорхойлох

Сэргээлт болон нөхөн сэргээлтийн дараах чиглэлүүдийн зарим суурь зорилтыг тодорхойл:

- Эрүүл мэнд
- Хөдөлмөр эрхлэлт
- Боловсрол
- Нийгмийн үйлчилгээнүүд.

## 5. Хэлэлцэх

- Таны бодлоор, дээрх чиглэлүүдийн аль нэг нь бусдаасаа илүү чухал уу?
- Таны эргэн тойронд байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олонх нь сэргээлт болон нөхөн сэргээлтийн зохих үйлчилгээг авч чадаж байгаа гэж та боддог уу? Тэд сэргээлт, нөхөн сэргээлтийн үйлчилгээ авах эрхийнхээ тухай мэддэг гэж та боддог уу? Үгүй бол яагаад?
- Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүрт сэргээлт, нөхөн сэргээлтийн үйлчилгээ авах боломжийг хангаж өгөхийн тулд юу хийх хэрэгтэй вэ?

### **Сэргээлт болон нөхөн сэргээлтэд бусад хүмүүсийн үзүүлэх дэмжлэг**

1960-аад оны эхээр дөрвөн мөчний саажилттай хоёр оюутан Беркли дэх Калифорнийн Их сургуульд элсэн орсон бөгөөд тэднийг бусад оюутнуудын хамт дотуур байранд биш харин сургуулийн эмнэлэгт амьдруулах болжээ. Тэдэнтэй ижил хөгжлийн бэрхшээлтэй оюутнууд сургуульд элсэх болсноор тэд бүлэг байгуулж өөрсдийгөө “Дугуйтай баг” гэж нэрлэжээ. Дугуйтай баг амьдрах нөхцлөө сайжруулахын төлөө ажиллаж эхэлжээ. Тэднийг яагаад эмнэлэгт амьдруулахаар шийдсэн бэ? Энэ асуултад олон хариулт өгч болохоор байлаа. Оюутны байрууд руу тэргэнцэртэй хүн нэвтрэх боломжгүй байв. Хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад эмнэлгийн тусламж, үйлчилгээ хэрэгтэй болно гэж сургуулийн захиргаа үзэж байв. Дугуйтай багийн гишүүд хувийн туслах, эсвэл асрагчтай байсан ч дотуур байрны журмаар туслах ажилтнууд оюутнуудтай хамт амьдрах боломжгүй байв. Дугуйтай баг бусад асуудлуудыг ч тавьжээ. Беркли хотын явган хүний зам нь тэргэнцэртэй хүн буухад зориулсан налуу хэсэггүй тул оюутнууд замын нөгөө талд гарч чадахгүй, хотоор чөлөөтэй явах боломжгүй байлаа. Мөн хотын нийтийн тээвэр ч тэдэнд хүртээмжгүй байв. Оюутны тэргэнцэр эвдэрлээ гэхэд очоод засуулчих засварын газар байхгүй байв.

Дугуйтай баг өөрсдийн хэрэгцээний талаар бусдад таниулахын төлөө хамтран ажиллахаар болжээ. Тэдний хийсэн нөлөөллийн ажлын үр дүнд сургууль Хөгжлийн бэрхшээлтэй оюутанд үйлчлэх анхны байраа нээв. Хэдэн жилийн дараа Дугуйтай багийн гишүүдийн зарим нь төгсөх болжээ. Ирээдүйгээ төлөвлөхийн тулд тэд “Бие даасан амьдрал” нэртэй курс нээж их сургуулийн хотхонд хэрэгжүүлсэн ажлын туршлага дээрээ үндэслэн Беркли хотын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдрах нөхцлийг хэрхэн сайжруулах талаар хэлэлцдэг болжээ. Ингээд энэ баг анхны “Бие даан амьдрах төв” нээж дэлхийг хамарсан хөдөлгөөнийг эхлүүлсэн юм.

Берклигийн оюутнууд өөрсдийн хүсэл, санаачилгаар ажиллаж байсан ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн төлөө тэмцлийг манлайлан оролцох өөр олон хүн байсан юм. Тэднийх шиг олон бүлэг дэлхийн өнцөг булан бүрт ажиллаж, хоорондоо холбоо тогтоож эхэлжээ. Ашиг сонирхлоо хамгаалах зорилготой эдгээр бүлгүүд хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдралын талаар “мэргэжилтнүүд”-ээс илүү сайн мэднэ гэдэгт итгэлтэй болж иржээ.

Тэдний амьдралд тохиолддог асуудлуудаар мэргэшсэн шинжээчид нь тэд өөрсдөө байх болно гэж шийджээ. Энэ итгэл нь тэдний ертөнцийг үзэх үзлийг өөрчилсөн юм. Хэрэв хөгжлийн бэрхшээлийн асуудлаар мэргэшсэн шинжээч нь тэд өөрсдөө юм бол өөрсдийн амьдралын туршлагаа бусадтай хуваалцан хөгжлийн бэрхшээлийн тухай хичээл сургалт явуулах, хөгжлийн бэрхшээлтэй бусад хүмүүст зөвөлгөө өгөх мэдлэг чадвартай хүмүүс нь тэд өөрсдөө байх ёстой. Тэд өөрсдийгөө үе тэнгийн зөвлөх гэж нэрлэх болжээ.

Дугуйтай баг их сургуулийн хүрээнд болон сургуулиас гадуурх амьдралынхаа зорилгыг тодорхойлж үүрэг хариуцлагыг өөрсдөдөө авч, эдгээр зорилгодоо хэрхэн хүрэх талаар төлөвлөгөө гаргажээ. Тэд хамтран ажиллах замаар бие биендээ тусалж байв. Тэдэнд ямар нөөц, хэрэглэгдэхүүн хэрэгтэй болохыг мэддэг болсон учраас эдгээр нөөцийг хэрхэн дайчлан ашиглах талаар бусдад яаж зааж өгөхөө мэддэг болсон байлаа. Тэд сэргээлт болон нөхөн сэргээлт авах эрхээ хангуулахын төлөө өөрсдөө ажиллаж байсан юм.<sup>5</sup>

## СЭРГЭЭЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТАЛААР ХҮНИЙ ЭРХИЙН ЭРХЗҮЙД ЮУ ГЭЖ ЗААСАН БАЙДАГ ВЭ?

Олон улсын хэд хэдэн хуульд нөхөн сэргээлтийн асуудлыг авч үзсэн байдаг. Хүүхдийн эрхийн конвенцийн 23 дугаар зүйлд Оролцогч улсуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд дараах үйлчилгээг хүртээмжтэй байлгахыг үүрэг болгосон бөгөөд үүнд:

*...хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг байж болох хамгийн дээд хэмжээнд нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, хувийн хөгжил, үүний дотор соёлын болон оюун санааны хөгжлийг хангах боломж олгосон арга хэлбэрээр боловсрол, сургалт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нөхөн сэргээх үйлчилгээ, хөдөлмөр эрхлэхэд бэлтгэх үйлчилгээ, чөлөөт цагийн арга хэмжээ<sup>6</sup> зэргийг багтаажээ.*

1983 онд Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ)-ын баталсан Мэргэжлийн нөхөн сэргээлт болон хөдөлмөр эрхлэлт (хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс)-ийн тухай конвенци өөрийн гишүүн орнууддаа хандан “бүх төрөл, хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зохих мэргэжлийн нөхөн сэргээлтийн арга хэмжээг хүртээмжтэй байлгах”-д анхаарсан мэргэжлийн нөхөн сэргээлтийн бодлого хэрэгжүүлэхийг уриалжээ.<sup>7</sup> Энэ конвенцид мэргэжлийн нөхөн сэргээлтийн зорилго нь “өөрт тохирсон ажилд орж, энэ ажлын байраа хадгалж үлдэх, цаашид дэвших боломжийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгон, улмаар энэ хүнийг нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оруулах, эргэн оруулахад дэмжлэг үзүүлэх” хэмээн тодорхойлжээ. Энэ өгүүлбэрт мэргэжлийн нөхөн сэргээлтэд юу багтаж байгаа тухай нарийвчлан заагаагүй ч ОУХБ-ын стандартуудыг анх баталсан 1995 оноос хойш энэхүү зарчим нь улам өргөжин хөгжсөн тул **НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн**

5 Стив Браун. “Үе тэнгийн зөвлөхийн үйлчилгээ: Нөлөөллийн үйл ажиллагаанд чиглэсэн үе тэнгийн зөвлөхийн дэмжлэг. Нэгдүгээр бүлэг.” 1999 он. *Бие даан амьдрах судалгааг ашиглах нь* материалаас өөрчлөн авав. [http://www.ilru.org/html/publications/readings\\_in\\_IL/peer1.html](http://www.ilru.org/html/publications/readings_in_IL/peer1.html)

6 <http://www.unhchr.ch/html/menu3/b/k2crc.htm> сайтаас үз

7 [http://www.ilo.org/public/english/employment/skills/hrdr/instr/c\\_159.htm](http://www.ilo.org/public/english/employment/skills/hrdr/instr/c_159.htm) сайтаас үз



**талаар авах арга хэмжээний хөтөлбөрт** тулгуурласан шинэ стандарт боловсруулах хэрэгцээ үүсээд байгааг хүлээн зөвшөөрсөн байна.<sup>8</sup> Заавал дагаж мөрдөх албагүй дээрх баримт бичигт нөхөн сэргээлтэд дараах төрлийн үйлчилгээг багтаан ойлгохоор заажээ:

- Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, арга хэмжээ авах
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх
- Нийгмийн, сэтгэлзүйн болон бусад төрлийн зөвлөх үйлчилгээ, туслалцаа үзүүлэх
- Хөдөлгөөн, харилцаа, өдөр тутмын амьдралын хэрэгцээгээ хангах ур чадвар зэрэг өөрийгөө асрах ур чадварт сургах, үүнд шаардлагатай тусгай хэрэгслийг ашиглахад сургах (тухайлбал, хараа, сонсголын бэрхшээлтэй хүмүүст зориулсан)
- Техникийн болон хөдөлгөөнд туслах тоног төхөөрөмж, бусад хэрэгслээр хангах
- Тусгай боловсрол олгох үйлчилгээ
- Мэргэжлийн нөхөн сэргээх үйлчилгээ (тухайлбал, мэргэжлийн зөвлөгөө, мэргэжлийн сургалт, нээлттэй болон тусгай ажлын байраар хангах)
- Дагалдах арга хэмжээг авах зэрэг болно.

Нөхөн сэргээлтийн тухай ойлголтын хүрээг улам өргөжүүлэн, илүү тодорхой болгож өгсөн **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боломжийг тэгшитгэх тухай НҮБ-ын стандарт дүрмүүдэд** нөхөн сэргээлт бол “хөгжлийн бэрхшээлийн талаарх бодлогын суурь зарчим”, “тэгш оролцооны урьтач нөхцөл” гэж үзээд, дараах тодорхойлолтыг санал болгосон байдаг:

*“Нөхөн сэргээлт” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие махбод, мэдрэхүйн, оюуны, сэтгэцийн/нийгмийн чадавхийн хамгийн дээд түвшинд хүрээд түүнийгээ хадгалах боломжоор ханган, улмаар аль болох дээд хэмжээнд биеэ даах чиглэлд амьдралаа залж өөрчлөх арга ухаанаар хангахад чиглэсэн үйл явц юм. Нөхөн сэргээлт нь чадавхийг хөгжүүлэх ба/ эсвэл хадгалах, алдагдсан юмуу огт байхгүй, эсвэл хязгаарлагдмал чадавхийг нөхөхөд чиглэсэн арга хэмжээг багтаасан байж болно. Нөхөн сэргээх үйл явцад эрүүл мэндийн анхны тусламж үйлчилгээг багтаахгүй. Харин үүнд анхан шатны болон ерөнхий нөхөн сэргээлтээс авахуулаад тусгай зориулалтын (жишээлбэл, мэргэжлийн) нөхөн сэргээлт хүртэл олон төрөл, хэлбэрийн арга хэмжээ, үйл ажиллагааг багтаана.<sup>9</sup>*

**Стандарт дүрмүүд** нь хөгжлийн бэрхшээлтэй бүх хүнд цогц, хувийн онцлогт тохирсон нөхөн сэргээх хөтөлбөр, үйлчилгээг хүртээмжтэй хүргэхийг Оролцогч улсуудаас уриалаад, “өөрсдөд нь хамааралтай нөхөн сэргээх үйлчилгээг боловсруулах, зохион байгуулахад” хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцуулах нь чухал болохыг онцолжээ. Стандарт дүрмүүдэд “сургалтын тодорхой зорилтыг хангах” үүднээс тодорхой байгууллагыг түшиглэсэн богино хөтөлбөрүүд чухал болохыг хүлээн зөвшөөрсөн ч нөхөн сэргээх үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдарч буй орчинд нь олгох ёстой гэж онцолсон байдаг. Мөн нөхөн сэргээх хөтөлбөр боловсруулах, үр дүнг нь үнэлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн байгууллагуудын мэдлэг, туршлагыг ашиглаж байхыг улс орнуудад зөвлөжээ.

8 <http://www.un.org/documents/ga/res/37/a37r052.htm> сайтаас үз

9 <http://www.un.org/ecosocdev/geninfo/dpi1647e.htm> сайтаас үз



2005 онд болсон Дэлхийн эрүүл мэндийн 58 дахь чуулганы үеэр **Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага** (ДЭМБ) нь нөхөн сэргээх цогц хөтөлбөр, үйлчилгээг дэмжих үүрэг амлалтаа баталгаажуулан тогтоол гаргасан ба үүнд “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүрэн дүүрэн оролцоо, тэгш боломжийг хангахын тулд амьдралын бүхий л чиглэлийн үйл ажиллагаа, үүний дотор эрүүл мэндийн болон нөхөн сэргээх үйлчилгээг дэд бүтэц, мэдээлэл, эдийн засгийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бүрэн хүртээмжтэй болгох” асуудал маш чухал болохыг дурьджээ. Тус тогтоолд “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмийн амьдралд чухал хувь нэмэр оруулдаг бөгөөд тэдний нөхөн сэргээлтэд хөрөнгө хуваарилж байх нь үнэн чанартаа хөрөнгө оруулалт мөн” гэдгийг хүлээн зөвшөөрсөн байна.<sup>10</sup>

**Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци** (ХБХЭК) нь сэргээлт, нөхөн сэргээлтийн аль алиныг авч үзсэн анхны баримт бичиг юм. 26 дугаар зүйлд “эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, боловсрол, нийгмийн үйлчилгээний салбарт цогц сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээ, хөтөлбөрүүдийг зохион байгуулах, бэхжүүлж, өргөжүүлэх”-ийг Оролцогч улсуудад уриалжээ. ХБХЭК-д сэргээлт болон нөхөн сэргээлт нь олон салбарыг хамарсан, тухайн хүний давуу талууд болон хэрэгцээг хамруулахын тулд хувь хүний онцлогийг харгалзсан шинжтэй байхын зэрэгцээ үйлчилгээ нь хүмүүсийн амьдарч буй орчинд нь аль болох ойр байх ёстойг онцолсон байдаг. Энэ баримт бичигт сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлдэг мэргэжилтнүүдэд тогтмол сургалт хийж байх хэрэгцээг хүлээн зөвшөөрөөд, сэргээх, нөхөн сэргээх үйл явцад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэглэх туслах технологи, хэрэгслүүд чухал үүрэгтэй болохыг дурьджээ.

ХБХЭК-ийн хөдөлмөр эрхлэх, эрүүл байх, аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос ангид байх тухай асуудлуудыг хөндсөн зүйл ангиудад нөхөн сэргээлтийн талаар дурьдсан ч дээрх нөхцлүүдэд нөхөн сэргээлт гэж юуг ойлгох талаар тодорхой тусгаагүй байна.

Сэргээлт, нөхөн сэргээлтийн хөтөлбөрийг төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцуулах зарчим нь ХБХЭК-ийн “Нийтлэг зарчмууд” гэсэн 3 дугаар зүйлийн оролцоо, бие даасан байдал, шийдвэр гаргалттай холбоотой зарчмуудад илэрхий туссан байдаг. Энэ зүйлд багтсан зарчмууд нь конвенцид дурьдагдсан бүх эрхтэй холбоотой ба эдгээр эрхийг ойлгоход ашиглах суурь ойлголтууд юм. 3 дугаар зүйлийн эхний нийтлэг зарчим нь:

- a) сонголт хийх эрх чөлөө болон хүний бие даасан байдлыг оролцуулан хүний нэр төр, нандин чанар, хувийн хараат бус байдлыг хүндэтгэх тухай юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонголт хийх эрх чөлөө, бие даасан байдлаа хүндэтгүүлэх эрх нь сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээ авах эрхийг хангах асуудлын чухал бүрэлдэхүүн хэсэг юм.

10 <http://www.who.int/disabilities/publications/other/wha5823/en/index.html> сайтаас үз

## Сэргээлт болон нөхөн сэргээлттэй холбоотой сэтгэл сэрдхийлгэм тоо баримт

- Аливаа оронд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь нийт хүн амын 10 хувийг эзэлдэг бөгөөд ойролцоогоор 2 хувьд нь нөхөн сэргээх үйлчилгээ шаардлагатай байдаг. Гэтэл хөгжиж байгаа улс орны хүн амын дөнгөж 0,01-0,02 хувь нь ийм үйлчилгээг хүртдэг.<sup>11</sup>
- Газарт булсан тэсрэх бөмбөгт өртөгсөдийн 10 хүрэхгүй хувь нь л шаардлагатай эмнэлгийн болон нөхөн сэргээх үйлчилгээ хүртэж чаддаг. Ихэнх оронд газрын минад өртөх явдал алслагдсан хөдөө орон нутагт давамгай тохиолддог ба өртсөн хүмүүс тэр даруй эмнэлэгт хүрч чаддаггүй. АНУ-ын Төрийн департаментын тооцоолсноор газрын тэсрэх бөмбөгт өртсөний улмаас хөл гараа тайруулсан 4 хүн тутмын нэг нь л шаардлагатай протезоор хангагддаг байна.
- Бүх төрөл, түвшний хөгжлийн бэрхшээлийг оролцуулан тооцоход Австралид хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь хэмжээ хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэйчүүдийнхээс бага байна. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн нөхөн сэргээх үйлчилгээ хүртэх, хөдөлмөр сургалтын хөтөлбөрт хамрагдах магадлал хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэйчүүдийнхээс бага байдаг ажээ. Их Британий Нөхөн сэргээх үйлчилгээний албанаас 1994 оны 5 сард гаргасан статистик мэдээгээр нийт хүсэлт гаргасан үйлчлүүлэгчдийн дөнгөж 35% нь эмэгтэйчүүд байсан бөгөөд эмэгтэйчүүд мэргэжлийн сургалтанд хамрагдахаас илүү (36%) бие даан амьдрахын тулд (45%) нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдах хүсэлтэй байжээ.<sup>12</sup>

### ДАСГАЛ 9.2: Сэргээлт, нөхөн сэргээлтийн хөтөлбөр боловсруулахад оролцох нь

<b>Зорилт:</b>	Сэргээх, нөхөн сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах дадлага хийх
<b>Хугацаа:</b>	1 цаг
<b>Хэрэглэгдэхүүн:</b>	Байхгүй

#### 1. Танилцуулах

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоо яагаад чухал болох талаар доорхтой ижил асуултуудыг тавина уу:

- Сэргээх, нөхөн сэргээх хөтөлбөрийг “хувь хүний онцлогт тохируулах” нь яагаад чухал вэ?

11 Тизун Зао, Жозеф Квок “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нөхөн сэргээх үйл ажиллагааны үнэлгээ: Хариуцлагатай үйл ажиллагааны удирдамж”. Хөгжлийн бэрхшээлийн тухай мэдээллийн сурвалж (DINF).

[www.dinf.ne.sp/doc/Englsih/resource/2000221/2000210z.htm](http://www.dinf.ne.sp/doc/Englsih/resource/2000221/2000210z.htm)

12 “Австралийн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд (WWDA) байгууллагаас Хөдөлмөр эрхлэлт болон ажлын байрны Байнгын хороонд өргөн барьсан “Цалинтай хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх тухай” захидал. 2003 он. Австралийн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд. <http://www.wwda.org.au/employsub.htm>



- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандсан төсөл, хөтөлбөр боловсруулахад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс яагаад оролцох ёстой вэ?
- Танай орон нутагт сэргээлт болон нөхөн сэргээлтийн хөтөлбөрийг хэрхэн төлөвлөдөг вэ?

## 2. Хэлэлцэх

Оролцогчдыг жижиг багуудад хуваагаад, дараах даалгаврыг өг.

- Эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, боловсрол юмуу нийгмийн үйлчилгээ зэрэг чиглэлийн аль нэгээр нь сэргээх юмуу нөхөн сэргээх үйлчилгээ авах шаардлагатай хүний тухай бодит амьдралд тохиолдоогүй ч нийтлэг гардаг нөхцөл байдлыг харуулсан өгүүлэмж зохио.
- Багийн нэг гишүүнийг “үйлчлүүлэгч” (сэргээх юмуу нөхөн сэргээх үйлчилгээ авч буй хүн)-ийн дүрд тоглуулахаар сонго.
- Багийн бусад гишүүд нь үйлчилгээ үзүүлэгч, зөвлөх, эмч, гэр бүлийн гишүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалагч, хөгжлийн бэрхшээлтэй бусад хүн, сэргээх юмуу нөхөн сэргээх үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд оролцох ёстой хүмүүсийн дүрд тогло.
- Төлөвлөгөөнийхөө ерөнхий загварыг гаргахдаа дараах асуултуудыг удирдамж болгон ашигла. Оролцогчид нь нарийн, детальчилсан төлөвлөгөө биш харин зорилго, хандлага, энгийн бүтцийг тусгасан ерөнхий төлөвлөгөө гаргах ёстой гэдгийг анхааруул. Зарим асуултад зөвхөн үйлчлүүлэгч ганцаараа хариулах шаардлагатай бол бусад асуултуудад хариулахад багийн бүх гишүүн оролцох хэрэгтэй болно.
  - Сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээтэй холбоотой ямар зорилгод та нар хүрэхийг зорьж байна вэ?
  - Танай сэргээлт юмуу нөхөн сэргээлтийн хөтөлбөрийн хувьд “амжилт” гэж юуг хэлж байгааг тодорхойлно уу?
  - Та ямар үндэслэлээр ийм төрлийн үйлчилгээ хүртэх эрхтэй вэ?
  - Энэ нөхцөлд сэргээлт, эсвэл нөхөн сэргээлт авах таны хэрэгцээ ямар ямар эрхтэй холбоотой байна вэ?
  - Танд хэрэгтэй энэ хөтөлбөрийг боловсруулахад хэн оролцох ёстой вэ?
  - Хөтөлбөр боловсруулахад оролцож байгаа хүн болгоны (үйлчлүүлэгчийг оруулаад) үүргийг тодорхойлно уу?
  - Үйлчлүүлэгч өөртөө тавьсан зорилго, зорилтуудаа амжилттай хэрэгжүүлэхийн тулд ямар нөөцүүдийг (тухайлбал, сургалт, туслах технологи) дайчлах хэрэгтэй болох вэ?
  - Үйлчлүүлэгчид шаардлагатай сэргээх, эсвэл нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхийн тулд сургагч багш, зөвлөх, эмч, багийн бусад гишүүн бүр ямар чадвар, боловсрол эзэмшсэн байх, ямар төрлийн сургалтуудад хамрагдсан байх ёстой вэ?

## 3. Илтгэх

Баг болгон “үйлчлүүлэгч”-ээ танилцуулаад, түүнд зориулсан сэргээх, юмуу нөхөн сэргээх үйлчилгээг төлөвлөхдөө ашигласан хамтын ажиллагааны үйл явцыг тайлбарлана. Үйлчлүүлэгч болон танилцуулга хийж байгаа хүн төлөвлөлтийн явцад ямар үүрэг гүйцэтгэж оролцсоноо мөн тайлбарлана. Төлөвлөгөөг товч танилцуул.

#### 4. Шинжлэх/хэлэлцэх

- Энэхүү үйл явцын хамгийн хэцүү хэсэг нь юу байсан бэ? Ямар бэрхшээлүүд тулгарсан бэ?
- Ямар төрлийн шийдвэрүүдийг гаргахад хялбар байсан бэ?
- Дээр дурьдсан асуултууд дээр нэмээд багууд өөр ямар чухал асуулт, сэдвүүдийг авч үзэх шаардлагатай болсон бэ?
- Өөрсдөд нь зориулсан сэргээлт, нөхөн сэргээлтийн хөтөлбөрийн тухай шийдвэр гаргахад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцуулахгүй байгаа мэт санагдах юм бол тэд юу хийж болох вэ?

#### **НҮБ-ын байгууллагууд ба олон нийтийн оролцоонд тулгуурласан нөхөн сэргээлт**

1994 онд Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ), НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО), Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллага (ДЭМБ) нь олон нийтийн оролцоонд тулгуурласан нөхөн сэргээлтийн (ОНОТНС) хөтөлбөр боловсруулахад баримтлах нэгдсэн хандлагатай болох зорилгоор “Олон нийтийн оролцоонд тулгуурласан нөхөн сэргээлтийн талаарх хамтарсан баримт бичиг”-ийг боловсруулсан байна. Үүнд:

*ОНОТНС нь орон нутгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд багтсан хөгжлийн бэрхшээлтэй бүх хүнийг нөхөн сэргээх, боломжийг нь тэгшитгэх, нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах стратеги юм.*

*ОНОТНС-ийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүл, байгууллага, орон нутаг болон эрүүл мэнд, боловсрол, мэргэжлийн боловсрол, нийгмийн болон бусад үйлчилгээ үзүүлдэг төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын хүчээр хэрэгжүүлдэг.*

ОНОТНС-ийн гол зорилтууд нь дараах болно:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бие махбод болон сэтгэцийн чадвараа дээд зэргээр дайчлах, тогтмол үйлчилгээ болон боломжуудыг ашиглах, орон нутгийн болон нийгмийн хөгжилд хувь нэмрээ идэвхтэй оруулах зэрэг боломжуудаар хангагдсан байхад анхаарах;
2. Орон нутагтаа хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоонд саад болдог тотгоруудыг арилгахад чиглэсэн үйл ажиллагаа санаачлан, хэрэгжүүлэх замаар орон нутгийн бусад иргэдийг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад идэвхтэй оролцдог болгон идэвхжүүлэх

ОУХБ/ЮНЕСКО/ДЭМБ-ын хандлага нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нөхөн сэргээх үйлчилгээ авах эрхийг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ бүх иргэнийхээ оролцох эрхийг хангах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оруулж чадах хувь нэмрийг сурталчилж ойлгуулахын тулд орон нутагт сургалт, дэмжлэг, шаардлагатай нөөц хөрөнгийг хангаж өгөх хэрэгтэйг онцолжээ.<sup>13</sup>

13 <http://www.ilo.org/public/english/employment/skills/download/jointpaper.pdf> сайтыг үз.

## ОЮУНЫ БОЛОН НИЙГЭМ-СЭТГЭЦИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ЗОРИУЛСАН СЭРГЭЭЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Оюуны, эсвэл нийгэм-сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх нэрээр эрхийг нь зөрчих явдал их гардаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид сэргээлт болон нөхөн сэргээлтийн зорилгыг “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хараат бус байдлыг дээд зэргээр хангах, тэднийг бие махбод, оюун санаа, нийгмийн болон мэргэжлийн бүрэн чадавхитай болгох, нийгмийн бүхий л хүрээнд бүрэн хамрагдах, оролцох боломжийг олгох” хэмээн тодорхойлжээ. Эдгээр арга хэмжээг нөхөн сэргээх үйлчилгээ авч буй хүний өөрийнх нь хувийн зорилго, сонголтод тулгуурлан хэрэгжүүлэх ёстой.

Оюуны юмуу нийгэм-сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өөрсдийнх нь хүссэн зүйлд хүрэхэд туслах зорилготой бус харин ч хүсээгүй тал руу нь өөрчлөх зорилготой хөтөлбөр, эмчилгээнд хүчээр хамруулах явдал элбэг гардаг. Гаргүй хүнийг хүсэхгүй байхад нь хиймэл гар хүчээр зүүлгэх, эсвэл амьтанд дургүй хараагүй хүнд хөтөч нохой ав гэж шаардана гэдэг хүний ухаанд багтахгүй зүйл юм. Гэтэл оюуны юмуу нийгэм-сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс “өөрт нь юу хэрэгтэй” болохыг өөрсдөө мэддэггүй, эсвэл өөрсдийн нөхцөл байдалд тохирсон зорилтыг тодорхойлж чаддаггүй гэж үздэг. Ийм тохиолдолд эмч, гэр бүлийн гишүүд, бусад хүмүүс ихэнхдээ өөрсдийнхөө л үзэмжээр нөхөн сэргээх үйлчилгээг сонгож, улмаар хөгжлийн бэрхшээлтэй хүний өөрийнх нь хүсэл, зоригийн эсрэг үйлдэл хийж ч мэднэ. Ийм “нөхөн сэргээлт” нь бие даасан байдал, үзэл бодлоо илэрхийлэх, оролцох, хамрагдах эрх чөлөө, үл гадуурхагдах, хувийн халдашгүй байдлаа хадгалах зэрэг хүний эрхийн үндсэн зарчмуудыг зөрчсөн хэрэг юм. Цаашилбал, энэ хандлага нь сэргээлт, нөхөн сэргээлтийн үйлчилгээнд баримталдаг хөгжлийн бэрхшээлтэй хүний өөрийнх нь хүсэж байгаа үйлчилгээг (өөрөө бие даан юмуу бусдын тусламжтайгаар үүнийгээ тодорхойлно) хүргэх зарчимтай шууд зөрчилдөж байгаа юм.

### **ДАСГАЛ 9.3: Сэргээх болон нөхөн сэргээх үйлчилгээ авах эрхийг дэмжих амлалт авах нь**

Хүний эрх бол эдлэх эрх, хүлээх үүргийн нэгдэл гэдгийг тайлбарла.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сэргээх болон нөхөн сэргээх үйлчилгээ авах эрхийг судалж, мэдсэний эцэст оролцогчид өөрсдөө тодорхой үйл ажиллагаа хийхэд бэлэн болсон эсэхийг асуу.
- Мэдээлэл цуглуулах, ажлаа төлөвлөх гээд хийх зүйл их байгаа ч өөрчлөлт хийх чин эрмэлзэл маш чухал гэдгийг тэмдэглэн хэл.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээ авах эрхээ бүрэн эдлэхэд нь нэмэр болох жижиг ч хамаагүй ямар ажлыг ирэх сард хийхийг хүсэж байгаа, хийх боломжтой байгааг оролцогч бүрээр хэлүүл.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах нөлөөллийн ажил хэрхэн төлөвлөх талаар “Хэсэг 3. Нөлөөлөл! Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа” (хуудас 278) хэсгээс уншина уу.

СЭРГЭЭХ, НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ  
НЭМЭЛТ МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

- ОУХБ-ын 159 дүгээр конвенци (Мэргэжлийн нөхөн сэргээлт болон хөдөлмөр эрхлэлт (Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс)):  
<http://www.ilo.org/ilolex/english/convdisp1.htm>
- ОУХБ-ын Мэргэжлийн нөхөн сэргээлт болон хөдөлмөр эрхлэлт (Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс)-ийн тухай зөвлөмж (№168):  
<http://www.ilo.org/ilolex/english/recdisp1.htm>
- ДЭМБ-ын Хөгжлийн бэрхшээл, нөхөн сэргээлтийн баг:  
<http://www.who.org.int/disabilities/en/>
- ДЭМБ-ын Хөгжлийн бэрхшээл, нөхөн сэргээлтийн талаарх 2006-2011 оны үйл ажиллагааны төлөвлөгөө:  
[http://www.who.org.int/disabilities/publications/dar\\_action\\_plan\\_2006to2011.pdf](http://www.who.org.int/disabilities/publications/dar_action_plan_2006to2011.pdf)
- Дэлхийн Банк, Олон нийтийн оролцоонд тулгуурласан нөхөн сэргээлт:  
<http://web.worldbank.org/WBSITE/EXTERNAL/TOPICS/EXTSOCIALPROTECTION/EXTDISABILITY/0,contentMDK:20192706~menuPK:418196~pagePK:148956~piPK:216618~theSitePK:282699,00.html>



## БҮЛЭГ 10. ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХ

### НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци

#### 27 дугаар зүйл: Ажил, хөдөлмөр эрхлэлт

1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бусадтай адил тэгш байх үндсэн дээр хөдөлмөр эрхлэх, тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд хүртээмжтэй, нээлттэй байгаа, оролцож болох хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөрлөх орчинд ажиллахаар чөлөөтэй сонгосон, эсхүл зөвшөөрлөө чөлөөтэй өгсөн нөхцөлд эрхэлж буй хөдөлмөрийнхөө үр шимээр амьжиргааны эх үүсвэрээ олох боломжтой байх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүлээн зөвшөөрнө. Оролцогч улсууд нь хөдөлмөр эрхлэх явцдаа хөгжлийн бэрхшээлтэй болсон хүмүүсийг оролцуулан хөгжлийн бэрхшээлтэй бүх хүний ажил, хөдөлмөр эрхлэх эрхийг эдлүүлэх үүднээс зохистой арга хэмжээ, тухайлбал хууль тогтоох болон дараах арга хэмжээ авах явдлыг хангаж, хөхиүлэн дэмжинэ:

- a) ажилд авах нөхцөл, хөлсөөр ажиллуулах, ажил олгох, ажил хөдөлмөр эрхлэх, мэргэжлийн хувьд өсөн дэвжих, эрүүл, аюулгүй хөдөлмөрийн нөхцлөөр хангагдах явдлыг оролцуулан хөдөлмөрийн бүх хэвшилтэй холбогдсон бүхий л асуудалд хөгжлийн бэрхшээлийн улмаас алагчлахыг хориглох;
- b) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бусадтай адил тэгш байх үндсэн дээр адил хөдөлмөрт ижил тэгш боломж, адил цалин хөлс авах, эрүүл, аюулгүй хөдөлмөрийн нөхцлөөр хангагдах, тухайлбал, дарамт шахалтад өртөхгүй байх, өргөдөл гомдлоо барагдуулах эрх;
- c) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусадтай адил тэгш байх үндсэн дээр хөдөлмөрлөх, үйлдвэрчний байгууллагатай холбогдсон эрхээр хангах;
- d) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг техникийн болон мэргэжлийн чиг баримжаа олгох ерөнхий хөтөлбөр, ажлын дадал олгох, мэргэжлийн болон гүнзгийрүүлсэн сургалтад үр дүнтэйгээр хамрагдах боломжийг бий болгох;
- e) хөдөлмөрийн зах зээлд ажил хайх, ажилд орох, ажиллах болон ажилдаа буцаж орох боломж нөхцөл, мэргэжлийн хувьд дэвших боломжийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст олгох явдлыг хөхиүлэн дэмжих;
- f) хувиараа хөдөлмөр эрхлэх, аж ахуйн нэгж байгуулах, нөхөрлөл, хоршоо ажиллуулах, хувийн бизнесээ эрхлэх боломжийг дэмжих;
- g) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг төрийн албанд ажиллуулах;
- h) зохих бодлого хэрэгжүүлэх, арга хэмжээ авах, түүний дотор тэдэнд зориулсан хөтөлбөр батлах, урамшуулал олгох зэрэг бусад арга хэмжээ авах замаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хувийн хэвшлийн байгууллагад хөдөлмөр эрхлэх явдлыг хөхиүлэн дэмжих;
- i) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажлын байранд боломжит хэрэглэгдэхүүнээр хангах;
- j) хөдөлмөрийн нээлттэй зах зээлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ажлын туршлага хуримтлуулах явдлыг хөхиүлэн дэмжих;

к) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэргэжлийн болон техник мэргэжлийн нөхөн сэргээлт, ажлын байрыг нь хадгалах болон ажилд нь буцааж оруулах хөтөлбөрийг хөхиүлэн дэмжих.

2. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг мөлжлөг, боолын байдалд оруулахгүй байх, бусадтай адил тэгш байх үндсэн дээр албадан хөдөлмөрөөс хамгаалагдах явдлыг хангана.

## ЗОРИЛТУУД

Энэ бүлгийн сэдэв, мэдээлэл, дасгалууд нь оролцогчдод дараах зорилтыг хангахад туслах зорилготой:

- Хөдөлмөрлөх эрхийг тодорхойлох;
- Хөдөлмөрлөх эрх нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд ямар ач холбогдолтой болохыг тайлбарлах;
- Хөдөлмөрлөх эрх, хүний бусад эрхийн хоорондын уялдааг ойлгох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөрлөх эрх хэрхэн хангагдаж эсвэл зөрчигдөж байгааг мэддэг болох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн (ХБХЭК) ажил, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой заалтуудыг ойлгох.

## ЭХЛЭЛ: АЖИЛ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЭХ НЬ

“Хөдөлмөрлөх эрх” гэдэг холбоос үг нь хүмүүсийг төөрөгдөлд оруулж болзошгүй юм. “Эрүүл байх эрх” нь хүний эрүүл саруул байхын баталгаа болж чаддаггүйтэй адилаар хөдөлмөрлөх эрх нь хөдөлмөрийн насны бүх хүнд ажлын байр олдох баталгаа биш юм. Аль ч засгийн газар ийм эрхэд бүрэн баталгаа өгч чадахгүй. Харин “хөдөлмөрлөх эрх” гэдэг нь бүх хүнд ажлаа чөлөөтэй сонгох, санал болгосон ажлын байрыг хүлээн авч амьжиргаагаа залгуулах, тухайн ажлыг аюулгүй бөгөөд таатай нөхцөлд гүйцэтгэх *боломжийг* эдлэх эрхийг олгож байгаа хэрэг юм. Хөдөлмөрлөх эрх нь мөн үйлдвэрчний эвлэл байгуулах, нэгдэн орох, үүгээр дамжуулан ашиг сонирхлоо хамгаалах, аюулгүй бөгөөд таатай ажлын нөхцлийг бүрдүүлэхийн төлөө нөлөөллийн үйл ажиллагаа явуулах эрхийг багтаадаг.

Харамсалтай нь, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хөдөлмөрлөх эрхээ эдэлж чадахгүй байх тохиолдол олон гардаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн чадавхийн тухай элдэв хандлага, төсөөллийн улмаас ажил олгогчид хөгжлийн бэрхшээл нь хүний чадавхийг дордуулж, ажил хөдөлмөртэй холбогдолтой үүрэг даалгавар гүйцэтгэх чадваргүй болгодог гэсэн эндүү ташаа дүгнэлт хийдэг. Ийм буруу ойлголтын нөлөөгөөр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажилд огт авахгүй, эсвэл тэдний мэдлэг, ур чадварыг бүрэн дайчлахааргүй ажилд л авдаг. Иймэрхүү хандлагын улмаас ажил олгогчид хөгжлийн бэрхшээлтэй, ялангуяа нийгэм-сэтгэцийн бэрхшээлтэй ажилтнуудыг өөрсдөд нь болон бусад ажилтнуудад “аюул учруулж” магадгүй, үйлчлүүлэгчид нь хөгжлийн бэрхшээлтэй хүнээр үйлчлүүлэхээс эвгүйцэх, дургүйцэх байх гэсэн бодолтой болдог. Мөн хөгжлийн

бэрхшээлтэй хүмүүст бүрдүүлж өгөх шаардлагатай тусгай нөхцлүүд (хүртээмжийг сайжруулах арга хэмжээ, уян хатан ажлын хуваарь зэрэг) нь тэднийг ажилд авахад саад болохуйц өндөр байдаг гэж зарим ажил олгогч боддог. Энэ шалтгааныг ашиглан зарим ажил олгогч хөгжлийн бэрхшээлтэй ажилчиддаа ижил ажил хийж буй бусад ажилчдаас бага цалин төлдөг. Тэр ч бүү хэл зарим онцгой тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүчээр мөлжлөг, дарамттай орчинд боолын хөдөлмөр эрхлүүлэх, аюулгүй байдлыг хангаагүй ажлын байранд ажиллуулаад, заримдаа мөнгө хөлсгүй ажиллуулах явдал ч гардаг. Өөр нэг жишээ гэвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусадтай хамт нэг цех тасагт ажиллуулахаас татгалзсаны улмаас тэд өөр тохиолдолд хүлээж авахааргүй тусгаарлагдсан орчинд ажиллахад хүрдэг.

Эдгээр хандлага, төсөөллийн нөлөөгөөр ажилд орох, ажлын байраа хадгалах, албан тушаалд дэвших зэрэг хөдөлмөр эрхлэлтийн бүхий л үе шатанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөрлөх эрх зөрчигддөг. Түүнчлэн, ажлын байран дахь хөгжлийн бэрхшээлээр нь алагчлах явдал далд хэлбэртэй, тухайн байгууллагаас гадагш задардаггүй учир эрх нь зөрчигдсөн тухай асуудал үүсгэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүнд байдаг. Тухайлбал, ажил олгогчдын олонх нь хөгжлийн бэрхшээлийн улмаас уг хүнийг ажилд аваагүй, эсвэл ажлаас халсан гэдгээ илэрхий хэлдэггүй. Тэд, жишээлбэл, илүү чадварлаг өөр ажилтан олсон гэж хэлж магад. Ийм алагчлал гарсныг батлах баримт нотолгоо цуглуулах боломж бараг байхгүй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хөдөлмөрлөх эрхээ эдлэхэд нь нэмэлт саад болдог зүйл бол тэдний бусад эрхийн зөрчил юм. Тухайлбал:

- Тээврийн хэрэгсэл хүртээмжгүй байх юм бол тэд ажлын байрандаа хүрч чадахгүй;
- Боловсрол эзэмших, мэргэжлийн болон бусад сургалтанд хамрагдах боломж муу байх юм бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ажлын байранд тавигдах онцлог шаардлагуудыг хангаж чадахгүй, улмаар цалин сайтай ажилд орж чадахгүй, насан туршдаа олж болох орлогын хэмжээ буурдаг;
- Бие даан бусад хүмүүсийн дунд амьдрах боломжгүй байх юм бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тусгаарлагдсан байгууламжид амьдрахаас өөр аргагүй болж, улмаар аятайхан ажил олж хийх боломж нь бүрмөсөн хаагдах, эсвэл ихээр хязгаарлагддаг;
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж муу байх юм бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэнд доройтож, улмаар ажил, хөдөлмөр эрхлэх боломжгүй болдог;
- Мэдээллийн хүртээмж муу байх юм бол хөгжлийн бэрхшээлтэй хүн ажлын зар болон хөдөлмөр эрхлэх бусад боломжийн тухай мэдэхгүй өнгөрнө.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрлөх эрхийн зөрчил нь түүний бусад эрх зөрчигдөхөд ч хүргэж мэднэ. Тухайлбал, хөдөлмөр эрхэлж боломжийн цалин авч чадахгүй хөгжлийн бэрхшээлтэй хүн өөртөө хүрэлцэхүйц түвшний амьжиргааг хангаж өгч чадахгүй. Улмаар энэ байдлаас болж хөгжлийн бэрхшээлтэй хүний сонголтууд хязгаарлагдаж, нийгэмдээ бие дааж амьдрах боломж нь хумигдаж, бусдаас хараат байдалд ордог. Өөрийгөө санхүүгийн хувьд хангах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ядууралд нэрвэгдэж, хоол хүнс, ус, хувцас, орон байр гэх мэт өөрийнхөө болон гэр бүлийнхээ наад захын хэрэгцээгээ хүссэн хэмжээгээр хангаж чадахгүйд хүрч ч мэднэ. Зарим оронд хөдөлмөр эрхлэлт нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах боломжийг нээж өгдөг эрүүл мэндийн даатгалд хамрагдах эх үндэс болдог. Ийм улс оронд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ажилд орж чадахгүй бол эрүүл мэндийн үйлчилгээ хүртэх боломж нь мөн хязгаарлагдаж мэднэ.

Хүний хөдөлмөрлөх эрхийг үгүйсгэх нь хүний өөрийгөө хүндлэх, үнэлэх мэдрэмжид сөргөөр нөлөөлдөг нь энэ эрхийн зөрчлөөс үүдэн гардаг хамгийн ноцтой уршиг болох болов уу. Олон улс оронд ажил хөдөлмөр эрхлэх нь нийгмийнхээ хөгжилд хувь нэмрээ оруулах хамгийн чухал арга зам гэж үздэг бөгөөд ажил хийх чадваргүй, эсвэл хүсэлгүй хүмүүсийг, ялангуяа орлого олох боломжгүйн улмаас бусад хүмүүс, төр засгийн дэмжлэгт найдахаас өөр аргагүй болсон хүмүүсийг нийгмийн бусад гишүүдээс доогуур үнэлэх хандлага гарч мэдэх юм. Тиймээс, хөдөлмөрлөх эрхээ бүрэн эдлэх нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн эрх тэгш гишүүн байх, өөрийгөө үнэлэх, хүндэтгэхэд чухал нөлөө үзүүлнэ.

### **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөрлөх эрх ба Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага**

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ) нь сайн ажилтай болох, хөдөлмөр эрхлэх боломжийг хангах зорилготой олон улсын хөдөлмөрийн стандарт боловсруулах, хэрэгжилтэд нь хяналт тавих үүрэгтэй олон улсын байгууллага юм. 1919 онд байгуулагдсан ОУХБ нь 1946 онд НҮБ-ын анхны мэргэжлийн агентлаг болжээ. НҮБ-ын бусад байгууллагатай харьцуулахад ОУХБ нь засгийн газар, ажил олгогч, ажилтны төлөөллийг оролцуулсан “гурван талт” тогтолцоог ашиглан хөтөлбөр, бодлогоо хамтран боловсруулдаг онцлогтой.

Хэдийгээр ОУХБ нь бүх хүнийг сайн ажлаар хангах зорилтыг хангахаар ажилладаг ч залуучууд, эмэгтэйчүүд, уугуул иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зэрэг тусгай бүлгийн хүмүүс хөдөлмөрлөх эрхээ эдэлж чадаж байгаад онцгой анхаарал хандуулдаг. ОУХБ нь 159 дүгээр конвенци (“Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс” хэсэг), Мэргэжлийн нөхөн сэргээлт болон хөдөлмөр эрхлэлтийн талаарх зөвлөмж (168 дугаар тогтоол) зэрэг баримт бичиг батлан гаргаж, “ОУХБ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөтөлбөр” хэрэгжүүлдэг.

ОУХБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн сайн ажил эрхлэх боломжийг хөхиүлэн дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөдөлмөрийн зах зээлд бүрэн оролцоход нь саад болж буй бэрхшээл, тотгорыг арилгах зорилготой. Ур чадвар, мэдлэг болон хөдөлмөр эрхлэх чадварыг хөгжүүлэх зорилготой “Ин-фокус” хөтөлбөрт багтаж явдаг дээрх хөтөлбөр нь дараах үндсэн үйл ажиллагаа явуулдаг:

- Хөгжлийн бэрхшээл нь сургалт, хөдөлмөр эрхлэлт зэрэгтэй хэрхэн холбогдож байгаа талаарх мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх;
- Засгийн газар, ажилчид болон ажил олгогчдын дунд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдэнд зориулсан сургалт, тэдний эрх ашгийг хамгаалдаг байгууллагуудын холбогдолтой заавар, бодлогын зөвлөгөө өгөх, сурталчлан нөлөөлөх;
- Техникийн зөвлөх үйлчилгээ болон хамтын ажиллагааг хөгжүүлэх.<sup>1</sup>

1 <http://www.ilo.org/public/english/employment/skills/disability/iloprogram.htm> сайтыг үз.

## ДАСГАЛ 10.1: Хөдөлмөрлөх эрхээ эдлэх гэж юуг хэлэх вэ?

- Зорилт:** Хөдөлмөрлөх эрхээ эдлэх гэдэг нь ямар утгатай болохыг ойлгох  
**Хугацаа:** 30 минут  
**Хэрэглэгдэхүүн:** Том цаас, фломастер, эсвэл самбар, шохой

### 1. Тодорхойлох

Оролцогчдыг жижиг багуудад хуваагаад, багаараа хөдөлмөрлөх эрхийн өөрсдийн тодорхойлолтыг гаргахыг хүс.

### 2. Илтгэх/Хэлэлцэх

Баг бүрээс томилогдсон илтгэгчээр тухайн багийн гаргасан тодорхойлолтыг уншуул. Тодорхойлолтуудыг бичиж аваад, эдгээрийн хоорондын ялгаатай бөгөөд төстэй талуудыг хэлэлц. Багуудын гаргасан тодорхойлолт нь энэ бүлэгт өгсөн тодорхойлолтоос юугаараа ялгаатай байгааг тогтооход оролцогчдод тусал.

### 3. Хэлэлцэх

- Таны орчин тойронд ажил хийдэг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байдаг уу? Тэд хаана, ямар төрлийн ажил эрхэлдэг вэ?
- Таны орчин тойрны ажил хийдэг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс таны гаргасан тодорхойлолтод нийцсэн хэмжээнд хөдөлмөрлөх эрхээ эдэлж чадаж байна уу?
- Таны бодлоор, танай орон нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ихэнх нь хөдөлмөрлөх эрхээ эдэлж чадаж байгаа юу? Бүр тодорхой хэлбэл, ямар хүмүүс энэ эрхээ эдэлж чадаж байгаа гэж бодож байна вэ? Хэн нь эдэлж чадахгүй байгаа вэ?
- Танай орон нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй бүх хүнд хөдөлмөрлөх эрхээ бүрэн эдлэх боломжийг хангахын тулд юу хийж болох вэ?

### Хөдөлмөрлөх эрхээ эдлэхэд тохиолддог бэрхшээлийн жишээ

- Ажлын байран дахь дэд бүтцийн саад. Өөрөөр хэлбэл, ажлын байрны дэд бүтэц нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжгүй;
- Ажлын байранд хүргэх хүртээмжтэй тээврийн хэрэгсэл дутагдалтай;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тодорхой ажилд авахад саад болдог хууль, журам, практик дадал зуршил оршсоор байх, эсвэл ажлын байранд хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхахыг хориглосон хууль, бодлого, практик дадал байхгүй;
- Хөдөлмөр эрхлэх боломжийн талаар хүртээмжтэй мэдээлэл дутагдалтай;
- Ялангуяа хараагүй, сонсголгүй, хараагүй бөгөөд сонсголгүй, оюуны эсвэл сурах хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй харьцах хэрэгслүүд ажлын байранд дутмаг;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажил хийх чадвартай, ажлын байрны шаардлагыг хангасан, үнэ цэнэтэй ажилтан мөн гэдэг эргэлзсэн хандлага

## ДАСГАЛ 10.2: Хөдөлмөрлөх эрхээ эдлэхэд саад болдог зүйлсийг ойлгох нь

<b>Зорилт:</b>	Хөдөлмөрлөх эрхээ эдлэхэд саад болдог тотгор, бэрхшээлийг судлах
<b>Хугацаа:</b>	45 минут
<b>Хэрэглэгдэхүүн:</b>	Байхгүй

### 1. Танилцуулах

Оролцогчдын амьдардаг орчинд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хөдөлмөрлөх эрхээ эдлэхэд нь саад болж буй бэрхшээл, хүндрэлийн жишээнүүдийг оролцогчдоор гаргуул. Жишээнүүдийг жагсааж бич.

Хөгжлийн бэрхшээлтэй зарим бүлэг хүмүүст хөдөлмөрлөх эрхээ эдлэхэд нь бусдаас илүү хүнд, хэцүү байдаг эсэхийг асуу.

### 2. Хэлэлцэх

Оролцогчдыг 2-3 хүнтэй жижиг багуудад хуваа. Оролцогчдын амьдардаг орчинд хөгжлийн бэрхшээлтэй нэг хүний хөдөлмөрлөх эрх хангагдахгүй байгаа тухай зохиомол боловч нийтлэг түүхийг баг болгон зохионо. Түүх нь энэ хүнд ажлын байр өгөхөөс татгалзсан тухай байна.

### 3. Илтгэх

Баг бүрээс “амьдралын түүх”-ээ танилцуулахыг хүс.

### 4. Шинжлэх/хэлэлцэх

Эдгээр “зохиомол” дүрд хөдөлмөрлөх эрхээ эдлэх боломжийг хангаж өгөхийн тулд юу хийх ёстойг оролцогчидтой хэлэлц.

- 27 дугаар зүйлд заасан төрөл бүрийн туслалцаа, дэмжлэгийг анхаараарай.
- Эдгээр туслалцаа, дэмжлэгийг авахын тулд юу хийж болох вэ?

ХҮНИЙ ЭРХИЙН ЭРХЗҮЙД ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХИЙН ТУХАЙ  
ЮУ ГЭЖ ЗААСАН БАЙДАГ ВЭ?

Хөдөлмөрлөх эрхийг хүний эрхийн олон баримт бичигт авч үзсэн байдаг. Тухайлбал, **Хүний эрхийн түгээмэл тунхаглалын (ХЭТТ)** 23 дугаар зүйлд хөдөлмөрлөх эрх, эрхлэх ажлаа сонгох эрх чөлөө, шударга цалин хөлс, ижил төрлийн ажилд ижил хэмжээний цалин хөлс олгох зарчим, үйлдвэрчний эвлэл байгуулах буюу нэгдэн орох эрх зэрэг асуудлыг тодорхой авч үзсэн байна. **Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИУТЭОУП)** нь боолчлол, мөлжлөг, мөн тодорхой хязгаарлагдмал нөхцлөөс бусад тохиолдолд албадан хөдөлмөрлөхөөс ангид байх эрхийг тодорхойлсон байдаг.

**Эдийн засаг нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын (ЭЗНСЭОУП)** гурван зүйлд хөдөлмөрлөх эрхийн асуудлыг илүү нарийвчлан тайлбарлажээ:

- **6 дугаар зүйлд** хөдөлмөрлөх эрхийг баталгаажуулаад, засгийн газруудад хандан “хувь хүний улс төр, эдийн засгийн үндсэн эрх чөлөө”-г хамгаалсан бодлого, үйл ажиллагаагаар энэ эрхийн хэрэгжилтийг хангахыг уриалжээ;





- **7 дугаар зүйлд** хүн бүр эрүүл, аюулгүй хөдөлмөрийн нөхцлөөр хангагдах, шударга цалин хөлс авах, ажилласан хугацаа, мэргэжлийн чадавхид үндэслэн албан тушаал дэвших адил тэгш боломжоор хангагдах, амралт, чөлөөт цагтай байх эрх зэрэг “шударга, таатай хөдөлмөрийн нөхцлөөр хангагдах” эрхийг тодорхойлжээ;
- **8 дугаар зүйлд** үйлдвэрчний эвлэл байгуулах, нэгдэн орох эрх, нийгмийн хэв журмыг хангах, бусад хүний эрх, эрх чөлөөг хамгаалах үүднээс ардчилсан нийгэмд баримталдаг хязгаарлалтаас бусад нөхцөлд үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагааг хязгаарлахгүй байх тухай заажээ.<sup>2</sup>

**Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос** (Эдийн засаг нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийг хянах үүрэг бүхий хараат бус байгууллага) гаргасан Ерөнхий зөвлөмжийн №5-д Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад заасан хөдөлмөрлөх эрхээ бүрэн эдлэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгардаг зарим саад бэрхшээлийг нэрлэсний дотор хөдөлмөрийн салбарт газар авсан хөгжлийн бэрхшээлээр алагчлах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажлын байрны стандартад нийцээгүй орчин нөхцөлд ажиллуулах, ажлын газартаа хүргүүлэх тээврийн хэрэгсэл олддоггүй зэрэг бусад эрхийн зөрчлөөс үүдэлтэй хөдөлмөрлөх эрхийг хязгаарладаг саадуудыг дурьджээ. Энэ баримт бичигт мөн засгийн газрууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үйлдвэрчний эвлэлтэй холбоотой эрхийг нь бүрэн дүүрэн эдлүүлэхэд анхаарах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлт, бусад эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг байгууллагуудтай тогтмол зөвлөлдөж байх шаардлагатайг сануулжээ.<sup>3</sup>

**Хүүхдийн эрхийн конвенцийн (ХЭК) 32 дугаар зүйлд** хүүхэд бүр эдийн засгийн мөлжлөгөөс ангид байх, тэдний боловсрол эзэмшилтэд саад болох, “эрүүл мэнд болон бие бялдар, оюун ухаан, оюун санаа, ёс суртахуун, нийгмийн хөгжил”-д сөрөг нөлөө үзүүлж мэдэх аливаа ажил эрхлэхээс хамгаалуулах эрхтэй болохыг хүлээн зөвшөөрчээ. Мөн Оролцогч улсууд нь ажилд авах насны доод хязгаарыг (хязгааруудыг) тогтоох, ажлын цаг болон хөдөлмөрийн нөхцлийг зохицуулах, 32 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангах зорилгоор хууль зөрчигчдөд оноох ял шийтгэл, бусад арга хэмжээг тодорхой зааж өгөхийг шаарджээ.<sup>4</sup>

1993 онд батлагдсан **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боломжийг тэгшитгэх тухай НҮБ-ын стандарт дүрмүүд** (Стандарт дүрмүүд) нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хөдөлмөрлөх эрхээ эдлэхэд нь нөлөөлөх хэд хэдэн асуудлыг хөнджээ:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, хэрэгцээ, боломж болон нийгэмд оруулах хувь нэмрийн тухай мэдлэгийг дээшлүүлэх (Дүрэм 1);
- Нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх (Дүрэм 3);
- Бие даасан байдлыг дэмжихэд чиглэсэн үйлчилгээ үзүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрхээ эдлэхэд нь туслах (Дүрэм 4);
- Дэд бүтцийн, мэдээллийн болон харилцаа холбооны хүртээмж (Дүрэм 5);
- Боловсрол (Дүрэм 6);
- Хөдөлмөр эрхлэлт (Дүрэм 7);
- Боловсон хүчний сургалт (Дүрэм 19).<sup>5</sup>

2 [http://www.unhchr.ch/html/menu3/b/a\\_ceschr.htm](http://www.unhchr.ch/html/menu3/b/a_ceschr.htm) сайтыг үз.

3 [http://www.unhchr.ch/tbs/doc.nsf/\(symbol\)/E.C.12.2000.4](http://www.unhchr.ch/tbs/doc.nsf/(symbol)/E.C.12.2000.4) сайтыг үз.

4 <http://www.unhchr.ch/html/menu3/b/k2csrc.htm> сайтыг үз.

5 <http://www.un.org/ecosocdev/geninfo/dpi1647e.htm> сайтыг үз.

**Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци** (ХБХЭК)-д өмнө батлагдсан хүний эрхийн тухай баримт бичигт тусгасан асуудлуудыг дэлгэрүүлж авч үзэн, Оролцогч улсуудын засгийн газар нь хөдөлмөрлөх эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэхийн тулд юу хийхийг тодруулж өгчээ. Хүний эрх **нэгдмэл, уялдаа холбоотой, харилцан хамааралтай** учраас ХБХЭК-ийн олон зүйл заалт нь хөдөлмөрлөх эрхтэй холбоотой гэж ойлгож болно. Харин хөдөлмөрлөх эрхийг тусгайлан авч үзсэн нь конвенцийн 27 дугаар зүйл юм.

Нэлээд урт хэмжээтэй 27 дугаар зүйл нь хоёр дэд хэсгээс бүрдэнэ. Эхний бөгөөд арай урт хэсэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусад хүмүүстэй адил тэгш хөдөлмөрлөх эрхтэй болохыг хүлээн зөвшөөрөөд, үүнд ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, санал болгосон ажлыг чөлөөтэй хүлээж авах замаар хүрэлцэхүйц түвшний амьжиргаатай болох эрх багтаж байгааг заажээ. Хөдөлмөрлөх эрхийг нээлттэй хөдөлмөрийн зах зээл болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нээлттэй, хүртээмжтэй, тэгш хамрагдалттай ажлын байранд эдлүүлэхээр заажээ. Дараа нь 27 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хөдөлмөрлөх эрхийг нь эдлүүлэхийн тулд Оролцогч улсуудын авч хэрэгжүүлж болох зарим тодорхой алхмуудыг санал болгосны дотор:

- Хөдөлмөрийн бүх салбар, төрөлд хөгжлийн бэрхшээлээр алагчлахыг хориглох;
- Ижил хөдөлмөрт адил цалин хөлс авах, эрүүл, аюулгүй хөдөлмөрийн нөхцлөөр хангагдах, дарамтаас хамгаалагдсан байх, өргөдөл гомдлоо барагдуулах боломжийг багтаасан хөдөлмөрийн шударга, таатай нөхцлөөр хангагдах эрхийг хамгаалах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусадтай адил тэгш байх үндсэн дээр хөдөлмөр болон үйлдвэрчний эвлэлтэй холбоотой эрхээ эдлэх боломжийг бүрдүүлэх;
- Техникийн болон мэргэжлийн чиг баримжаа олгох ерөнхий хөтөлбөр, ажилд зуучлах болон бусад сургалтуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэх боломж, зэрэг дэв, албан тушаал ахих боломжийг дэмжих, ажлын байр олох, ажилд орох, ажлын байраа хадгалах, ажилдаа эргэж ороход нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст туслалцаа үзүүлэх;
- Хувиараа хөдөлмөр эрхлэх, бизнес эрхлэх, нөхөрлөл, хоршоо байгуулж ажиллах, хувийн бизнесээ эхлүүлэх боломжийг дэмжих;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг төрийн албанд ажиллуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дэмжих бодлого болон төрөл бүрийн урамшуулал, бусад тохиромжтой бодлого, арга хэмжээгээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хувийн салбарт ажиллахад дэмжлэг үзүүлэх;
- Ажлын байранд боломжит тохируулга хийхэд анхаарах;
- Хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр хөгжлийг бэрхшээлтэй хүмүүс ажлын туршлага, дадлага олж авах боломжоор хангагдсан байхад анхаарах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан техник мэргэжлийн болон мэргэжлийн нөхөн сэргээлтийг дэмжих, ажлын байрыг нь хадгалах болон ажилд нь буцааж оруулах хөтөлбөрүүдийг хөхиүлэн дэмжих зэрэг багтжээ.

27 дугаар зүйлийн 2 дугаар хэсэг богинохон боловч мөлжлөгийн шинжтэй хөдөлмөр эрхлэлтийг хориглох чухал асуудлыг хөнджээ. Энэ хэсэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг мөлжлөг, боолын хөдөлмөр эрхлэхээс хамгаалах, бусадтай адил тэгш байх үндсэн дээр албадан хөдөлмөрөөс хамгаалахыг Оролцогч улсуудаас шаардсан байна. Оролцогч улсууд энэ эрхийг *хүндэтгэн* хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөрлөх



эрхээ эдлэх, хэрэгжүүлэхэд нь төрийн албан хаагч зэрэг төрийн этгээдүүд саад болохгүй байх нөхцлийг бүрдүүлэх үүрэгтэй. Мөн Оролцогч улсууд уг эрхийг *хамгаалан* хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрхээ эдлэхэд нь бизнесийн болон үйлдвэрчний эвлэл зэрэг төрийн бус этгээд саад болохгүй байх нөхцлийг хангах үүрэгтэй. Түүнчлэн Оролцогч улсууд энэ эрхийг *хангах* үүргээ биелүүлэхийн тулд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хөдөлмөрлөх эрхээ элдэх боломжийг хангаж өгөхөд чиглэсэн арга хэмжээ (тухайлбал, 27 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт заасан арга хэмжээнүүд) авах үүрэгтэй. Товчхондоо, олон улсын хүний эрхийн эрхзүйд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөрлөх эрхийг зөвхөн хүний эрх гэдэг утгаар нь дэмжээд зогсохгүй, энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусад эрхээ илүү бүрэн дүүрэн эдэлж, нийгмийн бүрэн эрхт гишүүнийн хувьд үүрэг хариуцлагаа бүрэн хүлээж, нийгэмдээ хувь нэмрээ оруулах арга зам гэдэг утгаар ойлгон дэмжиж байгаа билээ.

### ДАСГАЛ 10.3: Хөдөлмөрлөх эрхийг ойлгох нь

**Зорилт:** ХБХЭК-иор баталгаажсан хөдөлмөрлөх эрхийг ойлгох

**Хугацаа:** 45 минут

**Хэрэглэгдэхүүн:** Том цаас, фломастер, эсвэл самбар, шохой

#### 1. Бататгах

Оролцогчдыг жижиг багуудад хуваа. Багууд 27 дугаар зүйлийг энгийн үг, хэллэгээр өөрчлөн найруулаад, энэ эрхийг хэрхэн эдэлж болох, үүний үр дүнд оролцогчдын орчин тойронд амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралд ямар өөрчлөлт гарахыг харуулсан жишээ гаргах даалгавар авна.

Сургагч багшид: 27 дугаар зүйл нь нэлээд урт учраас хэд хэдэн богино хэсэгт хуваагаад, багуудыг өөр өөр хэсэг дээр ажиллуулж болно.

#### 2. Энгийн үг хэллэгээр өөрчлөн найруулах

27 дугаар зүйлийг чангаар унш. Уншихдаа таслал, эсвэл утга төгөлдөр богино хэсэг бүрийн дараа зогсож, энэ хэсгийг багууд хэрхэн энгийн үгээр өөрчлөн найруулсныг сонсоно. Бүх хүн санал нэгтэй зөвшөөрсөн нэг найруулга гарч иртэл оролцогчдын дунд хэлэлцүүлэг явуулна. 27 дугаар зүйлийн эцсийн найруулгыг том цаасан дээр бич.

#### 3. Жишээ гаргах

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хөдөлмөрлөх эрхээ хэрхэн эдэлж, үүний үр дүнд тэдний амьдралд эерэг өөрчлөлт гарч байгааг харуулсан жишээнүүдийг багуудаар хэлүүл.

#### 4. Хэлэлцэх

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах асуудлыг үндэсний хэмжээний бодлогын асуудал болгож тавих, мөн улс төрийн нам, шийдвэр гаргагчдад өргөн барих төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулахад ХБХЭК-ийн 27 дугаар зүйлийг хэрхэн ашиглаж болох вэ? Энэ нь танай улсын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ямар ач холбогдолтой вэ?

Ажил олгогчид одоо ажиллаж байгаа болон шинээр ажилд орох хөгжлийн бэрхшээлтэй ажилчдынхаа өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэх, нөгөө талаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдөө хөдөлмөрлөх эрхээ бүрэн эдлэхийн төлөө нөлөөллийн ажил явуулахын тулд ажил олгогчид, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн аль аль нь хүлээх үүрэг, эдлэх эрхээ мэддэг байх шаардлагатай. Улсын болон хувийн салбарын ажил олгогчдын дунд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ажил хөдөлмөр эрхлэлттэй холбоотой бодлого, журам батлан мөрдөх явдал улам нэмэгдэж байгаа бөгөөд энэ бодлогод ажил олгогчийн үүрэг хариуцлага, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг тодорхой зааж өгдөг болжээ. Заримдаа ажил олгогч ийм бодлогыг өөрийн санаачилгаар гаргаж байгаа бол заримдаа улсынхаа хуульд заасан шаардлагаар, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалдаг байгууллагуудын шахалтаар хийж байна. Эдгээр бодлого нь шийдвэр гаргах түвшний хүмүүст хөгжлийн бэрхшээлтэй ажилчид, үйлчлүүлэгчдийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагыг нь сануулахад тус болдог. Мөн эдгээр бодлого нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрхээ хангуулах шаардлага тавих, зөрчил гарсан тохиолдолд шүүхэд хандах боломжийг олгож байгаа юм.

Гэхдээ бодлогын баримт бичиг гаргах төдийхөн нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тухай мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд хангалтгүйн дээр энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрхээ бүрэн эдлэх баталгаа болж чадахгүй. Ажил олгогч зөвхөн бодлого *гаргаснаар* ажлаа хязгаарлаж болохгүй бөгөөд энэ бодлогод хамааралтай хүн болгон тухайн бодлогын агуулга, түүнийг жинхэнэ ажил хэрэг болгохын тулд юу хийх ёстойгоо мэдэж байхад анхаарах ёстой. Бодлогоор өөрт нь оногдож байгаа эрх, үүргийг ойлгуулахын тулд хүмүүстээ сургалт явуулах хэрэгцээ гарч болзошгүй бөгөөд цаашид бодлогыг хэрэгжүүлэх явцад туслалцаа дэмжлэг үзүүлэх шаардлага ч гарч ирнэ. Түүнчлэн, бодлого зөрчигдсэн тохиолдолд асуудлыг үр дүнтэй шийдвэрлэх механизмууд байх ёстой бөгөөд зөрчлийг шийдвэрлүүлэх хүсэлтэй хүмүүс эдгээр механизмыг хэрхэн ашиглах тухай ойлгож мэдсэн, энэ бол аюулгүй бөгөөд өөрт нь уршигт үр дагавар дагуулахгүй үйл явц гэдэгт итгэлтэй байх ёстой. Ажиллагсад нь зөрчлийг дэлгэж тавьсныхаа төлөө ажлын байраа алдах, эсвэл ямар нэг байдлаар шийтгэл хүлээнэ хэмээн эмээж байгаа нөхцөлд хамгийн сайн боловсруулсан бодлого ч үр дүнтэй хэрэгжихгүй нь ойлгомжтой.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажилд авах бодлого, журам батлан хэрэгжүүлж байгаа ажил олгогчийг та мэдэх үү?
- Эдгээр бодлогыг боловсруулахдаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэднийг төлөөллийн байгууллагуудыг оролцуулсан уу?
- Эдгээр бодлого, эсвэл бодлогын хэрэгжилтийг хангах үүднээс авсан арга хэмжээнүүдийг хэрхэн улам сайжруулж болох вэ?
- Иймэрхүү бодлогыг боловсруулах, эсвэл бодлогыг дэмжсэн нөлөөлөл явуулахад та өөрөө юмуу танай байгууллага хэрхэн тусалж чадах вэ?

## **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах талаар Вольксваген корпорацийн авсан амлалт**

2003 оныг Европт Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн жил болгон зарласантай холбоотойгоор компанийнхаа өмнөх туршлага, санаачилгыг үргэлжлүүлэн олон улсын машины үйлдвэрлэгч Вольксваген корпораци нь боловсрол, сургалт, дотоод харилцаагаа сайжруулах замаар хөгжлийн бэрхшээлтэй ажилчдыг үндсэн үйлдвэрлэлийн процессд тэгш оролцуулах тухай гэрээнд гарын үсэг зуржээ. Мөн түүнчлэн 2003 оны үйл ажиллагааны хүрээнд Вольксваген нь “Бусдын өмнөөс шийдвэр гаргадаг хэлбэрээс боломж олгох хэлбэр рүү шилжих нь” нэртэй материал хэвлүүлэн гаргасан бөгөөд үүндээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дэмжих талаар авч буй олон арга хэмжээг дурьджээ:

- Үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байлгахад анхаарах;
- Ажлын байранд хөгжлийн бэрхшээлээр алагчлах явдлыг хориглох;
- Эрүүл, аюулгүй ажлын орчинг дэмжих зорилгоор нийтлэг дизайны зарчмыг мөрдлөг болгох, компанийн хөгжлийн бэрхшээлтэй ажилчдыг тэгш хамруулах, компанид ажиллаж байх хугацаандаа хөгжлийн бэрхшээлтэй болсон ажилчдыг эргэж ирэхэд нь туслах;
- Нийтлэг дизайн нь хөгжлийн бэрхшээлтэй ажилчдын хэрэгцээнд нийцэхгүй тохиолдолд боломжит тохируулгаар хангах;
- Хөгжлийн бэрхшээлийн тухай бодлогыг компанийн бүх хэлтэс, үйлдвэрлэлийн бүх хэсэгт аажмаар нэвтрүүлэхийн тулд удирдах албан ажилтнууд болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөөлөл багтсан “тэгш хамрагдалтын багуудыг” байгуулах.

### **ДАСГАЛ 10.4: Хөдөлмөрлөх эрхийг дэмжих үүрэг амлалт авах нь**

Хүний эрх бол эдлэх эрх, хүлээх үүргийн нэгдэл гэдгийг тайлбарла.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөрлөх эрхийн асуудлыг судалж үзсэний эцэст оролцогчид өөрсдөө тодорхой алхам хийхэд бэлэн болсон эсэхийг асуу.
- Мэдээлэл цуглуулах, ажлаа төлөвлөх гээд хийх зүйл их байгаа ч өөрчлөлт хийх чин эрмэлзэл маш чухал гэдгийг тэмдэглэн хэл.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хөдөлмөрлөх эрхээ бүрэн эдлэхэд нь нэмэр болох жижиг ч хамаагүй ямар ажлыг ирэх сард хийхийг хүсэж байгаа, хийх боломжтой байгааг оролцогч бүрээр хэлүүл. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажилд авах нь зөвхөн хуулийн шаардлага төдий бус, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь ажил үйлдвэрлэл, ажлын байрандаа үнэтэй хувь нэмэр оруулах чадвартай тул ажил олгогчийн хувьд ашигтай нөөц болохыг ажил олгогчдод тайлбарлахын тулд оролцогч юу хийх вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах нөлөөллийн ажил хэрхэн төлөвлөх талаар “Хэсэг 3. Нөлөөлөл! Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа” (хуудас 278) хэсгээс уншина уу.

#### ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХИЙН ТУХАЙ НЭМЭЛТ МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

- “Хөгжлийн бэрхшээлтэй америкчууд” хуулийг хэрэгжүүлэх талаар жижиг бизнесийн салбарт зориулсан гарын авлага:  
<http://www.ada.gov/smbustxt.htm>
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны Ерөнхий зөвлөмж №5:  
[http://www.unhchr.ch/tbs/doc.nsf/\(Symbol\)4b0c449aa9ab4ff72c1256ed00054f17d?Opendocument](http://www.unhchr.ch/tbs/doc.nsf/(Symbol)4b0c449aa9ab4ff72c1256ed00054f17d?Opendocument)
- ОУХБ-ын 159 дүгээр конвенци (Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн Мэргэжлийн нөхөн сэргээлт ба хөдөлмөр эрхлэлтийн тухай):  
<http://www.ilo.org/ilolex/english/convdisp1.htm>
- ОУХБ-ын Мэргэжлийн нөхөн сэргээлт ба хөдөлмөр эрхлэлтийн тухай (Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс) зөвлөмж (№168):  
<http://www.ilo.org/ilolex/english/recdisp1.htm>
- ОУХБ-ын Ур чадвар болон хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс – Хөгжлийн бэрхшээл болон хөдөлмөр эрхлэлтийн тухай асуудлууд:  
<http://www.ilo.org/public/english/employment/skills/disability/index.htm>



## БҮЛЭГ 11: АМЬДАРЧ БУЙ ОРЧИНДОО БИЕ ДААН, НЭР ТӨРТЭЙ АМЬДРАХ ЭРХ

### НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци

#### 19 дүгээр зүйл. Бие даан амьдрах болон тухайн оршин суугаа орчиндоо байх эрх

Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй бүх хүний бусдын нэгэн адил ердийн оршин суугаа газартаа амьдрах тэгш эрхийг хүлээн зөвшөөрч, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс энэхүү эрхээ эдлэх явдлыг хангах, тухайн оршин суугаа орчиндоо бүрэн дүүрэн хамрагдаж оролцохыг дэмжих үүднээс дараах нөхцлийг хангах замаар зохистой, үр дүнтэй арга хэмжээ авна:

- a) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь бусдын нэгэн адил оршин суух газар болон хаана, хэнтэй амьдрах эсэхээ чөлөөтэй сонгох боломжтой байх ёстой бөгөөд тусгай нөхцөл байдалд амьдрахыг шаардахгүй;
- b) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст гэрийн, оршин суугаа газрын болон тухайн оршин суугаа бусад орчны үйлчилгээ, түүний дотор амьдрахад нь дэмжлэг болохуйц болон тухайн оршин суугаа орчиндоо оролцоход нь хувийн туслалцаа хүртэх боломжтой байх бөгөөд нийгмээс тусгаарлах, хөндийрүүлэхээс хамгаалагдана;
- c) нийт хүн амд үйлчлэх зориулалттай нийтийн үйлчилгээ, объект нь бусадтай адил тэгш байх үндсэн дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд хэрэглэх боломжтой байх бөгөөд хэрэгцээнд нь нийцсэн байна.

#### 28 дугаар зүйл. Амьжиргааны хүрэлцэхүйц түвшин, нийгмийн хамгаалал

1. Оролцогч улсууд нь хүрэлцэхүйц хоол хүнс, хувцас, орон байраар хангагдах эрх, амьдралын нөхцлөө тасралтгүй сайжруулах явдлыг оролцуулан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүл амьжиргааны хүрэлцэхүйц түвшинд байх эрхийг хүлээн зөвшөөрч, энэхүү эрхийг эдлэх явдлыг хөгжлийн бэрхшээлийн улмаас үл алагчлах үндсэн дээр хөхиүлэн дэмжих зохистой арга хэмжээ авна.
2. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн хамгаалал хүртэх эрх, уг эрхийг хөгжлийн бэрхшээлээс шалтгаалан аливаа алагчлалгүйгээр эдлэх явдлыг хүлээн зөвшөөрч, эдгээр эрхийг эдлүүлэх явдлыг хөхиүлэн дэмжих, хамгаалах үүднээс дараах зохистой арга хэмжээ авна:
  - a) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг цэвэр усны үйлчилгээнд тэгш хамрагдах явдлыг хангах болон хөгжлийн бэрхшээлтэй нь холбоотойгоор шаардагдах, боломжийн өртөгтэй үйлчилгээ, тоног төхөөрөмж болон бусад туслалцааг хүртэх явдлыг хангах;
  - b) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охид болон хөгжлийн бэрхшээлтэй ахмад настнуудыг нийгмийн хамгаалал болон ядуурлыг бууруулах хөтөлбөрүүдэд хамрагдах явдлыг хангах;
  - c) ядуу нөхцөлд амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний гэр бүлийн гишүүдийг хөгжлийн бэрхшээлтэй хүний тусгай хэрэгцээт зардал тухайлбал, шаардлагатай сургалт, зөвлөгөө, санхүүгийн туслалцаа болон түр хугацааны туслалцаа авахдаа төрөөс дэмжлэг авах боломжоор хангах;

- d) бүх нийтийг орон сууцаар хангах хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулах;
- e) тэтгэвэр, түүнтэй холбоотой хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулах.

## **12 дугаар зүйл. Хуулийн өмнө тэгш байх эрх**

1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь бусад хүний нэгэн адил хуулийн өмнө адил тэгш байх эрхтэйг дахин нотолж байна.
2. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь амьдралын бүхий л хүрээнд бусадтай адил тэгш байх үндсэн дээр эрхзүйн чадамжтай байх явдлыг хүлээн зөвшөөрнө.
3. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрхзүйн чадамжаа хэрэгжүүлэхэд нь шаардагдах дэмжлэг туслалцааг хүртээмжтэй байлгах үүднээс шаардлагатай арга хэмжээ авна.
4. Оролцогч улсууд нь эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй, зохистой хамгаалалтыг бий болгохуйц эрхзүйн чадамжаа хэрэгжүүлэхтэй холбогдсон бүх арга хэмжээг олон улсын хүний эрхийн хэм хэмжээний дагуу авна. эрхзүйн чадамжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон ийм хамгаалалт нь тухайн хүний сонголт, хүсэл зоригт нийцсэн, эрхийг хүндэтгэсэн, сонирхлын зөрчилгүй, сөрөг нөлөөгүй, хувийн нөхцөл байдалд нь тохирсон, байж болох хамгийн богино хугацаанд байх бөгөөд бүрэн эрхт, хараат бус, бие даасан байгууллага, эсхүл шүүхийн зохих шатны байгууллага түүнийг тогтмол хянаж байна. Эдгээр хамгаалалт нь тухайн хүний эрх, ашиг сонирхол аль хэр хөндөгдөнө төдий чинээний хэмжээтэй байна.
5. Энэ зүйлийн заалтуудын дагуу оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эд хөрөнгө эзэмших, түүнийг өвлөх, санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх болон банкны зээл, үл хөдлөх хөрөнгийн барьцаат зээл болон бусад төрлийн санхүүгийн үйлчилгээг тэгш хүртэх эрхийг баталгаажуулах зорилгоор шаардлагатай, үр дүнтэй арга хэмжээ авах бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүний эд хөрөнгийг хүсэл зоригийг нь үл хамааран хураахгүй байх явдлыг баталгаажуулна.

## **ЗОРИЛТУУД**

Энэ бүлгийн сэдэв, мэдээлэл, дасгалууд нь оролцогчдод дараах зорилтыг хангахад туслах зорилготой болно:

- Амьдарч байгаа орчиндоо бие даан, нэр төртэйгөөр амьдрах эрхийг тодорхойлох;
- Амьдарч байгаа орчиндоо бие даан, нэр төртэйгөөр амьдрах эрх хөгжлийн бэрхшээлтэй хүнд ямар ач холбогдолтой болохыг тайлбарлах;
- Амьдарч байгаа орчиндоо бие даан, нэр төртэйгөөр амьдрах эрх, хүний бусад эрхийн хоорондын уялдааг ойлгох;
- Амьдарч буй орчиндоо бие даан, нэр төртэйгөөр амьдрах эрх хэрхэн хангагдаж эсвэл зөрчигдөж байгааг мэддэг болох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн (ХБХЭК) нийгэмдээ бие даан, нэр төртэйгөөр амьдрах эрхтэй холбоотой заалтуудыг ойлгох.



ЭХЛЭЛ: АМЬДАРЧ БУЙ ОРЧИНДОО БИЕ ДААН, НЭР ТӨРТЭЙ АМЬДРАХ ЭРХИЙН ТУХАЙ  
ЭРГЭЦҮҮЛЭХ НЬ

Бусад хүмүүстэй харилцахгүй, тусгаарлагдан, орь ганцаараа амьдардаг хүн хорвоо дээр тун цөөн! Бид бүгд ямар нэг байдлаар бусад хүмүүсээс зөвлөгөө, нөхөрлөл, бараа, үйлчилгээ, бусад янз бүрийн дэмжлэг тусалцаа авч тэднээс хамааралтай амьдардаг. Тэгэхлээр “бие даан амьдрах” гэдэг нь бусдаас тусгаар, ганцаараа амьдарна гэсэн утга агуулаагүй юм бол ямар утга агуулж байна вэ? Мөн чанартаа, бие даан амьдрах эрх гэдэг нь хэрхэн, хаана, хэнтэй амьдрах, орчинтойгоо хэр их харилцах хүсэлтэй байгааг сонгох эрх юм. Мөн эдгээр сонголтоо хийж, амьжиргааны хүрэлцэхүйц түвшинд хүрэхийн тулд танд хэрэгтэй бүхий л төрлийн тусалцаа авах боломж энд мөн багтана.

Төрөлхийн нэр төрөө хүндэтгүүлэн биеэ даан амьдрах хүний эрхийн нэгэн чухал бүрэлдэхүүн нь хүн аливаа асуудлаар өөрөө шийдвэр гаргаж, гаргасан шийдвэрээ хүндэтгүүлэн, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авахуулах боломж юм. Хөгжлийн бэрхшээлтэй олон хүн юу өмсөх, юу идэж уух зэрэг наад захын шийдвэр дээрээ хүртэл энэ эрхээ эдэлж чаддаггүй. Заримдаа үндэсний хуулиуд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн (ялангуяа оюуны юмуу сэтгэц-нийгмийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс) шийдвэр гаргалтын суурь болсон **эрхзүйн чадамжийг** хязгаарлах замаар бие даан шийдвэр гаргах эрхэд саад болдог. Заримдаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг “ухамсартай” шийдвэр гаргаж чадахгүй гэж найз нөхөд, хамаатан саднууд нь үзэж, гаргасан шийдвэрийг нь үл тоомсорлож ханддаг.

Мэдээлэл, харилцаа холбооны саад тотгорууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн шийдвэр гаргалтад сөргөөр нөлөөлдөг. Тухайлбал, мэдээллийн хүртээмжгүй байдлаас болж хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс шийдвэрт хүрэхэд шаардлагатай мэдээллээ авч чаддаггүй. Харилцаа, холбооны хэрэгслүүдийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээнд тохируулаагүй байдгаас (жишээлбэл, компьютерийн тусламжтайгаар мэдээллийг бодит цаг хугацаанд нь бичвэр болгож хөрвүүлэх CART технологи суулгаагүй, дохионы хэлний хэлмэрч байхгүй зэргээс) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдийгөө илэрхийлэх, өөрсдийн үзэл бодол, шийдвэрийг ойлгуулахад хүндрэлтэй тулгардаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгэмдээ бие даан, нэр төртэй амьдрах эрхийн хэрэгжилтэд тэдний бусад эрхийн зөрчил ч сөргөөр нөлөөлж болзошгүй. Тухайлбал:

- Ажил, хөдөлмөр эрхлэлтийн орчинд хөгжлийн бэрхшээлээр алагчлах нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг амьдралаа тэтгэх орлогын эх үүсвэрээс нь салгаж мэднэ.
- Тээврийн хэрэгсэл хүртээмжгүй бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чөлөөтэй зорчих эрх хязгаарлагдаад зогсохгүй тэдний ажлын байр, боловсрол, эрүүл мэнд, дэлгүүр хоршооноос үйлчилгээ хүртэх, орчинтойгоо бүрэн хэмжээнд харьцах боломж хангагдахгүйд хүрдэг.
- Бусад хүмүүсийн орон нутгийн эмнэлэг, амбулаториос авдаг эрүүл мэндийн болон нөхөн сэргээх үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс харин зөвхөн тусгай эмнэлгээс авдаг нөхцөл үүсэж болзошгүй.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс амьжиргааны хүрэлцэхүйц түвшинд хүрч чадахгүйгээс болж тусгаарлагдсан асрамжийн байгууллагад амьдрах, эсвэл өлсөж цангахгүй, толгой хоргодох газартай байхын тулд л хамаатан садныхаа хүмүүстэй амьдрах болдог.

- Хүртээмжтэй орон сууц хүрэлцээгүй учраас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст амьдрах орчноо сонгох боломж тун бага байх магадлалтай.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх сөрөг, алагчласан хандлагын улмаас хүмүүсийн дунд байхдаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эвгүйцэх, таагүй, аюултай мэдрэмж төрөх явдал гардаг нь тэднийг бусадтай харилцахаас зайлсхийхэд хүргэж мэднэ. Уг хандлагын улмаас гэр бүлийнхэн нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нуух явдал ч гардаг.

Амьдарч буй орчиндоо бие даан амьдрах эрхийн зөрчил нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бусад эрх зөрчигдөхөд хүргэх нөхцөл болдог. Жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тусгаарлагдсан орчинд хүчээр амьдруулж буй нөхцөлд тэдний орон нутгийнхаа нийгэм, соёл, улс төрийн амьдралд оролцох эрх хэрэгжих боломжгүй болдог. Гэр бүлээсээ тусдаа амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд гэр бүлийн орчинд өсөж торних боломж нь алдагдаж, чанартай боловсролд тэгш хамрагдах эрх нь зөрчигддөг. Тусгаарлагдсан орчинд амьдардаг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ялангуяа эмэгтэйчүүд, охид, оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд хүчирхийлэл, бэлгийн дарамт, тэр бүү хэл амь насанд нь заналхийлэх аюулд өртөх эрсдэл нэмэгдэж ч мэднэ. Тусгаарлагдсан орчин нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гэрлэх, өөрийн гэр бүлтэй болох боломжийг нь хязгаарладаг. Эдгээр жишээ нь хүний эрхүүд **нэгдмэл, уялдаа холбоотой, харилцан хамааралтай** болохыг харуулж байгаа юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгэмдээ бие даан амьдрах эрхийг зөрчих нь тэдний төрөлхийн мөн чанар болох нэр хүнд, нандин чанарыг үл хүндэтгэсэн хэрэг юм.

## ДАСГАЛ 11.1: Нийгэмд бие даан, нэр төртэй амьдрах гэж юуг хэлэх вэ?

- Зорилт:** Бие даан, нэр төртэй амьдрах гэж юуг хэлж байгааг ойлгох
- Хугацаа:** 30 минут
- Хэрэглэгдэхүүн:** Том цаас, фломастер, эсвэл самбар, шохой

### 1. Санал солилцох/Хэлэлцэх

Багаараа дараах асуултуудын дагуу хэлэлцүүлэг хийж, хариултыг жагсааж бич:

- “Бие даан амьдрах” гэдэг нь таны хувьд ямар утга агуулж байна вэ? Таны амьдарч буй орчинд үүнийг хэрхэн ойлгодог вэ?
- Таны амьдарч буй орчинд хөгжлийн бэрхшээлтэй ихэнх хүн хаана, хэрхэн амьдардаг вэ?
- Таны амьдарч буй орчинд ямар хүнийг тусгай асрамжийн газар, эмнэлэгт амьдруулдаг вэ? Энэ хүмүүс ихэвчлэн ямар төрлийн хөгжлийн бэрхшээлтэй байдаг вэ?
- Бие даан амьдрах эрхийг тодорхойлсон таны өөрийн тодорхойлолтод нийцсэн амьдралаар амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг та мэдэх үү?



## Бие даасан амьдралын арван зарчим

Зарим улс оронд “Бие даан амьдрах төв”-үүд байдаг бөгөөд эдгээр нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст амьдарч буй орчиндоо бие даан, нэр төртэй амьдрах эрхийг нь эдлүүлэхийн тулд төрөл бүрийн дэмжлэг тусалцаа, үйлчилгээ үзүүлдэг. Эдгээр төвийн олонх нь бие даасан амьдралын үзэл баримтлалд суурилсан нийтлэг зарчмуудын баримталж ажилладаг бөгөөд эдгээр нь:

1. **Хүний эрх:** бүх хүнд тэгш эрх, боломж олгох; хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэвшмэл үзлийн нөлөөгөөр алагчлах явдал гаргахгүй байх.
2. **Хэрэглэгчийг хүндэтгэх үзэл:** аливаа үйлчилгээ, бүтээгдэхүүнийг худалдан авч байгаа юмуу хэрэглэж байгаа хүн (“хэрэглэгч” буюу “үйлчлүүлэгч”) түүнд ямар нь илүү сайн тохирохыг өөрөө шийднэ.
3. **Тусгаарлахгүй байх:** ямар ч хүнийг хөгжлийн бэрхшээлийнх нь улмаас тусгаарлаж (албадан ямар нэг барилга, хөтөлбөр юмуу гэр бүлийн хүрээгээр хязгаарлах) болохгүй;
4. **Эмнэлзүйн хандлагаас татгалзах:** хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь эмнэлзүйн загварын үздэг шиг “өвчтэй” хүмүүс биш бөгөөд өдөр тутмын амьдралаар амьдрахын тулд тэдэнд эмнэлгийн мэргэжилтнээс тусалцаа заавал авах хэрэгцээ байхгүй.
5. **Өөрөө өөртөө туслах:** хүмүүс өөрсдийн хэрэгцээ, сонирхол, асуудлуудаа ижил төстэй амьдралын туршлагатай хүмүүстэй хэлэлцэх замаар бусдаас суралцаж, өсөн дэвжиж байдаг. Тусалцаа, дэмжлэгийн эх сурвалж нь “шинжээч мэргэжилтнүүд” биш.
6. **Нөлөөлөл:** нийгмийн өгч чадах бүхий л төрлийн ашиг шимийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хүртэж байх нөхцлийг бүрдүүлэхийн тулд системтэй, тууштай, урт хугацааны, нийгмийг бүхэлд нь хамарсан өөрчлөлтийн арга хэмжээ шаардлагатай.
7. **Саадыг арилгах:** хүний эрх, хэрэглэгчийг хүндэтгэх зарчим, тусгаарлахгүй байх, эмнэлзүйн хандлагаас татгалзах, өөрөө өөртөө туслах зэрэг зарчмуудыг хэрэгжүүлэхийн тулд дэд бүтцийн, харилцаа холбооны болон хандлагын саадыг арилгах хэрэгтэй.
8. **Хэрэглэгчийн хяналт:** хөгжлийн бэрхшээлтэй хувь хүмүүст тусалцаа, дэмжлэг үзүүлэхэд хамгийн тохиромжтой байгууллагыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдөө удирдан, зохион байгуулж, хамт олныг нь өөрсдөө бүрдүүлж, ажиллуулна.
9. **Үе тэнгийнхнээсээ үлгэр дуурайлал авах:** бие дааж амьдрах, эрхээ хамгаалах үйл ажиллагааны манлайллыг эцэг эх, үйлчилгээ үзүүлэгч, бусад төлөөлөгчдөд даатгах бус зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдөө л гартаа авах ёстой.
10. **Хөгжлийн бэрхшээлүүдийн нэгдсэн хандлага:** эхний таван зарчмыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хөгжлийн бэрхшээлтэй бүх хүний сайн сайхны төлөө янз бүрийн төрөл, хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хамтран хэрэгжүүлэх ёстой.<sup>1</sup>

1 “Бие даан амьдрах үзэл баримтлалын арван зарчим” номоос авав. Рокландын Бие даан амьдрах төв. <http://www.nlc.org/principles.htm> сайтыг үз.

## 2. Санал солилцох/Хэлэлцэх

Хүн болгон бусадтай адил тэгш, нэр төртэй амьдрах эрхтэй болохыг онцол. Дараах асуултуудын дагуу санал бодлоо солилцон, харилтуудыг жагсааж бич:

- “Нэр төртэй амьдрах” гэдэг нь таны хувьд ямар утга агуулж байна вэ?
- Үүнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь одоо хөгжлийн бэрхшээлгүй байгаа хүмүүсийнхтэй ижил төстэй тодорхойлолт өгөх бол уу?
- Танай орон нутагт байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олонх нь нэр төртэй амьдарч чадаж байгаа гэж та боддог уу? Бүр онцолбол, ямар хүмүүс нэр төртэй амьдарч чадаж байгаа гэж та боддог вэ? Хэн чадахгүй байна вэ?

## 3. Хэлэлцэх

Таны орчин тойронд байгаа хөгжлийн бэрхшээлтэй бүх хүнд нэр төртэй амьдрах боломж, нөхцлийг хангахын тулд юу хийх хэрэгтэй вэ? Бие даан амьдрах боломжийг хангахын тулд юу хийх ёстой вэ?

### Амьдарч буй орчиндоо бие даан, нэр төртэй амьдрахад саад болдог бэрхшээл, тотгоруудын жишээ

- Ажлын байр, дэлгүүр, эрүүл мэндийн байгууллага болон нийтийн газруудад ороход биет саад тулгардаг;
- Ажлын байр, дэлгүүр, эрүүл мэндийн байгууллага болон нийтийн газрууд руу хүрэх хүртээмжтэй тээврийн хэрэгсэл хомс;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тусгаарлагдсан орчин, асрамжийн газарт өөрсдийнх нь хүслийг зөрчин хүчээр амьдруулах нөхцөл тулгадаг хууль, журам, бодлого, практик үйлчилдэг;
- Бие дааж амьдрахад туслах зорилготой үйлчилгээний талаарх, мөн энэ үйлчилгээг авах хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, үүргийн талаарх хүртээмжтэй мэдээлэл хомс;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ялангуяа хараагүй, сонсголгүй, хараагүй бөгөөд сонсголгүй, оюуны болон сурах хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй харилцахад туслах арга хэмжээ авдаггүй;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хаана, хэнтэй амьдрах тухайгаа сонголт хийх чадваргүй, өөртөө хэрэгтэй шийдвэрийг гаргаж чадахгүй гэж үзэх хандлага арилаагүй.

### ДАСГАЛ 11.2: Амьдарч буй орчиндоо бие даан, нэр төртэй амьдрах эрхийг эдлэхэд саад болдог тотгоруудыг ойлгох нь?

<b>Зорилт:</b>	Амьдарч буй орчиндоо бие даан, нэр төртэй амьдрах эрхийг эдлэхэд тохиолддог саадуудыг ойлгох
<b>Хугацаа:</b>	30 минут
<b>Хэрэглэгдэхүүн:</b>	Том цаас, фломастер, буюу самбар, шохой





## 1. Танилцуулах

Амьдарч буй орчиндоо бие даан, нэр төртэй амьдрахад хөгжлийн бэрхшээлтэй зарим хүнд тохиолддог саад, тотгорын жишээнүүдийг оролцогчдоор гаргуул. Жишээнүүдийг жагсаан бич.

- Хөгжлийн бэрхшээлтэй зарим бүлэг, хэсэг хүмүүст бие даан, нэр төртэй амьдрахад бусдаас илүү олон саад, илүү ноцтой бэрхшээл тулгардаг уу? Яагаад?

## 2. Хэлэлцэх

Оролцогчдыг 2-3 хүнтэй жижиг багуудад хуваа. Оролцогчдын эргэн тойронд амьдардаг хөгжлийн бэрхшээлтэй нэг хүний бие даан, нэр төртэй амьдрах эрх хангагдахгүй байгаа тухай зохиомол боловч нийтлэг түүхийг баг болгон зохионо.

Нөөц хувилбар: Зохиосон “түүх”-ээрээ багууд жүжигчилсэн тоглолт үзүүлнэ.

## 3. Илтгэх/Шинжлэх

Баг болгон “түүх”-ээ ярих ба энэ түүхийн “баатар” болсон зохиомол дүрийн ямар эрхийг зөрчсөн тухай хэлэлцүүлэг хийнэ. Эдгээрийг жагсааж бич.

## 4. Шинжлэх/Хэлэлцэх

Багуудын зохиосон түүхийн баатрууд нь бие даан, нэр төртэй амьдрах эрхээ хангуулахын тулд яах ёстой тухай ярилц. Үүний тулд багуудын зохиосон түүхэнд гарсан сөрөг үр дагавартай нөхцөл байдлыг эерэг тал руу нь хэрхэн өөрчлөх тухай хэлэлцүүлэг хэлбэрээр хийж болно.

- 12, 19 болон 28 дугаар зүйлүүдэд багтсан төрөл бүрийн туслалцаа, дэмжлэгүүдийг анхаар.
- Эдгээр дэмжлэг, туслалцааг авахын тулд юу хийх ёстой вэ?
- Эдгээр дэмжлэг, туслалцааг хангаж өгөх шаардлагыг хүний эрхийн байр сууринаас харж нөлөөллийн үйл ажиллагаа явуулбал тус болох уу?

АМЬДАРЧ БУЙ ОРЧИНДОО БИЕ ДААН, НЭР ТӨРТЭЙ АМЬДРАХ  
ЭРХИЙН ТАЛААР ХҮНИЙ ЭРХИЙН ЭРХЗҮЙД ЮУ ГЭЖ ЗААСАН БАЙДАГ ВЭ?

Амьдарч буй орчиндоо бие даан, нэр төртэй амьдрах эрхийг хүний эрхийн эрхзүйн хэд хэдэн баримт бичигт хөндсөн байдаг. Тухайлбал, **Хүний эрхийн түгээмэл тунхаглалд** (ХЭТТ) хүн бүр хүрэлцэхүйц амьжиргаатай байх (25 дугаар зүйл), хуулийн өмнө адил тэгш байх эрхээ хүлээн зөвшөөрүүлэх (6 дугаар зүйл) эрхтэй гэж заасан байдаг нь өөртөө хамаатай асуудлаар шийдвэрээ өөрөө гаргах хүний эрхтэй холбоотой заалт юм.<sup>2</sup> **Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад**<sup>3</sup> (ИУТЭОУП) шийдвэр гаргахтай холбоотой заалтууд мөн орсон байдаг бөгөөд эдгээр нь, тухайлбал, хүн бүр хуулийн өмнө адил тэгш эрхтэй хэмээн заасан 16 дугаар зүйл, хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй хэмээн заасан 17 дугаар зүйл зэрэг болно. **Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын**<sup>4</sup> (ЭЗНСЭОУП) хэрэгжилтийг хянадаг **Эдийн засаг, нийгэм,**

2 <http://www.unhchr.ch/udhr/> сайтыг үз.

3 <http://www.ohchr.org/english/law/ccpr.htm> сайтыг үз.

4 [http://www.unhchr.ch/html/menu3/b/a\\_ceschr.htm](http://www.unhchr.ch/html/menu3/b/a_ceschr.htm) сайтыг үз.

**соёлын эрхийн хорооны** Ерөнхий зөвлөмжийн №5-д “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусад хүмүүсийн дунд, өөрийн сонгосон арга хэлбэрээр, бие даан амьдрах нөхцлөөр хангах”-ад чиглэсэн бодлоготой болохыг засгийн газруудад уриалаад, “[х]өгжлийн бэрхшээлтэй холбоотой бодлогууд нь орон нутгийн бүх үйлчилгээг [хөгжлийн бэрхшээлтэй бүх хүнд] хүртээмжтэй болгоход чиглэгдэнэ” гэжээ.<sup>5</sup> **Эдийн засаг нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын** (ЭЗНСЭОУП) 11 дүгээр зүйлд хүн бүр хүрэлцэхүйц амьжиргаатай байх, үүний дотор “хангалттай хоол хүнс, хувцас, орон байраар хангагдах, мөн амьдрах нөхцлөө тасралтгүй сайжруулах” эрхтэй гэж заажээ.

**Хүүхдийн эрхийн конвенцийн** (ХЭК) олон зүйл заалт нь хүүхдийг гэр бүлд нь амьдруулахыг дэмждэг (энэ нь хүүхдийн эрх ашигт хамгийн ихээр нийцэж байгаа бол) бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд “нийгмийн амьдралд оролцох” (23 дугаар зүйл) эрхтэй болохыг онцолжээ. Цаашилбал, Хүүхдийн эрхийн хороо нь Оролцогч улсуудад хандан:

*... хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг гэр бүлээс нь салган тусгай байгууллагад амьдруулахаас зайлсхийн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүний гэр бүлд боломжийн хамгийн өргөн хүрээнд амбулаторийн болон олон нийтийн оролцоонд тулгуурласан туслалцаа, дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн шаардлагатай бүхий л арга хэмжээ авахыг<sup>6</sup> уриалжээ.*

1993 онд батлагдсан **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боломжийг тэгшитгэх тухай Стандарт дүрмүүд** (Стандарт дүрэм) нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгэмдээ бие даан амьдрах эрхтэй шууд холбоотой дараах асуудлуудыг авч үзжээ:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, хэрэгцээ, боломж болон нийгэмд оруулах хувь нэмрийн тухай мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх (Дүрэм 1);
- Эмнэлгийн тусламж ба нөхөн сэргээх үйлчилгээг орон нутагт нь хүртээмжтэй үзүүлэх (Дүрэм 2 ба 3);
- Бие даасан байдлыг дэмжих, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрхээ эдлэхэд нь шаардлагатай туслалцаа, дэмжлэгийг үзүүлэх (Дүрэм 4);
- Дэд бүтэц, мэдээлэл, харилцаа холбооны хүртээмжийг сайжруулах (Дүрэм 5);
- Боловсон хүчнийг сургаж бэлдэх (Дүрэм 19).<sup>7</sup>

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци (ХБХЭК) нь өмнөх үеийн хүний эрхийн баримт бичгүүдэд туссан асуудлуудыг улам дэлгэрүүлэн авч үзээд, амьдарч буй орчиндоо бие даан, нэр төртэй амьдрах эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалахын тулд Оролцогч улсууд юу хийхийг тодруулж өгчээ. Хүний эрхүүд **нэгдмэл, уялдаа холбоотой, харилцан хамааралтай** учир ХБХЭК-ийн олон зүйл, заалт нь энэхүү эрхийг хэрэгжүүлэхтэй ямар нэг байдлаар холбоотой. Харин 19, 28 болон 12 дугаар зүйл нь хөгжлийн бэрхшээлтэй хүн амьдарч буй орчиндоо бие даан, нэр төртэй амьдрах эрхтэй шууд холбоотой чухал заалтууд юм.

5 [http://www.unhchr.ch/tbs/doc.nsf/\(Symbol\)/CESCR%20General%20Comment%205.En?Opendocument](http://www.unhchr.ch/tbs/doc.nsf/(Symbol)/CESCR%20General%20Comment%205.En?Opendocument) сайтыг үз.

6 <http://www.unhchr.ch/html/menu2/6/crc/doc/days/violence.pdf> сайтыг үз.

7 <http://www.un.org/esa/socdev/enable/dissre00.htm> сайтыг үз.

ХБХЭК-ийн 19 дүгээр зүйл нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бие даан амьдрах, орон нутгийнхаа амьдралд бүрэн дүүрэн хамрагдах эрхийг тусгайлан авч үзсэн зүйл анги юм. Онцолбол, 19 дүгээр зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдын адил чөлөөтэй сонголт хийх эрхтэй болохыг заагаад, үүнд хаана, хэнтэй амьдрахаа өөрсдөө шийдэх, тусгай орчинд хүчээр амьдрах шахалтад өртөхгүй байх эрх багтаж байгааг дурьджээ. Түүнчлэн, бие даан амьдрах, тусгаарлагдахгүй байх, нийгмээс салахгүй байхын тулд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст шаардлагатай дэмжлэг, үйлчилгээг хангаж өгөхийг 19 дүгээр зүйл Оролцогч улсуудаас хүсжээ. Ийм төрлийн дэмжлэгийн дотор хувийн туслахаар хангаж өгөх, гэрээр үйлчилгээ үзүүлэх зэрэг багтахаас гадна олон нийтийн оролцоонд тулгуурласан бусад олон дэмжлэгийг хамруулж болох юм. Мөн нийт хүн амд хандсан үйлчилгээ болон ийм үйлчилгээ эрхэлж байгаа байгууллагууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бусадтай адил тэгш үндсэн дээр хүртээмжтэй байх, тэдний хэрэгцээг харгалзах шаардлага 19 дүгээр зүйлд багтжээ.

ХБХЭК-ийн 28 дугаар зүйлд хүрэлцэхүйц амьжиргаатай байх, нийгмийн хамгаалал хүртэх эрхийг зааж өгчээ. 28 дугаар зүйл нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрх, үүний дотор “хүрэлцэхүйц хоол хүнс, хувцас, орон байраар хангагдах, амьдрах нөхцлөө тасралтгүй сайжруулах” эрхийг хүлээн зөвшөөрөөд, эдгээр эрхээ хөгжлийн бэрхшээлээр алагчлахгүй байх үндсэн дээр эдлэх эрхтэйг онцолжээ. Оролцогч улсууд нь мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нийгмийн хамгааллыг хөгжлийн бэрхшээлээр алагчлалгүйгээр эдлүүлэхэд анхаарах ёстой. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс (ялангуяа, хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүд, өндөр настнууд) цэвэр усны хангамж, нийгмийн хамгаалал болон ядуурлыг бууруулах хөтөлбөрүүдэд хамрагдах, нийтийн орон сууцаар хангагдах, тэтгэвэр авах, хөтөлбөрүүдэд хамрагдах тэгш боломжоор хангагдсан байх ёстой ажээ.

Амьдарч буй орчиндоо бие даан, нэр төртэй амьдрах эрхийн хүрээнд төр дараах үүргийг хүлээнэ:

1. **Эрхийг хүндэтгэн** хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст энэ эрхээ эдлэх, хэрэгжүүлэхэд нь төрийн албан хаагч зэрэг төрийн этгээдүүд саад болохгүй байх нөхцлийг бүрдүүлэх үүрэг
2. **Эрхийг хамгаалан** хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс энэ эрхээ эдлэхэд нь бизнесийн болон үйлдвэрчний эвлэл зэрэг төрийн бус этгээд саад болохгүй байх нөхцлийг хангах үүрэг
3. **Эрхийг хангаж** хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хөдөлмөрлөх эрхээ эдлэх боломжийг хангахад чиглэсэн арга хэмжээ авах үүрэг.

Товчхондоо, олон улсын хүний эрхийн эрхзүй нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгэмдээ бие даан, нэр төртэй амьдрах эрхийг зөвхөн хүний эрх гэдэг утгаар нь дэмжээд зогсохгүй, бусад эрхээ илүү бүрэн дүүрэн эдэлж, нийгмийн бүрэн эрхт гишүүний хувьд үүрэг хариуцлагаа бүрэн хүлээж, нийгэмдээ хувь нэмрээ оруулах арга зам болох утгаар нь дэмжиж байгаа билээ. ХБХЭК-ийн 12 дугаар зүйл нь хуулийн өмнө адил тэгш байх эрхийн асуудлыг хөндөж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс “амьдралын бүхий л хүрээнд бусадтай адил тэгш байх үндсэн дээр эрхзүйн чадамжтай” болохыг хүлээн зөвшөөрдөг. Түүхэнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрхзүйн чадамжийг нь хязгаарласан хууль, практикт өртөж, улмаар тэдний бие даасан байдал, хаана, хэрхэн амьдрах сонголт хийх боломж хязгаарлагдах явдал олон гарч байжээ.

Зайлшгүй анхаарах шаардлагатай өөр нэг асуудал бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өмнөөс бусад хүмүүс шийдвэр гаргах явдал юм. Орлон шийдвэр гаргагч нь хөгжлийн бэрхшээлтэй хүний сайн сайхны төлөө, сайныг бодож ингэж байгаа ч гэсэн энэ үйлдэл нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өөртөө хамааралтай асуудлаар өөрөө шийдвэр гаргах эрхийг нь хязгаарлах үр дагавар авчирна. 12 дугаар зүйл нь энэ хандлагыг өөрчлөх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхзүйн чадамжийг хүлээн зөвшөөрч, эрхзүйн чадамжаа хэрэгжүүлэхэд нь тэдэнд туслах ямар арга хэмжээ авахыг зааж өгчээ. Хэдий хэмжээний туслалцаа, дэмжлэг шаардлагатай байгаагаас үл хамааран энэ туслалцаа нь хүчирхийллийн шинж агуулаагүй, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхэд халдаагүй байхад Оролцогч улсууд анхаарах ёстой.

Эцэст нь хэлэхэд, Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “эд хөрөнгө эзэмших, түүнийг өвлөх, санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх болон банкны зээл, үл хөдлөх хөрөнгийн барьцаат зээл болон бусад төрлийн санхүүгийн үйлчилгээг тэгш хүртэх эрх”- ийг хангаж, хөгжлийн бэрхшээлтэй хүний эд хөрөнгийг хууль бусаар хураахгүй байхад анхаарах үүрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс санхүүгийн болон эд хөрөнгийн эх сурвалж, нөөцүүдийг хүртэх, хянах боломжгүй бол нийгэмдээ бие даан амьдарч чадахгүйд хүрч мэдэх тул эдгээр нь маш чухал арга хэмжээ юм.

### **ДАСГАЛ 11.3: Амьдарч буй орчиндоо бие даан, нэр төртэй амьдрах эрхийг ойлгох нь**

**Зорилт:** ХБХЭК-иар баталгаажсан бие даан, нэр төртэй амьдрах эрхийг ойлгох  
**Хугацаа:** 45 минут  
**Хэрэглэгдэхүүн:** Том цаас, фломастер, буюу самбар, шохой, тараах материал

#### **1. Энгийн үг хэллэгээр өөрчлөн найруулах/Хэлэлцэх**

Оролцогчдыг гурван багт хуваагаад, ХБХЭК-ийн 12, 19, 28 дугаар зүйлүүдийг хуваарилж өг. 19 дүгээр зүйл урт учраас гурван бат хувааж болох бөгөөд ингэхдээ 4, 5 дугаар хэсгүүдийг хоёр өөр багт оноож болно. Баг бүрт оногдсон Зүйлийн хуулбар, энэ Зүйлтэй холбоотой нэмэлт асуултуудыг тарааж өг.

#### **Даалгавар:**

- а. Багт оногдсон Зүйлийн бүх хэсгийг энгийн үг хэллэгээр өөрчлөн найруулаад, том цаасан дээр бич.
- б. Танай багт оноосон Зүйлийн тухай дараах асуултуудад хариул:

#### **12 дугаар зүйл**

- 1 дэх хэсэгт “хуулийн өмнө адил тэгш байх” гэснийг юу гэж ойлгож байна вэ?
- 2 дахь хэсэгт “эрхзүйн чадамжтай байх” гэснийг юу гэж ойлгож байна вэ?
- 3 дахь хэсэгт “эрхзүйн чадамжаа хэрэгжүүлэхэд нь шаардлагатай дэмжлэг туслалцаа” гэсэнд ямар төрлийн туслалцааг багтаан ойлгож байна вэ?
- 4 дэх хэсэгт дурьдсан “эрхзүйн чадамжаа хэрэгжүүлэх”-тэй холбоотой жишээнүүд гаргана уу?



## 19 дүгээр зүйл

- “Бие даан амьдрах” гэдгийг юу гэж ойлгож байна вэ? Жишээ өгнө үү.
- “Тухайн оршин суугаа орчиндоо бүрэн дүүрэн хамрагдаж, оролцох” гэснийг юу гэж ойлгож байна вэ?

## 28 дугаар зүйл

- 1 дэх хэсэгт “амьжиргааны хүрэлцэхүйц түвшинд байх” гэснийг юу гэж ойлгож байна вэ?
- 1 дэх хэсэгт “амьдралын нөхцлөө тасралтгүй сайжруулах” гэснийг юу гэж ойлгож байна вэ?
- 2 дахь хэсэгт “нийгмийн хамгаалал” гэснийг юу гэж ойлгож байна вэ?
- 2(а) хэсэгт ямар төрлийн “үйлчилгээ, тоног төхөөрөмж болон бусад тусалцаа”-г багтааж болох вэ?

## 2. Илтгэх

Багуудын энгийн үг хэллэгээр өөрчилсөн найруулгыг ил газар хадаад, тодорхойлолтыг нь уншуулна. Ингэхдээ хэсэг болгоны дараа түр зогсоож бусад оролцогчдод асуулт, эсвэл санал болгох өөр найруулга байгаа эсэхийг лавлана. Зүйл тус бүрийг дагалдуулан тарааж өгсөн асуултуудад багууд хэрхэн хариулсныг тайлбарлуул. Зүйл болгоны тухайд энгийн, давхар утгагүй, ойлгомжтой хэлбэрээр найруулсан хувилбар гаргаж ирэхийг хичээгээрэй.

## 3. Жишээ гаргах

Эдгээр эрхийг хэрхэн эдлэх, энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралыг хэрхэн өөрчлөх талаар жишээ гаргахыг хүс.

## 4. Хэлэлцэх

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах асуудлыг үндэсний хэмжээний бодлогын асуудал болгож тавих, мөн улс төрийн нам, шийдвэр гаргагчдад өргөн барих үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулахад ХБХЭК-ийн эдгээр Зүйлийг хэрхэн ашиглаж болох вэ?

### **ДАСГАЛ 11.4: Амьдарч буй орчиндоо бие даан, нэр төртэй амьдрах эрхийг дэмжих үүрэг амлалт авах нь**

Хүний эрх бол эдлэх эрх, хүлээх үүргийн нэгдэл гэдгийг тайлбарла.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгэмдээ бие даан, нэр төртэй амьдрах эрхийг судалж, мэдлэгтэй болсны эцэст өөрсдөө тодорхой үйл ажиллагаа явуулахад бэлэн болсон эсэхийг оролцогчдоос асуу.
- Мэдээлэл цуглуулах, ажлаа төлөвлөх гээд хийх зүйл их байгаа ч өөрчлөлт хийх чин эрмэлзэл маш чухал гэдгийг тэмдэглэн хэл.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст орон нутагтаа бие даан, нэр төртэй амьдрах эрхээ бүрэн эдлэхэд нь нэмэр болох жижиг ч хамаагүй ямар ажлыг ирэх сард хийхийг хүсэж байгаа, хийх боломжтой байгааг оролцогч бүрээр хэлүүл.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах нөлөөллийн ажил хэрхэн төлөвлөх талаар “Хэсэг 3. Нөлөөлөл! Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа” (хуудас 278) хэсгээс уншина уу.

### **Бусдын туслалцаатай шийдвэр гаргах боломж**

Дэлхий даяар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өмнөөс өөр хүн шийдвэр гаргах *орлон шийдвэр гаргалтын* загвараас зайлсхийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хүсэлт гарган бусад хүний дэмжлэг туслалцаатайгаар өөрсдөө шийдвэр гаргадаг *бусдын дэмжлэгтэй* шийдвэр гаргах хэлбэрийг сонгох нь улам нэмэгдэж байна. Энэхүү хандлага нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төрөлхийн нэр төрийг хүндэтгэн, халамжлах арга барилаас зайлсхийх оролдлого юм. Шийдвэр гаргахад бусдын туслалцааг ашиглах шаардлагатай ямар ч хүнд энэ арга хэмжээ ач холбогдолтой ч орон гаргасан шийдвэрийг хүчээр дагахаас өөр аргагүй байдалд хамгийн их өртдөг нийгэм-сэтгэцийн болон оюуны бэрхшээлтэй хүмүүст онцгой хамаарна.

Бусдын дэмжлэгтэй шийдвэр гаргалтыг зөвшөөрсөн олон улсын санал нэгдсэн стандарт, удирдамжууд одоогоор гараагүй ч бусдын дэмжлэгтэй шийдвэр гаргах явцад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг зөрчихгүй байхад анхаарал тавьж байгаа хүмүүст дараах зүйлс хэрэг болох магадлалтай:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн шийдвэр гаргах төрөлхийн чадавхийг бусад хүмүүс хүндэтгэх үүрэгтэй;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс шийдвэр гаргалтад өөрсдийнхөө дуу хоолойг тусгах эрхтэй;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хүсэлт гаргаж шаардлагатай туслалцаа авах эрхтэй;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс жинхэнэ утгаар сонголт хийх, хийсэн сонголтдоо тулгуурлан шийдвэр гаргах эрхтэй;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс алдаа гаргах боломжтой байх эрхтэй.

Бусдын дэмжлэгтэйгээр шийдвэр гаргахтай холбоотой бусад стандарт, удирдамжийг та санал болгоно уу?<sup>8</sup>

8 “Бусдын дэмжлэгтэй шийдвэр гаргах нь”. *Насан туршийн төлөвлөгөөт амьдралыг дэмжих нөлөөллийн сүлжээ*. [http://www.plan.ca/Programs\\_Decisions.php](http://www.plan.ca/Programs_Decisions.php)



АМЬДАРЧ БУЙ ОРЧИНДОО БИЕ ДААН, НЭР ТӨРТЭЙ АМЬДРАХ ЭРХИЙН ТУХАЙ НЭМЭЛТ  
МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

- “Амьдралын хүртээмж” бие даан амьдрах төв:  
<http://www.accessliving.org>
- Канадын Бие даан амьдрах төвүүдийн холбоо:  
<http://www.cailc.ca>
- Хүүхдийн эрхийг хамгаалах хороо, 25 дугаар ээлжит хуралдааны тайлан, 2000 оны 9, 10 дугаар сар, CRC/C/100,688.17,20-22,21-25:  
<http://www.unhcr.org/home/RSDCOI/3F4782b84.pdf>
- АНУ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, бие даан амьдрах боломжийг дэмжих хөдөлгөөн. Калифорнийн Их сургууль:  
<http://bancroft.berkeley.edu/collections/drilm>
- *Бие даан амьдрах үзэл баримтлалын арван зарчим.* Рокландын Бие даан амьдрах төв:  
<http://www.rilc.org/principles.htm>
- *Бусдын дэмжлэгтэй шийдвэр гаргах нь.* Насан туршийн төлөвлөгөөт амьдралын төлөө нөлөөллийн сүлжээ:  
[http://www.plan.ca/Programs\\_Decisions.php](http://www.plan.ca/Programs_Decisions.php)

## БҮЛЭГ 12. ШҮҮХ АЖИЛЛАГААНД ХҮРТЭЭМЖТЭЙ ОРОЛЦОХ НЬ

### НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци

#### 13 дугаар зүйл. Шүүх ажиллагаанд хүртээмжтэй оролцох

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусадтай адил тэгш байх үндсэн дээр шүүхийн шатны бүх үйл ажиллагаа, түүний дотор мөрдөн байцаалт болон шүүхийн өмнөх шатны бусад ажиллагаа зэрэг хууль эрхзүйн бүх ажиллагаанд шууд болон шууд бус оролцох үүрэг, тухайлбал гэрчийн хувьд үр нөлөөтэй оролцох явдлыг байцаан шийтгэх ажиллагааны хэм хэмжээ болон насны онцлогт нийцсэн хэрэглэгдэхүүн ашиглах замаар шүүх ажиллагаанд хүртээмжтэй, үр дүнтэй оролцох эрхийг оролцогч улсууд хангана.
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг шүүх ажиллагаанд үр дүнтэй, хүртээмжтэй оролцох нөхцлийг хангах үүднээс оролцогч улсууд шүүхийн байгууллагуудад тухайлбал, цагдаа болон хорих ангийн албан хаагчдыг зохих сургалтад хамруулах явдлыг дэмжинэ.

#### ЗОРИЛТУУД

Энэ бүлгийн сэдэв, үндсэн мэдээлэл, дасгалууд нь оролцогчдод дараах зорилтыг хангахад туслах зорилготой:

- Шүүх ажиллагаанд хүртээмжтэй оролцох эрхийг тодорхойлох;
- Шударга шүүхийн тэгш хүртээмжтэй байдал нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд ямар ач холбогдолтой болохыг тайлбарлах;
- Шүүх ажиллагаанд хүртээмжтэй оролцох эрх, хүний бусад эрхийн хоорондын уялдааг ойлгох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн шүүх үйл ажиллагаанд хүртээмжтэй оролцох эрх хэрхэн хангагдаж эсвэл зөрчигдөж байгааг мэддэг болох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн шүүх үйл ажиллагаанд хүртээмжтэй оролцох эрхийн тухай заалтуудыг ойлгох.

#### ЭХЛЭЛ: ШҮҮХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХҮРТЭЭМЖТЭЙ ОРОЛЦОХ ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЭХ НЬ

“Шүүх үйл ажиллагаанд хүртээмжтэй оролцох” гэдэг нь их өргөн утгатай зарчим бөгөөд шүүхийн тогтолцоо, процедур, мэдээллийн хүртээмж, мөн шударга шүүхийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ашиглаж байгаа байрны хүртээмж зэргийг багтаадаг. Шударга бусаар, эсвэл зүй бус харьцааны хохирогч болсон гэж өөрийгөө үзэж байгаа хүн өөрийн улсын шүүхийн тогтолцоонд ханддаг. Мөн хүмүүсийг шүүх ажиллагаанд олон нийтийн шүүгч, гэрч зэрэг үүргээр дайчлан оролцуулдаг. Харамсалтай нь, шүүх, трибунал, тухайн орны шүүхийн тогтолцоог



бүрдүүлж буй бусад элементүүд хүртээмжгүй байдгаас болж хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс шударга шүүхээс эрх тэгш үйлчилгээ авч чадахгүй байх явдал олон гардаг. Эдгээр саад, тотгор нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн шүүх тогтолцоог ашиглах боломжийг хязгаарлаад зогсохгүй шударга шүүхийн үйлчилгээг хүргэхэд тэдний оруулах хувь нэмрийг ч хязгаарладаг.

Шүүх үйл ажиллагаанд хүртээмжтэй оролцох боломж нь бусад бүх эрхийг эдлэх боломжид хамгийн ихээр нөлөөлдөг. Жишээлбэл, хөдөлмөрлөх эрх нь зөрчигдсэн гэж үзэж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүн энэ зөрчлийг арилгуулахаар шүүхэд хандах хүсэлтэй байна гэж бодъё. Гэтэл шүүхийн тогтолцоо нь тэдний биет юмуу харилцааны, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй нь холбоотой хэрэгцээг хангаж чадахгүй бол, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүнийг илт ялгаварлаж хандвал шүүх үйл ажиллагаанд оролцох эрхээ эдэлж чадахгүйд хүрч, энэ нь давхар хөдөлмөрлөх эрхээ хамгаалуулж чадахгүйд хүргэх юм. Үүнтэй адилаар гэмт хэргийн хохирогч болсон хөгжлийн бэрхшээлтэй хүн цагдаад мэдэгдэн, гэмт хэрэгтнийг хариуцлагад татахыг хүслээ ч биет саадаас болж цагдаагийн байранд орж чадахгүй, цагдаатай харилцаж чадахгүй, ойлгомжтой хэлбэрээр хэрэгтэй мэдээллээ олж авч чадахгүй бол тэр хүн хохирогчийнхоо эрхийг бүрэн эдэлж чадахгүй. Эдгээр жишээ нь хүний эрхүүд **нэгдмэл, уялдаа холбоотой, харилцан хамааралтай** болохыг харуулж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн шүүх үйл ажиллагаанд оролцох эрхэд бусад эрхээ эдлэх боломж нь янз бүрийн эерэг, сөрөг нөлөө үзүүлдэг. Жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүн цагдаагийн хэлтэс, шүүхийн байр, эсвэл шүүхийн үйл ажиллагаа явагдаж байгаа бусад газарт очиж чадах эсэх нь тээврийн хэрэгслийн хүртээмжээс хамаарна. Үүнтэй адилаар чанартай боловсрол хүртсэн хөгжлийн бэрхшээлтэй хүн шүүх ажиллагааг илүү сайн ойлгож, ашиглах чадвартай болох бөгөөд харин түүний боловсрол эзэмших эрх зөрчигдсэн бол шүүх үйл ажиллагаа түүний хувьд ойлгомжгүй, хэцүү, бүр оролцох боломжгүй зүйл болж мэднэ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн амьдралд бүрэн дүүрэн хамруулахын тулд шүүхийн хүртээмж маш чухал байдаг. Шүүх үйл ажиллагаанд оролцоход нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд саад, тотгор тулгарсаар байх юм бол тэд нийгмийн нэгэн гишүүний хувьд хүлээсэн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлэх, эсвэл эрхээ хангуулж чадахгүйд хүрнэ. Ийм учраас эдгээр саадыг арилгаж, шүүх үйл ажиллагаанд гэрч, шүүгч, хуульч, арбитрч, шүүх үйл ажиллагааны бусад оролцогчийн үүргээ биелүүлэх боломжийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хангаж өгөх шаардлагатай.

## ДАСГАЛ 12.1: Шүүхэд хандах нь

- Зорилт:** Шүүхийн тогтолцоо бол нарийн ээдрээтэй бүтэц болохыг ойлгож, хүмүүс энэ тогтолцоог хэрхэн ашиглаж болохыг мэддэг болох
- Хугацаа:** 30 минут
- Хэрэглэгдэхүүн:** Том цаас, фломастер эсвэл самбар, шохой

### 1. Санал солилцох

Оролцогчдын орчин тойронд хүмүүс ямар асуудлаар шүүхэд голдуу ханддаг болохыг оролцогчдоор нэрлүүл. Аль болох олон шалтгааныг доор өгсөн хүснэгтэд жагсааж бич.

Өмч хөрөнгө, гэр бүлийн асуудал, аюултай гэмт хэрэг, эсвэл нэг хүн нөгөөдөө хохирол учруулсан боловч үүнийг нь гэмт хэрэг гэж тооцохгүй байх тохиолдол (хүний талаар худал мэдээлэл бичих, амаар тараах) зэрэг асуудлуудыг багтаа. Оролцогчдын нэрлэсэн тохиолдол тус бүрт хүмүүс шударга ёс тогтоолгохоор ямар байгууллагад ханддагийг асуу (цагдаагийн газар, ахмадын зөвлөл, шашны бүтэц, шүүгч, шүүх г.м). Эдгээрийг жагсааж бич.

## 2. Жагсаалт гаргах

Дасгалын эхний хэсэгт дурьдсан тохиолдлуудад шүүх тогтолцоонд хувь хүмүүс ямар үүрэг гүйцэтгэж оролцдог (хохирогч, сэжигтэн, гэрч, цагдаа, зөвлөгөө өгөх ахмад хүн, хуульч, иргэний төлөөлөл, шүүгч, мэргэжилтэн, шоронгийн ажилтан г.м) тухай асуугаад, гарсан хариултуудыг хүснэгтэд жагсааж бич.

- Таны эргэн тойронд байдаг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс дээрх үүрэг ролийг гүйцэтгэдэг үү? Тохирох хариултын өмнө тэмдэглэл хийгээрэй.

## 3. Хэлэлцэх

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гүйцэтгэж чаддаггүй үүрэг ролийг хэлэлц:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээр эдгээр үүрэг ролийг гүйцэтгүүлэхгүй, улмаар шүүх ажиллагаанд бүрэн оролцох боломж олгохгүй байвал ямар үр дагавар гарах вэ?
- Таны бодлоор, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээр эдгээр үүрэг ролийг яагаад гүйцэтгүүлэхгүй байна вэ?
- Шүүх ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцох боломжийг нэмэгдүүлэхийн тулд юу хийх ёстой вэ?

Шүүх байгууллагад ханддаг шалтгаан	Ямар байгууллагад ханддаг	Эдгээр байгууллагын үйл ажиллагаанд хүмүүсийн гүйцэтгэдэг үүрэг роль



## **Шүүх ажиллагаанд оролцоход учирч байгаа саад бэрхшээлийн жишээ**

- Цагдаагийн газар, шүүх байр, шорон, хорих газар, олон нийтийн бусад газар руу ороход биет саад таардаг;
- Цагдаагийн газар, шүүх байр, олон нийтийн бусад газарт хүргэж өгөх хүртээмжтэй тээврийн хэрэгсэл хомс;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг гэрч, шүүгч, олон нийтийн төлөөлөгч, хуульчийн үүргээр оролцоход шууд хориг тавьсан хууль, журам, бодлого, практик үйлчилсээр байна;
- Шүүхийн тогтолцоо хэрхэн ажилладаг, шүүх ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ямар эрх, үүрэгтэй оролцож болохыг тайлбарласан хүртээмжтэй мэдээлэл хомс;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ялангуяа хараагүй, сонсголгүй, оюуны болон сурах бэрхшээлтэй хүмүүсийн бусадтай харилцах боломжийг дэмжсэн зохицуулалтууд байхгүй;
- Шүүх ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хувь нэмэртэйгээр оролцож чадах эсэх тухайд эргэлзсэн үзэл, хандлага. Жишээлбэл, сэтгэц-нийгмийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс найдвартай гэрч болж чадахгүй гэсэн үзэл байдаг.
- Шүүх ажиллагаанд оролцож байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өвөрмөц, тусгай хэрэгцээг ойлгуулах, шаардлагатай зохицуулалтыг хэрхэн хангаж өгөх талаар цагдаагийн болон бусад албаны хүмүүст сургалт явуулдаггүй.

### **ДАСГАЛ 12.2: Шүүх ажиллагаанд оролцоход учирдаг саад тотгор**

- Зорилт:** Шүүх ажиллагаанд оролцоход хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст учирдаг саад тотгоруудыг тодорхойлох
- Хугацаа:** 30 минут
- Хэрэглэгдэхүүн:** Дасгал №12.1-ийн явцад гаргасан үүрэг ролиудын жагсаалт

#### **1. Шинжлэх**

12.1 дүгээр дасгалаар гаргаж ирсэн шүүх тогтолцооны хүрээнд харилцах шаардлагатай хүмүүс, байгууллагуудын жагсаалтаас оролцогч бүр (ганцаараа юмуу хосоороо) нэг ролийг сонгож аваад, хөгжлийн бэрхшээлтэй хүн энэ үүргийг гүйцэтгэх болбол түүнд ямар саад, тотгор учрах талаар дүгнэлт гарга.

#### **2. Дүрд тоглох**

Ганцаараа юмуу хосоороо хийсэн дүн шинжилгээгээ танилцуулаад, тухайн үүргийг гүйцэтгэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүнд тулгарах нэг бэрхшээлийг дүрийн тоглолтоор үзүүлэхийг оролцогчдоос хүс.

### 3. Хэлэлцэх

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг шүүх ажиллагаанд бүрэн дүүрэн оролцуулахгүй байснаас ямар үр дагавар гарах вэ? Хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд? Шүүх ажиллагааны хувьд? Нийгэмд бүхэлд нь?
- Ямар саад, тотгорууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хамгийн ноцтой нөлөөлөх вэ? Шүүх ажиллагааны хувьд? Нийгэмд бүхэлд нь?
- Бүрэн оролцоог хангахад саад болж байгаа олон шалтгаанаас хамгийн ноцтой саадуудыг арилгахын тулд юу хийх ёстой вэ? Тэдгээрийг жагсааж бичээд, 12.3 дугаар дасгалд дахин ашиглахаар хадгал.

#### **Хөгжлийн бэрхшээлтэй хохирогчдод дэмжлэг үзүүлэх үйлчилгээ**

Гэмт хэргийн хохирогч болсон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст дэмжлэг үзүүлэх үйлчилгээ албан ёсоор хэвшээгүй байгаа учраас хүний эрхийн нөлөөллийн байгууллагууд энэ төрлийн дэмжлэгийг өөрсдөө үзүүлдэг болж байна. Эдгээр үйлчилгээнд дараах үйл ажиллагаа багтана:

- Гэрчийг дагуулж цагдаагийн газарт очих;
- Цагдаагийн ажилтнуудтай ярилцаж гэрчийн бэрхшээлийг тэдэнд ойлгуулах;
- Мөрдөн байцаалтад туслах үүднээс нийтлэг процедурт ямар зохицуулалт, өөрчлөлт оруулах шаардлагатай тухай санал гаргах;
- Хэрэв хохирогч хүсвэл мөрдөн байцаалтын үеэр хамт байлцах;
- Шүүх хурал болох байр байшингийн орчин нөхцөлд хохирогчийн дасгахын тулд шүүх хурлын байранд болох аливаа албан уузалтад түүнтэй хамт очих;
- Шүүх хурлын хүрээнд ямар процедурууд явагдах тухай хохирогчид тайлбарлан өгч, эдгээр процедурын талаарх түүнд төрж болох сэтгэл зовнилыг тайлахад туслах;
- Шүүх үйл ажиллагааны явцад хохирогч өөрөө хүсэх юм бол түүнийг тайвшруулах, дэмжлэг үзүүлэхийн тулд хохирогчтой хамт байх;
- Шаардлагатай бол хохирогчийн зөвшөөрлийг авсны үндсэн дээр мэдүүлэг өгөх процедурт зохицуулалт, өөрчлөлт оруулах тухай хүсэлт тавих. Үүнд, жишээлбэл, хуралдааныг шүүхийн байрнаас дарамт арай багатай орчин руу (тухайлбал, шүүгчийн ажлын өрөө рүү) шилжүүлэх, хохирогчийн хөгжлийн бэрхшээлийн мөн чанар, мэдүүлэгт үзүүлж болох нөлөөг шүүхийн ажилтнуудад тайлбарлаж өгч чадах мэргэжлийн хүнийг авчрах зэрэг байж болно.<sup>1</sup>

1 Израилийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүний эрхийн төв: <http://www.bizchut.org.il/eng>



ХҮНИЙ ЭРХИЙН ЭРХЗҮЙД ШҮҮХ АЖИЛЛАГААНД ХҮРТЭЭМЖТЭЙ ОРОЛЦОХ ЭРХИЙН ТАЛААР ЮУ ГЭЖ ЗААСАН БАЙДАГ ВЭ?

Хүртээмжтэй шүүх ажиллагаанд оролцох эрх нь шүүхийн өмнө эрх тэгш байх, хуулиар тэгш хамгаалуулах, шүүх хурлын явцад тэгш харьцах зэрэг эрхийг баталгаажуулсан олон улсын хуулийн заалтуудаас үндэстэй. Эдгээр эрхийг **Хүний эрхийн түгээмэл тунхаглалын (ХЭТТ)<sup>2</sup> 6-11 дүгээр зүйлд дурьдсаны зэрэгцээ Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын (ИУТЭОУП)<sup>3</sup> 14-ээс 16 дугаар зүйлүүдэд илүү дэлгэрэнгүй авч үзжээ.**

Олон улсын бусад хууль, гэрээнд тодорхой бүлэг хүмүүсийн бусадтай адил тэгш үндсэн дээр эдгээр эрхийг эдлэх асуудлыг авч үзсэн байдаг. **Арьсны өнгөөр алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенци (АӨАБХУК)<sup>4</sup>, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенци (ЭАБХУК)<sup>5</sup>** нь давхар ялгаварлан гадуурхалд өртөх магадлалтай хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй үндэстний цөөнх зэрэг хүмүүст онцгой хамааралтай. Жишээлбэл, АӨАБХУК-ийн 5.а-д Оролцогч улсууд нь “арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгаж” хүн бүрт “шүүхийн ажиллагааг зохион байгуулдаг трибунал болон бусад байгууллагын өмнө эрх тэгш байх эрх”-ийг хангах үүрэгтэй гэж заажээ. ЭАБХУК-ийн 15 дугаар зүйл нь дээрх эрхийг эмэгтэйчүүдэд хамааруулах авч үзсэн бөгөөд “шүүх, трибуналын бүхий л үе шатанд” эмэгтэйчүүдэд адил тэгш хандахыг Оролцогч улсуудаас шаарджээ.

1993 онд батлагдсан **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боломжийг тэгшитгэх тухай НҮБ-ын стандарт дүрмүүдэд (Стандарт дүрэм)** шүүх ажиллагаанд хүртээмжтэй оролцох асуудлыг тусгайлан авч үзээгүй ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн шүүх үйл ажиллагаанд оролцох эрхээ эдлэх боломжид нөлөөлж болох асуудлуудыг хөндсөн байна. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн амьдралд оролцох эрх, хэрэгцээ, нийгмийн амьдралд тэдний оруулах хувь нэмрийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх (Дүрэм №1);
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бие даасан байдал, эрхээ эдлэх боломжийг дэмжсэн үйлчилгээ үзүүлэх (Дүрэм №4);
- Дэд бүтцийн, мэдээллийн болон харилцааны хүртээмжтэй байдлыг хангах (Дүрэм №5);
- Боловсрол олгох (Дүрэм №6);
- Боловсон хүчинд сургалт явуулах (Дүрэм №19)<sup>6</sup> зэрэг багтана.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци (ХБХЭК) нь өмнөх хүний эрхийн бичиг баримтуудад туссан асуудлуудыг улам дэлгэрүүлэн авч үзээд, шүүх үйл ажиллагаанд оролцох эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалахын тулд Оролцогч улсууд юу

2 <http://www.un/org/overview/rights.html> сайтаас үз.

3 [http://www.unhchr.ch/html/menu3/b/a\\_opt.htm](http://www.unhchr.ch/html/menu3/b/a_opt.htm) сайтаас үз.

4 <http://www.unhchr.ch/html/menu3/b/9.htm> сайтаас үз.

5 <http://www.unhchr.ch/html/menu3/b/e1cedaw.htm> сайтаас үз.

6 <http://www.unhchr.org/esa/socdev/enable/dissre00.htm> сайтаас үз.

хийхийг тодруулж өгчээ. ХБХЭК-ийн 13 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дараах эрхийг баталгаажуулжээ:

- шүүх ажиллагаанд бусадтай адил тэгш үндсэн дээр оролцох;
- шүүх ажиллагааны бүх үе шат, үүний дотор анхны байцаалт зэрэг шүүхийн урьдчилсан үе шатуудад үр дүнтэй оролцох;
- гэрчээр оролцохыг багтаан шууд ба шууд бус оролцогч байх;
- шүүх ажиллагаанд хүртээмжтэй оролцоход шаардлагатай процедурын болон насны онцлогт тохирсон зохицуулалт хийлгэх зэрэг болно.

Цаашилбал, шүүх үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үр дүнтэй оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Оролцогч улсууд нь шүүхийн ажилтнууддаа сургалт явуулж байхыг 13 дугаар зүйлд зөвлөжээ.

Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн шүүх ажиллагаанд хүртээмжтэй оролцох эрхийг *хүндэтгэн* хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн энэ эрхээ эдлэх, хэрэгжүүлэхэд нь төрийн албан хаагч (жишээлбэл, цагдаа, шүүгч, арбитрч, шоронгийн ажилтнууд) зэрэг төрийн этгээдүүд саад болохгүй байх нөхцлийг бүрдүүлэх үүрэгтэй. Мөн Оролцогч улсууд уг эрхийг *хамгаалан* хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрхээ эдлэхэд нь төрийн бус этгээдүүд (жишээлбэл, хувийн өмгөөлөгч, гэр бүлийн гишүүд гэх мэт) саад болохгүй байхад хяналт тавьж ажиллах үүрэгтэй. Түүнчлэн Оролцогч улсууд хүний эрхийг *хангах* үүргийнхээ хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст энэ эрхээ элдэх боломж олгоход чиглэсэн арга хэмжээ авах үүрэгтэй. Ийм арга хэмжээний нэг жишээ бол 13 дугаар зүйлд зөвлөсөн шүүхийн ажилтнуудад хөгжлийн бэрхшээлийн талаар явуулах сургалт юм.

Олон улсын хүний эрхийн эрхзүйд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн шүүх ажиллагааны бүхий л үе шатанд үр дүнтэй, хувь нэмэртэй оролцох эрхийг зөвхөн хүний эрх гэдэг утгаар нь дэмжээд зогсохгүй, энэ эрхээр дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусад эрхээ илүү бүрэн дүүрэн эдэлж, нийгмийн бүрэн эрхт гишүүний үүрэг хариуцлагаа хүлээж, нийгэмдээ хувь нэмрээ оруулах арга зам гэдэг утгаар нь дэмжиж байгаа билээ.

### **ДАСГАЛ 12.3: ХБХЭК-д шүүх үйл ажиллагаанд хүртээмжтэй оролцох ямар эрхийг баталгаажуулсан байдаг вэ?**

**Зорилт:** ХБХЭК-аар баталгаажсан шүүх үйл ажиллагаанд хүртээмжтэй оролцох эрхийг судлах, ойлгох

**Хугацаа:** 30 минут

**Хэрэглэгдэхүүн:** Цаас, фломастер, эсвэл самбар, шохой

#### **1. Бататгах**

Оролцогсдыг жижиг багуудад хуваа. Багууд 13 дугаар зүйлийг энгийн үг хэллэгээр өөрчлөн найруулж бичээд, дараа нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс энэ эрхийг хэрхэн эдэлж, энэ нь тэдний амьдралыг хэрхэн өөрчилж болохыг харуулсан жишээ гаргана.



## 2. Энгийн үг хэллэгээр өөрчлөн найруулах

13 дугаар зүйлийг чангаар унш. Утгат хэсэг бүрийн дараа түр зогсож, багуудаар энгийн үг хэллэгээр өөрчлөн найруулсан томъёоллыг хэлүүлнэ. Найруулгаа хэлэлцсээр оролцогчид бүгд санал нэгтэй хүлээн зөвшөөрсөн томъёоллыг гаргаж ирнэ. Хэсэг бүрийн эцсийн найруулгыг самбар дээр бич.

## 3. Жишээ гаргах

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс энэхүү эрхээ хэрхэн эдлэх, энэ нь тэдний амьдралд ямар өөрчлөлт гаргах тухай жишээнүүдийг хэлүүл.

## 4. Хэлэлцэх

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах асуудлыг үндэсний хэмжээний бодлогын асуудал болгож тавих, мөн улс төрийн нам, шийдвэр гаргагчдад өргөн барих үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулахад ХБХЭК-ийн 13 дугаар зүйлийг хэрхэн ашиглах вэ?
- Хууль зүйн яам болон шүүхийн байгууллагын удирдлагуудтай яриа хэлэлцүүлэг өрнүүлэхэд энэ зүйл заалтыг хэрхэн ашиглах вэ?

### ДАСГАЛ 12.4: Шүүх үйл ажиллагаанд оролцох эрхийг дэмжих амлалт авах нь

Хүний эрх нь эдлэх эрх, хүлээх үүргийн нэгдэл болохыг онцлон тэмдэглэ.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн шүүх ажиллагаанд хүртээмжтэй оролцох эрхийг судалж, тодорхой ойлголттой болсны эцэст энэ талаар бодит алхам хийхэд оролцогчид бэлэн болсон эсэхийг асуу.
- Мэдээлэл цуглуулах, ажлаа төлөвлөх гээд хийх зүйл их байгаа ч өөрчлөлт хийх чин эрмэлзэл маш чухал гэдгийг тэмдэглэн хэл.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст шүүх үйл ажиллагаанд оролцох эрхээ бүрэн эдлэхэд нь нэмэр болох жижиг ч хамаагүй ямар ажлыг ирэх сард хийхийг хүсэж байгаа, хийх боломжтой байгааг оролцогч бүрээр хэлүүл.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах нөлөөллийн ажил хэрхэн төлөвлөх талаар “Хэсэг 3. Нөлөөлөл! Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа” (хуудас 278) хэсгээс уншина уу.

**Шүүх ажиллагаанд оролцох эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ: Өмнөд Африкийн Тэгш эрхийн шүүх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн шүүх ажиллагаанд оролцох эрхийг дэмжиж байна**

Эстэ Мюллер нь Өмнөд Африкийн хуульч бөгөөд тэргэнцэртэй хүн юм. Шүүх танхим руу ороход түүнд болон хөгжлийн бэрхшээлтэй бусад хүмүүст шат саад болж байсныг тэрээр “Эрх тэгш байдлыг дэмжих, шударга бусаар ялгаварлан гадуурхагдахаас сэргийлэх тухай хууль”-ийг зөрчиж байна гэж үзэн 2000 онд шүүхэд ханджээ. Түүний энэ алхмыг Өмнөд Африкийн Хүний эрхийн комисс дэмжсэн бөгөөд энэ хэрэгт Өмнөд Африкийн Хууль зүйн яам, Олон нийтийн агентлаг хариуцагчаар татагджээ.

Шүүх хурлын танхим тэргэнцэртэй хүнд хүртээмжгүй байсан учраас хатагтай Мюллерийг дамжлан өргөж шүүхийн байранд оруулдаг байв. Нэг удаа түүнийг шүүх танхимд оруулж ирж чадаагүй тул шүүх ажиллагааг хойшлуулж байжээ. “Өмгөөлөгчийг нь шүүхийн танхимд дамжлан оруулж байгаад үйлчлүүлэгч маань эвгүйцдэг байсан. Би ч өөрөө үүнээс ичдэг байсан” гэж тэр хэлжээ.

2004 оны 9 дүгээр сард Өмнөд Африкийн Тэгш эрхийн шүүх энэ хэргийн дагуу шийдвэр гаргажээ. Хариуцагчаар татагдсан төрийн хоёр байгууллага тэргэнцэртэй хүмүүст дэд бүтцийн хүртээмжтэй байдлыг хангаж өгч чадаагүйгээ хүлээн зөвшөөрчээ. Мөн тэдний энэ алдаа нь хатагтай Мюллер болон түүнтэй ижил тусгай хэрэгцээтэй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхсан хэрэг болсныг тэд хүлээн зөвшөөрч, уучлал хүссэн байна. Хариуцагчид нь гурван жилийн дотор улс орон даяар байгаа шүүх байгууллагуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгохоо амлажээ. Барилга болгоны наад зах нь нэг шүүхийн танхим, нэг бие засах газрыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулан засахаар болсон байна. Ажлын төлөвлөгөөнд арга хэмжээ болгоныг хийж дуусгах хоног хугацааг тодорхой зааж, дээрх хоёр байгууллага ажлынхаа явцыг Тэгш эрхийн шүүхэд тайлагнаж байхаар болжээ. Энэ хооронд шүүхийн байранд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нэвтрүүлэх түр арга хэмжээ авч байв. Жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй түр шүүхийн байр барих, шүүгч, өмгөөлөгчид нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс орж болохоор өрөө, танхимд үйл ажиллагаагаа шилжүүлэхээр болжээ<sup>7</sup>.

**ШҮҮХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХҮРТЭЭМЖТЭЙ ОРОЛЦОХ ЭРХИЙН ТУХАЙ НЭМЭЛТ МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ**

- “Нөлөөлөл компани” <http://www.advocacyinc.org/index.cfm>
- “Reach Canada” Канадын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш эрх, шударга ёсны төлөө байгууллага <http://www.reach.ca/>

7 “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш эрхийн шүүхийн ялалт” 2004 оны 2 дугаар сарын 24. Өмнөд Африкийн Хүний Эрхийн Комисс. [http://www.sahrc.org.za/sahrc\\_cms/publish/article\\_150.shtml](http://www.sahrc.org.za/sahrc_cms/publish/article_150.shtml); Дэйв Рейнолдс. “Шүүхийн бүх байрыг хүртээмжтэй болгох үүргийг Засгийн газар өгч, гүйтцэтгэх хугацааг тогтоолоо.” 2005 оны 9 сарын 15. *Inclusion Daily Express*. <http://www.inclusiondaily.com/archives/04/09/15/091504sacourtaccess.htm>

## БҮЛЭГ 13: СУРЧ БОЛОВСРОХ ЭРХ

### НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци

#### 24 дүгээр зүйл: Боловсрол

1. Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хүлээн зөвшөөрнө. Энэхүү эрхийг ямар нэг алагчлалгүй, тэгш боломжийн үндсэн дээр эдлүүлэх үүднээс оролцогч улсууд нь дараах зорилгод чиглэсэн бүх түвшний болон насан туршийн сургалтын боловсролын тогтолцоог бий болгоно:
  - а) хүний чадвар, нандин чанарын мэдрэмж болон өөрийгөө үнэлэх үнэлэмжийг бүрэн дүүрэн хөгжүүлж, хүний эрх, үндсэн эрх чөлөө болон хүний ялгаатай байдлыг хүндэтгэх явдлыг бэхжүүлэх;
  - б) хөгжлийн бэрхшээлтэй хүний хувийн шинж чанар, авъяас чадвар, бүтээлч чанар болон тэдний оюуны болон бие махбодын чадварыг байж болох хамгийн бүрэн дүүрэн хэмжээгээр хөгжүүлэх;
  - в) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг чөлөөт нийгэмд үр дүнтэйгээр оролцох боломжийг олгох.
2. Эдгээр эрхийг хэрэгжүүлэх үүднээс оролцогч улсууд нь дараах зүйлээр хангана:
  - а) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь хөгжлийн бэрхшээлийн улмаас ерөнхий боловсролын тогтолцооны гадна, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд хөгжлийн бэрхшээлийн улмаас үнэ төлбөргүй, заавал эзэмших ёстой бага боловсрол болон дунд боловсрол олгох үйл ажиллагааны гадна үлдэхгүй;
  - б) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь өөрсдийн амьдарч буй орчиндоо бусадтай адил тэгш байх үндсэн дээр тусгай, үнэ төлбөргүй, чанартай, бага боловсрол болон дунд боловсролыг эзэмших боломжтой байх;
  - в) хувь хүний онцлог шаардлагад нийцсэн боломжит хэрэглэгдэхүүнээр хангагдах;
  - д) ерөнхий боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь өөрсдийн үр дүнтэйгээр сурч боловсрох нөхцөл байдлыг хангуулах үүднээс шаардлагатай дэмжлэг тусалцаа авах;
  - е) түүнчлэн, мэдлэг олгох болон нийгмийн хөгжилд аль болох дэмжлэг үзүүлснээр хувь хүнд зориулж авах арга хэмжээг үр дүнтэй байлгаж, бүрэн дүүрэн оролцуулах зорилтыг хангах
3. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмийн гишүүний хувьд боловсролд бүрэн дүүрэн, тэгш оролцоход нь дэмжлэг үзүүлэх амьдралын болон нийгмийн хөгжлийн ур чадваруудыг эзэмших боломжийг олгоно. Үүний тулд оролцогч улсууд нь дараах зүйлийг оролцуулан шаардлагатай бусад арга хэмжээ авна:
  - а) брайль үсэг болон түүнтэй төстэй өөр үсэг, нэмэлт болон сонголтот арга, төрөл хэлбэр, харилцаанд хэрэглэх бусад хэв маяг, түүнчлэн орон зайн чигийг баримжаалах болон хөдөлгөөн дэмжих ур чадвар эзэмшүүлэх, үе тэнгийнхэн болон сургагч нараас үзүүлэх тусалцаанд дэмжлэг үзүүлэх;



- b) дохионы хэл сургахад туслалцаа үзүүлэх болон дүлий хүмүүсийн хоорондын хэл ярианы өвөрмөц онцлогийг хөхиүлэн дэмжих;
- c) мэдлэг олгох болон нийгмийн хөгжилд аль болох дэмжлэг үзүүлснээр хүмүүс, ялангуяа хараагүй, дүлий, хараагүй-дүлий хүүхдүүдэд олгох боловсролыг тухайн хүний онцлогт нийцсэн хамгийн зохистой хэл яриа, арга хэлбэр, харилцаанд хэрэглэх бусад хэв маягаар олгох явдлыг хангах.

4. Эдгээр эрхийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор оролцогч улсууд нь багш нар, ялангуяа брайль үсэг эсхүл дохионы хэл эзэмшсэн хөгжлийн бэрхшээлтэй багш нарыг ажиллуулах талаар зохих арга хэмжээ авч, боловсролын бүх түвшинд ажилладаг ажилтан, мэргэжилтнүүдийг сургах зохистой арга хэмжээ авна. Ийм сургалт нь хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх болон зохистой нэмэлт болон сонголтот арга зам, төрөл хэлбэр, харилцаанд хэрэглэх бусад хэв маяг, хөгжлийн бэрхшээлтэй хүнд туслах боловсролын заах арга зүй, сургалтын материал хэрэглэх явдлыг хамарвал зохино.
5. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бусадтай адил тэгш, үл алагчлах үндсэн дээр дээд боловсрол эзэмших, мэргэжлийн сургалтад хамрагдах, насанд хүрэгсдийн болон насан туршийн сургалтад хамрагдах явдлыг хангана. Эл зорилгоор оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг боломжит хэрэглэгдэхүүнээр хангах явдлыг баталгаажуулна.

## ЗОРИЛТУУД

Энэ бүлгийн сэдэв, үндсэн мэдээлэл, дасгалууд нь оролцогчдод дараах зорилтыг хангахад туслах зорилготой:

- Сурч боловсрох эрхийг тодорхойлох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст боловсрол ямар чухал болохыг тайлбарлах;
- Сурч боловсрох эрх, хүний бусад эрхийн хоорондын уялдааг ойлгох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сурч боловсрох эрх хэрхэн хангагдаж эсвэл зөрчигдөж байгааг мэддэг болох;
- **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн (ХБХЭК)** сурч боловсрохтой холбоотой заалтуудыг ойлгох
- Боловсролд тэгш хамруулах зарчим болон тусгай боловсролын янз бүрийн үзэл баримтлалын талаар ойлголттой болох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсролд оролцох эрхийг дэмжих стратегиудыг судлах.

## ЭХЛЭЛ: БОЛОВСРОЛЫН ТАЛААР ЭРГЭЦҮҮЛЭХ НЬ

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сурч боловсрох эрх олонтаа зөрчигддөг. Олон улсын байгууллагуудын хамгийн наад захын тооцоогоор хөгжиж буй орнуудад хөгжлийн





бэрхшээлтэй хүүхдүүдийн 90 хувь нь сургуульд явахгүй байна.<sup>1</sup> Сургуульд явдаг хүүхдүүдэд ч хүндрэл бэрхшээл багагүй тулгардаг бөгөөд тухайлбал, сургуулийн барилга байгууламж хүртээмж муутай, багш нарын бэлтгэл сул, хөгжлийн бэрхшээлтэй хүн сурах чадваргүй, шаардлагагүй гэсэн хандлага зэргийг нэрлэж болно. Хүн бүр, үүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс насан туршдаа сурч боловсрох эрхтэй бөгөөд энэ эрхээ эдлэх боломжоор хангагдсан байх ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оюун санааны болон бие бялдрын чадваруудаа дээд зэргээр хөгжүүлэх насан туршийн чанартай боловсрол эзэмших боломжоор хангах, үүнд шаардлагатай бүхий л төрлийн дэмжлэгийг үзүүлэх нь Улс орнуудын хуулиар хүлээсэн үүрэг юм. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусад хүмүүстэй адил тэгш боловсролд (ерөнхий боловсролд) хамрагдах боломжоор хангагдсан байх ёстой гэсэн үг юм.

### Боловсрол эзэмшихэд тулгардаг саад тотгорууд

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сурах чадвар, сургалтын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох чадварын талаарх багш, сургуулийн удирдлага, гэр бүлийн гишүүд болон бусад хүүхдүүдийн дунд сөрөг ойлголт, хандлага тогтсон байдаг.
- Сургууль, цэцэрлэгт хүргэж өгөх хүртээмжтэй тээврийн хэрэгсэл байдаггүй.
- Боловсролын байгууллагад орох замыг хаасан биет саад олон байдаг. Жишээлбэл, тэргэнцрийн зам хийгээгүй, ажлын байрны орчин нөхцөл нь хүртээмжийн хэрэгцээ шаардлагыг харгалзаагүй.
- Брайль үсэг, дохионы хэл, аман мэдээллийн дүрсэн хөрвүүлэг зэрэг хүртээмжтэй хэлбэр, форматад оруулсан мэдээлэл дутагдалтай.
- Багш бэлтгэх хөтөлбөр байхгүйгээс мэргэшсэн багш, туслах ажилтан дутагдалтай.

**Хүүхдийн эрхийн конвенцид** (ХЭК)<sup>2</sup> боловсролын зорилго бол нийгэмдээ хувь нэмрээ оруулдаг идэвхтэй гишүүн болж төлөвшихөд шаардлагатай чадавхи, ур чадварыг хүүхэд бүрт эзэмшүүлэх явдал хэмээн тодорхойлжээ. Энэ зорилгодоо хүрэхийн тулд хүүхэд бүр бага боловсролыг үнэ төлбөргүй эзэмшиж, дунд болон насан туршийн боловсрол эзэмших боломжоор хангагдсан байх ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зөвхөн сургуульд сурах боломж олгох нь хангалтгүй юм. Сурах үйл ажиллагаа жинхэнэ утгаараа үр дүнтэй байхын тулд сургалтын хөтөлбөрийн агуулга нь өөрөө хүртээмжтэй байх ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сургалтын хөтөлбөрийг эзэмших, үр дүнтэй харилцах, нийгэмд бие даан амьдрахад шаардлагатай амьдрах ухааны чадваруудаа хөгжүүлэхэд нь тус болох үйлчилгээнүүдийг ашиглахын тулд **боломжит тохируулгаар** хангагдсан байх ёстой.

1 “Тэгш хамруулахын төлөө: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсрол.” 2005 оны 7 сар. Дэлхийн Банкны Институт: Хөгжил

<http://www1.worldbank.org/devoutreach/july05/textonly.asp?id=322>

2 <http://www.unhcr.ch/html/menu3/b/k2csrc.htm> сайтаас үз.

## Мэргэжлийн багшаар хангагдах эрх

Чанартай боловсрол эзэмших эрхийг хэрэгжүүлэхийн тулд Улс орнууд мэргэжлийн багш нараар хангах, тэднийг сургаж бэлтгэх үүрэгтэй. Багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сургах үр дүнтэй аргуудыг мэддэг байх ёстой бөгөөд үүнд:

- Харилцааны янз бүрийн аргууд (жишээлбэл: Брайль үсэг, дохионы хэл, нэмэлт болон хувилбарт харилцааны хэрэгслүүд)
- Нийгэм-сэтгэцийн, оюуны, харааны, сонсголын, хавсарсан зэрэг төрөл бүрийн хөгжлийн бэрхшээлээс үүдэлтэй хэрэгцээнд нийцсэн ганцаарчилсан сургалт
- Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, эерэг хандлагыг бусад суралцагч, багш, гэр бүлийнхэн, сургуулийн удирдлагынхны дунд түгээн дэлгэрүүлэх чадвар

Сурч боловсрох эрх нь хүний бусад эрхтэй холбоотой бөгөөд бусад эрхээ эдлэх суурь болдог. Боловсролоор дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрхээ хамгаалах, нийгэмдээ хувь нэмрээ оруулдаг хариуцлагатай иргэн болоход шаардлагатай ур чадваруудыг олж авдаг. Хэдийгээр “нийгэмд хувь нэмрээ оруулдаг иргэн” гэдгийг соёлын болон гэр бүлийн үнэт зүйлс, хувь хүний сонголтоос хамааран янз бүрээр ойлгож болох ч энэхүү зарчмыг хамгийн ерөнхий бөгөөд өргөн утгаар нь **бие даан амьдрах**, нийгэмдээ тэгш хамрагдах, ашигтай хөдөлмөр эрхлэх, улс төр, олон нийтийн амьдралд оролцох, орон байр, гэр бүлтэй байх, шүүх үйл ажиллагаанд үр дүнтэй оролцох зэрэг хүний үндсэн эрхээ эдлэх чадвартай байх хэмээн тодорхойлж болох юм.

ХБХЭК нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн чадавхи, ур чадваруудыг хөгжүүлэх чанартай сайн боловсролын үйлчилгээг хүртээмжтэй хүргэх шаардлага тавьдаг. Боловсролын зорилтыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд нийгэм, үүний дотор багш, боловсролын удирдах ажилтан, эцэг эх, бусад суралцагчид нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэдлэг, ур чадвараа ашиглан нийгэмдээ биеэ даан өөрийн хүссэнээр амьдрах эрхийг хүндэтгэж, боломжуудыг хангаж өгөх ёстой.

### ДАСГАЛ 13.1: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид сурч боловсрох ямар эрх туссан байдаг вэ?

<b>Зорилт:</b>	ХБХЭК-д заасан сурч боловсрох эрхийг судалж, ойлгох
<b>Хугацаа:</b>	30 минут
<b>Хэрэглэгдэхүүн:</b>	- ХБХЭК-ийн 24 дүгээр зүйлийг хувилж бэлдэх - Том цаас, фломастер эсвэл самбар, шохой

#### 1. Бататгах

Оролцогчдыг жижиг багуудад хуваана. Баг бүрт 24 дүгээр зүйлийн нэг хувийг өгөөд, энгийн үг хэллэгээр өөрчлөн найруулах даалгавар өг. Энэ Зүйл нь нэлээд урт тул баг болгонд тодорхой нэг хэсгийг оноож өгч болно.



## 2. Энгийн үг хэллэгээр өөрчлөн найруулах

24 дүгээр зүйлийг чангаар уншиж өг. Утгат хэсэг, таслал бүрийн дараа түр зогсож, энэ хэсгийг өөрчилсөн найруулгыг баг болгоноор хэлүүлнэ. Оролцогчид санал нэгтэй хүлээн зөвшөөрсөн хувилбар гартал тухайн хэсгийг хэлэлц.

## 3. Жишээ гаргах

Амьдралдаа тохиолдсон явдлуудаас санаа аван энэ эрхийг хэрхэн хэрэгжүүлж хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралыг өөрчилж болох тухай жишээнүүдийг оролцогчдоор гаргуул.

## 4. Хэлэлцэх

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах асуудлыг үндэсний хэмжээний бодлогын асуудал болгож тавих, мөн улс төрийн нам, шийдвэр гаргагчдад өргөн барих үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулахад ХБХЭК-ийн 24 дүгээр зүйлийг хэрхэн ашиглах вэ?

ХҮНИЙ ЭРХИЙН ЭРХЗҮЙД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ЮУ ГЭЖ ЗААСАН БАЙДАГ ВЭ?

Олон улсын эрхзүйн баримтуудад хүний сурч боловсрох эрхийн үндсэн асуудлууд туссан байдаг. **Хүний эрхийн түгээмэл тунхаглалын (ХЭТТ) 26** дугаар зүйл, **Хүүхдийн эрхийн конвенцийн (ХЭК) 28, 29** дүгээр зүйл, 1993 онд батлагдсан **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боломжийг тэгшитгэх тухай НҮБ-ын стандарт дүрмүүдийн** (Стандарт дүрэм) 6 дугаар дүрэмд сурч боловсрох эрхийн тухай өгүүлжээ.

Олон улсын эдгээр гэрээнд хүн бүр хүртээмжтэй боловсролд тэгш хамрагдах эрхтэй болохыг тунхаглажээ. ХЭК-ийн 28 дугаар зүйлд ерөнхий болон мэргэжлийн боловсролыг хөгжүүлэх, мөн боловсролын асуудлаар зөвлөгөө өгөх үйлчилгээг хүүхэд бүрт нээлттэй, хүртээмжтэй байлгах ёстой гэж онцлон заажээ. Түүнчлэн хичээлээ таслахгүй байхад дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авч, сахилга батын асуудлыг хүүхдийн нэр төрд халдахгүй арга хэлбэрээр шийдвэрлэж байхыг шаардсан байна. ХЭК-ийн 29 дүгээр зүйлд хүүхдийн боловсрол нь хүүхдийн зан чанар, авъяас, оюун ухаан болон бие бялдрын чадваруудыг бүрэн хөгжүүлэхэд чиглэгдэх ёстой гэжээ.

Стандарт дүрмүүдийн 6 дугаар дүрэмд (Боловсрол)<sup>3</sup> хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш хамруулах орчинд боловсрол олгох нь ерөнхий боловсролын удирдах ажилтнуудын анхаарах асуудал болохыг заагаад, үндэсний хэмжээнд боловсрол, сургалтын хөтөлбөр, сургуулийн бүтцийн холбогдолтой асуудлуудаар төлөвлөлт хийхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг харгалзаж байхыг шаарджээ. Мөн 6 дугаар Дүрэмд боловсролын үйл явцад эцэг эх, байгууллагуудын идэвхтэй оролцоог дэмжих тухай заагаад, хөгжлийн бэрхшээлтэй балчир хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрэгсэд, эмэгтэйчүүд, үндэсний цөөнх зэрэг давхар ялгаварлалд өртөх магадлалтай хүн амын бүлгүүдэд түлхүү анхаарахыг зөвлөжээ. 6 дугаар Дүрэмд тэгш хамруулах орчин бүрдүүлсэн жирийн сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг суралцуулах асуудлыг боловсролын хуульд тусгасан байх, энэ Дүрмийн заалтуудыг сургууль, орон нутгийн түвшинд хэрэгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх шаардлага тусжээ.

3 <http://www.un.org/esa/socdev/enable/dissre00.htm> сайтаас үз.

Мөн хэрэгцээнээс хамааран өөрчлөлт, нэмэлт оруулж болохуйц чанартай сайн сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, багш бэлтгэх ажлыг тасралтгүй зохион байгуулахад анхаархыг зөвлөсөн байна. Хамгийн гол нь, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст боловсрол олгох хамгийн үр ашигтай арга зам нь тэгш хамруулах зарчимд суурилсан боловсрол, олон нийтийн оролцоонд түшиглэсэн хөтөлбөрүүд болохыг Стандарт дүрмүүдэд онцлон тэмдэглэжээ.

ХБХЭК нь өмнөх үеийн хүний эрхийн баримт бичгүүдэд туссан сурч боловсрох эрхтэй холбоотой асуудлуудыг дэлгэрүүлэн авч үзээд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс мэргэжлийн багш, боломжит тохируулгаар хангагдах, **интеграцчилсан боловсролоос** гадна **тэгш хамруулах зарчимд суурилсан боловсролд** (дараах хайрцагт өгсөн мэдээллийг үзнэ үү) хамрагдах эрхтэй болохыг онцолжээ. ХБХЭК-ийн “Боловсрол” нэртэй 24 дүгээр зүйлд бүрэн хамрагдалтын үзэл баримтлал, түүнийг хэрэгжүүлэх тохиромжтой арга хэрэгслүүдийг тайлбарлахыг зорьсон байна. Мөн энэ зүйлд суралцагсдын өөр хоорондоо ялгаатай хэрэгцээнд нийцсэн боломжит тохируулга бүхий чанартай сургалт явуулах үр чадвартай мэргэжлийн сайн багш нарын хүчээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ерөнхий боловсролын тогтолцоогоор сургах ёстой гэж үзжээ. Боловсролын асуудлыг тусгайлан авч үзсэн энэ зүйл нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгэмдээ хувь нэмрээ оруулдаг идэвхтэй, үр бүтээлтэй иргэн болох боломжийг дэмжсэн насан туршийн сурч боловсрох тэгш эрхийг баталгаажуулах зорилго агуулжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үр бүтээлтэй, өгөөжтэй насан туршийн боловсролд хамрагдах эрхийг олон улсын эрхзүйд тууштай дэмждэг бөгөөд эрхийг зөвхөн хүний эрх гэдэг үүднээс дэмжээд зогсохгүй, энэ эрхээр дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусад эрхээ илүү бүрэн дүүрэн эдэлж, нийгмийн бүрэн эрхт гишүүнийн үүрэг хариуцлагаа бүрэн хүлээж, нийгэмдээ хувь нэмрээ оруулах арга зам гэж үзэж байгаа юм.

### **Боловсрол бодит амьдрал дээр: Шударсон Субедигийн түүх**

Шударсон Субеди бол хөгжлийн бэрхшээлтэй хүн. Тэрээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэхэд засгийн газартаа шахалт үзүүлэх зорилгоор 2000 онд Балбын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн төв (ХБХЭТ-Балба) нэртэй байгууллага байгуулжээ. Түүний үйл хэрэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг боловсролд тэгш хамруулах, эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэй болгох, хөдөлмөр эрхлэх шударга, тэгш боломжтой байх зэрэг чиглэлээр хүний эрхийг хамгаалах тэмцэлд үлгэр дуурайлал болдог. Тэрээр *хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үнэ төлбөргүй тэгш боловсрол олох эрхийг баталгаажуулахын* төлөө Балбын Дээд шүүх хүртэл тэмцсэн нь түүний байгуулсан томоохон ялалтуудын нэг юм. Хөгжлийн бэрхшээлтэй бүх хүн түүний энэхүү ялалтын үр өгөөжийг хүртэж уг эрхээ эдлээсэй гэсэн сэдлээр Шударсон энэ ялалтаа хэвлэл мэдээллээр дамжуулан олны сонорт хүргэхэд маш их анхаарсан юм. Дээд шүүхийн шийдвэр гарснаар өмнө нь сургуульд элсэж чадахгүй байсан Балбын 2000 гаруй хөгжлийн бэрхшээлтэй оюутан үнэ төлбөргүй боловсрол эзэмшжээ. Тэрээр Боловсролын яаманд захидал илгээснийг яам нь дүүрэг, тойргийн боловсролын асуудал хариуцсан түшмэдэд хүргүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сургуульд элсүүлэхээс татгалзах явдал гаргахгүй байх заавар өгчээ.

Мэдээлэл түгээх нь хүний эрхийг хамгаалах тэмцлийн шилдэг арга болохыг Шударсон ойлгосон юм. Хөгжлийн бэрхшээлтэй маш олон хүн хөгжлийн бэрхшээлээсээ үл хамааран сурч боловсрох, хөдөлмөр эрхлэх хуулиар хамгаалагдсан тэгш эрхтэй гэдгээ мэддэггүй. Мөн олон тооны төрийн албан хаагч, ажил олгогч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст энэ эрхээ эдлэх боломжийг хангах үүргийг хуулиар хүлээж байгаагаа мэддэггүй. 2002 онд Шударсоны санаачилгаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлуудаар хөгжлийн бэрхшээлтэй сурвалжлагчид долоо хоног тутмыг радио нэвтрүүлэг явуулж эхэлсэн. Тэрээр сонсогчдод хандаж хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хэрэгжилтэд хяналт тавих “Радио сонсогчдын клубууд” байгуулж ажиллахыг уриалжээ. Одоо Балба даяар радио сонсогчдын өөрсдийн үүсгэн байгуулсан 170 гаруй ийм клуб ажиллаж байна. Шударсон мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, тэдэнд тохиолдож буй асуудлуудыг хөндсөн “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дуу хоолой” нэртэй сар тутмын сэтгүүл гаргаж байгаа.

Шударсон нь янз бүрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах орон нутгийн сүлжээ, өөртөө туслах бүлгүүдийг дэмжин ажилладаг бөгөөд эдгээр нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийнхнийг жирийн хүмүүс, иргэдтэй зэрэгцэн амьдрахад нь тусалдаг ажээ. Түүний байгуулсан “Эрхэд суурилсан нөлөөллийн сүлжээ: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн төлөөх форум” хэмээх байгууллагад нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг үндэсний болон орон нутгийн 60 гаруй байгууллага нэгдэн ажиллаж байна.

Тэрээр мөн сэтгүүл зүй, хууль эрхзүйн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг. Мэдээлэл сургалтын төв байгуулжээ. Энэ төв нь эрхээ эдлэхийг хүсэж буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст шаардлагатай нөөц боломжуудыг хангаж өгдөг. ХБХЭТ-Балба байгууллага нь эрхзүйн тусалцааны гарын авлага, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан хууль, бодлогуудын эмхэтгэл хэвлэх, мэргэжлийн хуульчдын тусламжтайгаар хөгжлийн бэрхшээл болон иргэний эрхзүйн нарийн асуудлаар үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх зэрэг үйлчилгээ үзүүлж байна.<sup>4</sup>

## ДАСГАЛ 13.2: Боловсролын талаарх ойлголт

- Зорилт:** Боловсролын үйлчилгээтэй холбоотой өөрсдөдөө тохиолдсон бодит явдлуудыг бусадтай хуваалцан, энэ үйлчилгээ ямар байх ёстой талаарх зөвлөмж, саналуудыг үнэлэх
- Хугацаа:** 45 минут
- Хэрэглэгдэхүүн:** Том цаас, фломастер эсвэл самбар, шохой

### 1. Танилцуулах

Энэ дасгал нь оролцогчдод тохиолдсон боловсролын үйлчилгээтэй холбоотой бодит явдлуудыг эргэн санаж, тэдгээрт дүн шинжилгээ хийх боломжийг олгож байгааг тайлбарла. Оролцогчдод “тэгш хамруулах сургалт”, “интеграцчилсан сургалт”, “тусгай боловсрол” гэсэн нэр томъёонуудыг сануулаад (доор өгсөн “Тэгш хамруулан сургах ба интеграцчилсан боловсрол” нэртэй тайлбарыг үзнэ үү), өөрсдийнхөө эзэмшсэн боловсролын тухай ярихдаа эдгээр нэр томъёог ашиглахыг хүс.

4 Эх сурвалж: <http://www.ashoka.org/node/3651>

Оролцогчдыг 2-3 багт хуваагаад дараах асуултуудыг хэлэлц:

- Таны сурсан сургууль тэгш хамруулах сургалт, интеграцчилсан сургалт, тусгай боловсролын орчны алинд нь хамаарах вэ?
- Сургуульд сурч байх үеийн хамгийн тааламжтай тохиолдлыг сана. Үүнийг юу ийм сайхан дурсамж болгож байна вэ?
- Сургуульд сурч байх үеийн хамгийн тааламжгүй үе/тохиолдлыг ярина уу. Яагаад энэ нь ийм таагүй дурсамж/ тохиолдол болсон бэ?
- Танд тохиолдсон энэхүү тааламжгүй үе/тохиолдол нь таны сурч боловсрох эрхийг зөрчсөн үү?

Сургагч багшид: Тодорхойлолт, асуултууд нь нэлээд ярвигтай тул дараах хайрцагт өгсөн мэдээлэл, дээрх асуултуудыг баг бүрт хувиран өгч болно.

## **2. Илтгэх**

Баг бүрээс илтгэгч томилж, багийн ажлаа тоймлон танилцуулахыг хүс.

- Оролцогчид нь ямар орчинд (өөрөөр хэлбэл, тэгш хамруулах, интеграцчилсан, тусгай) боловсрол эзэмшсэн бэ?
- Сургуульд байх үеийнх нь тааламжтай болон тааламжгүй үе/тохиолдлуудыг үүсэхэд ямар хүчин зүйлс нөлөөлсөн бэ? Эдгээрийг жагсааж бич.

## **3. Жагсаалт гаргах**

Багуудын гишүүн нэг бүрээс сурч байсан сургууль нь ямар төрлийн боломжит тохируулгуудыг хангасан байсан, мөн сурах боломжийг нь нэмэгдүүлэх өөр ямар төрлийн боломжит тохируулга байж болох байсныг (жишээлбэл, Брайль үсгээр хэвлэсэн мэдээлэл, дүрсээр илэрхийлсэн үзүүлэн зэрэг харилцааны олон төрөл, туслах үйлчилгээ болон эмчилгээ, үе тэнгийн сургагч гэх мэт) жагсаан бичихийг хүс. Жагсаалтаа хоёр багана болгож бичнэ.

## **4. Хэлэлцэх**

- Өнөөгийн боловсролын тогтолцоо нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дэмжиж, тэднийг боломжит тохируулгаар хангаж байна уу? Хангаж өгөх ёстой юу?
- Боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гүйцэтгэж байгаа үүргийн талаар бод. Хэрэв хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээр эдгээр үүрэг ролийг гүйцэтгүүлэхгүй, эсвэл тэднийг боловсролын тогтолцооноос бүрмөсөн шахан гаргавал юу болох бол?
- Боловсрол эзэмшихэд танд тохиолдсон шиг ийм саад, тотгор бусад хүмүүст учрахаас сэргийлэхийн тулд ямар өөрчлөлт, сайжруулалт хийх шаардлагатай байгааг бодож үзнэ үү.





## Тэгш хамруулах болон интеграцчилсан боловсрол

### “Тэгш хамрагдалт” гэж юу вэ?

“Тэгш хамрагдалт” гэсэн нэр томъёо нь хэд хэдэн утгыг илэрхийлж ирэхдээ дийлэнхдээ хөгжлийн бэрхшээлтэй болон боловсролд хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүдийн тухайд хэрэглэгдэж иржээ. Түүхэн үүднээс харахад энэ нэр томъёо нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ердийн сургуульд шилжүүлэх, эсвэл сургуулиас гадуур байгаа бусад хүүхдийн ялгаварлан гадуурхлыг бууруулах утгаар хэрэглэж иржээ.

### Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах нь

“Интеграци” гэсэн нэр томъёо нь 1980-аад оны үед хэрэглэгдэж байсан бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ердийн сургуульд “байршуулж” тогтсон систем, орчинд нийцэж чадаж л байвал сургуульд байлгахыг “зөвшөөрөх” утгыг илэрхийлж байсан боловч хүүхдэд шаардлагатай дэмжлэгүүдийг хангах асуудлыг багтаадаггүй байв. Арьсны өнгөөр ялгаварлахгүй байхтай холбоотой “ассимиляци” гэсэн нэр томъёо дээрхтэй ижил утгатай юм. Харин одоо **хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд хамруулах нь тэднийг энгийн сургуульд авахаас хавьгүй илүү хүчин чармайлт гаргаж, сургуулийн хэмжээнд үйлчилж байгаа бодлого, үйл ажиллагаа, хандлагыг өөрчлөхийг шаардсан асуудал** гэдгийг бид ойлгосон билээ.

*“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг энгийн сургуульд элсүүлж авсан тохиолдолд тухайн хүүхдийн хувь нэмэр, оролцоог хангах үүднээс сургууль өөрөө өөрчлөгдөх ёстой гэсэн хүлээлт бий болох ёстой юм.”*

Жоү Витаккер “Тэгш хамруулах ба интеграцчилсан боловсрол”

Тэгш хамруулах зарчмыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчид нь боловсролын үйл ажиллагаанд бүрэн дүүрэн оролцох ёстой гэдгийг нийтээр хүлээн зөвшөөрөөд байна.

### Бүх хүүхдийг тэгш хамруулах нь

Саяхнаас тэгш хамруулах зарчим бол сургуульд сурч байгаа бүх хүүхдэд хамаатай ойлголт, нэн ялангуяа угаасаа ялгаварлан гадуурхагдаж ирсэн, эсвэл сурлагаар хоцрогдсон бүлгүүдэд илүү анхаарахыг шаардсан ойлголт гэдгийг бид ойлгох болсон юм. Мөн уг зарчим нь бүх эцэг эх, асран хамгаалагч, сургуулийн ажилтан, удирдах албан хаагчийг боловсролын үйл ажиллагаа, шийдвэр гаргалтад татан оруулах арга зам гэсэн утгаар нь ойлгож эхэлжээ.



*“Тэгш хамруулах гэдэг нь бид өөрсдийгөө интеграцчилахыг хэлж байгаа юм. Та бүхэн бидэнд зориулж интергацчилалыг хэрэгжүүлж болох ч энэ үйл явцад бид өөрсдөө бүрэн дүүрэн оролцохгүй юм бол тэгш хамрагдалт гэдэг зүйл хэрэгжихгүй.”*

Тэгш хамруулах боловсролыг дэмжих нийгэмлэг (хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрэгчид болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдийн холбоо)

*“Тэгш хамрагдалт бол боловсрол, оролцоонд саад болж буй бэрхшээл, тогторуудыг тодорхойлж, тэдгээрийг багасган, боловсрол болон оролцоог дэмжсэн нөөцийг аль болох нэмэгдүүлэхийг хэлнэ.”*

Бүүт, Айнскоу нар, 2000

Эх сурвалж: Бристоль хотын Хүүхэд залуучуудад зориулсан үйлчилгээний төв  
<http://www.bristol-cyps.org.uk/services/eit/definitions.html>

## **ДАСГАЛ 13.3: Боловсрол дахь ялгаварлан гадуурхлын шалтгааныг тодорхойлох**

### **1. Санал солилцох**

Чанартай боловсрол эзэмшихэд саад болж буй ялгаварлан гадуурхлын үндэс болж байгаа гол хүчин зүйлсийг тодорхойлон гаргахын оролцогчдоос хүс. Эдгээр хүчин зүйлсийг жагсаалт болгон бич.

- Хүндрэл бэрхшээлийг анзаарсан, эсвэл тэдгээрт өртөж байсан хүмүүсээс мэдээлэл авахыг хичээ.
- Сануулга: Энэ дасгалаар гарсан мэдээлэлд дараа үнэлгээ хийх тул дээрх жагсаалтыг хадгалаарай.

### **2. Шинжлэх**

Оролцогчдыг жижиг багуудад хуваагаад, баг бүрт дээрх жагсаалтаас нэг асуудлыг сонгож дүн шинжилгээ хийх даалгавар өг. Энэ даалгавар нь асуудал/проблемыг шийдвэрлэж болох жижиг хэсгүүдэд задалж харах зорилготой болохыг багуудад тайлбарла. Даалгаврыг тайлбарлаж өгсний дараа “Загасны яс” нэртэй диаграммыг танилцуулж, энэ диаграмм нь аливаа асуудлын бүхий л боломжит шалтгаануудыг салгаж харахад тус болно гэдгийг мөн тайлбарлана. Энэ схемийг хэрхэн ашиглаж болохыг энгийн нэг асуудал/проблемын жишээн дээр харуул.

**Алхам 1:** Асуудлаа тодорхойлох. Танд тулгарсан асуудлын нарийвчилсан тайлбарыг бичнэ.

**Алхам 2:** Энэ асуудалтай холбоотой ямар томоохон хүчин зүйлс илэрч байна вэ? Хүчин зүйл бүрийг загасны нурууны ясаар төлөөлүүлэн зурж нэр өгнө. Эдгээр нь хүмүүс, тогтолцоо, тоног төхөөрөмж, гадны хүчин зүйлс гэх мэт янз бүрийн хүрээг хамарч болно.

**Алхам 3:** Алхам 2-оор тодорхойлсон хүчин зүйл бүрийнхээ боломжит шалтгаануудыг тодорхойл. Эдгээрийг загасны “нурууны яснаас” салбарлан гарсан жижиг “яснууд” болгон



зурна. Том буюу адармаатай шалтгаануудыг улам задалж дэд шалтгаан болгон харуулаад, үүнийгээ жижиг яснаас салбарлуулан зурж болно.

**Алхам 4:** Схемдээ дүн шинжилгээ хий. Тухайн асуудал хэр адармаатай, хэр ач холбогдолтой болохоос хамаарч асуудлыг шийдвэрлэх арга замуудыг олох судалгаа, эсвэл үйл ажиллагаа хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруул.

Нөөц хувилбар: Асуудлаа гарчиг болгон авч, шалтгаануудыг нь дэд гарчиг болгон харуулсан ерөнхий төлөвлөгөө гаргаж болно.

### 3. Илтгэх/хэлэлцэх


Баг бүрээс нэг төлөөлөгч гарч багийнхаа дүн шинжилгээг тоймлон танилцуулна. Багууд гаргасан схемээ оролцогчдод харагдахаар байрлуулна.

### 4. Дүгнэх


Багуудын дүн шинжилгээг ашиглан дараах асуултуудын дагуу ерөнхий дүгнэлт гаргахыг оролцогчдоос хүс:

- Багуудын хийсэн дүн шинжилгээнд нийтлэг зүйл ажиглагдаж байна уу?
- Багууд ижил төстэй шалтгаан, дэд шалтгаануудыг нэрлэсэн үү?
- Өөр өөр асуудлууд дээр эдгээр шалтгаан яагаад ийнхүү олон удаа давтагдаж байна гэж та нар бодож байна вэ?
- Эдгээрээс зарим үндсэн шалтгааныг салган авч, хэрхэн шийдвэрлэж болохыг хэлэлц.

#### “Загасны яс” диаграмм



#### Терранозаврын араг ясны дүн шинжилгээ



### ДАСГАЛ 13.4: Боловсролын төлөө дуу хоолойгоо өргөх нь

- Зорилт:** Боловсролын үйлчилгээн дэх ялгаварлан гадуурхлыг судалж, түүний эсрэг ямар арга хэмжээ авч болохыг хэлэлцэх
- Хугацаа:** 60 минут
- Хэрэглэгдэхүүн:** Том цаас, фломастер эсвэл самбар, шохой

## 1. Танилцуулах

13.2 дасгалд ашигласан чанартай боловсрол эзэмшихэд саад болдог ялгаварлан гадуурхал, саад тотгоруудын жагсаалтыг дахин танилцуул. Өмнөх дасгалаар эдгээр асуудлын шалтгаануудыг судалж байсан бол энэ удаад асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх арга замыг хайх гэж байгааг тайлбарла.

## 2. Төлөвлөх

Оролцогчдыг 3-6 хүнтэй жижиг багууд болгох ба боломжтой бол янз бүрийн чадавхийн түвшинтэй холимог багууд бүрдүүлэхийг хичээ. Асуудал/проблемын жагсаалтаас баг болгон нэг асуудлыг сонгож авсны дараа дараах зааврыг өг:

- Багш, боловсролын удирдах ажилтан, эцэг эхчүүдээс бүрдсэн “Боловсролын зөвлөл” байгуулагдсан байна гэж төсөөлөөд, түүнд зориулж 5 минутын илтгэл тавихаар бэлд.
- Баг бүр нэг илтгэгч, мөн “Боловсролын зөвлөл”-д ажиллах нэг хүнийг сонгоно.
- “Зөвлөлийнхний” өгсөн хариу тайлбар нь танай орон нутгийнхны дунд нийтлэг байдаг санал бодолтой төстэй байна уу?
- Багууд танилцуулгаа бэлтгэж байх хооронд “Боловсролын зөвлөл”-ийн гишүүд хоорондоо уулзаж хүн бүр ямар дүрд тоглохоо тохирно. Эдгээр дүр нь тухайн орон нутгийнхны дунд өргөн дэлгэрсэн эерэг болон сөрөг хандлагуудыг илэрхийлэх ёстой. Дүрүүдийн дотор багш, эцэг эх, удирдах ажилтан, шашны болон орон нутгийн удирдагч, төрийн түшмэл зэргийг оруулж болно.
- Танилцуулгадаа:
  - 1) Тухайн төрлийн ялгаварлан гадуурхлыг тайлбарлаад, энэ нь хэнд нөлөөлж, ямар шалтгаантай байгаа зэргийг тайлбарлана.
  - 2) Тухайн төрлийн ялгаварлал ХБХЭК-д заасан ямар эрхийг хөндөж болохыг тайлбарлана.
  - 3) Тухайн ялгаварлал хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралд яаж нөлөөлж байгааг тайлбарлана.
  - 4) Уг асуудлыг шийдвэрлэснээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдрал хэрхэн сайжруулах тухай тайлбарлана.
  - 5) Асуудлыг шийдвэрлэхийн тулд ямар арга хэмжээ, тодорхой алхам хийж болохыг санал болгоно.

## 3. Дүрд тоглох/Хэлэлцэх

Баг бүрээс нэг хүн “Зөвлөл”-ийн гишүүдэд илтгэл тавина. “Зөвлөлийн” гишүүд нь өөрт оногдсон дүрийн дагуу хариулт өгнө.

## 4. Хэлэлцэх/Дүгнэлт хийх

Танилцуулга бүрийн дараа оролцогчдоос асуулт асуух, бодлоо илэрхийлэх, эсэргүүцэх, эсвэл санал гаргахыг хүс. Доорхтой төстэй асуултуудыг асууж болно:

- Тухайн асуудлыг танилцуулж байхдаа илтгэл тавьсан хүнд ямар сэтгэгдэл төрсөн бэ?
- “Зөвлөл” ямар байдлаар хандсан бэ? Ямар хандлага, саад тотгорууд илэрч гарсан бэ?



- “Зөвлөл”-ийнхний өгсөн хариултууд нь танай орон нутгийнхны дунд тархсан нийтлэг үзэл бодолтой төстэй байна уу?
- Хөндөгдсөн асуудал юмуу проблем нь хүний эрхтэй холбоотой байв уу?
- Эдгээр асуудлыг шийдвэрлэх арга зам нь танай боловсролын тогтолцоонд хэрэгжүүлж болохоор зүйл байна уу? Тийм бол яагаад? Үгүй бол яагаад?
- Бодит амьдрал дээр эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд авч болох дараагийн алхам нь юу байх бэ?

### Суурь боловсролоос чанартай боловсролд

Европын зөвлөлөөс гаргасан *Компасито* хэмээх хүүхдүүдэд зориулсан хүний эрхийн боловсролын гарын авлагад үнэ төлбөргүй суурь боловсролд хамруулах төдий нь боловсрол эзэмших эрхийн баталгаа болж чадахгүй тухай дурьджээ. Өөр нэмэлт гурван шаардлагыг хангах ёстой бөгөөд үүнд:

1. **Тэгш боломж:** Улс орнууд боловсролын тэгш хүртээмжийг баталгаажуулаад зогсохгүй амжилт гаргах тэгш боломжийг хангаж өгөх ёстой. Энэ нь зарим хүүхдүүдэд нэмэлт туслалцаа, тусгай нөхцөл шаардагдана гэсэн үг юм. Жишээлбэл, сонсголгүй хүүхдүүд дохионы хэл, сонсголын аппарат, шаардлагатай үед дохионы хэлний орчуулагч зэрэг боломжит тохируулга авах эрхтэй. Үүнтэй төстэй зохицуулалтуудыг тусгай хэрэгцээтэй бусад хүүхдэд хангаж өгөх шаардлагатай бөгөөд ингэснээр тэд ердийн сургуульд бусад хүүхдийн адил суралцаж ижил амжилт гаргах боломжтой болно. Амжилттай сурах тэгш боломж нь сургалтын бусад олон асуудалд анхаарал хандуулахыг шаарддаг бөгөөд үүний дотор хүүхдийг эх хэлээр нь суралцуулах, гэрийн даалгавар гүйцэтгэхэд шаардлагатай зохицуулалтуудыг хангаж өгөх, номын хүртээмж болон суралцахад нь тохиолдож буй хүндрэлүүдийг давахад туслах бусад туслалцаа дэмжлэгүүд багтана. Төрөлх хэлээрээ суралцах нь зөвхөн амжилттай суралцах нөхцөл болоод зогсохгүй соёлын эрхийг хүндэтгэж буй хэрэг юм. Сурах бэрхшээлтэй хүүхдүүдийг сургуулиас хассанаар асуудал шийдэгдэхгүй. Сурах янз бүрийн арга барилд тохируулан сургалт явуулах чадвартай, мэргэжлийн сайн багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч зэрэг туслах ажилтнуудын хүчийг дайчлах замаар асуудлыг шийдэх хэрэгтэй.
2. **Чанартай боловсрол:** Улс орнууд чанартай боловсрол эзэмших тэгш боломж хангаж өгөх үүрэгтэй. Гэтэл олон газарт элит хэсэгт зориулсан нэг төрлийн сургалт, ядуу хэсэгт зориулсан өөр төрлийн сургалттай хоёр давхаргат боловсролын тогтолцоо оршсоор байна. Тодорхой насны түвшинд хүртэл бүх хүүхдэд нийтлэг хүртээмжтэй, ирээдүйн амьдралд нь хэрэгтэй мэдлэг, чадвар олгох тийм л суурь боловсролын тогтолцоог хангаж өгөх нь зүйтэй.

**3. Хүний зан чанарын бүрэн хөгжлийг хангах боловсрол:** Бүх хүний эзэмших эрхтэй боловсролын хүрээ нь зөвхөн бичиг үсгийн боловсрол, тоо бодох аргаар хязгаарлагдахгүй. ХЭТТ-д боловсрол бол “хүний зан чанарын бүрэн хөгжлийг хангах, хүний эрхийг хүндэтгэх, дэлхийн улс орнуудын дунд ойлголцол, энх тайвныг бий болгоход” чиглэгдэх ёстойг онцлон заасан байдаг. Хүүхдийн эрхийн конвенцид (ХЭК) хүүхэд бүрийн эзэмших эрхтэй боловсрол ямар байх ёстой талаар тодорхой санаанууд багтсан байдаг.

Сурч боловсрох эрх нь мөн хүний эрхийг хангаж хамгаалах боловсрол эзэмших эрх юм.<sup>5</sup>

## ДАСГАЛ 13.5: Амлалт авах нь

- Зорилт:** Хүний эрх нь эдлэх эрх, хүлээх үүргийн нэгдэл гэдгийг онцлоод, энэ талаар гүнзгийрүүлэн судлах
- Хугацаа:** 30 минут
- Хэрэглэгдэхүүн:** Том цаас, фломастер эсвэл самбар, шохой

### 1. Үйл ажиллагаа:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сурч боловсрох эрхийн талаар мэдлэг, ойлголттой болсны эцэст тодорхой нэг ажил хийхэд бэлэн байгаа эсэхийг оролцогчдоос асуу.
- Мэдээлэл цуглуулах, ажлаа төлөвлөх гээд хийх зүйл их байгаа ч өөрчлөлт хийх чин эрмэлзэл маш чухал гэдгийг тэмдэглэн хэл.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст сурч боловсрох эрхээ бүрэн эдлэхэд нь нэмэр болох жижиг ч хамаагүй ямар ажлыг ирэх сард хийхийг хүсэж байгаа, хийх боломжтой байгааг оролцогч бүрээр хэлүүл.
- Хүн бүрийн амлалтыг том цаас юмуу самбар дээр бичээд, сургалтын дараа оролцогчдын амласан үйл ажиллагаануудыг тоймлон бичээд бүх хүнд тарааж өг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах нөлөөллийн ажил хэрхэн төлөвлөх талаар “Хэсэг 3. Нөлөөлөл! Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа” (хуудас 278) хэсгээс уншина уу.

5 Эх сурвалж: Компасито: хүүхдүүдэд зориулсан хүний эрхийн боловсролын гарын авлага (Европын Холбоо, 2007)





## БОЛОВСРОЛЫН ТУХАЙ НЭМЭЛТ МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

Дараах байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст сурч боловсрох эрхээ эдлэхэд нь туслах үйлчилгээ үзүүлдэг. Үүнд:

- **Бристоль хотын Хүүхэд залуучуудад зориулсан үйлчилгээний төв:**  
<http://www.bristol-cyps.org.uk/>
- **CAST Суралцахуйн нийтлэг дизайн:**  
<http://www.cast.org/index.html>
- **Тэгш хамруулах боловсролын судалгааны төв:**  
<http://inclusion.uwe.ac.uk/cise/index.htm>
- **Инклюжн Интернэйшнл:**  
[http://www.inclusion-international.org/en/ii\\_priority\\_areas/ie/index.html](http://www.inclusion-international.org/en/ii_priority_areas/ie/index.html)
- **Тэгш хамруулах боловсрол, ЮНЕСКО:**  
[www.unesco.org/education/inclusive](http://www.unesco.org/education/inclusive)

## БҮЛЭГ 14: СОЁЛ, СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭНД ОРОЛЦОХ ЭРХ

### НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци

#### 30 дугаар зүйл: Соёлын амьдралд оролцох, чөлөөт цаг, амралтаа өнгөрүүлэх, спортоор хичээллэх

1. Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусадтай адил тэгш байх үндсэн дээр соёлын амьдралд оролцох эрхийг хүлээн зөвшөөрөх бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дараах эрхийг хангах зохистой бүхий л арга хэмжээг авна:
  - a) соёлын бүтээлийг хүртээмжтэй хэлбэрээр хүртэх;
  - b) телевизийн хөтөлбөр, кино, театр болон соёлын бусад арга хэмжээг хүртээмжтэй хэлбэрээр хүртэх;
  - c) театр, музей, кино театр, номын сан, аялал жуулчлалын үйлчилгээ зэрэг соёлын үзвэр, үйлчилгээ эрхэлдэг газруудад нэвтрэх боломжтой байх бөгөөд түүнчлэн хөшөө дурсгал болон үндэсний соёлын ач холбогдол бүхий газруудад ч мөн хүрэх боломжтой байх
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зөвхөн өөрийн сайн сайхны төдийгүй нийгмийн баялагт хувь оруулах үүднээс уран бүтээлийн, урлагийн болон оюуны чадавхиа ашиглах болон хөгжүүлэх боломжийг тэдэнд бий болгох зохистой бүхий л арга хэмжээг оролцогч улсууд нь авна.
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс урлагийн бүтээлийг хүртэхэд оюуны өмчийн эрхийг хамгаалсан хууль тогтоомж нь үндэслэлгүй, алагчлах шинжтэй саад тотгорыг үүсгэхгүй байх явдлыг хангах үүднээс оролцогч улсууд бүхий л зохистой арга хэмжээг олон улсын эрхзүйн дагуу авна.
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдийн соёлын тусгай болон хэл ярианы онцлог байдал тухайлбал, дохионы хэл, дүлий хүмүүсийн өвөрмөц онцлогийг бусадтай адил тэгш байх үндсэн дээр хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй.
5. Бусадтай адил тэгш байх үндсэн дээр амралт, чөлөөт цагаа спортын арга хэмжээнд оролцох хэлбэрээр өнгөрүүлэх боломжийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хангах үүднээс оролцогч улсууд нь дараах зохистой арга хэмжээг авна
  - a) нийтэд зориулсан спортын бүх төрлийн арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг аль болох бүрэн хэмжээгээр оролцуулах явдлыг дэмжиж сурталчлах;
  - b) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусгайлан зориулагдсан спорт, чөлөөт цагийн арга хэмжээг зохион байгуулах, хөгжүүлэх болон оролцох боломжтой байх явдлыг тэдгээр хүнд баталгаажуулах, үүний тулд бусадтай адил тэгш байх үндсэн дээр шаардлагатай сургалт, бэлтгэл, хэрэгслээр хангах;
  - c) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс спорт, чөлөөт цагаа өнгөрүүлэх, аялал жуулчлалын байгууллагуудад хүрэх боломжтой байх явдлыг хангах;
  - d) хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тоглоом наадгайд оролцох, амралт чөлөөт цагаа спортын арга хэмжээ, тухайлбал сургууль дээр зохион байгуулагдаж байгаа ийм төрлийн арга хэмжээнд бусад хүүхдийн адил оролцох тэгш боломжтой байх явдлыг хангах;
  - e) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс чөлөөт цагаа өнгөрүүлэх, аялал жуулчлал, амралт, спортын үйл ажиллагааг зохион байгуулдаг байгууллагуудын үйлчилгээг хүртэх боломжтой байх явдлыг хангах.

## ЗОРИЛТУУД

Энэ бүлгийн сэдэв, үндсэн мэдээлэл, дасгалууд нь оролцогчдод дараах зорилтыг хангахад туслах зорилготой:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн соёлын амьдралд оролцох, амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх, спортоор хичээллэх эрхийг тодорхойлох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст соёлын болон спортын үйл ажиллагаанд оролцох нь ямар чухал болохыг тайлбарлах;
- Хүний соёлын амьдралд оролцох, амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх, спортоор хичээллэх эрх нь хүний бусад эрхтэй холбоотой болохыг ойлгох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн соёлын амьдралд оролцох, амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх, спортоор хичээллэх эрх хэрхэн хангагдаж эсвэл зөрчигдөж байгааг мэддэг болох;
- **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенци (ХБХЭК)** дахь соёлын амьдралд оролцох, амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх, спортоор хичээллэх эрхийн тухай заалтуудыг ойлгох.

ЭХЛЭЛ: СОЁЛЫН АМЬДРАЛД ОРОЛЦОХ, АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГАА ӨНГӨРҮҮЛЭХ, СПОРТООР ХИЧЭЭЛЛЭХ ТАЛААР ЭРГЭЦҮҮЛЭХ НЬ

Соёлын амьдрал, чөлөөт цаг, амралт, спортын үйл ажиллагаанд оролцох нь өөрийн амьдарч буй орон нутгийнхаа гишүүн байхын нэгэн чухал хэсэг юм. Харамсалтай нь, нийгмийн бусад гишүүдэд нээлттэй соёл урлаг, амралт, чөлөөт цаг, спортын олон төрлийн үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс оролцож чаддаггүй. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тоглох эрхээ эдэлж чадахгүй байх нь элбэг.

Соёлын амьдралын хүрээнд ялгаварлан гадуурхал нь олон хэлбэрээр илэрдэг дэлхий нийтийг хамарсан нийтлэг үзэгдэл юм. Соёлын төв, клубууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн орж гарах боломжийг анхаараагүй байдаг тул хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс соёлын арга хэмжээнд шууд оролцох, үзэж сонирхох эрхээ эдэлж чаддаггүй. Тэр бүү хэл хүн бүр төвөггүй оролцож болох наад захын олон үйл ажиллагаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжгүй байдаг. Жишээлбэл, тэргэнцрээс оч үсрэн бусад хүмүүсийг галын аюулд учруулах магадлалтай гэсэн үндэслэлээр тэргэнцэртэй хөгжлийн бэрхшээлтэй хүнийг кино театрт оруулаагүй тохиолдол ч гарч байсан. Дэлхий даяар жуулчдад зориулсан үзмэрийн газрууд хөдөлгөөнд саад болох, орох боломжийн хаасан зүйлээр дүүрэн байдаг. Зочид буудалд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг хангасан өрөө цөөн, харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан тэмдэглэгээ байдаггүй. Тэргэнцэртэй хүмүүст үйлчлэхээр тоноглогдсон автобус ховор. Ресторанууд оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үйлчлэхээс татгалзсан явдал хэд хэд гарч байсан бөгөөд ер нь дэлхий даяар ресторанууд бие махбодын бэрхшээлтэй хүмүүсийн орох, гарах боломжийг анхаардаггүйгээрээ зартай. Соёл урлаг, спортын үйл ажиллагааг хүмүүст хүргэдэг телевиз, бусад технологиуд нь сонсголтгүй хүмүүст мөн л хүртээмжгүй байдаг.

Дэлхий даяар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс соёл урлаг, амралт чөлөөт цаг, спортын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож чадахгүй гадуурхагдан үлддэг. Бусад хүмүүсийн хандлага, спортын үйл ажиллагааны тухай мэдээллийг хүргэж байгаа арга хэлбэр зэргээс үүдэлтэй нийгмийн болон харилцааны саад тотгороос болж хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс уралдаан тэмцээнүүдэд тамирчны болон үзэгчийн хувиар оролцож чаддаггүй. Биет саадуудаас болж хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс спортын зал, стадионд орж ч чадахгүйд хүрдэг. Хууль эрхзүй орчин, бодлого нь ч мөн гадуурхлын шалтгаан болох магадлалтай. Жишээлбэл, их дээд болон дунд сургуулийн ихэнх нь хөгжлийн бэрхшээлтэй оюутан, суралцагчдыг спортын үйл ажиллагаанд хамруулах бодлого байхгүй, спортын үйл ажиллагааг хөгжлийн бэрхшээлтэй тамирчдын хэрэгцээнд хэрхэн тохируулах тухай дасгалжуулагчид ч мэддэггүй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд спортоор хичээллэх, чөлөөт цагаа өнгөрүүлэх, тоглох эрхээ эдлэхэд олон саад тулгардаг. Үүний тодорхой жишээнүүдийг Хүүхдийг Ивээх Сан баримтжуулж чаджээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах чиглэлээр ажиллаж байгаа бусад олон байгууллага ч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оролцох боломжоор хангахын тулд сургуулийн биеийн тамирын хичээлийн хөтөлбөрт өөрчлөлт оруулах, олон нийтийг дайчлан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хүртээмжтэй тоглоомын талбай байгуулах зэрэг ажлыг амжилттай хэрэгжүүлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн соёлын амьдрал, чөлөөт цаг, амралт, спортын үйл ажиллагаанд оролцох эрх нь тэдний бусад эрхээ эдлэх боломжид шууд нөлөөлдөг тул дэлхий даяар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд энэ эрхийг хангахад анхаарч ажилладаг. Жишээлбэл, сургуулийнхаа спортын арга хэмжээнд оролцож чадахгүй байгаа нь хүүхдийн эрүүл байх эрхэд шууд нөлөөлнө. Соёл урлагийн амьдралд оролцох эрх нь мэдээлэл олж авах эрхтэй нягт уялдаатай бөгөөд соёлын арга хэмжээний тухай мэдээллийг хүртээмжтэй хэлбэрээр тараахгүй байгаа нь тухайн үйл ажиллагаанд оролцох боломжийг шууд хязгаарласан хэрэг юм. Биеийн тамир спорт, соёл урлагийн арга хэмжээ нь энх тайвныг бэхжүүлэх, нийгмийн идэвх санаачилгыг дайчлах, ДОХ/ХДХВ-ийн халдвараас сэргийлэх боловсрол, полиомиелитээс сэргийлэх вакцинжуулалт зэрэг нийгмийн эрүүл мэндийн сурталчилгаанд өргөнөөр ашиглагддаг чухал арга хэрэгсэл болоод байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дээрх арга хэмжээний гадуур үлдээж байгаа нь нийгмийн болон улс төрийн амьдралд оролцох эрхийг нь хөндөөд зогсохгүй эрүүл байх, сурч боловсрох эрхийг нь хөсөрдүүлж байгаа хэрэг юм. Эдгээр жишээ нь хүний эрхүүд **нэгдмэл, уялдаа холбоотой, харилцан хамааралтай** болохыг харуулж байна.

**Соёлын амьдралд, амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх  
спортын үйл ажиллагаанд оролцоход нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст  
саад болж буй тогторуудын жишээ**

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс соёл, амралт чөлөөт цаг, спортын үйл ажиллагаанд оролцогч, үзэгчийн хувиар үр дүнтэй оролцож чадах эсэх талаар нийгэмд сөрөг хандлага тогтсон байдаг.
- Музей, театр, концертын танхим, спортын заал, талбай, парк, спортын ордон болон соёл урлаг, амралт цэнгээний бусад барилга байгууламжуудад нэвтрэхэд биет саадууд тулгардаг.
- Соёл, спортын арга хэмжээ явагдаж байгаа газарт хүргэж өгөх хүртээмжтэй тээврийн хэрэгсэл байхгүй.
- Соёл, спортын арга хэмжээ, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан ийм арга хэмжээний тухай мэдээллийг хүртээмжтэй арга хэлбэрээр тараадаггүй.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн харилцааг дэмжих боломж, нөхцөл бүрдээгүй.
- Дохионы хэл бол сонсголгүй болон хараа-сонсголын хавсарсан бэрхшээлтэй олон хүний хувьд хэл, харилцааны үндсэн хэрэглүүр нь болж байгааг бусад хүмүүс ойлгодоггүй.
- Амралт чөлөөт цаг, аялал жуулчлал, спорт, соёл урлагийн үйл ажиллагаа зохион байгуулж буй хүмүүст хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тусгай хэрэгцээг ойлгуулах, боломжит тохируулгыг хэрхэн хангах талаар зааж сургадаггүй.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг спорт, амралт чөлөөт цагийн арга хэмжээнд оролцуулах, сургуулийн биеийн тамирын хичээлийг хувилбарт хөтөлбөрөөр баяжуулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохирсон тоглоомын талбай, тоног төхөөрөмж бүтээх талаарх мэдлэг, туршлага дутмаг.

**ДАСГАЛ 14.1: Соёл, амралт, чөлөөт цаг, спортын ажиллагаанд оролцоход  
тулгарч буй саадууд**

<b>Зорилт:</b>	Соёлын амьдрал, амралт, чөлөөт цаг, спортын үйл ажиллагаанд оролцоход нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тохиолддог саадуудыг тодорхойлох
<b>Хугацаа:</b>	60 минут
<b>Хэрэглэгдэхүүн:</b>	Том цаас, фломастер эсвэл самбар, шохой

### **1. Шинжлэх**

Оролцогчид ганцаараа юмуу хосоороо 30 дугаар зүйлд дурьдсан үйл ажиллагааны тодорхой нэг төрлийг (соёлын, спорт, чөлөөт цаг, амралтын тодорхой нэг арга хэмжээ, тоглох гэх мэт) сонгон авч, тухайн үйл ажиллагаанд оролцоход нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгарах саад, бэрхшээл, хүндрэлүүдэд үнэлгээ өгнө. Судалж буй асуудлаа нээж харуулах тохиолдол, сценарийг оролцогчид зохиох, бодох хэрэгтэй болох бөгөөд өөрсдөд нь тохиолдсон бодит явдлаас санаа авч болно.

## 2. Дүрд тоглох

Оролцогчид ганцаараа юмуу хосоороо хийсэн дүн шинжилгээгээ танилцуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоонд саад болж буй дор хаяж нэг тотгорыг дүрийн тоглолтоор харуулах даалгавар авна.

## 3. Хэлэлцэх

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс соёлын амьдрал, спорт, амралт чөлөөт цагийн болон эдгээртэй төстэй бусад үйл ажиллагаанд бүрэн оролцож чадахгүй байгаагаас ямар үр дагаврууд гарах вэ? Энэ нь тэдний орчин тойронд байгаа бусад хүмүүс, орон нутагт ямар үр дагавар авчрах вэ? Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ямар үр дагавар авчрах вэ? Нийгэмд бүхэлд нь?

- Дээрх саад тотгоруудаас аль нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хамгийн ноцтой нөлөө үзүүлэх вэ? Аль нь тэдний эргэн тойронд байгаа бусад хүн/ орон нутагт хамгийн ноцтой нөлөө үзүүлэх вэ? Аль нь нийгэмд бүхэлд нь хамгийн хүчтэй нөлөөлөх вэ?
- Бүрэн дүүрэн оролцоонд тулгарч буй хамгийн ноцтой эдгээр саад, тотгоруудыг арилгахын тулд юу хийж болох вэ? Жагсаалт болгож бич.

## 4. Боловсруулах

Оролцогчид бүгд хамтран ажиллаж, хөгжлийн бэрхшээлтэй хүний энэ эрхтэй холбоотой нэг юмуу хэд хэдэн асуудлаар оролцоог хангахад шаардагдах зүйлсийг харуулсан факт баримтын жагсаалт юмуу хяналтын хуудас боловсруулна. Жишээлбэл, тодорхой нэг асуудлын хүрээнд (спортын юмуу аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцох гэх мэт) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангаснаар гарах үр өгөөжийг тодорхойлоод, оролцоог хангахад чиглэсэн тодорхой шийдлүүдийг санал болгож болох юм. Эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг соёлын болон спортын үйл ажиллагаанд хэрхэн хамруулах, тэдэнд шаардлагатай боломжит тохируулгыг хэрхэн хангаж өгөхийг харуулсан зөвлөмжүүдийг жагсаан бичиж болно. Энэ жагсаалтуудаа дараа нь нөлөөллийн болон мэдлэг, мэдээлэл нэмэгдүүлэх үйл ажиллагаануудад ашиглаж болно. Боловсруулсан жагсаалтуудаа зорилтот бүлгийн төлөөлөгчдөд (орон нутгийнхан, спортын төвийн ажилтнууд, аялал жуулчлалын байгууллага) тарааж өгөх нь зүйтэй гэдгийг оролцогчдод хэл.

ХҮНИЙ ЭРХИЙН ЭРХЗҮЙД СОЁЛЫН АМЬДРАЛ, АМРАЛТ ЧӨЛӨӨТ ЦАГ, СПОРТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ ТАЛААР ЮУ ГЭЖ ЗААСАН БАЙДАГ ВЭ?

Соёлын амьдрал, чөлөөт цаг, амралт, спортын үйл ажиллагаанд оролцох эрхийн талаар **Хүний эрхийн түгээмэл тунхаглал (ХЭТТ)**, **Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (ЭЗНСЭОУП)**<sup>1</sup> зэрэг олон улсын хүний эрхийн үндсэн баримт бичгүүдэд тодорхой заалт орсон байна. Тусгайлсан конвенциудад ч мөн эдгээр эрхийг онцгойлон авч үзсэн байдаг бөгөөд, жишээлбэл, **Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцид (ЭАБХУК)** эмэгтэйчүүдийн амралт чөлөөт цаг, спорт болон соёлын амьдралын бүхий л үйл ажиллагаанд оролцох эрхийг нарийвчлан тодорхойлж баталгаажуулсан байдаг.<sup>2</sup> **Хүүхдийн эрхийн конвенцид (ХЭК)** хүүхдийн амрах эрх, хүүхдийн насны онцлогт тохирсон тоглоом, чөлөөт цагийн үйл ажиллагаанд

1 [http://www.unhchr.ch/html/menu3/b/a\\_ceschr.htm](http://www.unhchr.ch/html/menu3/b/a_ceschr.htm) сайтаас үз.

2 <http://www.un.org/womenwatch/daw/cedaw> сайтаас үз.





оролцох, соёлын амьдрал, урлагийн үйл ажиллагаанд чөлөөтэй оролцох эрхийг нь хүлээн зөвшөөрсөн байдаг.<sup>3</sup>

Хүний эрхийн олон баримт бичигт баталгаажсан ч эдгээр нь хүний бусад эрхтэй харьцуулахад тийм ч боловсронгуй болж чадаагүй, олон тохиолдолд мартагдан орхигддог эрхүүд юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүрэн хамрагдалтыг хангахад соёл, амралт, чөлөөт цаг, спортын төрөл бүрийн үйл ажиллагаанд оролцох эрх нь онцгой чухал үүрэгтэй болохыг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр ХБХЭК нь 30 дугаар зүйлдээ энэ эрхийг нэлээд нарийвчлан авч үзжээ. Ийм ч учраас ХБХЭК нь соёлын амьдрал, урлаг, спорт, амралт чөлөөт цагийн болон бусад төстэй үйл ажиллагаанд оролцох хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг баталгаажуулж чадсанаараа хүний эрхийн эрхзүйд чухал дэвшил авчирсан юм.

### **ХБХЭК-ийн 30 дугаар зүйлд дараах эрхийг тодорхой заажээ:**

- Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст соёлын үзвэр, үйлчилгээ явагдаж байгаа газруудад нэвтрэх боломжийг хангаж өгөх үүрэгтэй. Эдгээрт театр, музей, кино театр, номын сан, аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлдэг газрууд багтана. Түүнчлэн үүнд боломжийн хэрээр хөшөө дурсгал болон үндэсний соёлын дурсгалт газруудад хүрэх боломжийг мөн багтаах ёстой ажээ.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зөвхөн өөрийн төдийгүй нийгмийн амьдралыг баяжуулах үүднээс уран бүтээлийн, урлагийн болон оюуны чадавхиа ашиглах, хөгжүүлэх эрхтэй. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс орон нутгийнхаа соёлын амьдралд, тухайлбал, зураач, хөгжимчин, эрдэмтэн, жүжигчний хувиар бүрэн оролцох боломжтойг хүлээн зөвшөөрч байгаа хэрэг болно.
- Оюуны өмчийг хамгаалсан хууль, эрхзүй нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн урлагийн бүтээлүүдийг хүртэх эрхэд үндэслэлгүй, алагчилсан шинжтэй саад тотгор үүсгэхгүй байхад Оролцогч улсууд анхаарах үүрэгтэй. Үүнд, жишээлбэл, ном, бусад материалыг Брайль үсгээр хөрвүүлэх, аудио хуурцаг, дохионы хэлээр хүргэх, мөн уран бүтээлийг хүртээмжтэй технологиор хүргэх арга хэмжээнүүд багтаж байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусадтай адил тэгш байх үндсэн дээр өөрсдийн соёлын болон хэлний онцлог байдлаа хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй. Үүнд, жишээлбэл, дохионы хэл ашиглах эрх, Дүлий Хүмүүсийн Соёлыг дэмжсэн туслалцаа авах эрх зэрэг багтана. Улмаар ХБХЭК-д Дүлий Хүмүүсийн Соёлд хамрагдаж байгаа хүмүүсийн хувьд дохионы хэл бол тэдний үндсэн хэл бөгөөд тэд өөрсдийгөө хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэж үзэхгүй харин соёлын болон хэлний цөөнх гэж үзэж байгааг нь хүлээн зөвшөөрчээ.
- Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ердийн спортын үйл ажиллагаанд хамруулахад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст спорт, чөлөөт цагийн үйл ажиллагаа явуулдаг барилга байгууламжид нэвтрэх тэгш боломжийг хангах (усан сан, өөрсдийнх нь хэрэгцээнд нийцүүлсэн тоглоомын талбайд нэвтрэх), олон нийтэд зориулсан болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусгайлан зориулсан (тэргэнцэр дээрх сагсан бөмбөг гэх мэт) спортын үйл ажиллагааны аль алинд нь оролцох нөхцлийг бүрдүүлж өгөхийг шаардсан оролцооны зарчимд суурилсан үзэл баримтлал юм.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүн нь хөгжлийн бэрхшээлтэй бусад хүмүүсийн хамтаар спорт, чөлөөт цагийн үйл ажиллагаа, үүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусгайлан зориулсан үйл ажиллагаа зохион байгуулах, төлөвлөх, оролцох эрхтэй. Үүнд ердийн

3 <http://www.unhchr.ch/html/menu3/b/k2crc.htm> сайтаас үз.

болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусгайлан зориулсан спортын үйл ажиллагааны аль аль нь багтана.

- Амралт чөлөөт цаг, аялал жуулчлал, спортын үйл ажиллагаа зохион байгуулж байгаа байгууллагууд нь аливаа үйлчилгээ, үйл ажиллагаандаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг багтааж байхад Оролцогч улсууд анхаарах үүрэгтэй.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүн спорт, амралт чөлөөт цагийн болон аялал жуулчлалын үйлчилгээ явуулдаг байр байгууламж, тоног төхөөрөмжийг хүртээмжтэй ашиглах эрхтэй. Үүнд, тухайлбал, стадион, нийтийн бассейн, музей, зочид буудал зэрэг багтана.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тоглох эрхтэйн дээр сургууль дээрээ амралт чөлөөт цаг, спортын үйл ажиллагаанд оролцох эрхтэй. Үүнд, нийтийн эзэмшлийн тоглоомын талбай болон сургуулийн биеийн тамирын танхим зэрэг багтана.

Дүгнэж хэлэхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн соёлын амьдрал, амралт, чөлөөт цаг, спорт, тоглоомын үйл ажиллагаанд оролцох эрхийг **хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх** үүргийг төр хүлээнэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг **хүндэтгэх** үүргийнхээ хүрээнд Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн спорт, чөлөөт цагийн үйл ажиллагаа явуулдаг барилга байгууламжид нэвтрэх эрх, дохионы хэл зэрэг үндсэн хэлээ ашиглах эрх, бусад чиглэлээр соёлын үйл ажиллагаанд оролцох, хамрагдах эрхээ эдлэхэд нь хязгаарлалт тавихгүй, хөндлөнгөөс оролцохгүй байх ёстой. Оролцогч улсууд нь мөн ялгаварлан гадуурхсан үйлдлийг төрийн бодлогоороо дамжуулан хэрэгжүүлэхээс зайлсхийж, дохионы хэл ашиглахыг нь хориглох, хязгаарлах зэргээр соёлын амьдралтай холбоотой ялгаварлан гадуурхсан хэм хэмжээ тогтоохоос зайлсхийх ёстой. **Хамгаалах** үүргийнхээ хүрээнд Оролцогч улсууд нь, бусад арга хэмжээний зэрэгцээ, соёл, амралт, чөлөөт цаг, спортын үйл ажиллагаанд оролцох эрхийг хангахад чиглэсэн хуулийн, захиргааны болон бусад арга хэмжээ авах үүргийг хүлээнэ. Эдгээрийн дотор соёлын арга хэмжээний үеэр дохионы хэлний орчуулагч ажиллуулах, нэвтрэн ороход саадгүй спортын цогцолборууд барьж байгуулах зэргийг нэрлэж болно. Эцэст нь **хэрэгжүүлэх** үүргийнхээ хүрээнд Оролцогч улсууд нь эдгээр эрхийг бүрэн хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах үүрэгтэй. ХБХЭК-д Оролцогч улсууд нь, жишээлбэл, чөлөөт цаг, аялал жуулчлал, амралт, спортын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудад шаардлагатай сургалтуудыг явуулах үүрэгтэй болохыг онцолжээ.

### **Хөгжлийн бэрхшээл ба урлаг: Хамрагдалтын зарчмууд**

- Хөгжлийн бэрхшээлтэй залуу хүн бүр урлагийн өндөр чанартай боловсрол/ сургалтанд хамрагдах эрхтэй.
- Урлагийн хичээл заадаг хүн бүр хичээлдээ хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг хамруулах бэлтгэлтэй байх ёстой.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, өсвөр үеийнхэн, насанд хүрсэн хүн бүр соёлын байгууламжид нэвтрэх, үйл ажиллагаанд оролцох бүрэн боломжтой байх ёстой.
- Урлагийн салбарт мэргэжлийн ажил эрхлэх хүсэлтэй хөгжлийн бэрхшээлтэй бүх хүн шаардлагатай ур чадваруудаа хөгжүүлэх боломжоор хангагдсан байх ёстой.<sup>4</sup>

4 “Хүртээмж ба боломж: Хөгжлийн бэрхшээлийг ойлгоход туслах зөвлөмж”. VSA Arts. <http://www.vsarts.org>



## ДАСГАЛ 14.2: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид соёлын амьдралд оролцох, амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх, спортын үйл ажиллагаанд оролцох эрхийн талаар юу гэж заасан байдаг вэ?

- Зорилт:** ХБХЭК дахь соёлын амьдрал, амралт, чөлөөт цаг, спортын үйл ажиллагаанд оролцох эрхийн талаарх заалтуудыг судлан, ойлгох
- Хугацаа:** 30 минут
- Хэрэглэгдэхүүн:** Том цаас, фломастер эсвэл самбар, шохой

### 1. Бататгах

Оролцогчдыг жижиг багуудад хуваана. Багаараа ХБХЭК-ийн 30 дугаар зүйлийг энгийн үг хэллэгээр өөрчлөн найруулаад, эдгээр эрхийг эдэлснээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдрал хэрхэн өөрчлөгдөж болохыг харуулсан жишээнүүдийг оролцогчдоор гаргуул. 30 дугаар зүйл нилээд урт учраас хэд хэдэн хэсэгт хуваагаад, багуудад хэсэгчлэн хуваарилж болно.

### 2. Энгийн үг хэллэгээр өөрчлөн найруулах

30 дугаар зүйлийг чангаар уншиж өг. Өгүүлбэр, параграф болгоны эцэст зогсож, тухайн хэсгийг багууд энгийн үг хэллэгээр хэрхэн өөрчлөн найруулсныг сонсоно. Бүгд санал нэгтэй зөвшөөрсөн найруулга гарч иртэл тухайн хэсгийг нийтээрээ хэлэлц. 30 дугаар зүйлийг эцсийн найруулгыг том цаасан дээр бичнэ.

### 3. Жишээ гаргах

Дурьдсан эрхийг эдэлснээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдрал хэрхэн өөрчлөгдөж болохыг харуулсан жишээнүүдийг сонс.

### 4. Хэлэлцэх

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах асуудлыг үндэсний хэмжээний бодлогын асуудал болгож тавих, мөн улс төрийн нам, шийдвэр гаргагчдад өргөн барих үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулахад ХБХЭК-ийн 30 дугаар зүйлийг хэрхэн ашиглаж болох вэ? Орон нутаг, үндэсний болон олон улсын түвшинд эдгээр эрхийг дэмжин ажиллаж байгаа ямар байгууллагууд байна вэ? (Төрийн болон төрийн бус байгууллагуудын аль алиныг нь багтаана)

## СОЁЛЫН БОЛОН ХЭЛНИЙ ОНЦЛОГТОЙ ХОЛБООТОЙ ЭРХ

Хүн бүр амьдарч буй орон нутгийнхаа соёлын амьдралд ямар нэгэн дарамт, шахалтгүй оролцох эрхтэй. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдийн соёлын хэм хэмжээндээ нийцүүлэн амьдрах эрх, амьдарч буй орон нутгийнхаа соёлын амьдралд оролцох эрхээ хязгаарлуулах ёсгүй. Олон улсын хүний эрхийн эрхзүйд хүн амын цөөнх бүлгүүдийн төрөлх хэл, соёлоо ашиглах, хөгжүүлэх эрхийг нь хүлээн зөвшөөрснөөс гадна нэмэлт албан ёсны буюу үндсэн хэлийг төгс эзэмших эрхийг нь мөн хүлээн зөвшөөрсөн байдаг.

**Хүний эрхийн түгээмэл тунхаглалд (ХЭТТ)<sup>5</sup>** хүн бүр төрөлх хэлнээсээ болж ялгаварлагдахгүй байх эрхийг хүлээн зөвшөөрсөн (2 дугаар зүйл) байдаг бол **Үндэсний**,

5 <http://www.unhchr.ch/udhr/lang/eng.htm> сайтаас үз.

**яс үндэстний, шашны болон хэлний цөөнхөд хамаарах хүмүүсийн эрхийн тухай тунхаглал**<sup>6</sup> зэрэг олон улсын бусад эрхзүйн актуудад энэ эрхийг бататгаж өгсөн байдаг.

Энэ нь дохионы хэл, Брайль үсэг, харилцааны бусад арга хэрэгслүүдийг ашигладаг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст маш их хэрэгтэй хамгаалалт юм.

ХБХЭК-д хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дохионы хэл, Дүлий Хүмүүсийн Соёл зэрэг соёлын болон хэлний онцлогоо хүлээн зөвшөөрүүлж, дэмжүүлэх эрхийг баталгаажуулсан явдал нь хүний эрхийн эрхзүйд маш чухал дэвшил болсон юм.

### **ДАСГАЛ 14.3: Танай орон нутагт соёлын ямар ямар зан үйл болдог вэ?**

<b>Зорилт:</b>	Гэр бүл, орон нутгийн хүрээний соёлын онцлог зан үйлүүдийг авч үзэж соёлын үйл ажиллагаанд оролцох эрхээ эдлэхэд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгарч буй саадуудыг тодорхойлох
<b>Хугацаа:</b>	30 минут
<b>Хэрэглэгдэхүүн:</b>	Том цаас, фломастер эсвэл самбар, шохой

#### **1. Санал солилцох/Хэлэлцэх/Тайлагнах**

Оролцогчдыг жижиг багуудад хуваагаад, дараах асуултуудын дагуу санал бодлоо илэрхийлэхийг хүс:

- Хүний амьдралд тохиох чухал үйл явдал (хүүхэд төрөх, насны ой тохиох, гэр бүл болох, нас барах гэх мэт), эсвэл улирлын онцлогтой холбоотой (шашны баяр, үндэсний баяр гэх мэт) ямар зан үйлүүд танай орон нутагт болдог вэ? Эдгээрийг жагсааж бич.
- Тухайн үйл явдлууд хувь хүнд ямар үнэ цэнэтэй, ямар ач холбогдолтой вэ? Гэр бүлийн хувьд? Орон нутаг болон нийгэмд бүхэлд нь ямар үнэ цэнэ, ач холбогдолтой вэ?

#### **2. Шинжлэх**

Багууд ажлаа танилцуулсны дараа багуудын гаргасан жагсаалтуудыг нэгтгэ. Бүх оролцогчийг хамруулан дараах асуултуудын дагуу хэлэлцүүлэг хий:

- Эдгээр үйл явдалд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцуулдаг уу? Үгүй бол яагаад?
- Ийм үйл явдлуудад оролцуулахгүй байх нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст өөрсдөд нь ямар нөлөө үзүүлдэг вэ?
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эдгээр үйл явдалд оролцуулахгүй байгаа нь тэдний нийгмийнхээ бүрэн эрхт гишүүний хувьд нийгмийн амьдралд оролцох боломжид ямар нөлөө үзүүлэх вэ?

#### **3. Стратеги боловсруулах**

Эдгээр соёлын зан үйлд оролцох эрхтэй холбоотой ялгаварлан гадуурхлыг арилгах арга замуудыг тодорхойлохыг оролцогчдоос хүс.

- Эдгээр саадыг (а) гэр бүлийн хүрээнд, (б) орон нутгийн хүрээнд хэрхэн арилгаж болох вэ?

6 [http://www.unhchr.ch/html/menu3/b/d\\_minori.htm](http://www.unhchr.ch/html/menu3/b/d_minori.htm) сайтаас үз.



1982 онд баталсан **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлаарх дэлхий нийтийн үйл ажиллагааны хөтөлбөрт**<sup>7</sup> хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн спортын үйл ажиллагаанд оролцох эрхийг хангахын тулд төр оролцох боломж, зохион байгуулалтаар хангаж өгөх ёстойг онцлон тэмдэглэсэн байдаг. 1993 онд батлагдсан **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боломжийг тэгшитгэх тухай НҮБ-ын Стандарт дүрмүүдэд**<sup>8</sup> спорт болон чөлөөт цагийн үйл ажиллагааг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хэрхэн хүртээмжтэй байлгах тухай нарийвчилсан зөвлөмж багтжээ. 11 дүгээр дүрэмд Оролцогч улсууд спортын байгууламжуудыг нэвтрэх боломжтой болгох, спортын байгууллагуудын үйл ажиллагааг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нээлттэй болгоход чиглэсэн арга хэмжээ авах, боломжтой үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусгайлан зориулсан хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх замаар спортын үйл ажиллагаанд оролцох тэдний эрхийг хангах ёстой тухай заажээ. Мөн 11 дүгээр дүрэмд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг үндэсний болон олон улсын хэмжээний спортын уралдаан, тэмцээнд оролцуулах асуудалд анхаарлаа хандуулахыг уриалжээ. Мөн Дүрэмд спортын үйл ажиллагаанд оролцож буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусад оролцогчдын авч буйтай адил чанартай сургалт, дасгалжуулалт авах эрхтэй болохыг тодотгож өгсөн. Хамгийн чухал нь, 11 дүгээр дүрэмд спортын болон чөлөөт цагийн үйл ажиллагаа зохион байгуулдаг байгууллагууд үйлчилгээгээ төлөвлөхдөө хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн зөвлөгөөг авах ёстой гэж заажээ.

Өмнөх үеийн дээрх хүчин чармайлтуудыг **ХБХЭК**-д улам лавшруулж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь олон нийтэд зориулсан ердийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусгайлан зориулсан спортын үйл ажиллагааны аль алинд оролцох эрхтэй болохыг онцолжээ. Спортын байгууллагууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тусгай хөтөлбөр, үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ олон нийтэд зориулсан спортын хөтөлбөр, үйлчилгээгээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгоход чиглэсэн тусгай зохицуулалт хийх зэргээр энэ эрхийг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх боломжтой юм. *Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн спорт* гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст өрсөлдөх шударга нөхцөл боломж хангаж өгөх үүднээс хөгжлийн бэрхшээл болон чадавхид нь нийцсэн тэгш бөгөөд шударга спортын төрөл, категориор өрсөлдөх боломж олгосон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусгайлан зориулагдсан спорт юм. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн спортыг эмэгтэйчүүдийн спортын нэгэн адил спортын нэгэн ангилал гэж үздэг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалагчид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг спорт, чөлөөт цагийн үйл ажиллагаанд оролцуулах явдлыг олон жилийн туршид сурталчлан ухуулсаар ирсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн спортын оргил нь Параолимп юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусгайлан зориулсан олон улсын бусад үйл ажиллагаанд Сонголгүй хүмүүсийн спортын олон улсын хорооноос зохион байгуулдаг Дүлийчүүдийн тоглолт, мөн оюуны бэрхшээлтэй хүмүүст спорт, чөлөөт цагийн өрсөлдөөнт тоглоомд оролцох боломж олгох зорилготой дэлхийн Тусгай Олимп зэргийг нэрлэж болно. Эдгээрийн зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг олон нийтийн спортын үйл ажиллагаанд хамруулах, тэдэнд тусгайлан зориулсан спортыг хөгжүүлэх зорилгоор орон нутгийн спортын олон үйл ажиллагааг голдуу хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд зохион байгуулдаг. Хөгжлийн бэрхшээлийн асуудлаар дагнан ажилладаг НҮБ-ын Тусгай илтгэгчийн гаргасан саяхны илтгэлд дэлхийн олон оронд хөгжлийн бэрхшээлтэй тамирчид үндэсний бахархал болж олны хайр хүндэтгэлийг

7 <http://www.un.org/esa/socdev/enable/diswpa00.htm> сайтаас үз.

8 <http://www.un.org/esa/socdev/enable/dissre00.htm> сайтаас үз.



хүлээж байгааг дурьдаад, орон нутгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн спортын үйл ажиллагаанд оролцох боломж нэмэгдэж байгаа тухай мэдээлжээ.<sup>9</sup> Австралийн Спортын хорооны дэмжлэгээр хэрэгжиж байгаа санаачилга нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг спортод оролцуулахыг дэмжсэн нөлөөллийн ажлын нэгэн сонирхолтой жишээ юм (Дараах хайрцагт өгсөн мэдээллийг үзнэ үү.).

### **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн спорт Австралид: КОННЕКТ төсөл**

КОННЕКТ төсөл нь Австралийн Спортын хорооноос үндэсний хэмжээнд хэрэгжүүлж байгаа санаачилга бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг хангахад үндэсний спортын холбоодод шаардлагатай туслалцаа, дэмжлэгийг хангаж өгөх зорилготой шилжилтийн хөтөлбөр юм. Энэ хөтөлбөр нь орон нутгийн түвшнээс авахуулаад элит түвшин хүртэлх бүхий л шатны спортын үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлийн асуудлыг суулгаж үзэхийг хичээдэг. Хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй тамирчдад биеийн тамир, спортод оролцох боломж олгох, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан болон олон нийтийн спортын холбоотой саад тотгоруудыг арилгах зорилготой. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн спортод хамрагдах боломжийг хязгаарлаж байгаа хүчин зүйлсийг цогцоор нь авч үзэхийн тулд хөтөлбөр нь үндэсний, бүс нутгийн болон орон нутгийн түвшинд хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэхэд онцгой анхаардаг байна. Хөтөлбөрт оролцогч үндэсний спортын байгууллагууд “Хөгжлийн бэрхшээлийн талаар авах арга хэмжээний төлөвлөгөө” боловсруулан, хэрэгжүүлж байгаа нь энэхүү санаачилгын цөм хэсэг болдог юм. Энэ хөтөлбөрт КОННЕКТ төслийн хүрээнд үзүүлэх төрөл бүрийн туслалцаа, дэмжлэгийг тодорхой дурьдсан байдгийн дотор:

- КОННЕКТ төсөл болон спортын үндэсний байгууллагууд “Хөгжлийн бэрхшээлийн талаар авах арга хэмжээний төлөвлөгөө”-г зөвшилцөх
- Төлөвлөгөөнд багтсан Стратегид харилцан тохиролцсон үр дүн, цаг хугацаа, болон үнэлэх аргыг тусгах
- Стратегийг хэрэгжүүлэхэд нь үндэсний спортын байгууллагуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх
- “Хөгжлийн бэрхшээлийн талаар авах арга хэмжээний төлөвлөгөө” нь үндэсний спортын байгууллагуудын стратегиудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүхий л түвшний үйл ажиллагаанд оролцуулах зорилтыг заавал багтаасан байхыг шаарддаг байна. Энэ төлөвлөгөөг Австралийн Хүний эрхийн болон тэгш боломжийн хороонд хүргүүлэн бүртгэлд оруулжээ.

Австралийн Спортын хорооноос дэмжиж баталсан “Спортод тавигдах хөгжлийн бэрхшээлтэй холбоотой стандарт” нь дараах үр дүнг үнэлэх хүрээ болдог байна:

9 Хөгжлийн бэрхшээлийн асуудлыг хариуцсан НҮБ-ын Тусгай илтгэгчий зөвлөмж, Стандарт дүрмүүдийн хэрэгжилтийн талаар засгийн газруудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх дэлхий нийтийн судалгаа (Доха, 2006).



- **Хөгжил:** Спортын байгууллагууд нь спортоо хөгжүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тухайн спортод төрөл бүрийн үүрэг рольтойгоор оролцох (жишээлбэл, сайн дурын ажилтан, үзэгч, зохион байгуулагч, тоглогч, дасгалжуулагч, захиргааны ажилтан гэх мэт) сонирхлыг нь татах, хөгжүүлэхэд анхаарах ёстой.
- **Оролцоо:** Спортын байгууллагууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн болон олон нийтийн спортын үйл ажиллагаанд оролцох боломжуудыг хангаж өгөх ёстой.
- **Тэмцээн:** Спортын байгууллагууд нь хөгжлийн бэрхшээлтэй тамирчдад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн болон олон нийтийн спортын үйл ажиллагаанд өрсөлдөх боломжийг бүрдүүлж өгөх ёстой.

КОННЕКТ төсөл нь “Хөгжлийн бэрхшээлийн талаар авах арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулахдаа үндэсний спортын олон байгууллагын хүчийг дайчилж чадсан бөгөөд үүнд хөнгөн атлетик, сагсан бөмбөг, усан спорт, теннис, боулинг, далбаат завь, бейсбол, софтбол, серфинг, ширээний теннис, крикет, гольф, зүлэгний боулинг, морин спорт зэрэг чиглэлийн спортын байгууллагууд багтжээ.<sup>10</sup>

## ДАСГАЛ 14.4: Тамирчин хүн гэж хэнийг хэлэх вэ?

- Зорилт:** Тамирчин хүний шинж чанаруудыг тодорхойлох, хөгжлийн бэрхшээлтэй тамирчдын спортын үйл ажиллагаанд оролцох эрхээ эдлэхэд нь тулгарч буй саадуудыг тодорхойлох
- Хугацаа:** 30 минут
- Хэрэглэгдэхүүн:** Том цаас, фломастер эсвэл самбар, шохой

### 1. Санал солилцох/хэлэлцэх

Дараах асуултуудын дагуу санал бодлоо илэрхийлэхийг оролцогчдоос хүс:

- Тамирчин хүнд ямар ямар ерөнхий шинж чанар байх ёстой вэ?
- Тамирчин хүний тухай бодоход та нарын санаанд ямар үг хэллэгүүд бууж байна вэ?

Одоо дээрх асуултуудыг хөгжлийн бэрхшээлтэй тамирчдад хамааруулан хэлэлц. Хариултуудыг том цаасан дээр тэмдэглэж авна.

- Хөгжлийн бэрхшээлтэй тамирчин хүнд ямар ерөнхий шинж чанар чанарууд байх ёстой вэ?
- Та нарын санаанд ямар ямар үг хэллэг бууж байна вэ?

### 2. Шинжлэх

- Дээрх хоёр жагсаалт хоорондоо хэр ялгаатай байна вэ?
- Хэр төстэй байна вэ?
- Энэ хоёр жагсаалтанд та нарын гайхлыг төрүүлсэн зүйлс орсон уу?

10 Австрелийн Спортын хорооны Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн спортын нэгж, КОННЕКТ төсөл <http://www.ausport.gov.au/connect/index.asp>

### 3. Хэлэлцэх

- Та нарын эргэн тойронд хөгжлийн бэрхшээлтэй тамирчид бий юу?
- Хэрэв байдаг бол тэд ямар спортоор хичээллэдэг вэ?
- Хэрэв байдаггүй бол яагаад байдаггүй вэ?
- Орон нутгийн, үндэсний болон олон улсын түвшинд хөгжлийн бэрхшээлтэй тамирчдын эрхийг дэмжих ямар байгууллагууд ажиллаж байна вэ? (Төрийн болон төрийн бус байгууллагуудын аль алиныг нь багтаа)

**Нөөц хувилбар:** Энэ дасгал ажлыг зураач, хөгжимчин гэх мэт соёл, спорт, чөлөөт цагийн бусад үйл ажиллагаанд оролцогч хүмүүст хамааруулан хялбархан хувирган ашиглаж болно.

**Эх сурвалж:** Зүүн Хойд бүсийн Спорт болон нийгмийн төвийн ажилтан Эли Вольфийн боловсруулсан материалаас өөрчлөн авав.

#### **Шүүхийн шийдвэр: Мэргэжлийн гольф дахь ялгаварлан гадуурхалтай тэмцэх нь**

АНУ-ын Дээд шүүх 2001 онд “Иргэн Мартин, “МГХ-ны цуврал тэмцээн” компанийн эсрэг” нэртэй хэргийг шийдвэрлэсэн юм. Хөгжлийн бэрхшээлтэй мэргэжлийн гольфчин Кейси Мартин шүүхэд хандаж Мэргэжлийн гольфын холбооны (МГХ) цуврал тэмцээний үеэр гольфын тэргэнцэр унахыг нь зөвшөөрч боломжит тохируулга хийж өгөхийг хүсжээ. Мартины нэг хөлнийх нь цусны эргэлт муудсан тул хөл нь маш их өвддөг бөгөөд явган явахад өвчин нь улам нэмэгддэг байв. Дээд шүүхээс Хөгжлийн бэрхшээлтэй америкчуудын тухай хуулийн дагуу МГХ-ны цуврал тэмцээн нь олон нийтэд зориулсан үйл ажиллагаа тул гольфын талбайг ажиллуулж буй байгууллагын хувьд МГХ нь аль ч тамирчны уг талбайд байгаа хэрэглэгдэхүүн, үйлчилгээ, байгууламж, давуу тал ба нийцүүлгийг бүрэн бөгөөд тэгш эдлэх боломжийг хязгаарлах, ялгаварлах ёсгүй гэж үзжээ. Нэгэнт МГХ-ны цуврал тэмцээнүүд болдог талбай нь олон нийтэд зориулагдсан газар тул тухайн үйл ажиллагааны мөн чанарыг тэр чигээр нь өөрчлөх шаардлага гараагүй л бол МГХ нь Мартины хүсэлтийг хүлээн авч, нийцүүлэг хийх ёстой гэж Дээд шүүх үзсэн байна. Гольфын тоглоомын мөн чанар нь цохилт хийх явдал тул Мартинд гольфын тэргэнцэр ашиглуулах нь тухайн үйл ажиллагааны мөн чанарт нөлөөлөхгүй гэж Дээд шүүх дүгнэжээ.<sup>11</sup>

#### **АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ**

Аялал жуулчлал нь дэлхийн хамгийн том салбар юм. Зөвхөн АНУ-д жил бүр 42 сая хөгжлийн бэрхшээлтэй аялагч 31,7 сая удаа аялдаг ажээ. Тэд жил бүр 13,6 тэрбум доллар зарцуулж үүнээс 3,3 тэрбум долларыг нислэгийн тийзэнд, 4,2 тэрбум долларыг зочид буудалд, 2,7 тэрбум долларыг хоол унданд зарцуулдаг байна.<sup>12</sup> Хариуцлагатай аялал жуулчлал, хөгжлийн

11 Иргэн Мартин “МГХ-ны цуврал тэмцээн” компанийн эсрэг, *S32 U. S. 661, 121 S. Ct 1879 (2001)*  
12 Рейнс, Скотт Пол. “Дэлхий даяар хүртээмжтэй аялал жуулчлалын үйлчилгээг хөгжүүлэх нь”.  
2005 оны 5 дугаар сарын 16. [http://www.suite101.com/article.cfm/travel\\_with\\_disabilities/115976/3](http://www.suite101.com/article.cfm/travel_with_disabilities/115976/3)



бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хүндэтгэдэг аялал жуулчлал нь төслүүдээ төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тэгш хамруулахад анхаарах ёстой. Хамгийн чухал нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд ийм үйл явцад оролцож, аялал жуулчлалын үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн ажил явуулах ёстой. Аялал жуулчлалын салбарыг шууд дурьдсан олон улсын хүний эрхийн цорын ганц томоохон эрхзүйн акт болох ХБХЭК нь Оролцогч улсуудаасаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн аялан жуулчлах эрх, аялал жуулчлалын үйлчилгээ хүртэх эрхийг хүндэтгэн хандахыг шаарджээ.

### Хөгжлийн бэрхшээлтэй жуулчдад тохиолддог саад тотгор

- Онгоцны буудлуудын шилжин суух зорчигчдод зориулсан хэсэг нь хүртээмж муутай, нисэх буудлын ажилтнууд бэлтгэлгүй;
- Хүртээмжтэй тээврийн хэрэгсэл байхгүй;
- Хүртээмжтэй зочид буудлын өрөө байхгүй;
- Мэргэжлийн ажилтнууд нь хүртээмжтэй байдалтай холбоотой мэдээлэл, зөвлөгөө өгөх талаар бэлтгэлгүй;
- Үзвэрийн газруудын хүртээмжтэй байдлын талаарх мэдээлэл хомс (музей, шилтгээн, үзэсгэлэн гэх мэт);
- Ресторан болон олон нийтийн газрын бие засах өрөөнүүд нь нийцүүлэг, тохируулга хийгдээгүй;
- Ресторан болон жуулчдын үзвэрийн газрууд нь хүртээмжгүй;
- Гудамжаар зорчих боломжгүй (явган хүний замаас машин зам руу буух налуу хэсэг байхгүй, эсвэл нэвтрэх газрыг нь автомашин таглан зогссон байх гэх мэт);
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан төхөөрөмж (тэргэнцэр, ванны сандал, бие засах газрын өргөгч, цахилгаан тэргэнцэр) хөлслүүлэх үйлчилгээ байхгүй.

### ДАСГАЛ 14.5: Аялал жуулчлалын хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэхийн төлөө дуу хоолойгоо өргөх нь

- Зорилт:** Аялал жуулчлалын үйлчилгээн дэх ялгаварлан гадуурхалд дүн шинжилгээ хийж, үүний эсрэг ямар арга хэмжээ авч болохыг хэлэлцэх
- Хугацаа:** 60 минут
- Хэрэглэгдэхүүн:** Том цаас, фломастер эсвэл самбар, шохой

#### 1. Жагсаалт гаргах

Аялал жуулчлалын салбарт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхах, тэдэнд саад учруулах ямар тотгор, бэрхшээлүүд байгааг бодоод жагсаалт болгож бичихийг оролцогчдоос хүс.

## 2. Төлөвлөх

Оролцогчдыг жижиг багуудад хуваана. Баг болгон доорх жагсаалтаас нэг асуудлыг сонгон авч ажиллана. Асуудлаа сонгуулаад, дараах зааврыг өгнө:

- А. Аялал жуулчлалын салбарын ажилтан, төлөөлөгч болон олон нийтийн төлөөллөөс бүрдсэн зохиомол “Аялал жуулчлалыг хөгжүүлэх зөвлөл”- д зориулан 5 минутын илтгэл хийхээр бэлд.
- Б. Баг бүр илтгэгчээ томилохоос гадна “Аялал жуулчлалыг хөгжүүлэх зөвлөл”-д суух нэг хүнийг сонгоно.
- В. Багууд илтгэлээ бэлдэж байх хооронд “Аялал жуулчлалыг хөгжүүлэх зөвлөл”-ийн гишүүд тусдаа уулзаж хүн бүр ямар дүрд тоглохоо тохирно (Эдгээр дүр нь тухайн орон нутгийнхны дунд байдаг эерэг болон сөрөг хандлагуудын аль алиныг нь илэрхийлэх ёстой).
- Г. Танилцуулгадаа:
  - Ялгаварлан гадуурхал нь хэнд нөлөөлж буй, ямар шалтгаантай зэргийг тайлбарла.
  - Ялгаварлан гадуурхал нь ХБХЭК-д заасан ямар эрхийг хөндөж байгааг тайлбарла.
  - Ялгаварлан гадуурхал нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралд хэрхэн нөлөөлж байгааг тайлбарла.
  - Тухайн асуудлыг гаргаж тавьснаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдрал хэрхэн сайжрахыг тайлбарла.
  - Тухайн асуудлыг шийдвэрлэхийн тулд авах тодорхой арга хэмжээ, дараагийн алхмыг санал болго.

## 3. Дүрд тоглох/хэлэлцэх

Баг бүрээс нэг хүн “Аялал жуулчлалыг хөгжүүлэх зөвлөл”-д илтгэлээ тавина. “Зөвлөлийн” гишүүдээс өөрийн сонгосон дүрийн дагуу хариулт өгөхийг хүс. Илтгэл бүрийн дараа нийт оролцогчдоос асуулт, санал, эсрэг санал байгаа эсэхийг асуу.

## 4. Дүгнэлт гаргах

Дараахтай төстэй асуулт асууж энэ дасгалыг дүгнэ:

- Асуудлыг танилцуулж байхад илтгэгчид ямар сэтгэгдэл төрж байсан бэ?
- “Зөвлөл” ямар байдлаар хандсан бэ? Ямар хандлага, ямар саадыг илэрхийлж байв?
- Тухайн асуудлууд хүний эрхтэй холбоотой байв уу?
- Тухайн асуудлыг шийдвэрлэхээр санал болгосон арга зам нь танай орон нутагт хэрэгжүүлж болох зүйл мөн үү? Тийм бол яагаад, үгүй бол яагаад
- Бодит амьдрал дээр уг асуудлыг шийдвэрлэхийн тулд хийх дараагийн алхам юу байх байсан бэ?

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН АСУУДЛААРХ НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БА  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалан идэвхтэй тэмцэгчдийн дунд хүртээмжтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх хөдөлгөөн хүчээ авч байна. Олон шинэлэг стратегийг амжилттай хэрэгжүүлсний үр дүнд аялал жуулчлал хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нээлттэй болж байна:



- Баруун Австралийн Перт хотод “Конвенцийн хороо” холбооноос “Хүртээмжээс цааш” нэртэй хөтөлбөр хэрэгжүүлж байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд уг хороо нь зочид буудлуудад төрөл бүрийн хурал, зөвлөгөөний оролцогчдыг байршуулах ажилд зуучлан зохион байгуулалтын туслалцаа үзүүлдэг бөгөөд зочид буудлууд нь энэ үйл ажиллагаанаас олсон ашгийнхаа 10-15 хувийг буудлынхаа хүртээмжтэй байдлыг сайжруулахад зарцуулах үүрэгтэй ажээ.
- Австралийн Тасмани мужид аялал жуулчлалын нэгэн бүлэг тус арлын аялал жуулчлалын долоон бүсэд хэд хэдэн үл хөдлөх хөрөнгө худалдаж авчээ. Эзэмшил газар бүр нь тэргэнцэртэй хүн зорчих бүхий л боломжийг бүрдүүлсэн байна. Тус бүс нутгаар аялах хүмүүст үйлчлэх автобусууд бүгд тэргэнцэр оруулахад зориулсан өргөгчтэй бөгөөд үүний дүнд тус арал бүхэлдээ хөгжлийн бэрхшээлтэй аялагчдад нээлттэй болжээ.
- Канарын арлуудын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах нэгэн байгууллага Канарын арлуудын хөгжлийн бэрхшээлтэй оршин суугчдад зориулсан үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж чаджээ Уг байгууллага нь аялал жуулчлалын бизнес эрхлэгчидтэй зөвшилцөх, Тенериф хавийн хүртээмжтэй байдлыг үнэлсэн лавлах гаргах, хөгжлийн бэрхшээлтэй жуулчдад зориулсан маш өндөр түвшний интернет мэдээллийн сурвалж боловсруулан гаргах зэрэг ажлыг амжилттай хэрэгжүүлсэн юм.
- Роүд Айланд мужийн Дизайны сургуулийн уран барилгын ангийн багш, оюутнууд хамтран байгаль орчинд халгүй “ногоон” барилгын технологийг барилгын хүртээмжтэй байдалтай хослуулан АНУ-ын Виржиний арлууд дээр хүртээмжтэй эко-амралт байгуулж байгаа ажээ. Конкордиа эзэмшил хэмээн нэрлэгдсэн энэхүү амралтын газар нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст унаган байгальд ойртох боломжийг нээж өгч байна. Хавайн арлуудын зарим зочид буудал зочиддоо хүртээмжтэй тохилог өрөө санал болгоод зогсохгүй хооллох болон чөлөөт цагаа өнгөрөөх хүртээмжтэй газруудын талаар зөвлөгөө өгч, далайн эргээр аялахад зориулсан тусгай тэргэнцэр хөлслөхөд тусалж, далайн эргийг бүх хүн бүрэн нэвтрэх боломжтой газар болгож байна.<sup>13</sup>
- Коста Рикад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах байгууллага, засгийн газартайгаа хамтран халуун орны ширэнгэн ойн гайхамшигт газруудад хүрэх боломжийг нэмэгдүүлэх зорилготой хүртээмжтэй байдлын протоколыг боловсруулсан байна (Хайрцагт өгсөн мэдээллийг үзнэ үү).

Дээрх жишээнүүдээс харахад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалдаг нөлөөллийн байгууллагуудын санал санаачилгагүйгээр аялал жуулчлалыг бүх нийтийн хүртээл болгох зорилго хэрэгжиж чадахгүй юм.

13 Рейнс, Скотт Пол. “Дэлхий даяар хүртээмжтэй аялал жуулчлалын үйлчилгээг хөгжүүлэх нь”. 2005 оны 5 дугаар сарын 16.  
[http://www.suite101.com/article.cfm/travel\\_with\\_disabilities/115976/3](http://www.suite101.com/article.cfm/travel_with_disabilities/115976/3)

### Коста Рикагийн үндэсний паркуудад нэвтрэх боломж

Коста Рика улс нь үндэсний паркуудаа хөгжүүлэх төлөвлөгөөндөө тэгш хамрагдалтын зарчмуудыг суулгаж өгч чадсан бөгөөд үүний үр дүнд “Дархан цаазат газруудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нэвтрэх боломжийг хангах протокол” нэртэй баримт бичиг боловсруулан, хэрэгжүүлж байна. Уг баримт бичгийг гаргахдаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өөрсдийнх нь хийсэн өргөн хүрээтэй олон судалгаа, тэдний идэвхтэй оролцоог дайчлан ашиглажээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд холбогдох яамдтай хамтран хамгаалалттай газруудад нэвтрэхэд саад болж буй зүйлсийг тодорхойлж, чөлөөтэй нэвтрүүлэх төлөвлөгөө хийжээ. Уг төслийг удирдан хэрэгжүүлсэн Байгаль орчин, эрчим хүчний яам нь Хөгжлийн бэрхшээлийн асуудал хариуцсан хороо байгуулан, хөгжлийн бэрхшээлийн тухай үндэсний хуульд тусгасан шаардлагад нийцүүлэн хөгжлийн бэрхшээлийн тухай бодлого боловсруулсан байна.<sup>14</sup>

#### **ДАСГАЛ 14.5: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн соёлын амьдралд оролцох, амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх, спортоор хичээллэх эрхийг дэмжих чин эрмэлзэлтэй байх**

- Хүний эрх нь эдлэх эрх, хүлээх үүрэг хоёрын нэгдэл гэдгийг тайлбарла
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн соёлын амьдрал, амралт, чөлөөт цаг, спортын үйл ажиллагаанд хамрагдах эрхийг судалж ойлгосны эцэст өөрсдөө үйл ажиллагаа явуулах, тодорхой арга хэмжээ авахад бэлэн болсон эсэхийг оролцогчдоос асуу.
- Мэдээлэл цуглуулах, ажлаа төлөвлөх гээд хийх зүйл их байгаа ч өөрчлөлт хийх чин эрмэлзэл маш чухал гэдгийг тэмдэглэн хэл.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст соёлын амьдрал, амралт, чөлөөт цаг, спортын үйл ажиллагаанд оролцох эрхээ бүрэн эдлэхэд нь нэмэр болох жижиг ч хамаагүй ямар ажлыг ирэх сард хийхийг хүсэж байгаа, хийх боломжтой байгааг оролцогч бүрээр хэлүүл.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах нөлөөллийн ажил хэрхэн төлөвлөх талаар энэ гарын авлагын “Нөлөөлөл.Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа” нэртэй Хэсэг 3 (хуудас 278)-аас уншина уу.

14 Эх сурвалж: Гатьенс, Луис Фернандо Асторга. “Коста Рика Улс нь дархан цаазат газруудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх протоколыг санаачлан туршиж байна”, 2003. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ертөнц, [http://www.disabilityworld.org/01-03\\_03/access/costarica.shtml](http://www.disabilityworld.org/01-03_03/access/costarica.shtml)



СОЁЛЫН АМЬДРАЛ, СПОРТ, ЧӨЛӨӨТ ЦАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ ТУХАЙ  
НЭМЭЛТ МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

- “Зохицуулттай спорт” сан:  
<http://www.adaptivesportsfoundation.org>
- Зүүнхөйд мужийн Их сургуулийн дэргэдэх “Нийгэм ба спорт” судалгааны төвийн  
“Хөгжлийн бэрхшээл ба спорт” хөтөлбөр:  
<http://www.sportsinsociety.org/vpd/dis.php>
- Сонсголгүй хүмүүсийн спортын олон улсын хороо:  
<http://www.deaflympics.com>
- Олон улсын Параолимпийн хороо: <http://www.paralympic.org>
- Жон Ф. Кеннедийн нэрэмжит Урлагийн төв:  
<http://www.kennedy-center.org>
- Урлаг ба хөгжлийн бэрхшээлийн үндэсний төв: <http://www.nadc.ucla.edu>
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн урлаг соёлын нийгэмлэг:  
<http://www.s4dac.org>
- Тусгай олимп: <http://www.specialolympics.org>
- АНУ-ын хараагүй тамирчдын холбоо: <http://www.usaba.org>
- VSA урлаг: <http://www.vsarts.org>

## БҮЛЭГ 15: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮДИЙН ЭРХ

### НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци

#### Удиртгал

(r) Хүүхдийн эрхийн конвенцид оролцогч улсуудын хүлээсэн үүргийг эргэн санахын хамт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нь бусад хүүхдийн нэгэн адил хүний эрх, үндсэн эрх чөлөөгөө бүрэн дүүрэн эдлэх учиртайг хүлээн зөвшөөрнө.

#### 3 дугаар зүйл. Нийтлэг зарчмууд

Энэхүү конвенцийн зарчмууд нь:

- a) сонголт хийх эрх чөлөө болон хүний бие даасан байдлыг оролцуулан хүний нэр төр, нандин чанар, хувийн хараат бус байдлыг хүндэтгэх;
- b) алагчлахгүй байх;
- c) нийгэмд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох болон хамрагдах;
- d) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлог байдлыг хүндэтгэх, тэднийг хүний ялгаатай байдал, хүн төрөлхтний нэг хэсэг гэж хүлээн авах;
- e) тэгш боломж олгох;
- f) хүртээмжтэй байх;
- g) эрэгтэй, эмэгтэйчүүд тэгш эрхтэй байх;
- h) хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьсаж өөрчлөгдөх чадамжийг хүндэтгэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өөрийн онцлог байдлаа хадгалах эрхийг хүндэтгэн хандах.

#### 4 дүгээр зүйл. Нийтлэг үүргүүд

Энэхүү конвенцийг хэрэгжүүлэхэд чиглэсэн хууль тогтоомж, бодлого хөтөлбөрийг боловсруулж мөрдөх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой бусад шийдвэрийг гаргахдаа оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй зөвлөлдөх бөгөөд тэднийг төлөөлөх байгууллагаар дамжуулан тэднийг идэвхтэй оролцуулна.

#### 7 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд

1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд бусад хүүхдийн нэгэн адил хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлүүлэх явдлыг хангах бүхий л шаардлагатай арга хэмжээ авна.
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэхдээ хүүхдийн ашиг сонирхлыг нэн түрүүн харгалзан үзнэ.
3. Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд бусад хүүхдийн нэгэн адил нь өөрсдийн нас болон биеийн онцлогт тохирсон байдлаар өөрт нь хамаарах аливаа асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг эдлүүлэх бөгөөд энэхүү эрхээ эдлэхэд нь хөгжлийн бэрхшээл болон насны онцлогт тохирсон туслалцаа үзүүлэх явдлыг хангана.



## ЗОРИЛТУУД

Энэ бүлгийн сэдэв, үндсэн мэдээлэл, дасгалууд нь оролцогчдод дараах зорилтыг хангахад туслах зорилготой:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ялгаварлан гадуурхах нь хүний эрхийн асуудал болохыг ойлгох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрх болон бусад эрхийн хоорондын уялдааг ойлгох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрх хэрхэн хангагдаж эсвэл зөрчигдөж байгааг мэддэг болох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд өөрсөдтэй нь хамааралтай асуудлаар санал бодлоо нэмэрлэх боломж олгохын ач холбогдлыг тайлбарлах;
- **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенци (ХБХЭК)** дахь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрхийн тухай заалтуудыг ойлгож, хэрэгжүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрхийг улам баталгаажуулах стратегиудыг судлах.

## ЭХЛЭЛ: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮДИЙН ЭРХИЙН ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЭХ НЬ

Хүүхдүүд бол бүхэлдээ анхаарлын гадуур үлдэх гээд байдаг нийгмийн бүлэг юм. Гэхдээ охид, хөгжлийн бэрхшээлтэй юмуу үндэсний цөөнх зэрэг зарим бүлгийн хүүхдүүд илүү их ялгаварлан гадуурхалд өртдөг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд 1) хөгжлийн бэрхшээлтэй учраас, 2) хүүхэд учраас алагчлалд өртөх бүр ч илүү магадлалтай тул ялгаварлан гадуурхал, мөлжлөг, доромжлолд өртөх маш өндөр эрсдэлтэй бүлэг юм. Хүний эрхийн баримт бичгүүдэд нийгмийн эдгээр бүлгийг тусгайлан дурьдагдаагүй л бол тэд хүүхдийн эрхийг хамгаалах нийтлэг гэрээ конвенци, түүний дотор **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци (ХБХЭК)**-иар хангаж өгсөн хамгаалалт, баталгааны гадна үлддэг. Чухам энэ шалтгааны улмаас ХБХЭК-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлыг тусгай зүйл болгож оруулсан юм. Тэдний хувьд эрхийг нь баталгаажуулах, ялангуяа эрүүл байх, амьд явах болон хүрэлцэхүйц түвшний амьжиргаагаар хангагдах эрхийг нь бусад бүх хүүхэдтэй адил тэгш байх зарчмын үндсэн дээр баталгаажуулах явдал амин чухал юм.

*Дэлхий дээр ойролцоогоор 150 сая орчим хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд амьдарч байна. Тэдний 80 гаруй хувь нь хөгжиж буй оронд амьдарч, боловсрол болон бусад үйлчилгээ огт хүртэж чадахгүй, эсвэл маш бага хүртэж байгаа билээ.<sup>1</sup>*

1 1 Хүүхдийн эрхийн хороо, ерөнхий зөвлөмж №9: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрх. 2006 оны 9 дүгээр сарын 29. НҮБ-ын баримт бичиг. CRC/C/GC/9 <http://www.ohchr.org/English/bodies/crc/docs/co/CRC/C/GC.9.doc>

Хувийн зан чанар, хүйс, анги, гарал үүсэл, соёл, шашин, чадвар/хөгжлийн бэрхшээл, нийгэм-эдийн засгийн нөхцөл, байршил, гэр бүлийн нөхцөл, амьдарч буй орчин, боловсрол, ажил, бэлгийн чиг хандлага зэрэг маш олон хүчин зүйл, туршлага нь хүний хүүхэд насыг “бүрдүүлдэг”. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суурь эрх, эрх чөлөөг баталгаажуулахдаа эдгээрийг анхаарах шаардлагатай.

### **Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд тулгардаг саад, бэрхшээл**

#### **Төрөхийн өмнө**

- Эхийн эрүүл мэнд, хоол тэжээл муу байх
- Ядуурал
- Жирэмсний үеийн тусламж үйлчилгээ хангалтгүй
- Жирэмсний үеийн үзлэгийн дүнгээр жирэмслэлтийг таслах эрсдэл

#### **Төрөх үед**

- Эвтанази (үхүүлэх)
- Шаардлагатай эмчилгээ хийхээс татгалзах
- Эцэг эх нь хүлээж авахгүй байх
- Хүүхэд асрах газарт шилжүүлэх

#### **Төрсний дараа**

- Хүүхэд асрах газарт шилжүүлэх
- Гэрт нь хорих, олон нийтээс тусгаарлах
- Боловсрол эзэмших болон бусад эрхийг нь хэрэгжүүлэхгүй байх
- Эмчилгээ (өвтгөх, мөн шаардлагагүй эмчилгээ зэрэг) үргэлжлүүлэн хийгдэх эрсдэл
- Амьдралд нь нөлөөлөх шийдвэр гаргахад оролцох эрхийг нь хязгаарлах

### **ДАСГАЛ 15.1: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн ямар эрхийг хангаж өгч байна вэ?**

**Зорилт:** ХБХЭК-д заасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрхийг судалж, ойлгох

**Хугацаа:** 30 минут

**Хэрэглэгдэхүүн:** Том цаас, фломастер эсвэл самбар, шохой

#### **1. Бататгах**

Оролцогчдыг жижиг багуудад хуваа. Баг бүрт ХБХЭК-ийн удиртгал хэсэг, 3, 4, 7 дугаар зүйлийг хувилж өг. Багууд нь эдгээр зүйл заалтыг энгийн үг хэллэгээр өөрчлөн найруулж бичээд, тухайн эрхийг хэрхэн эдлүүлж хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн амьдралыг өөрчилж болохыг харуулсан жишээ гаргана.



## 2. Энгийн үг хэллэгээр найруулах

ХБХЭК-ийн дээр дурьдсан хэсгүүдийг чангаар уншиж өгнө. Параграф юмуу өгүүлбэр бүрийн төгсгөлд зогсож, тухайн хэсгийг багууд энгийн үг хэллэгээр хэрхэн өөрчлөн найруулсныг сонсоно. Бүгд санал нэгтэй зөвшөөрсөн нэг хувилбар гарч иртэл найруулгыг нийтээрээ хэлэлц. Эцсийн хувилбарыг том цаасан дээр бичнэ.

## 3. Жишээ гаргах

Тухайн эрхийг хэрхэн эдэлж, үүний үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амьдралд ямар өөрчлөлт гарахыг харуулсан жишээг оролцогчдоор гаргуул.

## 4. Хэлэлцэх

ХБХЭК-ийн эдгээр зүйл заалтыг нийгэмдээ эерэг өөрчлөлт авчрах, эсвэл үндэсний бодлого юмуу орон нутгийн шийдвэрт нөлөөлөх зорилгоор хэрхэн ашиглаж болох вэ?

### Хүүхдийн эрх, эрх чөлөөг хангах нь

Хүүхэд эрх, эрх чөлөөгөө эдлэх боломж нь хоорондоо уялдаатай олон хүчин зүйлээс хамаардаг. Дараах хүчин зүйл нь тодорхой соёлын орчин, амьдралын нөхцөлд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд гадуурхагдахад хүргэж мэднэ:

- **Үл тэвчих, үл хайхрах хандлага:** сөрөг хандлага, буруу итгэл үнэмшил нь бүх соёл, амьдралын нөхцөлд хамгийн гол саад болсоор байна.
- **Хүйс:** хөгжлийн бэрхшээлтэй охидын хувьд амь насаа алдах, хаягдах, ялгаварлан гадуурхагдах, боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байх, гэрлэх боломжгүй хэмээн тооцогдох, эх болох боломжоо алдах, нийгмийнхээ амьдралд оролцож чадахгүй байх зэрэг эрсдэл хамаагүй өндөр байдаг.
- **Ядуурал:** наад захын нөөц, эх сурвалжуудыг хүртэх боломж хязгаарлагдмал газарт хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй айл өрхүүд хамгийн ядуу байх, гадуурхагдан үлдэх явдал элбэг байдаг. Хэдийгээр хамгийн ядуу айл өрх ч эхэндээ хүүхдүүдээ асрамжлан хамгаалахыг оролддог ч тэд сөрөг итгэл үнэмшил болон мэдээлэл, мэдлэг, ур чадвар, нөөцийн хомсдлоос үүдэлтэй ядуурал, гадуурхлаас гарч чадахгүй гацаж орхидог.
- **Онцгой нөхцөл:** байгалийн гамшиг, зэвсэгт мөргөлдөөн болон дүрвэгсдийн хуаран зэрэг хүнд нөхцөлд байгаа хүүхдүүд гадуурхалд илүү өртөмтгий байдаг.

ХБХЭК болон **Хүүхдийн эрхийн конвенци** (ХЭК) нь хүүхдийн эрхийг баталгаажуулсан эрхзүйн хүрээний үндэс суурь болдог ч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд эдгээр эрхээ эдлэхэд нь маш олон хүчин зүйл нөлөөлдөг:

- бусад хүмүүсийн (эцэг эх, багш, хөршүүд, бусад хүүхдүүд) тэдэнд хандах хандлага, зан үйл;
- наад захын хэрэгцээ нь хангагдсан эсэх (амьд явах, хоол хүнс, орон байр, урам зориг гэх мэт);
- тэднийг хамруулсан болон гадуурхан орхигдуулсан олон улсын болон үндэсний бодлогууд;
- дэд бүтцийн хүртээмжтэй байдал (гэр орон, сургууль, олон нийтийн гэх мэт);
- тэдний бие бялдрын, нийгмийн, оюун санааны, харилцааны болон хувь хүнийх нь хөгжлийг хангахад чиглэсэн дэмжлэг туслалцаа хүртэх боломж (үндсэн тоног төхөөрөмж, туслалцаа, эрүүл мэнд болон боловсролын үйлчилгээ, бага насны хүүхдэд зориулсан халамж, боловсролын үйлчилгээний хүртээмж).

## Хүүхэд төвтэй хандлагад суурилсан хүүхдийн эрхийн хөтөлбөр

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бусад бүх хүүхдийн нэгэн адил өөрсдийнхөө амьдралд нөлөөлөх шийдвэрүүдэд идэвхтэй оролцох эрхтэй гэдгийг мартаж болохгүй. Хүүхдийн эрхийн төсөл, хөтөлбөрүүдэд хүүхэд төвтэй хандлагыг ашиглахдаа дараах чухал хүчин зүйлсийг анхаарах нь зүйтэй:

- Хүүхдүүдийн **ашиг сонирхолд хамгийн ихээр нийцсэн** байх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн санал бодлыг **сонсох**
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хэрэгцээ болон үзэл бодлын талаарх **өөрийн болон бусдын** төсөөллүүдийг өөрчлөх
  - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн юу хийж чадах, юу хийж чадахгүй талаар таамаглал бүү дэвшүүл
  - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хэрэгцээ, үзэл бодлын талаар таамаглал бүү дэвшүүл (өөрсдөөс нь асуу!)
- **Ялгаатай байдлыг хүндэтгэх**
  - Хөгжлийн бэрхшээл болон чадавхи нь хоорондоо ялгаатай зүйл болохыг ойлгох
  - Тухайн хүүхдийн чадвар, чадамжийг хөгжүүлэх зорилт тавьж ажиллах
- **Хүүхдийг бүхэлд нь авч үзэх**, түүний хөгжил, хэрэгцээг бүхэлд нь анхаарч үзэх
- Тухайн хүүхдийн нөхцөл байдлыг бүхэлд нь буюу гэр орон, амьдралын орчин зэргийг хамруулсан илүү өргөн хүрээгээр харж **дүн шинжилгээ хийх**
- **Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд** бол шийдвэр гаргах үйл явцад оролцох ёстой **“тодорхой үүрэг рольтой нийгмийн этгээд”** мөн гэж харах

## ДАСГАЛ 15.2: Хүүхэд насны талаарх ялгаатай хандлага, тогтсон ойлголт, үзэл бодлууд

<b>Зорилт:</b>	Хүүхэд насны талаарх янз бүрийн хандлага, тогтсон ойлголт, үзэл бодлуудыг тодорхойлох
<b>Хугацаа:</b>	40 минут
<b>Хэрэглэгдэхүүн:</b>	Тараах материал, том цаас, фломастер эсвэл самбар, шохой

### 1. Эргэцүүлэх/шинжлэх

Оролцогчдыг жижиг багуудад хуваагаад, “Тараах материал 15.2”-ын 1 ба 2 дахь баганы асуултуудыг хэлэлцэх даалгавар өг.

- Танай улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, тэдний хүүхэд насны талаар ямар ямар **сөрөг итгэл үнэмшил**, хандлага байдаг вэ? Хамгийн өргөн дэлгэрсэн таван жишээг нэрлэ.
- Танай улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, тэдний хүүхэд насыг дэмжсэн ямар **эерэг итгэл үнэмшил**, хандлага байдаг вэ? Тэдгээрээс хамгийн өргөн дэлгэрсэн таван жишээг нэрлэ.
- Багууд “Тараах материал 15.2”-т өгсөн хүснэгтийг том цаасан дээр хуулаад, түүн дээрээ багийн хариултуудаа бичнэ.





- 1 ба 2 дахь баганы асуултуудыг хэлэлцсэний дараа 3 дахь баганы асуултыг хэлэлцэх даалгавар өгнө.
- Хэрэв хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн санаа бодлыг сонсох юм бол, тэдэнд хандсан боломж, хөтөлбөрүүд (бүх хүүхдэд зориулсан хөтөлбөр болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан тусгай хөтөлбөр)-ийн талаар тэд ямар бодол, дүгнэлт, шүүмжлэлтэй байх бол? Эерэг болон сөрөг итгэл үнэмшил (1 ба 2 дахь багана) нь тэдний боломжуудад ямар нөлөө үзүүлдэг вэ?
- Багууд хариултаа бичсэн том цааснуудаа ханан дээр байрлуулна. Оролцогчдыг ерөөн дотуур явж багуудын өгсөн хариултуудыг уншин, ижил төстэй болон ялгаатай хариултуудад анхаарлаа хандуулахыг хүс.

## 2. Хэлэлцэх

Бүх оролцогчдыг байрандаа эргэж суугаад, төрсөн сэтгэгдлээ хуваалцахыг хүс. Үүний дараа хичээлээ тоймлон Тараах материал 15.2-ын зарим гол санааг давт.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн чадварын ялгаатай түвшнүүд эдгээр итгэл үнэмшил, үзэл бодлуудад хэрхэн нөлөөлдөг вэ (харааны, сэтгэц-нийгмийн болон хавсарсан бэрхшээлтэй хүүхдүүд гэх мэт)?
- Хүүхдүүдийн нас ямар нөлөөтэй вэ (бага насны хүүхэд, өсвөр үеийнхэн, залуучууд гэх мэт)?
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хүйс ямар нөлөө үзүүлэх вэ?
- Хувь хүмүүс/нийгэм өөрөө энэхүү дарангуйлал/гадуурхлын циклийг хэрхэн улам лавшруулдаг вэ? Соёлоос үүдэлтэй хүлээлт, төсөөлөл нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд ямар нөлөө үзүүлдэг вэ?
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаарх өөрийнхөө төсөөллийг эргэн хараад хүүхэд төвтэй хандлагыг бид хэрхэн дэмжиж болох тухай ярилц (хүүхдүүдийн санаа бодлыг сонсох, шийдвэр гаргах үйл явцад тэднийг идэвхтэй оролцуулах гэх мэт)?
- Тусгай төсөл, хөтөлбөрүүдийн тусламжтайгаар энэхүү циклийг хэрхэн эвдэж, өөрчилж болох вэ?

### Тараах материал 15.2

<p>Танай улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, тэдний хүүхэд насны талаар ямар сөрөг итгэл үнэмшил, хандлага, үзэл баримтлал байдаг вэ? Эдгээрээс хамгийн өргөн дэлгэрсэн таван жишээг нэрлэ.</p>	<p>Танай улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, тэдний хүүхэд насыг дэмжсэн ямар эерэг ойлголт, хандлага, үзэл баримтлал байдаг вэ? Эдгээрээс хамгийн өргөн дэлгэрсэн таван жишээг нэрлэ.</p>	<p>Хэрэв хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн санаа бодлыг сонсох юм бол, тэдэнд хандсан боломж, хөтөлбөрүүд (бүх хүүхдэд зориулсан хөтөлбөр болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан тусгай хөтөлбөр)-ийн талаар тэд ямар бодол, дүгнэлт, шүүмжлэлтэй байх бол? Эерэг болон сөрөг итгэл үнэмшилүүд (1 ба 2-р багана) нь тэдний боломжуудад ямар нөлөө үзүүлдэг вэ?</p>

## ХҮНИЙ ЭРХИЙН ЭРХЗҮЙД ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮДИЙН ЭРХИЙН ТАЛААР ЮУ ГЭЖ ЗААСАН БАЙДАГ ВЭ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрх нь олон улсын эрхзүйн баримт бичгүүдэд тодорхой туссан байдаг. **Хүний эрхийн түгээмэл тунхаглалын (ХЭТТ)<sup>2</sup> 25 дугаар зүйл, Хүүхдийн эрхийн конвенци (ХЭК)<sup>3</sup>, 1993 онд баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боломжийг тэгшитгэх тухай НҮБ-ын стандарт дүрмүүдэд (Стандарт дүрэм)<sup>4</sup> хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрхийн тухай заалтууд багтжээ.**

1948 онд батлагдсан **Хүний эрхийн түгээмэл тунхаглалын (ХЭТТ) 25, 26 дугаар зүйлд** хүүхдэд холбоотой заалтууд оржээ. 25 дугаар зүйлд эх, нялхас онцгой асрамж, туслалцаа авах эрхтэй бөгөөд баталгаатай гэр бүлд төрсөн эсэхээс үл хамааран бүх хүүхэд нийгмийн хамгааллыг ижил тэгш хүртэх ёстой гэж заасан байдаг. 26 дугаар зүйлд хүн бүр сурч боловсрох тэгш боломжоор хангагдсан байх ёстой гэж заагаад, хүүхэддээ ямар төрлийн боловсрол эзэмшүүлэхээ сонгоход эцэг эх давуу эрхтэй байна гэжээ.

1989 онд батлагдсанаасаа хойш хамгийн олон улс оронд соёрхон батлагдаад байгаа олон улсын хүний эрхийн баримт бичиг болох ХЭК (зөвхөн АНУ, Сомали улсууд нэгдээгүй) нь ХБХЭК-д хүлээн зөвшөөрсөн олон эрхийг тодорхойлж өгснөөрөө эдгээр эрхийн үндэс суурь болдог. ХЭК нь хүүхдийн эрхийн ерөнхий хүрээг тогтоож өгөхийн хажуугаар 2 болон 23 дугаар зүйлдээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрхийг тусгайлан тодорхойлж өгсөн байдаг. Гэхдээ ХЭК-ийн бүх заалтад орсон “хүүхэд” гэсэн нэр томьёо нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ч мөн хамааралтай гэдгийг мартаж болохгүй. Энэ баримтлал бол “эрхэд суурилсан хандлага”-ыг ойлгоход бидэнд тусалсан сэтгэлгээний томоохон өөрчлөлт мөн бөгөөд улмаар бүх хүүхдийн хэрэгцээг хангах нь төр, засгийн үүрэг болохыг тодотгосон хэрэг юм. ХЭК нь хүүхдийг эцэг эхийн өмч юмуу эсвэл зүгээр л халамж хүртэгч хэмээн үзэхийн оронд өөрийн насанд тохирсон эрх, хариуцлага хүлээгч гэсэн шинэ ойлголтыг бий болгож байна.

ХЭК-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хамааралтай тусгай заалтууд оржээ. 2.1 дүгээр зүйлд хүүхдийг хөгжлийн бэрхшээл болон бусад шалтгаанаар ялгаварлан гадуурхахыг хориглосон бол 23 дугаар зүйлд онцгой халамж, боловсрол, сургалтанд хамрагдах эрхтэйг зааж өгсөн байдаг. Хүүхдийн эрх нь хүүхдийн амьдралд нөлөөлөх үндсэн дөрвөн асуудлыг хөнддөг бөгөөд эдгээр нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд ч мөн адил үйлчилнэ. Эдгээр нь амьд явах эрх, хөгжих эрх, аюул ослоос хамгаалуулах эрх, оролцох эрх зэрэг юм.

- **Амьд явах эрх:** амьдрах болон наад захын хэрэгцээгээ хангуулах эрх (хүрэлцэхүйц түвшний амьжиргаа, орон байр, хоол хүнс, эмчилгээ зэрэг)
- **Хөгжих эрх:** чадавхиа бүрэн дүүрэн хөгжүүлэх эрх (боловсрол эзэмших, тоглох, чөлөөт цагаа өнгөрөөх, соёлын үйл ажиллагаанд оролцох, мэдээлэл олж авах болон чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх зэрэг)
- **Оролцох эрх:** хүүхдүүд болон өсвөр үеийнхэнд нийгэмдээ идэвхтэй үүрэг роль гүйцэтгэх боломж олгосон эрх (үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, өөрсдийнх нь амьдралд нөлөөлөх асуудлуудаар санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, чөлөөтэй

2 <http://www.unhchr.ch/udhr/lang/eng.htm> сайтыг үз.

3 <http://www.ohchr.org/english/law/crc.htm> сайтыг үз.

4 <http://www.ohchr.org/english/law/opportunities.htm> сайтыг үз.

эвлэлдэн нэгдэх зэрэг). Хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэх (12 дугаар зүйл) нь өөрсдийнхөө амьдралд нөлөөлөх асуудлуудаар (хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хэрхэн хандаж байгаа талаар гэх мэт) дуу хоолойгоо хүргэх эрхийг хүүхдүүдэд өгч байгаагаараа чухал ач холбогдолтой заалт юм.

- **Хамгаалуулах эрх:** хүүхдийг түрэмгийлэл, хүчирхийлэл, мөжлөгийн бүхий л хэлбэр, илэрхийллээс хамгаалахад чухал ач холбогдолтой эрх (дүрвэгч хүүхдүүдэд хандсан онцгой халамж, хүүхдийг зэвсэгт мөргөлдөөн, хүүхдийн хөдөлмөр, бэлгийн хүчирхийлэл, тамлан зовоолт, мансууруулах бодисын хэрэглээнээс хамгаалах гэх мэт).

1993 онд батлагдсан **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боломжийг тэгшитгэх тухай НҮБ-ын Стандарт дүрмүүдийн** (Стандарт дүрэм) 2 дугаар дүрэм (Эрүүл мэндийн халамж үйлчилгээ), 6 дугаар дүрэм (Боловсрол), 9 дүгээр дүрэм (Гэр бүлийн амьдрал ба хувь хүний бүрэн бүтэн байдал)-д хүүхэд болон тэдний гэр бүлийнхний эрхийн асуудлууд тусгагджээ.

2 дугаар дүрэмд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, нялхас бусадтай ижил түвшний эрүүл мэндийн халамж, үйлчилгээ авах эрхтэй гэж заажээ. 9 дүгээр дүрэмд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэр бүлдээ амьдрах боломжтой байх ёстой гэжээ. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээл, түүний гэр бүлд үзүүлэх нөлөөний тухай асуудлуудыг тохиромжтой арга хэлбэрээр гэр бүлд зөвлөгөө өгөх хөтөлбөрүүддээ багтаахыг дэмжих үүрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй айл өрхүүдэд байнгын болон тодорхой давтамжтайгаар асрагчийн үйлчилгээг хангаж өгсөн байх шаардлагатай. Боловсролын асуудлыг авч үзсэн 6 дугаар дүрэмд сурч боловсрох эрхийг хангах тухай өгүүлэхдээ ерөнхий боловсролын удирдах байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш хамруулах орчинд боловсрол олгох үүрэгтэйг заахын зэрэгцээ боловсролын үйл явцад эцэг эх, байгууллагуудын идэвхтэй оролцоог дэмжих нь чухал болохыг онцолжээ. Түүнчлэн, хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхдүүд болон давхар гадуурхалд өртөх эрсдэлтэй хүн амын хэсэгт онцгой анхаарал хандуулах шаардлагатай хэвээр байгааг мөн сануулжээ.

Олон улсын эрхзүйн бүх баримт бичиг нь *бүх хүнд*, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй нялхас, хүүхдүүд, өсвөр үеийнхэнд шууд хамааралтай, тэднийг бүгдийг хамгаалах, тэгш боломжоор хангах зорилготой гэдгийг мартаж болохгүй.

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮДИЙН ЭЦЭГ ЭХ, ГЭР БҮЛИЙНХЭН

Хүүхэд нь хөгжлийн бэрхшээлтэй гэдгийг мэдэнгүүтээ эцэг эхчүүд үндэс угсаа, эдийн засгийн боломж, нийгмийн гарал үүслээс үл хамааран бүгдээрээ л сэтгэлээр маш их унадаг. Гэхдээ тэдний итгэл үнэмшил болон тэдэнд байгаа нөөц, дэмжлэгийг харьцуулж үзвэл маш их ялгаа байгаа нь ажиглагддаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асран халамжлах үүргийг түүний гэр бүл, эмээ өвөө, ах дүү нар нь нийгмээс маш бага буюу ямар ч туслалцаагүйгээр гүйцэтгэсээр ирсэн. Шаардлагатай үйлчилгээнүүдийг хүртээмжтэй болгоход чиглэсэн нөлөөллийн ажил явуулахдаа эцэг эхчүүд ХЭК болон ХБХЭК-ээр хангаж өгсөн өөрсдийнхөө болон хүүхдийнхээ эрхийг судалж мэдсэн байх ёстой.

## Гэр бүлд үзүүлэх дэмжлэг

- **Олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх:** Хөгжлийн бэрхшээлтэй холбоотой буруу итгэл үнэмшил, сөрөг ойлголтыг тайлбарлан арилгах;
- **Мэдээлэл, нөөцөөр хангах:** Гэр бүлийн гишүүд, бусад хүүхэд, олон нийтийн мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх;
- **Сэргээх болон нөхөн сэргээх үйлчилгээг хүртээмжтэй болгох:** Хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн үйлчилгээ болон тоног төхөөрөмж, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан тусгай дэмжлэг, үйлчилгээг хүртээмжтэй болгох.

### Нэгэн эхийн яриа

Би хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй. Би мөн хөгжлийн бэрхшээлийн эрт үед дэмжлэг, туслалцаа үзүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн талаар нэлээд сайн мэддэг сайн дурын ажилтан.

Хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх энэ боломжийн талаар (“Нарны туяа” төвийн ЭХЛЭЛ хөтөлбөр) би их сайхан сэтгэгдэлтэй байдаг. Би ч бас энэ орон нутагт амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдэд тусалж, тэдэнд дэмжлэг үзүүлэхийг хүсдэг. Эцэг эхчүүд маань ийм амьдралыг туулаагүй хүмүүст тийм ч амар итгэдэггүй. Тэдэнд бусдаас тусгаарлагдсан, бусад хүмүүс тэдний зовлонг ойшоохгүй байгаа мэт санагддагийг би мэднэ. Тэдний олонх нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийнхээ хэрэгцээг огт ойлгодоггүй учраас гэр бүлийнхнээсээ дэмжлэг авдаггүйг би өөрийн туршлагаар мэдэж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ихэнх аавууд дэмжлэг үзүүлдэггүй. Хүү маань хөгжлийн бэрхшээлтэй гэдгийг хүлээн зөвшөөрөхөд миний нөхөрт маш хүнд байсан. Хүүгээ олны дунд битгий дагуулж явж бай гэж надад хэлдэг байсан. Ийм хүүхдийн гоо сайхныг бусад хүмүүс олж харна гэдэгт нөхөр маань итгэж чадахгүй байсан юм. Хүүд хэрэгтэй тусгай хоол хүнс авах мөнгө надад өгдөггүй байсан учраас надад маш хэцүү байсан.

Эдгээр эцэг эхчүүд хичнээн их ганцаардаж, хичнээн их айж байгааг би мэдэж байна. Хэрэв надад ямар нэгэн зүйл тохиолдвол миний хүүг хэн харж халамжлах вэ гэдэгт би маш их санаа зовдог. Тэр бүү хэл хүү минь надаас өмнө нас барвал дээр байхсан гэж хүртэл боддог.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдэд хичнээн их дэмжлэг хэрэгтэй байгааг олж харсан учраас би сайн дурын ажилтан болсон. Сургалтад хамрагдсан эцэг эхчүүд бие биедээ тусалж сурдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдээс ичдэг хүмүүс тэдэнд хэрэггүй. Хүүхэд хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй ч хүн гэдгийг ойлгодог хүнтэй л тэд ярилцахыг хүсдэг. Хүү минь бусад хүмүүст аюул авчрах өвчтэй хүн биш шүү дээ.<sup>5</sup>

5 Ллойд, Г. “Өмнөд Африкийн Гаутенг дахь олон нийтэд түшиглэсэн тусгай боловсролын интеграцилсан үйлчилгээ”. 2000. Олон улсын тусгай боловсролын конгресс. [http://www.isec2000.org.uk/abstracts/papers\\_1/lloyd\\_1.htm](http://www.isec2000.org.uk/abstracts/papers_1/lloyd_1.htm)



Олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, шаардлагатай дэмжлэгээр хангаж өгөх замаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсролд оролцох, өөрийгөө халамжлах, нийгэмд хувь нэмрээ оруулахад шаардлагатай ур чадварыг эзэмшүүлэх боломжуудыг нэмэгдүүлж болохыг энэ жишээ харуулж байна.

Хүүхдийн сурч боловсрох эрхийн талаарх нэмэлт мэдээллийг Хэсэг 2-ийн “Бүлэг 13. Сурч боловсрох эрх” хэсгээс (хуудас 198) үзнэ үү.

## ХҮҮХДИЙН ОРОЛЦОХ ЭРХ

Хүүхдийн оролцоо нь хүүхдийн эрхийг хангахад голлох үүрэгтэй. Хүүхдүүд өөрсдийнх нь амьдралд нөлөөлөх асуудлуудаар үзэл бодлоо илэрхийлэх, зөвлөгөө авах эрхтэй. Энэ эрх нь бодлогын юмуу орон нутаг, гэр бүл болон хувь хүний түвшинд хэрэгжиж байх ёстой. Хүүхэд, залуучууд өөрсдийнхөө хүсэл, хэрэгцээг илэрхийлэх чадвар эзэмшээд өөрсдийнх нь өмнөөс гаргаж буй шийдвэрүүдэд хувь нэмрээ оруулж байх ёстой.

Хүний эрхэд суурилсан хандлагын үүднээс оролцоо гэдэг нь гарал үүсэл, хөгжлийн бэрхшээлийн төрлөөс (оюуны юмуу сэтгэц-нийгмийн бэрхшээл зэрэг) үл хамааран охид хөвгүүдийг хүний эрхийн бодлого, хөтөлбөрийн төвд тавьж харна гэсэн үг юм. Энэ хандлага нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нийгмийн бүрэн эрхэт гишүүд гэдгийг хүлээн зөвшөөрдөг бөгөөд бүх хүн, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрхийг хангах, хамгаалах үүргийг төр, засаг хүлээх ёстой гэж үздэг.

### Хүүхдийн оролцоог хангах нь

#### Нийгмийн болон улс төрийн хөдөлгөөн

- Хүүхдийн байгууллага, хөдөлгөөнөөр дамжуулан насанд хүрэгсдийн дэмжлэгтэйгээр хүүхдүүд өөрсдийн эрхээ шаардахад нь туслах;
- Хүүхэд, насанд хүрэгсдийн хүчний харьцааг өөрчлөх;
- Хүүхдүүдийг ардчилсан нийгмийн иргэд болоход туслах.

#### Хүний эрх

- Хүүхдийн иргэний эрхийг дэмжих (үзэл бодлоо илэрхийлэх, бодох сэтгэх, мэдээлэл авах, эвлэлдэн нэгдэх гэх мэт)
- Хүүхдүүд эрх эдлэгч болохыг хүлээн зөвшөөрөх


#### Хүүхдийн хөгжил

- Хүүхдийн чадвар, өөртөө итгэх итгэл, бие даасан байдлыг хөгжүүлэх
- Хүүхдийн өөрөө өөрийгөө хамгаалах чадварыг хөгжүүлэх
- Хүүхдийн хяналт тавих асуудлуудын хүрээ, чадавхийн түвшин, суралцах боломжийг нэмэгдүүлэх

#### Хөгжил

- Хүүхдийг илүү сайн ойлгох
- Хүүхдэд зориулсан илүү өгөөжтэй хөтөлбөр, бодлого боловсруулах

Тэгш боломж олгох онолоор<sup>6</sup> бол нийгмийн бодлогоор дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг чадваржуулж (эрх мэдэл өгөх), тэднийг хамгааллыг сайжруулж болно. Гэвч бид хүүхдүүдэд шийдвэр гаргах ур чадварыг зааж сурган (өөрөөр хэлбэл тэдний **чадавхийг** нэмэгдүүлэх), тэдэнд шийдвэр гаргах **боломжуудыг** ханган өгч, тэдний хийсэн сонголтыг нь **хүндэтгэдэг** болтол ХБХЭК-ийн тулгуур болсон тэгш байдал, бүрэн хамрагдалтын зарчмууд хэрэгжиж чадахгүй. Энэ нь зөвхөн сонголт хийх боломжийн тухай асуудал биш бодит нөхцөлд зохицуулан орон нутагтаа өөрийн хүссэнээр амьдрах боломжийг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээ авах, чадавхи эзэмших тухай асуудал юм.



Эх сурвалж: **Тэгш боломжийн загвар** (Митог, 1998)

**ХҮҮХДИЙН ОРОЛЦОХ ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛСАН ХҮНИЙ ЭРХИЙН ЭРХЗҮЙ**

**Хүүхдийн эрхийн конвенцид туссан оролцооны тухай гол заалтууд:**

- **12 дугаар зүйл:** хүүхдийг өөртэй нь холбоотой бүх асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээр хангах бөгөөд хүүхдийн нас, төлөвшлийн байдлыг харгалзан түүний үзэл бодолд зохих ач холбогдол өгөхийг шаардсан ерөнхий зарчим

6 Митог, Деннис Е. “Чиний эрх, миний үүрэг үү?” *Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн холбооны сэтгүүл*, 23 (1), 41-43 1998



Оролцох эрхийг ХЭК-ийн бусад зүйлд шууд болон шууд бусаар тусгажээ. Үүнд:

- **5 дугаар зүйл:** эцэг эхчүүд хүүхдийн хөгжиж буй авьяас чадварт нийцүүлэн хүүхдээ удирдан чиглүүлэх;
- **9 дүгээр зүйл:** хүсэл зоригийг нь үл харгалзан хүүхдийг эцэг эхээс нь салгахгүй байх;
- **13 дугаар зүйл:** үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх;
- **14 дүгээр зүйл:** чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх эрх;
- **15 дугаар зүйл:** эвлэлдэн нэгдэх эрх;
- **16 дугаар зүйл:** хувийн халдашгүй дархан байдлаа хадгалах эрх;
- **17 дугаар зүйл:** мэдээлэл авах эрх;
- **29 дүгээр зүйл:** хүний эрх, ардчиллыг хүндэтгэсэн боловсрол эзэмших эрх;
- **31 дүгээр зүйл:** тоглох эрх.

### **Оролцох эрхтэй холбогдолтой ХБХЭК-ийн чухал заалтууд:**

**7 дугаар зүйл:** Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд бусад хүүхэдтэй адил тэгш байх үндсэн дээр хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлүүлэх боломжийг хангахад шаардлагатай бүхий л арга хэмжээ авах үүрэгтэй; хүүхдийн ашиг сонирхлыг эн тэргүүнд харгалзах ёстой; хүүхдүүд өөрсдийнх нь амьдралд хамааралтай асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй бөгөөд хүүхдийн нас, сэтгэхүйн хөгжлийг харгалзсан байна; эрхээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай хөгжлийн бэрхшээл, насны онцлогт тохирсон туслалцаа авах эрхтэй.

Оролцох эрхийг ХБХЭК-ийн бусад зүйл заалтуудад мөн хөндсөн бөгөөд эдгээр нь ХЭК дээр суурилсан заалтууд юм:

- **Удиртгал:** Хүүхдийн эрхийн конвенцид заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нь бусад хүүхэдтэй адил тэгш байдлаар хүний эрх, үндсэн эрх чөлөөгөө бүрэн дүүрэн эдлэх эрхтэй;
- **3 дугаар зүйл:** Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьсаж өөрчлөгдөх чадамжийг хүндэтгэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог байдлаа хадгалах эрхийг хүндэтгэж хандах;
- **4 дүгээр зүйл:** ХБХЭК-ийг хэрэгжүүлэхэд чиглэсэн хууль тогтоомж, бодлого хөтөлбөрийг боловсруулахдаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй зөвлөлдөх, тэднийг идэвхтэй оролцуулах.

### **ДАСГАЛ 15.3: Хүүхдийн оролцоог дэмжсэн шилдэг туршлагауудыг тайлбарлах, эсэргүүцлийг даван туулах нь**

<b>Зорилт:</b>	Хүүхдийн оролцоог дэмжсэн шилдэг туршлагауудыг тайлбарлах, хүүхдийн оролцоог эсэргүүцдэг насанд хүрэгчдийн эсэргүүцлийн нийтлэг хэлбэрүүдийг таних, тэдгээрийг даван гарах стратегиудыг тодорхойлох
<b>Хугацаа:</b>	50 минут
<b>Хэрэглэгдэхүүн:</b>	Тараах материал, том цаас, фломастер эсвэл самбар, шохой

## 1. Багаар ажиллах

- Оролцогчдыг жижиг багуудад хуваагаад, хөтөлбөр/төслийнхөө хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудтай хэрхэн хамтран ажилладаг туршлагаасаа хуваалцахыг хүс. Ингэхдээ эерэг үр дүнд хүрсэн амжилттай жишээнүүдийг сонгож авахыг оролцогчдод санал болго.
- Маш чухал үр дүнд хүрсэн зарим жишээг оролцогчдоор яриул. Танилцуулга бүрийн эцэст яагаад энэ жишээг сонгож авсныг нь асуу.
- Тараах материал 15.3-ыг ашиглан хүүхдийн оролцоог дэмждэггүй насанд хүрэгсдийн эсэргүүцлийн хэлбэрүүдийг тодорхойлж бичих, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн оролцоог хангахад тулгардаг эсэргүүцлийг даван гарах арга замуудыг тодорхойлж бичих (гэр бүл, сургууль, орон нутгийн орчинд, нутгийн удирдлагын тогтолцоонд гэх мэт) даалгавар өг.
- Хариултуудад дүн шинжилгээ хийж, эдгээр хариултын дотор элбэг тохиолддог эсэргүүцэл, эсэргүүцлийн даван туулах нийтлэг стратеги илэрч байгаа эсэхийг тодорхойл.
- Хөгжлийн бэрхшээлийн төрлөөр, охид, хөвгүүдийн хувьд, сургуульд сурдаг болон сурдаггүй хүүхдүүдийн хувьд, хот болон хөдөөний орчин гэх мэт тохиолдлуудад гарах эсэргүүцлийн төрөл хэлбэр, ялгаа зэргийг эргэцүүлэн бодохыг хүс.

## 2. Хэлэлцэх

- Оролцогчдоос эргэцүүлэн бодсон зүйлийнхээ үр дүнг хуваалцахыг хүс.
- Эсэргүүцлийг даван туулах асуудал дээр өөрт (болон бусдад) тохиолдсон эерэг тохиолдлуудыг ашиглаж болохыг сануул.



**Тараах материал 15.3: Хүүхдийн оролцоог эсэргүүцдэг насанд хүрэгсдийн эсэргүүцэл, түүнийг даван туулах нь**

	Хүүхдийн оролцоог эсэргүүцсэн насанд хүрэгчдийн хандлага	Насанд хүрэгчдийн эсэргүүцлийг даван туулах нь
Гэр бүл		
Сургууль		
Орон нутаг		
Ажлын байр		
Орон нутгийн засаг захиргаа		
Өөрийн байгууллага эсвэл ТББ дотор		
Бусад ...		

## ДАСГАЛ 15.4: Хөтөлбөрийн боловсруулалтад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд түнш болж оролцох нь

- Зорилт:** Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хөтөлбөр боловсруулах үйл явц болон энэхүү үйл явцын аль нэг үе шатанд оролцуулж байсан сайн туршлагуудыг гаргаж ирэх, энэ оролцоог сайжруулах арга замуудыг тодорхойлох
- Хугацаа:** 60 минут
- Хэрэглэгдэхүүн:** Тараах материал, том цаас, фломастер эсвэл самбар, шохой

### 1. Жагсаалт гаргах

Төсөл, хөтөлбөрийнхөө үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг оролцуулж байсан жишээнүүдийг оролцогчдоор яриулаад, ямар алдаа, дутагдал гарч байсныг тодорхойлуулна. Алдаа, дутагдлуудыг том цаасан дээр жагсааж бич.

### 2. Багаар ажиллах

- Оролцогчдыг жижиг багуудад хуваан өмнө тодорхойлсон алдаа, дутагдлуудыг дараах асуултуудын дагуу хэлэлцэх даалгавар өг.
  - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй (түүн дотор оюуны бэрхшээлтэй хүүхдүүд) зөвлөлдөж, тэднийг оролцуулдаг уу? Тэдний үзэл бодлыг хөтөлбөр боловсруулах үе шатууд/төслийн үйл явцад анхаарч үздэг үү?
  - Хүүхдэд хамааралтай, хүүхдэд ээлтэй, чадварт нь нийцсэн мэдээллээр хангадаг уу?
  - Хүүхдийн янз бүрийн бүлгийн (хөгжлийн бэрхшээлийн төрлүүд, насны бүлгүүд гэх мэт) үзэл бодлыг тусгадаг уу?
  - Энэ төсөл нь хүүхдийн эрх (ХЭК-д зааснаар), хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг (ХБХЭК-д зааснаар) шаардах чиглэлээр хүүхдүүд болон насанд хүрэгсдийг чадваржуулах зорилготой юу?
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хөтөлбөр, төслүүдэд оролцох оролцоог нэмэгдүүлэх ямар арга замууд байгааг хэлэлцэх даалгавар өг. Дараах чиглэлээр ямар ямар чухал зүйлийг сурч авсан бэ?
  - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг чадавхижуулах талаар
  - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрхийг насанд хүрэгсдэд ойлгуулах талаар

### 3. Хэлэлцэх

- Багуудыг тарааж, бүгдээрээ хамтран санал бодлоо солилц. Багаараа хийсэн ажлыг тоймлон дүгнэхийн тулд төсөл, хөтөлбөрийн үе шатуудыг авч үзээд, энэ үе шатанд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцох боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн төсөөтэй болон ялгаатай ямар арга замуудыг багууд нэрлэснийг давт. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуустай хамтран ажилласнаар гарах эерэг үр нөлөөний талаар илүү тодорхой ойлголттой болохын тулд доорх мэдээллийг судалж болно.



Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хамтран ажиллах хүүхэд, насанд хүрэгчдийг чадваржуулахын тулд бидний мэдэж байх ёстой чухал сургамжуудыг доорх жишээгээр харуулав.

### **Хүүхдүүд бол нийгэмдээ чухал үүрэг рольтой этгээд гэдгийг хүлээн зөвшөөрөх**

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн үзэл бодол, эрхийг хүндэтгэх үзлийг эцэг эх, олон нийтийн дунд дэлгэрүүлэх, тэгснээрээ тэдний байр суурь, дуу хоолойг нэмэгдүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд орон нутаг, нийгэмдээ хувь нэмэр оруулдаг нийгмийн гишүүн гэдгийг хүлээн зөвшөөрөх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нь насанд хүрэгсдийн хандлагыг өөрчлөх өдөөгч хүчин зүйл болж өгдөг тул үүгээрээ гэр бүл, сургууль, орон нутаг дахь ялгаварлан гадуурхах явдалтай тэмцэх боломжийг бүрдүүлдэг.

### **Хүүхдүүд эрх эдлэгч гэдгийг хүлээн зөвшөөрөх**

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг чадавхижуулснаар эрхийг нь зөрчиж буй үйлдлүүдтэй тэмцдэг, эрхээ шаарддаг болно.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурлагын амжилт нэмэгдэнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн өөртөө итгэх итгэл, өөрийгөө хүндлэх сэтгэл, эсэргүүцэн тэмцэх чадвар нэмэгдэнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн аливаа асуудлыг шийдэхдээ бусад хүүхдүүд, олон нийтийн ашиг сонирхлыг харгалзах эрмэлзэл нь нэмэгдэх
- Харилцах, зөвшилцөх, багаар ажиллах чадвар нэмэгдэнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дунд ардчиллын үнэт зүйлсийн тухай ойлголт, чадвар, мэдлэг дээшилнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй охид, хөвгүүд өөрсдийн эрхийн талаар мэдлэгтэй болж, оролцооны үнэ цэнийг мэдэрснээр чадавхи нь өснө.

### **Хөтөлбөр боловсруулахдаа хүүхдүүдтэй хамтран ажиллах**

- Орон нутаг, засгийн газрын янз бүрийн түвшинд төлөвлөлт хийх, шийдвэр гаргах, тайлагнах болон хуульд оруулах өөрчлөлт боловсруулах зэрэг ажилд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн оролцох боломж нэмэгдэнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд өөрсдийн үзэл бодол болон асуудал, бэрхшээл, анализ, шийдэл, тэргүүлэх чиглэлүүдийн талаарх ойлголтоо илэрхийлэх боломжтой болох бөгөөд эдгээр нь ихэвчлэн насанд хүрэгсдийнхээс өөр байдаг.

### **Хөтөлбөрийн үр дүн**

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ялгаварлан гадуурхах явдал буурна.
- Орон нутаг, сургуулийн үйл ажиллагаанд тэгш хамрагдах боломж өснө.
- Орон нутгийнхныг тодорхой алхам хийхэд ятгах, орон гэр, орон нутаг, сургуулийн орчин дахь хандлага, хүртээмж сайжирна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд өөрсдийгөө буруу зүйлд өртөхөөс сэргийлэх чадвартай болно.

## Насанд хүрэгчдийн хандлага, дэмжлэг

- Насанд хүрэгчид орон нутаг, дүүргийнхээ түвшинд хүүхдүүдийн оролцоо, үзэл бодлыг хүлээж авах нь нэмэгдэх
- Насанд хүрэгсэд болон бусад хүүхдүүдийн хандлага, үзэл бодолд өөрчлөлт гарч байгаа нь ажиглагдана.
- Хүүхдийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрхийн зөрчилтэй тэмцэх, бүх хүүхдэд чанартай, хүртээмжтэй үйлчилгээ хүргэх талаар насанд хүрэгчдийн хариуцлага нэмэгдэнэ.
- Насанд хүрэгчдийн дунд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй хамтран ажиллах, тэдний төлөө ажиллах хүсэл эрмэлзэл нэмэгдэнэ.<sup>7</sup>

Энэ бүлгээс та бүхэн хүүхдүүд өөрсдийн амьдралд нөлөөлөх асуудлуудад бүрэн дүүрэн оролцож үзэл бодлоо хэрхэн илэрхийлдэг, насанд хүрэгсэд янз бүрийн шалтгаанаар тэдний оролцоог хэрхэн эсэргүүцдэг талаар сурч мэдлээ. Түүнчлэн та бүхэн хүүхдийн эрхийг зөвхөн хамгаалаад зогсохгүй дэмжин дэлгэрүүлэх ёстой гэдгийг мэдлээ. Хамгийн чухал нь, төсөл, хөтөлбөр боловсруулахад хүүхдүүд хамтран ажиллах чадвартай бөгөөд үүний үр дүнд чадавхи нэмэгдэх, ялгаварлан гадуурхал багасах, хамрагдалт нэмэгдэх зэрэг маш олон эерэг үр дүн гарч болохыг олж мэдлээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрх зөрчигдөх эрсдэл өндөр учраас эдгээр эрх хэрэгжиж байгаад анхаарал тавих нь хүний эрхийн эрхзүй болон нийгмийн үүрэг юм.

## ДАСГАЛ 15.5: Амлалт авах нь

<b>Зорилт:</b>	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх нь эдлэх эрх, хүлээх үүргийн нэгдэл гэдгийг онцлох, энэ талаар гүнзгийрүүлэн судлах
<b>Хугацаа:</b>	30 минут
<b>Хэрэглэгдэхүүн:</b>	Том цаас, фломастер эсвэл самбар, шохой

### 1. Үйл ажиллагаа

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрхийн талаар мэдлэг, ойлголттой болсны үр дүнд тодорхой нэг ажил хийхэд бэлэн болсон эсэхийг оролцогчдоос асуу.
- Мэдээлэл цуглуулах, ажлаа төлөвлөх гээд хийх зүйл их байгаа ч өөрчлөлт хийх чин эрмэлзэл маш чухал гэдгийг тэмдэглэн хэл.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд эрхээ бүрэн эдлэхэд нь нэмэр болох жижиг ч хамаагүй ямар ажлыг ирэх сард хийхийг хүсэж байгаа, хийх боломжтой байгааг оролцогч бүрээр хэлүүл.
- Хүн бүрийн амлалтыг том цаас юмуу самбар дээр бичээд, сургалтын дараа оролцогчдын хийхээр амласан үйл ажиллагаануудыг тоймлон бичээд бүх хүнд тарааж өг.

7 О'Кейн, Клейр. "Хүүхэд ба засаглал" төслөөс гаргасан "Хүүхдийг Ивээх Сангийн Хүүхдийн эрхийн хөтөлбөрийн сургалтын гарын авлага"-аас өөрчлөн авав. [http://seap.savethechildren.se/South\\_East\\_Asia/Misc/Puffs?Child-Rights-Programming-Training-Manual](http://seap.savethechildren.se/South_East_Asia/Misc/Puffs?Child-Rights-Programming-Training-Manual)





Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрх нь бусад хүмүүсийнхээс ялгаагүй. ХЭК болон ХБХЭК-иар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нь бусад хүүхдүүд, мөн хөгжлийн бэрхшээлтэй бусад хүмүүсийн нэгэн адил хүний эрх болон үндсэн эрх чөлөөг эдлэх эрхтэй. Сонирхогч тал, байгууллагууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг үйл ажиллагаандаа оролцуулж, хүүхдийн эрх, эрх чөлөөгөө эдлэх боломжийг хангах үүрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг бодлого, хөтөлбөр боловсруулах үйл явцад идэвхтэй оролцуулах нь зөвхөн үүрэг төдий бус харин тухайн хүүхэд болон олон нийтэд аль алинд нь үр өгөөжтэй зүйл юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах нөлөөллийн ажил хэрхэн төлөвлөх талаар “Хэсэг 3. Нөлөөлөл! Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа” (хуудас 278) хэсгээс уншина уу.

### ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮДИЙН ЭРХИЙН ТУХАЙ НЭМЭЛТ МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

- Хүүхдийн эрхийн мэдээллийн сүлжээ: <http://www.crin.org> ба <http://www.crin.org/themes/ViewTheme.asp?id=5>
- Тэгш боломжийн онол: Митог, Д. Е. (1998). Чиний эрх, миний үүрэг үү?” *Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн холбооны сэтгүүл*, 23 (1), 41-43
- Олон Улсын Хүүхдийг Ивээх Сангийн нийгэмлэг: <http://www.savethechildren.net/alliance/index.html>
- Хүүхдүүдийг бодлого боловсруулах үйл явцад оролцуулах хичээлүүд: <http://www.savethechildren.net/alliance/resources/12lessons.pdf>
- Митог, Деннис. Е. “Чиний эрх, миний үүрэг үү?” *Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн холбооны сэтгүүл*, 23 (1), 41-43 1998
- Их Британий Хүүхдийг Ивээх Сан: [http://www.eenet.org.uk/bibliog/scuk/scuk\\_home.shtml](http://www.eenet.org.uk/bibliog/scuk/scuk_home.shtml)
- “Нарны туяа төв” холбоо (START зайны сургалтын төсөл): <http://www.sunshine.org.za>
- Хүүхдийн эрхийн хөтөлбөрийн сургалтын гарын авлага: [http://seap.savethechildren.se/South\\_East\\_Asia/Misc/Puffs?Child-Rights-Programming-Training-Manual](http://seap.savethechildren.se/South_East_Asia/Misc/Puffs?Child-Rights-Programming-Training-Manual)
- ЮНИСЕФ: <http://www.unicef.org/crc>

## БҮЛЭГ 16. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТЭГШ ЭРХ, ҮЛ АЛАГЧЛАЛ

### НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци

#### Удиртгал

- (q) хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охид нь хүчирхийлэл, осол гэмтэл, доромжлол, үл тоомсорлол, хайхрамжгүй харьцаа, хэрцгийлэл, мөлжлөгт өрх гэрийнхээ дотор, гадна хаана ч өртөж болзошгүй туйлын эрсдэлтэй байдалд амьдарч байгааг хүлээн зөвшөөрч [байна].
- (s) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүний эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлүүлэх явдлыг хөхиүлэн дэмжихдээ жендерийн асуудлыг бүх талаар харгалзан үзэх шаардлагатайг цохон тэмдэглэж [байна].

#### 3 дугаар зүйл. Нийтлэг зарчмууд

g) эрэгтэй, эмэгтэйчүүд тэгш эрхтэй байх

#### 6 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд:

1. Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй охид нь давхар алагчлалд өртөж болзошгүй гэдгийг хүлээн зөвшөөрч, үүнтэй холбогдуулан тэдэнд хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн, адил тэгш эдлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авна.
2. Оролцогч улсууд нь энэхүү конвенцид заасан хүний эрх, үндсэн эрх чөлөөг эдлүүлэх явдлыг баталгаажуулах зорилгоор эмэгтэйчүүдийг бүх талаар хөгжүүлэх, аж байдлыг нь дээшлүүлэх болон эмэгтэйчүүдийн эрх боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн зохих бүхий л арга хэмжээг авна.

#### 16 дугаар зүйл. Аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос ангид байх эрх

1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь орон гэрийнхээ дотор, гадна хаана ч жендерт үндэслэсэн байдлыг оролцуулан аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос ангид байх явдлыг хангах үүднээс бүхий л зохистой хууль тогтоох, захиргааны, боловсролын болон бусад арга хэмжээг авна.
2. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нас, хүйсийн онцлогт тохирсон тусламж, тусалцаа үзүүлэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гэр бүл, асран халамжлагчдад нь аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолтой холбоотой бодит явдлын талаар мэдээлэх, таниулах болон эдгээрээс хэрхэн сэргийлэх талаар мэдээлэл түгээх боловсрол олгох зэргээр дэмжлэг үзүүлэх явдлыг хангах замаар аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос урьдчилан сэргийлэх зохистой бүхий л арга хэмжээ авна. Оролцогч улсууд ийнхүү үзүүлж буй хамгаалалтын арга хэмжээ нь нас, хүйсийн онцлог болон хөгжлийн бэрхшээлийг харгалзан үзсэн байх явдлыг хангана.
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг мөлжсөн, хүчирхийлсэн, доромжилсон тохиолдол гарсан бол түүнийг илрүүлэх, мөрдөн шалгах болон мөрдөн байцаах хууль тогтоох болон бусад үр дүнтэй арга хэмжээ, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдэд чиглэсэн хууль тогтоох болон бусад арга хэмжээг оролцогч улсууд авна.

## ЗОРИЛТУУД

Энэ бүлгийн сэдэв, үндсэн мэдээлэл, дасгалууд нь оролцогчдод дараах зорилтыг хангахад туслах зорилготой:

- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидын тэгш эрх, хүйсээр алагчлагдахаас ангид байх эрх чөлөөний асуудлыг судлах
- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидод эдгээр зарчмууд ямар ач холбогдолтой болохыг тайлбарлах
- Үл алагчлагдах, тэгш байх зарчмууд болон хүний бусад эрхийн хоорондын уялдааг ойлгох
- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хүйсээр үл алагчлах эрх хэрхэн хангагдаж эсвэл зөрчигдөж байгааг мэддэг болох
- НҮБ-ын **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид** (ХБХЭК) хүйсийн эрх тэгш байдал болон үл алагчлагдах тухай заалтуудыг судлах

*Алагчлал нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн гэрт нь, тэдний амьдралын эхний жилүүдээс л эхэлдэг. Алагчлал нь гэр бүл, бүр тодорхой хэлбэл, гэр бүлд шийдвэр гаргагчдын зүгээс биет болон биет бус нөөц боломжуудыг хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд өгөхгүй байх явдлаар илэрч, энэ нь тэдний амьдрах боломжуудыг улам багасгадаг.*

Л.Абу-Хабиб<sup>1</sup>

## ЭХЛЭЛ: ТЭГШ БАЙДАЛ БОЛОН ҮЛ АЛАГЧЛАЛЫН ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЭХ НЬ

Дэлхий даяар хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд хүйс, хөгжлийн бэрхшээлээс үүдэлтэй давхар ялгаварлан гадуурхалд өртдөг. Тэднийг ажилд авахаас татгалзах, сургуульд явуулахгүй байх, гэрлэлт болон хамтын амьдрал зохиоход тохирохгүй гэж үзэх, шашны зарим зан үйлд оролцуулахгүй байх зэрэг явдал гардаг. Ядуурлаас гарч бүтээлчээр, сэтгэл хангалуун амьдрахад нь хэрэгтэй дэмжлэг туслалцааг (жишээлбэл, боловсрол, ажил олголт, эрүүл мэндийн ерөнхий үйлчилгээ гэх мэт) хамгийн сүүлд хүртдэг хүмүүс бол хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд юм. Тэдний хувьд хүчирхийлэл, доромжлолд өртөх эрсдэл маш өндөр байдаг бөгөөд энэ нь хөгжлийн бэрхшээлийг нь улам даамжруулах, сэтгэл зүйн эмгэг зэрэг хоёрдогч хөгжлийн бэрхшээл үүсгэх шалтгаан болж мэднэ.

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд ялгаварлан гадуурхалд илүү өртөмтгий байгаа нь дэлхий нийтээр тархсан нийтлэг үзэгдэл ч гэлээ энэ асуудлыг янз бүрийн нийгэм, соёлын орчинд өөр өөрөөр ойлгон, шийдвэрлэж байгаа юм. Хөгжиж буй улс орнуудын хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд гурван давхар алагчлалд өртдөг:

- Эмэгтэй хүн учраас,
- Хөгжлийн бэрхшээлтэй учраас,

1 Абу-Хабиб, Л. *Жендер ба хөгжлийн бэрхшээл: Ойрх Дорнод дахь эмэгтэйчүүдийн байдал* (Оксфам, Их Британи, 1997).

- Хөгжиж буй орны иргэн тул тэд ядуу байх магадлал өндөр, буурай орны хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидод олддог боломж, хүртээмж туйлын хязгаарлагдмал, тэдний талаар нийгэмд маш хүчтэй сөрөг хандлага хэвшсэн байдаг зэрэг шалтгаанаар тэд гадуурхагддаг.

Охид, эмэгтэйчүүдийн эрх тэгш байх, үл алагчлагдах эрх нь бусад бүх эрхтэй нь харилцан хамааралтай. Ялгаварлан гадуурхагдаж, тэгш бус хандлагад өртөж буй охид, эмэгтэйчүүд бусад үндсэн эрхээ бүрэн эдэлж чадахгүй. Жишээлбэл, хөвгүүдээс дутуу боловсрол эзэмшсэн хөгжлийн бэрхшээлтэй охин хөдөлмөр эрхлэх бүхий л насныхаа туршид тэгш бус хандлагын бай болдог. Эрүүл мэндийн ерөнхий үйлчилгээ, үүний дотор нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ хүртэж чадахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйн эрүүл байх эрх зөрчигдөөд зогсохгүй түүний мэдээлэл авах эрх, магадгүй гэр бүл, эх хүн болохтой холбоотой эрх ч зөрчигдөж мэднэ. Үүнээс үзэхэд хүний эрхүүд **нэгдмэл, уялдаа холбоотой, харилцан хамааралтай** юм.

## ДАСГАЛ 16.1: Ялгаварлан гадуурхлын хэтийн үр дагавар

<b>Зорилт:</b>	Ялгаварлан гадуурхал нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидод олон талт үр дагаврыг авчирдаг болохыг ойлгох
<b>Хугацаа:</b>	60 минут
<b>Хэрэглэгдэхүүн:</b>	“Үр дагаврын каскад” схем, цаас, фломастер

Нөөц хувилбар: Дугуй хэлбэрээр хайчилсан цаас/цаасан таваг, фломастер

### 1. Санал солилцох

Оролцогчдоос багаараа ярилцаад, хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдэд тулгардаг ялгаварлан гадуурхал, эсвэл тэгш бус хандлагын арга хэлбэрүүдийг гаргаж ирэхийг хүс. Гарч ирсэн санаануудыг жагсааж бичихдээ ижил төстэй жишээнүүдийг нэгтгэнэ. Энэ жагсаалтыг 16.2 дугаар дасгалд дахин хэрэглэхээр хадгал.

### 2. Шинжлэх

Оролцогчдыг хосоор юмуу жижиг багуудад хуваагаад, баг бүрт ялгаварлан гадуурхлын нэг жишээ сонгож дүн шинжилгээ хийх даалгавар өг. Дараах зааврыг өгөөд, “Үр дагаврын каскад” схемийг хэрхэн хэрэглэх тухай тайлбарла.

- **1 дүгээр алхам:** Асуудал/проблемыг тодорхойл. “Үр дагаврын каскад”-ын хамгийн дээд талын дугуй дотор сая тодорхойлсон асуудал/проблемаа бич.
- **2 дугаар алхам:** Энэ асуудал/проблемаас үүдэн хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдэд тулгарах гурван үр дагаврыг тодорхойлоод, тэдгээрийг схемийн том тойргийн доор байрлах гурван жижиг дугуй дотор бич.
- **3 дугаар алхам:** Дээр тодорхойлсон гурван үр дагавар тус бүрээс урган гарах нэмэлт хоёр үр дагаврыг тодорхойлж бич. Хэрэв нэмэлт олон санаа гарвал тойргуудыг нэмж зурж болно.

**Жишээ:** Хэрэв “хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охид боловсролд тэгш хамрагдаж чаддаггүй” гэсэн асуудлыг сонгосон бол дараах үр дагаврыг гаргаж болно:

- Тэд уншиж, бичиж чадахгүй
- Тэд амьдралдаа хүрэлцэхүйц мөнгөн орлого олж чадахгүй
- Тэд үе тэнгийнхнээсээ тусгаарлагдана

“Уншиж, бичиж чадахгүй” гэсэн үр дагавраас дараах гурван үр дүн урган гарч болно:

- Бичмэл мэдээллийг хүлээж авч чадахгүй
- Эмийн заавар уншиж чадахгүй
- Бусадтай захидал, и-мэйлээр харилцаж чадахгүй

**Нөөц хувилбар:** Цаг хангалттай байгаа бол “Хэрэв тэдний эрх нь хангагдсан бол ямар эерэг үр дүн гарах вэ” гэдгийг харуулсан эерэг үр дагаврын каскад хийлгэ (жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охид боловсролд тэгш хамрагдвал ...)

### 3. Илтгэх

Баг болгон “Үр дагаврын каскад” схемээ бусад оролцогчдод тайлбарлан танилцуулна. Танилцуулга бүрийн дараа оролцогчдоор тухайн асуудалд холбоотой нэмэлт үр дагавруудыг хэлүүлээд, гарсан саналуудыг схем дээр нэмж оруулна. Багуудын хийсэн бүх схемийг оролцогчдод харагдах газар байрлуулна.

### 4. Хэлэлцэх

Ялгаварлан гадуурхал нь хүний амьдралд он удаан жилийн туршид ч сөрөг нөлөө үзүүлсээр байх үзэгдэл болохын зэрэгцээ энэ нь олон янзын үр дагавар дагуулах хүний эрхийн ноцтой зөрчил болохыг тайлбарла. Багуудын хийсэн схемийг нэг нэгээр нь дахин нэг авч үзээд, эрх тэгш байх, ялгаварлан гадуурхлаас ангид байх нийтлэг эрхээс гадна өөр ямар эрх зөрчигдөж байгааг оролцогчидтой хамтран хэлэлц.

**Жишээ:** “Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охид боловсролд тэгш хамрагдаж чаддаггүй” гэсэн сэдвийн үр дагаврыг дараах байдлаар бичиж болно:

- “Уншиж, бичиж чадахгүй” = Сурч боловсрох эрх
- “Амьдралдаа хүрэлцээтэй мөнгөн орлого олж чадахгүй” = Хүрэлцэхүйц түвшний амьжиргаатай байх эрх
- “Үе тэнгийнхнээсээ тусгаарлагдана” = Эвлэлдэн нэгдэх эрх, олон нийтийн үйл ажиллагаанд хамрагдах эрх


### 5. Дүгнэх

Дасгал ажлын төгсгөлд хүний эрх хоорондоо уялдаа холбоотой болохыг онцлон хэл. Энэ уялдаа холбоо нь эерэг, сөрөг үр дагаврын аль алинд хамааралтай болохыг тайлбарла. Багийн ажлын үеэр хөндөгдсөн асуудлаас аль нэгийг сонгоод эерэг “Үр дагаврын каскад”-ын жишээн дээр нэг эрх хангагдсанаар бусад эрх хэрхэн хангагдаж байгааг тайлбарла.

**Жишээ:** Хэрэв “Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охид боловсролд тэгш хамрагдвал...” гарах үр дүн нь:

- “Уншиж, бичиж чадна” = Сурч боловсрох эрх

- “Амьдралдаа хүрэлцээтэй мөнгөн орлоготой болно” = Хүрэлцэхүйц түвшний амьжиргаатай байх эрх
- “Үе тэнгийхэнтэйгээ хамтран үйл ажиллагаанд оролцоно” = Эвлэлдэн нэгдэх эрх, олон нийтийн үйл ажиллагаанд хамрагдах эрх



ОЛОН УЛСЫН ЭРХЗҮЙД ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЭМЭГТЭЙЧҮҮД, ОХИДЫН ЭРХИЙН ТАЛААР ЮУ ГЭЖ ЗААСАН БАЙДАГ ВЭ?

Олон улсын хүний эрхийн эрхзүйд хүн бүр ялгаварлан гадуурхлаас ангид байх, тэгш байх эрхтэй гэж заасан байдаг. **Хүний эрхийн түгээмэл тунхаглал (ХЭТТ)** болон **Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИУТЭОУП)**<sup>2</sup> нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидыг хүйсээр ялгаварлан гадуурхагдахаас хамгаалдаг.

Эмэгтэйчүүдийн эрхийн асуудлыг тусгайлан авч үзсэн хамгийн чухал олон улсын баримт бичиг бол **Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенци (ЭАБХУК)**<sup>3</sup> юм. Энэхүү конвенци нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидын эрхийг тусгайлан авч үзээгүй ч бүх эмэгтэйчүүдэд хамааралтай асуудлууд, үүний дотор эмэгтэйчүүдийг хувийн болон нийгмийн амьдралын хүрээнд ялгаварлан гадуурхагдахгүй байхтай холбоотой чухал эрх, үүргийг нарийн зааснаараа онцлог юм. Тус конвенцийн хэрэгжилтийг хянах үүрэгтэй **ЭАБХУК-ийн хорооноос** боловсруулан гаргасан **Ерөнхий зөвлөмж №18-д** (Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд)<sup>4</sup> Оролцогч улсууд нь уг Хороонд ирүүлэх тайландаа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидын тухай мэдээллийг багтааж байх ёстой гэсэн шаардлага

2 <http://www.ohchr.org/english/law/ccpr.htm> сайтаас үз.

3 <http://www.un.org/womenwatch/daw/cedaw/cedaw.htm> сайтаас үз.

4 <http://www1.umn.edu/humanrts/gencomm/gener18.htm> сайтаас үз.

багтжээ. **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци** (ХБХЭК) нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидын эрхийн асуудалд ялгаатай хоёр хандлага баримталжээ. Эдгээрийг нэлээн ерөнхий хүрээтэй “өргөн бийрний арга”, мөн тодорхой тохиолдолд хамааралтай буюу “нарийн бийрний арга” гэж нэрлэж болно.

### **Хүйсээр ялгаварлан гадуурхах асуудалд хандах ерөнхий буюу “Өргөн бийр” хандлага**

“Өргөн бийр” хандлага нь ХБХЭК-ийн агуулгад бүхэлд нь хамааралтай тэгш байдал, үл гадуурхлын ерөнхий зарчмуудыг тогтоож өгдөг. Тэгш байдал, үл гадуурхлын зарчмууд нь хүний бүх эрхийн үндсийг тавьдаг тулгын чулуунууд юм. Хүний эрх нь мөн чанартаа хүн бүр ижил тэгш үнэ цэнэтэй, хүн гэдэг нэр төрөө хүндэтгүүлэх эрхтэй гэсэн утгыг илэрхийлнэ. Тиймээс ч тодорхой тохиолдол бүрт ашигласан үг, хэллэг нь ялгаатай байж мэдэх ч орчин үеийн олон улсын хүний эрхийн бүхий л баримт бичгийн эхэнд энэ хууль/ конвенци/ гэрээг тэгш зарчмын үндсэн дээр ялгаварлан гадуурхалгүй хэрэглэх ёстой гэж заадаг болсон байна.

ХБХЭК-ийн 3 дугаар зүйлийн (g) хэсэгт “эрэгтэй, эмэгтэйчүүд тэгш эрхтэй байна” гэж заасан нь уг конвенцид бүхэлд нь хамааралтай суурь зарчим юм. Тэгэхлээр зарим заалтад хүйсийн тэгш байдлын тухай илт дурьдаагүй ч гэсэн конвенцийн заалтуудыг ашиглахдаа тэгш байдлын зарчмыг заавал харгалзах ёстой. Энэ утгаараа хүйсийн тэгш байдал нь ХБХЭК-д бүхэлд нь хамаарах зарчим юм.

Оролцогч улсууд тус конвенцид заасан эрхийг *хүндэтгэх, хамгаалах, хангахтай* холбоотойгоор дэмжих болон хориглох арга хэмжээ авах үүрэгтэй. Оролцогч улсууд нь эмэгтэйчүүдийн эрхийг эрэгтэйчүүдийнхтэй тэгш *хүндэтгэхэд* анхаарах ёстой. Жишээлбэл, ХБХЭК-ийн “Шүүх ажиллагаанд тэгш хамрагдах эрх”-ийн тухай 13 дугаар зүйлд эрэгтэйчүүдэд илүү буюу давуу боломж олгох, улмаар нийгэм дэх эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хоорондын эрх мэдлийн ялгаа зөрүүг улам даамжруулах аливаа үйлдлийг Оролцогч улс хийж болохгүй гэж заажээ. Нөгөө талаар, конвенцид тодорхойлсон аливаа асуудал/ проблемыг шийдэхдээ нийгэмд эмэгтэйчүүдийн олсон амжилт, ахицыг *хамгаалсан*, улмаар тэдний нийгэмдээ эзлэх байр сууриа улам ахиулах цаашдын зорилго, зорилтуудыг нь дэмжсэн (*хангасан*) байдлаар хандах ёстой ажээ.

ХБХЭК-ийн 6 дугаар зүйл нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд тулгарч буй “давхар ялгаварлан гадуурхлыг” шийдвэрлэх үүргийг Оролцогч улсуудад шууд бөгөөд илт оноож өгснөөрөө бусад зүйл, заалтуудаас ялгаатай болжээ. Энэ Зүйлд эмэгтэйчүүдэд хүний эрхээ бүрэн дүүрэн эдлэх боломж хангаж өгөх зорилгоор Оролцогч улсууд нь эмэгтэйчүүдийг бүх талаар хөгжүүлэх, аж байдлыг нь дээшлүүлэх, эрх мэдлийг нь ахиулан чадавхижуулахад чиглэсэн бүхий л арга хэмжээг авах үүрэгтэй гэж заажээ.

### **Хүйсээр ялгаварлан гадуурхах асуудалд хандах тухайлсан буюу “Нарийн бийр” хандлага**

Тэгш байдал, үл алагчлалын тухай “өргөн бийрний” хандлага буюу ерөнхий заалтуудын хажуугаар олон улсын хүний эрхийн олон баримт бичигт эрх нь зөрчигдсөн тодорхой хүн



амд хамааралтай тусгай асуудлуудыг багтаасан байдаг. ХБХЭК нь мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолтой холбоотой асуудлуудаар “нарийн бийрний” хандлагыг баримталжээ.

ХБХЭК нь хүчирхийллийн асуудлаар Оролцогч улсуудын хүлээх үүргүүд хүний эрхийг хүндэтгэхээр хязгаарлагдахгүй гэж үзэн, хүний эрхийг хамгаалах, хангахтай холбоотой маш тодорхой зааварчилгаа өгчээ. Хамгийн чухал нь, ийнхүү тодорхой заавар өгөхдөө конвенци нь “нийгмийн амьдрал” болон “хувийн амьдрал” (гэр бүл доторх) хоёрын хоорондын хиймэл зааг хязгаарыг (заримдаа “нийгмийн/хувийн амьдралын зааг” гэж нэрлэдэг) арилгаж, энэ хоёр хүрээний аль алинд нь төрийн хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлж өгчээ.

#### **Нийгмийн амьдралын хүрээнд:**

Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс орон гэрийнхээ дотор, гадна хаана ч жендерт үндэслэсэн зэрэг аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос ангид байх явдлыг хангах үүднээс бүхий л зохистой эрхзүйн, захиргааны, боловсролын болон бусад арга хэмжээг авна.

#### **Хувийн амьдралын хүрээнд:**

Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нас, хүйсийн онцлогт тохирсон тусламж, тусалцаа үзүүлэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гэр бүл, асран халамжлагчдад нь аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолтой холбоотой бодит явдлын талаар мэдээлэх, таниулах болон эдгээрээс хэрхэн сэргийлэх тухай мэдээлэл түгээх, боловсрол олгох зэргээр дэмжлэг үзүүлэх замаар аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос урьдчилан сэргийлэх зохистой бүхий л арга хэмжээ авна.

ХБХЭК-ийн 16 дугаар зүйлийн 6-д хүчирхийлэл, доромжлолтой холбоотой асуудлаар Оролцогч улсуудын хамгаалах, хангах үүргийг улам өргөжүүлэн Оролцогч улсууд нь “хөгжлийн бэрхшээлтэй хүнийг мөлжсөн, хүчирхийлсэн, доромжилсон тохиолдол гарсан бол түүнийг илрүүлэх, мөрдөн шалгах болон мөрдөн байцаах хууль тогтоох болон бусад үр дүнтэй арга хэмжээ, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдэд чиглэсэн хууль тогтоох болон бусад арга хэмжээг авна” гэж заасан байна.

## **ДАСГАЛ 16.2: Ялгаварлан гадуурхлын үндэс суурь**

- Зорилт:** Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидод тулгардаг ялгаварлан гадуурхлын шалтгаануудыг шинжлэх
- Хугацаа:** 60 минут
- Хэрэглэгдэхүүн:** “Загасны яс” диаграммын хуулбар, цаас, фломастер

### **1. Танилцуулах**

16.1 дасгалаар гаргасан ялгаварлан гадуурхлын жишээнүүдийн жагсаалтыг дахин танилцуулж, эхний дасгал ажилд ялгаварлан гадуурхлын үр дагаврыг судалсан бол энэ дасгалаар шалтгаануудыг шинжлэн судлах гэж байгааг тайлбарлана.



## 2. Шинжлэх

Оролцогчдыг хосоор юмуу жижиг багуудад хуваагаад, баг болгон ялгаварлан гадуурхлын нэг жишээг сонгон авч дүн шинжилгээ хийнэ гэдгийг тайлбарла. 16.1 дасгалыг хийхэд байгуулсан багаараа эргэн нийлж, энэ дасгалаар гаргасан жишээнүүдээ ашиглах, эсвэл шинэ сэдвүүд өгч шинээр багууд байгуулж ч болно. Баг бүрт “Загасны яс” диаграмм, хүснэгт, цаас, фломастер өгнө. Энэ дасгалаар асуудлыг шийдвэрлэж болох хэд хэдэн хэсэгт хувааж харах ажлыг хийх гэж байгааг тайлбарла. Багуудад дараах зааварчилгааг өгөөд, “Загасны яс” диаграмм нь аливаа асуудлын бүхий л боломжит шалтгаануудыг салгаж харахад тус болно гэдгийг тайлбарла. Маш энгийн нэг асуудлыг сонгон авч диаграммыг хэрхэн хэрэглэхийг харуул.

- **1 дүгээр алхам:** Асуудлаа тодорхойл. Асуудлыг нэг өгүүлбэрээр, эсвэл цөөн хэдхэн үг, хэллэгээр томъёолон бичнэ.
- **2 дугаар алхам:** Энэ асуудалд нөлөөлж буй ямар ямар томоохон хүчин зүйлс харагдаж байна вэ? Хүчин зүйл бүрийг загасны нурууны ясаар төлөөлүүлэн зурж нэр өгнө. Эдгээр нь хүмүүс, тогтолцоо, тоног төхөөрөмж, гадаад хүчин зүйлс, хандлага, зан заншил, соёлын уламжлал зэрэг янз бүрийн хүрээг хамарч болно.
- **3 дугаар алхам:** 2 дугаар алхмаар тодорхойлсон хүчин зүйл бүрийнхээ боломжит шалтгаануудыг тодорхойл. Эдгээрийг загасны “нурууны яснаас” салбарлан гарсан жижиг “яс” болгож зурна. Том буюу адармаатай шалтгаануудыг дэд шалтгаан болгон жижиглэн задлаад, үүнийгээ жижиг яснаас салбарлуулан зурж харуулна.
- **4 дүгээр алхам:** Диаграммдаа дүн шинжилгээ хий. Тухайн асуудлын ач холбогдол, нарийн ээдрээтэй байдлыг харгалзан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн ямар ямар арга хэмжээ хэрэгжүүлж болохыг тодорхойл.

Нөөц хувилбар: Асуудлыг харуулсан бүдүүвч/ ерөнхий төлөвлөгөө гаргаж болно. Үүнд: асуудал/ проблем нь гарчиг болж, хүчин зүйлс болон дэд хүчин зүйлс нь дэд гарчиг болох юм.


## 3. Илтгэх

Багууд хийсэн диаграмаа бусаддаа тайлбарлана. Танилцуулга бүрийн төгсгөлд оролцогчдоос өөр шалтгаан байгаа эсэхийг, хэрхэн шийдэж болох тухай асуу.

## 4. Тоймлон дүгнэх

Багуудын хийсэн дүн шинжилгээнд нийтлэг, ижил шалтгаанууд дурьдагдсан эсэхийг оролцогчдоос асуугаад, жагсаалт болгож бич. Дараа нь ялгаварлан гадуурхлын эдгээр давамгайлах шалтгааныг хэрхэн арилгах талаар ярилц.

Загасны ясан диаграммын жишээ



**ДАСГАЛ 16.3: Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидын ялгаварлан гадуурхлаас ангид байх эрх, хүйсийн тэгш эрхийг ХБХЭК хэрхэн баталгаажуулсан бэ?**

**Зорилт:** ХБХЭК-аар баталгаажсан эмэгтэйчүүд, охидын эрхийг судлах, ойлгох

**Хугацаа:** 30 минут

**Хэрэглэгдэхүүн:** Том цаас, фломастер эсвэл самбар, шохой

**1. Бататгах**

Оролцогчдыг жижиг багуудад хуваана. Багууд ХБХЭК-ийн үл алагчлал, хүйсийн тэгш байдлыг хангах зорилготой “өргөн бийр” ба “нарийн бийр”-ний хандлагуудыг хэлэлцэнэ.

**2. Жишээ гаргах**

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидын эрхийг хэрхэн эдлүүлж, энэ нь тэдний амьдралд ямар өөрчлөлт авчрахыг харуулсан жишээнүүдийг оролцогчдоор гаргуул.

**3. Жагсаалт гаргах**

Оролцогчдын гаргасан жишээнээс 3-5 жишээ сонгож, бичгийн цаасан дээр хөндлөнгөөр нь жагсааж бич. Цаасны дээд хэсэгт “хүндэтгэх, хамгаалах, хангах” гэсэн гурван багана үүсгээд, шугамнуудыг доош татан хүснэгт болгоно. Хүснэгтийг жишээгээр бөглө.

**4. Хэлэлцэх**

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах асуудлыг үндэсний хэмжээний бодлогын асуудал болгож тавих, мөн улс төрийн нам, шийдвэр гаргагчдад өргөн барих үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулахад ХБХЭК-ийн хүйсийн тэгш байдал, үл алагчлах тухай заалтуудыг хэрхэн ашиглаж болох вэ?



## Хүчирхийлэл

Гэр бүлийнхээ гишүүдийн асрамж халамжид байгаа болон хувийн асрагчтай хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн аль аль нь хүчирхийлэлд маш ихээр өртдөг. Асран хамгаалагч гэж асрагч, хэлмэрч, гэрийн үйлчлэгч, жолооч, эмч, сувилагч, багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, сэтгэл судлаач, физик эмчилгээний эмч, зөвлөх, эмнэлэг болон бусад байгууллагын ажилтнуудыг хэлдэг. Ийм олон тооны хүн, мөн тэдний үзүүлж байгаа үйлчилгээний мөн чанар болсон бие махбодын болон сэтгэл санааны маш ойрхон харилцаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүчирхийлэлд өртөх эрсдлийг нэмэгдүүлдэг. Цаашилбал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс олон асуудлаар асран хамгаалагчдаасаа хамааралтай байдаг тул бусад эмэгтэйчүүдтэй харьцуулахад хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хариу арга хэмжээ авахуулахаар хөөцөлдөхөд хамаагүй хүнд байдаг. Европ, Хойд Америк, Австралид хийсэн судалгаагаар эдгээр улсуудад хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн талаас илүү хувь нь, хөгжлийн бэрхшээлгүй эмэгтэйчүүдийн гуравны нэг нь биеийн хүчирхийлэлд өртөж байсан дүн гарчээ. АНУ-д хийсэн судалгаанаас үзэхэд хөгжлийн бэрхшээлгүй хүүхэдтэй харьцуулахад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртөх магадлал хоёр дахин их байдаг байна.

### Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидод тулгардаг хүчирхийллийн хэлбэрүүд

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд тулгардаг хүчирхийлэл нь олон төрөл хэлбэртэй байдаг бөгөөд эдгээр нь нэгэн зэрэг тохиолдож мэднэ. Хүчирхийлэл нь доромжлох, хүчирхийлэх зэргээр ил хэлбэрээр гарахын зэрэгцээ анхаарал тавихгүй байх зэрэг далд хэлбэрээр илэрдэг.

- **Анхаарал тавихгүй байх** – хоол өгөхгүй байх, хувийн болон эрүүл мэндийн асаргаа сувилгаа огт үзүүлэхгүй юмуу шаардлагатай хэмжээнд үзүүлэхгүй байх;
- **Биеийн хүчирхийлэл** – хүчиндэх, асаргаа үзүүлэхдээ хатуу ширүүн эсвэл тохиромжгүй байдлаар хүрэх, хувийн болон эрүүл мэндийн асаргаа сувилгааг тохиромжтой байдлаар үзүүлэхгүй байх, хөдөлгөөн хорих хэрэгслийг хэтрүүлэн ашиглах, зан үйлийг засаж залруулах зорилгоор зохисгүй үйлдэл хийх, хэт их эм уулгах, хорих;
- **Сэтгэл санааны хүчирхийлэл** – хэл амаар доромжлох, айлгаж ичээх, нийгмээс тусгаарлах, сэтгэл зүйн хүнд байдалд оруулах, бие даан гаргасан шийдвэрийг нь няцаах, хүүхдийг нь авч явна гэж сүрдүүлэх;
- **Бэлгийн хүчирхийлэл** – эмэгтэй хүний бэлгийн хэрэгцээг үгүйсгэх, бэлгийн амьдралын талаарх мэдээлэл/боловсрол (жишээлбэл, жирэмслэлтээс хамгаалах, хүүхэд төрүүлэх гэх мэт сэдвээр) олгохгүй байх, хэл амаар доромжлох, хүсэхгүй байхад бэлгийг сэдлээр биед нь хүрэх, хүчиндэх, хүчээр үр хөндүүлэх, үргүй болгох.<sup>5</sup>

5 Сакстон Марша. “Хүчирхийллээс сэргийлэх, чадавхижуулах сургалтын хөтөлбөр”. *Хөгжлийн бэрхшээлийг судлах дэлхийн хүрээлэн*. <http://www.wid.org/programs/health-access-and-long-term-services/curriculum-on-abuse-prevention-and-empowerment-cape>

## **Нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах**

Нөхөн сэргээх үйлчилгээнээс ашиг тусыг олж болох хөгжлийн бэрхшээлтэй ихэнх хүнд энэ үйлчилгээ хүртээмжгүй байдаг бөгөөд байгаа нөхөн сэргээх үйлчилгээ нь эмэгтэйчүүд, охидод хүрэлцээгүй, хүртээмжгүй байдаг. Дайн байлдааны байдалд байгаа олон улс оронд нөхөн сэргээх эмчилгээ нь зөвхөн эрэгтэйчүүдэд зориулагдсан байдаг. Хөгжиж буй орнуудад мэдээлэл хүрэхгүй, үйлчилгээ үзүүлж буй газарт бие даан хүрч очих боломжгүй, мөнгө санхүүгийн чадавхигүй зэрэг олон шалтгаанаар хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд согог засал, ортопедийн үйлчилгээ авах боломж тун муутай байдаг ажээ. (Сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдах эрхийн талаар дэлгэрүүлж судлахыг хүсвэл 150-р хуудас дахь 9 дүгээр бүлгийг үзнэ үү.)

## **Эрүүл мэндийн суурь үйлчилгээний хүртээмж**

Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн суурь үйлчилгээ хүртэх эрхээ эдлэхэд нь ноцтой бэрхшээлүүд тулгардаг бөгөөд эдгээр саад тотгорын дотор ялгаварлан гадуурхал, тэгш бус хандлага, мэдээллийн хомсдол, тээврийн хэрэгслийн дутмаг байдал, бие даасан байдал болон хувийн нууцыг хүндэтгэхгүй байх зэрэг багтана. АНУ-д хөгжлийн бэрхшээлтэй нийт эмэгтэйчүүдийн 31 хувь нь хөгжлийн бэрхшээлээсээ болж эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзсан хариуг эмчээсээ сонсож байжээ.<sup>6</sup> Анагаах ухаан, асаргаа сувилгаа, нийгмийн эрүүл мэнд, шүдний эмчилгээ, эм найруулгын болон эрүүл мэндийн бусад мэргэжилтэн, нийгмийн ажилтан бэлтгэдэг сургуулиудад хөгжлийн бэрхшээлтэй холбоотой сургалт, хичээл бараг ордоггүй, орж байгаа цөөн хэд нь эмчилгээ, нөхөн сэргээхтийг явцуу хүрээнд авч үзэх төдийхнөөр үйл ажиллагаагаа хязгаарлаж байна.<sup>7</sup>

## **Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ хүртэх эрх**

Сэтгэцийн болон бие махбодын хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд өөрсдийнхөө эрүүл мэндтэй холбоотой асуудлуудаар шийдвэр гаралтад оролцохын төлөө тэмцэх шаардлагатай болдог. Эрүүл мэндийн ажилтнууд нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидод гэр бүл төлөвлөлтийн үйлчилгээ, аргуудын талаар зөвлөгөө өгөхөөс тууштай татгалзаж байсан олон тохиолдол гарч байжээ. Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийн санал, зөвшөөрлийг авалгүйгээр өмнөөс нь шийдвэр гаргаж, хүчээр үр хөндүүлэх, үргүй болгох зэргээр хүний эрхийг нь зөрчих явдал газар авсаар байна.<sup>8</sup> Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ авахаар ирсэн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй өөрийнх нь онцлог нөхцөл байдлыг ойлгоогүй эмчийн хүчээр тулгасан эмчилгээг авахад хүрдэг. Жишээлбэл, АНУ-д хийсэн нэгэн судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдтэй харьцуулахад хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг дотуур үзлэгт хамруулах нь бага байдаг нь илэрчээ.<sup>9</sup>

## **Гэрлэх, гэр бүлтэй болох эрх**

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд нь гэрлэх, гэр бүл үүсгэх эрхээ эдлэхдээ олон саадтай тулгардаг бөгөөд хүүхдээ асран хамгаалах эрхээ алдах явдал олон гардаг. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүүхдээ асарч чадахгүй, хөгжлийн бэрхшээлтэй тул хүүхэд гаргах хэрэггүй, амь насанд нь аюултай зэрэг буруу мэдээлэл өгөх явдал гарч ч мэднэ. Японы

6 Носек, М.С. нар, Бие махбодын бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн талаарх үндэсний судалгаа: Эцсийн тайлан. (Хьюстон: Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн судалгааны төв, 1997)

7 Хөгжлийн бэрхшээлийн асуудлаарх бодлогын төсөл (Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, хэвлэгдээгүй бүтээл, 1999).

8 АНУ-ын Төрийн департаментын Хүний эрхийн тайлан (2000 оны дугаар сар).

9 Руссо, Хариллин. Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд: олон улсын судалгааны тойм ба хураангуй. (Disabilities Unlimited Consulting Services, 2000).

Засгийн газар “гэмтэл, согогтой үр удам үлдээхээс сэргийлэх” зорилгоор 1949-1992 оны хооронд 16500 гаруй хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйг өөрсдийнх нь зөвшөөрөлгүйгээр үргүй болгож байснаа 1997 онд хүлээн зөвшөөрсөн байдаг.<sup>10</sup> Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гаргасан нөхөн төлбөрийн нэхэмжлэлийг Японы Засгийн газар хүлээж аваагүй бөгөөд дээрх процедур нь тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байсан дотоодын хууль тогтоомжид нийцсэн арга хэмжээ байсан хэмээн тайлбарлажээ. Зарим улс оронд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд хүүхэд өргөж авах боломжгүй шахам байдаг ажээ.

### **Боловсрол ба бичиг үсэг тайлагдалт**

Хүйсээр болон хөгжлийн бэрхшээлээр алагчлах давхар гадуурхлын үр нөлөөгөөр хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидын бичиг үсэг тайлагдалт, сургуульд хамрагдалт тун доогуур үзүүлэлттэй байдаг. АНУ-ын хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хувьд наймаас цөөн жилийн боловсрол эзэмшсэн байх магадлал нь ийм бэрхшээлгүй эмэгтэйчүүдээс 5 дахин их байна. Сургууль нь гэрээс нь хол, хүртээмж муутай, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй охид (хөвгүүд)-ыг авдаггүй зэрэг асуудал олон оронд байдаг. Охин хүүхдийнх нь амьдралд таатай боломж бага гарна гэж үзээд эцэг эхчүүд нь охидоо сургуульд явуулахгүй байхаар шийдэж ч мэднэ. Сургуульд явдаггүй хөгжлийн бэрхшээлтэй охидод нөхөн үржихүйн эрүүл мэндийн тухай мэдээлэл бүр ч бага хүрдэг учраас хөгжлийн бэрхшээлгүй охидтой харьцуулахад хөгжлийн бэрхшээлтэй залуу бүсгүйчүүд сургуулиас гараад 3-5 жилийн дараа ээж болох магадлал харьцангуй өндөр байгааг Америкт хийсэн нэгэн судалгаа харуулжээ. Хөгжлийн бэрхшээлтэй сурагчид сургууль дээрээ бэлгийн хүчирхийлэлд илүү ихээр өртдөг бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хөвгүүдтэй харьцуулахад хөгжлийн бэрхшээлтэй охид хүчирхийлэлд илүү өртдөг нь судалгаагаар батлагджээ.<sup>11</sup>

### **Ажлын байран дахь ялгаварлан гадуурхал**

Хөдөлмөрийн зах зээл дээр хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд боломж олгоход хангалттай анхаарал тавихгүй байгаагийн дээр бэлгийн хүчирхийлэл, хөгжлийн бэрхшээлээс үүдэлтэй хүчирхийллийг урьдчилан сэргийлэх, шийтгэх хуулийн зохицуулалтууд дутмаг байна. НҮБ-ын мэдээлж байгаагаар хөгжлийн бэрхшээлтэй нийт эмэгтэйчүүдийн зөвхөн дөрөвний нэг нь ажил эрхэлж байна. Тэдний хувьд хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэйчүүдтэй харьцуулахад ажил олох магадлал хоёр дахин бага байдаг ажээ.<sup>12</sup> Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан ажлын байрандаа хүчирхийлэлд өртөх нь мөн л түгээмэл үзэгдэл болсон бөгөөд “нууцлаг хөгжлийн бэрхшээл” гэж нэрлэгддэг сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эсрэг хүчирхийлэл бүр ч ноцтой байж мэднэ. Газар авсаар байгаа үл тоомсорлох хандлагын улмаас зарим ажил олгогч хөгжлийн бэрхшээлтэй хүн ажлын байранд тавигдах шаардлагыг хангаж чадахгүй, эсвэл боломжит тохируулга хангаж өгөхөд мөнгө их орно гэсэн буруу ойлголтын нөлөөгөөр хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйг ажилд авдаггүй байна. Хөгжиж буй оронд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин бараг л 100 хувь байдаг.<sup>13</sup>

10 “Женев дахь Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны 26 дугаар дээд хэмжээний хуралдаан дээр Японы Засгийн газрын тавьсан илтгэлийн сүүдэр тайлан.” 13-31 дүгээр хуудас. 2001 оны 8 дугаар сар. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс олон улсын байгууллагын Япон улс дахь салбарын үндэсний чуулган

11 Руссо, Харилин. Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийн талаарх олон улсын судалгааны тойм ба хураангуй. (Disabilities Unlimited Consulting Services, 2000).

12 “Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд”. 2006. Хүний эрхийн хяналт. <http://hrw.org/women/disabled.html>

13 “Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн талаарх тоо баримт”. Дон Онтарио, Онтариогийн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн сүлжээ. <http://dawn.thot.net/fact.html>



## Хүрэлцэхүйц хэмжээний амьжиргаа

Эмэгтэй хүнийг хөдөлмөрлөх болон нөхөн үржихүйн чадвараар нь үнэлдэг улс оронд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд ялгаварлан гадуурхалд илүү өртдөг. Түүнд хүнс болон бусад нөөцийг хамгийн бага хэмжээгээр хуваарилна. Үүнээс үүдэн хөгжлийн бэрхшээлтэй охидын амьд үлдэх боломж нь хөвгүүдийнхээс бага байдаг. Цөөн хэдэн хөгжиж буй оронд хөгжлийн бэрхшээлтэй охид сургуульд явах боломжтой байдаг бол хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургуульд хамруулах боломж олдвол дийлэнхдээ хөвгүүд энэ эрхийг эдэлдэг байна. Хотын захын ядуу хорооллын хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд зохистой орон байр болон цэвэр усны дутагдалтай, эрүү ахуйн шаардлага хангаагүй орчинд хүйсээр алагчлагдаж, агаарын бохирдолд өртөн онцгой хүнд нөхцөлд амьдарч байгаа юм.

### ДАСГАЛ 16.4: Гэр бүл дотор болон гадуурх орчин дахь шийдвэр гаргалт

<b>Зорилт:</b>	Гэр бүл доторх болон гадуурх орчинд шийдвэр гаргах эрх мэдэл хэрхэн хуваарилагдаж байгааг судлан тогтоох
<b>Хугацаа:</b>	90 минут
<b>Хэрэглэгдэхүүн:</b>	Том цаас, фломастер эсвэл самбар, шохой

#### 1. Санал солилцох

Оролцогчдод хандаж дараах асуултад хариулт өгөхийг хүс: *Ердийн нэгэн гэр бүлд ямар ямар асуудлуудаар шийдвэр гаргадаг вэ?* Оролцогчид ямар нэгэн тайлбар өгөлгүйгээр зөвхөн товч хариултуудаа өгнө. Тайлбар хийлгүйгээр оролцогчдын хариултыг бичиж ав.

#### 2. Хэлэлцэх

Эрэгтэй, эмэгтэйчүүдийн шийдвэр гаргадаг асуудлуудын ялгааны талаар оролцогчдын саналыг асуу. Оролцогчид дурьдахгүй бол дараах санааг нэм:

- Хэнтэй, ямар нөхцлөөр амьдрах;
- Гэрлэх эсэх;
- Хэнтэй гэрлэх;
- Хэзээ гэрлэх;
- Хүүхэдтэй болох эсэх;
- Хэзээнээс хүүхэдтэй болж эхлэх, хэдэн хүүхэдтэй болох;
- Гэрлэхдээ өөрийн үндэс угсаа, иргэншлээ хадгалах эсэх;
- Хүүхэд үрчилж авах эсэх, хэдийг үрчилж авах;
- Үрчилж авалгүйгээр өөр хүний хүүхдийг өсгөх эсэх;
- Гэрлэлтээ цуцлах эсэх, хэзээ цуцлах, ямар нөхцөлд цуцлах;
- Өөрийн хувийн эд хөрөнгөтэй болох эсэх, мөнгө зээлэх, бизнес эрхлэх эсэх;
- Цалинтай ажилд орохоор өргөдөл өгөх, ямар төрлийн ажилд орох.

#### 3. Тараан өгч шинжлэх

ХБХЭК-ийн 6 ба 3 дугаар зүйлийн (g) заалтыг оролцогчдод тарааж өгөөд, эдгээр нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг үл алагчлагдах зарчмын үүднээс харж тодорхойлсон бусадтай ижил тэгш эрх, үүрэгтэй байх тухай заалт гэдгийг тайлбарлана. Оролцогчдыг хосоор нь, эсвэл жижиг багуудад хуваагаад, дараах асуултуудын дагуу хэлэлцүүлэг хийгээд, дараа нь бусад оролцогчдод илтгэх даалгавар өг.





- ХБХЭК-ийн заалтууд ямар утга санааг илэрхийлж байна вэ?
- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдээс ялгаатай хэрэгцээтэй гэдгийг онцлон дурьдах шаардлагатай юу?
- Эдгээр заалтууд танай улс оронд ямар байдлаар хэрэгждэг, эсвэл хэрэгжихгүй байна вэ? Танай гэр бүлд?

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЭМЭГТЭЙ УДИРДАГЧИД

*Дэлхий нийтийг хамарсан хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн энэхүү бүлэгт багтаж байгаагаараа би бахархдаг. Үүний хажуугаар энэ нь улам даамжирч байгаа хөгжлийн бэрхшээл, гунигт ирээдүйдээ шаналсан ганцаардмал жижигхэн охин байсан үеийг минь надад санагдуулдаг. Харин одоо би ганцаардлыг мэдэрдэггүй, сэтгэл хангалуун нэгэн болсон. Одоо бид өөрсдийн байгуулсан хөдөлгөөний эрч хүчтэй, ухаалаг, үр бүтээлтэй удирдагчид болсон. Бид бие биенээ мэдлэг, эрх мэдэл, харилцаа холбоо, итгэл найдвараар дэмждэг хүмүүс. Үнэндээ бид хөгжлийн бэрхшээлтэй залуу охин, бүсгүйтэй тааралдах болгондоо үүнийг хийдэг бөгөөд түүнд шинэ мэдлэг, шинэ нөөц, бие биетэйгээ холбоотой, нэг нэгнээ дэмждэг хүчтэй, чадалтай хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бүхэл бүтэн ертөнцийн тусламжтайгаар алагчлал, ялгаварлан гадуурхалтай тэмцэх шинэ арга замыг түүнд санал болгодог.*

Дина Радтке

Эмэгтэйчүүдийн хорооны тэргүүн

Олон улсын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага, 1999 он

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд дэлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах хөдөлгөөний идэвхтэй, манлайлах хэсэг болоод зогсохгүй хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн асуудлуудад тусгайлан анхаардаг бие даасан хараат бус байгууллага, зөвлөл, хороо байгуулан ажиллаж байна. Энэ бүхэн нь амар хялбар байгаагүй нь ойлгомжтой. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бие даан амьдрах эрхийн төлөө тэмцдэг үндэсний болон олон улсын байгууллагуудын үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд онцгой чухал байдаг асуудлууд маш бага орон зайг эзэлсээр байна. Харин хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн холбоо, сүлжээнүүд нь энэ байдалд хэрхэн нөлөөлж болохыг маш ухаалгаар шийдэж байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд өөрсдийн тодорхойлон гаргасан зорилтуудаа төрөл бүрийн тогтоол шийдвэрт тусгуулж чадсаны дотор 1995 оны НҮБ-ын Эмэгтэйчүүдийн их хурлаар баталсан “Үйл ажиллагааны үндэс баримт бичиг”-ээс авахуулаад тодорхой улс орон, байгууллагуудын гаргасан хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эсрэг олон жилийн ялгаварлан гадуурхлыг устгах зорилготой төлөвлөгөөнүүд хүртэл багтаж байгаа юм. Хүний эрхийн асуудлуудаар хамтран ажиллахаар нэгдсэн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн үйл ажиллагаа нь дэлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах нөлөөллийн хөдөлгөөний чухал нэгэн хэсэг мөн. (Дараах хайрцагт өгсөн мэдээллийг үз.)

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛАХ ЗОРИЛГОТОЙ ОЛОН УЛСЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

**1995 оны Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн асуудлаарх симпозиумыг** НҮБ-ын дэлхий дахины Дөрөвдүгээр уулзалт болон Эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын Бээжингийн чуулга уулзалтын угтал болгож АНУ-ын Мобилити Интернэшнл (МИАНУ) байгууллагаа зохион байгуулсан

1995 оны **Төрийн бус байгууллагуудын Бээжингийн чуулга уулзалт, НҮБ-ын дэлхий дахины Дөрөвдүгээр уулзалтын үеэр зохиогдсон Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хуралдааныг** “Олон улсын хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн холбоо” гэж нэрлэгдсэн хөгжлийн бэрхшээлтэй манлайлагч эмэгтэйчүүдийн хороо зохион байгуулсан.

**1997 онд** АНУ-ын Мобилити Интернэшнл байгууллага **Манлайлал болон хөгжлийн бэрхшээлийн асуудлаарх олон улсын эмэгтэйчүүдийн хүрээлэн** нэртэй үйл ажиллагааг зохион байгуулж, АНУ-д манлайллын асуудлаар зохиогдсон хоёр долоо хоногийн эрчимжүүлсэн сургалтад дэлхийн олон орныг төлөөлсөн 35 хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйг хамруулсан.

**1997 онд Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн асуудлаарх олон улсын чуулга уулзалтыг** АНУ-ын Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний департаментуудын дэмжлэгтэйгээр Дэлхийн хөгжлийн бэрхшээлийг судлах институт болон Нөхөн сэргээлтийн олон улсын байгууллага зохион байгуулжээ.

**1998 онд МИАНУ-ын олон улсын симпозиумыг “Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд зориулсан бичил зээл”** сэдвийн дор АНУ-ын Орегон мужийн Южин хотод зохион байгуулсан.

**2000 онд МИАНУ-ын олон улсын симпозиумыг “Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн манлайлал, ажил эрхлэлтийн глобаль боломжууд”** сэдвийн дор АНУ-ын Орегон мужийн Южин хотод зохион байгуулсан.

**2006 онд НҮБ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг** баталсан. “Олон улсын хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн холбоо” нэртэй байгууллагаас санаачлан хэрэгжүүлсэн Эмэгтэйчүүдийн хуралдааны хүчин чармайлтын үр дүнд ХБХЭК-д хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, хүйсийн холбогдолтой бусад заалтууд орсон.

### ДАСГАЛ 16.5 Амлалт авах нь

<b>Зорилт:</b>	Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидын эрхийн асуудалд эдлэх эрх, хүлээх үүргийн аль аль нь багтаж байгааг онцлох, энэ талаар гүнзгийрүүлэн судлах
<b>Хугацаа:</b>	30 минут
<b>Хэрэглэгдэхүүн:</b>	Том цаас, фломастер эсвэл самбар, шохой



## 1. Үйл ажиллагаа

- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидын эрхийн асуудлыг судалж энэ талаар мэдлэг, ойлголттой болсны эцэст тодорхой нэг үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд бэлэн болсон эсэхийг оролцогчдоос асуу.
- Мэдээлэл цуглуулах, ажлаа төлөвлөх гээд хийх зүйл их байгаа ч өөрчлөлт хийх чин эрмэлзэл маш чухал гэдгийг тэмдэглэн хэл.
- Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийн ялгаварлан гадуурхлаас ангид байж, эрх тэгш байх эрхээ бүрэн эдлэхэд нь нэмэр болох жижиг ч хамаагүй ямар ажлыг ирэх сард хийхийг хүсэж байгаа, хийх боломжтой байгааг оролцогч бүрээр хэлүүл.
- Хүн бүрийн амлалтыг том цаас юмуу самбар дээр бичээд, сургалтын дараа оролцогчдын хийхээр амласан үйл ажиллагаануудыг тоймлон бичээд бүх хүнд тарааж өг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах нөлөөллийн ажил хэрхэн төлөвлөх талаар “Хэсэг 3. Нөлөөлөл! Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа” (хуудас 278) хэсгээс уншина уу.

### ЖЕНДЕР БОЛОН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХОЛБООТОЙ НЭМЭЛТ МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд спортын талбарт:  
<http://www.feminist.org/sports/disability.html>
- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн интернетийн сүлжээ:  
<http://www.disabilityhistory.org/dwa/>
- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн төлөө ажилладаг олон улсын байгууллага, тэдний түншүүдийн жагсаалт:  
<http://groups.yahoo.com/group/d-wild>
- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд хамааралтай асуудлуудыг хариуцсан байгууллага, хороод:  
[http://www.dpi.org/en/resources/topics/women/02-11-05\\_orgs.htm](http://www.dpi.org/en/resources/topics/women/02-11-05_orgs.htm)

## БҮЛЭГ 17: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМЫН БУСАД БҮЛГИЙН ХҮНИЙ ЭРХ

### НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци

#### Удиртгал (хэсэгчилсэн ишлэл)

Энэхүү конвенцид Оролцогч улсууд

- (i) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч [байна]
- (k) төрөл бүрийн баримт бичиг баталж, үүрэг хүлээлгэсэн хэдий ч дэлхийн аль ч өнцөг буланд тэдгээр хүний эрх зөрчигдөж, нийгмийн амьдралд бусадтай адил тэгш оролцоход саад учирсаар байгаад санаа зовниж [байна]
- (p) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэс угсаа, гарал үүсэл, нийгмийн гарал, өмч хөрөнгө, төрсөн байдал, нас болон бусад байдлаараа давхар болон хүнд хэлбэрийн алагчлалд өртөх хэцүү нөхцөл байсаар байгаад сэтгэл гүнээ зовниж [байна]
- (t) хөгжлийн бэрхшээлтэй ихэнх хүн ядуу нөхцөлд амьдарч байгааг тэмдэглэж, үүнтэй холбоотойгоор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст сөрөг нөлөө үзүүлж буй ядуурлын асуудлыг шийдвэрлэх нэн шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрч [байна]

### ЗОРИЛТУУД

Энэ бүлгийн сэдэв, үндсэн мэдээлэл, дасгалууд нь оролцогчдод дараах зорилтыг хангахад туслах зорилготой:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын доторх янз бүрийн дэд бүлгүүдэд тулгардаг ялгаварлан гадуурхлын олон төрөл хэлбэрийг ойлгож мэдэх, тэдний эсрэг ялгаварлан гадуурхал нь хүний эрхийн асуудал мөн болохыг ойлгох;
- Нийгмийн эдгээр бүлгүүдийн эрх хэрхэн хангагдаж эсвэл зөрчигдөж байгааг мэддэг болох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ашиг сонирхлыг нь хөндсөн асуудлуудаар шийдвэр гаргахад оролцуулах, үүний дотор улс орны хөгжлийн асуудлуудаар шийдвэр гаргахад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангахын ач холбогдлыг тайлбарлаж сурах;
- Олон төрөл, хэлбэрийн ялгаварлан гадуурхалд өртөх эрсдэлтэй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах чиглэлээр НҮБ-ын **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци (ХБХЭК)**-ийн заалтуудыг ойлгох, хэрэглэж сурах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг баталгаажуулахад ашиглаж болох стратегиудыг мэддэг болох.



## ЭХЛЭХ: ОЛОН ТӨРЛИЙН ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛД ӨРТСӨН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЭХ НЬ

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс олон асуудлаар анхаарлын гадуур үлдэж, хөгжлийн бэрхшээлээсээ үүдэлтэй ялгаварлан гадуурхалд өртсөөр байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын зарим бүлгүүд нь нийгмийн статус, эсвэл цөөнхийн бүлэгт багтаж байгаагаас болж давхар юмуу илүү хүчтэй алагчлалд өртдөг. Тэд хөгжлийн бэрхшээлээсээ болж, мөн нас, хүйс, нийгмийн орчин, эрүүл мэндийн байдал зэрэг бусад шинж чанар, нөхцөл байдал, амьдарч буй орчноосоо болж ялгаварлан гадуурхагддаг. Давхар ялгаварлан гадуурхал нь олон шалтгаан, хүчин зүйлээс үүсэж болох бөгөөд эдгээрийн зарим нь арьсны өнгө, яс үндэс, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэстэн, ястан, уугуул статус юмуу нийгмийн гарал үүсэл, өмч хөрөнгө, төрсөн гэр бүл, нас, бэлгийн чиг баримжаа, ядуурал зэрэг статустай нь холбоотой байдаг. Эрчимтэй туслалцаа, дэмжлэг шаардах төрөл, хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүн мөн хүчтэй алагчлалын бай болж мэднэ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс амьдралын янз бүрийн нөхцөл байдал, орчинд ялгаварлан гадуурхалтай тулгардаг. Зэвсэгт мөргөлдөөн юмуу байгалийн гамшгаас үүдэлтэй хүмүүнлэгийн хямралт нөхцөлд амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хөгжлийн бэрхшээлийн улмаас, мөн дүрвэгч, шилжин суурьшигчийн статусаасаа болж гадуурхагддаг. ДОХ/ХДХВ-ийн халдвартай, эсвэл бусад төрлийн халдварт өвчтэй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэндийн байдал нь гадуурхагдах шалтгаан болно.

Хөгжлийн бэрхшээлтэй бүх хүний үндсэн эрх чөлөө, хүний эрхийг дээд зэргээр баталгаажуулах арга замуудыг эрэлхийлэхдээ дээрх ялгаа, бусад олон төрлийн шинж чанар, нөхцөл байдлыг харгалзах шаардлагатай болдог.

### **Ялгаварлан гадуурхлын олон янзын шалтгааныг олж тодорхойлох**

2000 онд Европын холбооноос баталсан Хүний суурь эрхийн дүрэмд хүний эрхийн олон асуудлын зэрэгцээ нэгэн онцлог заалт багтсан нь орчин цагийн хүний эрхийн хуулиудаар баталгаажсан үл алагчлах тухай заалтуудын дотроос хамгийн алсын хараатай заалт болж чаджээ.

21.1 дүгээр зүйлд “Аливаа ялгаварлан гадуурхал, үүний дотор хүйс, үндэс, арьсны өнгө, болон нийгмийн гарал, үндэстний болон нийгмийн гарал үүсэл, генетикийн онцлог, хэл, шашин шүтлэг, итгэл үнэмшил, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний цөөнх, өмч, төрсөн байдал, хөгжлийн бэрхшээл, нас, бэлгийн чиг баримжаа зэргээр ялгаварлан гадуурхахыг хориглоно”<sup>1</sup> гэжээ.

Уг хуулийн үл алагчлах тухай заалт нь ямар ч үндэслэлээр, үүний дотор энэхүү заалтад онцгойлон заасан болон заагаагүй үндэслэлээр ялгаварлан гадуурхаж болохгүй гэдгийг тодорхой илэрхийлж чаджээ.

1 [http://www.europarl.europa.eu/charter/default\\_en.htm](http://www.europarl.europa.eu/charter/default_en.htm) сайтыг үз.

## ДАСГАЛ 17.1: Давхар ялгаварлан гадуурхлын үр дагавар

<b>Зорилт:</b>	Давхар ялгаварлан гадуурхлын үр дагаврыг ойлгож мэдэх
<b>Хугацаа:</b>	60 минут
<b>Хэрэглэгдэхүүн:</b>	Цаас, харандаа

### 1. Санал солилцох

Хөгжлийн бэрхшээлийн янз бүрийн төрлийг оролцогчдоор нэрлүүл (бие махбодын, мэдрэхүйн, сурах, оюуны, сэтгэц-нийгмийн хөгжлийн бэрхшээл гэх мэт). Хөгжлийн бэрхшээлийн төрөл нэг бүрийг тусдаа зурвас цаасан дээр бичүүлнэ. Зурвас цааснуудыг цуглуулж аваад, саванд хий.

Дараа нь ялгаварлан гадуурхагддаг нийгмийн бүлгүүдийг оролцогчдоор нэрлүүл (шашны болон үндэсний цөөнх, уугуул иргэд, цагаач болон шилжин суурьшигч, өнгөт арьстан, ядуу хүмүүс, ДОХ/ХДХВ-той хүмүүс гэх мэт). Оролцогчдын нэрлэсэн нийгмийн бүлэг бүрийг жижиг зурвас цаасан дээр бичээд, өөр хайрцагт цуглуулж хийнэ.

### 2. Төсөөлөх/хэлэлцэх

Оролцогчдыг жижиг багуудад хуваа. Баг болгон нь тодорхой шинж чанар бүхий нэг хүнийг төсөөлж бодох ёстой бөгөөд энэ хүний шинж чанаруудыг хөгжлийн бэрхшээлийн төрлөөс нь эхлүүлэн савнаас сугална гэдгийг тайлбарла. Баг бүр хөгжлийн бэрхшээлийн төрлүүдийг агуулсан савнаас нэг цаас сугалаад, энэ төрлийн хөгжлийн бэрхшээлийн улмаас энэ хүн ямар ямар ялгаварлан гадуурхалд өртөж болохыг багаараа хэлэлцэнэ.

### 3. Төсөөлөх/хэлэлцэх

Тав орчим минутын дараа энэ хүнд хөгжлийн бэрхшээлээс гадна ялгаварлан гадуурхагдах үндэс болж мэдэх өөр нэг шинж байгааг зарла. Багуудаар нийгмийн бүлгүүдийн нэрийг агуулсан хоёрдахь савнаас нэг зурвас цаас сугалуулна. Одоо энэ хүн ямар ямар нэмэлт ялгаварлан гадуурхалд өртөж болохыг багаараа төсөөлөн хэлэлцэх даалгавар өг.

### 4. Төсөөлөх/хэлэлцэх

5 минутын дараа энэ хүнд ялгаварлан гадуурхлын шалтгаан болж мэдэх өөр нэг шинж байгааг хэлээд, нийгмийн бүлгүүдийн нэрийг агуулсан хоёрдахь савнаас дахин нэг зурвас цаас багуудаар сугалуулна. Багууд энэ хүн өөр ямар ямар ялгаварлал, алагчлалд өртөж мэдэх тухай төсөөлөн хэлэлцэнэ.

### 5. Хэлэлцэх

Оролцогчдыг буцааж байранд нь суулгаад, баг болгоны илтгэгчийг гарч ирж багаараа төсөөлсөн хүнийг “танилцуулаад”, энэ хүнд тулгарах олон давхар ялгаварлан гадуурхлыг тайлбарлахыг хүс.

### 6. Хэлэлцэх/стратеги боловсруулах

Багуудын төсөөлсөн эдгээр хүмүүст тулгарч байгаа ялгаварлан гадуурхлын төрөл, хэлбэрүүдийг устгахын тулд ямар алхмууд хийж болохыг хэлэлц. Хэлэлцүүлэгтээ дараах асуултуудыг ашигла:

- Зарим төрлийн ялгаварлан гадуурхлыг арилгахад бусад төрлөөсөө илүү хүнд, хэцүү байдаг уу?



- Зарим төрлийн ялгаварлан гадуурхал нь бусдаасаа илүү хор хөнөөл, шаналал дагуулдаг уу?
- Зарим төрлийн ялгаварлан гадуурхал нь бусдаасаа хамаагүй алс хэтийн үр дагавартай байх уу?
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгардаг давхар давхар ялгаварлан гадуурхлыг устгахын тулд юу хийж болох вэ?

**ДАВХАР ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛД ӨРТСӨН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ТАЛААР ОЛОН УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ЭРХЗҮЙД ЮУ ГЭЖ ЗААСАН БАЙДАГ ВЭ?**

Үл алагчлах зарчим бол хүний эрхийн эрхзүйн суурь хэм хэмжээний нэг юм. Тодорхой байдлаасаа болж ялгаварлан гадуурхалд өртөж мэдэх хүмүүсийн эрхийг хүний эрхийн хуулиудад маш тодорхой хүлээн зөвшөөрсөн байдаг. Үнэхээр ч **НҮБ-ын дүрэмд** оруулж өгсөн үл алагчлалын тодорхойлолт нь хүний эрхийн хамгааллын тулгын чулуу юм. Энэ баримт бичигт НҮБ нь “бүх хүний эрх, эрх чөлөөг үндэстэн ястан, хүйс, хэл буюу шашин шүтлэгээр нь үл алагчлан нийтлэгээр хүндэтгэж, хэрэгжүүлэх явдлыг”<sup>2</sup> дэмжинэ гэжээ. Олон улсын хүний эрхийн гол конвенциуд нь үл ялгаварлан гадуурхах тухай зүйл, заалтуудыг агуулсан байдаг ба эдгээр нь НҮБ-ын дүрэмд багтсан үл алагчлах зарчимд үндэслэжээ.

**Хүний эрхийн түгээмэл тунхаглалд<sup>3</sup>:**

*“Хүн бүр энэ Тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой” гэж заажээ.*

**Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИУТЭОУП)<sup>4</sup>-д ХЭТТ-д** тодорхойлогдсон үл алагчлах зарчмыг давтсан заалт, эрэгтэй эмэгтэй хүмүүс эрх тэгш байх тухай заалт, үндэстэн, шашны болон хэлний цөөнхөд багтаж байгаа хүмүүст өөрийн бүлгийн бусад хүмүүстэй хамтран өөрийн соёлыг хадгалах, өөрийн шашныг шүтэж хөгжүүлэх, өөрийн хэлийг ашиглах эрх зэргийг хангасан заалтууд багтжээ.

Хүний эрхийн тодорхой асуудлуудыг авч үзсэн конвенциудыг боловсруулахдаа нийгмийн цөөнх, эсвэл онцгой эмзэг бүлэгт багтаж байгаагийн улмаас хүний эрхээ эдлэхдээ нэмэлт саад, бэрхшээлтэй тулгарч болох нийгмийн бүлгүүдийн эрхийг нарийвчлан авч үзэх хандлага баримталжээ. Эдгээр баримт бичгийн дотор, тухайлбал, **Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенци<sup>5</sup>, Арьсны өнгөөр алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенци<sup>6</sup>, Хүүхдийн эрхийн конвенци<sup>7</sup>, Цагаач**

2 <http://www.un.org/aboutun/charter> сайтаас үз.  
 3 <http://www.unhchr.ch/udhr/lang/eng.htm> сайтаас үз.  
 4 <http://www.ohchr.org/english/law/ccpr.htm> сайтаас үз.  
 5 <http://www.ohchr.org/english/law/cedaw.htm> сайтаас үз.  
 6 <http://www.ohchr.org/english/law/cerd.htm> сайтаас үз.  
 7 <http://www.ohchr.org/english/law/crc.htm> сайтаас үз.



**ажилчид болон тэдний гэр бүлийн гишүүдийг хамгаалах тухай конвенци**<sup>8</sup> зэрэг багтана. Уугуул иргэдийн эрхийг 2007 оны 9 дүгээр сард НҮБ-ын баталсан **Тусгаар тогтносон улс орнууд дах уугуул болон омгоор амьдардаг иргэдийн эрхийн тухай конвенци**<sup>9</sup> (ОУХБ №169), **Уугуул иргэдийн эрхийн тунхаглал**<sup>10</sup> зэрэгт авч үзсэн байна. Хүн амын бусад бүлгүүд ч (жишээлбэл, өндөр настнууд) эрхээ хүндэтгүүлж, хүлээн зөвшөөрүүлэхийн тулд шинээр пакт, конвенци болон заавал дагаж мөрдөх албагүй бусад баримт бичиг батлуулахыг хүсэж байгаа юм.

Хөгжлийн бэрхшээлийнхээ улмаас хүмүүс зарим төрлийн ялгаварлан гадуурхалд өртөх явдал гарсаар байгааг ХБХЭК-д хүлээн зөвшөөрч, эдгээрийг тодорхойлж тогтоохын зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй хүн нь өөр төрлийн ялгаварлан гадуурхалд өртөх магадлалтай нийгмийн бүлэгт хамаардаг бол давхар алагчлалд өртөж болохыг сануулжээ. Улмаар ийм хүний эмзэг байдал улам гүнзгийрч, хүний эрхээ эдлэхэд нь түүнд нэмэлт хүндрэл, бэрхшээл тулгардаг ажээ. ХБХЭК-ийн Удиртгал хэсэгт:

- хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч,
- нэн түрүүн дэмжлэг үзүүлэх шаардлагатай байгаа хүмүүсийг оролцуулан хөгжлийн бэрхшээлтэй бүх хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих хэрэгцээ байгааг хүлээн зөвшөөрч,
- хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэс угсаа, гарал үүсэл, нийгмийн гарал, өмч хөрөнгө, төрсөн байдал, нас болон бусад байдлаараа давхар болон хүнд хэлбэрийн алагчлалд өртөх хэцүү нөхцөл байсаар байгаад сэтгэл гүнээ зовниж,
- хөгжлийн бэрхшээлтэй ихэнх хүн ядуу нөхцөлд амьдарч байгааг тэмдэглэж, үүнтэй холбоотойгоор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст сөрөг нөлөө үзүүлж буй ядуурлын асуудлыг шийдвэрлэх нэн шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрчээ.

ХБХЭК-д заасан хүний бүх эрх нь цөөнхийн бүлэгт хамаарч буй эсэх, нийгмийн ямар нөхцөлд амьдралын ямар орчинд амьдарч байгаагаас үл хамааран хөгжлийн бэрхшээлтэй бүх хүнд хамааралтай. ХБХЭК-ийн бүх ерөнхий зарчим нь тухайн нийгмийн бүлгийг уг баримт бичигт тухайлан дурьдсан эсэхээс үл хамааран хөгжлийн бэрхшээлтэй бүх хүний эрхийг хамгаалах үндэс суурь болох ёстой. Улмаар Ерөнхий зарчмын 3 дугаар зүйл нь олон давхар ялгаварлан гадуурхалд өртөх магадлалтай хүмүүсийн эрхийг хамгаалах нөлөөллийн ажилд ашиглаж болох чухал заалт юм. 3 дугаар зүйлд багтсан хэд хэдэн зарчмыг онцгойлон дурьдахад илүүдэхгүй:

**Алагчлахгүй байх зарчим:** Хөгжлийн бэрхшээлээр болон бусад шалтгаанаар ялгаварлан гадуурхахыг хориглоно гэсэн утгыг илэрхийлнэ.

**Нийгэмд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох болон хамрагдах зарчим:** Хөгжлийн бэрхшээлтэй бүх хүн, үндэсний цөөнхөд хамаарч буй эсэх болон нийгмийн болон амьдралын бусад нөхцөл байдлаасаа үл хамааран орон нутаг, нийгмийнхээ амьдралд бүрэн оролцох, өөрсдийнх нь ашиг сонирхолд хамааралтай асуудлаар шийдвэр гаргалтад оролцох эрхтэй гэсэн утгыг илэрхийлнэ.

8 <http://www.ohchr.org/english/law/cmw.htm> сайтаас үз.

9 <http://www.ohchr.org/english/law/indigenous/htm> сайтаас үз.

10 <http://www.ohchr.org/english/issues/indigenous/docs/draftdeclaration.pdf> сайтаас үз.

**Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлог байдлыг хүндэтгэх, тэднийг хүний олон талт байдал, хүн төрөлхтний нэг хэсэг гэж хүлээн авах зарчим:** Хүн төрөлхтний ялгаатай байдал, үүний дотор хөгжлийн бэрхшээл болон бусад шинж чанарт суурилсан ялгаатай байдлыг хүндэтгэж, үнэлж хандана гэсэн утгыг илэрхийлнэ.

**Тэгш боломж олгох зарчим:** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмийн цөөнх, бусад нөхцөл байдал, орчноос үл хамааран тэгш боломжоор хангагдана гэсэн утгыг илэрхийлнэ.

**Эрэгтэй, эмэгтэйчүүд эрх тэгш байх зарчим:** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрэгтэй, эмэгтэйгээсээ үл хамааран эрх тэгш байхыг хүлээн зөвшөөрснөөр хөгжлийн бэрхшээл болон хүйсээр давхар гадуурхалтаас хамгаалах үндэс суурь болсон зарчим юм.

**Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьсаж өөрчлөгдөх чадамжийг хүндэтгэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өөрийн онцлог байдлаа хадгалах эрхийг хүндэтгэн хандах зарчим:** Хүүхдийн эрхийг хүлээн зөвшөөрч, хөгжлийн бэрхшээл болон насаар нь үл ялгаварлан гадуурхах асуудлуудыг тусгажээ.

## **ДАСГАЛ 17.2: Давхар ялгаварлан гадуурхалд өртдөг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ямар эрхийг ХБХЭК-д баталгаажуулсан бэ?**

**Зорилт:** Давхар ялгаварлан гадуурхалд өртдөг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг судалж, ойлгох

**Хугацаа:** 30 минут

**Хэрэглэгдэхүүн:** Том цаас, фломастер эсвэл самбар шохой хэрэглэх

### **1. Бататгах**

Оролцогчдыг жижиг багуудад хуваа. Багууд нь ХБХЭК-ийн Удиртгал хэсгийн зүйл заалтуудыг энгийн үг хэллэгээр өөрчлөн найруулаад, эдгээр заалтууд нь эмзэг бүлгийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрхээ эдлэхэд хэрхэн тус болох талаар жишээ гаргах даалгавар авна.

### **2. Энгийн үг хэллэгээр илэрхийлэх**

ХБХЭК-ийн Удиртгал хэсгийн зүйл, заалтуудыг чангаар уншиж өг. Таслал, эсвэл утгат хэсэг бүрийн дараа зогсож, тухайн хэсгийг багууд энгийн үг хэллэгээр хэрхэн өөрчлөн найруулсныг сонс. Бүх хүн санал нэгтэй зөвшөөрсөн нэгдсэн найруулга гартал хэлэлцүүлгээ үргэлжлүүл. Эцсийн найруулгыг том цаасан дээр бич.

### **3. Жишээ гаргах**

ХБХЭК-ийн Удиртгал хэсэгт орсон эдгээр эрхийг хэрхэн эдлэх, ингэснээрээ давхар ялгаварлан гадуурхалд өртдөг хөгжлийн бэрхшээлтэй янз бүрийн бүлэг хүмүүсийн амьдралд ямар өөрчлөлт гарахыг харуулсан жишээ гаргуул.

### **4. Хэлэлцэх**

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах асуудлыг үндэсний хэмжээний бодлогын асуудал болгож тавих, мөн улс төрийн нам, шийдвэр гаргагчдад өргөн барих үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулахад ХБХЭК-ийн эдгээр заалтуудыг хэрхэн ашиглаж болох вэ?

## ХӨГЖЛИЙН АСУУДЛААРХ ШИЙДВЭР ГАРГАЛТАД ЯДУУ АМЬДРАЛТАЙ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ОРОЛЦОО

Ядуурал бол нийгмийн олон талбарт давхар эмзэг байдлыг үүсгэдэг статус мөн. НҮБ-ын тооцоолсноор 20 хүн тутмын нэг нь хөгжлийн бэрхшээлтэй бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 75-аас дээш хувь нь хөгжиж буй оронд амьдарч байна.<sup>11</sup> Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ядуучуудын дотроо хамгийн ядуу бүлэгт багтах нь элбэг. Дэлхийн Банкны тооцоолсноор дэлхийн хамгийн ядуу таван хүн тутмын нэг нь хөгжлийн бэрхшээлтэй байна.<sup>12</sup> Харамсалтай нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст боловсрол, хөдөлмөр эрхлэлт, орон байр, эрүүл мэнд, нөхөн сэргээлт, тээвэр болон амралт соёлын үйлчилгээтэй холбоотой эрхээ эдлэхэд нь саад болдог тотгор, бэрхшээлүүд нь мөн тэдний амьдралыг сайжруулах нөлөө үзүүлж чадах хөгжлийн үйл ажиллагааны төлөвлөлтөд оролцоход нь саад болдог. Хөгжлийн төсөл, хөтөлбөрийг төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх ажилд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүрэн дүүрэн оролцуулах нь ядуурлыг бууруулах стратегиудыг амжилтад хүргэхэд онцгой чухал нөлөөтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд, тэдний түншүүд нь олон улсын хөгжлийн үйл ажиллагааг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дуу хоолойг харгалздаг, тэдний хэрэгцээг анхаардаг болгохын төлөө ажиллаж байна.

Хөгжлийн холбогдолтой шийдвэр гаргалтад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцуулах нь ядуурлыг бууруулах, хариуцлагатай хөгжлийг бий болгох амлалтыг хэрэгжүүлэхэд чухал нөлөөтэй. **ХБХЭК** нь хөгжлийн үйл явцуудад хөгжлийн бэрхшээлийн асуудлыг хамруулах шаардлагатай байгааг хүлээн зөвшөөрчээ. Конвенцид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангахад олон улсын хамтын ажиллагаа чухал болохыг онцлоод, олон улсын хамтын ажиллагаа, үүний дотор олон улсын хөгжлийн төсөл хөтөлбөрүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцуулах, тэдэнд хүртээмжтэй байхад чиглэсэн арга хэмжээ авахыг Оролцогч улсуудад хандаж уриалжээ.

Олон улсын хөгжлийн байгууллагууд нь хөгжлийн төсөл, хөтөлбөрийн үр шимийг шууд хүртэх хүмүүс нь уг төсөл, хөтөлбөрүүдийг төлөвлөх ажилд аль болох эрт үеэс оролцуулахыг чухалчилж үздэг. Гэхдээ л ихэнх тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ийм үйл ажиллагаанд оролцож чаддаггүй. Дэлхийн Банк болон хөгжлийн бусад байгууллагууд нь энэ асуудлыг анхааралдаа авч, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг төрөл бүрийн хөгжлийн төсөл, хөтөлбөрийн төлөвлөлтөд оролцуулахыг хичээж байна (Доорх хайрцагт өгсөн мэдээллийг үз). Тэгш хамруулах зарчимд суурилсан хөгжлийн төлөвлөлтийг бодит ажил хэрэг болгохын тулд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудын идэвхтэй үйл ажиллагаа чухал юм.

11 Е. Хеландер. “Сүжиг ба нэр төр: Олон нийтэд түшиглэсэн нөхөн сэргээлт.” НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, 1992 он.

12 Анн Элбан. “Ядуурал ба хөгжлийн бэрхшээл: дэлхийн хөгжлийн тайлангийн суурь мэдээлэл,” Дэлхийн Банк, 1999 оны 10 сар.

## ДАСГАЛ 17.3: Хөгжлийн холбогдолтой асуудлаар шийдвэр гаргалтад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцуулах, хамруулахын төлөө дуу хоолойгоо нэмэрлэх нь

<b>Зорилт:</b>	Хөгжлийн холбогдолтой асуудлаар шийдвэр гаргалтад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцох эрхийг судлах
<b>Хугацаа:</b>	60 + минут
<b>Хэрэглэгдэхүүн:</b>	Том цаас, фломастер, эсвэл самбар шохой

### 1. Санал солилцох

Орон нутагтаа хөгжлийн холбогдолтой шийдвэр гаргалтын ямар үйл ажиллагаанд оролцоход (жишээлбэл, олон улсын хөгжлийн байгууллага, орон нутгийн засаг захиргааны байгууллага, шашны тэргүүн зэрэгтэй ажиллахад г.м) саад бэрхшээл тулгардагийг оролцогчдоос асуугаад, хариултыг жагсааж бич. Оролцогчдыг жижиг багуудад хуваагаад, баг болгон оролцоо, хамрагдалтыг хангалгүйгээр шийдвэр гаргадаг хөгжлийн холбогдолтой үйл ажиллагааны нэг чиглэл, талбарыг сонгон авч (хөгжлийн төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжгүй автобус худалдаж авсан тохиолдол, эсвэл эрүүл мэнд, нийгмийн халамж, боловсролын талаар баримтлах бодлого г.м), энэ асуудалдаа төвлөрөн ажиллах даалгавар авна.

### 2. Төлөвлөх

Баг тус бүр “Орон нутгийн хөгжлийг удирдах хороо”-нд зориулж таван минутын илтгэл бэлдэнэ. Илтгэлдээ:

- Хөгжлийн холбогдолтой шийдвэр гаргах тодорхой үйл явцад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс оролцож чадахгүй байгаа байдлыг дүрслээд, энэ шийдвэрт өртөх х хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүлгүүдийг тодорхойлоод, хэрэв боломжтой бол асуудал/проблемын учир шалтгааныг дүрсэлнэ.
- Энэ асуудлыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхтэй холбон тайлбарлана.
- Энэ асуудал нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралд (хамааралтай бол мөн тэдний гэр бүл) хэрхэн нөлөөлж байгааг тодруулан тайлбарлана.
- Энэ асуудлыг шийдвэрлэснээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдрал хэрхэн сайжрахыг тайлбарлана.
- Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд авч хэрэгжүүлж болох тодорхой алхмуудыг санал болгоно.
- Асуудлыг шийдвэрлэхэд орон нутгийн иргэд хэрхэн оролцож болохыг тайлбарлана.

Багууд нэг илтгэгч, мөн “Орон нутгийн хөгжлийг удирдах хороо”-ны гишүүнээр “ажиллах” 1-2 хүнийг томилно. Багууд илтгэлээ төлөвлөж байх хооронд хорооны гишүүд тусдаа уулзаж, орон нутгийн тэргүүнүүдийн дунд нийтлэг тархсан хандлага, үзэл баримтлалуудыг төлөөлсөн дүрүүдийг хуваарилж авна.

### 3. Дүрд тоглох

Баг болгоноос томилогдсон илтгэгч нь багийнхаа боловсруулсан илтгэлийг тавьж, хорооны гишүүд илтгэлийг сонсож, оноож өгсөн дүрийнхээ өмнөөс хариулт, тайлбар, няцаалт өгөх, санал тавих зэргээр тоглоно.

#### 4. Хэлэлцэх

Илтгэлүүдээ тавьж дүрийн тоглолтуудаа хийж дуусаад дараах асуултын дагуу хэлэлцүүлэг хий:

- Асуудлыг танилцуулж байхад илтгэгчдэд ямар сэтгэгдэл төрж байсан бэ?
- Илтгэлүүдэд хорооны гишүүд хэрхэн хандсан бэ? Орон нутагт нийтлэг тархсан ямар хандлага, үзэл баримтлалууд илэрсэн бэ?
- Бусад оролцогчдоос бүрдсэн үзэгчид илтгэлүүдэд хэрхэн хандсан бэ?
- Илтгэгчдээс хэн нэг нь асуудлаа хүний эрхийн зөрчил талаас нь хөндөж тайлбарласан уу? Асуудлыг ийм байр сууринаас тайлбарласан нь аргумент, үндэслэлийг улам батжуулж чадсан уу?
- Энд дурьдагдсан санаанууд нь танай орон нутагт хэрэгжих магадлалтай юу? Тийм бол яагаад? Үгүй бол яагаад?

#### 5. Дүгнэх

Дараах асуултуудыг ашиглан оролцогчдод мэдлэгээ сорих, асуудлыг хэр цар хүрээтэй ойлгож байгаадаа үнэлгээ өгөх боломж олго:

- Оролцоонд саад болж байгаа бэрхшээл тотгорууд, тэдгээрийн үр нөлөөний талаарх мэдээллийг та хаанаас олж авсан бэ? Таны мэдээлэл үнэн зөв, бүрэн дүүрэн байж чадсан уу? Хэрэв үгүй бол, танд ямар нэмэлт мэдээлэл хэрэгтэй, түүнийг хэрхэн олж авах вэ?
- Та энэ асуудлаар болон энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралд хэрхэн нөлөөлж байгаа тухай хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй зөвлөлдсөн үү? Тэгвэл асуудлыг шийдвэрлэхийн тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухайд?
- Бодит амьдрал дээр хүний эрхийн нөлөөллийн ажил хийх гэж байгаа нөхцөлд тухайн асуудалд хамааралтай, энэ асуудлын нөлөөлөлд өртөх хүмүүсийг идэвхтэй оролцуулах нь ямар ач холбогдолтой вэ?
- Энэ дасгалыг та хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалахад чиглэсэн нөлөөллийн ажил төлөвлөх, хэрэгжүүлэхэд хэрхэн ашиглах вэ?



## Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг болон оролцоонд тулгуурласан хөгжил

Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг (ЯБС) гэсэн нэр томъёо нь 1999 онд Дэлхийн Банк, ОУВС-аас орлого багатай, өр ихтэй улс орнуудад ядуурлыг хэрхэн бууруулах, амьдралын нөхцлийг хэрхэн сайжруулах талаар үндэсний төлөвлөгөө гаргахад нь туслах зорилгоор гаргасан хөгжлийн баримт бичгийн нэгэн чухал төрөл юм. ЯБС-ийг боловсруулж баталсан улсууд нь Дэлхийн Банк, ОУВС, хандивлагч орнуудад хандан өрөө чөлөөлүүлэх хүсэлт тавьж болох төдийгүй хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр шинэ зээл, буцалтгүй тусламж авах эрхтэй болох юм. ЯБС нь тухайн улс орны хөгжлийн чиг баримжааг гаргаж өгсөн чухал төлөвлөгөө бөгөөд үүнд ядуурлыг бууруулахын тулд эн тэргүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тусгасан байдаг. Энэ болон үүнтэй төстэй баримт бичгүүдийг олон улсын хөгжлийн байгууллагууд өргөнөөр ашигладаг. ЯБС боловсруулах үйл явц нь олон сонирхогч талын идэвхтэй оролцоог хангасан дээд зэргийн нээлттэй үйл явц байх ёстой ажээ. Энэхүү үйл явцын үндсэн зарчим нь үндэсний ядуурлыг бууруулах стратеги боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцад иргэний нийгмийг идэвхтэй оролцуулах явдал юм. Харамсалтай нь, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ихэнхдээ энэхүү чухал үйл явцад оролцож чадалгүй хоцордог. Дэлхийн Банк нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудтай хамтран хөгжлийн холбогдолтой шийдвэр гаргалтад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцоог сайжруулахаар ажиллаж байна<sup>13</sup>.

### ДАСГАЛ 17.4: Давхар ялгаварлан гадуурхалд өртсөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах талаар амлалт авах нь

Хүний эрх гэдэг нь эдлэх эрх болон үүргийн нэгдэл гэдгийг тайлбарла.

- Давхар ялгаварлан гадуурхалд өртсөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаарх мэдлэгээ нэмэгдүүлснээр оролцогчид тодорхой үйл ажиллагаа хийхэд бэлэн болсон эсэхийг асуу.
- Мэдээлэл цуглуулах, ажлаа төлөвлөх гээд хийх зүйл их байгаа ч өөрчлөлт хийх чин эрмэлзэл маш чухал гэдгийг тэмдэглэн хэл.
- Давхар алагчлалд өртөж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрхээ бүрэн эдлэхэд нь нэмэр болох жижиг ч хамаагүй ямар ажлыг ирэх сард хийхийг хүсэж байгаа, хийх боломжтой байгааг оролцогч бүрээр хэлүүл.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах нөлөөллийн ажил хэрхэн төлөвлөх талаар “Хэсэг 3. Нөлөөлөл! Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа” (хуудас 278) хэсгээс уншина уу.

13 “Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичгийг боловсруулахад олон талын оролцоог хангах” 2006 оны 1 дүгээр сар. *Handicap International Christoffel-Blindenmission*. <http://siteresources.worldbank.org/DISABILITY/Resources/280658-1172608138489/MakingPRSPInclusive.pdf>



## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ТУХАЙ НЭМЭЛТ МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

- Хүүхэд ба хөгжлийн бэрхшээл:  
<http://www.un.org/esa/socdev/enable/comp501.htm>
- Хөгжлийн бэрхшээл, ядуурал ба хөгжил:  
<http://www.dfid.gov.uk.pubs/files/disability.pdf>
- Үндэсний цөөнх болон хөгжлийн бэрхшээл:  
<http://www.un.org/socdev/enable/comp507.htm>
- Насжилтын талаар авч байгаа дэлхий нийтийн арга хэмжээ:  
<http://www/globalaging.org>
- Насжилттай холбоотой туслалцаа үзүүлэх HelpAge International байгууллага:  
<http://www/helpage.org/home>
- Уугуул иргэд ба хөгжлийн бэрхшээл:  
<http://www.un.org/esa/socdev/enable/comp506.htm>
- Уугуул иргэдийн асуудлаарх олон улсын ажлын хэсэг:  
<http://www.iwgia.org>
- Цагаач ажилчид ба хөгжлийн бэрхшээл:  
<http://www.un.org/esa/socdev/comp509.htm>
- Ахмад хүмүүс ба хөгжлийн бэрхшээл:  
<http://www.un.org/esa/socdev/comp503.htm>
- Ядуу болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс:  
<http://www.un.org/esa/socdev/comp508.htm>
- ДОХ/ХДХВ-тэй иргэд ба хөгжлийн бэрхшээл:
- Дүрвэгсэд ба хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс:  
<http://www.un.org/esa/socdev/comp505.htm>
- Дэлхийн Банк, ДОХ/ХДХВ-тэй хүмүүс ба хөгжлийн бэрхшээл: нуугдмал дуу хоолойг сонсоё. Дэлхийн Банк, Йелийн Их сургуулийн хамтарсан ДОХ/ХДХВ-ын дэлхийн судалгаа (2004 он Вашингтон)  
<http://cira.med.yale.edu/globalsurvey/>
- Эмэгтэйчүүд ба хөгжлийн бэрхшээл:  
<http://www.un.org/esa/socdev/comp504.htm>



## ХЭСЭГ 3. НӨЛӨӨЛӨЛ!

### ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХАД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА



#### ГУРАВДУГААР ХЭСГИЙН АГУУЛГА

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа . . . . .	278
Нөлөөллийн ажлын үйл ажиллагааны төлөвлөгөө . . . . .	290
Нөлөөллийн үйл ажиллагааны төлөвлөгөөний маягт . . . . .	291



### ХЭСЭГ 3. НӨЛӨӨЛӨЛ!

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХАД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ЭХЭЛСНЭЭ ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ НЬ: НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

**Нөлөөлөл** бол эерэг өөрчлөлт гаргах зорилгоор хийж байгаа үйлдэл юм. Ихэнхдээ нийтлэг эрхэм зорилго, зорилтод хүрэхийн тулд олон хүн, байгууллага хамтран нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн төлөө хамгийн сайн өмгөөлөгч нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдөө юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний түншүүдийн идэвхтэй хамтын ажиллагааны үр дүнд л хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх хангагдаж, улмаар нийгэмд эерэг өөрчлөлтүүд гарна.

#### НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧУХАЛ БҮРДЭЛ ХЭСГҮҮД

**Хүний эрхийн талаар мэддэг байх**

**Өөрийнхөө талаар мэддэг байх**

**Үйлдэл хийх**

#### ХҮНИЙ ЭРХИЙН ТАЛААР МЭДДЭГ БАЙХ

Бүх хүн өөрийнхөө эрх, эрх чөлөөний талаар мэддэг байх ёстой! Энэхүү гарын авлагын эхний хоёр хэсэгт олон улсын эрхзүйгээр тодорхойлогдон, **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухайн конвенциар** баталгаажсан ямар эрхийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эдлэх ёстойг танилцуулахыг зорьсон билээ. Чухам хүний эдгээр эрхийг хэрэгжүүлэх үүднээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний түншүүд нь өөрсдийн амьдарч буй нийгэм, улс төрийн орчинд дүн шинжилгээ хийх, шахалт шаардлага тавих ёстой. Энэхүү мэдлэг нь ухамсрыг нэмэгдүүлж, тодорхой үйлдэл хийх, ялгаварлан гадуурхалттай тэмцэх, эдлэх ёстой эрхийнхээ төлөө тэмцэхэд хүмүүсийг дайчлан хөдөлгөдөг.

## Нөлөөллийн үйл ажиллагаанд хүний эрхийн хандлагыг ашиглах нь

Хөгжлийн бэрхшээлд хандах хүний эрхийн хандлага нь нийгэм, биет хүрээллийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст учирч байгаа хязгаарлалтуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн зөрчил гэж үздэг. Хүний эрхэд суурилсан хандлага нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг шаардаж, сурталчилж болох эрх болгон хувиргах чадалтай.

## ӨӨРИЙНХӨӨ ТАЛААР МЭДДЭГ БАЙХ

Өөрийн тухай мэдлэг, үр өгөөжтэй харилцаа хоёр нь өөрийнхөө эрхийг хамгаалах чадварлаг өмгөөлөгч болоход хамгийн чухал зүйлс юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдийнхөө давуу тал болон хэрэгцээг мэддэг, эрхээ хамгаалах нөлөөллийн ажлынхаа хүрээнд эдгээр хэрэгцээгээ үр дүнтэй таниулан тайлбарлах чадвартай байх шаардлагатай болж байна. Ямар ч чадварын нэгэн адилаар нөлөөлөл хийх чадварыг тогтмол ашиглан, дадлага туршлагаа нэмэгдүүлж байх хэрэгтэй. Нийгмийнхээ амьдралд идэвхтэй оролцож, хуулиар олгогдсон хүний эрхээ эдлэхийн тулд танд юу хэрэгтэй байгааг тайлбарлах дадлагыг хийж бай.

## ҮЙЛ АЖИЛЛАГАА

Мэддэг болсноор өөрчлөлт гарахгүй. ҮЙЛДЭЛ ХИЙСНЭЭР Л ӨӨРЧЛӨЛТ ГАРНА!

Та одоо мэдлэгтэй болсон бөгөөд эрхээ хамгаалах үр дүнтэй нөлөөллийн ажил хийх чадвараа хөгжүүлж байна. Үйл ажиллагаа явуулахад хүсэл зориг, чин эрмэлзэл маш чухал. Хэрэгжүүлж болох жижиг алхмуудаас ажлаа эхэл. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагын үйл ажиллагаанд оролцохоос эхэлж болно. Энэ нь нөлөөллийн ажил явуулах ур чадвараа хөгжүүлэхэд тань хэрэгтэй орчинг бүрдүүлж өгөхийн зэрэгцээ ижил төстэй туршлага, үзэл бодолтой хүмүүстэй холбоо тогтоож, тэдний нэг болохоо мэдрэхэд тань тусална.

Нөлөөллийг олон янзын зорилгоор явуулж болдог бөгөөд үүнд хувийн хэрэгцээгээ хангах, хөгжлийн бэрхшээлтэй бусад хүмүүсийн хэрэгцээг хангах, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй нийт хүмүүсийн хэрэгцээг хангах зэрэг зорилго тавьж болно. Мөн нөлөөллийг орон нутаг, үндэсний, олон улсын гэх мэт олон түвшинд хийж болно. Нөлөөллийн үйл ажиллагааны жишээ дурьдвал.

### Боловсролын үйл ажиллагаа

- **Өөрсдийгөө боловсруулах:** асуудлыг ойлгоход туслах мэдээлэл цуглуулах, сурч мэдсэн зүйлсдээ дүн шинжилгээ хийх
- **Бусдыг сургах:** шийдвэрлэх шаардлагатай асуудалд бусад түнш, олон нийтийн анхаарлыг татах, хэрхэн ямар арга замаар өөрчлөлт хийхийг хүсэж байгаагаа харуулах



- **Хандлагыг өөрчлөх:** тодорхой асуудлыг шийдэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар нийгэмд бүрэлдсэн буруу болон хэвшмэл ойлголтуудыг залруулах

### Улс төрийн үйл ажиллагаа

- **Бодлого боловсруулагчдад хандах:** олон нийтэд чиглэсэн бодлого боловсруулахдаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг анхааран тусгадаг болгохын тулд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй аливаа асуудлаар зөвлөлдөж, санаа бодлыг нь тусгаж байхын төлөө ажиллах
- **Хууль тогтоогчдод хандах:** хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах, тэдэнд дэмжлэг үзүүлэх чиглэлээр лоббидох
- **Төрийн албан хаагчдад хандах:** хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хүндэтгэсэн, хамгаалсан бодлого, журам, хуулийн хэрэгжүүлэх шаардлага тавих, шахалт үзүүлэх
- **Нийгмийн болон төрийн үйлчилгээ үзүүлэгчдэд хандах:** үйлчилгээний хүргэлттэй холбоотой асуудлуудаар үр өгөөжтэй харилцах. Жишээлбэл: банк, хүнсний бүтээгдэхүүн борлуулагч, нийгмийн ажилтан, эмнэлгийн ажилтнуудтай харилцах замаар үйлчилгээг сайжруулах

### Эрхзүйн үйл ажиллагаа

- **Шинэ хууль санаачлах:** хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхтэй холбоотой шинэ хуулийг дэмжсэн нөлөөллийн ажилд оролцох, ийм хууль боловсруулахад оролцох. Жишээлбэл, олон улсын эрхзүй, үүний дотор Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид нийцсэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх цогц хууль гаргахад чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа явуулах
- **Сөрөг нөлөөтэй хуулийг хүчингүй болгох:** хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрхээ эдлэхэд нь саад тотгор болж буй хуулийг хүчингүй болгох чиглэлд тодорхой алхам хийх. Жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг алагчилж гэр бүл болох эрхийг нь зөрчсөн хуулийг хүчингүй болгоход чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа явуулах
- **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэхээр ажиллах:** Жишээлбэл, шинээр барилга байшин барихдаа хүртээмжтэй байдлыг хангахыг шаардсан стандартуудыг баримтлаагүй тохиолдлыг мэдээлэх талаар тодорхой үйлдэл хийх, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудад боломжит тохируулга хангаж өгөх асуудлаар ажил олгогчдод сургалт явуулах.

Хувь хүмүүс, нийгмийн бүлгүүд нийтлэг зорилго, нэгдсэн зорилтыг хангахын төлөө хамтран ажилласнаар нөлөөллийн ажил улам их амжилтад хүрнэ. Урт хугацааны эерэг нөлөөтэй өөрчлөлтийг хийхэд, ялангуяа хуучинсаг хандлага, зуршлыг өөрчлөхөд цаг хугацаа хэрэгтэй гэдгийг туршлагатай өмгөөлөгчид сайн мэддэг. Тогтвортой, удаан хугацааны өөрчлөлт хийхийн тулд төлөвлөгөө гаргаж тууштай ажилладаг бөгөөд үүний зэрэгцээ мөн богино хугацааны зорилго, хүрэх түвшнээ тодорхойлдог.

Хүрсэн амжилтаа хамтдаа тэмдэглэж, нэгдсэн зорилго, харилцаа холбоогоо хөгжүүлэх бэхжүүлэхэд анхаарч цаг гаргаж байгаарай.

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хамтран ажилласнаар бид түнш хувь хүн, байгууллагуудынхаа ур чадвар, нөөцийг оновчтойгоор дайчилсан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж чадна. Түншүүд олсон амжилт, гарсан алдаа, мөн өрнөж буй үйл явдал, шинээр гарсан боломжуудад үндэслэн энэ төлөвлөгөөгөө тогтмол үнэлдэг.

Үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах нь тийм ч хэцүү ажил биш; (англиар) WH- асуултуудыг санаж байхад л хангалттай.

- **(What?) Юу/ямар?** Жишээ: *Ямар асуудлыг танай баг шийдвэрлэхийг зорьж байна вэ? Ямар үйл ажиллагаа хийх шаардлагатай вэ?*
- **(Who?) Хэн?** Жишээ: *Хэн энэ үйл ажиллагааг хийх вэ?*
- **(When?) Хэзээ?** Жишээ: *Хэзээ хийж дуусах вэ?*
- **(Where?) Хаана?**
- **(Why?/How?) Яагаад эсвэл хэрхэн?** Жишээ: *Хэрхэн (үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай) санхүүгийн, материаллаг болон хүний нөөцийг бүрдүүлэх вэ?*

Эдгээр асуултыг тавьснаар цаашдаа юу хийх гэж байгаа талаар хүн болгон тодорхой ойлголттой болно. Үйл ажиллагааны төлөвлөлтийн дараагийн алхам бол энэ төлөвлөгөө **биелэгдэхүйц** бөгөөд **үндэслэлтэй** болсон эсэхийг нягтлах явдал юм. Тодорхой нэг үйлдлийг хийж дуусаад дараах нэмэлт асуултуудыг тавьж ажлаа эргэн хянаарай:

- Энэ үйл ажиллагаа хэзээ болж өнгөрөв?
- Энэ үйлдлийн үр дүнд юу болсон бэ?
- Таны дараагийн алхмууд юу вэ?

## НӨЛӨӨЛЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН АЛХМУУД

### АЛХАМ 1: ХИЙХИЙГ ХҮСЭЖ БУЙ ӨӨРЧЛӨЛТӨӨ ТОДОРХОЙЛОХ (30 МИНУТ)

#### 1. Хэлэлцэх/жагсаалт гаргах

- Танай орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрхээ эдлэхэд ямар асуудал, саад бэрхшээл тулгардаг вэ? Тал талаасаа санаа гаргаад, том цаасан дээр жагсаан бич.
- Эдгээр асуудал, саад бэрхшээлийн аль нэгийг та өөрчилж чадахаар байгаа бол эдгээрээс аль нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралд хамгийн том өөрчлөлтийг авчирч чадах вэ? Тэдгээрийг одоор тэмдэглэ.

#### 2. Шинжлэх

Одоор тэмдэглэсэн нэг асуудал дээр ажиллахыг хүсэж байгаа хүмүүсийг нэг баг болгох замаар оролцогчдыг хэд хэдэн багт хуваа. Хэрэв олон хүн нэг буюу ижил төрлийн асуудлыг хэлэлцэхээр сонгосон бол нэг том бүлэг байснаас хэд хэдэн жижиг багт хуваагдах нь илүү үр дүнтэй гэдгийг ойлгуул.

Баг болгонд хэлэлцүүлэг хийхэд нь зориулж асуултын хуудас тарааж өг.





## Тараах материал №1

### Хийх гэж байгаа өөрчлөлтөө тодорхойлох

1. Та яг ямар өөрчлөлт хийхийг хүсэж байна вэ? Үүнийгээ том цаасан дээр цөөн хэдэн өгүүлбэрээр тайлбарлан бич.
2. Энэ өөрчлөлт нь хүний эрхийг дараах чиглэлээр бэхжүүлж байна уу:
  - **Хүндэтгэх** (хүний эрхийг хүлээн зөвшөөрүүлэх, эсвэл хүмүүс болон байгууллагын зүгээс хүний эрхийг зөрчих, хязгаарлахыг таслан зогсоох)
  - **Хамгаалах** (хүний эрхийг баталгаажуулсан хууль, хэм хэмжээнүүдийг зөрчих явдлыг зогсоох, зөрчигдөхөөс сэргийлэх)
  - **Хангах** (уг эрхийг баталгаажуулах, эдлэхэд нь туслах хангалттай дэмжлэг, санхүүжилт гаргасан, бусад эерэг үйлдлүүдийг хийсэн байх)
3. Өөрчлөхийг хүсэж буй тухайн нөхцөл байдлыг үүсгэж байгаа суурь шалтгаануудыг шинжлэн судал. Шалтгаан болгоныг аль болох олон өнцөг, талаас харахыг хичээгээрэй. Жишээлбэл:
  - Хандлага
  - Хууль
  - Нийгэм
  - Шашин, соёл
  - Төр засаг
  - Эрүүл мэндийн тогтолцоо
  - Хувь хүн, гэр бүл
  - Бусад талаас нь?
4. Бэрхшээл тус бүрийг үүсгэж байгаа эдгээр суурь шалтгааны аль нь хамгийн ноцтой шалтгаан бэ?

### 3. Илтгэх

Баг болгон бэлдсэн хариултуудаа бүх хүнд харагдах газар хадаад, хийхийг хүсэж байгаа өөрчлөлтийнхөө талаар хийсэн дүн шинжилгээгээ товч танилцуулна. Бүх оролцогчдоос ямар нэг санал, тайлбар байгаа эсэхийг асуу.

## АЛХАМ 2: ХИЙХИЙГ ХҮСЭЖ БУЙ ӨӨРЧЛӨЛТӨӨ ТОМЪЁОЛОХ (2 ЦАГ)

### 1. Төлөвлөгөө

Хийхийг хүсэж буй өөрчлөлтийнхөө талаар тодорхой төсөөлөлтэй болсон бол одоо дотроо өөртөө төсөөлсөн зүйлээ бусдад (эдгээрийн дотор дэмжигчид, болон эсэргүүцэгчид

байгаа) ойлгомжтой, тодорхой, үнэмшилтэйгээр ярьж ойлгуулах ур чадвараа хөгжүүлэх хэрэгтэй.

Багуудад сонгосон асуудлаараа “Орон нутгийн удирдах хороо”-нд 5 минутын илтгэл хийхээр бэлдэх даалгавар өг. Илтгэл бүрт дараах санаануудыг аль болох бүгдийг нь тусгахыг хичээх хэрэгтэй.

Сургагч багшид: Төлөвлөлт, дадлага хийхэд хангалттай цаг гаргаж өг. Хэдийгээр багийн зарим гишүүд олон нийтийн өмнө илүү чөлөөтэй ярьж чаддаг хүмүүс байлаа ч гэсэн хүн бүр энэ төлөвлөлтөд оролцож, хийх гэж байгаа өөрчлөлтийнхөө талаарх төсөөллийг тайлбарлах чадвартай болох ёстой гэдгийг онцлон тэмдэглэ.

## Тараах материал №2

### Хийхийг хүсэж байгаа өөрчлөлтөө томъёолох

1. Асуудлаа тайлбарла. Боломжтой бол дараах зүйлсийг багтаа:
  - Энэ асуудал нь хөгжлийн бэрхшээлтэй олон хүний амсаж туулсан хүний эрхийн бусад зөрчилтэй хэрхэн огтлолцож байгаа;
  - Үүнд дийлэнхдээ өртдөг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүлг(үүд); асуудал үүсэхэд хүргэж байгаа боломжит учир шалтгаанууд зэрэг.
1. Асуудлыг ХБХЭК-ийн холбогдох зүйл заалт, мөн боломжтой бол хүний эрхийн бусад баримт бичгүүдийн заалтуудтай уялдуулан тайлбарлах замаар уг асуудлыг хүний эрхтэй холбо.
2. Уг асуудал нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралд (хамааралтай бол мөн тэдний гэр бүлд) хэрхэн нөлөөлж байгааг тодорхой тайлбарла.
3. Уг асуудлыг шийдвэрлэснээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдрал ахуй, мөн орон нутгийн нөхцөл бүхэлдээ хэрхэн сайжрахыг тайлбарла.
4. Уг асуудлыг шийдвэрлэхийн тулд авч хэрэгжүүлж болох тодорхой үйл ажиллагаануудыг санал болго.\
5. Уг асуудлыг шийдвэрлэхэд орон нутгийн оршин суугчид хэрхэн оролцож болохыг харуул.

Баг болгоноос илтгэлээ танилцуулах нэгээс хоёр илтгэгч, мөн “Орон нутгийн удирдах хороо”-ны төлөөлөгчөөр ажиллах 2-3 хүнийг томилохыг хүс. Багууд илтгэлээ бэлтгэж байх хооронд “Орон нутгийн удирдах хороо”-ны гишүүд тусдаа уулзаж, орон нутгийн удирдагчдын дунд нийтлэг тархсан хандлага, үзэл баримтлалуудыг төлөөлсөн дүрүүдийг хуваарилж авна (жишээлбэл: сөрөг байр суурьтай засаг дарга, дэмжигч байр суурьтай орон нутгийн өөрөө удирдах байгууллагын тэргүүлэгч, шашны тэргүүн гэх мэт). Эсвэл баг болгоноос 1-2 хүн гаргаж “хороо” байгуул.



## 2. Дүрд тоглох

Баг болгоноос томилогдсон илтгэгч нь багийнхаа илтгэлийг танилцуулж, хорооны гишүүд илтгэлийг сонсон, оноож өгсөн дүрийн өмнөөс хариулт, тайлбар, няцаалт өгөх, санал тавих зэргээр тоглоно.

**Сургагч багшид:** Илтгэлийн цагийг нарийн баримтал. Илтгэлүүд ихэнхдээ 5 минутдаа хүрэхгүй дуусдаг. Мөн баг бүрт илтгэлээ тавих боломж олгохын тулд хорооны гишүүдийн ярих цагийг хязгаарла.

## 3. Хэлэлцэх

Илтгэлүүдээ тавьж, дүрийн тоглолтуудаа хийж дуусаад дараах асуултын дагуу хэлэлцүүлэг хий:

- Асуудлыг танилцуулж байхад илтгэгчдэд ямар сэтгэгдэл төрж байсан бэ?
- Илтгэлүүдэд хорооны гишүүд хэрхэн хандсан бэ? Орон нутагт нийтлэг тархсан ямар хандлага, үзэл баримтлалууд илэрсэн бэ?
- Бусад оролцогчдоос бүрдсэн үзэгчид илтгэлүүдэд хэрхэн хандсан бэ?
- Илтгэгчдээс хэн нэг нь асуудлаа хүний эрх зөрчил талаас нь хөндөж тайлбарласан уу? Асуудлыг ийм байр сууринаас тайлбарласан нь аргумент, үндэслэлийг улам батжуулж чадсан уу?
- Энд дурьдагдсан санаанууд нь танай орон нутагт хэрэгжих магадлалтай юу? Тийм бол яагаад? Үгүй бол яагаад?

## 4. Дүгнэх

Дараах асуултуудыг ашиглан оролцогчдод мэдлэгээ сорих, асуудлыг хэр цар хүрээтэй ойлгож байгаадаа үнэлгээ өгөх боломж олго:

- Энэ илтгэлийг бодит амьдрал дээр хэрэглэх бол та юуг нь хэрхэн өөрчлөх вэ?
- Илтгэлд ашигласан мэдээллийг та хаанаас олж авсан бэ? Таны мэдээлэл үнэн зөв, бүрэн дүүрэн байж чадсан уу? Хэрэв үгүй бол, танд ямар нэмэлт мэдээлэл хэрэгтэй вэ, түүнийг хэрхэн олж авах вэ?
- Та энэ асуудлаар, мөн энэ нь тэдний амьдралд хэрхэн нөлөөлж байгаа тухай хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй зөвлөлдсөн үү? Тэгвэл асуудлыг шийдвэрлэхийн тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухайд?
- Бодит амьдрал дээр хүний эрхийн нөлөөллийн ажил хийх гэж байгаа нөхцөлд тухайн асуудалд хамааралтай, энэ асуудлын нөлөөнд өртөх хүмүүсийг идэвхтэй оролцуулах нь ямар ач холбогдолтой вэ?
- Энэ дасгалыг та хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалахад чиглэсэн нөлөөллийн ажил төлөвлөх, хэрэгжүүлэхэд хэрхэн ашиглах вэ?

Хийх гэж байгаа өөрчлөлтөө томъёолон илэрхийлж чаддаг байх нь таны нөлөөллийн үйл ажиллагааг амжилтад хүргэх чухал ур чадвар мөн боловч энэ нь тогтмол дадлага туршлагаар төлөвшин хөгждөг гэдгийг онцол. Олон дахин давтахын хэрээр та улам чадваржина. Хийхийг хүсэж байгаа өөрчлөлтийнхөө талаар ярих, танилцуулах боломж бүрийг алдахгүй ашиглаж, мөн өөрөө ийм боломжуудыг үүсгэж байхыг оролцогчдод зөвлө.

**Сургагч багшид:** Хэрэв техник хэрэгсэл нь байвал илтгэлүүдийн видео бичлэгийг хийж, дараа нь илтгэгч бүрт ганцаараа бичлэгээ үзээд шүүн тунгаах боломж олго.

## АЛХАМ 3: ҮЙЛДЭЛ ХИЙХЭД БЭЛДЭХ

### **A. SWOT дүн шинжилгээ хийх (45 минут)**

**Strengths** – давуу талууд

**Weaknesses** - сул талууд

**Opportunities** - боломжууд

**Threats** – аюул занал

Та хийхийг хүсэж байгаа өөрчлөлтөө томъёолон илэрхийлж сурсан тул одоо өөрийнхөө болон байгууллагынхаа давуу болон сул тал, олдож байгаа боломж болон гарч мэдэх аюул занал талаас нь дүн шинжилгээ хий. Дараах асуултуудад хариулж бич. Шаардлагатай бол асуултуудыг өөрчилж болно:

#### **Давуу тал:**

- Танд ямар давуу талууд байгаа вэ?
- Та юуг сайн хийдэг вэ?
- Бусад хүмүүс таны ямар давуу талуудыг үнэлдэг вэ?
- Танд ямар онцгой нөөц байгаа вэ?

Давуу талаа тодорхойлохдоо өөрийн байгууллагын болон хувийнхаа зүгээс, мөн харьцдаг хүмүүсийн байр сууринаас хар. Даруухан байх гэж хичээх хэрэггүй бөгөөд бодитой байх нь чухал!

#### **Сул тал:**

- Та юугаа сайжруулах хэрэгтэй вэ?
- Та юунд муу вэ?
- Та юунаас зайлсхийх ёстой вэ?
- Бусадтай харьцуулахад танд ямар нөөц дутагдаж байна вэ?
- Бусад хүмүүс таны юуг сул тал чинь гэж хардаг вэ?

Үүнийг мөн л гадаад, дотоод байр сууринаас харж дүгнэхийн тулд таны өөртөө олж хараагүй сул талыг бусад хүмүүс хэлж байсан уу гэдгийг бод. Одооноос л аль болох бодитой байж, таагүй үнэнийг аль болох эрт мэдэх нь чухал.

#### **Боломж:**

- Таны өмнө ямар сайхан, таатай боломжууд байна вэ?
- Ямар сонирхолтой хандлагуудыг та мэдэж байгаа, мэдэрч байгаа вэ?
- Таныг дэмжих магадлалтай ямар хүмүүс байгаа вэ?

#### **Аюул занал:**

- Танд ямар саад, тотгор тулгарч байна вэ?
- Энэ ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай бүхий л ур чадварууд танай баг/бүлэгт байгаа юу?
- Өрсөлдөгчид, эсэргүүцэгчид байгаа уу?<sup>1</sup>

---

1 Эх сурвалж: <http://www.mindtools.com/swot.html>



## **Б. Талбараа судлах нь**

1. Таны одоогийн болон ирээдүйн үйл ажиллагаатай холбоотой дараах асуултуудыг анхаар:

- Та болон бусад хүмүүс эдгээр асуудлын алиныг өөрчлөхөөр ажиллаад эхэлчихсэн байгаа вэ? Хэрхэн ажиллаж байгаа вэ?
- Одоо хийж байгаа ажил чинь асуудлыг үүсгэж байгаа шалтгаануудыг арилгах зорилго агуулж байгаа юу? Яаж?
- Тодорхойлон гаргасан асуудлуудаас алийг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний төлөө ажилладаг байгууллагууд одоо хийж гүйцэтгэж байгаа ажил дээрээ төвөггүй нэмж хийж болох вэ? Яагаад?
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгарч байгаа эдгээр асуудлыг шийдвэрлэхээр ажиллалаа гэхэд зарим асуудал нь онцгой хүнд, ашиггүй, эсвэл бүр аюултай байх уу? Яагаад?

2. Одоо хамтран ажиллаж байгаа түншүүд, мөн түнш болж болох байгууллагуудын талаарх дараах асуултуудыг анхаар:

- Таны үйлдэл, үйл ажиллагааг дэмжих хамгийн өндөр магадлалтай хүмүүс хэн бэ? Яагаад?
- Та нарыг нэг ижил зорилго нэгтгэж байгаа юу?
- Таны болон таны түншүүдийн хийж байгаа ажил хэрхэн бие биенээ дэмжиж байгаа вэ?
- Энэ түншлэлд та болон/эсвэл танай байгууллага ямар хувь нэмэр, дэмжлэг санал болгож чадах вэ?
- Энэ түншлэлээс та болон/эсвэл танай байгууллага юу олж авах вэ?
- Аль нэг бүлэгтэй хамтран ажиллахад гарах асуудал байгаа юу?
- Та энэ хамтын ажиллагааг хэрхэн бий болгох вэ?

## **В. Мэдээлэл цуглуулах**

1. Танд орон нутаг, улс орон, дэлхий дахины хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх ямар статистик мэдээлэл бэлэн олдох вэ (жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоо, нас, орлогын түвшин гэх мэт)?

- Үйл ажиллагаагаа явуулахад тань ямар нэмэлт статистикийн мэдээлэл хэрэгтэй вэ?

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст шууд нөлөөлөх ямар бодлого, хууль дүрэм танай улсад үйлчилж байна вэ?

- Таны бодлоор эдгээр хууль, бодлого нь зохистой, үр дүнтэй юу?
- Тэдгээр нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг зохистойгоор хамгаалж чаддаг уу?
- Эдгээр хууль, бодлогыг тууштай хэрэгжүүлдэг үү? Үгүй бол яагаад?
- Өөр шинэ хууль хэрэгтэй юу? Хэрэв хэрэгтэй бол ямар хууль байж болох вэ?

3. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хамаатай олон улсын хүний эрхийн ямар **гэрээг** танай улс **соёрхон баталсан**, улмаар **дагаж мөрдөх үүрэг** хүлээсэн бэ? Соёрхон баталсан гэрээнүүдийн талаарх мэдээллийг <http://www.icrpd.net/ratification/en/index.htm> хаягаар орж үзнэ үү.

4. Танай улс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци (ХБХЭК)-ийг соёрхон баталсан уу?

- Хэрэв үгүй бол яагаад? Энэ гэрээг соёрхон батлуулахын тулд та юу хийж чадах вэ?
- Хэрэв тийм бол, энэ чиглэлээр танай улсын засгийн газар ямар алхмуудыг хэрэгжүүлчихсэн байгаа вэ?
- Танай улсад ХБХЭК-ийг соёрхон батлуулахын төлөө нийгмийн аль нэг бүлэг нөлөөллийн ажил хийж байна уу? Тэд юу хийж байгаа вэ? Тэдэнд та яаж тусалж чадах вэ?

5. Танай улсад үндэсний Хүний эрхийн комисс, эсвэл Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үндэсний холбоо, хороо бий юу?<sup>2</sup> Хэрэгжилтийг хянах зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олон улсын байгууллагаас гаргасан “Хэрэгжилтийг хянах хэрэглэдэхүүн” –ийг <http://www.icprd.net/implementation/en.index.htm> хаягаас үзнэ үү.

6. Эдгээр байгууллага нь танай улсын засгийн газрын харъяанд байдаг уу, эсвэл бие даасан, өөрөө хэлбэл, иргэний нийгмийн байгууллага уу?

- Эдгээр байгууллага хүний эрхийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралыг сайжруулах талаар юу хийж байна вэ (хэрвээ ямар нэг зүйл хийж байгаа бол)?
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг баталгаажуулсан стандарт, хэм хэмжээнүүдийн хэрэгжилтэнд хяналт тавих үүднээс та эдгээр байгууллагатай хэрхэн хамтран ажиллах вэ?
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах, хэрэгцээг хангах асуудлыг аль яам, агентлаг хариуцан ажиллаж байгааг олж мэд. Эдгээр байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн холбогдолтой бодлого, журамтай юу; энэ асуудлыг аль нэг албан тушаалтандаа тусгайлан хариуцуулсан уу?
- Засгийн газрын эдгээр байгууллагууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөө хийх нөлөөллийн үйл ажиллагааг тусгайлан дэмжиж байна уу, эсвэл огт дэмжихгүй байна уу?

#### **АЛХАМ 4: ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАХ**

Та эхний гурван алхмыг гүйцэтгэж дууссан учраас одоо “Үйл ажиллагаагаа төлөвлөх маягт”-аа (290-292-р дугаар хуудас) сонгож бөглөөрэй. Өөрийн баг/бүлэг, эсвэл хийхээр төлөвлөж байгаа ажилд тохирох загварыг сонго. Тохирох бэлэн маягт байхгүй бол өөрөө зохио. Урт хугацааны зорилгыг хангахад чиглэсэн үйл ажиллагаануудаараа нэг төлөвлөгөө, харин богино хугацааны зорилгуудаа хангах тодорхой, салангид үйл ажиллагаануудаа хэд хэдэн ажлын төлөвлөгөө болгон боловсруулж болно. Төлөвлөсөн ажлуудаа гүйцэтгэсний дараа

2 “Оролцогч улсууд нь өөрсдийн эрхзүйн болон засаг захиргааны тогтолцоондоо нийцүүлэн өөрийн улсын хувьд шаардлагатай нэг буюу хэд хэдэн бие даасан механизмыг оролцуулан энэхүү конвенцийн хэрэгжилтэд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх, хамгаалах ажиллагааг эрхэлсэн бүтцийг шаардлагатай тохиолдолд байгуулах, томилох, бэхжүүлэх зэргээр тогтвортойгоор ажиллуулна. Иргэний нийгмийн байгууллагууд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэднийг төлөөлөх байгууллагууд ийнхүү хяналт тавих ажиллагаанд бүрэн дүүрэн оролцох, хамрагдах ёстой” хэмээн ХБХЭК-ын 33 дугаар зүйлд оролцогч улсуудын үүргийг зааж өгсөн.



залгуулаад хийх алхмууд болон үр дүнг тооцох үнэлгээний хэсгийг төлөвлөгөөндөө бас оруулах хэрэгтэй.

Баяр хүргэе! Та дараах алхмуудыг гүйцэтгэж дууслаа:

**АЛХАМ 1: ХИЙХИЙГ ХҮСЭЖ БУЙ ӨӨРЧЛӨЛТӨӨ ТОДОРХОЙЛОХ**

**АЛХАМ 2: ХИЙХИЙГ ХҮСЭЖ БУЙ ӨӨРЧЛӨЛТӨӨ ТОМЬЁОЛОХ**

**АЛХАМ 3: ҮЙЛДЭЛ ХИЙХЭД БЭЛДЭХ**

**АЛХАМ 4: ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАХ**

Одоо дараагийн алхмыг хийх цаг ирлээ.

### **АЛХАМ 5: ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЯВУУЛАХ**

Одоо Үйл ажиллагааны төлөвлөгөөгөө баримтлан ажиллаж, жижиг ч хамаагүй үйлдэл, алхмуудаар дамжуулан олж авсан ур чадвараа ашиглан нийгэмдээ өөрчлөлт хий.

Зорилгодоо хүрэхийн тулд өөртөө хангалттай цаг гаргаад, үнэлгээ дүгнэлт, дагалдах алхам хийх хоног хугацаагаа товл.

### **АЛХАМ 6: ҮНЭЛГЭЭ ДҮГНЭЛТ, ДАРААГИЙН АЛХАМ**

Үйл ажиллагаа явуулаад эхэлсэн бол өөрийн баг/ бүлэгтэйгээ тогтмол холбоотой бай. Ажлыг гүйцэтгэх явцад гарсан амжилт, бэрхшээлийг тэдэнд мэдээлж бай. Дараах асуултуудыг тунгааж үз:

1. Та Үйл ажиллагааны төлөвлөгөөгөө баримталсан уу? Та ямар амжилтад хүрсэн бэ? Ямар бэрхшээлтэй тулгарсан бэ?
2. Та зорилгодоо хүрсэн бол:
  - Ямар хүчин зүйлс таны амжилтад нэмэр болсон бэ?
  - Эдгээр амжилтаа хэрхэн улам ахиулж болох вэ?
  - Энэ стратегиа та дахин нэг ашиглах хэрэгтэй юү?
3. Хэрэв та зорилгодоо хүрээгүй бол:
  - Үйл ажиллагааны төлөвлөгөөндөө ямар өөрчлөлт хийх хэрэгтэй бэ?
  - Нэмэлт судалгаа хийх хэрэгтэй юү?
  - Нэмэлт нөөц хэрэгтэй юү?
4. Таны дараагийн алхам юу вэ?
  - Та өөр үйлдэл, алхам хийх шаардлагатай юү?

Үйл ажиллагаагаа хянаж, явцыг нь тэмдэглэж байх нь маш чухал байдаг. Ажлын явцыг Үйл ажиллагааны төлөвлөгөөний маягтдаа бичиж, олсон амжилтуудаа тэмдэглэж байх хэрэгтэй! Бусад хүн, зохион байгуулалттай бүлгүүдтэй ажлаа зохицуулан хамтарч нөлөөллийн үйл ажиллагаа хийх нь нийгмээ өөрчлөх хамгийн үр дүнтэй арга юм. Хамтран ажиллах нь



бэрхшээлтэй байж болно. Энэ нь зөрчлийг даван туулж, нэгдсэн баримтлал, зөвшилцөлд хүрч ажиллахыг шаарддаг ч бүх хүнд эрх, эрх чөлөөг эдлүүлэхэд маш чухал арга юм.

Санаж явах зүйл:

*“Зорилготой, бодолтой жижиг бүлэг хүн дэлхийг ч өөрчилж чадна. Ер нь ч ийм л байж ирсэн” – Маргарет Мийд*

## НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Нэг удаагийн нэг уулзалтаар Үйл ажиллагааны нэг л төлөвлөгөө боловсруулах нь зүйтэй гэж бид зөвлөж байна.

Ажлын баг \_\_\_\_\_

Он, сар, өдөр \_\_\_\_\_

Асуудал	Явуулах үйл ажиллагаа	Хэн хийх	Хэзээ хийсэн байх	Хэрэгцээт нөөц	Үйл ажиллагаа хэрэгжсэн хугацаа	Үнэлгээ
Баг ямар асуудлыг шийдэхээр ажиллаж байна вэ?	Ямар үйл ажиллагаа явуулах шаардлагатай вэ?	Хэн үүнийг хийх вэ?	Хэдийд энэ ажлыг хийж дуусгасан байх вэ?	Энэ ажлыг хийхэд санхүүгийн, материаллаг, хүн хүчний ямар нөөц шаардлагатай вэ?	Хэзээ энэ ажлыг хийсэн бэ?	Үйл ажиллагааны үр дүнд юу болсон бэ?

Бальсаар, Ф.И (2005) Нөлөөллийн үйл ажиллагааны төлөвлөлтийн удирдамж. Чикаго хот дах Иллинойс мужийн Их сургуулийн Хөгжлийн бэрхшээл ба хүний хөгжлийн тэнхим

Лого

## Нөлөөллийн үйл ажиллагааны төлөвлөгөөний маягт

Нэг бүлгийн нэг уулзалтаар Үйл ажиллагааны нэг л төлөвлөгөө хийхийг зөвлөж байна.

Ажлын баг: \_\_\_\_\_ Он, сар, өдөр: \_\_\_\_\_

### ЗААВАР

Хийх гэж буй өөрчлөлт: \_\_\_\_\_

Хийгдэх ажил:

Хэн хийх: \_\_\_\_\_ Хэзээ: \_\_\_\_\_

Шаардагдах нөөц: \_\_\_\_\_

Үйл ажиллагаа явагдсан огноо: \_\_\_\_\_ Үр дүнг шалгах: \_\_\_\_\_

**Өөрчлөлт**- Ямар төрлийн өөрчлөлт хийхийг хүсч байна вэ?

**Ажил**- Ямар үйл ажиллагаа явуулах шаардлагатай вэ?

**Хэн хийх**- Хэн энэ ажлыг хийх вэ?

**Хэзээ**-Хэдэн гэхэд энэ ажлыг хийж дуусгасан байх вэ?

**Шаардагдах нөөц** – Энэ ажлыг хийж гүйцэтгэхэд санхүүгийн, материаллаг болон хүн хүчний ямар нөөц шаардагдах вэ?

**Үйл ажиллагаа явагдсан огноо**- Хэзээ энэ ажлыг хийсэн бэ?

**Үр дүнг шалгах**- Ажлыг хийж гүйцэтгэсний эцэст ямар үр дүн гарсан бэ?

Зорилго нь:

**T**-тодорхой **X**-Хэмжигдэхүйц **X**-Хүрч болохуйц **Б**-Бодит **Ц**-цаг хугацаатай байх

**1. Зорилго.** Зорилго/ зорилт бүрээ товч тайлбарлаад, энэ зорилго/ зорилтод хэзээ хүрсэн байх, эсвэл биелүүлсэн байхыг бичнэ.

**2. Хэмжилт.** Зорилго/ зорилтыг хэрхэн үнэлэх вэ? Та ажлаа хийж дуусгасан уу?

**3. Ач холбогдол.** Зорилгоо зайлшгүй, чухал, байж болох хэмээн дараах байдлаар ангилна:

*Зайлшгүй* - Хүний эрхийг эдлэхэд заавал шаардлагатай

*Чухал* - Хүний эрхийг эдлэхэд тустай

*Байж болох* - Хүний эрхийг эдлэхэд эерэг нөлөөтэй



### Зорилго 1

**Тодорхойлолт:**

**Хэмжүүр:**

**Ач холбогдол:**      Зайлшгүй                      Чухал                      Байж болох

### Зорилго 2

**Тодорхойлолт:**

**Хэмжүүр:**

**Ач холбогдол:**      Зайлшгүй                      Чухал                      Байж болох

### Зорилго 3

**Тодорхойлолт:**

**Хэмжүүр:**

**Ач холбогдол:**      Зайлшгүй                      Чухал                      Байж болох

## ХАВСРАЛТУУД



### ХАВСРАЛТ ХЭСГИЙН АГУУЛГА:

#### 1. Хүний эрхийн баримт бичгүүд

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал (ХЭТТ) бүрэн эх..... 294
- ХЭТТ-ын хялбаршуулсан эх ..... 299
- ХЭТТ-ын тойм эх ..... 303
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци..... 305
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци..... 331
- Хүний эрхийн хуулиудын жагсаалт..... 351

#### 2. Хүний эрхийн сургалт зохион байгуулах нь ..... 352

#### 3. Нэмэлт эх сурвалж материалын жагсаалт..... 362

#### 4. Хөгжлийн бэрхшээл ба хүний эрхийн нэр томъёоны тайлбар толь . 364

#### 5. Сэдэвчилсэн индекс..... 373

## Хавсралт 1. Хүний эрхий баримт бичгүүд

### ХҮНИЙ ЭРХИЙН ТҮГЭЭМЭЛ ТУНХАГЛАЛ (Албан ёсны монгол орчуулга)

(1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейн  
217А тоот тогтоолоор баталж тунхаглав)

#### УДИРТГАЛ

Хүн төрөлхтний ам бүлийн гишүүн бүхэнд угаас заяасан нэр төр болон тэдний адил тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шударга ёс, бүх нийтийн энх тайвны үндэс мөнийг иш үндэс болгон;

хүний эрхийг үл тоомсорлох, басамжлах нь зон олны ариун сэтгэлийг сэвтээн жигшээсэн балмад үйлдэлд хүргэж байсан бөгөөд хүмүүс үгээ хэлэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөтэй түүнчлэн айх аюулгүй, гачигдах зовлонгүй дэлхий ертөнцийг бий болгох нь хүн ардын эрхэм дээд эрмэлзэл мөн хэмээн үзэж;

хүмүүс эзэрхэг засаглал, дарлалын эсрэг өөрийн эрхгүй эцсийн арга болгон зэвсэглэн босоход хүргэхгүйн тулд хүний эрхийг хуулиар хамгаалах нь нэн чухал гэдгийг анхааран;  
улс түмний хооронд найрсаг харилцаа хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх нь нэн чухлыг харгалзан;

хүн үндсэн эрхтэй, хувь хүн нэр төр, үнэ цэнэтэй, эрэгтэй, эмэгтэйчүүд тэгш эрхтэй гэдэгт Нэгдсэн Үндэстний улс түмэн итгэл төгс байгаагаа дүрмээрээ нотлохын хамт, илүү эрх чөлөөтэй байдалд нийгмийн дэвшлийг урагшлуулах, амьдралын нөхцлийг сайжруулахад дөхөм үзүүлэхээр шийдвэрлэснийг харгалзан;

гишүүн улсууд Нэгдсэн Үндэстний Байгууллагатай хамтран хүний эрх, үндсэн эрх чөлөөг нийтээр хүндлэн сахихад тус дөхөм үзүүлэх үүрэг авсныг үндэслэн;

энэхүү үүргийг бүрэн биелүүлэхэд хүний эрх, эрх чөлөөг нийтээр нэг мөр ойлгох явдал нэн чухал ач холбогдолтойг харгалзан;

*тийнхүү, үүний учир, Ерөнхий Ассамблей,*

Энэхүү хүний эрхийн түгээмэл тунхаглалыг дэлхийн бүх улс түмэн, бүх улс гүрэн хэрэгжүүлэхийг эрмэлзвэл зохих нийтлэг зорилт болгон дэвшүүлж, энэ зорилтын үүднээс хүн бүр, нийгмийн нэгж байгууллага бүхэн эл Тунхаглалыг байнга бодолцон гэгээрч боловсрох замаар хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн сахихад дөхөм үзүүлэхийг эрмэлзэх ёстойг, түүнчлэн үндэсний болон олон улсын хэмжээний дэвшилтэт арга хэмжээ авах замаар эдгээр эрх, эрх чөлөөг Нэгдсэн Үндэстний гишүүн улсын ард түмэн, тэдгээр улсын эрх мэдлийн нутаг дэвсгэр дээр оршин суудаг ард түмний аль алинаар нь бүх нийтээр үр нөлөөтэй хүлээн зөвшөөрүүлж, дагаж мөрдөх явдлыг хангахад тус дөхөм үзүүлэхийг эрмэлзэх ёстойг зарлан тунхаглаж байна.

#### 1 дүгээр зүйл

Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. Тэдэнд оюун ухаан, өрлөг сэтгэл заяасан бөгөөд өөр хоорондоо ахан дүүгийн ёсоор харилцах ёстой.

## **2 дугаар зүйл**

Хүн бүр энэ Тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой. Мөн түүнчлэн тухайн хүнийг харьяалдаг улс буюу нутаг дэвсгэрийн улс төр, эрхзүй болон олон улсын статус ямар ч байлаа гэсэн, тухайлбал, тусгаар тогтносон буюу асрамжинд байгаа, өөрөө эс удирдах зэрэг бүрэн эрхт байдал нь ямар ч байдлаар хязгаарлагдмал байсан тэр нь ялгаварлах үндэс болох ёсгүй.

## **3 дугаар зүйл**

Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй.

## **4 дүгээр зүйл**

Хэнийг ч боолчлох буюу бусдын эрхшээлд байлгах ёсгүй. Аливаа төрлийн боолчлол болон боолын худалдааг хориглоно.

## **5 дугаар зүйл**

Хэнд ч эрүү шүүлт тулган эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэх ёсгүй.

## **6 дугаар зүйл**

Хүн бүр хаана ч байсан эрхзүйн чадвартай байх эрхээ хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй.

## **7 дугаар зүйл**

Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчлалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй. Хүн бүр энэхүү Тунхаглалд харшлах аливаа алагчлалаас болон тийнхүү алагчлахыг өдөөсөн турхиралтаас адилхан хамгаалуулах эрхтэй.

## **8 дугаар зүйл**

Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон үндсэн эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй.

## **9 дүгээр зүйл**

Хэнийг ч дур мэдэн баривчлах, саатуулах буюу хөөн зайлуулах ёсгүй.

## **10 дугаар зүйл**

Хүн бүр тулгасан аливаа эрүүгийн ял болон эрх үүргээ тодорхойлуулахдаа хараат бус, тал хардаггүй шүүхээр бүрэн адил тэгш үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй.

## **11 дүгээр зүйл**

1. Гэмт хэрэгт буруутгагдаж буй хэн боловч өмгөөлөх бүх боломжоор хангагдсан нээлттэй шүүх хурлаар гэм буруутайг нь хуулийн дагуу тогтоох хүртэл гэм буруугүй гэж тооцогдох эрхтэй.

2. Тухайн үед үндэсний буюу олон улсын хуулийн дагуу гэмт хэрэгт эс тооцож байсан аливаа үйлдэл буюу эс үйлдлийг үндэслэж, хэнийг ч гэмт хэрэгт яллан шийтгэх ёсгүй. Түүнчлэн гэмт хэрэг гарсан тэр үед ногдуулж болох байснаас илүү хүнд ял тохоож болохгүй.



## **12 дугаар зүйл**

Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааных нь нууц болон нэр төр, алдар хүндэд нь халдах ёсгүй. Тийм оролцоо халдлагын эсрэг хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй.

## **13 дугаар зүйл**

1. Хэн боловч улсынхаа дотор чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй.
2. Хэн боловч аливаа улс орныг, түүний дотроо эх орноо орхин явах, эх орондоо эргэж очих эрхтэй.

## **14 дүгээр зүйл**

1. Хэн боловч мөрдөлт мөшгөлтөөс зугтаж, өөр улсад орогнох боломжийг эрэлхийлэх болон орогнох эрхтэй.
2. Улс төрийн бус гэмт хэргийн улмаас буюу Нэгдсэн Үндэстний Байгууллагын зорилго, зарчимд харш хэрэг үйлдсэний улмаас зайлшгүй мөрдөгдөж буй тохиолдолд дээрх эрхийг эдлэж үл болно.

## **15 дугаар зүйл**

1. Хүн бүр иргэний харьяалалтай байх эрхтэй.
2. Аливаа хүний иргэний харьяалал болон харьяаллаа өөрчлөх эрхийг дур мэдэн цуцлах ёсгүй.

## **16 дугаар зүйл**

1. Насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүс арьс үндэс, яс үндэс, шашин шүтлэгтэй холбогдсон аливаа хязгаарлалтгүйгээр гэрлэх, өрх тусгаарлах эрхтэй. Тэд гэрлэхдээ, гэрлэсний дараа болон гэрлэлтээ цуцлуулах үед тэгш эрх эдлэнэ.
2. Нөхөр, эхнэр болох хоёр хүн чөлөөтэй, харилцан бүрэн зөвшөөрсөн нөхцөлд гэрлэж болно.
3. Гэр бүл бол нийгмийн жам ёсны үндсэн нэгж мөн бөгөөд нийгэм, төрөөр хамгаалуулах эрхтэй.

## **17 дугаар зүйл**

1. Хүн бүр эд хөрөнгийг ганцаараа буюу бусадтай хамтарч өмчлөх эрхтэй.
2. Хэний ч өмч хөрөнгийг дураар хураан авч болохгүй.

## **18 дугаар зүйл**

Хүн бүр чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, эс шүтэх эрхтэй. Энэхүү эрхэнд шашин буюу шүтлэгээ өөрчлөх эрх чөлөө, бие даан буюу бусадтай хамтран нийтийн өмнө болон хувийн журмаар хичээл заах, хурал мөргөл хийх, шашны хийгээд зан үйлийн ёслол үйлдэх зэргээр шашин буюу шүтлэгээ номлох эрх чөлөө багтана.

## **19 дүгээр зүйл**

Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана.

## **20 дугаар зүйл**

1. Хүн бүр чөлөөтэй, тайван хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхтэй.
2. Хэнийг ч аливаа эвлэл холбоонд албадан оруулах ёсгүй.

## **21 дүгээр зүйл**

1. Хүн бүр улсаа удирдахад шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох эрхтэй.
2. Хүн бүр улсдаа төрийн алба хаших тэгш эрхтэй.
3. Ард түмний хүсэл зориг бол засгийн эрх мэдлийн үндэс байх ёстой. Энэ хүсэл зориг нь сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хураах буюу саналаа чөлөөтэй гаргах явдлыг хангахуйц өөр адил чанартай хэлбэрийг ашиглах замаар явуулж байвал зохих тогтмол, хуурамч бус сонгуулиар илрэлээ олно.

## **22 дугаар зүйл**

Хүн бүр нийгмийн гишүүний хувьд нийгмийн хангамж эдлэх, түүнчлэн нэр төрөө хадгалах, биеэ боловсруулж хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ улс бүрийн бүтэц, нөөц бололцоотой уялдуулан үндэсний хүч чармайлт хийгээд олон улсын хамтын ажиллагааны замаар хэрэгжүүлэх эрхтэй.

## **23 дугаар зүйл**

1. Хүн бүр хөдөлмөрлөх, ажлаа чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн шударга, аятай нөхцлөөр хангуулах, ажилгүйдлээс хамгаалуулах эрхтэй.
2. Хүн бүр ямар ч алагчлалгүйгээр адил хэмжээний хөдөлмөрт адил хэмжээний шан хөлс авах эрхтэй.
3. Ажил хөдөлмөр эрхэлж байгаа хэн боловч хувийн болон ам бүлийнхээ ахуй амьжиргааг хүний зэрэгтэй авч явахад хүрэлцэхүйц бөгөөд зайлшгүй тохиолдолд нийгмийн хангамжийн эх үүсвэрээр нэмэн арвижуулсан, хийсэндээ таарсан, хүртээмжтэй шан хөлс авах эрхтэй.
4. Хүн бүр эрх ашгаа хамгаалах зорилгоор үйлдвэрчний эвлэл байгуулах буюу үйлдвэрчний эвлэлд нэгдэх эрхтэй.

## **4 дүгээр зүйл**

Хүн бүр ажлын цагаа зохистойгоор хязгаарлуулах, цалинтай ээлжийн амралт эдлэх эрхийг оролцуулан амрах, зав чөлөөтэй байх эрхтэй.

## **25 дугаар зүйл**

1. Хүн бүр хоол хүнс, хувцас хунар, орон байр, эмчилгээ сувилгаа, нийгэм ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг оролцуулаад өөрийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй. Ажилгүйдэх, өвчлөх, тахир дутуу болох, бэлэвсрэх, өтлөх, эсхүл өөрөөс үл хамаарах бусад шалтгаанаар амь зуулгагүй болох нөхцөлд тэтгэмж авах эрхтэй.
2. Эх нялхас онцгой асрамж, туслалцаа авах эрхтэй. Баталгаатай гэр бүлээс гарсан буюу бутач гэдгээс үл хамааран бүх хүүхэд нийгмээс адилхан хамгаалалт эдлэх ёстой.

## **26 дугаар зүйл**

1. Хүн бүр сурч боловсрох эрхтэй. Наад зах нь анхан шатны болон ерөнхий боловсрол үнэ төлбөргүй байвал зохино. Анхан шатны боловсролыг заавал эзэмшүүлэх ёстой.

Техникийн болон тусгай мэргэжлийн боловсрол нийтэд хүртээлтэй байх ёстой. Авъяас чадвартай нь уялдан хүн бүрт дээд боловсрол эзэмших боломж адилхан хүртээлтэй олгох ёстой.

2. Боловсрол нь бие хүнийг өв тэгш хөгжүүлэх, хүний эрх, үндсэн эрх чөлөөг улам бүр хүндэтгэдэг болоход чиглэх ёстой. Боловсрол нь аливаа улс түмэн, янз бүрийн арьстан хийгээд шашны бүлгүүд бие биеэ харилцан ойлгох, хүлцэн тэвчих, эвсэн найрамдах, мөн түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагаас энх тайвныг сахиулах талаар явуулж буй үйл ажиллагаанд дөхөм үзүүлэх ёстой.
3. Хүүхэддээ олгох боловсролын чиглэлийг сонгоход эцэг эх давуу эрх эдлэнэ.

### **27 дугаар зүйл**

1. Хүн бүр нийгмийнхээ соёлын амьдралд чөлөөтэй оролцох, урлагийн цэнгэлийг эдлэх, шинжлэх ухааны дэвшилд оролцож үр шимийг нь хүртэх эрхтэй.
2. Хүн бүр өөрийн туурвисан шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны бүтээлийн материаллаг болон ёс суртахууны эрх ашгаа хамгаалуулах эрхтэй.

### **28 дугаар зүйл**

Хүн бүр энэхүү Тунхаглалд заасан эрх, эрх чөлөөг бүрэн эдлэж болохуйц нийгмийн болон олон улсын дэг журамд аж төрөх эрхтэй.

### **29 дүгээр зүйл**

1. Хүн бүр нийгмийнхээ өмнө тодорхой үүрэг хүлээх бөгөөд гагцхүү нийгэм л бие хүний чөлөөтэй, өв тэгш хөгжлийг хангана.
2. Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ гагцхүү бусдын эрх, эрх чөлөөг зохих ёсоор хүлээн зөвшөөрч хүндлэх, мөн ардчилсан нийгмийн ёс суртахууны шударга шаардлага, нийгмийн хэв журам, ерөнхий сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосноос өөр хязгаарлалтад өртөгдөх ёсгүй.
3. Эдгээр эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхдээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын зорилго, зарчимтай хэрхэвч зөрчилдүүлж болохгүй.

### **30 дугаар зүйл**

Энэхүү Тунхаглалын ямар ч зүйлийг аль нэг улс, бүлэг буюу бие хүний зүгээс энд тунхагласан эрх, эрх чөлөөг устгахад чиглэсэн аливаа үйл ажиллагаа явуулах буюу тийм үйлдэл хийх эрх олгож байгаа мэтээр мушгин тайлбарлаж болохгүй.

## **ХҮНИЙ ЭРХИЙН ТҮГЭЭМЭЛ ТУНХАГЛАЛ**

*(Албан ёсны хялбаршуулсан эхийн албан бус монгол орчуулга)*

### **1 дүгээр зүйл. Тэгш байх эрх:**

Чи эрх чөлөөтэй төрсөн бөгөөд бусад хүмүүстэй яг л адил тэгш эрхтэй. Чи сэтгэн бодох, бурууг зөвөөс ялгах чадвартай. Чи бусдад найрсаг хандах ёстой.

### **2 дугаар зүйл. Ялгаварлагдахгүй байх эрх чөлөө:**

Чи ямар яс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, үзэл бодолтой байх, танай гэр бүлийн нийгмийн байр суурь, чиний өөрийн нийгмийн болон соёлын статус, төрсөн байдал, язгуур угсаанаас хамаарахгүйгээр эдгээр эрхийг бүгдийг эдлэх ёстой.

### **3 дугаар зүйл. Амьд явах эрх, эрх чөлөөтэй байх эрх, хувийн хамгаалагдсан байдал:**

Та амьд явах, эрх чөлөөтэй байх, аюулгүй байдлыг мэдрэх эрхтэй.

### **4 дүгээр зүйл. Боолчлолоос ангид байх эрх:**

Хэн ч чамтай боол шиг харьцах эрхгүй бөгөөд чи ч гэсэн хэн нэгнийг боолчилж болохгүй.

### **5 дүгээр зүйл. Эрүү шүүлт, нэр хүндийг доромжилсон харьцаанаас ангид байх эрх чөлөө:**

Хэн ч чамайг эрүүдэн тамлах, гэмтэл хохирол учруулах юмуу нэр төрийг тань гутаан доромжлох эрхгүй.

### **6 дугаар зүйл. Эрхзүйн чадамжийг хүлээн зөвшөөрүүлэх эрх:**

Таныг хаана ч гэсэн хуулийн этгээд мөн гэдгийг хүлээн зөвшөөрүүлэх эрх танд бий.

### **7 дугаар зүйл. Хуулийн өмнө эрх тэгш байх эрх:**

Та ямар ч төрөл, хэлбэрийн гадуурхалгүй бусадтай эрх тэгш байдлаар хуулиар хамгаалуулах эрхтэй.

### **8 дугаар зүйл. Эрх мэдэл бүхий шүүгчдээр эрхээ сэргээлгэх эрх:**

Таны хууль ёсны эрх зөрчигдсэн тохиолдолд та эрх мэдэл бүхий шударга шүүгчдээр эрхээ хамгаалуулах эрхтэй.

### **9 дүгээр зүйл. Хууль бус баривчилгаа, цөллөгөөс ангид байх эрх:**

Үндэслэл бүхий шалтгаангүйгээр хэн ч таныг баривчлах, шоронд хийх, эсвэл эх орноос тань хүчээр хөөж гаргах эрхгүй.

### **10 дугаар зүйл. Шударга нээлттэй шүүхээр шүүлгэх эрх:**

Хэрэв та гэмт хэрэгт сэжиглэгдсэн бол та хэргээ шударга шүүхээр нээлттэй хуралдаанаар шүүлгэх эрхтэй.

### **11 дүгээр зүйл. Гэм бурууг нь баталтал буруугүй гэж тооцогдох эрх:**

1) Шударга шүүхээр таны гэм буруутай болохыг батлагдах хүртэл таныг буруугүй хүн гэж тооцох ёстой.

2) Ямар нэг үйлдлийг хийх тухайн үед энэ үйлдлийг гэмт хэрэг гэж тооцдоггүй байсан бол таныг уг үйлдлийн төлөө яллах ёсгүй.

**12 дугаар зүйл. Хувийн болон гэр бүлийн амьдрал, орон байр болон захидал харилцааныхаа нууцыг хөндлөнгийн оролцохоос хамгаалуулах эрх:**

Хэн нэгэн хүн таны нэр хүндэд халдах, эсвэл үндэслэл шалтгаангүйгээр таны орон байранд нэвтрэх, захидал болон цахим харилцааг тань нээж үзэхийг оролдох, эсвэл таныг болон таны гэр бүлийнхнийг тайван байлгахгүй байвал та хамгаалуулах эрхтэй.

**13 дугаар зүйл. Чөлөөтэй зорчих эрх:**

- 1) Та өөрийн улсынхаа дотор өөрийн хүссэнээр чөлөөтэй явах, зорчих эрхтэй.
- 2) Та бусад улс оронд зорчихоор хил давах эрхтэй бөгөөд өөрөө хүсвэл эх орондоо буцаж орох эрхтэй.

**14 дүгээр зүйл. Өөр улс орон хамгаалагдсан байх эрх:**

- 1) Хэн нэгэн хүн танд хор хохирол учруулна гэж заналхийлэх юм бол та өөр улс орон руу явж тэндээ дүрвэгчийн хувьд хамгаалалт хүсэх эрхтэй.
- 2) Та ноцтой гэмт хэрэг үйлдэх юм бол энэ эрхээ алдана.

**15 дугаар зүйл. Иргэншилтэй байх, түүнийгээ солих эрх:**

- 1) Та аль нэг улсад харьяалагдан иргэн нь байх эрхтэй.
- 2) Таны иргэний харьяаллыг үндэслэл шалтгаангүйгээр хэн ч цуцлах эрхгүй. Та өөрөө хүсвэл иргэний харьяаллаа солих эрхтэй.

**16 дугаар зүйл. Гэрлэх, гэр бүлтэй байх эрх:**

- 1) Хуулиар тогтоож өгсөн насанд хүрсэн л бол арьсны өнгө, иргэний харьяалал, шашин шүтлэг зэргээс үл хамааран та гэрлэж, гэр бүлтэй болох эрхтэй. Гэрлэсэн хосын аль аль нь гэр бүл байхдаа болон салсны дараа эн тэгш эрхтэй.
- 2) Хэн ч таныг хүчээр гэрлүүлэх ёсгүй.
- 3) Гэр бүл бол нийгмийн үндсэн нэгж бөгөөд засгийн газар нь гэр бүлийг хамгаалах ёстой.

**17 дугаар зүйл. Өмчтэй байх эрх:**

- 1) Та юм өмчлөх эрхтэй.
- 2) Хэн ч таны эд зүйлсийг үндэслэл шалтгаангүйгээр танаас салгаж авах эрхгүй.

**18 дугаар зүйл. Сэтгэн бодох, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх эрх:**

Та өөрийн бодолтой, шашин шүтлэгтэй байх эрхтэй. Та өөрийн шашны зан үйлийг мөрдөх, итгэх эрхтэй бөгөөд өөрөө хүсвэл шашнаа өөрчилж болно.

**19 дүгээр зүйл. Үзэл бодол, мэдээллийн эрх чөлөө:**

Та өөрийн үзэл бодолтой байж, түүнийгээ илэрхийлэх эрхтэй. Та өөрийн үзэл бодлоо бусадтай, үүний дотор гадаад улс орны хүмүүстэй мэдээллийн төрөл бүрийн арга хэрэгслээр дамжуулан хуваалцах боломжтой байх ёстой.

**20 дугаар зүйл. Тайван хурал цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрх:**

- 1) Та бусад хүмүүстэй тайван хурал цуглаан хийх эрхтэй.

2) Хэн ч таныг хүчээр аль нэг бүлгийн гишүүн болгох эрхгүй.

**21 дүгээр зүйл. Засаглал болон сонгууль оролцох эрх:**

- 1) Та өөрийн орныг удирдахад төрийн алба хаших юмуу өөрийгөө төлөөлөх төрийн албан хаагчийг сонгох байдлаар оролцох эрхтэй.
- 2) Та болон бусад хүмүүс бүгд төрийн алба хаших эрхтэй.
- 3) Төрийн дээд байгууллагыг тогтмол зохион байгуулах шударга сонгуулиар нууц санал хураалтаар сонгоно.

**22 дугаар зүйл. Нийгмийн хамгаалал хүртэх эрх:**

Таны амьдарч байгаа нийгэм танд нийгмийн хамгаалал эдлүүлж, нэр төрөө хамгаалах, хувийн хөгжлөө хангахад шаардлагатай эрхийг хангаж өгөх ёстой.

**23 дугаар зүйл. Сайн ажил хөдөлмөр эрхлэх, үйлдвэрчний эвлэлд элсэх эрх:**

- 1) Та ажил хөдөлмөр эрхлэх, ямар ажил эрхлэхээ сонгох, хөдөлмөрийн сайн нөхцөлд ажиллах эрхтэй.
- 2) Ижил төрлийн ажил эрхэлж байгаа хүмүүс ижил хэмжээний цалин хөлс авах ёстой.
- 3) Та хувийн болон ам бүлийнхээ хэрэгцээг хангахад хүрэлцэхүйц цалин хөлс авах боломжтой байх ёстой.
- 4) Ажил хөдөлмөр эрхэлж буй бүх хүн өөрийн сонирхлыг хамгаалах зорилгоор нэгдэж эвлэл байгуулан ажиллуулах эрхтэй.

**24 дүгээр зүйл. Амрах, чөлөөт цагтай байх эрх:**

Та амрах, чөлөөт цагтай байх эрхтэй. Таны ажлын өдөр хэтэрхий урт байх ёсгүй бөгөөд та тогтмол хугацаанд цалинтай ээлжийн амралт авах ёстой.

**25 дугаар зүйл. Хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрх:**

- 1) Та болон таны гэр бүлийн эрүүл мэнд, сайн сайхан байдалд шаардлагатай зүйлсийг та авах эрхтэй бөгөөд үүний дотор хоол хүнс, орон байр, эрүүл мэндийн болон нийгмийн үйлчилгээ багтана. Та ажилгүй болсон юмуу ажиллах боломжгүй болсон үед тусламж авах эрхтэй.
- 2) Хүүхэд, эхчүүд тусгай халамж, туслалцаа авах ёстой.

**26 дугаар зүйл. Сурч боловсрох эрх:**

- 1) Та сургуульд сурах эрхтэй. Бага боловсрол нь үнэ төлбөргүй, заавал эзэмших ёстой боловсрол юм. Та ямар нэг мэргэжилд суралцах, эсвэл өөрийн боломжоор хэдий ч хугацаагаар үргэлжлүүлэн суралцах боломжтой байх ёстой.
- 2) Сургуульд сурч байх хугацаандаа та өөрийн бүхий л авьяас чадварыг хөгжүүлэх боломжтой байж, бусад хүмүүсийг арьсны өнгө, шашин шүтлэг, яс үндсээр нь ялгаварлахгүй хүндэтгэж сурах ёстой.
- 3) Эцэг эх тань чамд ямар боловсрол олгох талаар шийдвэр гаргахад оролцож боломжтой байх ёстой.

**27 дугаар зүйл. Орон нутгийнхаа соёлын амьдралд оролцох эрх:**

- 1) Та өөрийн орон нутгийн уламжлалт зан үйл, сурах үйл ажиллагаанд оролцох, урлаг уран сайхнаас цэнгэл эдлэх, шинжлэх ухааны дэвшлийн ашиг шимийг хүртэх эрхтэй.
- 2) Хэрэв та зураач, зохиолч, эрдэмтэн хүн бол таны бүтээл хамгаалагдсан байх ёстой

бөгөөд та аливаа бүтээлийнхээ ашиг шимийг хүртэх эрхтэй.

**28 дугаар зүйл. Нийгмийн дэг журам эдлэх эрх:**

Та болон бусад бүх хүн эдгээр эрх, эрх чөлөөгөө эдлэх боломжтой нийгэмд амьдрах эрх танд бий.

**29 дугаар зүйл. Нийгмийн хариуцлага**

- 1) Таны бие хүний зан чанар зөвхөн нийгэм дотор л бүрэн хөгжих бөгөөд та орон нутаг, нийгмийнхээ өмнө тодорхой үүрэг хүлээдэг.
- 2) Хүний эрхийг хуулиар хамгаалсан байдаг. Хууль нь хүн бүрт бусдыг хүндэтгэх, бусдаар хүндэтгүүлэх нөхцлийг хангаж өгөх ёстой.
- 3) Эдгээр эрх, эрх чөлөө нь Нэгдсэн Үндэсний байгууллагын тунхагласан зарчим, зорилтуудыг дэмжсэн байх ёстой.

**30 дугаар зүйл. Хүний эрхэд хөндлөнгөөс халдахаас хамгаалагдах эрх чөлөө**

Дэлхийн хаана ч гэсэн ямар ч хүн, бүлэг, засгийн газар эдгээр эрхийг устгахад чиглэсэн ямар нэг үйлдэл хэрхэвч гаргаж болохгүй.

Эх сурвалж: *Компасито –хүүхдэд зориулсан хүний эрхийн боловсролын гарын авлага* (Европын зөвлөл, 2007).



## **ХҮНИЙ ЭРХИЙН ТҮГЭЭМЭЛ ТУНХАГЛАЛ**

*(Албан ёсны тойм эхийн албан бус орчуулга)*

### **1 дүгээр зүйл**

Адил тэгш байх эрх

### **2 дугаар зүйл**

Ялгаварлан гадуурхлаас ангид байх эрх

### **3 дугаар зүйл**

Амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрх

### **4 дүгээр зүйл**

Боолчлолоос ангид байх эрх

### **5 дугаар зүйл**

Эрүү шүүлт, нэр төрийг доромжилсон харьцаанаас ангид байх эрх

### **6 дугаар зүйл**

эрхзүйн чадвартай байх эрхээ хүлээн зөвшөөрүүлэх эрх

### **7 дугаар зүйл**

Хуулийн өмнө адил тэгш байх эрх

### **8 дугаар зүйл**

Эрх мэдэл бүхий шүүхээр эрхээ сэргээлгэх эрх

### **9 дүгээр зүйл**

Дур мэдэн баривчлагдах, хөөн зайлуулагдахаас ангид байх эрх

### **10 дугаар зүйл**

Хараат бус шүүхээр нээлттэй шударгаар шүүлгэх эрх

### **11 дүгээр зүйл**

Гэм буруутайг нь батлах хүртэл гэм буруугүйд тооцогдох эрх

### **12 дугаар зүйл**

Хувь хүн, гэр бүл, орон байр, захидал харилцааны халдашгүй дархан байдалд халдахаас хамгаалагдах эрх

### **16 дугаар зүйл**

Сайн дурын үндсэн дээр гэрлэх, гэр бүл болох эрх

### **17 дугаар зүйл**

Хувийн өмчтэй байх эрх

### **18 дугаар зүйл**

Шашин шүтлэг, итгэл үнэмшилтэй байх эрх

### **19 дүгээр зүйл**

Өөрийн үзэл бодолтой байх, мэдээлэл авах эрх

### **20 дугаар зүйл**

Тайван замаар хуран цугларах, эвлэлдэн нэгдэх эрх

### **21 дүгээр зүйл**

Улсаа удирдахад болон чөлөөт сонгуульд оролцох эрх

### **22 дугаар зүйл**

Нийгмийн хангамж эдлэх эрх

### **23 дугаар зүйл**

Ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох, үйлдвэрчний эвлэлд нэгдэх эрх

### **24 дүгээр зүйл**

Амрах, зав чөлөөтэй байх эрх

### **25 дугаар зүйл**

Хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрх

### **26 дугаар зүйл**

Сурч боловсрох эрх

### **27 дугаар зүйл**

Нийгмийнхээ соёлын амьдралд оролцох эрх

**13 дугаар зүйл**

Улсынхаа дотор чөлөөтэй зорчих, гадаад оронд зорчих, эх орондоо буцаж орох эрх

**14 дүгээр зүйл**

Мөрдөлт мөшгөлтөөс зугтаж, өөр улсад орогнох эрх

**15 дугаар зүйл**

Иргэний харьяалалтай байх болон түүнийг чөлөөтэй солих эрх

**28 дугаар зүйл**

Энэхүү Тунхаглалд заасан эрх, эрх чөлөөг эдэлж болохуйц нийгмийн дэг журамд аж төрөх эрх

**29 дүгээр зүйл**

Чөлөөтэй, өв тэгш хөгжлийг хангахад нийгмийн өмнө хүлээх үүрэг

**30 дугаар зүйл**

Дээрх эрхээ эдлэхэд төр, бие хүний хөндлөнгийн нөлөөнөөс ангид байх эрх чөлөө

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН  
ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦИ**  
(Албан ёсны монгол орчуулга)

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2006 оны 12 дугаар сарын 13-ны өдөр баталсан.

**Удиртгал**

Энэхүү конвенцид оролцогч улсууд,

- (a) Нэгдсэн Үндэсний Байгууллагын дүрэмд тунхагласан зарчмын дагуу хүн төрөлхтний ам бүлийн гишүүн бүхэнд угаас заяасан нэр төр болон тэдний адил тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шударга ёс, бүх нийтийн энх тайвны иш үндэс мөн болохыг эргэн санаж,
- (b) Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон Хүний эрхийн олон улсын пактуудад заасан бүх эрх, эрх чөлөөг хүн бүр ямар нэг ялгаваргүй эдлэх эрхтэй гэдгийг Нэгдсэн Үндэсний Байгууллага тэдгээр баримт бичигт тунхаглан баталгаажуулсныг эргэн санаж,
- (c) хүний бүх эрх, үндсэн эрх чөлөө нь түгээмэл, хуваагдашгүй, биеэ даасан, өөр хоорондоо харилцан хамааралтай болон хөгжлийн бэрхшээлтэй хүн эдгээрийг ямар нэг алагчлалгүй, бүрэн дүүрэн эдлэх явдлыг баталгаажуулах шаардлагатай байгааг дахин нотолж,
- (d) Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Бүх цагаач ажилчин, тэдний гэр бүлийн гишүүдийг хамгаалах тухай олон улсын конвенцийг эргэн санаж,
- (e) хөгжлийн бэрхшээл гэдэг нь өөрчлөгдөн хувьсаж байдаг ойлголт бөгөөд нийгмийн амьдралд бусдын нэгэн адил бүрэн дүүрэн чөлөөтэй оролцоход саад тотгор учруулахуйц бие эрхтний согог, нийгмийн хандлагын болон орчны хязгаарлалтаас үүдэн бий болж байгаа гэдгийг хүлээн зөвшөөрч,
- (f) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох явдлыг дээшлүүлэхэд чиглэсэн үндэсний, бүс нутгийн болон олон улсын хэмжээний бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, тодорхойлох, үнэлэлт дүгнэлт өгөхөд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тухайд хэрэгжүүлэх үйл ажиллагааны дэлхийн хөтөлбөр болон Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тэгш боломж олгох стандарт, дүрэм журамд заасан зарчим, бодлогын удирдамжийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрч,
- (g) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг тогтвортой хөгжлийн зохих стратегийн бүрэлдэхүүн хэсэг болгох зайлшгүй шаардлагатайг онцлон тэмдэглэж,
- (h) хүнийг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан алагчлах нь угаас заяасан хувь хүний нэр төр болон нандин чанарыг үгүйсгэж буй явдал гэдгийг мөн хүлээн зөвшөөрч,
- (i) түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч,
- (j) нэн түрүүн дэмжлэг үзүүлэх шаардлагатай байгаа хүмүүсийг оролцуулан хөгжлийн бэрхшээлтэй бүх хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих хэрэгцээ байгааг хүлээн зөвшөөрч,

- (k) төрөл бүрийн баримт бичиг баталж, үүрэг хүлээлгэсэн хэдий ч дэлхийн аль ч өнцөг буланд тэдгээр хүний эрх зөрчигдөж, нийгмийн амьдралд бусадтай адил тэгш оролцоход саад учирсаар байгаад сэтгэл гүнээ зовниж,
- (l) орон бүрд, ялангуяа хөгжиж буй орнуудын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралын нөхцлийг дээшлүүлэхэд олон улсын хамтын ажиллагаа чухал болохыг хүлээн зөвшөөрч,
- (m) бүх нийтийн сайн сайхан хийгээд тухайн хүрээн дэх ялгаатай байдалд хүний эрх, эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлүүлэх явдлыг дэмжих нөхцөлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн зүгээс өнөө үед оруулж буй үнэт, зохих хувь нэмэр, түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүрэн дүүрэн оролцуулснаар тэдний нийгмийн оролцооны мэдрэмжийг дээшлүүлж хүний, нийгмийн, эдийн засгийн хөгжил дэвшилд мэдэгдэхүйц амжилт олон ядуурлыг бууруулах боломжтой гэдгийг хүлээн зөвшөөрч,
- (n) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд сонголтоо чөлөөтэй хийх эрхийг оролцуулан хувийн бие даасан, хараат бус байдал чухал гэдгийг хүлээн зөвшөөрч,
- (o) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тэднийг шууд хамаарах болон бусад төрлийн хөгжлийн бодлого, хөтөлбөр боловсруулах, шийдвэр гаргах түвшинд хүрч ажиллах боломжоор хангагдсан байх ёстойг харгалзан үзэж,
- (p) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэс угсаа, гарал үүсэл, нийгмийн гарал, өмч хөрөнгө, төрсөн байдал, нас болон бусад байдлаараа давхар болон хүнд хэлбэрийн алагчлалд өртөх хэцүү нөхцөл байсаар байгаад сэтгэл гүнээ зовниж,
- (q) хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охид нь хүчирхийлэл, осол гэмтэл, доромжлол, үл тоомсорлол, хайхрамжгүй харьцаа, хэрцгийлэл, мөлжлөгт өрх гэрийнхээ дотор, гадна хаана ч өртөж болзошгүй туйлын эрсдэлтэй байдалд амьдарч байгааг хүлээн зөвшөөрч,
- (r) Хүүхдийн эрхийн тухай конвенцид оролцогч улсуудын хүлээсэн үүргийг эргэн санахын хамт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нь бусад хүүхдийн нэгэн адил хүний эрх, үндсэн эрх чөлөөгөө бүрэн дүүрэн эдлэх учиртайг хүлээн зөвшөөрч,
- (s) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүний эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлүүлэх явдлыг хөхиүлэн дэмжихдээ жендерийн асуудлыг бүх талаар харгалзан үзэх шаардлагатайг цохон тэмдэглэж,
- (t) хөгжлийн бэрхшээлтэй ихэнх хүн ядуу нөхцөлд амьдарч байгааг тэмдэглэж, үүнтэй холбоотойгоор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст сөрөг нөлөө үзүүлж буй ядуурлын асуудлыг шийдвэрлэх нэн шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрч,
- (u) Нэгдсэн Үндэсний Байгууллагын дүрэмд заасан зорилго, зарчмыг бүрнээ хүндэтгэх сахиж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүрэн дүүрэн хамгаалахад нэн чухал хүний эрхийн баримт бичгүүдийг бүхий л нөхцөл байдалд, ялангуяа зэвсэгт мөргөлдөөн болон гадаад улсын түрэмгийллийн үед ч дагаж мөрдөх нь энх тайван, аюулгүй байдлын гол нөхцөл мөн болохыг анхааралдаа авч,
- (v) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс биеийн, нийгмийн, эдийн засгийн, соёлын орчинд, эрүүл мэнд, боловсрол, мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хүртсэнээр хүний бүхий л эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлэхэд чухал болохыг хүлээн зөвшөөрч,
- (w) аливаа хувь хүн өөрийг нь харьяалах нийгэмлэг болон бусад хүний өмнө үүрэг хүлээснээр Хүний эрхийн тухай олон улсын биллд заасан хүний эрхийг хөхиүлэн дэмжиж сахин биелүүлнэ гэдгийг анхааралдаа авч,

- (х) гэр бүл бол хүний мөн чанараас урган гарсан, нийгмийн үндсэн нэгж бөгөөд нийгэм, төрийн хамгаалалтанд байх эрхтэй хийгээд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрхээ бүрэн дүүрэн, тэгш эдлэх нөхцлийг бий болгох үүднээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд тусламж дэмжлэг хүртэх, шаардлагатай хамгаалалтад байх ёстойд итгэл төгс байж,
- (у) хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, эрх чөлөө, нэр төрийг хамгаалах, хөхиүлэн дэмжих өргөн хүрээтэй бөгөөд суурь олон улсын конвенцийг батлан гаргах нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өмнө тулгарч буй нийгмийн сөрөг нөлөөллийг арилгах болон хөгжингүй, хөгжиж байгаа аль ч оронд тэдгээр хүмүүс бусдын нэгэн адил иргэний, улс төрийн, эдийн засгийн бүхий л хүрээнд оролцох явдлыг дэмжихэд чухал хувь нэмэр оруулна гэдэгт итгэл төгс байж,

*дараах зүйлийг хэлэлцэн тохиров:*

### **1 дүгээр зүйл. Зорилго**

Энэхүү конвенцийн зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй бүх хүн хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлэх явдлыг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих, түүнчлэн тэдний нэр төр, нандин чанарыг хүндэтгэн дэмжихэд оршино.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогтой бөгөөд уг согог нь бусад төрлийн бэрхшээлтэй нэгдэн нийлсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон этгээдийг хэлнэ.

### **2 дугаар зүйл. Тодорхойлолт**

Энэхүү конвенцийн зорилгод:

“Харилцаа” гэж хэл яриа, эх бичвэрийн үзүүлэн, брайль болон тактил хэл, том үсгээр хэвлэгдсэн ойлгоход хялбар мультимедиа хэлбэртэй тоног төхөөрөмж, тухайлбал хэвлэмэл төхөөрөмж, аудио тоног төхөөрөмж, ердийн хэл яриа, ярьдаг ном, түүнчлэн эдгээрийг томруулсан болон орлуулсан аргачлал, харилцаа, түүний дотор мэдээлэл харилцааны технологид нэвтрэх бусад хэрэгслийг хэлнэ;

“Хэл яриа” гэдэгт ярианы болон бичгийн хэл, түүнчлэн ярианы бус бусад төрлийн хэлийг хэлнэ;

“Хөгжлийн бэрхшээлийн улмаас алагчлах” гэж улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, иргэний болон бусад салбарт хүний эрх, үндсэн эрх чөлөөг бусадтай адил тэгш байх үндсэн дээр эдлэх явдлыг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан сулруулах буюу ийм эрхийг хүлээн зөвшөөрөхийг үгүйсгэх зорилго агуулсан, эсхүл тийм үр дүнд хүргэсэн бүх төрлийн алагчлал, гадуурхал, хязгаарлалтыг хэлнэ. Энэ нь алагчлалын бүх хэлбэр, түүний дотор тохирох хэрэглэгдэхүүнээс татгалзах явдал мөн хамаарна;

“Боломжит тохируулга” гэж тодорхой тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын нэгэн адил хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг эдлэх явдлыг хангах үүднээс зохицоогүй,

эсхүл үндэслэлгүй саад тотгорыг арилгах, багасгахад чиглэгдсэн нэн хэрэгцээтэй бөгөөд шаардлагатай тохируулга хийх болон өөрчилж засварлахыг хэлнэ;

“Нийтлэг дизайн” гэж ямарваа нэгэн нэмэлт тохиргоо, тусгай загвар шаардагдахгүйгээр бүх хүн ашиглахад хамгийн дээд зэргээр тохиромжтой байж болох бүтээгдэхүүн, байрлал, програм болон үйлчилгээний хэв маягийг хэлнэ. Нийтлэг дизайнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс шаардлагатай тохиолдолд хэрэглэх туслах хэрэгслүүдийг орхигдуулахгүй.

### **3 дугаар зүйл. Нийтлэг зарчмууд**

Энэхүү конвенцийн зарчмууд нь:

- a) сонголт хийх эрх чөлөө болон хүний бие даасан байдлыг оролцуулан хүний нэр төр, нандин чанар, хувийн хараат бус байдлыг хүндэтгэх;
- b) алагчлахгүй байх;
- c) нийгэмд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох болон хамрагдах;
- d) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлог байдлыг хүндэтгэх, тэднийг хүний ялгаатай байдал, хүн төрөлхтний нэг хэсэг гэж хүлээн авах;
- e) тэгш боломж олгох;
- f) хүртээмжтэй байх;
- g) эрэгтэй, эмэгтэйчүүд тэгш эрхтэй байх;
- h) хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьсаж өөрчлөгдөх чадамжийг хүндэтгэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өөрийн онцлог байдлаа хадгалах эрхийг хүндэтгэн хандах.

### **4 дүгээр зүйл. Нийтлэг үүргүүд**

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан алагчлалгүйгээр хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлүүлэх явдлыг оролцогч улсууд хангаж, хөхиүлэн дэмжих үүрэг хүлээнэ. Эл зорилгоор оролцогч улсууд дараах үүрэг хүлээнэ:
  - a) энэхүү конвенцид заасан эрхийг эдлүүлэхийн тулд хууль тогтоох, захиргааны болон холбогдох бусад арга хэмжээ авна;
  - b) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг алагчлах явдлыг үүсгэж байгаа бүхий л хууль тогтоомж, дүрэм журам, зан заншил, уламжлалыг арилгах, өөрчлөх бүхий л зохистой арга хэмжээг авна;
  - c) төрийн бүх бодлого, хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих явдлыг тусгана;
  - d) энэхүү конвенцид үл нийцэх үйлдэл, эсхүл дадал зуршил гаргахаас татгалзаж, төрийн эрх бүхий албан тушаалтан, байгууллагыг энэхүү конвенцид нийцсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэх явдлыг хангана;
  - e) аливаа этгээд, байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн зүгээс хүнийг хөгжлийн бэрхшээлийн улмаас алагчлах явдлыг устгахад чиглэгдсэн шаардлагатай бүхий л арга хэмжээг авна;
  - f) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тусгай хэрэгцээг хангахад чиглэсэн аль болох хамгийн бага тохируулга шаардагдах бөгөөд хамгийн бага үнэ өртөгтэй энэхүү конвенцийн 2 дугаар зүйлд тодорхойлсон нийтлэг дизайн бүхий бараа, үйлчилгээ, тоног төхөөрөмж болон хэрэгслийг зохион бүтээх, боловсруулах, энэ талаар судалгаа шинжилгээ хийхийг хөхиүлэн дэмжих, тэдгээрийг ашиглахад дэмжлэг

үзүүлэх, түүнчлэн стандарт, гарын авлагыг боловсруулахдаа нийтлэг дизайныг тусгуулах явдлыг дэмжинэ;

- g) хөгжлийн бэрхшээлтэй хүнд тохирсон, юуны өмнө өртгийн хувьд хямд шинэ технологи, түүний дотор мэдээлэл харилцааны технологи, хөдөлгөөн хөнгөвчлөх хэрэгсэл, тоног төхөөрөмж болон туслах технологийг боловсруулах, энэ талаар судалгаа шинжилгээ хийхийг хөхиүлэн дэмжих;
- h) хөдөлгөөн хөнгөвчлөх хэрэгсэл, тоног төхөөрөмж болон туслах технологи, ялангуяа шинэ технологи, тусламж үзүүлэх бусад хэлбэр, нэмэлт үйлчилгээ болон объектын талаарх мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгох;
- i) туслалцаа, үйлчилгээг сайжруулах үүднээс энэхүү конвенцид заасан эрхийг эдлэхэд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй харьцаж ажилладаг мэргэжилтнүүд, ажилтнуудыг сургах ажлыг дэмжих.

2. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухайд эдгээр эрхийг бүрэн дүүрэн эдлүүлэх нөхцөл байдлыг аажмаар бий болгох үүднээс оролцогч улс бүр олон улсын эрхзүйн дагуу нэн даруй үүсэх энэхүү конвенциор хүлээлгэсэн үүрэгтэй үл харшлах байдлаар өөрийн боломжит нөөцийг дээд хэмжээгээр ашиглах бөгөөд шаардлагатай тохиолдолд олон улсын хамтын ажиллагаанд түшиглэнэ.
3. Энэхүү конвенцийг хэрэгжүүлэхэд чиглэсэн хууль тогтоомж, бодлого хөтөлбөрийг боловсруулж мөрдөх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой бусад шийдвэрийг гаргахдаа оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй зөвлөлдөх бөгөөд тэднийг төлөөлөх байгууллагаар дамжуулан тэднийг идэвхтэй оролцуулна.
4. Энэхүү конвенцийн аль ч заалт нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрхээ эдлэх давуу боломж олгосон аливаа улсын дотоодын хууль тогтоомж, эсхүл тухайн улсын хувьд хүчин төгөлдөр олон улсын эрхзүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх явдалд нөлөө үзүүлэхгүй. Энэхүү конвенцид оролцогч аливаа улсын хууль тогтоомж, конвенц, дүрэм журам, зан заншлаар хүлээн зөвшөөрсөн буюу хэрэгжүүлж байгаа хүний аливаа эрх, үндсэн эрх чөлөөг энэхүү конвенцид тэдгээр эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрөөгүй буюу доогуур хэмжээгээр хүлээн зөвшөөрсөн гэх шалтгаанаар хязгаарлах буюу бууруулж болохгүй.
5. Энэхүү конвенцийн заалт бүхэн холбооны улсын хувьд бүх нутаг дэвсгэрт ямарваа нэгэн ялгаа, хязгаарлалтгүй үйлчилнэ.

## **5 дугаар зүйл. Адил тэгш байдал, үл алагчлал**

1. Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд хуулиар ямарваа нэгэн алагчлалгүйгээр тэгш хамгаалуулж, адил ашиг хүртэх эрхтэй болохыг оролцогч улсууд хүлээн зөвшөөрнө.
2. Оролцогч улсууд нь хүнийг хөгжлийн бэрхшээлийн улмаас бүх хэлбэрээр алагчлах явдлыг хориглох бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ямарваа хэлбэрийн алагчлалд өртөхөөс хамгаалах адил тэгш, үр дүнтэй хууль зүйн хамгаалалтыг бий болгоно.
3. Тэгш байдлыг хөхиүлэн дэмжих, алагчлалыг устгах үүднээс оролцогч улсууд нь боломжит зохицлыг хангах бүхий л алхмыг хийнэ.



4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш байдлыг de facto хангах, ийм байдлыг бий болгоход чиглэсэн зайлшгүй шаардлагатай тусгай арга хэмжээнүүдийг энэхүү конвенцийн агуулгад алагчлал гэж үзэхгүй.

#### **6 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд**

1. Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй охид нь давхар алагчлалд өртөж болзошгүй гэдгийг хүлээн зөвшөөрч, үүнтэй холбогдуулан тэдэнд хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн, адил тэгш эдлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авна.
2. Оролцогч улсууд нь энэхүү конвенцид заасан хүний эрх, үндсэн эрх чөлөөг эдлүүлэх явдлыг баталгаажуулах зорилгоор эмэгтэйчүүдийг бүх талаар хөгжүүлэх, аж байдлыг нь дээшлүүлэх болон эмэгтэйчүүдийн эрх боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн зохих бүхий л арга хэмжээг авна.

#### **7 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд**

1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд бусад хүүхдийн нэгэн адил хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлүүлэх явдлыг хангах бүхий л шаардлагатай арга хэмжээ авна.
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэхдээ хүүхдийн ашиг сонирхлыг нэн түрүүн харгалзан үзнэ.
3. Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд бусад хүүхдийн нэгэн адил нь өөрсдийн нас болон биеийн онцлогт тохирсон байдлаар өөрт нь хамаарах аливаа асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг эдлүүлэх бөгөөд энэхүү эрхээ эдлэхэд нь хөгжлийн бэрхшээл болон насны онцлогт тохирсон туслалцаа үзүүлэх явдлыг хангана.

#### **8 дугаар зүйл. Мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх**

1. Оролцогч улсууд нь дараах үр дүнтэй, холбогдох арга хэмжээг нэн түрүүн авах үүрэгтэй:
  - а) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх мэдлэг ойлголтыг нийгмийн бүх хүрээ, ялангуяа гэр бүлийн хүрээнд нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний нэр төр, нандин чанарыг хүндэтгэх явдлыг бэхжүүлэх;
  - б) амьдралын бүх үе шатанд хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд хор уршигтай, хохирол учруулахуйц, ялангуяа нас, хүйс зэрэгт үндэслэсэн дадал зуршлыг бий болгохуйц нийгэмд тогтсон хэв маягтай тэмцэх;
  - в) хөгжлийн бэрхшээлтэй хүний чадавхи, тэдний оруулж буй хувь нэмрийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх.
2. Эдгээр арга хэмжээ нь дараах төрөлтэй байж болно:
  - а) дараах төрлийн үр нөлөөтэй олон нийтэд чиглэгдсэн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх олныг хамарсан ажлыг санаачилж, зохион байгуулах:
    - (i) хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүлээн зөвшөөрөх байдлыг бий болгох;

- (ii) хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар эерэг ойлголт, нийгмийн зөв хандлагыг тогтоохыг дэмжих;
- (iii) хөгжлийн бэрхшээлтэй хүний ур чадвар, авъяас билиг, чадавхи, түүнчлэн ажлын байр болон хөдөлмөрийн зах зээл дээр тэдний оруулж буй хувь нэмрийг хүлээн зөвшөөрүүлэх явдалд дэмжлэг үзүүлэх.
- b) боловсролын тогтолцооны бүхий л түвшин, ялангуяа бүх хүүхдэд бага наснаас эхэлж хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүндэтгэх хандлагыг төлөвшүүлэх;
- c) бүх төрлийн хэвлэл мэдээллийн байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг энэхүү конвенцийн зорилгод нийцүүлэн дүрслэн харуулахыг дэмжих;
- d) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаарх танин мэдэхүй, сурталчилгааны ажлыг хөхиүлэн дэмжих.

## 9 дүгээр зүйл. Хүртээмж

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бие даан амьдрах, амьдралын бүхий л хүрээнд бүрэн дүүрэн оролцох боломжийг бий болгох зорилгоор оролцогч улсууд нь хөдөө орон нутаг, хот суурин газрын хаана ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусдын нэгэн адил өөрийг нь хүрээлэн буй орчин, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо тухайлбал, мэдээлэл харилцаа холбооны технологи, систем болон нийтэд нээлттэй үйлчлэх буюу зориулагдсан бусад төрлийн объект, үйлчилгээг хүртэх явдлыг хангахад чиглэсэн зохих арга хэмжээ авна. Хүртээмжтэй байх явдалд учруулж буй саад, тотгорыг илрүүлэх, устгахад чиглэсэн эдгээр арга хэмжээг *inter alia* дараах газарт авна:
  - a) барилга байшин, зам, тээвэр болон сургууль, орон сууцны байр, эмнэлгийн газар, ажлын байр зэрэг бүх төрлийн доторх болон гаднах байгууламж;
  - b) мэдээлэл, харилцаа холбооны болон бусад төрлийн үйлчилгээ тухайлбал, түргэн тусламжийн болон цахим үйлчилгээ.
2. Түүнчлэн оролцогч улсууд нь дараах шаардлагатай арга хэмжээг авна:
  - a) нийтэд нээлттэй үйлчлэх буюу зориулагдсан объект, үйлчилгээг хүртээмжтэй байлгахад чиглэсэн наад захын стандарт, гарын авлагыг боловсруулж мөрдүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих;
  - b) нийтэд нээлттэй үйлчлэх буюу зориулагдсан объект, үйлчилгээг эрхэлдэг хувийн хэвшлийн байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байдлыг бий болгох бүхий л хүчин зүйлийг харгалзан үзэх явдлыг хангах ;
  - c) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өмнө тулгарч буй хүртээмжийн асуудлаар холбогдох талуудад зориулсан сургалт зохион байгуулах;
  - d) нийтэд нээлттэй үйлчлэх байшин барилга, бусад байгууламжид брайль үсгээр буюу хялбар уншигдах, ойлгогдохуйц байдлаар тэмдэг, тэмдэглэгээ хийх;
  - e) нийтэд нээлттэй үйлчлэх байшин барилга, бусад байгууламжийн хүртээмжтэй байдлыг дээшлүүлэх үүднээс хүний туслалцаа, зуучлалын хэлбэрүүд, тухайлбал, хөтөч, уншигч, дохионы хэлний мэргэжлийн орчуулагчийг бий болгох;
  - f) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэдээлэл хүлээн авах хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн дэмжлэг, туслалцаа үзүүлэх зохих хэлбэрийг хөхиүлэн дэмжих;
  - g) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс мэдээлэл, харилцаа холбооны шинэ технологи, систем, үүний дотор интернетийг хэрэглэх боломжийг нэмэгдүүлэх;
  - h) хүртээмжтэй мэдээлэл, харилцаа холбооны технологи, системийн загварыг

зохиох, сайжруулах, үйлдвэрлэх, түгээн борлуулахдаа эхний ээлжинд эдгээр технологи, системийг байж болох хамгийн хямд өртөгтэй байх явдлыг хангах.

### **10 дугаар зүйл. Амьд явах эрх**

Оролцогч улсууд нь хүн бүр амьд явах салшгүй эрхтэй гэдгийг дахин нотолж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдын нэгэн адил энэ эрхээ бүрэн дүүрэн эдлэх явдлыг хангах талаар шаардлагатай бүх арга хэмжээ авна.

### **11 дүгээр зүйл. Хүмүүнлэгийн гамшиг болон эрсдэл бүхий нөхцөл байдал**

Оролцогч улсууд олон улсын хүмүүнлэгийн эрхзүй, олон улсын хүний эрхийн хэм хэмжээг оролцуулан олон улсын эрхзүйгээр хүлээлгэсэн үүрэгтэй нийцүүлэн эрсдэл бүхий байдал, тухайлбал зэвсэгт мөргөлдөөн, хүмүүнлэгийн гамшиг, байгалийн аюул гамшиг тохиолдсон үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалах, аюулгүй байдлыг нь хангахад чиглэсэн шаардлагатай бүхий л арга хэмжээг авна.

### **12 дугаар зүйл. Хуулийн өмнө тэгш байх эрх**

1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь бусад хүний нэгэн адил хуулийн өмнө адил тэгш байх эрхтэйг дахин нотолж байна.
2. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь амьдралын бүхий л хүрээнд бусадтай адил тэгш байх үндсэн дээр эрхзүйн чадамжтай байх явдлыг хүлээн зөвшөөрнө.
3. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрхзүйн чадамжаа хэрэгжүүлэхэд нь шаардагдах дэмжлэг туслалцааг хүртээмжтэй байлгах үүднээс шаардлагатай арга хэмжээ авна.
4. Оролцогч улсууд нь эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй, зохистой хамгаалалтыг бий болгохуйц эрхзүйн чадамжаа хэрэгжүүлэхтэй холбогдсон бүх арга хэмжээг олон улсын хүний эрхийн хэм хэмжээний дагуу авна. Эрхзүйн чадамжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон ийм хамгаалалт нь тухайн хүний сонголт, хүсэл зоригт нийцсэн, эрхийг хүндэтгэсэн, сонирхлын зөрчилгүй, сөрөг нөлөөгүй, хувийн нөхцөл байдалд нь тохирсон, байж болох хамгийн богино хугацаанд байх бөгөөд бүрэн эрхт, хараат бус, бие даасан байгууллага, эсхүл шүүхийн зохих шатны байгууллага түүнийг тогтмол хянаж байна. Эдгээр хамгаалалт нь тухайн хүний эрх, ашиг сонирхол аль хэр хөндөгдөнө төдий чинээний хэмжээтэй байна.
5. Энэ зүйлийн заалтуудын дагуу оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эд хөрөнгө эзэмших, түүнийг өвлөх, санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх болон банкны зээл, үл хөдлөх хөрөнгийн барьцаат зээл болон бусад төрлийн санхүүгийн үйлчилгээг тэгш хүртэх эрхийг баталгаажуулах зорилгоор шаардлагатай, үр дүнтэй арга хэмжээ авах бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүний эд хөрөнгийг хүсэл зоригийг нь үл хамааран хураахгүй байх явдлыг баталгаажуулна.

### **13 дугаар зүйл. Шүүх ажиллагаанд хүртээмжтэй оролцох**

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусадтай адил тэгш байх үндсэн дээр шүүхийн шатны бүх үйл ажиллагаа, түүний дотор мөрдөн байцаалт болон шүүхийн өмнөх шатны бусад ажиллагаа зэрэг хууль эрхзүйн бүх ажиллагаанд шууд болон шууд бус оролцох үүрэг, тухайлбал гэрчийн хувьд үр нөлөөтэй оролцох явдлыг байцаан шийтгэх ажиллагааны хэм хэмжээ болон насны онцлогт нийцсэн хэрэглэгдэхүүн ашиглах замаар шүүх ажиллагаанд хүртээмжтэй, үр дүнтэй оролцох эрхийг оролцогч улсууд хангана.
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг шүүх ажиллагаанд үр дүнтэй, хүртээмжтэй оролцох нөхцлийг хангах үүднээс оролцогч улсууд шүүхийн байгууллагуудад тухайлбал, цагдаа болон хорих ангийн албан хаагчдыг зохих сургалтад хамруулах явдлыг дэмжинэ.

### **14 дүгээр зүйл. Эрх чөлөө, хувийн халдашгүй эрх**

1. Оролцогч улсууд нь бусадтай адил тэгш байх эрхийг хангах үүднээс хөгжлийн бэрхшээлтэй хүний дараах эрхийг хангана:
  - а) эрх чөлөөтэй байх, хувийн халдашгүй эрхээ эдлэх;
  - б) хуульд заасан үндэслэл, журмаас гадуур тэдгээр хүний эрх чөлөөг үл хасах, эсхүл зөвхөн хуульд нийцсэн журмын дагуу эрх чөлөөг хасах болон аль ч тохиолдолд хөгжлийн бэрхшээл нь эрх чөлөөг нь хасах үндэслэл болохгүй байх.
2. Хэрэв хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх чөлөөг аливаа журмын дагуу хассан бол уг тохиолдолд оролцогч улсууд нь бусадтай адил тэгш нөхцлийн үндсэн дээр боломжит хэрэглэгдэхүүнээр хангахыг оролцуулан энэхүү конвенцийн зорилго, зарчим болон олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцсэн байдлаар тэдэнд хандах явдлыг хангана.

### **15 дугаар зүйл. Эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрх**

1. Хэнд ч эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхийг хориглоно. Ялангуяа, өөрийнх нь чөлөөтэй өгсөн зөвшөөрөлгүйгээр хэнийг ч эмнэлгийн буюу шинжлэх ухааны туршилтад оруулж болохгүй.
2. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусадтай адил тэгш байх эрхийн үндсэн дээр эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхээс урьдчилан сэргийлэх бүхий л үр дүнтэй хууль тогтоох, захиргааны, шүүхийн буюу бусад арга хэмжээг авна.

### **16 дугаар зүйл. Аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос ангид байх эрх**

1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь орон гэрийнхээ дотор, гадна хаана ч жендерт үндэслэсэн байдлыг оролцуулан аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос ангид байх явдлыг хангах үүднээс бүхий л зохистой хууль тогтоох, захиргааны, боловсролын болон бусад арга хэмжээг авна.

2. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нас, хүйсийн онцлогт тохирсон тусламж, туслалцаа үзүүлэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гэр бүл, асран халамжлагчдад нь аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолтой холбоотой бодит явдлын талаар мэдээлэх, таниулах болон эдгээрээс хэрхэн сэргийлэх талаар мэдээлэл түгээх боловсрол олгох зэргээр дэмжлэг үзүүлэх явдлыг хангах замаар аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос урьдчилан сэргийлэх зохистой бүхий л арга хэмжээ авна. Оролцогч улсууд ийнхүү үзүүлж буй хамгаалалтын арга хэмжээ нь нас, хүйсийн онцлог болон хөгжлийн бэрхшээлийг харгалзан үзсэн байх явдлыг хангана.
3. Аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлол гарахаас урьдчилан сэргийлэхийн тулд оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулагдсан байгууллага, хөтөлбөрийг хараат бус эрх бүхий байгууллагаар үр нөлөөтэй хянуулах явдлыг хангана.
4. Оролцогч улсууд аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолын хохирогч болсон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бие махбод, танин мэдэхүй, сэтгэлзүйн хувьд сэргээх, нөхөн сэргээх, нийгмийн амьдралд дахин оролцуулах, ялангуяа хамгаалах үйлчилгээ үзүүлэх зэрэг зохистой бүхий л арга хэмжээг авна. Тийнхүү сэргээх, нийгэмд оролцуулах арга хэмжээг тухайн хүний эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, өөрийгөө хүндэтгэх байдал, нандин чанар, хувь хүний хараат бус байдлыг хангасан орчин нөхцөлд л авахын зэрэгцээ тухайн хүний нас, хүйсийн онцлогийг харгалзан үзсэний үндсэн дээр хэрэгжүүлнэ.
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг мөлжсөн, хүчирхийлсэн, доромжилсон тохиолдол гарсан бол түүнийг илрүүлэх, мөрдөн шалгах болон мөрдөн байцаах хууль тогтоох болон бусад үр дүнтэй арга хэмжээ, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдэд чиглэсэн хууль тогтоох болон бусад арга хэмжээг оролцогч улсууд авна.

### **17 дугаар зүйл. Хувийн нэгдмэл байдлыг хамгаалах**

Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүр бусдын нэгэн адил өөрийнхөө бие махбод болон сэтгэхүйн нэгдмэл байдлаа хүндэтгүүлэх эрхтэй.

### **18 дугаар зүйл. Чөлөөтэй зорчих болон иргэний харьяаллаа чөлөөтэй сонгох эрх**

1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний бусадтай адил чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох болон иргэний харьяаллаа чөлөөтэй сонгох эрхийг хүлээн зөвшөөрч, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дараах эрхийг хангана:
  - а) иргэний харьяалал олж авах болон өөрчлөх эрх мөн иргэний харьяаллыг хүсэл зоригоос нь гадуур буюу хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан хасахыг хориглох;
  - б) иргэншлийг нь нотолсон бичиг баримт, эсхүл өөрийг нь тодорхойлох бусад төрлийн биеийн байцаалтыг олж авах, эзэмших, ашиглах, эсхүл чөлөөтэй зорчих эрхээ хэрэгжүүлэхэд нь зайлшгүй шаардлагатай цагаачлалын журам зэрэг холбогдох дүрэм журмыг ашиглах эрхийг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан хасахыг хориглох;
  - в) төрөлх улсыг нь оролцуулан аливаа улсыг орхин явах;

- d) өөрийн эх орондоо эргэн ирэх эрхийг хөгжлийн бэрхшээлийн улмаас, эсхүл хүсэл зоригоос гадуур хязгаарлаж болохгүй.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд төрөхөөс, эсхүл төрсөн даруй улсын бүртгэлд бүртгэгдэх, нэртэй болох, иргэний харьяалал олж авах болон боломжийн хэрээр эцэг эхээ мэдэх, тэднээрээ асран тэтгүүлэх эрхтэй.

### **19 дүгээр зүйл. Бие даан амьдрах болон тухайн оршин суугаа орчиндоо байх эрх**

Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй бүх хүний бусдын нэгэн адил ердийн оршин суугаа газартаа амьдрах тэгш эрхийг хүлээн зөвшөөрч, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс энэхүү эрхээ эдлэх явдлыг хангах, тухайн оршин суугаа орчиндоо бүрэн дүүрэн хамрагдаж оролцохыг дэмжих үүднээс дараах нөхцлийг хангах замаар зохистой, үр дүнтэй арга хэмжээ авна:

- a) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь бусдын нэгэн адил оршин суух газар болон хаана, хэнтэй амьдрах эсэхээ чөлөөтэй сонгох боломжтой байх ёстой бөгөөд тусгай нөхцөл байдалд амьдрахыг шаардахгүй;
- b) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст гэрийн, оршин суугаа газрын болон тухайн оршин суугаа бусад орчны үйлчилгээ, түүний дотор амьдрахад нь дэмжлэг болохуйц болон тухайн оршин суугаа орчиндоо оролцоход нь хувийн туслалцаа хүртэх боломжтой байх бөгөөд нийгмээс тусгаарлах, хөндийрүүлэхээс хамгаалагдана;
- c) нийт хүн амд үйлчлэх зориулалттай нийтийн үйлчилгээ, объект нь бусадтай адил тэгш байх үндсэн дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд хэрэглэх боломжтой байх бөгөөд хэрэгцээнд нь нийцсэн байна.

### **20 дугаар зүйл. Хувийн хөдөлгөөн**

Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бие даасан байдлыг байж болох хамгийн дээд түвшинд хангах замаар хувийн хөдөлгөөнийг хангах үүднээс дараах хэлбэрээр үр дүнтэй бүх арга хэмжээг авна:

- a) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн хөдөлгөөнийг тэдний сонгосон аргаар, сонгосон цаг хугацаанд нь аль болох хамгийн бага зардлаар хангах явдлыг дэмжих;
- b) чанарын шаардлага хангасан хөдөлгөөн дэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмж, туслах технологи болон туслагчид болон дэмжлэг үзүүлэгчдийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс аль болох хамгийн хямд өртгөөр хүртэх явдлыг дэмжих;
- c) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдэнтэй ажилладаг мэргэшсэн ажилтнуудыг хөдөлгөөн дэмжих ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулах;
- d) хөдөлгөөн дэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмж, туслах технологиудыг үйлдвэрлэж боловсруулахдаа аж ахуйн нэгжүүд хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлгөөний бүхий л тал, хэрэгцээг харгалзаж байх явдлыг хангах.

### **21 дүгээр зүйл. Үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэх, мэдээлэл хүртэх эрх чөлөө**

Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусадтай адил тэгш байх үндсэн дээр энэхүү конвенцийн 2 дугаар зүйлд заасан өөрсдийн сонгосон харилцааны бүх төрлийн хэрэглэгдэхүүнээр дамжуулан үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл хүртэх, тухайлбал, төрөл



бүрийн мэдээлэл, үзэл бодлыг хайх, олж авах, түгээх эрхээ эдлэх нөхцөл байдлыг бий болгох үүднээс зохих бүхий л арга хэмжээ авах бөгөөд ялангуяа:

- a) нийгмийн бүх гишүүнд зориулсан мэдээллийг түгээхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүн ашиглахад хүртээлтэй байхад зориулж хөгжлийн бэрхшээлийн янз бүрийн хэлбэрт нийцсэн арга замаар, тухайн цаг хугацаанд нь, ямар нэг нэмэлт өртөг зардалгүйгээр түгээх;
- b) албан харилцаанд дохионы хэл, брайль үсэг, харилцааны нэмэлт болон сонголтот хэлбэр болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгосон мэдээлэл хүртэх харилцааны бусад арга зам, хэлбэр, хэв маягийг ашиглах явдлыг хүлээн авч дэмжлэг үзүүлэх;
- c) интернетийг оролцуулан нийгмийн бүх гишүүнд зориулсан үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг мэдээлэл түгээх, үйлчилгээ үзүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ашиглаж болохуйц хэлбэрээр түгээх нөхцөл бололцоо бий болгохыг уриалах;
- d) интернетээр мэдээлэл түгээдэг байгууллагуудыг оролцуулан олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийн үзүүлдэг үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байлгахад дэмжлэг үзүүлэх;
- e) дохионы хэлнүүдийг хэрэглэх явдлыг хүлээн зөвшөөрч, хөхиүлэн дэмжих.

## **22 дугаар зүйл. Хувийн нууцыг хүндэтгэх**

1. Амьдран буй газар, орон байрны нөхцөл байдлаас нь үл шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байр буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд уг халдлага буюу өртөлтөөс хуулийн дагуу хамгаалагдана.
2. Оролцогч улсууд нь бусадтай адил тэгш байх эрхийн үндсэн дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн, эрүүл мэндийн болон нөхөн сэргээлтийн талаарх мэдээллийн нууцлалыг хамгаална.

## **23 дугаар зүйл. Орон байр болон гэр бүлийг хүндэтгэх**

1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг гэрлэлт, гэр бүл, эцэг эх, төрөл садангийн харьцаанд бусадтай адил тэгш эрхийн үндсэн дээр алагчлах явдлыг устгах үр дүнтэй, шаардлагатай дараах арга хэмжээг авна:
  - a) гэрлэх насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй хүний гэр бүл болох эрхийг гэрлэх хүнийх нь бүрэн, чөлөөтэй өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр хүлээн зөвшөөрөх;
  - b) хөгжлийн бэрхшээлтэй хүн нь хүүхдийн тоо, хүүхэд төрүүлэх хоорондын зайг чөлөөтэй шийдвэрлэх, хариуцах эрхтэй бөгөөд насныхаа онцлогт тохирсон мэдээлэл, нөхөн үржихүй, гэр бүл төлөвлөлтийн боловсрол эзэмшиж, эдгээр эрхээ эдлэхэд нь шаардлагатай нөхцөл бололцоо болон үр удмаа үлдээх тэгш боломжоор хангагдах;
  - c) хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оролцуулан хөгжлийн бэрхшээлтэй бүх хүнийг бусадтай адил тэгш эрхийн үндсэн дээр үр удмаа үлдээх эрхээр хангах.



2. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асран хамгаалах, харгалзан дэмжих, итгэмжлэх, хүүхэд үрчлэх, эсхүл эдгээртэй ижил төрлийн арга хэмжээ хэрэв үндэсний хууль тогтоомжид тусгагдсан бол эдгээр арга хэмжээний хувьд эрх, үүргээр хангах бөгөөд ямар ч тохиолдолд хүүхдийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавина. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүүхэд өсгөхтэй холбогдсон үүргээ биелүүлэхэд нь зохих тусламжийг үзүүлнэ.
3. Оролцогч улсууд нь гэр бүлийн харилцаанд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тэгш эрхийг хангана. Энэхүү эрхийг хэрэгжүүлэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нууцлах, орхих, үл тоомсорлох, хөндийрүүлэхээс урьдчилан сэргийлэхийн тулд оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон тэдний гэр бүлийн гишүүдийг эхнээсээ л бүх талын мэдээллээр хангаж, үйлчилгээ болон туслалцаа үзүүлнэ.
4. Оролцогч улсууд нь холбогдох хууль тогтоомж, журмын дагуу тийнхүү хөндийрүүлэх нь хүүхдийн эрх ашигт хамгийн ихээр нийцэх тухай шүүхээр шийдвэрлэсний дагуу эрх бүхий зохих байгууллагаас тодорхойлохоос бусад тохиолдолд хүүхдийг өөрийнхөө хүсэл зоригоос гадуур эцэг эхээсээ тусгаарлагдахгүй байх эрхээр хангана. Ямар ч тохиолдолд эцэг эхийн аль нэг нь, эсхүл хоёулаа, эсхүл хүүхэд нь хөгжлийн бэрхшээлтэй гэх шалтгаанаар хүүхдийг эцэг эхээс нь тусгаарлаж болохгүй.
5. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үндсэн гэр бүл нь асран халамжлах боломжгүй тохиолдолд төрөл садангийн гэр бүлийн хүрээнд асран хамгаалуулах бүх төрлийн арга хэмжээг авах бөгөөд ийм арга хэмжээ үр дүнгүй болсон тохиолдолд тухайн оршин суугаа орчинд нь гэр бүлийн нөхцлийг бий болгож асран хамгаална.

## **24 дүгээр зүйл. Боловсрол**

1. Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хүлээн зөвшөөрнө. Энэхүү эрхийг ямар нэг алагчлалгүй, тэгш боломжийн үндсэн дээр эдлүүлэх үүднээс оролцогч улсууд нь дараах зорилгод чиглэсэн бүх түвшний болон насан туршийн сургалтын боловсролын тогтолцоог бий болгоно:
  - а) хүний чадвар, нандин чанарын мэдрэмж болон өөрийгөө үнэлэх үнэлэмжийг бүрэн дүүрэн хөгжүүлж, хүний эрх, үндсэн эрх чөлөө болон хүний ялгаатай байдлыг хүндэтгэх явдлыг бэхжүүлэх;
  - б) хөгжлийн бэрхшээлтэй хүний хувийн шинж чанар, авъяас чадвар, бүтээлч чанар болон тэдний оюуны болон бие махбодын чадварыг байж болох хамгийн бүрэн дүүрэн хэмжээгээр хөгжүүлэх;
  - в) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг чөлөөт нийгэмд үр дүнтэйгээр оролцох боломжийг олгох.
2. Эдгээр эрхийг хэрэгжүүлэх үүднээс оролцогч улсууд нь дараах зүйлээр хангана:
  - а) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь хөгжлийн бэрхшээлийн улмаас ерөнхий боловсролын тогтолцооны гадна, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд хөгжлийн бэрхшээлийн улмаас үнэ төлбөргүй, заавал эзэмших ёстой бага боловсрол болон дунд боловсрол олгох үйл ажиллагааны гадна үлдэхгүй;

- b) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь өөрсдийн амьдарч буй орчиндоо бусадтай адил тэгш байх үндсэн дээр тусгай, үнэ төлбөргүй, чанартай, бага боловсрол болон дунд боловсролыг эзэмших боломжтой байх;
  - c) хувь хүний онцлог шаардлагад нийцсэн боломжит хэрэглэгдэхүүнээр хангагдах;
  - d) ерөнхий боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь өөрсдийн үр дүнтэйгээр сурч боловсрох нөхцөл байдлыг хангуулах үүднээс шаардлагатай дэмжлэг тусалцаа авах;
  - e) түүнчлэн, мэдлэг олгох болон нийгмийн хөгжилд аль болох дэмжлэг үзүүлснээр хувь хүнд зориулж авах арга хэмжээг үр дүнтэй байлгаж, бүрэн дүүрэн оролцуулах зорилтыг хангах.
3. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмийн гишүүний хувьд боловсролд бүрэн дүүрэн, тэгш оролцоход нь дэмжлэг үзүүлэх амьдралын болон нийгмийн хөгжлийн ур чадваруудыг эзэмших боломжийг олгоно. Үүний тул оролцогч улсууд нь дараах зүйлийг оролцуулан шаардлагатай бусад арга хэмжээ авна:
- a) Брайль үсэг болон түүнтэй төстэй өөр үсэг, нэмэлт болон сонголтот арга, төрөл хэлбэр, харилцаанд хэрэглэх бусад хэв маяг, түүнчлэн орон зайн чигийг баримжаалах болон хөдөлгөөн дэмжих ур чадвар эзэмшүүлэх, үе тэнгийнхэн болон сургагч нараас үзүүлэх тусалцаанд дэмжлэг үзүүлэх;
  - b) дохионы хэл сургахад тусалцаа үзүүлэх болон дүлий хүмүүсийн хоорондын хэл ярианы өвөрмөц онцлогийг хөхиүлэн дэмжих;
  - c) мэдлэг олгох болон нийгмийн хөгжилд аль болох дэмжлэг үзүүлснээр хүмүүс, ялангуяа хараагүй, дүлий, хараагүй-дүлий хүүхдүүдэд олгох боловсролыг тухайн хүний онцлогт нийцсэн хамгийн зохистой хэл яриа, арга хэлбэр, харилцаанд хэрэглэх бусад хэв маягаар олгох явдлыг хангах.
4. Эдгээр эрхийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор оролцогч улсууд нь багш нар, ялангуяа брайль үсэг эсхүл дохионы хэл эзэмшсэн хөгжлийн бэрхшээлтэй багш нарыг ажиллуулах талаар зохих арга хэмжээ авч, боловсролын бүх түвшинд ажилладаг ажилтан, мэргэжилтнүүдийг сургах зохистой арга хэмжээ авна. Ийм сургалт нь хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх болон зохистой нэмэлт болон сонголтот арга зам, төрөл хэлбэр, харилцаанд хэрэглэх бусад хэв маяг, хөгжлийн бэрхшээлтэй хүнд туслах боловсролын заах арга зүй, сургалтын материал хэрэглэх явдлыг хамарвал зохино.
5. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бусадтай адил тэгш, үл алагчлах үндсэн дээр дээд боловсрол эзэмших, мэргэжлийн сургалтад хамрагдах, насанд хүрэгсдийн болон насан туршийн сургалтад хамрагдах явдлыг хангана. Эл зорилгоор оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг боломжит хэрэглэгдэхүүнээр хангах явдлыг баталгаажуулна.

## **25 дугаар зүйл. Эрүүл мэнд**

Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөгжлийн бэрхшээлийн улмаас алагчлалгүйгээр эрүүл мэндийн дээд түвшингийн стандартад хүрэх эрхийг хүлээн зөвшөөрнө. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрүүл мэндтэй холбоотой

нөхөн сэргээх эмчилгээг оролцуулан жендерийн онцлогийг харгалзсан эрүүл мэндийн үйлчилгээгээр хангагдах боломжийг баталгаажуулах бүхий л зохистой дараах арга хэмжээг авна. Тухайлбал, оролцогч улсууд нь:

- a) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүн амд суурилсан нийтийн эрүүл мэндийн хөтөлбөр, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн салбарыг оролцуулан бусад хүнд хүргэдэгтэй ижил түвшин, чанар, стандарт бүхий үнэ төлбөргүй буюу худалдан авах чадавхид нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хөтөлбөрүүдээр хангах;
- b) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрүүл мэнд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй нь холбоотойгоор шаардлагатай үйлчилгээнд хамруулах, эрт оношлох, зохих үед таслан зогсоох буюу багасгахад чиглэгдсэн болон хүүхдүүд, ахмадуудыг цаашид хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх үйлчилгээнд хамруулах;
- c) хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан эмнэлгийн үйлчилгээг бүх газарт тухайлбал, хөдөө орон нутагт ч аль болох гэрт нь ойр газар үзүүлэх;
- d) эмч, эмнэлгийн ажилтнуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бусдад үзүүлдгийн нэгэн адил чанартай үйлчилгээ, тухайлбал хүний эрх, нандин чанар, хараат бус байдал болон хөгжлийн бэрхшээлтэй хүнд боловсрол олгох тусгай хэрэгцээ, төрийн эзэмшлийн болон хувийн эмнэлгийн байгууллагуудын ажилтнуудын баримтлах ёс зүйн хэм хэмжээний талаарх ойлголтыг нэмэгдүүлэх замаар *inter alia* чөлөөтэй олж авсан мэдээллийн үндсэн дээр үзүүлнэ;
- e) эрүүл мэндийн даатгал, хэрэв дотоодын хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бол амь насны даатгалын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг алагчлахыг хориглох бөгөөд эдгээрт шударга, боломжит үндэслэлээр даатгуулна;
- f) хөгжлийн бэрхшээлийн улмаас эмнэлгийн тусламж, эрүүл мэндийн үйлчилгээ, эсхүл хоол хүнс, ундны асуудалд алагчилж, үгүйсгэхээс урьдчилан сэргийлэх.

## **26 дугаар зүйл. Сэргээлт, нөхөн сэргээлт**

1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хараат бус байдлыг дээд зэргээр хангах, тэднийг бие махбод, оюун санаа, нийгмийн болон мэргэжлийн бүрэн чадавхитай болгох, нийгмийн бүхий л хүрээнд бүрэн хамрагдах, оролцох боломжийг олгох, эзэмшүүлэх үүднээс бүхий л үр дүнтэй, зохистой арга хэмжээ авна. Эл зорилгоор оролцогч улсууд, ялангуяа эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, боловсрол, нийгмийн үйлчилгээний салбарт өргөн хүрээтэй сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээ, хөтөлбөрүүдийг дараах арга замаар зохион байгуулан бэхжүүлж, өргөжүүлнэ:
  - a) тухайн хувь хүний зүгээс нэн түрүүн шаардлагатай байгаа хэрэгцээг олон талаас нь үнэлж, дүгнэсний үндсэн дээр аль болох эрт үед хэрэгжүүлж эхлэх;
  - b) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тухайн оршин суугаа орчинд нь болон нийгмийн амьдралын бүхий л салбарт сайн дурын үндсэн дээр оролцуулах болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тэдний амьдарч буй, ялангуяа хөдөө, орон нутаг дахь орчинтой нь аль болох ойртуулахад дэмжлэг үзүүлэх.
2. Оролцогч улсууд нь сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх салбарт ажилладаг мэргэжилтнүүд, ажилтнуудад зориулсан анхан болон үргэлжилсэн шатны сургалт зохион байгуулах ажлыг хөхиүлэн дэмжинэ.

3. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулагдсан сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээнд хэрэглэх туслах тоног төхөөрөмж, технологиудыг хүртээлтэй байлгах, тэдгээрийг хэрэглэх зааварчилгаа, мэдлэг олгох явдлыг хөхиүлэн дэмжинэ.

## **27 дугаар зүйл. Ажил, хөдөлмөр эрхлэлт**

1. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бусадтай адил тэгш байх үндсэн дээр хөдөлмөр эрхлэх, тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд хүртээлтэй, нээлттэй байгаа, оролцож болох хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөрлөх орчинд ажиллахаар чөлөөтэй сонгосон, эсхүл зөвшөөрлөө чөлөөтэй өгсөн нөхцөлд эрхэлж буй хөдөлмөрийнхөө үр шимээр амьжиргааны эх үүсвэрээ олох боломжтой байх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүлээн зөвшөөрнө. Оролцогч улсууд нь хөдөлмөр эрхлэх явцдаа хөгжлийн бэрхшээлтэй болсон хүмүүсийг оролцуулан хөгжлийн бэрхшээлтэй бүх хүний ажил, хөдөлмөр эрхлэх эрхийг эдлүүлэх үүднээс зохистой арга хэмжээ, тухайлбал хууль тогтоох болон дараах арга хэмжээ авах явдлыг хангаж, хөхиүлэн дэмжинэ:
- a) ажилд авах нөхцөл, хөлсөөр ажиллуулах, ажил олгох, ажил хөдөлмөр эрхлэх, мэргэжлийн хувьд өсөн дэвжих, эрүүл, аюулгүй хөдөлмөрийн нөхцлөөр хангагдах явдлыг оролцуулан хөдөлмөрийн бүх хэвшилтэй холбогдсон бүхий л асуудалд хөгжлийн бэрхшээлийн улмаас алагчлахыг хориглох;
  - b) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бусадтай адил тэгш байх үндсэн дээр адил хөдөлмөрт ижил тэгш боломж, адил цалин хөлс авах, эрүүл, аюулгүй хөдөлмөрийн нөхцлөөр хангагдах, тухайлбал, дарамт шахалтад өртөхгүй байх, өргөдөл гомдлоо барагдуулах эрх;
  - c) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусадтай адил тэгш байх үндсэн дээр хөдөлмөрлөх, үйлдвэрчний байгууллагатай холбогдсон эрхээр хангах;
  - d) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг техникийн болон мэргэжлийн чиг баримжаа олгох ерөнхий хөтөлбөр, ажлын дадал олгох, мэргэжлийн болон гүнзгийрүүлсэн сургалтад үр дүнтэйгээр хамрагдах боломжийг бий болгох;
  - e) хөдөлмөрийн зах зээлд ажил хайх, ажилд орох, ажиллах болон ажилдаа буцаж орох боломж нөхцөл, мэргэжлийн хувьд дэвших боломжийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст олгох явдлыг хөхиүлэн дэмжих;
  - f) хувиараа хөдөлмөр эрхлэх, аж ахуйн нэгж байгуулах, нөхөрлөл, хоршоо ажиллуулах, хувийн бизнесээ эрхлэх боломжийг дэмжих;
  - g) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг төрийн албанд ажиллуулах;
  - h) зохих бодлого хэрэгжүүлэх, арга хэмжээ авах, түүний дотор тэдэнд зориулсан хөтөлбөр батлах, урамшуулал олгох зэрэг бусад арга хэмжээ авах замаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хувийн хэвшлийн байгууллагад хөдөлмөр эрхлэх явдлыг хөхиүлэн дэмжих;
  - i) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажлын байранд боломжит хэрэглэгдэхүүнээр хангах;
  - j) хөдөлмөрийн нээлттэй зах зээлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ажлын туршлага хуримтлуулах явдлыг хөхиүлэн дэмжих;
  - k) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэргэжлийн болон техник мэргэжлийн нөхөн сэргээлт, ажлын байрыг нь хадгалах болон ажилд нь буцааж оруулах хөтөлбөрийг хөхиүлэн дэмжих.

2. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг мөлжлөг, боолын байдалд оруулахгүй байх, бусадтай адил тэгш байх үндсэн дээр албадан хөдөлмөрөөс хамгаалагдах явдлыг хангана.

## **28 дугаар зүйл. Амьжиргааны хүрэлцэхүйц түвшин, нийгмийн хамгаалал**

1. Оролцогч улсууд нь хүрэлцэхүйц хоол хүнс, хувцас, орон байраар хангагдах эрх, амьдралын нөхцлөө тасралтгүй сайжруулах явдлыг оролцуулан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүл амьжиргааны хүрэлцэхүйц түвшинд байх эрхийг хүлээн зөвшөөрч, энэхүү эрхийг эдлэх явдлыг хөгжлийн бэрхшээлийн улмаас үл алагчлах үндсэн дээр хөхиүлэн дэмжих зохистой арга хэмжээ авна.
2. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн хамгаалал хүртэх эрх, уг эрхийг хөгжлийн бэрхшээлээс шалтгаалан аливаа алагчлалгүйгээр эдлэх явдлыг хүлээн зөвшөөрч, эдгээр эрхийг эдлүүлэх явдлыг хөхиүлэн дэмжих, хамгаалах үүднээс дараах зохистой арга хэмжээ авна:
  - a) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг цэвэр усны үйлчилгээнд тэгш хамрагдах явдлыг хангах болон хөгжлийн бэрхшээлтэй нь холбоотойгоор шаардагдах, боломжийн өртөгтэй үйлчилгээ, тоног төхөөрөмж болон бусад туслалцааг хүртэх явдлыг хангах;
  - b) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охид болон хөгжлийн бэрхшээлтэй ахмад настнуудыг нийгмийн хамгаалал болон ядуурлыг бууруулах хөтөлбөрүүдэд хамрагдах явдлыг хангах;
  - c) ядуу нөхцөлд амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний гэр бүлийн гишүүдийг хөгжлийн бэрхшээлтэй хүний тусгай хэрэгцээт зардал тухайлбал, шаардлагатай сургалт, зөвлөгөө, санхүүгийн туслалцаа болон түр хугацааны туслалцаа авахдаа төрөөс дэмжлэг авах боломжоор хангах;
  - d) бүх нийтийг орон сууцаар хангах хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулах;
  - e) тэтгэвэр, түүнтэй холбоотой хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулах.

## **29 дүгээр зүйл. Улс төр, нийгмийн амьдралд оролцох**

Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн эрхийг баталгаажуулж, эдгээр эрхээ бусдын нэгэн адил эдлэх боломжийг бий болгох үүднээс дараах үүрэг хүлээнэ:

- a) бусадтай адил тэгш байх үндсэн дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгох, сонгогдох эрх, боломжийг оролцуулан шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөллийн байгууллагаараа дамжуулан улс төр, нийгмийн амьдралд үр дүнтэй, бүрэн дүүрэн оролцох байдлыг дараах хэлбэрээр хангана:
  - (i) сонгууль өгөх журам, байр, сонгуулийн хуудас нь ашиглахад зохистой, хүртээмжтэй болон ойлгох, ашиглахад хялбар байх явдлыг хангах;
  - (ii) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сонгууль болон ард нийтийн санал асуулгад ямар нэг сүрдүүлэггүйгээр саналаа нууцаар өгөх, сонгуульд нэрээ дэвшүүлэх, болон шаардлагатай тохиолдолд туслах болон шинэ технологи ашиглах замаар

албан тушаал хаших, төр, засгийн байгууллагын аль ч түвшинд төрийн алба хаах эрхийг дэмжиж хамгаалах;

- (iii) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сонгогчийн хувьд өөрийн санал, бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үүний тулд шаардлагатай тохиолдолд тэдгээр хүмүүсийн хүсэлтээр сонгосон хүний туслалцаатайгаар саналаа өгөх.
- b) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бусадтай адил тэгш байх үндсэн дээр ямар нэг алагчлалгүйгээр төрийн удирдах хэрэгт бүрэн дүүрэн, үр нөлөөтэй оролцох орчин бүрдүүлэх явдлыг идэвхтэйгээр хөхиүлэн дэмжиж, тэдний нийгмийн үйл хэрэгт оролцох оролцоог дараах хэлбэрээр дэмжих:
  - (i) улс орны улс төрийн болон төрийн хэрэг, ялангуяа улс төрийн намуудын үйл ажиллагаа болон удирдлагатай нь холбоотойгоор үйл ажиллагаа явуулдаг засгийн газрын бус байгууллагуудын үйл ажиллагаанд оролцох;
  - (ii) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг олон улсын, үндэсний, бүс нутгийн болон орон нутгийн түвшинд төлөөлөх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага байгуулах, тийм байгууллагад элсэх.

### **30 дугаар зүйл. Соёлын амьдралд оролцох, чөлөөт цаг, амралтаа өнгөрүүлэх, спортоор хичээллэх**

1. Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусадтай адил тэгш байх үндсэн дээр соёлын амьдралд оролцох эрхийг хүлээн зөвшөөрөх бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дараах эрхийг хангах зохистой бүхий л арга хэмжээг авна:
  - a) соёлын бүтээлийг хүртээмжтэй хэлбэрээр хүртэх;
  - b) телевизийн хөтөлбөр, кино, театр болон соёлын бусад арга хэмжээг хүртээмжтэй хэлбэрээр хүртэх;
  - c) театр, музей, кино театр, номын сан, аялал жуулчлалын үйлчилгээ зэрэг соёлын үзвэр, үйлчилгээ эрхэлдэг газруудад нэвтрэх боломжтой байх бөгөөд түүнчлэн хөшөө дурсгал болон үндэсний соёлын ач холбогдол бүхий газруудад ч мөн хүрэх боломжтой байх.
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зөвхөн өөрийн сайн сайхны төдийгүй нийгмийн баялагт хувь оруулах үүднээс уран бүтээлийн, урлагийн болон оюуны чадавхиа ашиглах болон хөгжүүлэх боломжийг тэдэнд бий болгох зохистой бүхий л арга хэмжээг оролцогч улсууд нь авна.
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс урлагийн бүтээлийг хүртэхэд оюуны өмчийн эрхийг хамгаалсан хууль тогтоомж нь үндэслэлгүй, алагчлах шинжтэй саад тотгорыг үүсгэхгүй байх явдлыг хангах үүднээс оролцогч улсууд бүхий л зохистой арга хэмжээг олон улсын эрхзүйн дагуу авна.
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдийн соёлын тусгай болон хэл ярианы онцлог байдал тухайлбал, дохионы хэл, дүлий хүмүүсийн өвөрмөц онцлогийг бусадтай адил тэгш байх үндсэн дээр хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй.
5. Бусадтай адил тэгш байх үндсэн дээр амралт, чөлөөт цагаа спортын арга хэмжээнд оролцох хэлбэрээр өнгөрүүлэх боломжийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хангах үүднээс оролцогч улсууд нь дараах зохистой арга хэмжээг авна:



- a) нийтэд зориулсан спортын бүх төрлийн арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг аль болох бүрэн хэмжээгээр оролцуулах явдлыг дэмжиж сурталчлах;
- b) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусгайлан зориулагдсан спорт, чөлөөт цагийн арга хэмжээг зохион байгуулах, хөгжүүлэх болон оролцох боломжтой байх явдлыг тэдгээр хүнд баталгаажуулах, үүний тулд бусадтай адил тэгш байх үндсэн дээр шаардлагатай сургалт, бэлтгэл, хэрэгслээр хангах;
- c) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс спорт, чөлөөт цагаа өнгөрүүлэх, аялал жуулчлалын байгууллагуудад хүрэх боломжтой байх явдлыг хангах;
- d) хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тоглоом наадгайд оролцох, амралт чөлөөт цагаа спортын арга хэмжээ, тухайлбал сургууль дээр зохион байгуулагдаж байгаа ийм төрлийн арга хэмжээнд бусад хүүхдийн адил оролцох тэгш боломжтой байх явдлыг хангах;
- e) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс чөлөөт цагаа өнгөрүүлэх, аялал жуулчлал, амралт, спортын үйл ажиллагааг зохион байгуулдаг байгууллагуудын үйлчилгээг хүртэх боломжтой байх явдлыг хангах.

### **31 дүгээр зүйл. Статистик болон мэдээлэл цуглуулах**

1. Оролцогч улсууд энэхүү конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор бодлого, стратеги боловсруулах, статистик болон судалгааны мэдээллийг оролцуулан шаардлагатай бүхий л мэдээллийг цуглуулах, тэдгээр мэдээллийг тухайн бодлогод ашиглах үүрэг хүлээнэ. Ийм мэдээллийг олж авах, цуглуулах ажиллагаа нь:
  - a) мэдээллийн нууцлал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн халдашгүй байдлыг хангахын тулд мэдээллийг хамгаалах тухай хууль тогтоомжийг оролцуулан бусад хууль тогтоомжоор олгосон хамгаалалтыг чанд сахих;
  - b) статистик мэдээллийг цуглуулах, ашиглахдаа хүний эрх, үндсэн эрх чөлөөний талаарх олон улсын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ болон ёс зүйн хэм хэмжээг чанд сахих.
2. Энэ зүйлийн дагуу цуглуулсан мэдээлэл нь зохих түвшинд тодорхой байх бөгөөд оролцогч улсууд энэхүү конвенцийн дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлж байгаа эсэхэд үнэлэлт өгөх болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрхээ эдлэх явцад учирч буй саад бэрхшээлүүдийг тогтоох, арилгахад түүнийг мөн хэрэглэнэ.
3. Оролцогч улсууд статистик эдгээр мэдээллийг түгээх үүрэг хүлээх бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон бусад хүнд эдгээр мэдээлэл нь хүртээлтэй байх явдлыг хангана.

### **32 дугаар зүйл. Олон улсын хамтын ажиллагаа**

1. Оролцогч улсууд нь энэхүү конвенцийн зорилт, зорилгыг хэрэгжүүлэх өөрийн үндэсний хүчин чармайлтад дэмжлэг үзүүлэхэд олон улсын хамтын ажиллагаа чухал болохыг хүлээн зөвшөөрөх бөгөөд үүнтэй холбогдуулан улс хооронд үр дүнтэй арга хэмжээ авах, шаардлагатай тохиолдолд олон улсын, бүс нутгийн болон иргэний нийгмийн байгууллагууд ялангуяа, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудтай



хамтран ажиллах бүхий л зохистой арга хэмжээг авна. Тухайн арга хэмжээ нь дараах байдалтай байж болно:

- a) олон улсын хөгжлийн хөтөлбөрүүдийг оролцуулан олон улсын хамтын ажиллагаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамарсан, хүртээмжтэй байх явдлыг хангах;
- b) байгаа нөөц бололцоондоо тулгуурлан, түүний дотор мэдээлэл, туршлага, хөтөлбөр болон тэргүүний туршлагаудаа солилцох замаар чадавхийг бэхжүүлэх явдлыг дэмжих;
- c) шинжлэх ухаан, техникийн мэдлэг болон судалгаа шинжилгээний салбар дахь хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
- d) шаардлагатай тохиолдолд техник, эдийн засгийн туслалцаа, түүний дотор хүртээмжтэй болон туслах технологийг хүртэх явдлыг хөнгөвчлөх, тэдгээрийг өөр хоорондоо харилцан солилцох, түүнчлэн технологийг шилжүүлэх замаар үзүүлэх.

2. Оролцогч аливаа улс энэхүү конвенцийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд энэ зүйлийн заалт аливаа байдлаар нөлөөлөхгүй.

### **33 дугаар зүйл. Үндэсний түвшинд хэрэгжүүлэх болон хяналт тавих**

1. Оролцогч улсууд нь төрийн байгууллагын тогтолцоондоо нийцүүлэн засгийн газартаа нэг буюу хэд хэдэн шатны байгууллагыг энэхүү конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдсон үүрэг гүйцэтгүүлэхээр томилох бөгөөд төрөл бүрийн салбарын төрөл бүрийн түвшинд тухайн асуудлыг зохицуулах механизмыг засгийн газрын бүрэлдэхүүнд бий болгох, томилох боломжийг судалж үзнэ.
2. Оролцогч улсууд нь өөрсдийн эрхзүйн болон засаг захиргааны тогтолцоондоо нийцүүлэн өөрийн улсын хувьд шаардлагатай нэг буюу хэд хэдэн бие даасан механизмыг оролцуулан энэхүү конвенцийн хэрэгжилтэд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх, хамгаалах ажиллагааг эрхэлсэн бүтцийг шаардлагатай тохиолдолд байгуулах, томилох, бэхжүүлэх, тогтвортойгоор ажиллуулна. Ийм механизмыг байгуулахдаа оролцогч улсууд нь хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих үндэсний байгууллагуудын үйл ажиллагаа, эрхзүйн байдлын талаарх зарчмуудыг анхааралдаа авна.
3. Иргэний нийгмийн байгууллагууд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэднийг төлөөлөх байгууллагууд ийнхүү хяналт тавих ажиллагаанд бүрэн дүүрэн оролцох, хамрагдах ёстой.

### **34 дүгээр зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хороо**

1. Үүгээр дор заасан чиг үүргийг гүйцэтгэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хороог (цаашид “Хороо” гэх) байгуулав.
2. Энэхүү конвенцийг хүчин төгөлдөр болох үед Хороо нь арван хоёр гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулна. Энэхүү конвенцийг жаран улс соёрхон баталсан, эсхүл нэгдэн орсон бол Хороог хамгийн дээд хязгаар арван найман гишүүн хүртэл зургаан гишүүнээр нэмэгдүүлнэ.

3. Хорооны гишүүд нь өөрийн нэрийн өмнөөс ажиллах бөгөөд өндөр ёс суртахуунтай, энэхүү конвенцид заасан салбарт хүлээн зөвшөөрөгдсөн мэдлэг чадвар, туршлагатай этгээд байна. Хорооны гишүүнд нэр дэвшүүлэхдээ оролцогч улсууд энэхүү конвенцийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан нөхцлийг зайлшгүй харгалзан үзнэ.
4. Хорооны гишүүд нь оролцогч улсуудаас сонгогдох бөгөөд ийнхүү сонгохдоо улсууд нь газар зүйн шударга хуваарилалт, соёл иргэншил болон эрхзүйн тогтолцооны олон хэлбэрийн төлөөлөл болон хүйсийн тэгш төлөөлөл, хөгжлийн бэрхшээлийн талаар мэргэшсэн байдлыг харгалзан үзнэ.
5. Өөрсдийн улсаас нэр дэвшүүлсэн оролцогч улсуудын нэр дэвшигчдээс бүрдсэн жагсаалтаас оролцогч улсуудын Бага хурал нууцаар санал хурааж Хорооны гишүүдийг сонгоно. Оролцогч улсуудын гуравны хоёр нь оролцсон санал хураалтыг хүчин төгөлдөр гэж үзэх бөгөөд хуралдаанд байлцаж санал өгсөн оролцогч улсын төлөөлөгчдийн хамгийн олонхи буюу дийлэнх олонхийн саналыг авсан нэр дэвшигчийг Хорооны гишүүнд сонгогдсонд тооцно.
6. Анхны сонгуулийг энэхүү конвенци хүчин төгөлдөр болсноос хойш зургаан сараас илүүгүй хугацааны дотор явуулна. Ээлжит сонгууль явуулахаас наад зах нь дөрвөн сарын өмнө Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга оролцогч улсуудад захидал илгээж хоёр сарын дотор нэр дэвшүүлэхийг санал болгоно. Ерөнхий нарийн бичгийн дарга ийнхүү нэр дэвшсэн хүмүүсийн нэрсийн жагсаалтыг үсгийн дарааллаар нь дэвшүүлсэн улсын хамт гаргаж оролцогч улсуудад хүргүүлнэ.
7. Хорооны гишүүд нь дөрвөн жилийн бүрэн эрхийн хугацаатайгаар сонгогдох бөгөөд нэг удаа улиран сонгогдох эрхтэй. Гэхдээ анхны сонгуулиар сонгогдсон зургаан гишүүний бүрэн эрхийн хугацаа хоёр жил байх бөгөөд анхны сонгуулийг явуулж дуусмагц эдгээр зургаан гишүүний нэрийг энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан хуралдааныг даргалагч шодож тогтооно.
8. Нэмж сонгогдох зургаан гишүүнийг энэ зүйлийн холбогдох заалтын дагуу ердийн сонгууль явуулах замаар сонгоно.
9. Хорооны гишүүн нас барах, огцрох буюу бусад шалтгаанаар үүргээ гүйцэтгэх боломжгүй гэж зарласан тохиолдолд түүний нэрийг дэвшүүлсэн оролцогч улс энэ зүйлийн холбогдох заалтыг шаардлагад нийцсэн мэргэшил бүхий өөр шинжээчийн нэрийг дэвшүүлж үлдсэн хугацаанд томилуулж ажиллуулна.
10. Хороо нь үйл ажиллагааныхаа горим, дэгийг өөрөө тогтооно.
11. Энэхүү конвенцийн дагуу Хорооны ажил үүргийг үр дүнтэй гүйцэтгэхэд шаардлагатай боловсон хүчин, материаллаг хэрэгслээр Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Хороог хангах бөгөөд түүний анхны хуралдааныг мөн зарлаж хуралдуулна.

12. Энэхүү конвенцийн дагуу байгуулагдсан Хорооны гишүүн нь Хорооны хүлээсэн үүрэг, хариуцлагын ач холбогдлыг харгалзан Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий Ассамблейн тогтоосон журам, нөхцлийн дагуу Нэгдсэн Үндэсний Байгууллагын хөрөнгөөс Ерөнхий Ассамблейн баталсан хөлсийг авна.
13. Нэгдсэн Үндэсний Байгууллагын дархан эрх, эрх ямбын тухай конвенцийн холбогдох заалтын дагуу Нэгдсэн Үндэсний Байгууллагын томилолтоор ажиллахдаа Хорооны гишүүд нь шинжээчийн эрх ямба, дархан эрх, хөнгөлөлтийг эдэлнэ.

### **35 дугаар зүйл. Оролцогч улсуудын тайлан илтгэл**

1. Оролцогч улс бүр энэхүү конвенцийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор авсан арга хэмжээ, үүнтэй холбоотойгоор гарсан дэвшлийн талаарх дэлгэрэнгүй тайлан илтгэлээ энэхүү конвенци хүчин төгөлдөр болсноос хойш хоёр жилийн дотор Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргаар уламжлан Хороонд хүргүүлнэ.
2. Оролцогч улс цаашид шинээр авсан арга хэмжээнийхээ тухай нэмэлт тайлан илтгэлийг дөрвөн жилд нэгээс доошгүй удаа, түүнчлэн Хорооны хүссэн үед бусад тайлан илтгэлийг гарган өгч байна.
3. Хороо нь тайлан илтгэлийн агуулгыг тодорхойлох аргачлал зааварчилгаагаар хангана.
4. Анхны дэлгэрэнгүй тайлан илтгэлээ Хороонд хүргүүлсэн оролцогч улсын хувьд дараагийн тайлан илтгэлийн өмнө нь дурдсан мэдээллийг давтах шаардлагагүй. Хороонд хүргүүлэх тайлан илтгэлийг бэлтгэхдээ оролцогч улсууд нь нээлттэй, ил тод зарчмыг баримтлах бөгөөд энэхүү конвенцийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан нөхцлийг харгалзан үзнэ.
5. Тайлан илтгэлдээ энэхүү конвенциор хүлээсэн үүргээ биелүүлэхэд саад учруулж буй хүндрэл, нөхцөл байдлын талаар дурдаж болно.

### **36 дугаар зүйл. Тайлан илтгэлийг хэлэлцэх**

1. Хороо нь тайлан илтгэл бүрийг авч хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл ерөнхий зөвлөмж, саналыг оролцогч улсад хүргүүлнэ. Оролцогч улс аливаа мэдээллийг хариулт болгон өөрийн сонголтоор Хороонд хүргүүлж болно. Түүнчлэн Хороо нь энэхүү конвенцийг хэрэгжүүлэхтэй холбоотой нэмэлт мэдээллийг оролцогч холбогдох улсаас хүсэж болно.
2. Оролцогч улсууд нь тайлан илтгэлээ хүргүүлэх хугацааг нэлээд хугацаагаар хожимдуулсан тохиолдолд Хороо оролцогч холбогдох улсад мэдэгдэл өгснөөс хойш гурван сарын дотор зохих тайлан илтгэлийг хүлээж аваагүй тохиолдолд нь оролцогч тухайн улсын хувьд энэхүү конвенцийн хэрэгжилтийг өөрт байгаа бодит мэдээлэлд тулгуурлан хэлэлцэх талаар мэдэгдэнэ. Ийнхүү хэлэлцэхэд оролцогч тухайн улсыг оролцуулах талаар Хороо санал гаргана. Оролцогч улсын зүгээс мэдэгдлийн дагуу тайлан илтгэлийг хүргүүлсэн тохиолдолд энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг удирдлага болгоно.

3. Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга нь тайлан илтгэлийг оролцогч бүх улсад хүргүүлнэ.
4. Оролцогч улсууд нь өөрийн орондоо тайлан илтгэлийг олон нийтэд өргөн хэмжээгээр танилцуулах бөгөөд тайлан илтгэлтэй холбогдуулан гаргасан ерөнхий зөвлөмж, саналыг олон нийт танилцахад хүртээмжтэй байлгана.
5. Хороо нь шаардлагатай гэж үзвэл техникийн зөвлөгөө, дэмжлэг туслалцаа хүсэх зорилгоор оролцогч улсуудын тайланг Нэгдсэн Үндэсний Байгууллагын төрөлжсөн байгууллагууд, сангууд, хөтөлбөрүүдэд анхаарлыг нь хандуулах үүднээс хүргүүлэх бөгөөд хэрэв байгаа бол тухайн тайлан илтгэлтэй холбогдуулж Хорооноос гаргасан санал, зөвлөмжийг хавсарган хүргүүлнэ.

### **37 дугаар зүйл. Оролцогч улсууд болон Хорооны хамтын ажиллагаа**

1. Оролцогч улс бүр Хороотой хамтран ажиллах бөгөөд Хорооны гишүүд өөрийн мандатаа хэрэгжүүлэхэд нь тэдэнд туслалцаа үзүүлнэ.
2. Оролцогч улсуудтай хамтран ажиллахдаа Хороо нь олон улсын хамтын ажиллагаанаас үзүүлэх туслалцааг оролцуулан энэхүү конвенцийг хэрэгжүүлэх үндэсний чадавхийг дээшлүүлэх арга зам, хэлбэрийг харгалзан үзнэ.

### **38 дугаар зүйл. Хорооноос бусад байгууллагатай харилцах**

Энэхүү конвенцийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх болон түүний хамарсан салбарт олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх үүднээс:

- a) Нэгдсэн Үндэсний Байгууллагын төрөлжсөн байгууллагууд болон бусад байгууллага өөрийн бүрэн эрхийн хүрээнд хамаарах асуудлаарх энэхүү конвенцийн холбогдох зүйл заалтын хэрэгжилттэй холбоотой асуудлыг хэлэлцэхэд төлөөлөө байлцуулж болно. Хороо нь шаардлагатай гэж үзвэл төрөлжсөн байгууллага болон бусад эрх бүхий байгууллагыг тэдгээрийн бүрэн эрхийн хүрээнд хамаарах асуудлаар энэхүү конвенцийн хэрэгжилтийн тухайд шинжээчийн зөвлөгөө өгөхийг хүсэж болно. Түүнчлэн Хороо нь Нэгдсэн Үндэсний Байгууллагын төрөлжсөн байгууллагууд болон бусад байгууллагыг үйл ажиллагааных нь хүрээний асуудлаар энэхүү конвенцийн хэрэгжилтийн талаарх тайлан илтгэл ирүүлэхийг хүсэж болно.
- b) тухайн асуудал Хорооны бүрэн эрхийн хүрээнд үл хамаарах тохиолдолд шаардлагатай гэж үзвэл олон улсын хүний эрхийн гэрээний үндсэн дээр байгуулагдсан бусад холбогдох байгууллагатай өөрсдийн тайлан илтгэлийг хэлэлцэх аргачлал, санал, ерөнхий зөвлөмж гаргах журмын нийцлийг хангах үүднээс зөвлөлдөх бөгөөд үйл ажиллагааны давхцал, хийдэл гаргахаас сэргийлнэ.

### **39 дүгээр зүйл. Хорооны тайлан илтгэл**

Хороо нь хоёр жил тутамд өөрийн үйл ажиллагааны талаарх тайлан илтгэлийг Ерөнхий Ассамблей болон Эдийн засаг, нийгмийн зөвлөлд хүргүүлэх бөгөөд оролцогч улсуудаас хүлээн авсан мэдээлэл, тайлан илтгэлийг хэлэлцсэний үр дүнд үндэслэн ерөнхий

зөвлөмж, санал гаргаж болно. Ийнхүү гаргасан ерөнхий зөвлөмж, санал нь Хорооны тайлан илтгэлд хавсаргагдах бөгөөд хэрэв оролцогч улсуудаас тайлбар ирүүлсэн бол түүнийг мөн хамтад нь хүргүүлнэ.

#### **40 дүгээр зүйл. Оролцогч улсуудын бага хурал**

1. Энэхүү конвенцийн хэрэгжилттэй холбоотой аль ч асуудлыг хэлэлцэх зорилгоор оролцогч улсууд нь Оролцогч улсуудын бага хурлыг тогтмол хуралдуулна.
2. Энэхүү конвенци хүчин төгөлдөр болсноос хойш зургаан сараас илүүгүй хугацаанд Оролцогч улсуудын бага хурлыг Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга зарлан хуралдуулна. Дараагийн Бага хурлуудыг Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргын зарлан хуралдуулснаар хоёр жил тутамд нэг удаа, эсхүл оролцогч улсуудын Бага хурлаас шийдвэрлэсэн тухай бүр хуралдана.

#### **41 дүгээр зүйл. Эх хадгалагч**

Энэхүү конвенцийн эх хадгалагч нь Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга байна.

#### **42 дугаар зүйл. Гарын үсэг зурах**

Энэхүү конвенци нь Нэгдсэн Үндэсний Байгууллагын Нью-Йорк хот дахь төв байранд 2007 оны 3 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн гарын үсэг зурахад бүх улс болон бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудын хувьд нээлттэй байна.

#### **43 дугаар зүйл. Дагаж мөрдөх зөвшөөрөл**

Энэхүү конвенцид гарын үсэг зурсан улсуудын хувьд түүнийг соёрхон батлах бөгөөд, гарын үсэг зурсан бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудын хувьд албан ёсоор батламжилна. Энэхүү конвенцид гарын үсэг зураагүй аливаа улс болон бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудын хувьд энэхүү конвенци нь нэгдэн ороход нээлттэй байна.

#### **44 дүгээр зүйл. Бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагууд**

1. “Бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагууд” гэж тодорхой бүс нутгийн тусгаар тогтносон улсуудаас бүрдсэн, гишүүн улсууд нь энэхүү конвенциор зохицуулсан асуудлаар шийдвэр гаргах өөрийн эрх мэдлээ шилжүүлсэн байгууллагыг хэлнэ. Тийм байгууллагууд нь албан ёсоор батламжилсан, эсхүл нэгдэн орох тухай баримт бичигт энэхүү конвенциор зохицуулсан асуудлын хувьд ямар эрх мэдэлтэй болох талаар тусгана. Түүний дараа эдгээр байгууллага нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд гарсан аливаа өөрчлөлтийн талаар эх хадгалагчид мэдээлж байна.
2. Энэхүү конвенцид “Оролцогч улс” гэсэн ишлэл нь эдгээр байгууллагын хувьд түүнд олгосон бүрэн эрхийн хүрээнд үйлчилнэ.

3. Энэхүү конвенцийн 45 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 2 болон 3 дах хэсгийн зорилгын хүрээнд бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагаас хадгалуулсан аль ч баримт бичгийг тооцохгүй.
4. Өөрийн эрх мэдлийн хүрээнд хамаарах асуудлаар бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллага нь Оролцогч улсуудын бага хуралд энэхүү конвенцийн оролцогч болж буй өөрийн гишүүн улсуудынхаа тоотой тэнцүү хэмжээний саналын эрхтэй оролцож болно. Чингэхдээ гишүүн улсуудынх нь аль нэг нь санал өгөх эрхээ эдэлсэн тохиолдолд хамтын ажиллагааны байгууллагууд эсрэгээр санал өгөх эрхээ эдлэхгүй.

#### **45 дугаар зүйл. Хүчин төгөлдөр болох**

1. Энэхүү конвенци нь хорь дахь соёрхон баталсан батламж жуух, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар хүргүүлснээс хойш гуч хоногийн дараа хүчин төгөлдөр болно.
2. Хорь дахь баримт бичгийг хадгалуулахаар өгснөөс хойш энэхүү конвенцийг соёрхон баталсан буюу нэгдэн орсон улс, эсхүл албан ёсоор батламжилсан бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагын хувьд ижил төрлийн баримт бичгээ хадгалуулахаар өгснөөс хойш гуч дахь өдрөөс эхлэн энэхүү конвенци хүчин төгөлдөр болно.

#### **46 дугаар зүйл. Тайлбар хийх**

1. Энэхүү конвенцийн зорилго, зорилттой үл нийцэх тайлбарыг хүлээн авахгүй.
2. Тайлбарыг ямар ч үед буцааж авч болно.

#### **47 дугаар зүйл. Нэмэлт өөрчлөлт оруулах**

1. Энэхүү конвенцид оролцогч аль ч улс нэмэлт өөрчлөлт хийх саналаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хүргүүлж болно. Ерөнхий нарийн бичгийн дарга уг саналыг оролцогч улсуудад мэдээлж, тухайн саналыг хэлэлцэж санал хураах Оролцогч улсуудын бага хурал хуралдуулах саналтай эсэхээ хариу мэдэгдэхийг хүснэ. Ийнхүү мэдээлснээс хойш дөрвөн сарын дотор оролцогч улсын гуравны нэгээс багагүй нь Бага хурлыг хуралдуулах саналтай байвал Ерөнхий нарийн бичгийн дарга түүнийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын ивээл дор зарлан хуралдуулна. Нэмэлт өөрчлөлт нь хуралд оролцогч улсуудын гуравны хоёроос доошгүйн саналаар дэмжигдэх бөгөөд ийнхүү дэмжигдсэн нэмэлт өөрчлөлтийг Ерөнхий нарийн бичгийн дарга Ерөнхий Ассамблейгаар батлуулахаар хүргүүлэх бөгөөд дараа нь оролцогч улсуудаар хүлээн зөвшөөрүүлэхээр хүргүүлнэ.
2. 1 дэх хэсгийн заалтын дагуу дэмжигдэж, батлагдсан нэмэлт өөрчлөлт нь тухайн нэмэлт өөрчлөлтийг дэмжих үед байлцсан оролцогч улсуудын гуравны хоёрын тоотой тэнцүү тооны улс түүнийг хүлээн зөвшөөрсөн тухай баримт бичгийг хадгалуулахаар хүргүүлснээс хойш гуч хоногийн дараа хүчин төгөлдөр болно. Түүнээс хойш нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн оролцогч аливаа улсын хувьд хүлээн зөвшөөрсөн тухай баримт бичгээ хадгалуулахаар хүргүүлснээс хойш гуч хоногийн дараа нэмэлт өөрчлөлт

нь хүчин төгөлдөр болно. Хүчин төгөлдөр болсон нэмэлт өөрчлөлт нь зөвхөн түүнийг баталсан оролцогч улсуудын хувьд заавал дагаж мөрдөх хүчинтэй байна.

3. Хэрвээ Оролцогч улсуудын бага хурлаас нийтийн тохиролцооны үндсэн дээр шийдвэрээ гаргасан бол энэхүү конвенцийн 34, 38, 39 болон 40 дүгээр зүйлийн заалтад хамаарах энэ зүйлийн 1 хэсгийн заалтын дагуу дэмжигдэж, батлагдсан нэмэлт өөрчлөлт нь түүнийг дэмжих үед байлцсан оролцогч улсуудын гуравны хоёртой тэнцүү тооны хүлээн зөвшөөрсөн тухай баримт бичгийг хадгалуулахаар хүргүүлсэн өдрөөс хойш гуч хоногийн дараа оролцогч бүх улсын хувьд хүчин төгөлдөр болно.

#### **48 дугаар зүйл. Цуцлах**

Оролцогч аливаа улс Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад бичгээр мэдэгдэх замаар энэхүү конвенцийг цуцалж болно. Цуцлалт нь Ерөнхий нарийн бичгийн дарга мэдэгдлийг хүлээн авснаас хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно.

#### **49 дүгээр зүйл. Боломжит хувилбар**

Энэхүү конвенцийн эх бичвэр нь хүртээмжтэй хэлбэрээр үйлдэгдэнэ.

#### **50 дугаар зүйл. Ижил хүчинтэй эх бичвэр**

Энэхүү конвенцийн англи, араб, испани, орос, хятад, франц хэлээрх эх бичвэр нь ижил хүчинтэй байна.

Үүнийг нотолж, засгийн газраасаа зохих ёсоор бүрэн эрх олгогдсон бүрэн эрхт төлөөлөгчид энэхүү конвенцид гарын үсэг зурав.



# ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦИ

(Албан бус хялбаршуулсан найруулгын албан бус монгол орчуулга)

## УДИРТГАЛ

Энэхүү конвенцид нэгдэн орж буй улс орнууд дараах зарчмуудыг хүлээн зөвшөөрч байна:

- a. НҮБ-ын суурь баримт бичгүүдэд бид бүгд тэгш эрхтэй бөгөөд хүн төрөлхтний нэгэн гэр бүлийн гишүүд гэсэн байдаг. Энэ нь эрх чөлөө, шударга ёс, дэлхий нийтэд энх тайвныг тогтооход чухал зарчмууд юм.
- b. Бид бүгд адил тэгш бөгөөд бүх хүн ижилхэн хүний эрхийг эдлэх ёстой.
- c. Дэлхийн хаана амьдарч байгаагаас үл шалтгаалан хүн бүр хүний бүх эрхийг эдлэх ёстой. Хүний эрхийг салгаж болохгүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг эдлэх ёстой бөгөөд ялгаварлан гадуурхагдах ёсгүй.
- d. Хүний эрхийг дэмжих, хамгаалах зорилготой олон улсын өөр долоон гэрээ байдаг.
- e. Хөгжлийн бэрхшээл байнга хувиран өөрчлөгдөж байдаг. Хөгжлийг бэрхшээлийг үүсгэдэг зүйл бол хүрээлэн буй орчин, бусад хүмүүсийн хандлага юм.
- f. Аливаа хууль, дүрэм журам, шийдвэр, хөтөлбөр, үйл ажиллагааг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээнд илүүтэй нийцүүлэн өөрчлөх гэж байгаа бол НҮБ-ын Стандарт дүрмүүд болон Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх дэлхийн үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг чухал баримтуудад дэвшүүлсэн зорилго, зорилтыг судлах хэрэгтэй.
- g. Улс орны засгийн газар болон олон улсын байгууллагууд тухайн улс орныг хөгжүүлэх (жишээлбэл, хүмүүсийг хэрхэн ядуурлаас гаргах, эсвэл ажилтай болгох зэрэг асуудлууд) төлөвлөгөө боловсруулахдаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нөхцөл байдлыг мөн адил хэмжээнд тусгасан байхад байнга анхаарч байх хэрэгтэй.
- h. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхах явдал гаргасан хүн бол тэдний нэр хүнд, нандин чанарыг нь булааж авч байгаа хэрэг юм.
- i. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бие биенээсээ олон зүйлээр ялгаатай байдаг.
- j. Хөгжлийн бэрхшээлтэй бүх хүн, тэдний дотор нэмэлт дэмжлэг авах ёстой хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь хүний бүх эрхээ эдлэх ёстой.
- k. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалсан гэрээнүүд байдаг ч тэдний эрх зөрчигдсөөр л байна.
- l. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ялангуяа хөгжиж буй орнуудад амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралыг сайжруулахын тулд улс орнууд бие биентэйгээ хамтран ажиллах нь нэн чухал.
- m. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмийн амьдралд бүрэн оролцдог болж, хүний эрхээ эдэлдэг болох юм бол тэд улс орныхоо хөгжилд зохих хувь нэмрээ оруулж чадна.
- n. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөртөө хамааралтай шийдвэрүүдийг өөрсдөө чөлөөтэй гаргадаг байх нь нэн чухал.
- o. Аливаа бодлого, хөтөлбөр боловсруулах, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст шууд хамааралтай асуудлаар тэднийг өөрсдийг нь оролцуулж байх хэрэгтэй.
- p. Хөгжлийг бэрхшээлтэй хүмүүс зөвхөн хөгжлийн бэрхшээлээсээ болоод зогсохгүй мөн яс үндэс, хүйс гээд бусад олон шалтгаанаар ялгаварлан гадуурхагдаж байна.

- q. Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд хүчирхийлэлд өртөх, зодуулах, гэмтэл бэртэл авах, бусдад ашиглуулах явдал олон гардаг.
- r. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бусад бүх хүүхэдтэй адилхан эрхтэй бөгөөд хүүхдийн эрхийг хамгаалсан олон улсын гэрээнүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд мөн л хамааралтай.
- s. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах, хамгаалах чиглэлээр хийж байгаа бүхий л үйл ажиллагаандаа улс орнууд нь эмэгтэй, эрэгтэйчүүдийг аль алиных нь нөхцөл байдлыг анхааран авч үзэх нь чухал.
- t. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ихэнх нь ядуу амьдралтай байгааг санаж, ядуурал тэдний амьдралд хэрхэн нөлөөлж байгааг судлах нь нэн чухал байна.
- u. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хангаж хамгаалахын тулд бидэнд энх тайван, аюулгүй байдал нэн чухал бөгөөд ялангуяа дайн байлдаантай нөхцөлд юмуу гадаадын түрэмгийллийн дор амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг онцгой анхаарах ёстой.
- v. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс амьдралын бүхий л салбарт оролцох, эрүүл мэнддээ анхаарах, сургуульд явах, хүний эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл олж авах зэрэг боломжоор хангагдсан байх ёстой.
- w. Хүн бүх бусад хүмүүс эрхээ эдэлж чадаж байгаад анхаарах үүрэгтэй.
- x. Гэр бүл бол нийгмийн хамгийн чухал хэсэг бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний гэр бүл нь хүний эрхээ хамгаалах, хангуулахын тулд шаардлагатай бүхий л хамгаалалт, дэмжлэгүүдийг авах ёстой.
- y. Амьдралын бүхий л салбарыг хамарсан Гэрээ нь ядуу болон баян улс орнуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралыг сайжруулах, тэдэнд бусадтай адил тэгш ханддаг болох, амьдралын бүхий л салбарт тэднийг ижил тэгш хамруулдаг болоход дэм тустай байх болно.

Дээр жагсаасан шалтгаануудын улмаас энэхүү Гэрээнд нэгдэн орохоор шийдсэн улс орнууд нь дараах зүйлсийг зөвшөөрч байна:

### **1 дүгээр зүйл: Зорилт**

Энэ Гэрээ нь дараах зүйлсийг баталгаажуулах зорилготой

- хөгжлийн бэрхшээлтэй бүх хүний эрх, эрх чөлөөг хангах, хөхиүлэн дэмжих, хамгаалах;
- хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нэр төр, нандин чанарыг хүндэтгэх үзэл хандлагыг хөхиүлэн дэмжих. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дотор удаан хугацааны согогтой хүмүүс (жишээлбэл, бие махбодын, сэтгэц- нийгмийн, оюуны согог) болон янз бүрийн шалтгаанаар нийгмийн амьдралд оролцоход нь саад бэрхшээл тулгардаг хүмүүс (жишээлбэл, бусад хүмүүсийн хандлага, хэл, бие махбодын юмуу эрхзүйн саад тотгорууд) зэргийг багтааж үзнэ.

### **2 дугаар зүйл: Тодорхойлолт**

“Харилцаа” гэдэг нь хүмүүсийн хоорондоо харилцахдаа хэрэглэдэг бүхий л арга хэрэгслийг багтаана (жишээлбэл, аман харилцаа, дохионы хэл, бичвэр, Брайль үсэг, том үсгээр бичих, биед нь хүрэх, бичмэл, аудио юмуу хялбаршуулсан найруулгын хэл, уншиж өгөх) зэргийг багтаана.

“Хэл” гэдэг нь хэлний бүхий л төрөл, хэлбэр (жишээлбэл, аман, дохионы, эсвэл ярианы төрөл хэлбэргүй хэлнүүд) зэргийг багтаана.

“Хөгжлийн бэрхшээлийн улмаас ялгаварлан гадуурхах” гэдэг нь хүнийг хөгжлийн бэрхшээлтэй учраас ямар нэг зүйлээс хасах, хориглох, ямар нэг зүйл хийхэд нь саад болох гэсэн утгатай. Энэ ялгаварлан гадуурхал нь амьдралын бүхий л салбарт гарч болно.

“Боломжит тохируулга” гэдэг нь эрхээ эдлэх боломжтой болохын тулд хүмүүст зарим нэг өөрчлөлт хийж өгөх шаардлага гарч болохыг хэлж байгаа юм (жишээлбэл, амьдралын юмуу ажлын орчинд нь өөрчлөлт хийх хэрэгцээ). Хэрвээ хэт өртөг өндөртэй юмуу маш хэцүү өөрчлөлт хийх хэрэгтэй болох юм бол түүнийг хийх боломжгүй болж ч мэднэ.

“Нийтлэг дизайн” гэдэг нь эд зүйлсийг үйлдвэрлэх, программ хангамжийг зохион бүтээх, байр байшингийн дизайныг гаргахдаа бүх хүн ашиглах боломжтой байдлаар хийхийг хэлж байгаа юм. Заримдаа зарим төрлийн хөгжлийг бэрхшээлтэй хүмүүс эрхээ эдлэх боломжтой болохын тулд тэдэнд тусгайлан зориулсан тусгай эд зүйлс хэрэгтэй болж мэднэ.

### **3 дугаар зүйл: Нийтлэг зарчим**

Энэ Гэрээ нь дараах зарчмуудад тулгуурлаж байна:

- Нэр төр
- Сонголт хийх чадавхи
- Бие даасан байдал
- Ялгаварлан гадуурхахгүй байх
- Оролцоо
- Бүрэн хамрагдалт
- Ялгаатай байдлыг хүндэтгэх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүн төрөлхтний нэг хэсэг гэж хүлээж авах
- Тэгш боломж
- Хүртээмжтэй байдал
- Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш байдал
- Хүүхдийг хүндэтгэх.

### **4 дүгээр зүйл: Нийтлэг үүрэг**

1. Энэ Гэрээнд нэгдэж байгаа улс орнууд нь хүний эрхийг хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхалгүйгээр хүн бүрт эдлүүлэхэд анхаарахын амлаж байна. Энэ амлалтаа биелүүлэхийн тулд улс орнууд нь:
  - а. өөрийн улс орондоо Гэрээнд дурьдсантай төстэй шинэ хууль, бодлого, үйл ажиллагааг хэвшүүлнэ;
  - б. хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхсан агуулгатай хуучин дүрэм журам, хууль, уламжлалуудаа хална;
  - с. хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг бүх бодлого, хөтөлбөрүүддээ тусгана;

- d. энэ Гэрээтэй нийцээгүй ямар нэг зүйл хийхгүй, бусад нь энэ Гэрээг хүндэтгэн мөрдөнө;
  - e. хувь хүн, байгууллага, хувийн бизнесүүд хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхаж байгааг зогсоох арга хэмжээ авна;
  - f. дэлхий нийтээрээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ашиглах боломжтой үнэтэй өртөг багатай бараа, үйлчилгээ, тоног төхөөрөмж, байр байгууламжийг боловсруулах, хүртээмжтэй болгоход анхаарч ажиллана;
  - g. хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст амьдралын бүхий л салбарт хэрэгтэй, боломжийн үнэтэй технологи боловсруулахад анхаарна;
  - h. бүхий л төрлийн туслалцаа, дэмжлэг, үүний дотор туслах технологийн тухай мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ойлгомжтой арга хэлбэрээр хүргэх;
  - i. хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажилладаг хүмүүст энэ Гэрээнд багтсан эрхийн талаар сургалт явуулж байхыг сурталчлан дэмжинэ.
2. Өөрт байгаа хөрөнгө нөөцийн хүрээнд хүний эдийн засаг, нийгмийн болон соёлын эрхийг дэмжсэн хууль, дүрэм журмуудыг хэрэгжүүлэх. Шаардлагатай бол эдгээр эрхийг хэрэгжүүлэхийн тулд улс орнууд нь бусад улс орнуудтай хамтран ажиллана. Хүний бусад эрхийг нэн даруй хэрэгжүүлж эхлэх ёстой.
  3. Энэ Гэрээтэй холбоотой ямар нэг хууль, дүрэм журам гаргахдаа улс орнууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон хүүхдүүдийг төлөөлж байгаа байгууллагуудаар дамжуулан тэдний бодол саналыг сонсож, тэднийг шууд оролцуулна.
  4. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг илүү сайн хангасан хууль, дүрэм, журмыг энэ Гэрээний улмаас өөрчлөхгүй байх. Улс орнууд нь энэ Гэрээг одоогийн байдлаар баталгаажихсан байгаа хүний эрхийг хэрэгжүүлэхгүй байх шалтаг болгон ашиглаж болохгүй.
  5. Энэ Гэрээг нийт үндэсний хэмжээнд хэрэгжүүлнэ.

## **5 дугаар зүйл: Тэгш байдал ба үл ялгаварлал**

1. Хөгжлийн бэрхшээлтэй бүх хүн хуулийн өмнө ижил тэгш бөгөөд ямар ч ялгаварлалгүй хуулиар хамгаалагдсан болно.
2. Хөгжлийн бэрхшээлийн улмаас ямар нэг ялгаварлан гадуурхал гаргаж болохгүй бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ийм төрлийн ялгаварлалаас хуулиар хамгаалагдсан байдаг.
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрхээ эдлэхийн тулд хүрээлэн буй орчиндоо ямар нэг өөрчлөлт хийлгэх шаардлага гарах юм бол эдгээр өөрчлөлтийг хийж өгөх ёстой.
4. Бусад хүмүүстэй адил тэгш байхын тулд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусгай арга хэмжээ хэрэгтэй болох юм бол энэ тусгай хандлага нь бусад хүмүүсийг ялгаварласан шударга бус хандлага гэж тооцогдохгүй.

## **6 дугаар зүйл: Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд**

1. Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд олон төрлийн ялгаварлан гадуурхалтай тулгардаг. Улс орнууд нь охид, эмэгтэйчүүдэд хүний эрхээ бүрэн дүүрэн, бусадтай адил тэгш хэмжээнд эдлэх боломжийг хангаж өгнө.
2. Улс орнууд нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд эрхээ хангуулах, эдлэх боломжийг хангахын тулд тэдний хөгжил, чадавхижилтад дэмжлэг үзүүлнэ.

## **7 дугаар зүйл: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд**

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нь бусад бүх хүүхэдтэй адил эрхтэй.
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хамааралтай аливаа арга хэмжээ нь хүүхдийн сайн сайхны төлөө хийгдэх ёстой.
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нь өөрийн үзэл бодлыг илэрхийлэх, санал бодлоо сонгох эрхтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд үзэл бодлоо илэрхийлэхэд нь шаардлагатай тусалцаа дэмжлэгийг авах ёстой.

## **8 дугаар зүйл: Мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх**

1. Улс орнууд нь:
  - a. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгардаг саад тотгорын талаар тэдний гэр бүл, бусад хүмүүсийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд тусална. Улс орнууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, нэр төрийг хүндэтгэх хандлагыг төлөвшүүлэхэд анхаарна;
  - b. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх хэвшмэл ойлголт, сөрөг хандлагатай тэмцэнэ (Хэвшмэл ойлголт гэж зарим хүмүүст тогтсон бусдын талаарх хэт ерөнхий бөгөөд буруу ойлголтыг хэлнэ. Эдгээр итгэл үнэмшил нь хор хохирол учруулах нь их байдаг бөгөөд ялгаварлан гадуурхалд хүргэх явдал гардаг.)
  - c. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс юу хийж чадах, улс орныхоо хөгжил дэвшилд хэрхэн хувь нэмрээ оруулж чадах талаар ойлгож авахад хүн бүрт тусална.
2. Улс орнууд нь мөн:
  - a. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг хүн бүрт хүргэнэ.
    - I. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусадтай адил эрхтэй болохын харуулах;
    - II. Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар эерэг ойлголт, нийгмийн зөв хандлагыг тогтоох;
    - III. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ур чадварууд болон тэдгээрийг хэрхэн ашиглаж болох тухай ойлгуулах.
  - b. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хүндэтгэж хандах талаар сургуульд сургаж байхад анхаарна;
  - c. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр (жишээлбэл, радио, телевиз, сонин, сэтгүүл) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дүрсийг ашиглах замаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг сурталчилж байхад анхаарна;
  - d. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай олон нийт, хүн амын мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх сургалтуудыг дэмжинэ.

## **9 дүгээр зүйл: ХҮРТЭЭМЖ**

1. Улс орнууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгардаг саад тотгоруудыг арилгана. Ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бие даан бүрэн дүүрэн амьдралаар амьдрах боломжтой болно.  
Улс орнууд нь дараах саад тотгорын арилгана:
  - a. барилга байшин, зам, тээвэр болон байшин доторх болон гадуурх зүйлс (жишээлбэл, сургууль, орон байр, эмнэлэг, эрүүл мэндийн төв, ажлын байр);
  - b. мэдээлэл, харилцаа, бусад үйлчилгээ (жишээлбэл, цахим харилцааны үйлчилгээ болон яаралтай тусгай үйлчилгээ).
2. Улс орнууд нь мөн:
  - a. Олон нийтийн газар, үйлчилгээнд хамааралтай стандартуудыг боловсруулна;
  - b. Олон нийтэд үйлчилдэг хувийн бизнес, байгууллагуудын хүртээмжтэй байлгахад анхаарна;
  - c. Хүртээмжтэй байдалтай холбоотойгоор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ямар хэрэгцээ байдгийг бусад хүмүүст зааж сургана;
  - d. Олон нийтийн барилга байшинд Брайль үсгээр бичсэн тэмдэг, уншиж ойлгоход хялбар дөхөм мэдээлэл байрлуулна;
  - e. Олон нийтэд нээлттэй барилга байшингуудад нэвтрэхэд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст шаардлагатай туслалцааг хангаж өгнө (жишээлбэл, уншиж өгөх хүмүүс, дохионы хэлний орчуулагч, хөтөч гэх мэт);
  - f. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэдээлэл авахад нь туслах бусад дэмжлэг, туслалцааг хангаж өгнө;
  - g. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ашигтай шинэ технологиудыг дэмжинэ;
  - h. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэдээлэл авах, харилцах боломжийг сайжруулах зорилготой шинэ технологиудыг дэмжих сурталчилна.

## **10 дугаар зүйл: Амьд явах эрх**

Хөгжлийн бэрхшээлтэй бүх хүн амьд явах эрхтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст энэ эрхийг нь эдлүүлэх талаар улс орнууд арга хэмжээ авч ажиллана.

## **11 дүгээр зүйл: Эрсдэлт нөхцөл ба хүмүүнлэгийн хямралт нөхцөл**

Дайн байлдаан, байгалийн гамшиг, бусад эрсдэлд нөхцөлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хамгаалагдсан байхад улс орнууд анхаарал хандуулна..

## **12 дугаар зүйл: Хуулийн өмнө ижил тэгш байх эрх**

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь бусдын адил хуулийн этгээд болохоо хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй.
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь өөрсдийнхөө амьдралын бүхий л хүрээнд тохиолдох эрхзүйн аливаа асуудлаар бусдын адил чадамжтай.
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрхзүйн аливаа асуудлаар шийдвэр гаргахдаа шаардлагатай туслалцааг авах эрхтэй.

4. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрхзүйн юмуу санхүүгийн туслалцаа хэрэг болсон үед:
- тэд аливаа хүчирхийллээс хамгаалагдсан байна;
  - тэдний эрх, өөрсдийнх нь сонголтыг хүндэтгэнэ;
  - туслалцаа үзүүлж байгаа хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг шийдвэр гаргаж байхад нь шахалт үзүүлэхгүй;
  - тэд өөрсдөд нь шаардлагатай байгаа туслалцааг зөвхөн өөрсдөд нь хэрэгтэй цаг үед, өөрсдөд нь хэрэгтэй хугацаагаар авна;
  - тэдэнд үзүүлсэн туслалцааг шүүх хянаж үзнэ.
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс дараах эрхээ эдэлж чадаж байгаад улс орнууд анхаарна:
- а. хөрөнгө эзэмших ба хөрөнгөтэй болох эрхтэй;
  - б. мөнгө, санхүүгийн бусад үйл ажиллагаагаа өөрсдөө хянах эрхтэй;
  - с. банкнаас зээл авах, барьцааны болон кредитийн үйлчилгээнд хамрагдах бусадтай адил тэгш боломжтой;
  - д. үндэслэл, шалтгаангүйгээр өмчийг нь хураахгүй байх.

### **13 дугаар зүйл: Шүүх ажиллагаанд хүртээмжтэй оролцох**

1. Тухайн улсын шүүхийн тогтолцоо нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бусад хүмүүстэй адил хэмжээнд хүртээмжтэй үйлчилж байгаад улс орнууд анхаарал тавина. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг шүүх үйл ажиллагааны бүхий л үе шатанд оролцуулахын тулд үйл ажиллагааг явуулах журам, заавраа өөрчлөн зохицуулах хэрэгтэй (жишээлбэл, гэрчээр оролцох тохиолдолд гэх мэт).
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хэрхэн илүү хүртээмжтэй байдлаар ажиллах талаар шүүхийн тогтолцоонд ажиллаж байгаа хүмүүст (жишээлбэл, цагдаагийн юмуу шоронгийн ажилтнууд) сургалт явуулж байх хэрэгтэй.

### **14 дүгээр зүйл: Эрх чөлөө ба хувийн халдашгүй байдал**

1. Улс орнууд нь:
  - а. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь бусад хүмүүсийн адил эрх чөлөөтэй, халдашгүй байх эрхээ эдэлж чадаж байгаад анхаарна;
  - б. хөгжлийн бэрхшээлийн улмаас юмуу бусад хууль бус арга замаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн уг эрхийг хасахгүй байхад анхаарна.
2. Аливаа хүн эрх чөлөөгөө хасуулсан байлаа ч түүнд хуулийн хамгаалалт хэвээр үйлчилж байгаад улс орнууд анхаарна. Тухайн хувь хүнд эрхийг нь эдлүүлэхийн тулд түүний орчин нөхцөлд өөрчлөлт оруулах шаардлагатай болох юм бол эдгээр өөрчлөлтийг хийж өгөх хэрэгтэй.

### **15 дугаар зүйл: Эрүү шүүлт, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг гутаасан харьцаа, шийтгэлээс ангид байх эрх**

1. Ямар ч хүнийг тамлан зовоож, эсвэл хэрцгий, хүнлэг бус, нэр төрийн нь гутаасан байдлаар харьцах юмуу шийтгэж болохгүй. Хэнийг ч эмнэлгийн юмуу шинжлэх ухааны туршилтад хүчээр оролцуулахгүй.



2. Улс орнууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусдын адил эрүү шүүлт, хэрцгийллээс хамгаалсан хууль батлах юмуу бусад арга хэмжээ авна.

### **16 дугаар зүйл: Аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос ангид байх эрх**

Улс орнууд нь:

1. хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэртээ болон гэрээсээ гадуур орчинд мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолд өртөхөөс сэргийлсэн хууль батлах юмуу бусад арга хэмжээ авна.
2. хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийнхэнд туслалцаа үзүүлэх, шаардлагатай мэдээлэл өгөх замаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүчирхийллээс хамгаалах арга хэмжээ авна.
3. хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үйлчилгээ үзүүлдэг газар, хөтөлбөрүүдийн хүрээнд хүчирхийлэл, доромжлол гарахаас сэргийлж эдгээрт тогтмол хяналт тавина.
4. хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь хүчирхийлэл, доромжлолд өртөж хохирсон тохиолдолд тэднийг нөхөн сэргэх, нийгэмдээ эргэж ороход нь туслалцаа, дэмжлэг үзүүлнэ.
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүчирхийлсэн, тэдэнтэй зохисгүй харьцсан тохиолдлуудыг мөрдөн шалгах, буруутай хүмүүсийг шийтгэх хууль, бодлого боловсруулж батлах. Эдгээр хууль, бодлого нь хүүхэд, эмэгтэйчүүдийн хэрэгцээг тусгасан байна.

### **17 дугаар зүйл: Хувийн нэгдмэл байдлыг хамгаалах нь**

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь бусад хүмүүсийн адил бие махбодын болон сэтгэл санааны нэгдмэл байдлаа хүндэтгүүлэх эрхтэй.

### **18 дугаар зүйл: Чөлөөтэй зорчих болон иргэний харьяаллаа чөлөөтэй сонгох эрх**

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь бусдын адил өөрийн улс орон дотроо болон улс орнуудын хооронд зорчих, хаана амьдрах, аль улсын иргэн байхаа сонгох эрхтэй. Улс орнууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дараах эрхийг хангаж өгнө:
  - a. иргэний харьяалалтай болох, солих эрх. Тэдний иргэний харьяаллыг үндэслэл шалтгаангүйгээр юмуу хөгжлийн бэрхшээлтэй гэсэн шалтгаанаар хэн ч цуцлах эрхгүй;
  - b. иргэний үнэмлэх, иргэний харьяалалтай холбоотой бусад баримт бичгийг үндэслэл шалтгаангүйгээр юмуу хөгжлийн бэрхшээлтэй гэсэн шалтгаанаар хурааж авч болохгүй бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусад улс орнууд руу зорчиход саад болохгүй;
  - c. өөрийн болон бусад орноос гарах боломжтой байна;
  - d. тодорхой үндэслэлгүйгээр, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй гэсэн шалтгаанаар өөрийн улс орон руу ороход нь саад хориг тавихгүй.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд төрсөн даруйдаа бүртгэлд хамрагдана. Тэд өөрийн нэртэй байх, үндсэн захиргаандаа харьяалалтай байх эрхтэй бөгөөд боломжийн хэрээр өөрийн эцэг эхийг мэдэх, эцэг эхийнхээ гар дээр өсөж торних эрхтэй.

### **19 дүгээр зүйл: Бие даан амьдрах болон тухайн оршин суугаа орчиндоо байх эрх**

Хөгжлийн бэрхшээлтэй бүх хүн бусдын нэгэн адил орон нутагтаа бусад хүмүүсийн дунд амьдрах, орон нутгийнхаа нийгмийн амьдралд хамрагдах, оролцох эрхтэй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дараах эрх хангагдаж байгаад улс орнууд анхаарах болно:

- a. Бусад хүмүүстэй адил хаана, хэнтэй амьдрахаа сонгох боломжтой байх. Тэд өөрсдөө л хүсээгүй бол тэднийг асрамжийн газар юмуу өөр бусад тусгай нөхцөлд хүчээр амьдруулж болохгүй;
- b. Орон нутагтаа хаана, хэрхэн амьдрах тухайд сонголт хийх боломжтой байх, үүний дотор нийгмийн амьдралд хамрагдах, улмаар нийгмээсээ тусгаарлагдахгүй байхын тулд хувийн туслахын үйлчилгээ авах боломж багтана;
- c. Олон нийтэд үйлчилдэг орон нутгийн үйлчилгээнүүдийг ашиглах боломжтойн дээр шаардлагатай бол эдгээрийг хувь хүний онцлог хэрэгцээнд тохируулан өөрчилж байх.

### **20 дугаар зүйл: Хувийн хөдөлгөөн**

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байж болох дээд зэргийн бие даасан, хараат бус байдлаар зорчих боломжтой байхад улс орнууд анхаарна. Үүний дотор:

- a. хүссэн цаг хугацаандаа сонгосон арга хэлбэрээрээ аль болох хамгийн бага зардлаар зорчиход нь туслах;
- b. хувийн хөдөлгөөнийг дэмждэг туслах хэрэгсэл, технологийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст олдоцтой байлгах, үүний дотор боломжийн үнэтэй байхад анхаарах;
- c. хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдэнтэй ажилладаг мэргэжилтнүүдийг хувийн хөдөлгөөн дэмжих ур чадвар суулгах сургалтууд явуулах;
- d. хөдөлгөөн дэмжих хэрэгсэл, технологи үйлдвэрлэхдээ хувийн хөдөлгөөнтэй холбоотой бүхий л асуудал, хэрэгцээг харгалзаж байхыг үйлдвэрлэгчдэд ойлгуулах.

### **21 дүгээр зүйл: Үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэх, мэдээлэл хүртэх эрх чөлөө**

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бодол, саналаа Брайль, дохионы хэл юмуу өөрийн сонгосон харилцааны бусад хэлбэрээр илэрхийлэх эрхтэй бөгөөд энэ эрхийг хэрэгжүүлэхэд улс орнууд анхаарна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдын адил мэдээлэл өгөх, авах эрхээ эдэлж чадаж байгаад улс орнууд анхаарна. Үүний дотор:

- a. олон нийтэд зориулсан мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээнд тохирсон арга хэлбэрээр (жишээлбэл, Брайль үсгээр) нэмэлт үнэ төлбөргүй хүргэнэ;

- b. хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс албан нөхцөлд өөрийн хэрэгцээнд нийцүүлэн харилцааны янз бүрийн арга хэлбэр ашиглаж болно гэдгийг хүлээн зөвшөөрнө;
- c. олон нийтэд үйлчилдэг хувийн хэвшлийн байгууллага, бизнесүүдэд хандаж үйлчилгээгээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст илүү хүртээмжтэй болгохын уриалан дэмжинэ;
- d. хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд хандаж мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст илүү хүртээмжтэй байдлаар тарааж байхыг уриалах;
- e. дохионы хэл ашиглахыг хүлээн зөвшөөрөх, хөхиүлэн дэмжинэ.

## **22 дугаар зүйл: Хувийн нууцыг хүндэтгэх**

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хаана амьдарч байгаас үл хамааран хэн ч тэдний хувийн амьдралд хөндлөнгөөс оролцох, орон гэрт нь нэвтрэх, захидал харилцааг нь нээж үзэх, гэр бүлийхэнд нь төвөг болох, нэр хүндэд нь халдах зэрэг хууль бус үйлдэл хийж болохгүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ийм төрлийн халдлагаас хуулиар хамгаалагдсан байх эрхтэй.
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүн, тэдний эрүүл мэнд, нөхөн сэргээлтийн тухай мэдээлэл нь хувийн нууцад хамаарах ба хуулиар хамгаалагдсан байна.

## **23 дугаар зүйл: Орон байр, гэр бүлийг хүндэтгэх**

1. Улс орнууд нь гэрлэлт, гэр бүлийн харилцааны асуудлуудаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхдаг явдлыг таслан зогсоож, дараах зүйлсэд анхаарна:
  - a. хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэрлэх, гэр бүлтэй болох тал дээр бусдын адил эрхтэй байна;
  - b. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдын адил үр хүүхэдтэй болох, хэзээ хэдэн хүүхэдтэй болохоо өөрсдөө шийдэх эрхтэй. Тэд нөхөн үржихүй, гэр бүл төлөвлөлтийн талаар мэдээлэл авах, энэ мэдээллийг ойлгоход туслалцаа дэмждэг авах эрхтэй;
  - c. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдын адил нөхөн үржихүйн чадавхиа хадгалах эрхтэй.
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь хүүхэд асрах, үрчилж авахтай холбоотой бүх үүрэг, хариуцлагыг хүлээх ба бүх асуудлыг хүүхдийн сайн сайхан байдалд хамгийн нийцтэй талаас нь харж шийднэ. Улс орнууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүүхдээ өсгөхөд нь шаардлагатай бүх дэмжлэгийг үзүүлнэ.
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нь гэр бүлийнхээ бусад гишүүдтэй ижил тэгш эрхтэй. Улс орнууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хүчирхийлэлд өртөхөөс сэргийлэхийн тулд тэдэн болон тэдний гэр бүлийнхэнд мэдээлэл, үйлчилгээ, дэмжлэг туслалцааг үзүүлнэ.
4. Хүүхдийн өөрийнх нь сайн сайхны төлөө, зохих хуулийн дагуу хийж байгаа л биш бол хүүхдийг өөрөө хүсээгүй байхад нь эцэг эхээс нь салгаж болохгүй. Хүүхэд өөрөө юмуу эцэг эх нь хөгжлийн бэрхшээлтэй гэсэн шалтгаанаар хүүхдийг эцэг эхээс нь салгаж болохгүй.
5. Хэрвээ ойрын хамаатнууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асран халамжлах боломжгүй бол улс орнууд нь хүүхдийг халамжлах хүнийг түүний бусад хамаатнууд дундаас юмуу орон нутгийн иргэдийн дундаас хайна.

## 24 дүгээр зүйл: Боловсрол

1. Хөгжлийн бэрхшээлтэй бүх хүн боловсрол эзэмших эрхтэй. Улс орнууд нь боловсролын тогтолцоогоо бүхэлд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нээлттэй болгоход анхаарах бөгөөд боловсролын тогтолцоо нь дараах зорилтуудыг хангахаар ажиллана:
  - a. хүн бүрийн хувийн авьяас чадавхи, нэр төрийн мэдрэмж, өөрийгөө үнэлэх сэтгэл болон хүний эрх, эрх чөлөө, ялгаатай байдлыг хүндэтгэх хандлагыг хөгжүүлэх;
  - b. хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн зан чанар, авьяасыг дээд хэмжээнд нь бүрэн дүүрэн хөгжүүлэх;
  - c. хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн амьдралд оролцох боломжтой болгох.
2. Эдгээр зорилтыг хангахын тулд улс орнууд нь:
  - a. Хөгжлийн бэрхшээлийн улмаас хүмүүсийг боловсролд хамруулахгүй үлдээхээс зайлсхийх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хөгжлийн бэрхшээлээс нь болж үнэ төлбөргүй заавал эзэмших бага боловсрол, мөн дунд боловсролд хамруулахгүй байхаас зайлсхийнэ;
  - b. Хөгжлийн бэрхшээлтэй бүх хүн өөрийг нь тэгш хамруулсан, хүртээмжтэй бөгөөд өөрийнх нь орон нутагт өөрт нь ойрхон боловсролын үйлчилгээг сонгох боломжтой байхад анхаарах;
  - c. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст боловсролын үйлчилгээг дээд зэргээр ашиглах боломж олгохын тулд боломжит тохируулгуудыг хийнэ;
  - d. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст боловсролын үйлчилгээг дээд зэргээр ашиглах боломжийг хангахын тулд шаардлагатай тусламж, дэмжлэг үзүүлэх;
  - e. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын онцлог хэрэгцээг хангахад анхаарна.
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст сургуульд сурах, бусад хүмүүсийн дунд байхад шаардлагатай нийгмийн болон амьдрах ухааны ур чадваруудын эзэмшүүлэхэд улс орнууд анхаарна. Энэ зорилтыг хангахын тулд улс орнууд нь:
  - a. суралцагсдад харилцааны (тухайлбал, Брайль цагаан толгой) болон хөдөлгөөний ур чадвар зааж сургах, үе тэнгийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээс туслалцаа, дэмжлэг авч байх боломжийг хангана;
  - b. Дохионы хэлнүүд заана;
  - c. Ялангуяа хараагүй, дүлий, эсвэл хараагүй болон дүлий хавсарсан бэрхшээлтэй хүүхдүүдэд боловсролын үйлчилгээг дээд зэргээр ашиглах боломж олгохын тулд харилцааны тохиромжтой арга хэлбэрүүдийг зааж сургана.
4. Эдгээр эрхийг баталгаатай хангах, хэрэгжүүлэхийн тулд улс орнууд нь хөгжлийн бэрхшээлтэй багш нар, Брайль цагаан толгой болон дохионы хэл заар чадвартай багш нарын ажил авах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст чанартай сайн боловсролын үйлчилгээ хүргэх асуудлаар боловсролын бүхий л түвшинд ажиллаж байгаа багш, захиргааны ажилтнуудыг сургах зэрэг арга хэмжээ авна.
5. Техник мэргэжлийн, дээд болон насан туршийн тасралтгүй боловсрол нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бусдын адил тэгш хүртээмжтэй байхад улс орнууд анхаарч, энэ зорилтыг хангахын тулд шаардлагатай бүх өөрчлөлтийг хийнэ.

## 25 дугаар зүйл: Эрүүл мэнд

Хөгжлийн бэрхшээлтэй бүх хүн бусдын адил чанартай сайн эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхтэй бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй гэдэг шалтгаанаар ялгаварлан гадуурхагдах ёсгүй.

Улс орнууд нь эрүүл мэндийн болон нөхөн сэргээх үйлчилгээг хүртээмжтэй байлгахад анхаарч ажиллах бөгөөд үүний дотор:

- a. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусад хүмүүстэй ижил төрөл зүйл, чанар, стандартын эмнэлгийн тусламж үйлчилгээг үнэгүй болон боломжийг үнээр авч байхад анхаарна;
- b. Хөгжлийн бэрхшээлээс үүдсэн онцлог хэрэгцээндээ нийцсэн болон хөгжлийн бэрхшээл даамжрахаас урьдчилан сэргийлэх үйлчилгээнүүд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүрч байхад анхаарна;
- c. Эрүүл мэндийн үйлчилгээг хүмүүсийн амьдарч байгаа орчинд нь үзүүлнэ;
- d. Сургалт явуулах, стандарт тогтоож мөрдүүлэх замаар эрүүл мэндийн ажилтнууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бусад хүмүүстэй ижил чанартай үйлчилгээ үзүүлж байхад анхаарна;
- e. Эрүүл мэндийн даатгал, амь насны даатгалын үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ялгаварлан гадуурхлыг таслан зогсооно;
- f. Хөгжлийн бэрхшээлийн улмаас хүмүүст эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, эсвэл хоол, ундаар хангах дээр ялгаварлан гадуурхах, үйлчлэхээс татгалзах явдал гаргахгүй байхад анхаарна.

## 26 дугаар зүйл: Сэргээлт ба нөхөн сэргээлт

1. Улс орнууд нь зорилтот арга хэмжээ авах замаар (жишээлбэл, үе тэнгийн сургагч бэлдэх хөтөлбөрийг хөхиүлэн дэмжих) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дээд зэргээр бие даасан байдал, хувь хүний чадваруудыг дэмжих, нийгмийн амьдралын бүхий л салбарт хамрагдан оролцох боломжийг хангаж өгнө. Эдгээр зорилтод хүрэхийн тулд улс орнууд нь амьдралын бүхий л салбарт шаардлагатай үйлчилгээ, үүний дотор сэргээх болон нөхөн сэргээх үйлчилгээг хүртээмжтэй болгохдоо дараах асуудалд анхаарах:
  - a. Эдгээр үйлчилгээ нь хөгжлийн бэрхшээлийн аль болох эрт үед эхлэхийн зэрэгцээ хувь хүний давуу тал, хэрэгцээнд нийцсэн байх;
  - b. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст орон нутгийнхаа амьдралд оролцоход нь дэмжлэг болж чадахуйц, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдарч буй аль болох ойрхон сайн дурын үндсэн дээр үзүүлдэг үйлчилгээ байх.  
(Сэргээлт гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй төрсөн юмуу бага насандаа хөгжлийн бэрхшээлтэй болсон хүмүүст шинэ ур чадвар, чадавхи, мэдлэг олж авахад нь туслах үйл явц юм. Нөхөн сэргээлт гэдэн нь алдагдсан чадавхи, чадварыг эргээж олж авахад нь туслах үйл явц юм).
2. Сэргээх болон нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлж байгаа хүмүүсийг сургахад улс орнууд анхаарч ажиллана.
3. Улс орнууд нь сэргээх болон нөхөн сэргээх үйлчилгээний хүрээнд төрөл бүрийн туслах болон дэмжих тоног төхөөрөмж, бусад төрлийн туслах хэрэгслийн ашиглахад дэмжлэг үзүүлнэ.

## **27 дугаар зүйл: Ажил, хөдөлмөр эрхлэлт**

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь ажил хөдөлмөр эрхлэх асуудлаар бусадтай адил тэгш эрхтэй. Тэд бүх хүнд нээлттэй бөгөөд хүртээмжтэй ажлын орчинд өөрийн сонгосон ажлыг эрхлэн, хөдөлмөрийн хөлсөөрөө амьдралаа залгуулах боломжтой байх ёстой. Улс орнууд нь дараах зорилтуудыг хангах үүднээс зохих хууль тогтоомж гаргах, бусад арга хэмжээ авах болно:
  - a. Ажлын орчинд, үүний дотор ажил эрх хайх, ажилд орох, ажлын байраа хадгалах, албан тушаал дэвших, эрүүл бөгөөд аюулгүй нөхцөлд ажиллах зэрэг асуудлаар хөгжлийн бэрхшээлийн улмаас ялгаварлан гадуурхах явдлыг таслах зогсооно;
  - b. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ижил төрлийн ажилд ижил хэмжээний цалин авах, тэгш боломжтой байх, эрүүл бөгөөд аюулгүй ажлын байраар хангагдах, өргөдөл гомдол гаргах зэрэг эрхийг хамгаална.
  - c. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бусдын нэгэн адил үйлдвэрчний эвлэл болон худалдааны эвсэл байгуулах, нэгдэж орох боломжийг хангана;
  - d. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ажил эрхлэлттэй холбоотой зөвлөгөө авах, ажлын ур чадвар хөгжүүлэх сургалтад хамрагдах боломжийг хангана;
  - e. Ажил эрхлэх болон албан тушаал ахих боломжийг хөхиүлэн дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ажил олох, ажлын байраа хадгалахад тусална;
  - f. Хувиараа хөдөлмөр эрхлэх, бизнес хийх, хоршоо байгуулах, бизнес эхлүүлэхэд төсөл хэрэгжүүлэх зэргийг хөхиүлэн дэмжинэ;
  - h. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажилд авахад нь ажил олгогчдод туслах, хөхиүлэн дэмжинэ;
  - i. Ажлын байр, хөдөлмөрийн орчинд боломжит тохируулгыг хийх замаар хөгжлийн бэрхшээлтэй хүн байхад тохиромжтой орчин болгон зассан байхад анхаарна;
  - j. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хөдөлмөрийн зах зээл дээр ажлын туршлага олж авах боломжийг хангана;
  - k. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажилдаа эргэн орох, ажлын байраа хадгалахад нь дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүдийг дэмжинэ.
2. Улс орнууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг боолчлогдохоос хамгаална. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдын адил хүчээр хөдөлмөр эрхлэхээс хамгаалагдсан байхад улс орнууд анхаарна.

## **28 дугаар зүйл: Амьжиргааны хүрэлцэхүйц түвшин, нийгмийн хамгаалал**

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдний гэр бүл нь хүрэлцэхүйц сайн амьжиргаатай байх эрхтэй. Үүнд хангалттай хоол хүнс, хувцас, орон байр болон амьдарч буй орчноо тасралтгүй сайжруулах боломж зэрэг багтана.
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс төрийн нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамрагдах эрхтэй бөгөөд ингэхдээ хөгжлийн бэрхшээлийн улмаас ялгаварлан гадуурхаж болохгүй. Улс орнууд нь энэ эрхийг хамгаалан, хэрэгжүүлэхдээ дараах асуудлыг анхаарна:
  - a. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хэрэгтэй үйлчилгээ, тоног төхөөрөмж, тусалцаа дэмжлэг хүрч чадаж байгаад анхаарах;



- b. Ядуурлыг бууруулах зорилготой санхүүгийн хөтөлбөр, туслалцаанууд нь хүмүүст, нэн ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охид, өндөр настнуудад хүртээмжтэй байхад анхаарах;
- c. Ядуу амьдралтай хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүл нь хөгжлийн бэрхшээлтэй холбоотой гарах аливаа зардал, төлбөрийг төлөх төрөөс санхүүгийн дэмжлэг авч байх;
- d. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс төрөөс хэрэгжүүлж байгаа орон сууцны хөтөлбөрт хамрагдаж байх;
- e. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өндөр насны тэтгэвэр авч байх.

### **29 дүгээр зүйл: Улс төр, нийгмийн амьдралд оролцох**

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусад хүмүүстэй адил улс төрийн эрхийг эдэлнэ. Улс орнууд нь:

- a. хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, жишээлбэл, сонгуульд оролцох, сонгогдох зэрэг эрхээр хангагдан улс төр, нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцох боломжтой байхад анхаарна. Энэ зорилтыг хангахын тулд улс орнууд нь:
  - I. санал өгөх үйл явцыг ойлгомжтой, хүртээмжтэй болгох;
  - II. хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс саналаа нууцаар өгөх боломжтойн дээр төрийн албан сонгогдох, энэ албан тушаалаа хаших боломжтой байхад анхаарах;
  - III. саналаа өгөхдөө хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрийн сонгосон хүнээр туслуулах боломжтой байхад анхаарна.
- b. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг төрийн болон нийгмийн үйл ажиллагаанд оролцоход нь тал бүрийн дэмжлэг үзүүлэх ба үүний дотор:
  - I. улс төрийн нам, иргэний нийгмийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага, эвсэл, холбоодын ажилд оролцох боломжтой байх;
  - II. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг олон улсын, үндэсний, бүс нутгийн юмуу орон нутгийн хэмжээнд төлөөлөн ажилладаг байгууллага байгуулах, нэгдэж орох боломжтой байх.

### **30 дугаар зүйл: Соёлын амьдрал, амралт чөлөөт цаг, спортын үйл ажиллагаанд оролцох**

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс соёлын амьдралд оролцох эрхтэй. Улс орнууд нь дараах зорилтуудыг хангахын төлөө ажиллах болно:
  - a. уран зохиол, урлагийн бүтээлүүдийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ашиглаж чадах хэлбэр, форматаар хүргэх;
  - b. телевизийн нэвтрүүлэг, кино, жүжиг, соёлын бусад үйл ажиллагааг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ойлгомжтой арга хэлбэрээр хүргэх. Жишээлбэл, телевизийн нэвтрүүлэгт гүйдэг текст ашиглах, дохионы хэл ашиглах гэх мэт;
  - c. өгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь номын сан, музей, театр, соёлын арга хэмжээ явагддаг бусад чухал газруудад очиж үзвэр, үйлчилгээнд хамрагдах боломжтой байх.



2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь өөрсдийн бүтээлч, урлагийн болон оюуны авьяас чадавхиа ашиглах, хөгжүүлэх боломжоор хангагдсан байхад улс орнууд анхаарна.
3. Бичгийн бүтээл болон бусад зохиол, зохион бүтээсэн зүйлсийг хууль бусаар хуулбарлах, дуурайлган хийхээс сэргийлсэн хуулиуд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхахгүй байхад анхаарна.
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдын адил өөрсдийн соёлын болон хэлний онцлогийг хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй бөгөөд үүнд, жишээлбэл, дохионы хэл, Дүлий Хүмүүсийн Соёл зэргийг нэрлэж болно.
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдын адил амралт чөлөөт цаг, спортын арга хэмжээнд оролцох эрхтэй. Улс орнууд нь дараах арга хэмжээнүүдийг авна:
  - a. хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бүх түвшний спортын үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлгүй хүмүүстэй хамтран оролцож байхыг сурталчлах, дэмжих;
  - b. хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст спортын арга хэмжээ зохион байгуулах, тэдгээрт оролцох боломжийг хангах, бусдын адил хэмжээний сургалт дасгалжуулалт, дэмжлэг авч чадаж байгаад анхаарах;
  - c. хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь бусадтай адил спортын болон чөлөөт цагийн арга хэмжээ зохион байгуулдаг газруудад хүрч очиж чадаж байгаад анхаарах;
  - d. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сургууль дээр нь зохион байгуулагдаж байгаа тоглоом, спортын арга хэмжээнд бусад хүүхдийн адил оролцож чадаж байгаад анхаарах;
  - e. чөлөөт цаг, спортын арга хэмжээ зохион байгуулах гэж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст шаардлагатай туслалцаа, дэмжлэг хүрч байхад анхаарах.

### **31 дүгээр зүйл: Статистик мэдээ ба мэдээлэл цуглуулах нь**

1. Энэ Гэрээг хэрэгжүүлэхийн тул улс орнууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар мэдээлэл цуглуулж, түүндээ дүн шинжилгээ хийнэ. Мэдээлэл цуглуулах, ашиглахдаа улс орнууд нь:
  - a. хүмүүсийн хувийн нууцыг хүндэтгэж хандана. Зөвхөн тухайн хүн өөрөө зөвшөөрсөн тохиолдолд мэдээллийг гаргуулж авна;
  - b. Хүний эрх болон судлаачийн ёс зүйн зарчмуудыг хүндэтгэн баримтална.
2. Цуглуулсан мэдээллээ чухал бүлгүүдэд багцлан хадгалах ба энэ мэдээллээс улмаар улс орнууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгарч байгаа саад тотгорын талаар илүү сайн ойлгож авах, энэ Гэрээг хэрхэн бодит ажил хэрэг болгох талаар илүү тодорхой төсөөлөлтэй болоход ашиглагдах болно.
3. Энэ мэдээллийг тараан түгээх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст энэ мэдээллийг уншиж, ойлгоход хялбар арга хэлбэрээр хүргэх зэрэг хариуцлагыг хүлээнэ.

### **32 дугаар зүйл: Засгийн газрын хариуцлага**

Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүр эрхээ бүрэн дүүрэн эдлэх боломжийг бүрдүүлэхийн тулд хувь хүн, засгийн газрууд хэрхэн хамтран ажиллах ёстойг эг Гэрээний зүйл заалтуудад тайлбарласан байна.

Үүний гол санааг тоймлон дүгнэвэл:

- Энэ Гэрээг хэрэгжүүлэхийн тулд улс орнууд хамтран ажиллах ёстой.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдгээрийн эрхийг хамгаалдаг байгууллагуудыг энэ ажилдаа татан оролцуулах хэрэгтэй.
- НҮБ нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрхийн комисс байгуулж, энэ Гэрээгээр хүлээсэн үүргээ улс орнууд хангаж байгаад хяналт тавьж ажиллана.
- Улс орнууд нь энэ Гэрээг хэрхэн хэрэгжүүлж байгаа тухай тайлан бичиж Комисст тогтмол ирүүлж байна. Комисс нь НҮБ-ын Ерөнхий Ассамблей болон бусад зөвлөл, хороодод тогтмол тайлангаа тавьж, энэ Гэрээг хэрхэн сайжруулах талаарх тэдний саналыг сонгож байх юм.
- Энэ Гэрээнд гарын үсэг зурсан улс орнууд нь Гэрээг бодитоор хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. Гэхдээ улс орнууд нь санал нийлэхгүй байгаа тодорхой хэсгүүдээ хүлээж авахгүй байж болно.
- Энэ Гэрээг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс уншиж, ойлгох хэлбэр, арга замаар тараах ёстой.

Тайлбар: НҮБ-ын Ерөнхий Ассамблей уг Гэрээг 2006 оны 12 дугаар сард баталлаа.

Одоо улс орнууд энэ Гэрээг хэрэгжүүлэх тухай амлалт авч эхлээд байна. Хангалттай тооны улс орнууд энэ Гэрээнд нэгдэхлээх уг Гэрээ нь олон улмын хууль болох юм.

People with disabilities have the same rights as all people. Countries will take action to ensure these rights.

A Summary of the United Nations

# CONVENTION ON THE RIGHTS OF PERSONS WITH DISABILITIES:

All people with disabilities are equal before the law. Not just men, but women and girls — and children with disabilities, too.

If you need changes made to your surroundings in order to enjoy these rights, those changes will be made.



## RESPECT

FOR THE  
INDIVIDUAL



## INCLUSION

IN THE  
COMMUNITY



## CHANGE

IN THE  
SOCIETY

### What Is the Convention on Rights of Persons with Disabilities?

It is an agreement between countries of the world. The goal is to make sure that people with disabilities have the same rights and freedoms as all people.

### If Countries Sign the Convention, What Will They Do?

When countries sign this agreement, they are promising to take action to end discrimination based on disability! They will:

- change laws and make new ones
- protect people's rights
- include people with disabilities in planning these actions
- make progress reports to the United Nations
- educate the public

### When Will This Agreement Become Law?

The United Nations General Assembly adopted this agreement in 2007. That was only the first step. Now, countries must promise to put it into practice. When enough countries have made this promise, the agreement will become international law.

### About this Summary

The United Nations said that this agreement should be made available in ways that people with disabilities can read and understand. This summary covers most of the main points in four pages. The original Convention is very long and can be hard to read.

This document produced by:

**ACT**  
Advocacy Training Program  
[www.actadvocacy.org](http://www.actadvocacy.org)  
1411 University Avenue, Suite 206  
Berkeley, CA 94702

• Dignity • Ability to choose • Independence • Non-discrimination • Participation • Full inclusion • Respect for difference •  
• Acceptance of disability as part of everyday life • Equality of opportunity • Accessibility • Equality of men and women • Respect for children •

People with disabilities have the same rights as all people. Countries will take action to ensure these rights.

# RESPECT FOR THE INDIVIDUAL

People with disabilities have these rights:

## Life

THE RIGHT to life.

## Equal Before Law

THE RIGHT to be recognized as a capable person before the law. You can own property and control your own money. THE RIGHT to get support when you have legal or money issues.

## Freedom

THE RIGHT to liberty and security, just like all other people. No one can keep you away from your will.

## Safety

THE RIGHT to be safe from being harmed by others. You cannot be treated in a cruel way. You cannot be forced to take part in medical experiments. Your government will punish abusers, educate the public and pass laws to keep you safe from abuse.

## Citizenship

THE RIGHT to a name and a country. THE RIGHT to know who your parents are and to be raised by them. THE RIGHT to move around freely within your country.

## Privacy

THE RIGHT to privacy, no matter where you live. Information about you is also private.

## Family

THE RIGHT to marry and have a family. You can keep your fertility, have children and raise them with support if you need it.



Your Government Will Take Action to Make Sure You Have These Rights

People with disabilities have the same rights as all people. Countries will take action to ensure these rights.

# INCLUSION IN THE COMMUNITY

People with disabilities have these rights:

## Getting Around

THE RIGHT to get help to move around in the way you choose and at a cost that you can afford. Things like wheel chairs or crutches should not cost a lot.

## Speaking Out

THE RIGHT to say what you think, in the way you communicate best.  
THE RIGHT to public information presented in a way you can understand.

## Education

THE RIGHT to the same education as others. THE FIGHT to get the help you need to get the most out of your education. Schools should build your self-worth and your talents.

## Health Care

THE RIGHT to good—and affordable—health care. Your government will make sure that health workers know how to give quality care to meet your needs.

## Life Skills

THE RIGHT to training that gives you skills for independence and inclusion in all parts of life. Your government will train people who can teach you these skills and also help you get and use things to help you live your life.

## A Good Job

THE RIGHT to work. THE FIGHT to earn a decent living from work you choose. THE RIGHT to work in a setting that is accessible to you.

## Standard of Living

THE RIGHT to enough food, clothing and housing. THE RIGHT to the help you need to to pay bills, pay rent and get out of poverty.



People with disabilities have the same rights as all people. Countries will take action to ensure these rights.

# CHANGE IN THE SOCIETY

Countries will take action to ensure your rights:

## Attitudes

YOUR GOVERNMENT WILL WORK to teach all people about the issues facing people with disabilities, about harmful attitudes, and about what people with disabilities can do. This is your right.

## Barriers

YOUR GOVERNMENT WILL WORK to get rid of barriers that people with disabilities face—to help you use public buildings, private businesses, and services. This is your right.

## Emergency Situations

YOUR GOVERNMENT WILL WORK to make sure that you have equal protection in the case of war, floods, earthquakes, or other emergencies. This is your right.

## Legal System

YOUR GOVERNMENT WILL WORK so that you can use the justice system in your country just like all other people. This is your right.

## Voting and Politics

YOUR GOVERNMENT WILL WORK to make sure voting is easy to understand and accessible. You have the same right to vote and be elected as anyone else. You can get help in voting from someone of your choice. This is your right.

## Culture and Sports

YOUR GOVERNMENT WILL WORK to make sure that you can take part equally in culture, sports, and recreation events. Your culture and language should be recognized. Your talents should be developed. You can take part in sports with people who don't have disabilities, and sports where only people with disabilities play. This is your right.



Your Government Will Take Action to Make Sure You Have These Rights

## ХҮНИЙ ЭРХИЙН ХУУЛИУДЫН ЖАГСААЛТ

Доор бид “Хүний эрхийн төлөө!” гарын авлагад ашигласан хүний эрхийн гол баримт бичгүүдийн интернет хаягийн жагсаалтыг өгөв.

- Хүний болон улс түмний эрхийн тухай Африк тивийн дүрэм  
<http://www1.umn.edu/humanrts/instree/z1afchar.htm>
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрийн хэрцгий, хүнлэг бусаар, хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийн эсрэг конвенци (ЭШЭК)  
[http://www.unhchr.ch/html/menu3/b/h\\_cat39.htm](http://www.unhchr.ch/html/menu3/b/h_cat39.htm)
- Тусгаар тогтносон улс орнууд дах уугуул болон омгоор амьдардаг иргэдийн эрхийн тухай конвенци (ОУХБ №16)  
<http://www.ohchr.org/english/law/indigenous/htm>
- Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенци (ЭАБХУК)  
<http://www.ohchr.org/english/law/cedaw.htm>
- Арьсны өнгөөр алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенци (АӨАБХУК)  
<http://www.unhchr.ch/html/menu3/b/9.htm>
- Хүүхдийн эрхийн конвенци (ХЭК)  
<http://www.ohchr.org/english/law/crc.htm>
- Цагаач ажилчид болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай конвенци  
<http://www.ohchr.org/english/law/cmw.htm>
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци (ХБХЭК)  
<http://www.ohchr.org/english/law/disabilities-convention.htm>
- Уугуул иргэдийн эрхийн тунхаглал  
<http://www.ohchr.org/english/issues/indigenous/docs/draftdeclaration.pdf>
- Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах Европын конвенци  
<http://conventions.coe.int/Treaty/en/Treaties/Html/005.htm>
- ОУХБ-ын 159 дүгээр конвенци (Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлт болон хөдөлмөр эрхлэлт  
<http://www.ilo.org/ilolex/english/convdisp1.htm>
- Америк тивийн хүний эрхийн конвенци  
<http://www1.umn.edu/humanrts/oasinstr/zoas3con.htm>
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИУТЭОУП)  
<http://www.ohchr.org/english/law/ccpr.htm>
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (ЭЗНСЭОУП)  
[http://www.unhchr.ch/html/menu3/b/a\\_cescr.htm](http://www.unhchr.ch/html/menu3/b/a_cescr.htm)
- Хүний эрхийн түгээмэл тунхаглал (ХЭТТ)  
<http://www.unhchr.ch/udhr/>
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боломжийг тэгшитгэх тухай стандарт дүрмүүд (стандарт дүрмүүд)  
<http://www.un.org/esa/socdev/enable/dissre00.htm>



## ХАВСРАЛТ 2

### ХҮНИЙ ЭРХИЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ НЬ

“Хүний эрхийн төлөө!” гарын авлага нь оролцогчдыг өөрсдийг нь сурах үйл явцын “эзэн” болгож, бүхий л үйл ажиллагааны төвд тавьж ханддаг суралцагч төвтэй сургалтын арга зүйд суурилсан материал юм. Энд байгаа хүн бүр нэгэн зорилгын төлөө хамтдаа зүтгэж байгаа суралцагч учраас сурах үйл ажиллагааг багш бус харин сургагч/ идэвхжүүлэгч удирдаж явуулдаг. Суралцагсад нь баг, бүлгээрээ амьдралын туршлагадаа дүн шинжилгээ хийж байгаа ч хүн бүр өөр өөрийн дүгнэлтэд хүрэхийг зорьж байгаа. Хүмүүст юу гэж бодохыг нь зааж, тулгаж болохгүй тул аливаа дасгал ажлын зорилго нь ямар нэгэн “зөв хариулт”, эсвэл ямар нэгэн зүйл дээр санал нэгдэх бус харин аливаа санаа, асуудлыг хамтран судлахад оршиж байна.

Энэ арга зүй нь хүн бүр өөрийн гэсэн үзэл бодолтой байх эрхтэй гэдгийг хүлээн зөвшөөрч хүмүүсийн ялгаатай байдлыг хүндэтгэж үздэг учраас энэ нь хүний эрхийн боловсролд илүү нийцдэг арга зүй юм. Энэ арга зүй нь бодит амьдралын жинхэнэ явдлуудад дүн шинжилгээ хийхэд хөтөлж, улмаар өөрчлөлт авчрах үр дүнтэй, бодож төлөвлөсөн алхам хийхэд хүргэж чадах юм.

### ИДЭВХЖҮҮЛЭГЧИЙН ҮҮРЭГ

Идэвхжүүлэх ур чадвар төрөлхөөсөө бий болдоггүй. Идэвхжүүлэх урлагийг бүрэн эзэмшихэд байнгын дасгал хэрэгтэй бөгөөд үүний зэрэгцээ идэвхжүүлэгчийн үүргийг бүрэн ойлгосон байх шаардлагатай. Идэвхжүүлэгчийн үүрэг нь:

- **Оролцогчидтой эрх тэгш, түншийн харилцаа бий болгох.** Идэвхжүүлэгч нь “эрх тэгш хүмүүсийн дотроос хамгийн сайн” нь мөн боловч сурах үүрэг хариуцлагыг суралцагчид үүрнэ.
- **Нээлттэй, харилцан итгэлцлийн уур амьсгалыг бий болгох.** Олон янзын үзэл бодол, мөн харилцан адилгүй чадвартай хүмүүсийн харилцан бие биенээ хүндэтгэсэн орчинд хүн бүр өөрийн үзэл бодлыг хэнээс ч айхгүй, чөлөөтэй илэрхийлэх боломжтой байхад идэвхжүүлэгч тусална.
- **Хүн бүр өөрийгөө энэ багийн нэг гишүүн гэдгийг мэдрэх,** хүн бүрт оролцох боломж хангаж өгөх.
- **Суралцах үйл ажиллагааг бүтцэд оруулах.** Үүнд уулзах цагийг товлон мөрдүүлэх, сургалтын нээлт болон хаалтын хэсгүүдийг оруулах, сургалтын хөтөлбөрийг дагаж мөрдөх зэрэг багтана. Идэвхжүүлэгч энэхүү бүтэц нь хэр үр дүнтэй байгаа талаар оролцогчидтой тогтмол зөвлөлдөж байх үүрэгтэй.
- **Сургалтууд нь зохион байгуулалт сайтай байхад анхаарах.** Үүнд сургалтын хэрэглэгдэхүүнийг цуглуулж бэлдэх, уулзах өрөөгөө бэлдэх, оролцогчдод мэдэгдэх, шаардлагатай бэлтгэл ажлууд хийгдэж байгаад анхаарах зэрэг багтана. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст сурах нөхцлийг бүрдүүлж, хүн бүрт оролцох боломж олгохын тулд шаардлагатай нийцүүлгээр хангах хэрэгтэй.

Идэвхжүүлэгч нь:

- **багш** эсвэл “хариуцаж буй хүн” **биш**: Танхимд байгаа хүн бүр суралцах үүрэгтэй. Идэвхжүүлэгчийн үүрэг бол суралцах үйл ажиллагааг илүү үр дүнтэй явагдахад нь туслах явдал юм. Идэвхжүүлэгч бол асуудал бүрийг тэгш эрхтэй хамтрагчийн үүднээс судалж бусдын мэдлэг, туршлагад өөрийн хувийн мэдлэг, туршлагаа нэмэрлэж буй хамтран суралцагч юм.
- **шүүгч биш**: Идэвхтэй суралцах явцад хэн ч, тэр тусмаа идэвхжүүлэгч зарим үзэл бодол “зөв” эсвэл “бусдынхаас илүү” гэдгийг тогтоох эрхгүй.
- **заавал эксперт байх албагүй**: Хэдийгээр хичээл бүрт бэлтгэх боловч идэвхжүүлэгч тухайн асуудал, сэдвийн талаар оролцогчдоос илүү мэдлэгтэй биш байж болно.
- **анхаарлын төв биш**: Сайн идэвхжүүлэгч бусад оролцогчдоос ерөнхийдөө бага ярьдаг. Харин үүний оронд тэрээр бусдыг ярианд татан оролцуулдаг.
- **“гэрийн эзэн” биш**: Хэдийгээр идэвхжүүлэгч анхандаа хичээлийг зохицуулахад манлайлах үүрэгтэй байх боловч тэрээр бүх хариуцлагыг үүрэх цорын ганц хүн болох ёсгүй.

Аливаа ур чадварын нэгэн адилаар суралцах үйл явцыг идэвхжүүлэхэд суралцах хамгийн сайн арга зам бол байнга сургуулиж, өөртөө шүүмжлэлтэй хандаж, байнга өөрийгөө сайжруулах арга замыг хайх явдал юм.

## ХАРИЛЦАН ИДЭВХТЭЙ СУРГАХ ҮЙЛ ЯВЦ

Суралцах үйл явц нь сургалтын агуулгаас илүү чухал байдаг. “Хүний эрхийн төлөө!” гарын авлагын дасгалууд нь оролцогчдыг суралцах үйл ажиллагаанд идэвхтэй татан оруулах зорилготой бөгөөд насанд хүрэгчид өөр өөрийн сурах арга барилтай гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Хичээл бүрээр оролцогчдыг дараах байдлаар идэвхжүүлнэ:

- **бодит туршлага**: тэднийг шинэ туршлага, үйл явдалд бүрэн дүүрэн, ямар нэгэн ялгаварлалгүйгээр оролцуулах
- **эргэцүүлэх ажиглалт**: эдгээр туршлагуудаа олон талаас нь, олон өнцгөөс харж эргэцүүлэн, дүгнэлт хийх
- **хийсвэрлэн онолжуулах**: суралцагчдын ажиглалт, дүгнэлтийг цэгцтэй онол болгоход туслах зарчмуудыг бий болгох
- **идэвхтэй туршилт**: эдгээр онолуудаа шийдвэр гаргах, асуудал шийдвэрлэх, бодит алхам хийхдээ ашиглах

АНУ-ын Мейн мужийн Бетель хот дах Үндэсний сургалтын лаборатори нь сургалтын янз бүрийн аргуудыг хэрэглэхэд суралцагчдын ой тогтоолт хэрхэн нөлөөлж байгааг зэрэгцүүлэн хэмжих замаар идэвхтэй сургалтын аргын үр дүнг тоон үзүүлэлтээр гарган тайлбарлажээ.

Арга зүй	Тогтоолтын дундаж хэмжээ
Лекц	5%
Унших	10%
Харуулж сонсгох	20%
Биеэр хийж үзүүлэх	30%
Багаар хэлэлцэх	75%
Бусдад зааж сургах	80%

## ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЧИГЛҮҮЛЭХ

Хэлэлцүүлэг нь хүмүүсийг өөрсдийнх нь сурах үйл ажиллагаанд татан оролцуулах хамгийн чухал замуудын нэг юм. Тиймээс идэвхжүүлэгч бүр хэлэлцүүлгийг чадварлагаар чиглүүлж сурах шаардлагатай.

**1. Нээлттэй, эсвэл чиглүүлэх асуулт асуу.** “Хүний эрхийн төлөө!” гарын авлагад оруулсан хэлэлцүүлгийн асуултуудын нэлээд хэсэг нь энэ хоёр төрөлд багтана.

Нээлттэй асуулт нь хүний хувийн амьдрал, туршлагаас эхлээд (“Энэ нь намайг бага байхад тохиолдсон явдлыг санагдуулж байна ...”) объектив (“Зарим улсад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэр бүл болох эрхгүй байдаг гэж сонссон”) хүртэл олон төрлийн хариултууд гаргаж ирдэг. Нээлттэй асуултад “тийм” эсвэл “үгүй” гэсэн хариулт өгөх боломжгүй. Жишээлбэл дараах асуултуудыг нээлттэй асуулт гэж үзнэ.

- “Боломжит тохируулга” гэдгийг та хэрхэн тодорхойлох вэ?
- Манлайлагч мөн дагалдагч байж болох уу?

Чиглүүлэх асуултууд нь оролцогчдыг суралцах зорилгодоо хүрэхэд нь алхам алхмаар хөтөлдөг. Асуулт бүр өмнөх асуултын хариулт дээр суурилж дараагийн асуулт руу хөтөлнө. Грекийн философич Сократ хичээлдээ чиглүүлэх асуултуудыг ашигладаг байсан учраас энэ аргыг заримдаа “Сократын арга” хэмээн нэрлэдэг. Дараах чиглүүлэх асуултуудыг жишээ болгон өгье.

- Таны амьдралтай холбоотой чухал асуудлаар таны бодлыг сонсоогүй, тантай зөвлөлдөөгүй тохиолдлыг санаж байна уу?

- Хэрэв тантай зөвлөлдсөн бол байдал одоогийнхоос хэр өөр байх байсан бол?
- Таны үзэл бодлоо илэрхийлэх боломжийг хаах нь ямар үр дүнд хүргэх вэ?
- ХБХЭК хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг яагаад чухалчилж үзсэн гэж та бодож байна вэ?

Хэтэрхий олон субъектив асуулт асуухаас зайлсхий. Ийм асуултууд нь хэт хувийн шинжтэй хариултуудыг гаргаж ирдэг бөгөөд харилцан яриа, хэлэлцүүлэгт тэр бүр хүргэдэггүй (Жишээлбэл, “Таны хэлснийг би зөв тоймлон хэлсэн үү? Та нар завсарламаар байна уу?” гэх мэт). Түүнчлэн зөвхөн тоо баримт болон “тийм” эсвэл “үгүй” хэмээн хариулж болох хаалттай асуултаас зайлсхийх хэрэгтэй (“Цаг хэд болж байна вэ? Энэ дасгал ажил танд таалагдсан уу?” гэх мэт).

- 2. Хүн бүрийн хариулт, үзэл бодлыг хүндэтгэж ханд.** Идэвхжүүлэгчийн үүрэг бол хариултыг шүүх явдал биш бөгөөд идэвхжүүлэгчийн хувийн үзэл бодлоос үл хамааран оролцогчид бүгд өөрсдийн үзэл бодлыг сонсгон хүндэтгүүлэх эрхтэй. Гэсэн хэдий ч бусад оролцогчдыг үл хүндэтгэсэн хариулт, эсвэл хамтран суралцах ёс зүйд нийцэхгүй асуултуудыг анзаарч анхааруулга өгч байх нь зүйтэй.
- 3. Давтаж хэл.** Оролцогчдын хэлсэн зүйлсийг бусад хүмүүс сонссон, ойлгосныг баталгаажуулах үүрэг ихэнхдээ идэвхжүүлэгчид оногддог. Заримдаа идэвхжүүлэгч нь оролцогчдын хэлсэн зүйлийг дахин давтаж хэлэх шаардлагатай болдог ч давтан хэлсэн зүйл нь үнэн зөв гэдгийг тухайн оролцогчоос лавлан асуух ёстой (“Таны хэлсэн зүйлийг би зөв ойлгож уу?”).
- 4. Анхааралтай хандаж байгаагаа ойлгуул.** Үгээр хариулахаас гадна идэвхжүүлэгч анхаарал хандуулж байгаагаа дууны өнгө, дохио зангаа, хэлсэн саналыг бичиж тэмдэглэж авах, нүд рүү нь харах зэрэг олон арга замаар илэрхийлж, ойлгуулж болно.
- 5. Үзэл бодлоо тулгахаас зайлхий.** Идэвхжүүлэгчийн үүрэг бол өөрийн үзэл бодлоо бусдад тулгах бус харин үзэл бодлоо хуваалцахад хүмүүсийг уриалах явдал юм. Хамтран суралцагчийн хувьд идэвхжүүлэгч өөрийн үзэл бодлыг ярилцлагад нэмэрлэж болох ч үүнийгээ болгоомжтой, анхааралтай хийх нь чухал.
- 6. Харилцааны динамикийг хяна.** Идэвхжүүлэгч хэлэлцүүлгийн үеэр хэн нэгэн хүн давамгайлахгүй байхад анхаарлаа хандуулж хүн бүрт ярих, санал бодлоо хэлэх боломж олгох, хэлэлцүүлэг сэдвийн дагуу явагдаж байгаад хяналт тавина.

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ОРОЛЦОГЧДОД НИЙЦҮҮЛЭХ НЬ

### 1. Сургалтын өмнө

- Боломжтой бол сургалтын өмнө сургалтанд ямар хүмүүс оролцох, тэдэнд бүрэн дүүрэн оролцоход нь ямар нийцүүлэг шаардлагатайг олж тогтоо.
- Хүн бүрт оролцох боломж олгох үүднээс сургалтын материал, төлөвлөгөө, дасгал ажлуудаа өөрчилж хувирга (томоор хэвлэх, Брайль үсгээр хэвлэх, тараах материалыг энгийн үг хэллэгээр өөрчлөн найруулах гэх мэтээр).
- Харилцааны шаардлагатай арга хэрэгслүүдийг ашигла (дохионы хэлний орчуулагч гэх мэт).

- Уригдсан илтгэгч, бусад идэвхжүүлэгч нарт танилцуулгаа хүртээмжтэй болгох талаар товч зөвлөгөө өг.
- Сургалт явагдах газрын аюулгүй байдал болон нэвтрэх боломжийг анхаар:
  - сургалт болох газар хүргэх, авах унаа
  - сургалт болох барилгад нэвтрэх боломж
  - сургалтын өрөөнүүдэд бүгдэд нь нэвтрэх боломж
  - бие засах өрөө болон цайны газруудад нэвтрэх боломж.

## 2. Сургалтын үед

- Сургалтын эхэнд өөрийн анзаараагүй бусад саад, хүндрэл, бэрхшээл байгаа эсэхийг асуу.
- Сургалтын үеэр өөр бусад саад, хүндрэл шинээр гарч ирвэл мэдэгдэхийг оролцогчдоос хүс.
- Оролцогчид хоорондоо ялгаатай гэдгийг үргэлж сана.
- Өөрийн болон оролцогчдын хэлсэн чухал санааг тэмдэглэж, чангаар давтаж хэл.
- Хэзээ завсарлах, хэр удаан үргэлжлэхийг оролцогчдоор шийдүүл.
- Хөдөлгөөний хязгаарлалттай оролцогчдод багийн ажлуудад оролцоход нь хангалттай цаг гарган өгч цагаа төлөвлө.
- Бүтээлч бай. Чухал ойлголт, үйл явц, заавруудыг тайлбарлах нэгээс илүү арга замыг төлөвлө.

## 3. Сургалтыг дүгнэх болон сургалтын дараах үйл ажиллагаа

- Оролцогчдод хувийн хэрэгцээ, хөгжлийн бэрхшээл, нөлөөллийн үйл ажиллагааны зорилгодоо нийцсэн алхмуудыг эрж хайхыг сануул.
- Сургалтын үнэлгээний хуудаст оролцогчдоос бүрэн дүүрэн, тэгш оролцох боломжтой байсан эсэхийг асуусан асуулт оруул.
- Дараагийн сургалтыг илүү хүртээмжтэй болгох талаарх тэдний зөвлөгөө, саналыг ав.

## СУРГАЛТАА ТӨЛӨВЛӨХ

Хэдийгээр сургалт бүр зорилго, орчин, хугацаагаараа ялгаатай байдаг боловч аливаа идэвхтэй сургалтын үндсэн бүрэлдэхүүн ямар байдгийг дараах хэсгээс харж сургалтаа төлөвлөхдөө ашиглаж болно.

## НЭЭЛТ БА ТАНИЛЦУУЛГА

- Оролцогчид орж ирэхээс авахуулаад ажлаа төлөвлө (тэднийг хэрхэн мэндчилж, угтаж авах, мэдээлэл өгөх, орчинтойгоо танилцах гэх мэт). Хөгжлийн төрөл бүрийн бэрхшээлтэй хүмүүс ирэхэд тэдэнд нийцүүлэх бэлтгэлтэй бай.
- Оролцогчид бие биетэйгээ хэрхэн танилцах цаг төлөвлө. Хэд хэдэн хувилбар ашиглахаар бэлд (өөрсдийгөө танилцуулах гэх зэрэг аман хэлбэр, нэр бичсэн энгэрийн тэмдэг зэрэг бичгийн хэлбэр).

## **ЗОРИЛГО, ХҮЛЭЭЛТ**

- Сургалтын зорилго, зорилтыг амаар болон бичгээр танилцуул.
- Зарим зорилго ерөнхий бөгөөд үйл явцад суурилсан байдаг. Жишээлбэл, ойлголттой болох, мэдэж авах, таних гэх мэт. Ийм зорилт тавигдаж байгаа үед суралцах үйл ажиллагаа хэрхэн нөлөөлснийг үнэлэхэд хүндрэлтэй байдаг (сургалтын төгсгөлд оролцогчид хамтын удирдлагын талаар ойлголттой болно гэх мэт).
- Бусад зорилгууд нь оролцогчдод тодорхой ур чадваруудыг суулгаж өгөх, хөгжүүлэхэд чиглэсэн байдаг. Жишээлбэл, хийх, бичих, төлөвлөх, бий болгох, бүтээх, тодорхойлох, харьцуулах, цуглуулах, зурах, шийдвэрлэх, хэмжих гэх мэт.

## **ОРОЛЦОГЧДЫН ХҮЛЭЭЛТ**

- Сургалтын эхэнд оролцогчдод сургалтаас юу олж мэдэхийг хүсэж байгаа талаар хэлүүлэх цаг гаргаж өг.
- Зарим хүмүүсийн хүлээлтийг биелүүлэх боломжгүй гэдгийг хүлээн зөвшөөрөхөд бэлэн бай (хүмүүсийн чадавхи хүрэхгүй байх, байгууллагын хэрэгцээнд нийцэхгүй байх, санхүүжүүлэгчийн хязгаарлалт гэх мэт). Гэхдээ боломжтой үед, ялангуяа тодорхой хүлээлтийг нэлээд олон хүн илэрхийлж байгаа тохиолдолд сургалтын чиглэлийг өөрчлөн нийцүүлэхэд нээлттэй бай.

## **СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

- Хугацаа болон мэдээлэл, танилцуулга хийх хүмүүсийн нэрсийг багтаасан сургалтын хөтөлбөрийг бичиж ил газар байрлуул. Тэгснээр оролцогч бүр ямар үйл явдал болох талаар мэдээлэлтэй болно.
- Сургалтын хөтөлбөр нь тухайн багт хамаатай зүйл учир оролцогчидтой сургалтын хөтөлбөрийн талаар санал солилц. Энэ хөтөлбөр тэдний шаардлагад нийцэж байна уу (сэдвийн хувьд, завсарлага, амралт гэх мэт асуудлаар)?
- Хэдэн өдөр үргэлжлэх сургалтын үед өдөр бүрийн сургалтын агуулга, бүтцийн талаар санал солилц.
- Сургалтын хэсэг бүрийн эхэнд энэ хэсгийг чангаар уншиж өг

## **ТАНИЛЦУУЛГА БА СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

- Боломжтой бол мэдээлэл, танилцуулга хийх хэд хэдэн хүн болон идэвхжүүлэгчтэй бай.
- Оролцогчид суралцах өөр өөр арга барилтай гэдгийг бодолцон сургалтын янз бүрийн арга хэрэглэ.
- Оролцогчдын хэрэгцээ, сонирхол, чадварт тохируулан дасгал ажлуудаа хувирган өөрчил.
- Өдрийн хоолны дараа болон өглөө эрт хүмүүс нойрмоглодог гэдгийг анхаар.

## **ЭРГЭЦҮҮЛЭХ БОЛОН АСУУЛТ АСУУХ БОЛОМЖ**

- Сургалтын үеэр оролцогчдод юу сурч, юуг мэдэрч байгаагаа эргэцүүлэн бодох боломжийг олгох цаг төлөвлө. Энэ нь тэмдэглэл хөтлөх, хосоор болон жижиг багаар хэлэлцэх, эсвэл зүгээр л нам гүм бодох цаг гаргаж өгөх арга хэлбэрүүд байж болно.

- Сургалтын үеэр оролцогчид асуулт, эргэцүүлээ хүссэн үедээ илэрхийлж байх боломж олгох буюу саналаа нээлттэй хэлэх тусгай цаг гаргаж өг.

## **ДҮГНЭЛТ БА ҮНЭЛГЭЭ**

- Сургалтын төгсгөлд (олон хоногийн сургалтын үед өдөр бүр) оролцогчдод анх төлөвлөсөн зорилгоо танилцуулж тухайн зорилгод хүрэхдээ ашигласан танилцуулга, дасгал ажлуудыг сануул.
- Оролцогчдод тухайн зорилгод хүрсэн эсэх талаар болон өөрсдийнх нь хувийн үзэл бодлын үүднээс сургалтыг үнэлэх (нэрээ хэлэлгүй оролцох) аргыг хэрэглэхээр төлөвлө. Шаардлагатай хүмүүст үнэлгээг бичгээр бус өөр хувилбарт аргаар хийх боломж хангаж өг.
- Хийсэн сургалт болгоныхоо үнэлгээнүүдийг нэгтгэн хадгал. Үүнийг өөрийн идэвхжүүлэх чадвараа сайжруулахад ашиглаарай.

## **СУРГАЛТЫН ДАРАА**

- Оролцогчид хүсвэл бие биетэйгээ, тантай болон танай байгууллагатай хэрхэн харилцаатай байх арга замыг мэдээл.
- Сургалтаас хойш хэдэн долоо хоногийн дараа хийсэн үнэлгээ нь таны идэвхжүүлэлтийн талаар өөр, илүү үнэн зөв мэдээллийг өгнө.

## **СУРГАЛТЫН ЖИШЭЭ**

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенци батлагдсанаар олон байгууллага хүний эрхийн сургалт хийлгэх хүсэлтэй болох тул хүний эрхийн хуульчдыг сургалт зохион байгуулахаар урих явдал нэмэгдэх болно. “Хүний эрхийн төлөө!” гарын авлагын дасгал ажил, сургалтын материалуудыг ашиглан сургалт семинар хийх замаар хүний эрхийг хамгаалах, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах чиглэлээр ажиллаж байгаа маш олон байгууллагад туслах боломж байна. Ийм байгууллагын дотор:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд
- Хүний эрхийн ердийн байгууллагууд
- Парламентын хүний эрхийн хороо
- Үндэсний хүний эрхийн комисс
- Сонгуулийн хорооны ажилтнууд
- Бага, дунд сургуулийн багш нар
- Ажил олгогчдын холбоо
- Аялал жуулчлалын удирдах байгууллагууд
- Шашны байгууллагууд
- Хөгжлийн болон хүмүүнлэгийн байгууллагууд багтана.

Сургалт семинаруудын илүү тодорхой жишээнүүдийг “Хүний эрхийн төлөө!” веб сайтаас үзэж болно (<http://www.humanrightsyeyes.org>). Амжилттай хэрэгжсэн сургалт, семинаруудад тулгуурласан эдгээр жишээгээр сургалт зохион байгуулах зарим үндсэн загваруудыг өгсөн байгаа.



## 1. ХАГАС ӨДРИЙН БУЮУ 3.5 ЦАГИЙН СУРГАЛТЫН ЗАГВАР

### Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сурч боловсрох эрх

**Сэдэв:** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сурч боловсрох эрх  
**Төрөл:** Дунд сургуулийн багш нарт зориулсан мэргэжил дээшлүүлэх сургалт  
**Оролцогчид:** Дунд сургуулийн багш нар  
**Зорилго:** Тэгш хамруулан сургах зарчимд суурилсан боловсролын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх

#### Танилцуулга

10 минут

Оролцогч бүр өөр нэг хүнтэй хос болж өөрсдийн талаар, энэ сургалтанд тэднийг юу хөтөлж авчирсан болон энэ сургалтаас юу олж мэдэхийг хүсэн хүлээж байгаа талаараа ярилцана. Дараа нь хүн болгон хос болсон хүнээ танилцуулна.

#### Сургалтын хөтөлбөр болон зорилго

5 минут

Идэвхжүүлэгч нь сургалтын хөтөлбөр, зорилгыг танилцуулж, оролцогчдын хүлээлтийг хэрхэн хангаж чадах, эсвэл чадахгүй талаар товч тайлбар өгнө.

#### Дасгал ажил 13.2: Боловсролын талаарх ойлголт

45 минут

Энэ дасгал нь оролцогчдод боловсролын тогтолцоо болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн холбогдолтой өөрсдийн амьдралд тохиолдсон зүйлсээс хуваалцаж, эдгээр нь ямар байх ёстой талаар үнэлгээ өгөхөд чиглэгдэнэ.

#### Танилцуулга: ХБХЭК-ийг танилцуулах

15 минут

#### Дасгал ажил 13.1: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци сурч боловсрох ямар эрхийг баталгаажуулсан бэ?

30 минут

Энэ дасгалаар оролцогчдод ХБХЭК-ийн боловсролын тухай заалт, гол зарчмуудыг танилцуулна.

#### ЗАВСАРЛАГА

10 минут

#### Дасгал ажил 13.3: Боловсрол дах ялгаварлан гадуурхлын шалтгааныг тодорхойлох

30 минут

Энэ дасгал нь боловсролын тогтолцоон дах ялгаварлан гадуурхлыг судалж, түүний эсрэг ямар арга хэмжээ авах тухай бодуулах зорилготой.

#### Дасгал ажил 13.4: Боловсролын төлөө дуу хоолойгоо өргөх

30 минут

Энэ дасгал нь оролцогчдод боловсролын тогтолцоон дах ялгаварлан гадуурхлыг судалж, түүнтэй тэмцэх ямар арга хэмжээ авах талаар бодох боломж олгох зорилготой.

#### Сүүлийн дасгал ажил 13.5: Амлалт авах нь

30 минут

Энэ дасгал нь хүний эрх бол эрх, үүргийн аль алийг нь багтааж байгааг ойлгох боломж олгож, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сурч боловсрох эрхийг дэмжих зорилготой тодорхой алхам хийхэд хөтлөх зорилготой.

**Үнэлгээ**

**5 минут**

Үнэлгээний хуудсуудыг тарааж өгч бөглүүлээд, хурааж авна.

**2. БҮТЭН ӨДРИЙН БУЮУ 6 ЦАГИЙН СУРГАЛТЫН ЗАГВАР**  
**Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаарх ойлголт**

**Сэдэв:** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаар ойлголт өгөх

**Төрөл:** Хөгжлийн Бэрхшээлийн асуудлаарх Үндэсний Бага Хурал

**Оролцогчид:** Өмнө нь хүний эрхийн боловсролд бараг хамрагдаж байгаагүй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн төлөө тэмцэгчид

**Зорилго:**

- 1) Хүний эрхийн талаарх ойлголт, нөлөөллийн стратегиудын талаар ойлголттой болох
- 2) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалагчдад хүний эрхийн талаар суралцах орчинг бий болгож, тэдний явуулах хүний эрхийн нөлөөллийн ажлыг эрчимжүүлэх
- 3) Оролцогчид өөрсдийн орон нутагт хэрэгжүүлэх ур чадварт суралцах

**Танилцуулга**

**10 минут**

Оролцогч бүр өөр нэг оролцогчтой хос болж өөрсдийн талаар, энэ сургалтанд юу тэднийг хөтөлж авчирсан болон энэ сургалтаас юу олж авахыг хүсч байгаа талаараа ярилцана. Дараа нь хүн бүр ярилцсан хүнээ бусдадаа танилцуулна.

**Сургалтын хөтөлбөр болон зорилго**

**5 минут**

Идэвхжүүлэгч нь сургалтын хөтөлбөр болон зорилгыг танилцуулж эдгээр нь оролцогчдын хүлээлтийг хангаж чадах эсэх талаар саналаа хэлнэ.

**Дасгал ажил 1.1: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх нийгэмд байдаг хэвшмэл ойлголт, тогтсон хандлагуудын үзүүлэх нөлөө**

**45 минут**

Энэ дасгал нь оролцогчдод нийгэмд тогтсон ойлголтуудаас үүдэлтэй ялгаварлан гадуурхлын талаарх өөрсдийнх нь амьдралд тохиолдсон зүйлсийг хэлэлцэж, эдгээр нь хүний эрхэд ямар нөлөө үзүүлэх талаар боддог болгох зорилготой

**Танилцуулга: Хүний эрхийн хүрээ**

**15 минут**

Хүний эрхийн талаарх суурь ойлголтуудыг танилцуулна.

**Дасгал ажил 1.2: Эрхийн хоорондын харилцан хамаарал 30 минут**  
Энэ дасгал нь ХЭТТ-д заасан хүний суурь эрхийг судалж, эдгээр эрх нь хоорондоо ямар холбоотой байдаг тухай ойлголтыг нэмэгдүүлэх зорилготой.

**ЗАВСАРЛАГА 10 минут**

**Танилцуулга: ХБХЭК-тай танилцуулах 15 минут**  
ХБХЭК болон хөгжлийн бэрхшээлд хандах хүний эрхэд суурилсан хандлагыг танилцуулна.

**Дасгал ажил 1.3: Эрхийн мод 30 минут**  
Энэ дасгал нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ямар эрх эдлэх ёстойг харуулах, тодорхойлох зорилготой.

**Дасгал ажил 1.5: Үг хэллэг ба эрх 45 минут**  
Нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гүйцэтгэх үүргийн талаарх эерэг болон сөрөг хандлагуудыг бэхжүүлэхэд бидний ашиглаж байгаа үг, хэллэг ямар үүрэг гүйцэтгэдэг талаарх ойлголт өгөхөд туслах дасгал юм.

**ӨДРИЙН ХООЛ 1 цаг**

**Сэргээх дасгал 5 минут**  
“Нэр дуудах” гэх мэт богино хугацааны, сэргээх дасгалуудаар оролцогчдыг сэргээнэ. “Нэр дуудах” дасгалд оролцогчид тойргоор зогсож тэдний ажлыг дэмждэг, тэдэнд урам өгдөг, тэднийг чиглүүлдэг хүмүүсийн тухай бодно. Хүн бүр тэдгээр хүмүүсийнхээ нэрийг нэг нэгээрээ дуудан хэлнэ. (Эх сурвалж: Нэнси Флаурс, Хүний эрхийн боловсролын гарын авлага, 2000: <http://www1.umn.edu/humanrts/edumat/hreduseries/hrhandbook/activities/6.htm>)

**Дасгал ажил 13.1: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци сурч боловсрох ямар эрхийг хангаж өгсөн бэ? 30 минут**  
Энэ дасгал нь оролцогчдод ХБХЭК-ийн сурч боловсрох эрхтэй холбоотой заалт, гол зарчмуудыг танилцуулна.

**ЗАВСАРЛАГА 10 минут**

**Дасгал ажил 13.4: Боловсролын төлөө дуу хоолойгоо өргөх 30 минут**  
Энэ дасгал нь оролцогчдод боловсролын тогтолцоон дах ялгаварлан гадуурхлыг судалж, тэдгээртэй тэмцэх арга хэмжээний талаар бодох боломжийг олгох зорилготой.

**Сүүлийн дасгал ажил 13.5: Чин эрмэлзэлтэй байх 30 минут**  
Энэ дасгал ажил нь хүний эрхийн асуудалд эрх болон үүргийн аль аль нь багтаж байгааг ойлгох боломж олгон, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сурч боловсрох эрхийг хөхиүлэн дэмжих тодорхой алхам хийхэд уриалах зорилготой.

**Үнэлгээ 5 минут**

**Үнэлгээний хуудсуудыг тарааж өгч үнэлүүлээд, хурааж авна.**

## ХАВСРАЛТ 3

### НЭМЭЛТ ЭХ СУРВАЛЖ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

#### Интернет дэх олон улсын хүний эрхийн эрхзүйн номын сан

Хүний эрхийн дээд комиссарын газар (олон улсын хүний эрхийн хуулиуд):

<http://www.unhchr.ch/html/intlinst.htm>

Миннесота мужийн Хүний эрхийн номын сан

<http://www1.umn.edu/humanrts>

#### Хүний эрх, хөгжлийн бэрхшээлийн асуудлаарх нийтлэг эх сурвалж

Өөрчлөлтийн төлөө хамтдаа (Advocating Change Together) (Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалагчид, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй идэвхтэн ухуулагчдад зориулсан мэдээлэл):

<http://www.selfadvocacy.org>

Тересия Деженер, Иолан Костер-Дриис (хянан тохиолдуулагч). *Хүний эрх ба хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс: Эссе ба холбоо хамааралтай хүний эрхийн баримт бичгүүд.* (Мартинус Нийхоф хэвлэлийн газар, 1995)

Teresia Degener, Yolana Koster-Dreesse, eds., *Human Rights and Disabled Persons: Essays and Relevant Human Rights Instruments* (Martinus Nijhoff Publishers 1995).

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олон улсын байгууллага. *Соёрхон батлах үйл явцыг дэмжих хэрэглэгдэхүүн.* (Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг соёрхон батлуулахад чиглэсэн нөлөөллийн ажил).

Disabled Peoples' International, *Ratification Toolkit* (On ratification advocacy for the Convention on the Rights of Persons with Disabilities):

<http://www.icrpd.net/ratification/en/index.htm>

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олон улсын байгууллага. *Хэрэгжүүлэх үйл явцыг дэмжих хэрэглэгдэхүүн.* (Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг хэрэгжүүлэхэд чиглэсэн нөлөөллийн ажил).

Disabled Peoples' International, *Implementation Toolkit* (On implementation advocacy for the Convention on the Rights of Persons with Disabilities):

<http://www.icrpd.net/implementation/en/index.htm>

Харвардын Их сургуулийн Хуулийн сургуулийн Хөгжлийн бэрхшээлийг судлах төсөл (төслийн хүрээнд бүрдүүлсэн төрөл бүрийн хууль, бодлого, нөлөөллийн хэрэглэгдэхүүнүүд): энэ гарын авлагыг хэвлэх үед вебсайт хийгдэж байсан болно

Harvard Project on Disability, Harvard Law School (Information on the range of law, policy and advocacy initiatives of the Project): (website pending at time of publication)

Хөгжлийн бэрхшээлийн асуудлаарх үндэсний зөвлөл. *Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай олон улсын конвенцийн үүрэг роль: Бодлого боловсруулагчид болон АНУ-*

ын хүний эрх болон хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн идэвхтнүүдэд зориулсан эрхзүй, нийгэм, практик түвшний үр дагавруудын дүн шинжилгээ (2002 оны 5 дугаар сар):

National Council on Disability, *Understanding the Role of an International Convention on the Human Rights of People with Disabilities: An analysis of the legal, social, and practical implications for policy makers and disability and human rights advocates in the United States* (May 2002):

[http://www.ncd.gov/newsroom/publications/unwhitepaper\\_05-23-02.html](http://www.ncd.gov/newsroom/publications/unwhitepaper_05-23-02.html)

Жерар Квинн, Тересия Деженер нар. Хүний эрхийг хүн бүрт: НҮБ-ын хүний эрхийн эрхзүйн баримт бичгүүдийн хөгжлийн бэрхшээлтэй холбон ашиглаж байгаа өнөөгийн байдал, цаашдын төлөвийн судалгаа ((Хүний эрхийн дээд комиссарын газар, 2002 оны 2 дугаар сар):

Gerard Quinn and Theresia Degener, et. al., *Human Rights Are for All: A Study on the Current Use and Future Potential of the UN Human Rights Instruments in the Context of Disability* (OHCHR, February 2002):

<http://www.ohchr.org/english/issues/disability/study.htm>

НҮБ-ын Эдийн засаг, соёлын газар (хөгжлийн бэрхшээл, түүнтэй холбоотой асуудлаарх НҮБ-ын хөтөлбөрүүдийн тухай мэдээллийн вебсайт)

United Nations Department of Economic and Social Affairs (Website offering info on the UN program on Disability and disability specific resources):

<http://www.un.org/disabilities>

World Enable (Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци гэх мэт хөгжлийн бэрхшээлтэй холбоотой олон сэдвээр мэдээлэл өгөх интернетийн хүртээмжтэй технологийг ашигласан веб хуудас):

World Enable (Internet accessibility initiative providing information on a range of topics, including the Convention on the Rights of Persons with Disabilities):

<http://www.worldenable.net>

## ХАВСРАЛТ 4

### ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ БА ХҮНИЙ ЭРХИЙН НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР ТОЛЬ

*Тэмдэглэл: Энэ тайлбарт орсон нэр томъёог “Хүний эрхийн төлөө!” гарын авлагын агуулгад тод үсгээр тэмдэглэсэн болно.*

**Adoption – Батлах:** Олон улсын гэрээний бичвэр (эх бичвэр)-ийг хүлээн зөвшөөрөхөд чиглэсэн эхний дипломат алхмуудыг голдуу хэлнэ (жишээлбэл, НҮБ-аас гаргаж байгаа олон улсын гэрээний хувьд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаар батлуулах алхам). Баталсны дараа засгийн газрууд олон улсын гэрээнд гарын үсэг зурж соёрхон батална.

**Affirmative action - Илт дэмжсэн арга хэмжээ,** (мөн “шударга ялгаварлал”, “ээрэг ялгаварлал”, “урвуу ялгаварлал” гэж хэлдэг): Боловсрол, хөдөлмөр эрхлэлтэнд өмнө нь байсан ялгаварлан гадуурхлын үр дагаврыг арилгах, эсвэл жендер, арьсны өнгө, яс үндэс, шашин шүтлэг, хөгжлийн бэрхшээлийн улмаас ялгаварлан гадуурхагдахгүй байхыг хөхиүлэн дэмжих зорилгоор засгийн газар, эсхүл хувийн байгууллагаас авч хэрэгжүүлж буй эерэг үйлдлүүдийг хэлнэ.

**African Charter on Human and People’s Rights – Хүний болон улс түмний эрхийн тухай Африк тивийн дүрэм:** Африк тивийн эв нэгдлийн байгууллагаас 1981 онд баталсан Африк тивийн хэмжээнд үйлчлэх хүний эрхийн бүс нутгийн гэрээ.

**American Convention on Human Rights – Америк тивийн хүний эрхийн конвенци** (Америкийн конвенци, Коста Рика улсын Сан Хосегийн Пакт): Америк тивийн байгууллагаас (АОБ) 1969 онд баталсан бүс нутгийн хэмжээнд үйлчлэх хүний эрхийн гэрээ. Хойд, Төв болон Өмнөд Америкийг хамарна.

**Americans with Disabilities Act (ADA) – Хөгжлийн бэрхшээлтэй америкчуудын тухай хууль:** 1990 онд батлагдсан АНУ-ын холбооны энэхүү хууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэмд бүрэн хамруулах, оролцуулах зорилгоор тэдний иргэний эрхийг цогцоор нь хамгаалахыг заасан. Тухайн үедээ хөгжлийн бэрхшээлийн асуудлын хамгийн алс хэтийн төлөв байдлаар нь харж чадсан талаарх энэхүү хууль өөр олон улсад ижил төстэй хууль боловсруулахад загвар болсон.

**Article – Зүйл:** Олон улсын гэрээ, эсвэл тунхаглал зэрэг эрхзүйн баримт бичгийн дугаар бүхий хэсэг. Жишээ нь, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн 7 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлыг хөнджээ.

**Basic Principles for the Treatment of Prisoners – Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм:** НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаар 1990 онд баталсан энэ баримт бичигт хоригдлуудтай харьцах, мөн хорих газруудын менежментийн эерэг (зохистой) практик дадлын стандартыг тогтоож өгсөн. Хоригдлуудын хүний эрхийг хангах хэрэгцээ нь энэ баримт бичгийн үндэс суурь болно.

**Body of Principles for the Protection of All Persons under Any Form of Detention or Imprisonment - Аливаа хэлбэрээр саатуулагдсан бүх хүнийг хамгаалах зарчмууд:** НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаар 1920 онд баталсан энэ баримт бичигт аливаа хэлбэрээр саатуулагдсан бүх хүнд хандах наад захын жишиг дүрмүүдийг тогтоож өгсөн.

**Committee on Economic, Social and Cultural Rights – Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо: Эдийн засаг нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактыг (ЭЗНСЭОУП) Оролцогч улсууд** хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт, үнэлгээ хийдэг хараат бус экспертийн байгууллага

**Convention – конвенци:** Заавал дагаж мөрдөх шинжтэй, улс хоорондын олон талт гэрээ бөгөөд конвенци нь тунхаглалаас илүү хүчтэй. НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаар баталсан конвенци нь олон улсын хэм хэмжээ, стандарт болдог. НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаар баталсан конвенцийг **гишүүн орнууд гарын үсэг зурж соёрхон батлах** ба үүгээрээ тэд конвенцийг мөрдөх үүрэг амлалт хүлээж байгаа хэрэг болно. Конвенцийн тогтоосон хэм хэмжээ, стандартыг зөрчсөн засгийн газруудыг НҮБ хянан арга хэмжээ авдаг.

**Convention on the Elimination of All Forms of Discrimination against Women – Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенци** (1979 онд батлагдаж, 1981 онд хүчин төгөлдөр болсон): эмэгтэйчүүдийн ялгаварлан гадуурхлыг хориглож, эмэгтэйчүүдийн тэгш байдлыг ханган баталгаажуулах үүднээс **зэрэг арга хэмжээ** авах үүргийг засгийн газруудад хүлээлгэсэн хамгийн анхны заавал мөрдөх ёстой олон улсын баримт бичиг.

**Convention on the Rights of Persons with Disabilities (CPRD) – Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци** (2006 онд баталж, 2007 оноос соёрхон батлах гарын үсэг зурахад нээлттэй болсон): олон улсын хүний эрхийн эрхзүйд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, хөгжлийн бэрхшээлтэй холбоотой эрхийг тодорхойлсон хамгийн анхны олон улсын гэрээ.

**Convention on the Rights of the Child (CRC, Children’s Convention) – Хүүхдийн эрхийн конвенци** (1989 онд баталж, 1990 онд хүчин төгөлдөр болсон): Хүүхдийн иргэний, соёлын, эдийн засгийн, нийгмийн болон улс төрийн эрхийг бүхэлд нь тодорхойлон тогтоосон **олон улсын гэрээ**.

**Covenant – Пакт:** засгийн газруудын хооронд байгуулсан заавал дагаж мөрдөх гэрээ, конвенци, олон улсын гэрээ зэрэг нэр томъёотой ижил утгаар хэрэглэнэ. 1966 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан олон улсын хүний эрхийн хамгийн чухал хоёр гэрээ бол **Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИУТЭОУП), Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (ЭЗНСЭОУП)** юм.

**Declaration – Тунхаглал:** санал нийлэн зөвшөөрсөн стандартуудыг жагсаасан, гэхдээ эрхзүйн хувьд заавал мөрдөх албагүй баримт бичиг. НҮБ-ын бага хурлууд (жишээлбэл, 1993 онд Женев хотод болсон Хүний эрхийн асуудлаарх НҮБ-ын бага хурал, 1995 онд Бээжин хотод болсон Эмэгтэйчүүдийн дэлхийн бага хурал) голдуу хоёр төрлийн тунхаглал гаргадаг нь засгийн газрын төлөөлөгчдийн боловсруулсан албан ёсны баримт бичиг, мөн төрийн бус байгууллагуудын боловсруулсан албан бус баримт бичиг зэрэг багтана. НҮБ-ын



Ерөнхий Ассамблей мөн чухал нөлөөтэй боловч **эрхзүйн хувьд заавал мөрдөх албагүй** тунхаглал гаргах нь олонтаа.

**Declaration on the Rights of Persons Belonging to National or Ethnic, Religious and Linguistic Minorities – Үндэстэн, ястны, шашны болон хэлний цөөнхөд хамаарах хүмүүсийн эрхийн тухай тунхаглал** (1992 онд батлагдсан): Хүн амын цөөнхийн оршин тогтнол, мөн үндэстний эсвэл угсаатны, соёлын, шашны болон хэлний цөөнх болж байгаа хүмүүсийн эрхийг хүлээн зөвшөөрч, хамгаалах баримт бичиг.

**De factor equality – де факто (жинхэнэ/бодит) тэгш байдал:** Бодит амьдрал дээр оршиж байгаа, хүмүүсийн амьдралд дадал болж хэвшсэн, хуулиар мөрдөгддөг тэгш байдал. Ялгаварлан гадуурхал жинхнээсээ үгүй болж, хүмүүс бүр эрхээ бусадтай адил тэгш байдлаар бүрэн эдэлдэг болсон тохиолдолд л *де факто* тэгш байдалд хүрнэ.

**Entry into force – хүчин төгөлдөр болох:** Олон улсын гэрээг үндэсний парламент батламжилж засгийн газар нь бүрэн хэмжээгээр, заавал дагаж мөрдөх хүчинтэй нь хүлээн зөвшөөрөгдсөн баримт бичиг болох үйл явц. Тухайн гэрээг батламжилсан улс орны тоо нь гэрээнд заасан тоо хэмжээнд хүрснээр олон улсын гэрээ хүчин төгөлдөр болно.

**Equality of opportunity – Боломжийг тэгшитгэх:** хүмүүс бусадтай адил тэгш боломжтой байж, тэдгээр боломжийг эдэлж чадах боломжтой байх зарчим дээр үндэслэсэн тэгш байдал.

**European Convention for the Protection of Human Rights and Fundamental Freedoms – Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах Европын конвенци:** Европын Холбооноос 1950 онд баталсан хүний эрхийн тухай бүс нутгийн гэрээ. Европын холбооны бүх гишүүн улс энэхүү гэрээнд нэгдэн орсон ба шинэ гишүүд ч гэрээг хамгийн анхны боломж тохионгуут батална гэсэн хүлээлт байгаа ажээ.

**Formal Equality – Эрхзүйн тэгш байдал:** Тэгш байдлын энэхүү үзэл баримтлалын хүрээнд адил төстэй хүмүүст тэгш хандаж, уг хүнд байгаа шинж чанараар нь тэднийг үнэлэх ёстой гэж үздэг. Хөдөлмөр эрхлэлтийн тэгш байдлын дор, тухайлбал ажилд орох өргөдөл гаргасан хүмүүсийн холбогдох туршлага, мэдлэг, чадварыг харьцангуй үнэлж, шалгаруулах явцад өөр хүчин зүйлсийг /жишээ нь, арьсны өнгө, нийгмийн байдал, гэр бүлийн холбоо зэрэг холбогдолгүй шинж чанарыг/ давуугаар эсвэл дутуугаар авч тооцдоггүй байхыг шаардана.

**Fulfill human rights – Хүний эрхийг ханган биелүүлэх:** Хүний эрхийг “биелүүлэх” үүрэг гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй болон бусад бүх хүн эрхээ хэрэгжүүлж чаддаг байхад чиглэсэн эерэг арга хэмжээг засгийн газрууд авч хэрэгжүүлэх ёстой гэсэн үг. Хүний эрхийг хөхиүлэн дэмжсэн хууль, бодлогыг засгийн газрууд батлах ёстой. Эдгээр эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөр, бусад арга хэмжээг засгийн газрууд боловсруулах үүрэгтэй. Тэдгээр хуулиа мөрдөх, хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцийг засгийн газрууд мөн хуваарилах ёстой.

**General Comment – Ерөнхий зөвлөмж:** Олон улсын тухайн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь засгийн газруудад зөвлөмж болгон НҮБ-ын олон улсын гэрээг хянаж,

үнэлдэг хороонуудаас (жишээлбэл, **Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо**) бичгээр гаргадаг мэдэгдэл. Мэдэгдэл нь мөн олон улсын тухайн гэрээний утга, агуулга, хүрээг тайлбарласан байж болно.

**Habilitation – Сэргээлт:** Хөгжлийн бэрхшээлтэй төрсөн, эсвэл амьдралынхаа эрт үе шатанд хөгжлийн бэрхшээлтэй болсон хүмүүсийг өсөж хүмүүжих явцдаа чадавхиа бүрэн дайчилдаг болгон чадавхжуулах үүднээс дээд зэргээр хараат бус бие даан амьдрах, амьдралын бүхий л хүрээнд бүрэн хамрагдаж, оролцоход нь туслах зорилготой оновчтой бөгөөд зохистой арга хэмжээ. Харин **нөхөн сэргээлт** бол хөгжлийн бэрхшээлтэй болсны дараа, эсвэл хөгжлийн бэрхшээлийнх нь мөн чанар өөрчлөгдсөний дараа дээд байдлаар бие даан хараат бус амьдрах, бүрэн хамрагдах, оролцох байдлаа дахин олж авах, үргэлжлүүлэх нөхцөл бүрдүүлэхийг хэлнэ.

**Human Rights Committee** – Хүний эрхийн комисс: Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын гишүүн улсууд хүлээсэн үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавьдаг бие даасан экспертүүдийн байгууллага.

**Inalienable – Салшгүй:** Хүний эрх бол хүн бүрт байдаг бөгөөд эрхийг нь ямар ч нөхцөлд түүнээс салгаж болдоггүй гэсэн зарчим. Хүн бүр төрсөн цагаасаа л заяагдмал хүний эрхтэй байдаг. Хүний эрхийг засгийн газрууд, эсвэл хэн нэгэн эрх мэдэлтэн хүнд олгодоггүй, заагдаж салган авах эрхгүй.

**Inclusive education** – Тэгш хамруулан сургах боловсрол: Хөгжлийн бэрхшээлтэй болон хөгжлийн бэрхшээлгүй хүүхэд, залуучууд, насанд хүрэгсдийн боловсролыг хэлж байгаа бөгөөд энэ боловсролыг тухайн хүмүүсийн амьдарч байгаа орон нутагт нь ерөнхий боловсролын тогтолцоогоор олгоно. Тэгш хамруулан сургах боловсролыг дэмжлэг үзүүлэх зохистой бүтэц, сүлжээ бүхий орчинд үзүүлэх ёстой ба суралцах үйл явцад суралцагчдад учирдаг сургуулийн орчинтой холбоотой саад, тотгорыг арилгахын тулд бодлого, практик арга ажиллагаа болон болон хандлагыг өөрчлөхөд чиглэсэн арга хэмжээ зэрэг асуудал мөн багтана.

**Independent living movement** – “Бие даасан амьдралын төлөө” хөдөлгөөн: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах зорилготой хөдөлгөөний нэгэн хэсэг ба хөгжлийн бэрхшээлтэй хүн бусад хүмүүсийн хамтаар нийгэм, орон нутагтаа амьдрах эрхтэй гэсэн үзэл дээр тулгуурладаг. Хувийн туслалцаа үзүүлдэг үйлчилгээ бий болгох замаар ийм боломжийг хангаж болох ба ингэснээр тухайн хүн хувийн тусламж авах, орон гэрээ авч явах, хөдөлмөр эрхлэх, сургуульд сурах, шашны үйл ажиллагаанд оролцох зэргээр нийгмийнхээ амьдралд бүрэн оролцох боломжтой болно.

**Indivisible – Хуваагдашгүй:** Хүний аливаа эрх өөр ямар ч эрхтэй адил тэгш ач холбогдолтой байх зарчим. Хэн нэгэн хүн аль нэг эрхийг “ач холбогдол багатай” эсвэл “чухал биш” гэж үзэн тэрхүү эрхийг хүнээс салгаж болохгүй.

**Informed consent – Бүрэн дүүрэн мэдээлэлд үндэслэсэн сайн дурын зөвшөөрөл:** Авах гэж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар шийдвэр гаргалтад бүрэн оролцоход шаардлагатай бүх мэдээллийг үйлчлүүлэгчид хангаж өгөх үйл явц. Энэ нь өөрийн бие махбодын талаарх шийдвэрийг үйлчлүүлэгч өөрөө гаргах тухай эмчлүүлэгчийн

эрхийн үзэл баримтлал болон эмчилгээний талаарх шийдвэр гаргалтад өвчтөнийг заавал оролцуулах тухай эмчийн ёс зүйн зарчимд үндэслэсэн.

**Inherent – Төрөлхийн:** Хүний эрх бол хүн байхын салшгүй нэг хэсэг мөн гэсэн зарчим. **Хүний эрхийн түгээмэл тунхаглалын** 1 дүгээр зүйлд “Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна” гэж заасан байдаг.

**Instrument – Хэрэглэгдэхүүн ба баримт бичиг:** Засгийн газраас хүний эрхийн тодорхой зарчим, хэм хэмжээг хүндэлж мөрдөхөө илэрхийлсэн албан ёсны баримт бичиг (жишээлбэл, **олон улсын гэрээ, тунхаглал** гэх мэт). Эдгээр нь заавал мөрдөх ёстой, эсвэл **заавал мөрдөх албагүй** гэсэн хоёр төрлийн байж болохоос гадна дэлхийн, бүс нутгийн, эсвэл үндэсний түвшин үйлчлэх баримт бичгүүд байж болно.

**Integrated education – Интеграцчилсан боловсрол:** Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тусгай дэмжлэг туслалцаа үзүүлэлгүйгээр, суралцахад нь тогтор болж байгаа саадуудыг тусгайлан арилгалгүйгээр, ингэхдээ хүүхэд тэрхүү тогтолцоо, орчинд зохицож, эсвэл “таарч” чадна гэж тооцоолж ерөнхий боловсролын тогтолцоогоор дамжуулан боловсрол олгох арга хэлбэр. **Тэгш хамруулах боловсрол** нь тусгай дэмжлэг туслалцаа, **боломжит тохируулга** хийдгээрээ үүнээс ялгаатай.

**Inter-American Convention on the Elimination of all forms of Discrimination against Persons with Disabilities – Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Америк тивийн конвенци:** 1999 онд Америк тивийн улс орнуудын байгууллагаас баталсан олон улсын гэрээ бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг тусгайлан заасан хамгийн анхны бүс нутгийн гэрээ.

**Interdependent – Харилцан хамааралтай:** Хүний эрхийн хуулиудын хоорондоо бие биенээ нөхдөг, харилцан үйлчилдэг байдлыг хэлнэ. Жишээлбэл, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, сурч боловсрох эрх, тэр бүү хэл, хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрх хүртэл төрийн үйл хэрэгт оролцох таны боломжид шууд нөлөөлнө.

**Intergovernmental organizations – Засгийн газар хоорондын байгууллага:** Хүчин чармайлтаа нэгтгэж хамтран ажиллах хүсэлтэй байгаа хэд хэдэн засгийн газрын дэмжлэгтэй байгууллага. Зарим нь бүсийн (жишээлбэл, Европын Зөвлөл, Америк тивийн улс орнуудын байгууллага гэх мэт), зарим нь холбоо (жишээлбэл, Умард Атлантын гэрээний байгууллага), зарим нь тусгай зорилгод чиглэсэн (жишээлбэл, **Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага** гэх мэт) байдаг.

**International Bill of Human Rights – Олон улсын хүний эрхийн гэрээ, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт ба түүний нэмэлт протокол, мөн Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт** зэргийн нэгдэл.

**International Convention on the Elimination of All Forms of Racial Discrimination (ICERD) – Арьсны өнгөөр алагчлах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенци** (1965 онд батлагдаж, 1969 онд хүчин төгөлдөр болсон): Арьсны өнгөөр ялгаварлан гадуурхал гэсэн ойлголтын нэгдсэн тодорхойлолтыг өгч, түүнийг хориглосон олон улсын гэрээ.

**International Convention on the Protection of the Rights of All Migrant Workers and Members of their Families (ICRMW)** – Шилжин суурьшигч ажилчид, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын пакт (1990 онд батлагдаж, 1998 онд хүчин төгөлдөр болсон): Шилжин суурьшигч ажилчид, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрхийг тодорхойлсон олон улсын гэрээ.

**International Covenant on Civil and Political Rights (ICCPR) – Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт** (1966 онд батлагдаж, 1976 онд хүчин төгөлдөр болсон): Бүх хүн иргэний болон улс төрийн өргөн хүрээний эрхтэй гэдгийг тунхагласан. Энэ гэрээ нь **Олон улсын хүний эрхийн гэрээний** нэг бүрэлдэхүүн хэсэг.

**International Covenant on Economic, Social and Cultural Rights (ICESCR) – Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт** (1966 онд баталж, 1976 онд хүчин төгөлдөр болсон): Бүх хүн эдийн засаг, нийгэм, соёлын өргөн хүрээний эрхтэй гэдгийг тунхагласан. Энэ гэрээ нь **Олон улсын хүний эрхийн гэрээний** нэг бүрэлдэхүүн хэсэг.

**International humanitarian law – Олон улсын хүмүүнлэгийн эрхзүй:** Олон улсын эрхзүйн нэг хэсэг бөгөөд зэвсэгт мөргөлдөөний үед хэрэглэгддэг. Олон улсын зүгээс заримдаа дотоодын зэвсэгт мөргөлдөөний үед нийгмийн зарим бүлгийг хамгаалах, энгийн иргэдийг хамгаалах, хохирогчдод туслах, учирч болох хүний амь эрсдэх, эд хөрөнгө хохирох явдлыг багасгах үүднээс дайн байлдааны арга хэлбэрт хязгаарлалт тогтоодог. Үндсэндээ 1949 оны Женевийн конвенциос бүрдэнэ.

**International Labor Organization (ILO) – Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага /ОУХБ/:** Версалийн Энх тайвны гэрээний хүрээнд хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах, нийгмийн шударга ёсыг сайжруулах зорилгоор 1919 онд байгуулагдсан засгийн газар хоорондын байгууллага. ОУХБ нь 1946 онд НҮБ-ын тусгай байгууллага болсон.

**Interrelated – Харилцан холбоотой:** Хүний олон эрх бие биенээ нөхдөг, бие биедээ нөлөөлдөг гэсэн үзэл баримтлал.

**Legal capacity – эрхзүйн чадамж:** (1) Хэн нэгнийг хуулийн этгээд байхыг хүлээн зөвшөөрөх; хүмүүсийг эрхзүйн этгээд (зөвхөн хуулийн объект эсвэл өөр хэн нэгний өмч бус) байх статусыг баталгаажуулна. (2) Мөн үйлдэл хийх чадавхи, хуулийн этгээдийн (жишээ нь, санхүүгийн холбогдолтой) эрх, үүргээ хэрэгжүүлэх чадавхийг баталгаажуулна.

**Non-binding – Заавал мөрдөх албагүй:** Тунхаглалын адил заавал биелүүлэх эрхзүйн үүрэг агуулаагүй баримт бичиг. Гэхдээ ийм баримт бичиг нь ёс зүйн үүрэг дагуулсан, эсвэл (бичигдээгүй) уламжлалт олон улсын хуулийн хүчтэй байж болно.

**Non-governmental organization – Төрийн бус байгууллага /ТББ/:** Иргэдийн байгуулсан, засгийн газрын бус байгууллага. ТББ-ууд нь Хүний эрхийн комисс зэрэг хүний эрхийн байгууллагын үйл ажиллагаа, баримт бичиг, шийдвэрт хяналт үнэлгээ хийдэг. ТББ-ууд олон улсын том байгууллага (жишээлбэл, Улаан Загалмай, Амнести Ентэрнэшнл, Скаутын холбоо гэх мэт), эсвэл жижиг бөгөөд орон нутгийн чанартай (жишээлбэл, аль нэг хотын, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй холбоотой тодорхой асуудлаар ажилладаг) байж

болно. ТББ-ууд нь НҮБ-аас бодлого, шийдвэр гаргахад чухал үүрэг роль гүйцэтгэдэг ба тэдгээрийн зарим нь НҮБ-тай албан ёсны зөвлөхийн статустайгаар хамтран ажилладаг.

**Office of the High Commissioner for Human Rights (OHCHR) – Хүний эрхийн дээд комиссарын газар (ХЭДКГ):** Хүний эрхийн олон улсын эрхзүй, олон улсын гэрээгээр тодорхойлсон бүх эрхийг хамгаалж, сайжруулах үүрэг бүхий алба бөгөөд НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын газрын нэг нэгж. Женев хотноо байрладаг ХЭДКГ нь хүний эрхийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, хүний бүх эрхийг хүндлэх явдлыг баталгаажуулах, хүний эрхийг хамгаалах олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх, холбогдох үйл ажиллагааг НҮБ-ын хэмжээнд зохицуулах зорилготой.

**Protocol – Протокол:** Олон улсын гэрээтэй холбоотой, эсвэл түүнийг өөрчилсөн (жишээлбэл, нэмэлт журам тогтоосон, эсвэл агуулгыг тодруулсан) өөр нэг олон улсын гэрээний төрөл. Олон улсын үндсэн гэрээг баталгаажуулсан засгийн газрууд эдгээр протоколоор оруулсан өөрчлөлтийг мөрдөх, эс мөрдөхөө сонгох эрхтэй байдаг тул эдгээр протоколыг “**заавал мөрдөх албагүй протокол**” гэж мөн нэрлэдэг.

**Positive discrimination – “илт дэмжсэн арга хэмжээ”-г үз.**

**Protect – (Хүний эрхийг) хамгаалах:** Хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллага, хувийн бусад байгууллага зэрэг төрийн бус аливаа этгээдийн зүгээс хүний эрхийн зөрчил гаргахаас бүх хүнийг, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүнийг, хамгаалах талаар засгийн газар арга хэмжээ авах шаардлагатай гэсэн үг.

**Ratification, Ratify – Соёрхон батлах:** Олон улсын гэрээнд гарын үсэг зурсан засгийн газрынхаа эрхийг баталгаажуулсан талаар тухайн улсын хууль тогтоох байгууллага ба эрх бүхий бусад байгууллагаас батлах эсэхийг шийдвэрлэхийг хэлнэ. Энэхүү албан ёсны журмыг гүйцэтгэснээр тухайн улс холбогдох олон улсын гэрээгээр тодорхойлсон үүргүүдийг өөртөө хүлээнэ.

**Reasonable accommodation – боломжит тохируулга:** Тодорхой орчинг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй, зохистой, хэрэглэгдэхүйц болгох үүднээс тэрхүү орчин дах практик дадал, хөтөлбөр, биет дэд бүтцэд хийсэн (хийвэл зохих) шаардлагатай бөгөөд зохистой өөрчлөлт, нийцүүлэг.

**Rehabilitation – Нөхөн сэргээлт:** Хөгжлийн бэрхшээлтэй болсон, мөн амьдралын нөхцөл юмуу эсвэл хөгжлийн бэрхшээл нь өөрчлөгдсөн хүмүүст боломжийн хэрээр дээд зэргээр хараат бус байдлаар амьдрах, бие махбодын, оюуны, нийгмийн болон мэргэжлийн бүрэн чадавхитай байх, амьдралын бүхий л хүрээнд бүрэн хамрагдаж, оролцоход нь туслах зорилготой оновчтой бөгөөд зохистой арга хэмжээ. Харин **сэргээлт** бол хөгжлийн бэрхшээлтэй төрсөн эсвэл амьдралынхаа эрт үед хөгжлийн бэрхшээлтэй болсон хүмүүст боломжийн хэрээр дээд зэргээр хараат бус, бүрэн хамрагдсан байдлаар амьдрахад нь туслах гэсэн утгатай болно.

**Respect for human rights – Хүний эрхийг хүндэтгэх:** Хүний эрхийг хүндэтгэх үүрэг гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүн эрхээ эдлэх, хэрэгжүүлэхэд төр хөндлөнгөөс оролцохгүй байхыг хэлнэ. Хүний эрхийг зөрчсөн аливаа үйлдлээс ямар ч төр, засгийн газар татгалзах ёстой. Мөн хүний эрхэд харш аливаа хууль, бодлого, дадал заншлыг төр, засгийн газрууд арилгах ёстой гэсэн үг.



**Reverse discrimination – Урвуу ялгаварлан гадуурхал:** “илт дэмжсэн арга хэмжээ”-г үз.

**Signing, sign – Гарын үсэг зурах:** Хүний эрхийн салбарт бол, олон улсын гэрээг батламжлах үйл явцын анхны алхам. Конвенци, олон улсын аль нэгэн гэрээнд гарын үсэг зурах гэдэг нь тухайн баримт бичгийн зарчмыг сааруулахаас татгалзах, түүний үг үсгийг хүндэтгэх амлалт авна гэсэн утгатай болно.

**Special rapporteur – Тусгай илтгэгч:** Тодорхой сэдвээр (жишээлбэл, хүүхдийг худалдах, хүүхдийг садар самуунд уруу татах, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл гэх мэт), эсвэл тодорхой улсын хэмжээнд хүний эрхийн байдлаар тайлан тавих үүрэгтэй НҮБ-ын сонгосон хүн. 1993 оны **Стандарт дүрмийн** хүрээнд хөгжлийн бэрхшээлийн асуудлаарх тусгай илтгэгчийг томилсон бөгөөд энэ илтгэгч нь Стандарт дүрмүүдийн хэрэгжилтийн талаар жил бүр илтгэл тавьдаг. Илтгэгчийн мандатыг тодорхой хугацаанд шинэчилнэ.

**Standard Rules – Стандарт дүрмүүд:** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боломжийг тэгшитгэх тухайн стандарт дүрмүүдийг үз.

**State – Улс:** “Орон” гэсэн үгтэй ижил утгатай. Нийтлэг хууль, засгийн газартай, олон улсын түвшинд үйл хэрэг явуулах чадавхтай, тодорхой газар нутагт тогтмол суурьшдаг хэсэг хүн.

**State Party – Оролцогч улс:** Олон улсын гэрээ, конвенцийг батламжилж, түүний заалтуудтай нийцүүлэн ажиллах үүрэгтэй улсууд.

**Treaty – Олон улсын гэрээ:** Улсуудын үүрэг, хариуцлагыг тодорхойлдог, эсвэл өөрчилдөг улс хоорондын албан ёсны гэрээ. Конвенци гэсэн нэр томъёотой ижил утгатай. НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас конвенцийн батлагдсанаар түүнд гарын үсэг зурсан гишүүн улсууд эрхзүйн хувьд заавал мөрдөх ёстой олон улсын үүргийг бий болгодог. Үндэсний засгийн газар тэрхүү олон улсын гэрээг батламжилснаар олон улсын гэрээний заалт бүр тухайн улсын дотоодын эрхзүйн болон үндсэн хуулийн хүрээнд хүлээсэн үүргийн бүрэлдэхүүн хэсэг болно.

**United Nations Charter – Нэгдсэн Үндэсний Байгууллагын дүрэм:** Нэгдсэн Үндэстний Байгууллагын зорилго, үүрэг, хариуцлагыг тогтоосон анхны баримт бичиг. 1945 онд Сан Франциско хотод баталсан.

**UN Standard Rules on the Equalization of Opportunities for Persons with Disabilities – Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боломжийг тэгшитгэх тухайн стандарт дүрмүүд:** 1993 онд Ерөнхий Ассамблейгаар баталсан энэхүү заавал мөрдөх албагүй баримт бичиг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст олддог боломжийг бусад хүмүүсийнхтэй тэнцүүлэх талаар арга хэмжээ авах засгийн газруудын ёс зүйн болон улс төрийн эрмэлзлийг илэрхийлсэн баримт бичиг. Түүний 22 дүрэм нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралын бүх талыг хамардаг бөгөөд бодлого боловсруулах, мөн техникийн болон эдийн засгийн хамтын ажиллагааны үндэс суурь болдог.

**Universal – Түгээмэл:** Хүний эрх бол дэлхий хүн нэг бүрт хамааралтай бөгөөд хүний арьс, өнгө, хүйс, яс үндэсний болон нийгмийн гарал үүсэл, шашин, хэл, уг гарал, нас, бэлгийн хандлага, хөгжлийн бэрхшээл болон бусад байдлаас үл хамаарна. Хүний эрхтэй байх ганцхан нөхцөл бол хүн байх явдал юм.

**Universal Declaration of Human Rights – Хүний эрхийн түгээмэл тунхаглал (ХЭТТ),** НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаар 1948 оны 12 дугаар сарын 10-нд батлагдсан: Хүний эрхийн стандарт, хэм хэмжээг тогтоосон НҮБ-ын анхдагч баримт бичиг. Гишүүн улсууд нь ХЭТТ-ыг хүндлэн дээдлэхээ зөвшөөрсөн болно. Хэдийгээр ХЭТТ эхнээсээ **заавал мөрдөх албагүй** байсан боловч цаг хугацааны явцад түүний олон заалтыг улс орнууд дээдлэн хүндэлдэг болсон учраас түүнийг одоо олон улсын уламжлалт хууль гэж нэрлэж болохоор болжээ. ХЭТТ нь хүний эрхийн олон улсын гэрээний нэг бүрэлдэхүүн хэсэг.

**Universal design – Нийтлэг дизайн:** ямар нэгэн тусгай загвар, тохируулгагүйгээр бүх хүмүүс хамгийн дээд хэмжээгээр хэрэглэхүйц бүтээгдэхүүн, орчин нөхцөл, хөтөлбөр, үйлчилгээний загвар. Жишээлбэл, явган хүний замын хашлагыг налуу болгосноор хүүхдийн тэрэгтэй эх эцэг, дугуйтай ачаа чирсэн хүмүүс, тэргэнцэртэй хүмүүс, хараагүй хүмүүс, дугуйчид зэрэг олон хүний хэрэгцээ хангагдсан юм.

**World Health Organization – Дэлхий Эрүүл Мэндийн Байгууллага:** Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүрээнд эрүүл мэндийн чиглэлээр дэлхий даяар үйл ажиллагаа явуулдаг засгийн газар хоорондын байгууллага.



## ХАВСРАЛТ 5. СЭДЭВЧИЛСЭН ИНДЕКС

<b>Ажил хөдөлмөр</b> . . . . .	<b>Бүлэг 10. Хөдөлмөрлөх эрх</b>
• Мэдлэг нэмэгдүүлэх	Бүлэг 10. Хөдөлмөрлөх эрх
• Эмэгтэйчүүдийг гадуурхах	Бүлэг 16. Эмэгтэйчүүд
<b>Асрамжийн газар амьдрах</b>	
• -т байгаа хүүхдүүд	Бүлэг 6. Эрүү шүүлт/ хэрцгийллээс ангид байх
• Амь насанд аюултай	Бүлэг 5. Амьд байх эрх
• Бие даасан амьдрах	Бүлэг 11. Бие даан нэр төртэй амьдрах
• -д гардаг хүчирхийлэл	Бүлэг 6. Эрүү шүүлт/ хэрцгийллээс ангид байх
<b>Бие дааж амьдрах</b> . . . . .	<b>Бүлэг 11. Бие даан нэр төртэй амьдрах</b>
• Бие дааж амьдрах хөдөлгөөн	Бүлэг 9. Сэргээлт/нөхөн сэргээлт
	Бүлэг 11. Бие даан нэр төртэй амьдрах
• эрх	Бүлэг 16. Эмэгтэйчүүд
	Бүлэг 11. Бие даан нэр төртэй амьдрах
<b>Боловсрол</b>	
• Хүүхдийн эрх	Бүлэг 15. Хүүхэд
• Тэгш хамран сургах	Бүлэг 13. Боловсрол
• Интеграцчилсан	Бүлэг 13. Боловсрол
• Мэргэшсэн багш	Бүлэг 13. Боловсрол
• Чанартай боловсрол	Бүлэг 13. Боловсрол
• Эрх	Бүлэг 13. Боловсрол
• Эмэгтэйчүүдийн эрх	Бүлэг 16. Эмэгтэйчүүд
<b>Боломжит тохируулга</b>	
• ба хүртээмж	Бүлэг 2. Хүртээмж
• нөхөн сэргээлттэй харьцуулах	Бүлэг 9. Сэргээлт/нөхөн сэргээлт
• тодорхойлолт	Хэсэг 1. Хүний эрх
• тэгш байдалд онцгой чухал	Бүлэг 1. Тэгш байдал, үл ялгаварлал
• боловсролд	Бүлэг 13. Боловсрол
<b>Бэлгийн амьдрал</b> . . . . .	<b>Бүлэг 7. Хувийн нууц</b>
• Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ	Бүлэг 16. Эмэгтэйчүүд
• Бэлгийн түрэмгийлэл ба хүчирхийлэл	Бүлэг 6. Эрүү шүүлт/ хэрцгийлэл
	Бүлэг 16. Эмэгтэйчүүд
• Бэлгийн амьдралын нууцлал	Бүлэг 7. Хувийн нууц
<b>Гэр бүл</b>	
• Шийдвэр гаргалтад	Бүлэг 16. Эмэгтэйчүүд
• Эрх	Бүлэг 7. Хувийн нууц, нэр төр, орон байр, гэр бүл
• -тэй амьдрах эрх	Бүлэг 7. Хувийн нууц, нэр төр, орон байр, гэр бүл
• Гэрлэх эрх	Бүлэг 7. Хувийн нууц, нэр төр, орон байр, гэр бүл;
	Бүлэг 16. Эмэгтэйчүүд
<b>Гэрлэлт</b> . . . . .	<b>Бүлэг 7. Хувийн нууц, нэр төр, орон байр, гэр бүл</b>
• Эмэгтэйчүүдийн эрх	Бүлэг 16. Эмэгтэйчүүд
<b>Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)</b> . . . . .	<b>Бүлэг 8. Эрүүл мэнд;</b>
	<b>Бүлэг 9. Сэргээлт/нөхөн сэргээлт</b>
<b>Евгеникийн онол</b> . . . . .	<b>Бүлэг 5. Амьд явах эрх</b>
<b>Интернет</b>	
• Хүртээмж	Бүлэг 2. Хүртээмж
	Бүлэг 3. Улс төр, нийгмийн амьдралд оролцох
<b>Мэдээлэл</b>	
• Хүртээмж	
• Хялбар хэл найруулга	Бүлэг 4. Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө
• Нууцлал	Бүлэг 7. Хувийн нууц, нэр төр, орон байр, гэр бүл
• Интернетийн	Бүлэг 4. Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө
<b>Мэдээлэлд тулгуурласан зөвшөөрөл</b> . . . . .	<b>Бүлэг 8. Эрүүл мэнд</b>

<b>Мөлжлөг</b> . . . . .	<b>Бүлэг 6. Эрүү шүүлт/хэрцгийлэл</b>
<b>Нийтлэг загвар</b>	
• ба хүртээмж	Бүлэг 2. Хүртээмж
• сургалтанд	Бүлэг 13. Боловсрол
• эрүүл мэндийн үйлчилгээнд	Бүлэг 8. Эрүүл мэнд
<b>Нөхөн сэргээлт</b> . . . . .	<b>Бүлэг 9. Сэргээлт/нөхөн сэргээлт</b>
<b>Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)</b> . . . . .	<b>Бүлэг 10. Ажил хөдөлмөр;</b> <b>Бүлэг 9. Сэргээлт/нөхөн сэргээлт</b>
<b>Онцгой байдал, байгалийн гамшиг</b> . . . . .	<b>Бүлэг 5. Амьд явах эрх</b>
<b>Оролцоо</b>	
• Хүүхдийн	Бүлэг 15. Хүүхдүүд
• Шийдвэр гаргалтад	Бүлэг 11. Бие даан нэр төртэй амьдрах
• Хөтөлбөр боловсруулахад	Бүлэг 17. Бусад хүн ам
• Сонгуульд	Бүлэг 9. Сэргээлт/ нөхөн сэргээлт
• Эрүүл мэндийн шийдвэрт	Бүлэг 16. Эмэгтэйчүүд
• Байгууллагад	Бүлэг 3. Улс төр, нийгмийн амьдралд оролцох
• Улс төр, нийгмийн амьдралд	Бүлэг 8. Эрүүл мэнд
	Бүлэг 3. Улс төр, нийгмийн амьдралд оролцох
	Бүлэг 3. Улс төр, нийгмийн амьдралд оролцох
<b>Спорт</b> . . . . .	<b>Бүлэг 14. Спорт, соёлын амьдрал</b>
<b>Сэргээлт/Нөхөн сэргээлт</b> . . . . .	<b>Бүлэг 9. Сэргээлт/нөхөн сэргээлт</b>
• эмэгтэйчүүдэд хүртээмжтэй	Бүлэг 16. Эмэгтэйчүүд
<b>Сэргээх эмчилгээ хийлгэхгүй тухай заавар</b> . . . . .	<b>Бүлэг 5. Амьд явах эрх</b>
<b>Сэтгэц-нийгмийн хөгжлийн бэрхшээл</b>	
• -тэй хүмүүсийг хүчирхийлэх	Бүлэг 6. Эрүү шүүлт/ хэрцгийллээс ангид байх
• Сэргээлт ба нөхөн сэргээлт	Бүлэг 8. Эрүүл мэнд
<b>Тэгш байдал, үл гадуурхал</b>	
• де факто тэгш байдал	Бүлэг 1. Тэгш байдал, үл ялгаварлал
• тэгш боломж	Бүлэг 1. Тэгш байдал, үл ялгаварлал
• эрхзүйн тэгш байдал	Бүлэг 1. Тэгш байдал, үл ялгаварлал
• Эрүүл мэндийн үйлчилгээн дэх	Бүлэг 8. Эрүүл мэнд
• Эмэгтэйчүүд	Бүлэг 16. Эмэгтэйчүүд
<b>Тээвэр/Аялал</b> . . . . .	<b>Бүлэг 14. Спорт, соёлын амьдрал</b>
• Аюулгүй байдлын хяналт	Бүлэг 7. Хувийн нууц
• Аялал жуулчлал	Бүлэг 14. Спорт, соёлын амьдрал
<b>Уугуул иргэд</b> . . . . .	<b>Бүлэг 17. Бусад хүн ам</b>
<b>Үе тэнгийн зөвлөх</b> . . . . .	<b>Бүлэг 9. Сэргээлт/ нөхөн сэргээлт</b>
<b>ХДХВ/ДОХ</b> . . . . .	<b>Бүлэг 8. Эрүүл мэнд;</b> <b>Бүлэг 17. Бусад хүн ам</b>
<b>Хөгжил</b> . . . . .	<b>Бүлэг 17. Бусад хүн ам</b>
<b>Хөгжлийн бэршээлтэй эмэгтэйчүүд</b> . . . . .	<b>Бүлэг 16. Эмэгтэйчүүд</b>
• Идэвхтэн	Бүлэг 16. Эмэгтэйчүүд
<b>Хувийн туслах</b> . . . . .	<b>Бүлэг 7. Хувийн нууц</b>
<b>Хүйсээр ялгаварлах</b> . . . . .	<b>Бүлэг 16. Эмэгтэйчүүд</b>
<b>Хүртээмж</b> . . . . .	<b>Бүлэг 2. Хүртээмж</b>
• Хандлагын	Бүлэг 2. Хүртээмж
• Мэдээллийн	Бүлэг 2. Хүртээмж; Бүлэг 3. Үг, үзэл бодол
• Тогтолцооны	Бүлэг 2. Хүртээмж
• Биет	Бүлэг 3. Үг, үзэл бодол
• Шүүх, шүүхийн үйлчилгээний	Бүлэг 2. Хүртээмж
• Эрүүл мэндийн үйлчилгээний	Бүлэг 12. Шүүхийн хүртээмж
• Шүүхийн тогтолцооны	Бүлэг 8. Эрүүл мэнд
	Бүлэг 16. Эмэгтэйчүүд
	Бүлэг 12. Шүүхийн хүртээмж

• Нийгмийн үйлчилгээний	Бүлэг 3. Улс төр, нийгмийн амьдралд оролцох
• Нөхөн сэргээх үйлчилгээний	Бүлэг 16. Эмэгтэйчүүд
• Спорт, соёлын арга хэмжээний	Бүлэг 14. Спорт, соёлын амьдрал
<b>Хүчирхийлэл.</b>	<b>Бүлэг 6. Эрүү шүүлт/ хүчирхийллээс ангид байх</b>
• хүүхдийн эсрэг	Бүлэг 7. Хувийн нууц, нэр төр, орон байр, гэр бүл
• эмэгтэйчүүдийн эсрэг	Бүлэг 15. Хүүхдүүд; Бүлэг 16. Эмэгтэйчүүд
• үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс	Бүлэг 16. Эмэгтэйчүүд
<b>Хэвшмэл үзэл, тогтсон ойлголт.</b>	<b>Хэсэг 1. Хүний эрх; Бүлэг 8. Эрүүл мэнд</b>
<b>Хэл, соёлын өвөрмөц байдал</b>	<b>Бүлэг 14. Спорт, соёлын амьдрал</b>
<b>Хэрцгийлэл</b>	<b>Бүлэг 6. Эрүү шүүлт, хэрцгийлэл</b>
• Шоронд	Бүлэг 6. Эрүү шүүлт/ хэрцгийллээс ангид байх
• Хүүхдийн	Бүлэг 6. Эрүү шүүлт/ хэрцгийллээс ангид байх
• Эмэгтэйчүүдийн	Бүлэг 16. Эмэгтэйчүүд
<b>Шийдвэр гаргалт</b>	
• Эрүүл мэндийн үйлчилгээнд	Бүлэг 8. Эрүүл мэнд
• Туслалцаатай шийдвэр гаргалт	Бүлэг 11. Бие даасан байдал, нэр төр
• Хөгжлийн тухай шийдвэр	Бүлэг 18. Бусад хүн ам
<b>Шорон</b>	<b>Бүлэг 6. Эрүү шүүлт/ хэрцгийллээс ангид байх</b>
<b>Эмчийн туслалцаатай амиа хорлох.</b>	<b>Бүлэг 5. Амьд явах эрх</b>
<b>Эрүү шүүлт</b>	<b>Бүлэг 6. Эрүү шүүлт/ хэрцгийллээс ангид байх</b>
<b>Эрүүл мэнд/Эрүүл мэндийн үйлчилгээ.</b>	<b>Бүлэг 8. Эрүүл мэнд</b>
• ба сэргээлт /нөхөн сэргээлт	Бүлэг 8. Эрүүл мэнд
• Шийдвэр гаргалт	Бүлэг 8. Эрүүл мэнд
• Нөхөн үржихүйн	Бүлэг 16. Эмэгтэйчүүд
<b>Эрүүл мэндийн тусламжийн тухай урьдчилсан заавар</b>	<b>Бүлэг 8. Эрүүл мэнд</b>
• Зэвсэгт мөргөлдөөн	Хэсэг 1. Хүний эрх; Бүлэг 5. Амьд явах эрх
• Амиа хорлоход туслас	Бүлэг 5. Амьд явах эрх
• Хүүхдүүд	Бүлэг 15. Хүүхэд
• Хүчирхийлэл	Бүлэг 7. Хувийн нууц, нэр төр, гэр бүл;
	Бүлэг 6. Эрүү шүүлт/ хэрцгийлэл
• Байгууллагад	Бүлэг 6. Эрүү шүүлт/ хэрцгийлэл
• Эцэг эх, гэр бүл	Бүлэг 15. Хүүхэд
• Хувийн нэгдмэл байдал	Бүлэг 7. Хувийн нууц, нэр төр, гэр бүл
• Сурч боловсрох эрх	Бүлэг 13. Боловсрол; Бүлэг 15. Хүүхэд
• Оролцох эрх	Бүлэг 15. Хүүхэд
• Тоглох эрх	Бүлэг 14. Спорт, соёлын амьдрал
<b>Эрхзүйн чадамж.</b>	<b>Бүлэг 11. Бие даан нэр төртэй амьдрах</b>
<b>Эфтаназия.</b>	<b>Бүлэг 5. Амьд явах эрх</b>
<b>Ядуурал.</b>	<b>Бүлэг 17. Бусад хүн ам</b>
<b>Ялгаварлан гадуурхал</b>	
• Эрүүл мэндийн үйлчилгээнд	Бүлэг 8. Эрүүл мэнд
• Давхар гадуурхал	Хэсэг 1. Хүний эрх; Бүлэг 18. Бусад хүн ам